


Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 28 ны өдрийн
264 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



ТӨМӨР ЗАМЫН ДОХИОЛОЛ, ХОЛБООНЫ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Төмөр замын тээврийн тасралтгүй хэвийн, аюулгүй ажиллагаа болон галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалтыг шуурхай удирдлагаар хангах, галт тэрэгний хөдөлгөөний **болон** сэлгээний ажлын үеийн үзэгдэх болон дуут дохионы тогтолцоо, эдгээр дохиог өгдөг хэрэгслийн хэв маягийг тодорхойлж, тэдгээрийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Төмөр замын дохиоллын байгууламж, техник тоног төхөөрөмж, тэдгээрийн үйлчилгээнд тавигдах шаардлага болон дохиоллын зарчим нь Төмөр замын техник ашиглалтын журамд зааснаар зохицуулагдана.

1.3. Төмөр замын дохиолол холбооны журмаар тогтоосон дохио, тэмдгийн шаардлагыг чанд биелүүлснээр галт тэрэгний хөдөлгөөний **болон** сэлгээний ажлын аюулгүй, тасралтгүй ажиллагаа хангагдана.

1.4. Энэхүү журамд хэрэглэгдсэн нэр томьёо, тодорхойлолтыг Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төмөр замын техник ашиглалтын журам болон MNS 6387-1,2,3,4:2013 "Төмөр зам, замын, автоматик, телемеханикийн, хөдлөх бүрэлдэхүүний, тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томьёо, тодорхойлолт" заасан утгаар ойлгож хэрэглэнэ.

1.5. Энэхүү журмаар тодорхойлсон дохио, тэмдгийн заалтыг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч бүр заавал дагаж мөрдөнө.


ХОЁРДУГААР БҮЛЭГ ДОХИОНЫ АНГИЛАЛ, ЗОРИУЛАЛТ

2.1. Дохио нь хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, галт тэрэгний хөдөлгөөний **болон** сэлгээний ажлыг зохион байгуулахад зориулагдана. Дохиог үзэгдэх дуут гэж ангилна.

2.2. Үзэгдэх дохио нь дохионы заалтын өнгө, хэлбэр, байдал, тоогоор тодорхойлогдоно. Үзэгдэх дохионы хэрэгсэлд гэрлэн дохио, семафор, зээрэнхий, самбар, гар дэнлүү, дарцаг, дохионы заагч ба тэмдэг орно.

2.2.1. Үзэгдэх дохиог хэрэглэх байдлаар нь гурав ангилна.

а. **өдрийн дохиог** хоногийн гэрэлтэй үед хэрэглэнэ. Үүнд семафорын далавч, зээрэнхий, самбар, дарцаг, замын хаалт, сумын заагч орно.



б. **шөнийн дохиог** хоногийн харанхуй үед хэрэглэнэ. Үүнд семафор, зээрэнхий, гар дэнлүү ба ишин дээр байрлуулсан гар дэнлүү, дохионы заагч, галт тэрэгний тогтоосон өнгийн гэрэл.

Манан будан, шороон болон цасан шуурга зэрэг байгаль цаг уурын үзэгдлээс шалтгаалан өдрийн цагт зогсоох дохио 1000 метрт, хурд бууруулах дохио 400 метрт үзэгдэхгүй байвал шөнийн дохиог хэрэглэнэ.

в. хоногийн туршид хэрэглэгдэх дохиог хоногийн гэрэлтэй ба харанхуй аль ч үед хэрэглэнэ. Үүнд: Гэрлэн дохионы тогтсон өнгийн гэрэл, замнал заагч, хурд бууруулах байнгын зээрэнхий, ачааны галт тэрэгний сүүлийн улаан дохио, дохионы тэмдгүүд орно.

2.2.2. Төмөр замын хонгилд шөнийн болон хоногийн туршид хэрэглэгдэх дохиог байрлуулна.

2.3. Дуут дохио нь урт, богино, дууны тоо, хослолоор тодорхойлогдоно. Эдгээрийн шаардлага нь өдөр, шөнийн цагт нэгэн адил байна.


2.3.1. Дуут дохио өгөхөд бүрээ, гар шүгэл, зүтгүүр ба өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний дуут дохио, тусгай зориулалтын дуут дохио, галт тэрэгний шүгэл, бялт зэргийг хэрэглэнэ.

2.3.2. Бялтны тэсрэлт галт тэргийг нэн даруй зогсоохыг шаардана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭРЛЭН ДОХИО, СЕМАФОР

3.1. Гэрлэн дохио, семафорыг байнгын дохионд хамааруулж зориулалтаар нь дараахь байдлаар ангилна:

- **Оруулах**-Өртөөг хоорондын замаас зааглах, галт тэргийг өртөө рүү орохыг зөвшөөрөх буюу хориглох;
- **Гаргах**-Өртөөнөөс галт тэрэг хоорондын замд явуулахыг зөвшөөрөх буюу хориглох;
- **Замналын**-Өртөөний нэг бэлчрээс нөгөө бэлчирт галт тэрэг өнгөрүүлэхийг зөвшөөрөх буюу хориглох;
- **Өнгөрүүлэх**-Нэг хориг-хэсгээс нөгөө хориг-хэсэгт орохыг зөвшөөрөх буюу хориглох;
- **Халхлах**-Төмөр замын шугам нь бусад төмөр зам, троллейбус, трамвайны шугамтай нэг түвшинд огтлолцох газар болон газарчтай өнгөрөх хэсгийг хаана;
- **Хаах**-Гарам, том хэмжээний хиймэл байгууламж ба уулын хэсэгт нуралт үүсч болзошгүй газарт хөдөлгөөнд аюултай саад гарахад галт тэргийг зогсооно;




- **Анхааруулах**-Оруулах, өнгөрүүлэх, хаах, халхлах гэрлэн дохионы заалтыг урьдчилан анхааруулна;
- **Сэлгээний**-Сэлгээний ажил хийхийг зөвшөөрөх буюу хориглох;
- **Довын**-Довоос вагоныг ялган тараахыг зөвшөөрөх буюу хориглох;
- **Давтах**-Гаргах, замналын, довын үндсэн гэрлэн дохионы заалт тухайн газрын байдлаас хангалтгүй үзэгдэж байвал түүний заалтыг давтана;
- **Зүтгүүрийн гэрлэн дохио**-Хоорондын замын нэг хориг-хэсгээс нөгөө хориг-хэсэг рүү орохыг зөвшөөрөх буюу хориглох, ойртож байгаа гэрлэн дохионы заалтыг анхааруулна.

3.2. Гэрлэн дохио нь линзэн ба гэрэлт диодон гэрэлтэй байна.

3.3. Гэрлэн дохиог шонтой, шонгүй /3.1 дүгээр зураг/ ба хөндлөвч, консоль дээр байрлуулсан гэж ангилна.

3.4. Нэг гэрлэн дохио /гаргах ба сэлгээний, гаргах ба замналын гэх мэт/ хэд хэдэн зориулалттай байж болно.




3.1 дүгээр зураг

3.5. Гэрлэн дохионы ялгах пайзыг үсэг буюу үсэг тоогоор хийж бүх гэрлэн дохионы шон болон суурьт байрлуулна.

3.6. Байрлал ба түүний зориулалтаас нь үл хамааран гэрлэн дохиогоор дараахь үндсэн дохиог өгнө. Үүнд:

- **Нэг ногоон гэрэл** -Галт тэрэг тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио нээлттэй.




- **Анивчсан нэг шар гэрэл**-Галт тэрэг тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио нээлттэй, гэрлэн дохиог бууруулсан хурдтай өнгөрөхийг шаардана.
- **Нэг шар гэрэл**-Галт тэрэг зогсоход бэлэн явна. Дараагийн гэрлэн дохио хаалттай.
- **Дээд тал нь анивчсан хоёр шар гэрэл**-Галт тэрэг хажуугийн замаар орно, гэрлэн дохиог бууруулсан хурдтай өнгөрөхийг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио нээлттэй.
- **Хоёр шар гэрэл**-Галт тэрэг хажуугийн замаар орно, дараагийн гэрлэн дохионы өмнө зогсоход бэлэн, бууруулсан хурдтай өнгөрөхийг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио хаалттай
- **Нэг улаан гэрэл**-Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно.

3.7. Радио /өртөө хоорондын/ хориглол ашиглан галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулж байгаа үед оруулах, анхааруулах гэрлэн дохионоос бусад бүх байнгын болон түр дохионы заалтын утга хэвээр хадгалагдана.

3.8. Замналын гэрлэн дохиотой өртөөний оруулах гэрлэн дохио дараахь дохиог өгнө.

3.9. Оруулах гэрлэн дохио дараахь дохиог өгнө:

- **Нэг ногоон гэрэл**-Галт тэрэг өртөөний гол замаар тогтоосон хурдтай орохыг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио /замналын, гаргах/ нээлттэй. /3.2. "а" дугаар зураг/



3.2 дугаар зураг /а, б/

• **Анивчсан нэг шар гэрэл**-Галт тэрэг өртөөний гол замаар тогтоосон хурдтай орохыг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио /замналын, гаргах/ нээлттэй, гэрлэн дохионы дэргэдүүр бууруулсан хурдтай өнгөрөхийг шаардана. /3.2“б” дугаар зураг/

• **Нэг шар гэрэл**-Галт тэрэг гол замаар зогсоход бэлэн явж өртөөнд орохыг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио хаалттай. /3.3“а” дугаар зураг/

• **Хоёр шар гэрэл**-Галт тэрэг хажуугийн замаар зогсоход бэлэн бууруулсан хурдтай өртөөнд орохыг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио хаалттай. /3.3“в” дугаар зураг/


• **Дээд тал нь анивчсан хоёр шар гэрэл**-Галт тэрэг хажуугийн замаар орно, гэрлэн дохионы дэргэдүүр бууруулсан хурдтай өнгөрөхийг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио нээлттэй. /3.3“б” дугаар зураг/

• **Нэг улаан гэрэл**- Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно. /3.3“г” дугаар зураг/


• **Дээд тал нь анивчсан хоёр шар гэрэл**-Галт тэрэг хажуугийн замаар өртөөнд орно. Гэрлэн дохионы дэргэдүүр бууруулсан хурдтай өнгөрөхийг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио нээлттэй. /3.3“б” дугаар зураг/

• **Хоёр шар гэрэл**-Галт тэрэг хажуугийн замаар зогсоход бэлэн бууруулсан хурдтай өртөөнд орохыг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио хаалттай. /3.3“в” дугаар зураг/

• **Нэг улаан гэрэл**-Зогс! дохио өнгөрөхийг хориглоно. /3.3“г” дугаар зураг/




МОНГОЛ УРСЫН
ДАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
дарын 2018. 20 дугаар тушаал



3.3 дугаар зураг /а,б,в,г/

3.10. Урих дохиог оруулах, замналын, гаргах гэрлэн дохионд /бүлэглэснээс бусад/ байрлуулах ба дараахь дохиог өгнө.

- **Анивчсан нэг цагаан гэрэл** – Оруулах, замналын гэрлэн дохио нээгдэхгүй улаан гэрэлтэй /эсвэл унтарсан/ үед галт тэрэг дараагийн гэрлэн дохио /гаргах дохиогүй бол хүлээн авах замын хязгаарын шон/ хүртэл 20 км/цагаас ихгүй хурдтай, саад тохиолдвол яаралтай зогсоход бэлэн онцгой сэрэмжтэй хөдөлгөөнийг үргэлжлүүлэхийг зөвшөөрнө. /3.4 дүгээр зураг/




3.4 дүгээр зураг

МОНГОЛ УРСЫН
 ДАМ, ТЭЭВЭРИЙН ХЭВЭЖЛИЙН ЯАМ
 ЭХ ХУВЬ
 Санд Төрийн нарийн бичгийн
 дарга 2018 264 тушаал

3.11. Гаргах гэрлэн дохио дараахь дохиог өгнө.


3.11.1. хагас автомат хориглолоор тоноглогдсон хэсэгт гаргах гэрлэн дохио дараахь дохиог өгнө:

- **Нэг ногоон гэрэл**—Галт тэрэг тогтоосон хурдтай өртөөнөөс явахыг зөвшөөрнө. Дараагийн өртөө /замын пост/ хүртэл хоорондын зам чөлөөтэй. /3.5“а” дугаар зураг/
- **Хоёр шар гэрэл**—Галт тэрэг суман шилжүүлгийн хажуу байрлалаар бууруулсан хурдтайгаар өртөөнөөс явахыг зөвшөөрнө. Дараагийн өртөө хүртэл хоорондын зам чөлөөтэй. /3.5“б” дугаар зураг/
- **Нэг улаан гэрэл**—Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно. /3.5“в” дүгээр зураг/




3.5 дугаар зураг

3.11.2. хагас автомат хориглолоор тоноглогдсон хэсгийн өртөөнөөс салаалсан хоорондын замд галт тэрэг явуулахад гаргах гэрлэн дохион дээр шаардлагатай бол замнал заагчийг тавина.



- **Хоёр ногоон гэрэл**-Галт тэрэг салаалсан хоорондын замд явахыг зөвшөөрнө. Дараагийн өртөө хүртэл хоорондын зам чөлөөтэй. /3.7 дугаар зураг/



3.6 дугаар зураг /а,б/.

3.7 дугаар зураг


3.11.3. автомат хориглолтой хэсэгт гаргах гэрлэн дохио дараахь дохиог өгнө:

- **Нэг ногоон гэрэл**-Галт тэргийг өртөөнөөс тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө. Өмнөх хоёр болон түүнээс дээш хориг-хэсэг чөлөөтэй. /3.5“а” дугаар зураг/
- **Нэг шар гэрэл**-Галт тэрэг зогсоход бэлэн хурдтайгаар өртөөнөөс явахыг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио хаалттай. /3.6“а” дугаар зураг/
- **Дээд тал нь анивчсан хоёр шар гэрэл**-Галт тэрэг бууруулсан хурдтай өртөөний хажуугийн замаас явахыг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио нээлттэй. /3.6“б” дугаар зураг/
- **Хоёр шар гэрэл**-Галт тэрэг бууруулсан хурдтай өртөөний хажуугийн замаас явахыг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио хаалттай. /3.5“б” дүгээр зураг/
- **Нэг улаан гэрэл**-Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно. Дараагийн хориг-хэсэг эзэлгээтэй.


3.12. Халхлах гэрлэн дохио дараахь дохиог өгнө:

- **Нэг ногоон гэрэл**-Галт тэрэг тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө. /3.8“а” дугаар зураг/
- **Нэг улаан гэрэл**-Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно. /3.8“д” дугаар зураг/


3.13. Хаах гэрлэн дохио дараахь дохиог өгнө:



•Нэг улаан гэрэл-Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно. /3.8“а” дугаар зураг/



Хаах гэрлэн дохионы өмнөх анхааруулах гэрлэн дохионы нэг шар гэрлээр үндсэн гэрлэн дохионд улаан гэрэл асаж байгааг заана. /3.8“б” дугаар зураг/



3.8 дугаар зураг


МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Слид Төрлийн нарийн бичгийн
дэргэ 2018. 2004 тушаал

- Хаах гэрлэн дохио ба түүний анхааруулах гэрлэн дохио нь хэвийн байдалдаа асахгүй. Энэ байдалд гэрлэн дохио нь дохионы үүрэг гүйцэтгэхгүй. /3.8. "в" дугаар зураг/

3.14. Оруулах, өнгөрүүлэх, халхлах гэрлэн дохионы өмнө тавигдсан анхааруулах гэрлэн дохио дараахь дохиог өгнө:

• **Нэг ногоон гэрэл**-Галт тэрэг тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө. Үндсэн гэрлэн дохио, семафор нээлттэй. /3.9 дүгээр зураг/

• **Нэг шар гэрэл**-Галт тэрэг зогсоход бэлэн явахыг зөвшөөрнө. Үндсэн гэрлэн дохио, семафор хаалттай. /3.10 дугаар зураг/



3.9 дүгээр зураг.

3.10 дугаар зураг.

3.11 дүгээр зураг

• **Анивчсан нэг шар гэрэл**-Галт тэрэг тогтоосон хурдтай өнгөрөхийг зөвшөөрнө. Оруулах гэрлэн дохио нээлттэй. Оруулах гэрлэн дохионы дэргэдүүр бууруулсан хурдтай өнгөрөхийг шаардана.

3.15. Давтах гэрлэн дохио дараахь дохиог өгнө:

• **Нэг ногоон гэрэл**- Гаргах, замналын, довын гэрлэн дохио нээлттэй. /3.11 дүгээр зураг/



- Давтах гэрлэн дохионы гэрэл хэвийн байдалдаа асахгүй ба энэ байдалд дохионы үүрэг гүйцэтгэхгүй.

3.16. Замналын гэрлэн дохио дараахь дохиог өгнө:


- **Нэг ногоон гэрэл**-Галт тэрэг тогтоосон хурдтай өнгөрөхийг зөвшөөрнө. Дараагийн замналын ба гаргах гэрлэн дохио нээлттэй.
- **Нэг шар гэрэл**-Галт тэрэг зогсоход бэлэн гэрлэн дохионы дэргэдүүр өнгөрөхийг зөвшөөрнө. Дараагийн замналын ба гаргах гэрлэн дохио хаалттай.
- **Анивчсан нэг шар гэрэл**-Галт тэрэг тогтоосон хурдтай гэрлэн дохиог өнгөрөхийг зөвшөөрнө. Дараагийн замналын ба гаргах гэрлэн дохио нээлттэй, бууруулсан хурдтай өнгөрөхийг шаардана.
- **Дээд тал нь анивчсан хоёр шар гэрэл**-Галт тэрэг бууруулсан хурдтай хажуугийн замаар өнгөрөхийг зөвшөөрнө. Дараагийн замналын, гаргах гэрлэн дохио нээлттэй.
- **Хоёр шар гэрэл**-Галт тэрэг бууруулсан хурдтай гэрлэн дохиог өнгөрөхийг зөвшөөрнө. Хажуугийн зам руу орно. Дараагийн гэрлэн дохио хаалттай. Зогсоход бэлэн яв!
- **Нэг улаан гэрэл**-Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно.

3.17. Өнгөрүүлэх гэрлэн дохио автомат хориглолоор тоноглогдсон хоорондын замд дараахь дохиог өгнө.

- **Нэг ногоон гэрэл**- Галт тэрэг тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө. Өмнөх хоёр болон түүнээс дээш хори-хэсэг чөлөөтэй.
- **Нэг шар гэрэл**-Галт тэрэг зогсоход бэлэн өнгөрөхийг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио хаалттай.
- **Нэг улаан гэрэл**-Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно.


3.18. Автомат хориглол болон зүтгүүрийн автомат дохиоллоор тоноглогдсон хэсэгт зүтгүүрийн гэрлэн дохио дараахь дохиог өгнө:

- **Нэг ногоон гэрэл**-Хөдөлгөөнийг үргэлжлүүлэхийг зөвшөөрнө. Галт тэрэгний ойртож байгаа өнгөрүүлэх (замын) гэрлэн дохион дээр ногоон гэрэл асаалттай байна. /3.12"а" дугаар зураг/
- **Нэг шар гэрэл**-Хөдөлгөөнийг үргэлжлүүлэхийг зөвшөөрнө. Галт тэрэгний ойртож байгаа гэрлэн дохион дээр нэг шар эсвэл хоёр шар гэрэл асаалттай байна. /3.12"б" дугаар зураг/
- **Нэг шар гэрэл улаан гэрэлтэй хамт**-Зогсоход бэлэн явахыг зөвшөөрнө. Галт тэрэгний ойртож байгаа гэрлэн дохион дээр улаан гэрэл асаалттай байна. /3.12"в" дугаар зураг/



• Улаан гэрэл гэрлэн дохиог өнгөрөх тохиолдолд зүтгүүрийн гэрлэн дохион дээр улаан гэрэл асна. /3.12“г” дугаар зураг/

• **Нэг цагаан гэрэл**-Зүтгүүрийн бүхээгний дохиоллын төхөөрөмж хэвийн ажиллагаатай, зүтгүүрийн гэрлэн дохионд өнгөрүүлэх гэрлэн дохионы заалт дохио дамжихгүй байгааг илтгэнэ. Энэ тохиолдолд машинч зөвхөн замын гэрлэн дохионы заалтыг баримтлан хөдөлгөөнд оролцоно. /3.12.“д” дугаар зураг/




3.12 дугаар зураг

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТӨСВИРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Санд Төрийн нарийн бичгийн
дэргэ 2018 оны 264 дүгээр тушаал


3.19. Семафор дараахь дохиог өгнө:

3.19.1. едөр шонгоосоо 135 градусын өнцгөөр өргөгдсөн далавчаар, шөнө нэг ногоон гэрлээр галт тэргийг өртөөний гол замаар хүлээн авна. /3.13“а” дугаар зураг/




3.13 дугаар зураг /а/

3.13 дугаар зураг /б/



3.14 дугаар зураг




3.19.2. өдөр семафорын хөндлөн далавч буюу шөнө нэг улаан гэрэл - Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно. /3.13"б" дугаар зураг/

3.19.3. өдөр шонгоосоо 135 градусын өнцгөөр өргөгдсөн хоёр далавчаар, шөнө нэг ногоон, нэг шар гэрлээр галт тэргийг өртөөний хажуугийн замаар хүлээн авна. /3.14 дүгээр зураг/

3.19.4. хоёр далавчтай семафорын хоёр дахь далавч нь хаалттай байхдаа шонгийн дагуу байрлах бөгөөд дохионы гэрэл нь самбараар халхлагдаж, хоорондын замаар ирж буй галт тэргэнд үзэгдэхгүй.

3.19.5. семафорын далавчийн байдлыг шөнийн цагт өртөөний талаас шалгахад зориулсан хяналтын гэрлүүд байна. Семафор хаалттай байхад өртөөний талаас түүн дээр далавчийн тоогоор хяналтын тунгалаг цагаан гэрэл, нээлттэй байхад далавчийн тоогоор ногоон гэрлүүд тус тус харагдана.

3.19.6. байгаль, цаг уурын хүндрэлээс дохионы үзэгдэлт хангалтгүй бөгөөд хүлээн авах зам эзэлгээтэй эсвэл семафор гэмтэлтэй тохиолдолд өдөр, шөнийн аль ч цагт бялт тавина. Бялтыг семафороос замын хэвгийг харгалзан техник захирамжийн актаар тогтоосон тоормосын замын уртын зайд бялт тавих "Б" тэмдгийн харалдаа хөдөлгөөний чиглэлийн баруун гар талын зам төмөр дээр нэгдүгээр бялтыг, харин хоёрдугаар бялтыг хоорондын зам руу нэгдүгээр бялтаас 20 метр зайд хөдөлгөөний чиглэлийн зүүн гар талын зам төмөр дээр, гуравдугаар бялтыг хоорондын зам руу хоёрдугаар бялтаас 20 метрийн зайд хөдөлгөөний чиглэлийн баруун гар талын зам төмөр дээр тус тус тавина. /3.15 дугаар зураг/



3.15 дугаар зураг

3.19.7. семафор гэмтсэн тохиолдолд түүний далавчийг хаалттай байдалд оруулна. Шөнө болон цаг агаарын хүндрэлээс дохионы үзэгдэлт хязгаарлагдсан өдрийн цагт гэмтсэн семафорын дэнлүүний улаан гэрлийг асаана. Гэмтлийн улмаас далавчийг хаалттай байдалд оруулах боломжгүй байвал дэнлүүг асаалгүйгээр түүний харалдаа замын тэнхлэгт зөөврийн улаан дохиог байрлуулж, ажилтан томилж хамгаалуулна.

3.19.8. өртөөний оруулах семафор нээлттэй байдалд гэмтсэн, тэр тухай хоорондын замд яваа галт тэрэг урьдчилан мэдээгүй бөгөөд уг галт тэргийг өртөөн дээр хүлээн авах боломжгүй байвал зөөврийн улаан дохионоос гадна уг семафорын



цаана хоорондын зам талд техник захирамжийн актаар тогтоосон тоормосын замын хэмжээнд бялт тавина.


3.20. Хурд бууруулах байнгын зээрэнхий нь дараахь дохиог өгнө:

- **Шар зээрэнхий**-“Осолтой газрын эхлэл”, “Осолтой газрын төгсгөл” дохионы тэмдгээр хязгаарлагдсан осолтой газрыг суурь бүтэц эзэмшигчийн тушаалд заасан хурдтай өнгөрөхөд бэлтгэж хурдаа бууруулж явахыг зөвшөөрнө. /3.16“а” дугаар зураг/

- **Ногоон зээрэнхий**-Галт тэрэг осолтой газрыг өнгөрснийг заана. Энэ заалт нь хоорондын замд машинчид хөдөлгөөний чиглэлийн дагуу зүүн гар талд харагдана. Хурд бууруулах байнгын зээрэнхий нь шар өнгөтэй, ар тал нь ногоон өнгөтэй байх ба гэрэл ойлгогч материалаар хийгдсэн байна. /3.16“б” дугаар зураг/


3.20.1. суурь бүтэц эзэмшигчийн тушаалд заасан хурд бууруулах осолтой газрыг түүний захаас хоёр тийш 50 метрийн зайд “Осолтой газрын эхлэл”, “Осолтой газрын төгсгөл” гэсэн дохионы тэмдгээр хязгаарлана. /3.17 дугаар зураг/

3.20.2. энэ тэмдгээс 4.1 дүгээр хүснэгтэд үзүүлсэн баримтлах хэвгий, хөдөлгөөний хурдаас хамаарсан “А” зайд хурд бууруулах байнгын зээрэнхийг байрлуулна.



3.16 дугаар зураг


МОНГОЛ УРСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нурууны бичгийн
дэргэд 2018. 204




3.17 дугаар зураг

ТАЙЛБАР: Энэ журамд орсон бүдүүвч мөн 3.17 дугаар зураг болон 3.1 дүгээр хүснэгт дэх зайн хэмжээг метрээр илэрхийсэн болно.

3.21. Ажиллагаанд оруулаагүй гэрлэн дохио, семафорыг хаалттай байдалд оруулан /гэрлэн дохиог унтрааж/ чэгтлэн хөндлөн хоёр модыг шонд байрлуулна. /3.18 дугаар зураг/




3.18 дугаар зураг



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЗӨӨВРИЙН ДОХИО

4.1. Зөөврийн дохионд ар, өвөр тал нь гэрэл ойлгогч бүхий улаан өнгийн тэгш өнцөгт дөрвөлжин самбар, нэг тал нь шар, нөгөө тал нь ногоон өнгийн тэгш өнцөгт дөрвөлжин самбар, урт ишин дээр байрлуулсан улаан гэрэлтэй дэнлүү, улаан, шар дарцаг хамаарагдана.



4.1 дүгээр зураг

4.2. Зөөврийн дохиогоор дараахь шаардлагыг тавина.


4.2.1. өдөр улаан өнгөтэй тэгш өнцөгт дөрвөлжин самбар буюу улаан дарцаг, шөнө урт ишин дээр байрлуулсан дэнлүүний улаан гэрлээр «Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно» гэсэн дохиог өгнө. /4.1“а” дүгээр зураг/

4.2.2. өдөр, шөнө шар өнгийн дөрвөлжин самбараар “Зогсоох буюу хурд бууруулж өнгөрөх шаардлагатай, осолтой газар дөхөж байна. Бууруулсан хурдтай яв!” гэсэн дохиог өгнө. /4.1“б” дүгээр зураг/

4.2.3. ертөөний зам дээр байрлуулсан шар өнгөтэй тэгш өнцөгт дөрвөлжин самбар бүхий зөөврийн дохио /4.1“б” дүгээр зураг/-ны дэргэдүүр 25 км/цагаас ихгүй хурдтай өнгөрнө.

4.2.4. өдөр, шөнийн аль ч цагт урт ишинд байрлуулсан ногоон өнгийн дөрвөлжин самбар нь галт тэрэг осолтой газраар өнгөрсөн болохыг заана. /4.1“в” дүгээр зураг/


4.2.5. зөөврийн дохионы ишийг дохионы үндсэн өнгө ба цагаан өнгөөр алаглуулж будсан байна.




4.3. Галт тэрэгний хөдөлгөөнд саадтай газар болон хоорондын замд ажил хийх газрыг дараахь байдлаар хамгаална.

4.3.1. галт тэрэг ирэх эсэхийг үл харгалзан хоорондын замд хөдөлгөөнд саад гарсан газрыг зогсоох дохиогоор 4.2"а, б" дугаар зурагт заасан бүдүүвчийн дагуу хааж хамгаална.


4.3.2. хоорондын замд хийгдэх ажил нь галт тэргийг зогсоохоор байвал уг газрыг саадтай газрын нэгэн адил хамгаална.



4.2 дугаар зураг /а, б/



4.2 дугаар зураг /в, г/





4.4 дүгээр зураг

4.3.12. Бялтыг эхний "Б" зайд байрлах/ бялтаас саадтай газар тийш 20 метр зайд улаан дохио барьсан төмөр замын ажилтан хамгаална. /4.4 дүгээр зураг/

Тайлбар: 4.1 дүгээр хүснэгтийн "Б"-д саадтай ба ажил хийх газарт хориг хамгаалалт тавих зайг хоорондын замын баримтлах хэвгий ба галт тэрэгний хурдтай уялдуулан заасан болно.

4.1 дүгээр хүснэгт

Хоорондын замд гарсан саад болон осолтой газарт хурд
бууруулах дохио, бялт тавих зай

Д/д	Хоорондын замын баримтлах хэвгий ба галт тэрэгний хөдөлгөөний хурд	Осолтой газрын эхлэл тэмдгээс хурд бууруулах дохио хүртэл зай /А/	Зөөврийн улаан дохио ба гэнэт гарсан саадтай газраас нэгдүгээр бялт хүртэлх зай /Б/
1	0,006-гаас бага баримтлах хэвгийтэй хоорондын замд ачааны галт тэрэгний хурд 80 км/цагаас ихгүй, зорчигчийн галт тэрэгний хурд 100 км/цагаас ихгүй байхад	800	1000
2	0,006-0,014 баримтлах хэвгийтэй хоорондын замд ачааны галт тэрэгний хурд 80 км/цагаас ихгүй, зорчигчийн галт тэрэгний хурд 100 км/цагаас ихгүй байхад	1000	1200
3	0,014-ээс дээш хэмжээний баримтлах хэвгийтэй хоорондын замд	1300	1600

4.3.13. нэг замтай хэсэгт галт тэрэг аль талаас ирэх нь мэдэгдэхгүй байвал дохиог эхлээд уруудуур талд, тэгш зам дээр бол эхлээд тахир буюу сэтэрхий талд тус тус тавина. /4.4 дүгээр зураг/




4.4. Бялтыг ямар ч үед гурван ширхэгийг тавина. Үүнд: хоёрыг галт тэрэгний хөдөлгөөний чиглэлийн дагуу баруун талын зам төмөр дээр, нэгийг зүүн талын зам төмөр дээр түрүүчийн хоёр бялтын дунд тавина. Бялт хоорондын зай 20 метр байна.

4.5. Хурд бууруулах зөөврийн дохиог байнгын дохионы бүдүүвчийн дагуу байрлуулна. /3.17 дугаар зураг/


4.5.1. машинч нь зөөврийн шар дохионд ойртон очихдоо зүтгүүрийн шүглээр нэг урт дохио өгөх бөгөөд «Осолтой газрын эхлэл» /4.5.“а” дугаар зураг/ ба «Осолтой газрын төгсгөл» /4.5.“б” дугаар зураг/ гэсэн дохионы тэмдгээр хязгаарлагдсан газрыг анхаарамжид заасан хурдтай, харин анхаарамж олгоогүй бол 25 км/цагаас ихгүй хурдтай өнгөрөхөөр галт тэргийг жолоодно.


4.5.2. хурд бууруулах шаардлагатай газар нь өртөөнд ойрхон байснаас хурд бууруулах дохиогоор тогтоосон бүдүүвчийн дагуу хамгаалах боломжгүй бол шар самбарыг гаргах суман шилжүүлгийн шорын үзүүрийн харалдаа тавьж, осолтой газрын төгсгөлөөс 50 метр зайд «Осолтой газрын эхлэл» тэмдгийг тавина. /4.6 дугаар зураг/

4.6. Зогсоох буюу хурд бууруулах дохиогоор хаах шаардлагагүй боловч галт тэрэг ойртож буйг ажилтан нарт анхааруулах шаардлагатай ажил хийж байгаа газрыг мөн түүнчлэн зэрэгцээ гол замын тухайн хэсгийг замын хажууд байрлуулсан шүгэл дуугаргахыг шаардах “Ш” гэсэн тэмдэгтэй /4.2.“б”, 4.3, 4.6, 4.7 дугаар зураг/ зөөврийн дохиогоор хамгаална.



4.5 дугаар зураг /а, б/





4.6 дугаар зураг




4.7 дугаар зураг

4.7. Өртөөн дээрх галт тэрэгний хөдөлгөөнд саадтай ба ажил хийж байгаа газрыг дараахь байдлаар хамгаална.

4.7.1. галт тэрэг /сэлгээний бүрэлдэхүүн /хүлээж байгаа эсэхийг үл харгалзан өртөөний зам болон суман шилжүүлгийн ажиллагаанд саад гарвал уг газрыг зогсоох дохиогоор хамгаална.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрлийн харьяан бичгийн
дэргэд 2018 209 тушаал



4.8 дугаар зураг

4.7.2. өртөөний зам дээрх саадтай буюу ажил хийж байгаа газрыг зогсоох дохиогоор хамгаалахдаа энэ газар руу хөдлөх бүрэлдэхүүн орж чадахгүй байдалд холбогдох бүх сумыг тавьж цоожлох буюу хадна. Саадтай буюу ажил хийж байгаа газрын замын голд зөөврийн улаан дохио байрлуулна. /4.8. "а" дугаар зураг/


4.7.3. суман шилжүүлгийн аль нэгний шор саадтай буюу ажил хийж байгаа газар руу чиглэсэн бөгөөд замыг тусгаарлах бололцоогүй байвал саадтай буюу ажил хийж байгаа газрын заагаас 50 метрийн зайд зөөврийн улаан дохио байрлуулна. /4.8"б" дугаар зураг/

4.7.4. суман шилжүүлгийн шор нь саадтай буюу ажил хийж байгаа газарт 50 метрээс ойр байрласан байвал шорын хооронд зөөврийн улаан дохио байрлуулна. /4.8"в" дугаар зураг/


4.7.5. суман шилжүүлэг дээрх саадтай буюу ажил хийж байгаа газрыг зөөврийн улаан дохиогоор хамгаалахдаа тонолжийн талаас бол нийлсэн зам тус бүрийн голд хязгаарын шонгийн харалдаа, нөгөө талаас бол сумын шороос 50 метрийн зайд уул дохиог тус тус байрлуулна. /4.9"а" дүгээр зураг/

4.7.6. хамгаалбал зохих суман шилжүүлгийн ойролцоо уул саадтай суман шилжүүлэг рүү хөдлөх бүрэлдэхүүн оруулахгүй байх боломжтой өөр суман шилжүүлгийг байрлуулсан байвал тэдгээр суман шилжүүлгийг тэр байдалд нь шилжүүлж цоожлох буюу хадна. Энэ тохиолдолд уул тусгаарлагдсан суман шилжүүлгийн талд зөөврийн улаан дохио тавихгүй. /4.9"б" дүгээр зураг/

4.7.7. саад тохиолдсон ба ажил хийж байгаа газар нь оруулах суман шилжүүлэг дээр байвал түүнийг хоорондын замын талаас хориглосон заалттай оруулах дохиогоор хаах бөгөөд өртөөний талаас нийлсэн зам тус бүр дээр




хязгаарын шонгийн харалдаа зөөврийн улаан дохио байрлуулж хаана. /4.9"в" дүгээр зураг/




4.9 дүгээр зураг

4.7.8. саадтай буюу ажил хийж байгаа газар нь оруулах суман шилжүүлэг, оруулах дохио хоёрын хооронд байвал уул газрыг хоорондын зам талаас хориглосон заалттай оруулах дохиогоор, өртөөний талаас оруулах суман шилжүүлэгийн шорын хооронд байрлуулсан зөөврийн улаан дохиогоор тус тус хамгаална. /4.9"г" дүгээр зураг/


4.7.9. суман шилжүүлэг дээр саад тохиолдсоныг илрүүлсэн ажилтан саадтай газарт /засварын ажил эхэлтэл/ нэн даруй зөөврийн улаан дохио тавьж тэр тухайгаа өртөөний жижүүрт мэдэгдэнэ.



4.10 дугаар зураг



4.7.10. Өртөөн дээр зэргэлдээ замаар нь хөдлөх бүрэлдэхүүн өнгөрөхөд саад болох газарт галт тэрэг зогссон үед уул зогссон галт тэрэгний хажуугаас хөдлөх бүрэлдэхүүн орж болох замыг зогсох дохиогоор хамгаална. /4.10 дугаар зураг/



4.12 дугаар зураг

4.7.11. Өртөөний гол замаар өнгөрөх галт тэрэг болон хөдлөх бүрэлдэхүүний хурдыг анхаарамжид заасан хэмжээнд хүртэл бууруулах шаардлагатай газрыг хурд бууруулах зөөврийн дохиогоор 4.11 дүгээр зурагт үзүүлсэн бүдүүвчийн дагуу



4.7.12. Өртөөний бусад замд хурд бууруулах шаардлага гарвал зөөврийн шар дохиогоор хамгаална. /4.12 дугаар зураг/

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сэлэн Төршн нэрийн бичгийн
даргаар /.../ тушаалаа
2012 264

4.8. Өртөөний зам дээр байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг дараахь байдлаар хамгаална.


4.8.1. өртөөний зам дээр засварлаж байгаа болон тусгай зориулалтын зам дээр байгаа аюултай ачаатай, түүнчлэн шахсан, шингэрүүлсэн хий ачсан вагоныг зам дээр нь хоёр талаас нь, мухар зам дээр бол суман шилжүүлгийн талаас 50 метрээс багагүй зайтай замын голд зөөврийн улаан дохио тавина.

4.8.2. дээрх вагоны захын вагон нь хязгаарын шон хүртэл 50 метрээс бага зайд байвал тэр талд зөөврийн улаан дохиог хязгаарын шонгийн харалдаа замын голд тавьж хаана. Аюултай ачаатай болон шахсан, шингэрүүлсэн хий ачсан мөн түүнчлэн шахсан, шингэрүүлсэн хийнээс суларсан вагон зогсож байгаа зам руу оруулах суман шилжүүлгийг уг замд орохооргүй байдалд тавьж зүүдэг цоожоор цоожилсон байна.


4.9. Хоорондын замд аргагүйдэн зогссон үед галт тэргийг дараахь байдлаар хамгаална.

4.9.1. хоорондын замд аргагүйдэн зогссон галт тэргийг хамгаалахдаа энэхүү журамд зааснаар машинч галт тэрэгний бүрэлдэхүүний ажилтнуудыг галт тэргийг хамгаалах ажилд татан оролцуулж гүйцэтгүүлэх ба хэрэв эдгээр ажилтнуудаас ойролцоо байхгүй бол туслах машинчаар гүйцэтгүүлнэ.

4.9.2. зорчигчийн галт тэрэг хоорондын замд аргагүйдэн зогсож туслах зүтгүүр шаардсан бол тусламж ирэхийг хүлээж байгаа талд нь /галт тэрэгний толгой талаас ирэх бол туслах машинч, сүүлийн талаас бол сүүлийн вагоны үйлчлэгч/ 800 метрийн зайд бялт тавьж, тэрхүү бялт тавьсан газраас галт тэрэгний зүгт 20 метр зайд дээр дурдсан ажилтнаар улаан дохио бариулж хамгаалуулна. /413 дугаар зураг/



4.13 дугаар зураг




4.9.3. Тусламж хаанаас ирэх нь мэдэгдэхгүй тохиолдолд дээрх ажилтнуудаас галт тэрэгний толгой ба сүүл талаас тус тус 800 метрийн зайд бялт тавиулан дээрхийн нэгэн адил хамгаалуулна.

4.9.4. сэргээн босгох буюу галын галт тэрэг түүнчлэн туслах зүтгүүр шаардсан бол тусламж ирэх талд /4.14 дүгээр зураг/ туслах машинч, харин чухам хаанаас ирэх нь мэдэгдэхгүй байгаа бол толгой ба сүүл талд /4.15 дугаар зураг/ хаалт хамгаалалт тавина. Хаалт хамгаалалт тавихдаа хэрэв галт тэргэнд машинч, туслах машинч нараас өөр төмөр замын ажилтан байгаа бол түүнийг толгой талд томилон хамгаалуулна, байхгүй бол туслах машинч нь толгой талаас 800 метрийн зайд 3 бялт тавьсны дараа сүүл талд очиж галт тэрэгний сүүлээс 800 метрийн зайд бялт тавьж тэндээ улаан дохио барин 4.13 дугаар зурагт заасны нэгэн адил хамгаална.


4.9.6. галт тэрэг хамгаалсан ажилтан бялтыг хураан авч галт тэрэг рүүгээ буцаж явахдаа улаан дохиог хоорондын зам руу харуулсаар явах бөгөөд галт тэргэндээ ирмэгц энэ тухайгаа өдөр бол дэлгэсэн шар дарцаг, шөнө бол тунгалаг цагаан гэрэлтэй дохионы гар дэнлүүгээр /7.4 дүгээр зурагт зааснаар/ толгой дээгүүрээ даллаж дохио өгнө.

4.9.7. хэрэв сэргээн босгох буюу галын галт тэрэг, туслах зүтгүүрийг дуудахтай холбогдуулан хаалт, хамгаалалтын дохио тавьсан бол галт тэрэг буюу зүтгүүр дохионы дэргэд ирж зогссоны дараа түүнийг хурааж авна.



4.14 дүгээр зураг

4.15 дугаар зураг



4.9.8 галт тэрэг хоорондын замд зогссон ба түүнийг өртөөнд хэсэгчлэн зөөх үед хоорондын замд үлдсэн хэсгийг толгой талд нь 300 метрийн зайд бялт тавьж хамгаална.

ТАВДУГААР БҮЛЭГ ГАР ДОХИО


5.1. Гар дохионы хэрэгслээр дараахь дохиог өгнө.

5.1.1. өдөр дэлгэсэн улаан дарцаг, шөнө гар дэнлүүний улаан гэрэл – “Зогс!” хөдөлгөөнийг хориглоно. /5.1 дүгээр зураг/



5.1 дүгээр зураг


5.1.2. өдрийн цагт улаан дарцаггүй, шөнийн цагт улаан гэрэлтэй дэнлүүгүй байвал өдөр шар дарцаг, өөр ямар нэгэн зүйлээр, шөнө ямар ч хамаагүй өнгийн гэрэлтэй гар дэнлүүг гараараа бүтэн тойргоор эргүүлж зогсоох дохио өгнө. /5.2 дугаар зураг/





5.2 дугаар зураг

5.1.3. өдөр дэлгэсэн шар дарцаг, шөнө гар дэнлүүний шар гэрэл-анхаарамж бичигт буюу суурь бүтэц эзэмшигчийн тушаалд заасан хурдаар явах, харин анхаарамж бичиггүй бол 25 км/цагаас дээшгүй хурдтай явахыг зөвшөөрнө. /5.3 дугаар зураг/



5.3 дугаар зураг

5.4 дүгээр зураг

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХЭГ ЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Санд Торжийн нарийн бичгийн
даргын тушаал
2018 264

5.1.4. гар дэнлүүний шар гэрлийг зөвхөн өртөөн дээр хэрэглэнэ. Шөнийн цагт шар гэрэлтэй дэнлүү байхгүй байвал өртөөн дээр хурд бууруулах дохиог тунгалаг цагаан гэрэлтэй дэнлүүгээр дээш доош нь алгуур хөдөлгөж өгнө. /5.4 дүгээр зураг/

5.1.5. хоорондын замд хурд бууруулах заалтыг ямар ч тохиолдолд шөнө тунгалаг цагаан гэрэлтэй дэнлүүгээр дээш, доош нь алгуур хөдөлгөж өгнө.

5.2. Автомат тоормосыг шалгах үед дараахь дохиог өгнө.

5.2.1. хэлж анхааруулсны дараа машинчаас тоормос туршихыг шаардахдаа, өдөр гараа эгц дээш нь өргөж, шөнө тунгалаг цагаан гэрэлтэй гар дэнлүүг мөн дээш нь өргөж дохио өгнө. /5.5 дугаар зураг/





5.5 дугаар зураг

5.2.2. машинч зүтгүүрийн шүглийг нэг богино дуугаргаж хариу дохио өгөөд тоормослож эхэлнэ.

5.2.3. тоормос суллахыг машинчаас шаардахдаа өдөр гараа сунгаж өөрийнхөө урдуур хоёр тийш нь хөдөлгөж, шөнө тунгалаг цагаан гэрэлтэй дэнлүүг мөн урдаа хоёр тийш нь хөдөлгөж дохио өгнө. /5.6 дугаар зураг/


5.2.4. машинч зүтгүүрийн шүглийг хоёр богино дуугаргаж хариу дохио өгөөд тоормосоо суллана.






5.6 дугаар зураг

5.2.5. галт тэргийг явуулах буюу өртөөгөөр зогсолтгүй өнгөрүүлэхдээ өртөөний жижүүр нь өдөр хуйлсан шар дарцаг, шөнө ногоон гэрэлтэй гар дэнлүүг тус тус дээш нь өргөн үзүүлж дохио өгнө. /5.7 дугаар зураг/ Энэ дохио нь галт тэрэг өртөөгөөр өнгөрөхдөө тогтоосон хурдаар явж болохыг заана.



5.7 дугаар зураг

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Торжон ирлийн бичгийн
дэргэцэнэ /2018/ 2699



5.8 дугаар зураг

5.2.6. цагийн хуваариар зогсолтгүй өнгөрөх галт тэргийг өртөөн дээр зогсоох шаардлага тохиолдвол өртөөний жижүүр өдөр улаан өнгийн гар зээрэнхий буюу дэлгэсэн улаан дарцаг, шөнө улаан гэрэлтэй гар дэнлүү барьж дохио өгнө. /5.8 дугаар зураг/

5.2.7. цагийн хуваариар зогсох галт тэргийг өртөөний жижүүр угтаж авахдаа зогсох дохио өгөхгүйгээр гар дохиог биедээ авч явбал зохино.

5.3. Өртөөний жижүүрийн байрыг сумчны байранд нэгтгэсэн хэсэглэх газруудад өртөөний жижүүр галт тэргийг дараахь журмаар угтаж, үднэ.

5.3.1. галт тэргийг явуулах, өртөөгөөр зогсолтгүй өнгөрүүлэхдээ өдрийн цагаар хуйлсан шар дарцаг, шөнийн цагаар ногоон гэрэлтэй гар дэнлүүг дээш нь өргөн дохио өгнө. Энэ үед галт тэргийг өртөөгөөр зогсолтгүй өнгөрүүлэхдээ хоорондын зам эзлэх эрхийн очирьг машинчид зөвхөн оруулах сумчны байранд гардуулан өгнө.


5.3.2. цагийн хуваариар зогсох галт тэргийг оруулах сумчны байранд өдрийн цагаар дэлгэсэн шар дарцаг, шөнийн цагаар гар дэнлүүний шар гэрлээр дохио өгч угтах ба гаргах сумчны байранд өдрийн цагаар хуйлсан шар дарцаг, шөнийн цагаар тунгалаг цагаан гэрэлтэй гар дэнлүүгээр дохио өгнө. /5.9 дүгээр зураг/

5.3.3. цагийн хуваариар зогсолтгүй өнгөрөх галт тэргийг өртөөн дээр зогсоох шаардлага тохиолдвол оруулах сумчны байранд өдрийн цагаар дэлгэсэн шар дарцаг, шөнийн цагаар гар дэнлүүний шар гэрлээр дохио өгч угтах ба гаргах сумчны байранд өдрийн цагаар дэлгэсэн улаан дарцаг, шөнийн цагаар улаан гэрэлтэй гар дэнлүү барьж дохио өгнө.




5.4. Сумчин, дохиочин, жижүүр галт тэргийг угтаж авахдаа:

5.4.1. ертөөн дээр гол замаар зогсолтгүй шууд өнгөрүүлэх галт тэргийг өдрийн цагаар хуйлсан шар дарцаг, шөнийн цагаар тунгалаг цагаан гэрэлтэй гар дэнлүү барьж угтана.



5.9 дүгээр зураг



5.10 дугаар зураг

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
дарга *2018 20/11*

5.4.2 галт тэргийг хажуугийн замаар, өртөөн дээр зогсолттой хүлээж авахдаа өдрийн цагаар дэлгэсэн шар дарцаг, шөнийн цагаар шар гэрэлтэй гар дэнлүү барьж угтана. /5.10 дугаар зураг/

5.4.3. өртөөний жижүүрийн байрыг сумчны байранд нэгтгэсэн хэсэглэх газарт цагийн хуваариар зогсолтгүй өнгөрөх галт тэргийг зогсолттой хүлээн авах үед гаргах сумчны байранд өдрийн цагаар дэлгэсэн улаан дарцаг, шөнийн цагаар улаан гэрэлтэй гар дэнлүү барьж дохио өгнө.

5.4.4. өртөөнөөс гарч байгаа галт тэргийг сумчин өдрийн цагт хуйлсан шар дарцаг, шөнийн цагаар тунгалаг цагаан гэрэлтэй гар дэнлүү барьж үднэ.

5.5. Зогсоох дохиог галт тэрэгнээс өгөхдөө өдрийн цагаар дэлгэсэн улаан дарцаг, шөнийн цагаар гар дэнлүүний улаан гэрлээр түүчээ зүтгүүрийн машинчийн зүг харуулж өгнө.

5.6. Зорчигчийн галт тэрэгний үндсэн болон эргэлтийн өртөөнөөс хөдлөх үед вагоны үйлчлэгч нар зорчигчийг бүрэн буулган, суулгаж, аюулгүй байдлыг хангасны дараа эхний болон сүүлийн вагоны үйлчлэгч нар өдрийн цагаар хуйлсан шар дарцаг, шөнийн цагаар гар дэнлүүний тунгалаг цагаан гэрлийг зорчигчийн тавцангийн зүг түүний төгсгөлийг хүртэл харуулна. Энэ нь жижүүрт галт тэргийг хэвийн аялж байгааг илтгэнэ.

5.7. Зорчигчийн галт тэргийг зогссоны дараа өртөөнөөс явуулах үед зорчигчийн вагоны үйлчлэгч нар өдрийн цагаар хуйлсан шар дарцаг, шөнийн цагаар гар дэнлүүний тунгалаг цагаан гэрлийг зорчигчийн тавцангийн зүг түүний төгсгөлийг хүртэл харуулна. Энэ нь жижүүрт галт тэргийг хэвийн аялж байгааг илтгэнэ.


5.8. Замын хэсэг болон зөвшөөрөгдсөн газарт зорчигчийн галт тэрэг зогсмогц вагоны үйлчлэгч нар вагоныхоо хаалгыг онгойлгож зорчигчийг буулгасны дараа өдрийн цагаар хуйлсан шар дарцаг, шөнийн цагаар гар дэнлүүний тунгалаг цагаан гэрлийг машинчид харуулна. Машинч уг дохиогоор хөдөлгөөнөө үргэлжлүүлнэ.


5.9. Төмөр замын тахир хэсэгт зорчигчийн галт тэрэгний сүүлчийн вагоны үйлчлэгчийн тахирын дотор талаас өгсөн дохиог бүх үйлчлэгч нар дамжуулан зүтгүүрийн бригадад өгнө.

5.10. Үзэгдэх орчин хязгаарлагдсанаас дохионы үзэгдэлт муудсан үед сүүлчийн вагоны үйлчлэгчээс зүтгүүрийн бригадад өгсөн дохиог бусад вагоны үйлчлэгч нар харилцан дамжуулна.

5.11. Хоорондын замд зам, гүүр нурж болох газрын замын эргүүл ба гармын жижүүр зам чөлөөтэй үед галт тэргийг угтаж өнгөрүүлэхдээ хөдөлгөөний чиглэлийн дагуу зогсож, өдрийн цагаар хуйлсан шар дарцаг, шөнийн цагаар гар дэнлүүний тунгалаг цагаан гэрэл харуулна. /5.11 дүгээр зураг/

5.12. Тухайн газарт хурд хязгаарласан бол дээр дурдсан ажилтнууд түүнтэй зохицох дохиог галт тэргэнд өгнө.





5.11 дүгээр зураг

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ДОХИОНЫ ТЭМДЭГ БА ЗААГЧ

6.1. Галт тэрэг ба сэлгээний бүрэлдэхүүн хүлээж авах зам болон явуулах чиглэлийг заах шаардлагатай тохиолдолд замналын чиглэлийг заах /тоо, үсэг, байдлын/ цагаан өнгийн гэрэлтэй замнал заагчийг хэрэглэнэ.

6.1.1. замнал заагчийг гэрлэн дохионы багана эсвэл тусгай баганад байрлуулна. /6.1“а” дүгээр зураг/

6.1.2. галт тэрэг явуулахыг зөвшөөрсөн замын дугаарыг заах ногоон гэрэлтэй замнал заагчийг бүлэг замын гаргах ба замналын гэрлэн дохионд суурилуулна. /6.1“б” дүгээр зураг/


6.2. Гар суман шилжүүлгийн гэрэл ойлгогчтой заагч дараахь байдлаар заалт өгнө.

6.2.1. суман шилжүүлгийг шулуун замд шилжүүлсэн байхад суман шилжүүлгийн заагчийн ирмэг харагдана. /6.2.“а” дугаар зураг/


6.2.2. “Б” тэмдэг нь /3.15 дугаар зураг/ анхааруулах дохиогүй оруулах семафорын өмнө бялт тавих газрыг заана.

Суман шилжүүлгийг хажуугийн замд шилжүүлсэн байхад суман шилжүүлгийн заагчийн цагаан дэвсгэр дээр хажуугийн зам руу чиглэсэн хар сум харагдана. /6.2“б” дугаар зураг/






6.1 дүгээр зураг




6.2 дугаар зураг

6.3. Мухар замын хаалтын заагчийг тулгуур модны баруун үзүүр дээр зөвхөн зам руу харуулж байрлуулна. /6.3 дугаар зураг/

6.3.1. замын хаалтын заагч нь гэрэл ойлгогчтой байж болох ба түүнийг ертөөний техник захирамжийн актаар тогтооно.






6.3 дугаар зураг

6.4. Хязгаарын шон гэж суман шилжүүлэг ба огтлолцлын чиглэлд уг шонгоос цааш хөдлөх бүрэлдэхүүн зогсоож үл болох газрыг заана /6.4 дүгээр зураг/. Нийлсэн хоёр замын тэнхлэгүүдийн хоорондох зай Техник ашиглалтын журамд заасан хэмжээнд хүрсэн газарт хязгаарын шонг байрлуулна.




6.4 дүгээр зураг

6.5. "Өртөөний зааг" тэмдэг нь хоёр ба түүнээс олон зам бүхий хоорондын зам өртөөний хязгаарыг илэрхийлнэ. /6.5 дугаар зураг/



6.6. Байнгын тэмдэг болох "Осолтой газрын эхлэл" /6.6"а" дугаар зураг/, "Осолтой газрын төгсгөл" /6.6"б" дугаар зураг/ тэмдэг нь галт тэрэг, бага хурдтай явахыг шаардах замын хэсгийг заана.

6.6.1. "Осолтой газрын төгсгөл" дохионы тэмдгийг "Осолтой газрын эхлэл" гэсэн тэмдгийн ар тал дээр хийнэ.




6.5 дугаар зураг

6.6 дугаар зураг

6.6.2. "Осолтой газрын төгсгөл" болон "Осолтой газрын эхлэл" гэсэн тэмдгийг тус тус байрлуулна.

6.7. Анхааруулах дохионы тэмдэг нь дараахь байдлаар заалт өгнө.




6.7 дугаар зураг

6.8 дугаар зураг


МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
дэргэдгээр 2018.06.04 тушаалт

6.7.1. “Ш” тэмдэг нь гүүр, гарам, хонгил, тахир тойруу ба үзэгдэх орчин хязгаарлагдсан хэсэгт галт тэрэг ойртож ирэхэд шүгэл дуугаргах газрыг заана. /6.7, 6.8 дугаар зураг/

6.7.2. “Д” тэмдэг автомат хориглолын үед сунгуу өгсүүр газар улаан дохиог өнгөрч болох газар тавина. /6.9 дүгээр зураг/



6.9 дүгээр зураг




6.10 дугаар зураг


6.7.3. Тоормос шалгах газрын заагч “Т” тэмдэг нь хоорондын замд галт тэрэгний тоормосны найдвартай ажиллагааг шалгах газрыг заана.

• “Т1”-Галт тэрэгний тоормосыг бариулж, тоормосын найдвартай ажиллагааг шалгаж эхлэх газрыг заана. /6.10 дугаар зураг/

• “Т2”-Галт тэрэгний хурд **10 км/цаг** болон түүнээс дээш буурсан байх үеийн тоормосын замыг заана. /6.11 дүгээр зураг/

• “Т3”-Галт тэрэгний хурд “Т2” тэмдэг хүртэл **10 км/цагаар** буурч чадаагүй боловч “Т3” тэмдэг хүртэл **10 км/цаг** ба түүнээс дээш хэмжээгээр буурч байвал уг галт тэргийг **25 км/цагаас** ихгүй хурдтай дараагийн өртөө хүртэл явахыг зөвшөөрнө. Хэрэв “Т3” тэмдгийн дэргэд ирэх үед галт тэрэгний хурд **10 км/цагаас** багагүй хэмжээгээр буураагүй тохиолдолд яаралтай зогсож шалтгааныг тодруулахыг машинчаас шаардана. /6.12 дугаар зураг/





6.11 дүгээр зураг

6.12 дугаар зураг

6.7.4. "Түлхэлт эхлэх" /6.13 дугаар зураг/, "Түлхэлт дуусах" /6.14 дугаар зураг/ тэмдгийг суурь бүтэц эзэмшигчийн шийдвэрээр тогтоосон газарт байрлуулна.



6.13 дугаар зураг

6.14 дүгээр зураг


МОНГОЛ УЛСЫН
 ДАМ, ТЭЭВРИЙН ХЭГ АЖЛИЙН ЯАМ
 ЭХ ХУВЬ
 Саид Төршүүрчигийн бичгийн
 дарга 2018. 2.6.18

6.7.5. "Зүтгүүрийг зогсоо" тэмдгийг байрлуулах газрыг суурь бүтэц эзэмшигчийн томилсон комисс тогтооно. /6.8 дугаар зураг/

6.8. Цас цэвэрлэгч ажиллах хэсэгт дохионы дараахь түр тэмдэг хэрэглэнэ.

6.8.1. саадтай газрын өмнө "Хусуураа өргөн далавчаа эвх" гэсэн тэмдэг тавина. /6.16 дугаар зураг/

6.8.2. саадтай газар өнгөрсний дараа "Хусуураа буулгаж, далавчаа дэлгэ" гэсэн тэмдэг тавина. /6.17 дугаар зураг/



6.16 дугаар зураг


6.17 дугаар зураг

6.18 дугаар зураг

6.8.3. Цас цэвэрлэгч ажилладаг замын хэсэгт "Хусуураа өргөн далавчаа эвх" тэмдгийн өмнө "Далавчаа эвхэж, хусуураа өргөхөд бэлтгэ" дохионы түр тэмдгийг тавина. /6.18 дугаар зураг/

6.8.4. Цас цэвэрлэгч ажилладаг замын хэсэгт дохионы түр тэмдгийг 6.19 дугаар зурагт заасны дагуу байрлуулна.





6.19 дугаар зураг


6.8.5. ойролцоо байрласан хоёр саадын хооронд цас цэвэрлэгч ажиллаж болохгүй байвал нэг ишинд хоёр тэмдгийг цувуулан тавина. /6.20 дүгээр зураг/



6.20 дүгээр зураг

6.9. Радио сувгаар галт тэрэгний хөдөлгөөнийг хоорондын зай, хугацаагаар зохицуулах систем /СИРДП-Е/-ээр тоноглогдсон хэсэглэлд дараахь нэмэлт байнгын дохионы тэмдгүүдийг хэрэглэнэ:

6.9.1. "Радио хориглолын бүсийн эхлэл"—улаан хүрээтэй цагаан дэвсгэр бүхий гурвалжин тэмдгийг цамхаг буюу шон дээр суурилуулна. Радио хориглолын систем үйлчлэх бүсийн эхлэлийг заана. /6.21 дугаар зураг/





6.21 дүгээр зураг

6.9.2. "Радио хориглол залгах"–хар хүрээтэй цагаан дэвсгэр бүхий гурвалжин тэмдгийг цамхаг буюу шон дээр суурилуулна. Машинч тэмдгээр өнгөрөхдөө радио хориглолын системд ЗАБС /зүтгүүр дэх аюулгүй байдлын систем/ бүртгэгдсэнийг магадлах шаардлагатай. /6.22 дугаар зураг/




6.22 дугаар зураг

6.9.3. "Удирдлагын төвтэй холбогдох хил" хар хүрээтэй шар дэвсгэр бүхий дөрвөлжин тэмдгийг цамхаг буюу шон дээр суурилуулна. Машинч тэмдгээр өнгөрөхдөө хөдөлгөөний удирдлагын төвтэй радио холбоо тогтоогдсоныг магадлах шаардлагатай. /6.23 дугаар зураг/



6.23 дугаар зураг

6.9.4. "Радио хориглолын бүсийн төгсгөл"–хар хүрээтэй ташуу улаан зураастай шар дэвсгэр бүхий дөрвөлжин тэмдгийг цамхаг буюу шон дээр суурилуулна. Радио хориглолын систем үйлчлэх бүсийн төгсгөлийг заана. /6.24 дүгээр зураг/





6.24 дүгээр зураг

Тайлбар: 6.21-6.24 дүгээр зурагт үзүүлсэн тэмдгүүдэд бичигдсэн тоо, тэмдэглэл нь аль хориглолын бүсэд хамаарагдаж байгааг заана.


ДОЛДУГААР БҮЛЭГ

СЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮЕД ХЭРЭГЛЭХ ДОХИО

7.1. Сэлгээний гэрлэн дохио дараахь дохиог өгнө.


7.1.1. гаргах ба замналын гэрлэн дохионы улаан гэрэл унтарсан үед тэдгээрийн саран цагаан гэрлээр сэлгээний ажил хийхийг зөвшөөрнө. /7.1 дүгээр зураг/

7.1.2. ертөөний тодорхой бэлчирт сэлгээний ажил хийхийг зөвшөөрсөн сэлгээний бүлэг гэрлэн дохио нь нэг буюу хоёр талдаа дохиолно. Галт тэрэг хүлээн авч, явуулдаггүй замууд, мухар замууд түүнчлэн сэлгээний ажил хийгддэг нийт замуудын сэлгээний гэрлэн дохионд улаан гэрлийг заавал байрлуулна. /7.2 дугаар зураг/



7.1 дүгээр зураг

7.2 дугаар зураг




7.2. Ялгах довын гэрлэн дохио дараахь дохиог өгнө.

7.2.1. ногоон гэрэл - Вагоныг тогтоосон хурдтай ялган тараахыг зөвшөөрнө. /7.3“а” дугаар зураг/

7.2.2. шар гэрэл - Вагоныг бууруулсан хурдтай ялган тараахыг зөвшөөрнө. /7.3“б” дугаар зураг/

7.2.3. улаан гэрэл - “Зогс! Ялган тараах үйлдлийг хориглоно.” /7.3“в” дугаар зураг/


7.2.4. гэрлэн дохионы улаан гэрэлтэй хамт ассан цагаан өнгөтэй гэрлэн заагч дээрх “У” үсэг нь вагоныг ухраан суулгах аргаар сэлгээ хийхийг шаардана. /7.3“г” дугаар зураг/



7.3 дугаар зураг

7.2.5. хэрэв ялгах довын гэрлэн дохионы үзэгдэлт хангалтгүй байвал заалтыг машинчид мэдэгдэхийн тулд давтах гэрлэн дохиог байрлуулна. Давтах гэрлэн дохио нь ялгах довын үндсэн гэрлэн дохионы гэрэлтэй адил гэрлээр дохиолно. Хүлээн авах паркийн замын дунд хэсэгт байрлуулсан давтах гэрлэн дохионд улаан гэрлийн оронд хөх гэрлийг хэрэглэж болно.

7.2.6. хүлээн авах паркийн зам дахь довын гэрлэн дохио хүртэл хөдлөх бүрэлдэхүүнийг явуулахыг зөвшөөрөх болон довын ялгах замд сэлгээний дохиог дохионы хэрэгсэл болгон ашиглаж болно.



7.2.7. сэлгээний гэрлэн дохиогүй өртөөнд гаргах гэрлэн дохионы хориглосон заалтаар сэлгээ хийх зөвшөөрлийг өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар сэлгээний удирдагч гүйцэтгэнэ. Энэ үед паркийн чанга яригч, зөөврийн радио станц, гар дохиог ашиглана.


7.3. Сэлгээний үед гар ба дуут дохиогоор дараахь дохиог өгнө.

7.3.1. “Машинч жолоодож байгаа талаараа зүтгүүрийг урагшаа хөдөлгө” дохиог өдөр дэлгэсэн шар дарцаг, шөнө тунгалаг цагаан гэрэлтэй гар дэнлүүг толгой дээгүүрээ хоёр тийш нь хөдөлгөх /7.4 дүгээр зураг/ мөн шүгэл буюу бүрээгээр нэг урт дуугаргаж өгнө.



7.4 дүгээр зураг


7.3.2. “Зүтгүүр ухар” дохиог өдөр дэлгэсэн шар дарцаг, шөнө тунгалаг цагаан гэрэлтэй гар дэнлүүг хөлийн өмнүүр хоёр тийш нь хөдөлгөх, /7.5 дугаар зураг/ мөн шүгэл буюу бүрээгээр хоёр урт дуугаргаж өгнө.






7.5 дугаар зураг

7.3.3. “Удаан яв” дохиог өдөр дэлгэсэн шар дарцаг, шөнө тунгалаг цагаан гэрэлтэй дэнлүүг хажуудаа дээш доош нь аажим хөдөлгөж /7.6 дугаар зураг/ мөн шүгэл буюу бүрээгээр хоёр богино дуугаргаж өгнө.



7.6 дугаар зураг



7.3.4. “Зогс!” дохиог өдөр дэлгэсэн улаан буюу шар дарцаг, шөнө ямар нэгэн гэрэлтэй гар дэнлүүгээр даллан эргүүлэх /7.7 дугаар зураг/ мөн шүгэл буюу бүрээгээр гурван богино дуугаргаж өгнө.



7.7 дугаар зураг

7.3.5. сэлгээний ажлын тушаалыг радио холбоогоор дамжуулна. Радио холбоо нь дохионы үүрэг гүйцэтгэхгүй.


7.3.6. сэлгээний үед өгч байгаа дохиог зүтгүүрийн шүглээр давтаж уг дохиог гүйцэтгэхээр хүлээн авсан тухайгаа батална.


НАЙМДУГААР БҮЛЭГ ГАЛТ ТЭРЭГНИЙ ДОХИО

8.1. Нэг замтай хэсэгт явах галт тэргэнд дараахь дохиог хэрэглэнэ.

8.1.1. өдрийн цагт явж байгаа галт тэрэгний зүтгүүрт дохио үл тавина.


8.1.2. хоорондын замд явж байгаа галт тэрэгний зүтгүүрийг шөнийн цагт бамбайн хоёр тунгалаг цагаан гэрлээр илэрхийлнэ. /8.1“а” дүгээр зураг/





8.1 дүгээр зураг /а/

8.1.3. ачаа, ачаа-зорчигчийн галт тэрэгний сүүлийг өдрийн ба шөнийн цагт сүүлийн вагоны бамбайн ялууны баруун талд нэг маягийн улаан зээрэнхий өлгөнө. /8.2 "а" дугаар зураг/



8.1 дүгээр зураг /б/

8.1.4. зүтгүүр прожектороор тоноглогдсон бол ямар ч галт тэрэгтэй яваа үед галт тэрэгний зүтгүүрийн дохионд шөнийн цагт прожекторын тунгалаг цагаан гэрэл нэмэгдэнэ. /8.1"б" дүгээр зураг/


ТАЙЛБАР: Энэхүү журмын "Галт тэрэгний дохио" гэсэн VIII бүлэгт дохиог баруун, зүүн талд байрлуулах талаарх бүх заалтыг хөдөлгөөний чиглэлийн дагуу харуулсан болно.

8.1.5. ачааны галт тэрэг вагонтой талаараа урагш явах үед галт тэрэгний эхний вагоныг өдрийн цагт бамбайн ялууны зүүн талд нэг улаан зээрэнхийгээр, эсвэл вагоны дамжих тавцангаас /нүүрний/ дэлгэсэн улаан дарцаг барьсан ажилтан дохио өгч явна. Шөнийн цагт дэнлүүний тунгалаг цагаан гэрлээр, эсвэл улаан өнгийн




гэрэлтэй гар дэнлүүгээр галт тэрэг дагалдсан ажилтан зүүн гар талдаа дохио өгч явна. /8.1“в, г” дүгээр зураг/

8.1.6. галт тэрэгний сүүлд яваа зүтгүүрийг өдрийн цагт уул зүтгүүрийн бамбайн ялууны баруун талд дэлгэсэн улаан дарцаг буюу улаан зээрэнхий өлгөж илэрхийлэх /8.1“б” дүгээр зураг/ ба шөнийн цагт бамбайн ялууны баруун талд улаан гэрлээр илэрхийлнэ. /8.1“б” дүгээр зураг/




8.1. “в” дүгээр зураг




8.1. “г” дүгээр зураг

8.1.7. зорчигчийн галт тэрэгний сүүлийн вагоныг өдөр, шөнийн аль ч цагт гурван улаан гэрлээр илэрхийлнэ. /8.2“б” дугаар зураг/


8.1.8. дохионы байнгын гэрэлгүй вагоныг зорчигчийн галт тэрэгний сүүлд холбох бол өдрийн цагаар сүүлийн вагоны бамбайн ялууны баруун талд нэг маягийн улаан зээрэнхий буюу дэлгэсэн улаан дарцаг, шөнийн цагаар сүүлийн вагоны бамбайн ялууны баруун талд улаан гэрэлтэй дэнлүүг өлгөж илэрхийлнэ. /8.2“в” дугаар зураг/





8.2 дугаар зураг

8.2. Ганцаараа яваа зүтгүүрийг галт тэрэгтэй яваа зүтгүүрийн нэгэн адил илэрхийлэх /8.1“а” дүгээр зураг/ ба түүний ар талыг нь галт тэрэгний сүүлд яваа зүтгүүрийн адил илэрхийлнэ. /8.1“б” дүгээр зураг/




8.3 дугаар зураг

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Санд Термин нарийн бичгийн
дэргэд 2018. 264 тушаал


8.3. Түлхэгч зүтгүүр ба өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүнийг ганцаараа яваа зүтгүүрийн нэгэн адил дохиогоор хангана.

8.4. Нэг хоорондын замд нэг галт тэргийг нөгөө галт тэрэгний хойноос зохих хугацаагаар тусгаарлан мөрдөж явуулах ба цувж яваа тохиолдолд түрүүчийн галт тэрэг буюу ганцаараа яваа зүтгүүрт бамбайн баруун талд дэлгэсэн шар дарцаг нэмж өлгөнө. /8.3 дугаар зураг/



8.4 дүгээр зураг

8.5. Галт тэргийг хоорондын замаас хэсэглэн татаж авахдаа хамгийн сүүлийнхээс бусад хэсэг бүрийн сүүлийн вагоны бамбайн ялууны баруун талд өдрийн цагт дэлгэсэн шар дарцаг, шөнийн цагт шар гэрэлтэй дэнлүү өлгөнө. Хамгийн сүүлийн



татан авч байгаа хэсгийн сүүлийн вагоныг ердийн ачааны галт тэрэгний адил дохиогоор хангана. /8.4“а” дүгээр зураг/

8.6. Радио сувгаар галт тэрэгний хөдөлгөөнийг хоорондын зай, хугацаагаар зохицуулах систем /СИРДП-Е/-ээр тоноглогдсон үед галт тэрэгний дохиог суурь бүтэц эзэмшигчийн баталсан журмаар зохицуулна.

8.7. Цас цэвэрлэгч нэг замтай хэсэгт яваа үед дараахь дохиог хэрэглэнэ.

8.7.1. Цас цэвэрлэгч толгойд нь яваа бол түүний хажуугийн хоёр дэгээнд өдрийн цагт дэлгэсэн хоёр шар дарцаг, шөнийн цагт цас цэвэрлэгчийн хажуугийн хоёр шар гэрэл харагдах бөгөөд зүтгүүр тийш хандсан тал нь хяналтын хоёр тунгалаг цагаан гэрэлтэй байна. /8.4“б” дүгээр зураг/

8.7.2. зүтгүүр толгойд нь яваа бол өдрийн цагт бамбайн дэнлүүний дэргэд дэлгэсэн хоёр шар дарцаг, шөнийн цагт бамбайн хоёр шар гэрэл харагдана. /8.4“в” дүгээр зураг/

8.7.3. Цас цэвэрлэгчийн сүүлийг ганцаараа яваа зүтгүүрийн нэг адил дохиогоор хангана.

8.8. Сэлгээ хийж байгаа, галт тэргэнд очих ба галт тэрэгнээс буцаж яваа зүтгүүрийн ард, урд шөнийн цагт бамбайн дэнлүүний машинчийн талд тус бүр нэг тунгалаг цагаан гэрэл харагдана.

8.9. Замаас авагддаг өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүн /дрезин/, тэргэнцэр, мөн замаас авч болдог бусад нэгжүүдийг хоорондын замд ажиллуулахдаа дор дурдсан дохиогоор хамгаалсан байна.


8.9.1. өдрийн цагт хоёр тал нь улаан будагтай тэгш өнцөгт дөрвөлжин самбар эсвэл урт иштэй дэлгэсэн улаан дарцаг, шөнийн цагт урт ишинд байрлуулсан хоёр талдаа улаан гэрэл /ар, өвөр/ харагдах дэнлүүтэй байна.

8.9.2. хоорондын замд ажиллаж байгаа тэргэнцэрийг дээрх дохионоос гадна хоёр талд нь 800 метр зайтай газарт гар ба зөөврийн улаан дохиогоор хааж хамгаалах бөгөөд тэргэнцэрийг хөдлөхөд нэгэн зэрэг дохиог өөрчлөн байрлуулахаар зохицуулна.

8.9.3. тэргэнцэр өртөөнд ажиллаж байхдаа өдрийн цагт хоёр тал нь улаан самбар эсвэл урт иштэй улаан дарцаг, шөнийн цагт хоёр тал нь улаан гэрэл бүхий урт иштэй дэнлүүтэй байна.

8.9.4. өртөөний зам ба суман шилжүүлэг дээр ажиллаж байгаа тэргэнцэрийг хоёр талд нь 50 метр зайтай газарт гар ба зөөврийн улаан дохиогоор хааж бөгөөд тэргэнцэрийг хөдлөхтэй нэгэн зэрэг дохиог өөрчлөн байрлуулна.

8.9.5. тэргэнцэр болон замаас авагддаг бусад нэгжийг хоёр талаас нь хааж явах төмөр замын ажилтан, түүнчлэн эдгээр нэгжийн хөдөлгөөнийг удирдаж яваа ажилтан зөөврийн самбар, гар дарцаг, дохионы дэнлүүнээс гадна галт тэрэг ойртож байгаа тухай мэдэгдэх, хэрэв шаардлага гарвал галт тэргэнд зогсоох дохио өгөхөд зориулсан бялт ба бүрээгээр хангагдсан байна.




ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ДУУТ ДОХИО

9.1. Галт тэрэгний хөдөлгөөнд хэрэглэгдэх дуут дохиог шүгэл, бүрээ, зүтгүүрийн ба өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний шүгэл зэргээр өгнө.

9.1 дүгээр хүснэгт

Дуут дохио

Дугаар	Дохио	Дохионы шаардлага	Дохиог өгөх субъект
9.1.1	Гурван богино ● ● ●	“Зогс”	Зүтгүүр ба галт тэрэгний бригад, өртөөний болон галт тэрэгний хөдөлгөөнд оролцдог бусад ажилтан өгнө
9.1.2	Нэг урт ■	“Галт тэргийг явуул”	Өртөөний замд галт тэргэнд өртөөний жижүүр буюу техник захирамжийн актад заасан ажилтан, аж ахуйн галт тэргэнд түүний ажил удирдагч, сэлгээний үед найруулагчийн бригад өгнө. Түүчээ зүтгүүрийн машинч зүтгүүрийн шүглээр хариу өгнө. Хос зүтгүүртэй бол хоёр дахь зүтгүүрийн машинч дохиог давтана.
9.1.3	Гурван урт ■ ■ ■	Галт тэрэгний бригад “Тоормосло” гэж шаардана.	Галт тэрэг авч яваа түүчээ зүтгүүрийн машинч өгнө. Хоёр зүтгүүртэй бол хоёр дахь зүтгүүрийн машинч давтана.
9.1.4	Хоёр урт ■ ■	Галт тэрэгний бригад “Тоормосоо сулла” гэж шаардана.	Галт тэрэг авч яваа түүчээ зүтгүүрийн машинч өгнө. Хос зүтгүүртэй бол хоёр дахь зүтгүүрийн машинч давтана.
9.1.5	Гурван урт нэг богино ■ ■ ■ ●	Өртөөнд галт тэрэг бүрэн бус бүрэлдэхүүнтэй ирсэн.	Зүтгүүрийн машинч өгнө.
9.1.6	Гурван урт хоёр богино ■ ■ ■ ● ●	Машинчаас туслах машинч, механик-бригадын дарга, ажил удирдагчийг зүтгүүрт дуудах	Хоорондын замд зогссон буюу зам засварын ажил хийж байх үед зүтгүүрийн машинч өгнө.
Хос зүтгүүртэй яваа үед			
9.1.7	Нэг богино ●	Хоёр дахь зүтгүүрийн машинчид хурдаа бууруулахыг шаардана.	Түүчээ зүтгүүрийн машинч өгнө.



9.1.8	Хоёр богино ● ●	Хоёр дахь зүтгүүрийн машинчид хурд нэмэхийг шаардана.	Түүчээ зүтгүүрийн машинч өгнө. Дохиог хоёр дахь зүтгүүрийн машинч давтана.
9.1.9	Хоёр богино ● ●	Түлхэгч зүтгүүртэй явахад “Түлхэлт эхлэх”-ийг шаардана.	Галт тэрэгний зүтгүүрийн машинч өгч түлхэгч зүтгүүрийн машинч дохиог давтана.
9.1.10	Нэг богино, нэг урт, нэг богино ● ■ ●	“Түлхэлт зогсоо” гэвч галт тэрэгнээс битгий хоцор гэж шаардана.	Галт тэрэгний түүчээ зүтгүүрийн машинч өгч түлхэгч зүтгүүрийн машинч дохиог давтана.
9.1.11	Дөрвөн урт ■■■■	Түлхэлт зогсоож, буцахыг шаардана.	Галт тэрэгний зүтгүүрийн машинч өгч түлхэгч зүтгүүрийн машинч дохиог давтана.

9.2 дугаар хүснэгт

Сэлгээний үед хэрэглэх дуут дохио

9.1.12	Нэг урт ■	Сэлгээ урагшаа яв.	Найруулагчийн бригад өгч машинч давтана.
9.1.13	Хоёр урт ■■ ■■	Сэлгээний бүрэлдэхүүн ухар.	Найруулагчийн бригад өгч машинч давтана.
9.1.14	Хоёр богино ● ●	Сэлгээний бүрэлдэхүүн зөөлөр.	Найруулагчийн бригад өгч машинч давтана.
9.1.15	Гурван богино ● ● ●	Зогс	Найруулагчийн бригад өгч машинч давтана

ТАЙЛБАР: Түлхэгч зүтгүүртэй бол түүнээс өгсөн бүх дохиог хоёрдугаар зүтгүүрийн машинч давтана.

9.2. Мэдэгдэх дохиог өртөө, замын пост, зорчигч буух, суух газар, шүгэл дуугаргахыг шаардах дохионы “Ш” тэмдэг, хурд бууруулах зөөврийн ба гар дохионууд, сэтэрхий, тойруу зам, хонгил, гарам, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүн, замаас авагддаг тэргэнцэр болон зам дээр байгаа хүмүүст галт тэрэг ойртож ирж байгааг зүтгүүр, өөрөө явагч тусгай бүрэлдэхүүний шүглийг нэг урт дуугаргаж мэдэгдэнэ.


9.3. Ажил хийж байгаа газарт галт тэрэг ойртоход зөөврийн дохио байгаа эсэхийг харгалзахгүйгээр анхаарамж бичигт дурдсан километрийн өмнөх километрээс эхлэн шүглээ нэг урт дуугаргаж мэдэгдэнэ.

9.4. Цаг агаарын хүндрэлтэй манан будан, цасан ба шороон шуурга зэрэг үзэгдэх орчин хязгаарлагдсан үед дохиог байнга давтан өгч байна.

9.5. Хоорондын замд зам, гүүр, хонгил, нурж болох газрын эргүүл, гармын жижүүр, замын ажил удирдаж байгаа ажилтан, замаас авагддаг тэргэнцэр авч яваа дохиочид, ажилтан галт тэрэг ойртож яваа дохиог бүрээгээр өгнө.

9.6. Сондгой чиглэлийн галт тэрэг ойртож явааг бүрээгээр нэг урт, тэгш чиглэлийн галт тэрэг ойртож явааг хоёр урт дуу гаргаж мэдэгдэнэ.

9.7. Өртөөний зам дээр байгаа зорчигчийн, ачаа-зорчигчийн, хүн тээсэн галт тэргэнд суух ба тэдгээрийг явуулах тухай зорчигчдод чанга яригчийн холбоогоор зарлан мэдэгдэнэ.



9.8. Мэдэгдэх дохиог ойлгомогц зам дээр ажиллаж байгаа бүх ажилтнууд замын хажууд гарч галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаад хяналт тавьж өнгөрүүлнэ.

9.9. Урих дохиогоор болон оруулах дохионы хориглосон заалтаар өртөө рүү орох үед сэрэмжлэх дохиог зүтгүүрийн шүглээр нэг богино нэг уртаар давталтайгаар өгнө.

АРАВДУГААР БҮЛЭГ ТҮГШҮҮРИЙН ДОХИО БА ТУСГАЙ ТЭМДЭГ

10.1. Түгшүүрийн дохиог зүтгүүр, өөрөө явагч тусгай бүрэлдэхүүний шүгэл, бүрээ, цэргийн дохионы бүрээ, тусгай зориулалтын дуут дохио, аливаа дүүжилсэн төмрөн эдлэлийг дуугаргах зэргээр өгнө.

10.1.1. нийтийн түгшүүрийн дохиог нэг урт гурван богино дуугаргаж дор дурдсан нөхцөлүүдэд өгнө. /10.1 дүгээр зураг/



10.1 дүгээр зураг

- галт тэрэгний хөдөлгөөнд аюул учруулж болох гэмтэл зам дээр илэрсэн үед;
- галт тэргэнд сүйрэл тохиолдох, цасан болон элсэн хунгарт саатан зогсох зэрэг тусламж шаардах үед.

10.1.2. галын түгшүүрийн дохиог нэг урт хоёр богино дуу гаргаж өгнө. /10.2 дугаар зураг/



10.2 дугаар зураг

10.1.3. шаардлагатай үед нийтийн ба галын түгшүүрийн дохиог төмөр замын ямар ч ажилтан өгнө.

10.1.4. агаарын түгшүүрийн "АТ" дохиог 3 минутын турш тасралтгүй олон богино дуугаргаж өгнө. /10.3 дугаар зураг/



10.3 дугаар зураг

10.1.5. төмөр замын үйлдвэрийн газар өртөө, зөрлөг, аж ахуйн нэгж, байгууллага байрлаж байгаа хот, суурин газар өгөгдсөн агаарын түгшүүрийн дохиог зүтгүүр, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний шүглээр яаралтай давтана.




10.1.6. хоорондын замд агаарын түгшүүрийн дохиог зүтгүүр ба өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний шүглээр өгнө.

10.2. Цацраг идэвхит болон химийн аюулын “ХА” дохиог нэг урт, нэг богино дуугаргаж өгнө. /10.4 дүгээр зураг/



10.4 дүгээр зураг

10.2.1. хоорондын замд зүтгүүр, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний шүглээр өгнө.




10.5 дугаар зураг

10.2.2. ертөө, зөрлөг, аж ахуйн нэгж, байгууллага дээр өлгөсөн төмрөн эдлэлийг бүдүүвчийн дагуу цохиж 1-ээс 2 минутын турш үе үе давтаж өгнө. Химийн аюулын дохиог өртөөн дээр төмөр замын ажилтан өгөх бөгөөд хоорондын замд зүтгүүр, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний жолооч өгнө.

10.3. Агаарын түгшүүр болон химийн аюул “ХА” өнгөрсөн тухай төмөр замын ажилтан зорчигч иргэдэд дараахь байдлаар мэдэгдэнэ.

10.3.1. өртөөн дээр бол өртөөний дарга буюу түүний томилсон ажилтны захирамжаар радио нэвтрүүлгийн сүлжээ, бусад холбооны хэрэгслээр болон хүн явуулж мэдэгдэнэ.




10.3.2. хоорондын замд яваа зорчигчийн галт тэргэнд галт тэрэгний даргын шийдвэрээр галт тэрэгний зохих албан тушаалтнаар болон галт тэрэгний радио нэвтрүүлгийн сүлжээгээр, цэргийн галт тэрэг бол цувааны даргын шийдвэрээр цувааны холбооны хэрэгслээр дамжуулан тус тус мэдэгдэнэ.

10.4. Хортой хэсгээр галт тэрэг явж өнгөрнө гэдгийг зүтгүүрийн ба галт тэрэгний бригадад мэдэгдэнэ.

10.4.1. хордсон хэсэгт хүмүүсийг баг, хамгаалах тусгай хувцас зэрэг тусгай хамгаалалтгүйгээр оруулахгүйн тулд уг газрыг “Хортой”, “Энд хортой” гэдэг тусгай тэмдгээр хаана. /10.5 дугаар зураг/

10.4.2. “Хортой”, “Энд хортой” гэсэн тусгай тэмдгийг 10.6 дугаар зурагт заасны дагуу байрлуулна.



10.6 дугаар зураг


10.4.3. хоорондын зам буюу өртөөн дээр хордсон газрын хязгаараас 50 метрийн зайд “Энд хортой” гэсэн тэмдгийг замын ул шорооны дэнж дээр байрлуулна.

10.4.4. галт тэрэгний хөдөлгөөний чиглэлийн дагуу “Хортой” гэсэн нэгдүгээр тэмдгийн өмнө машинч нь химийн аюулын дохио өгөөд хордсон газрыг тогтоосон хурдаар явж өнгөрнө.

10.4.5. “Хортой”, “Энд хортой” гэсэн тэмдэг нь шөнийн цагт гэрэлтүүлэгтэй, эсхүл гэрэл ойлгогчтой байна.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЕХНОЛОГИЙН ХОЛБОО

11.1. Төмөр замын технологийн холбоонд галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоо, өртөө хоорондын холбоо, шугам замын холбоо, радио холбоо багтана. Өртөөний жижүүрийн ажлын байранд галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоо, өртөө хоорондын холбоо, радио холбоо, чанга яригчийн холбоог суурилуулна.



11.2. Төмөр замын технологийн зориулалттай холбоог ашиглах журмыг Төмөр замын техник ашиглалтын журам, Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам болон суурь бүтэц эзэмшигчийн холбогдох тушаал, заавруудаар зохицуулна.


АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ

ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

12.1. Энэхүү журмын хэрэгжилтэд төрийн захиргааны төв байгууллагын зам, тээврийн хяналт хариуцсан нэгж, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нар тус тусын бүрэн эрхийн хэмжээнд хяналт тавина.

12.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
204 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Төмөр замын галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам нь Төмөр замын тээврийн тухай хууль, Төмөр замын техник ашиглалтын журам болон Дохиолол холбооны журмын заалтыг хэрэгжүүлэхэд оршино.

1.2. Төмөр замын өртөө, зөрлөгт галт тэрэг хүлээн авах, явуулах, өнгөрүүлэх, сэлгээний ажлыг дараахь нөхцөлд удирдан зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө. Үүнд:

1.2.1. дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламж, төхөөрөмж хэвийн ажиллагаатай болон гэмтэлтэй;

1.2.2. зам, төхөөрөмжийг засварлах, өргөтгөх, шинээр барих.


1.3. Төмөр замын техник ашиглалтын журмын 15 дугаар бүлгийн /Галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулахад ;авигдах шаардлага/ 15.1.1-15.1.4-т заасны дагуу галт тэрэгний хөдөлгөөнийг зөвхөн нэг ажилтан удирдана. Хэсэгт-галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч, өртөөнд-өртөөний жижүүр, постонд-постын жижүүр, хоорондын зам дахь аж ахуйн галт тэргэнд ажил удирдагч, хоёроос дээш тооны зүтгүүр бүхий галт тэргэнд түүчээ зүтгүүрийн машинч удирдана.

1.4. Өртөө, замын пост, парк дээр галт тэрэг хүлээн авах, явуулах, өнгөрүүлэхийг зөвхөн нэг ажилтан /өртөөний жижүүр, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн төвлөрүүлэлттэй хэсэгт зохицуулагч, постын ба паркийн жижүүр/ удирдана.

1.5. Галт тэрэг хүлээн авах, явуулах, өнгөрүүлэх түүнчлэн сэлгээний ажилтай холбогдсон бүх үйл ажиллагааг Техник ашиглалтын журам, Төмөр замын дохиолол холбооны журам, өртөөний техник захирамжийн акт, нэгдсэн технологийн горимын дагуу явуулна.

1.6. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч, өртөөний жижүүрээс зүтгүүрийн машинчид өгөх галт тэрэгний хөдөлгөөний болон сэлгээний ажлын талаарх захирамж товч, тод, ойлгомжтой байна. Захирамж өгсөн ажилтан өгсөн захирамжаа давтуулан сонсож зөв ойлгосныг магадлана.

1.7. Дохиолол төвлөрүүлэлт, хориглолын тоног төхөөрөмжийг ашиглан дохио нээх, хаахыг дор дурдсан ажилтан гүйцэтгэнэ. Үүнд:



1.7.1. өртөө, ялгах дов, өртөөний парк, замын постонд тэдгээрийн жижүүр ба өртөөний жижүүрийн удирдлагаар түүний туслах, сумчин;

1.7.2. галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн төвлөрүүлэлттэй хэсэгт зохицуулагч.

1.8. Өртөөний гаргах дохио хориглосон заалттай буюу гаргах дохиогүй замаас галт тэрэг явуулах үед хоорондын зам эзлэх зөвшөөрлийг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч, өртөөний жижүүр техник захирамжийн актад зааснаар гүйцэтгэнэ.

1.9. Машинч олгогдсон зөвшөөрөлд галт тэрэгний дугаар, явах хоорондын замтай тохирч байгаа эсэхийг магадлана.

1.10. Өртөөний жижүүр нь галт тэрэг нэг бүрийн явсан, ирсэн, өнгөрсөн цаг минутыг зохих ёсны нэмэгдэл үсэгтэй бол үсгийн хамт галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт тэмдэглэнэ.

1.11. Галт тэрэг явуулсан, өнгөрүүлсэн тухай дараахь маягаар мэдэгдэнэ.

“...-р галт тэрэг... паркын ...дугаар, ... паркын ...-р замаар ... цаг ... минутанд явлаа. /өнгөрлөө/”

1.12. Тэсрэх дэлбэрэх, аюултай ачаатай вагонтой галт тэрэг бол дугаарын ард “т” үсэг /жишээ нь: 2303т/, галт тэрэг явуулах, өнгөрүүлэх үед урт бүрэлдэхүүнтэй бол “у” /2303у/ хүнд жинтэй бол “х” /2303х/, овор хэтэрсэн ачаатай бол оврын индекс /2303Н-0010/ бичнэ.


1.13. Галт тэрэг ирсэн /буцаж ирсэн/ тухай дараахь маягаар мэдэгдэнэ.

“...-р галт тэрэг ... цаг ... минутанд ирсэн /буцаж ирсэн/”

1.14. Галт тэрэг түлхэгч зүтгүүртэй яваа бол явсан, ирсэн тухай мэдэгдэхдээ “түлхэгчтэй” гэдгийг хэлнэ.

1.15. Өртөөний жижүүр /өөрийн биеэр буюу бусад ажилтны илтгэлээр/ зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжид гэмтэл илрүүлбэл “Зам, суман шилжүүлэг дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр”-т энэ тухай мэдэгдсэн цаг, минутыг бичиж, байгууламжийг хариуцсан ажилтан нарт /замын мастер, цахилгаан механикч болон зохих аж ахуйн нэгжийн холбогдох ажилтан/ нэн даруй мэдэгдэж энэ тухай галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид илтгэнэ.

1.16. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн төвлөрүүлэлттэй хэсэгт зам, суман шилжүүлэг, дохиолол төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжид гэмтэл илрүүлбэл галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч Өртөөний дарга, Холбооны албаны диспетчер /зохицуулагч/, Замын албаны диспетчер /зохицуулагч/-д тус тус мэдэгдэнэ.



1.17. Гэмтлийг арилгасан тухай зохих ажилтан “Зам, суман шилжүүлэг, Дохиолол төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр”-т тэмдэглэл хийж байгууламж хэвийн ажиллаж байгааг хамтран шалгаж дэвтэрт өөрөө болон өртөөний жижүүр гарын үсэг зурна. Дохиолол төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн гэмтэл нь урих дохионы товрууны ломбыг таслах, тоолуурын заалтыг өөрчлөхөд хүргэвэл “Зам, суман шилжүүлэг, дохиолол төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр”-т бичлэг хийнэ. Бичлэг хийх загварыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

1.18. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн гэмтлийн улмаас галт тэрэг хүлээн авах, явуулах ажлыг өртөөний жижүүр тоолуурын заалтаар тоноглогдсон урих дохиогоор гүйцэтгэсэн тохиолдолд “Зам суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр”-т тоолуурын заалтыг тэмдэглэнэ.

1.19. Хоорондын зам хаах, нээх, дохиолол холбооны нэг хэрэгслээс нөгөөд шилжүүлэхийг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар гүйцэтгэнэ.

1.20. Дохиолол холбооны үндсэн хэрэгслээс холбооны утсан хэрэгсэлд шилжих үед өртөөний жижүүр хоорондоо галт тэрэгний утсан мэдээг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоогоор түүний хяналтын дор солилцоно.

1.21. Оруулах, гаргах /замналын/ гэрлэн дохионы хориглосон заалттайгаар өртөөнд галт тэрэг хүлээн авах, өртөөнөөс галт тэрэг явуулах бүх тохиолдолд өртөөний жижүүр урих дохионы товрууг ашиглах эсвэл галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар хориглосон заалттай дохиог өнгөрөх зохих зөвшөөрлийг машинчид өгөхийн өмнө, өртөөний техник захирамжийн актаар хүлээн авах зам чөлөөтэй, замналд орсон сум зөв тавигдаж түгжигдсэн, галт тэрэг явуулах үед эхний хориг-хэсэг чөлөөтэй /автомат хориглолын үед/, холдох хэсэг чөлөөтэй /өртөө хоорондын хориглолын үед зөвхөн радио галт тэргэнд/ хоорондын зам чөлөөтэйг /хагас автомат хориглолын үед, өртөө хоорондын хориглолын үед/ магадлана.

1.22. Урих дохионы товрууг галт тэрэгний түүчээ зүтгүүр оруулах гэрлэн дохио өнгөртөл дарна.

1.23. Өртөө хоорондын хориглолын системийн үед радио галт тэргийг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн зөвшөөрлөөр хүлээн авна.

1.24. Өртөө хоорондын хориглолын системийн үед бусад галт тэргийг урих дохиогоор хүлээж авна.

1.25. Өртөөний жижүүр ажилд гарахын өмнө доорх үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

1.25.1. хийх ажлын төлөвлөгөө, галт тэрэг хүлээн авах, явуулах, сэлгээний ажилтай холбоотой өгөгдсөн тушаал, захирамж, хүлээн авах, явуулах замын эзэлгээтэй, чөлөөтэй эсэх, зам дээр хөдлөх бүрэлдэхүүн байгаа бол түүний байрлал, тооцоот ивүүрээр бэхэлсэн байдлыг магадлах;



1.25.2. дохиолол төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн удирдах хэрэгсэлийн хэвийн ажиллагаа болон тэдгээр нь ломботой эсэх, ломбоны тоо жагсаалттай тохирч байгаа, өөрсдийн үйлчилдэг суман шилжүүлэг хэвийн ажиллагаатай эсэхийг магадлах;

1.25.3. ажлын байранд байгаа хатуу тооцоот багаж /билет газарч, сум шилжүүлэх түлхүүр, нөөц удирдлагад шилжүүлэх түлхүүр очир г.м/, дохионы хэрэгсэл бусад эд хогшил, тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг шалгах;

1.25.4. хоорондын зам чөлөөтэй буюу эзэлгээтэй эсэх өгөгдсөн хүчинтэй анхаарамжтай танилцах;

1.25.5. өртөөний жижүүрийн хөтөлдөг хөдөлгөөн зохицуулагчийн тушаалын, галт тэрэгний хөдөлгөөний, анхаарамжийн, галт тэрэгний утсан мэдээний, вагон үзлэгийн болон бусад дэвтэрт бичигдсэн бичлэгүүдтэй танилцах.

1.26. Жижүүр нь галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт дараахь маягаар бичлэг хийнэ.

“20... оны ...-р сарын ...-ны ... цаг ... минутанд ээлж хүлээн авсан. Өртөөний жижүүр
/гарын үсэг/”

“20... оны ...-р сарын ...-ны ... цаг ... минутанд ээлж хүлээлгэж өгсөн. Өртөөний жижүүр
/гарын үсэг/”

1.27. Өртөөний жижүүр ээлжийн ажил хүлээн авмагц сумчин, туслах жижүүр, постын жижүүр, галт тэрэгний найруулагч, түүний туслах бусад ажилтан ажилдаа ирсэн эсэх, тэднээр дамжуулан техник захирамжийн актад заасан чухал ажлын байранд ажил хэвийн байгаа, хөдлөх бүрэлдэхүүнийг зөв бэхэлсэн эсэхийг шалгуулж, дутагдал зөрчил илэрвэл арилгуулах арга хэмжээ авч, шаардлагатай бол өртөөний даргад мэдэгдэх үүрэгтэй.

1.28. Галт тэрэг болон сэлгээний ажлын үеийн албан ярианы дэглэмийг суурь бүтэц эзэмшигч тогтооно.


ХОЁРДУГААР БҮЛЭГ

АВТОМАТ ХОРИГЛОЛЫН ҮЕИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН

2.1. Автомат хориглолоор тоноглогдсон нэг замтай хоорондын замын галт тэрэгний хөдөлгөөнийг хоёр чиглэлийн байхаар зохион байгуулна.

2.2. Хос замтай хоорондын замд галт тэрэгний хөдөлгөөнийг нэг чиглэлийн байхаар зохион байгуулах боловч зам тус бүрт хоёр чиглэлийн хөдөлгөөний автомат хориглолоор тоногдсон байна.

2.3. Хос замт шугамын чиглэл болон онцгой тохиолдолд чиглэлийн эсрэг галт тэрэг явуулах журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.



2.4. Техник ашиглалтын журмын 16.2, 16.3-т заасны дагуу автомат хориглол дараахь шаардлагыг хангах ёстой. Үүнд:

2.4.1. галт тэрэг хориг -хэсгийг эзлэх зөвшөөрөл нь гаргах буюу өнгөрүүлэх гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт болно;

2.4.2. сунгуу өгсүүрт байрласан өнгөрүүлэх гэрлэн дохионд /оруулах гэрлэн дохионы өмнөхөөс бусад/ “Д” үсгийн хэлбэрт гэрэл ойлгогчтой таних тэмдэг бүхий самбарыг суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр байрлуулна. Ийм дохио нь ачааны галт тэрэг гэрлэн дохионы улаан гэрлийн заалтыг зогсолтгүйгээр өнгөрөх зөвшөөрөл болдог. Энэ үед машинч онцгой сонор сэрэмжтэй явж хориглосон заалттай гэрлэн дохиог 20 км/цагаас ихгүй хурдтайгаар өнгөрөх ба цаашдын хөдөлгөөнд ямар нэг саад учрахад яаралтай зогсоход бэлэн явна;

2.4.3. улаан заалттай өнгөрүүлэх гэрлэн дохио, унтарсан буюу үл ойлгогдох заалттай гэрлэн дохионы өмнө зогссон галт тэрэгний машинч өмнөх хориг-хэсэг галт тэргээр эзэлгээтэйг мэдэх ба харж байвал уг хориг -хэсэг чөлөөлөгдөх хүртэл явахгүй байхыг хатуу анхаарна;

2.4.4. хэрэв машинчид өмнөх хориг -хэсэгт галт тэрэг байгаа нь мэдэгдэхгүй бол зогссоны дараа заавал автотоормосоо суллах ба гэрлэн дохионд зөвшөөрсөн заалт асахгүй бол дараагийн гэрлэн дохио хүртэл онцгой сонор сэрэмжтэй 20 км/цагаас ихгүй хурдтай цаашдын хөдөлгөөнд ямар нэгэн саад учрахад яаралтай зогсоход бэлэн явна. Дараагийн өнгөрөх гэрлэн дохио мөн адил байх тохиолдолд зогссоны дараа дээрх дарааллаар хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ;

2.4.5. хориглосон заалттай өнгөрүүлэх гэрлэн дохиог тогтоосон дарааллын дагуу өнгөрсний дараа зүтгүүрийн гэрлэн дохио зөвшөөрсөн заалттай болсон тохиолдолд машинч зүтгүүрийн гэрлэн дохионы заалтыг удирдлага болгон 40 км/цагаас ихгүй хурдтай дараагийн гэрлэн дохио хүртэл явж болно;

2.4.6. зүтгүүрийн гэрлэн дохио нь зөвшөөрсөн заалттай байхад түүний заалтыг удирдлага болгон гэрэл унтарсан өнгөрүүлэх гэрлэн дохиог зогсолтгүйгээр өнгөрөхийг зөвшөөрнө;

2.4.7. галт тэрэгний хөдөлгөөний үед машинч, туслах машинч нар нь гэрлэн дохионы заалтыг хатуу мөрдөх ёстой. Харин зүтгүүрийн автомат дохиоллын системтэй бол өнгөрүүлэх гэрлэн дохио ба зүтгүүрийн гэрлэн дохионы заалтыг нэгэн адил мөрдөнө.

2.5. Өнгөрүүлэх гэрлэн дохио гэрлэн дохио ба зүтгүүрийн гэрлэн дохионы заалт харилцан тохирохгүй бол машинч зөвхөн өнгөрүүлэх гэрлэн дохионы заалтыг удирдлага болгоно.

2.6. Зүтгүүрийн автомат дохиоллын замын байгууламжаар тоноглогдсон хоорондын ба өртөөний замын хөдөлгөөний үед зүтгүүрийн гэрлэн дохионд цагаан гэрэл асвал /зүтгүүрийн гэрлэн дохионд зөвшөөрсөн заалт өгөгдөх хүртэл/ машинч



онцгой сонор сэрэмжтэй 40 км/цагаас ихгүй хурдтай галт тэргийг дараагийн гэрлэн дохио хүртэл жолоодно.

2.7. Зүтгүүрийн автомат дохиолол гэмтсэн тохиолдолд машинч дараахь үүргийг гүйцэтгэнэ.

2.7.1. ачааны ба зорчигчийн галт тэрэгний зүтгүүрийг жолоодох үед радио холбоо нь хэвийн ажилтай бол зүтгүүрийн бригадын амралтын байртай өртөө хүртэл явна;

2.7.2. зүтгүүрийн автомат дохиолол буюу аюулгүй байдлын систем гэмтэлтэй тохиолдолд зорчигчийн галт тэрэгний зүтгүүрийг нэг машинч жолоодож байвал машинч ойрын өртөө хүртэл галт тэргийг жолоодох ба тусламжийн зүтгүүр шаардана.

2.7.3. зүтгүүрийн автомат дохиоллын ба аюулгүй байдлын систем гэмтэлтэй үед галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчаас өртөөний жижүүрээр дамжуулан өгсөн тушаалд заагдсан газарт хүргэнэ.

2.8. Хос замтай хоорондын зам нь хоёр талын хөдөлгөөнийг зохион байгуулахдаа зам тус бүрт нэг чиглэлийн хөдөлгөөнтэй байхаар автомат хориглолоор тоноглогдсон хэсэгт зүтгүүрийн автомат дохиололыг хэрэглэж болно. Ийм хоорондын замд галт тэрэгний хөдөлгөөнийг зөв чиглэлд автомат хориглолын дохиогоор, харин эсрэг чиглэлд зүтгүүрийн гэрлэн дохиогоор зохицуулна. Эсрэг чиглэлийн замаар өртөөнөөс явж байгаа галт тэрэг нь гаргах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалтаар гарна.

2.9. Эсрэг чиглэлийн замаар зүтгүүрийн гэрлэн дохионы дохиогоор явж байгаа галт тэрэгний машинч ба туслах машинч дараахь үүрэгтэй.


2.9.1. зүтгүүрийн гэрлэн дохионы заалт ногоон байхад суурь бүтэц эзэмшигчийн тушаалаар тогтоосон хурдтай явна;

2.9.2. шар гэрлийн үед 50 км/цагаас ихгүй хурдтай өнгөрнө;

2.9.3. зүтгүүрийн гэрлэн дохионы шар ба улаан заалт хамт өгөгдөхөд 20 км/цаг хүртэл бууруулж эхний гэрлэн дохионы дэргэд галт тэргийг зогсооно;

2.9.4. шар ба улаан заалт хамт өгөгдснөөс болж зогссон галт тэрэгний машинч өмнөх хориг-хэсэг галт тэргээр эзэлгээтэйг мэдэх буюу харж байвал хориг-хэсэг чөлөөлөгдөхийг хүлээнэ. Зүтгүүрийн гэрлэн дохионд шар буюу ногоон заалт өгөгдсөний дараа зүтгүүрийн гэрлэн дохионы дохиогоор хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ;

2.9.5. машинч өмнөх хориг-хэсэгт галт тэрэг байгааг мэдэхгүй ба зогсох болон тоормос суллах хугацаанд зүтгүүрийн гэрлэн дохионд шар буюу ногоон заалт өгөгдвөл дараагийн хориг-хэсэг хүртэл онцгой сонор сэрэмжтэй, 20 км/цагаас ихгүй хурдтай цаашдын хөдөлгөөнд ямар нэгэн саад учрахад яаралтай зогсоход бэлэн



байдалд хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ. Хориг-хэсгээр өнгөрөх үед улаан заалт нь шар ба улаан заалттай хамт өгөгдөж өөрчлөгдвөл машинч 20 км/цагаас ихгүй хурдтай хөдөлгөөнийг үргэлжлүүлж болно. Шар ба ногоон заалт өгөгдвөл машинч 40 км/цаг хүртэл хурдыг нэмж болно;

2.9.6. хориг-хэсгийн төгсгөлд зүтгүүрийн дохиолол шар ба ногоон заалттай байвал энэ дохиог удирдлага болгон хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ. Улаан заалт хэвээр буюу шар, улаан заалттай хамт өгөгдөж байгаа үед машинч галт тэргийг заавал зогсоох ба цаашид энэхүү журмын 2.9.4, 2.9.5-т заасныг удирдлага болгоно;

2.9.7. зүтгүүрийн гэрлэн дохионд гэнэт зөвшөөрсөн заалтын оронд хориглосон заалт бий болох шар, улаан заалттай хамт, улаан ба цагаан заалт буюу зүтгүүрийн гэрлэн дохионы гэрэл унтарвал машинч хурд бууруулах арга хэмжээ авах үүрэгтэй;

2.9.8. хориг-хэсгийн төгсгөл буюу зүтгүүрийн гэрлэн дохио зөвшөөрсөн заалт асах хүртэл онцгой сонор сэрэмжтэй ба цаашдын хөдөлгөөнд ямар нэгэн саад учрахад зогсоход бололцоотой хурдтай галт тэргийг жолоодно. Улаан заалт хэвээр буюу шар, улаан заалттай хамт өгөгдөж байгаа үед машинч галт тэргийг заавал зогсоох ба цаашид энэхүү журмын 2.9.4, 2.9.5-т заасныг удирдлага болгоно.

2.9.9. зүтгүүрийн автомат дохиоллын системд гэмтэл гарсан тохиолдолд эхний гэрлэн дохионы дэргэд галт тэргийг зогсооно. Энэ тохиолдолд оруулах гэрлэн дохио /"өртөөний зааг" дохионы тэмдэг/ хүртэл онцгой сонор сэрэмжтэй 20 км/цагаас ихгүй хурдтай цаашдын хөдөлгөөнд ямар нэгэн саад учрахад яаралтай зогсоход бэлэн байдалд явна.

2.10. Өртөөний эсрэг чиглэлийн замаас галт тэргийг оруулах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалтаар хүлээн авах бүх тохиолдолд хурд нь хажуугийн замаар тогтоосон хурдаас хэтрэхгүй.


ГУРАВДУГААР БҮЛЭГ

ӨРТӨӨ ХООРОНДЫН ХОРИГЛОЛЫН ҮЕИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН

3.1. Өртөө хоорондын хориглолоор тоноглогдсон нэг замтай хоорондын замын галт тэрэгний хөдөлгөөнийг хоёр чиглэлийн байхаар зохион байгуулна. Хос замтай хоорондын замд нэгэн адил зохион байгуулна.

3.2. Өртөө хоорондын хориглолын үед радио сувгаар галт тэрэгний хөдөлгөөнийг завсарлагатайгаар зохицуулах системийн сүлжээнд бүртгэгдсэн, зүтгүүрийн аюулгүй байдлын системээр /радио галт тэрэг/ тоноглогдсон галт тэрэгний хөдөлгөөн дараахь шаардлагыг хангасан байна:

3.2.1. галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн удирдлагын үед автоматжуулсан ажлын байрнаас галт тэргэнд хоорондын зам эзлүүлэх зөвшөөрлийг гаргах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт болон машинчийн дэлгэц дээрх зөвшөөрсөн мэдээллээр зохицуулна;



3.2.2. өртөөний удирдлагын үед гаргах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалтаар зохицуулна;

3.2.3. системийн бүрдэл хэсгийн гол тоологчийн мэдээллээр өртөөнд галт тэргийг бүрэн бүрэлдэхүүнтэй ирснийг мэдээлнэ.

3.3. Өртөө хоорондын хориглолтой үед эхний хос дугуй гол тоологчоор өнгөрөх үед хоорондын зам эзлэгдсэн цагийг галт тэрэг жинхэнэ явсан цаг минут гэж тооцно.

3.4. Суурь бүтэц эзэмшигч "Радио сувгаар галт тэрэгний хөдөлгөөнийг хоорондын зай, хугацаагаар зохицуулах системээр тоноглогдсон хэсэгт галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулах заавар"-аар тогтооно.

3.5. Галт тэрэг явуулахаар гаргах дохио нээсний дараа өртөөний жижүүр өөр галт тэрэг явуулахын тулд дохиог хааж замнал өөрчлөх тухай захирамж өгөхгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

3.6. Шаардлагатай тохиолдолд галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар гаргах дохио хааж замнал өөрчилж болно. Энэ тухай явах галт тэрэгний машинчид мэдэгдэнэ. Машинчид мэдэгдэх загварыг нэгдүгээр хавсралтад үзүүлэв.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХАГАС АВТОМАТ ХОРИГЛОЛЫН ҮЕИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН

4.1. Хагас автомат хориглолтой үед галт тэрэг хүлээн авах ба явуулах.


4.1.1. галт тэргэнд хоорондын зам эзлүүлэх зөвшөөрөл нь гаргах буюу өнгөрүүлэх гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт байна.

4.1.2. техник ашиглалтын журмын 16.4-т заасны дагуу нэг замтай хэсэгт гаргах гэрлэн дохио нээхийн тулд галт тэрэг очих зэргэлдээ өртөөний жижүүрээс зөвшөөрлийн хориг дохиог хориглолын аппаратаар урьдчилан авна.

4.2. Галт тэрэг хүлээн авахын өмнө өртөөний жижүүр хүлээн авах замналыг урьдчилан бэлтгээд оруулах дохиог нээнэ.

4.3. Зам, сум нь цахилгаан тусгаарлагчгүй өртөөнд галт тэрэг оруулах дохиог өнгөрсний дараа өртөөний жижүүр, сумчин уг дохионы товруу /баруул/-г хаалттай байдалд тавина.

4.4. Өртөөний жижүүр галт тэргийг өртөөнд бүрэн бүрэлдэхүүнтэй ирснийг магадлаад, явуулсан өртөөнд ирэлтийн хориг дохиог өгч утсаар галт тэрэг ирсэн цаг, минутын тухай мэдэгдэнэ.



4.5. Галт тэрэг түлхэгч зүтгүүртэй явж байгаа бол өртөөний жижүүр ирэлтийн тухай мэдэгдэл, ирэлтийн хориг дохиог түлхэгч ирснийг магадласны дараа явуулсан өртөөнд өгнө.

4.6. Галт тэрэг хүлээн авсны дараа ирэлтийн хяналтын байгууламж ажиллахгүй тохиолдолд өртөөний жижүүр галт тэрэг бүрэн бүрэлдэхүүнтэй ирснийг магадлаад хоорондын замыг хязгаарлагч хоёр өртөөнд нэгэн зэрэг дамжуулан өгөгдөх галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар зохиомол ирэлтийн хориг дохиог явуулсан өртөөнд туслах товрууны тусламжтайгаар өгнө.

4.7. Зохиомол ирэлтийн туслах товрууны ломбыг таслах ба тоолуурын заалтыг ахиулах тухай өртөөний жижүүр “Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр”-т урьдчилан бичлэг хийнэ.”

4.8. Ирэлтийн хориг дохиог зохиомлоор өгч байгаа тохиолдолд өртөөний жижүүр галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт галт тэрэгний дугаарын эсрэг талд тоолуурын заалтыг бичнэ.

4.9. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн гэмтлийн улмаас зохиомлоор ажиллуулсан бол гэмтлийн тухай “Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр”-т бичнэ.

4.10. Өртөөний жижүүр хоорондын замаас галт тэрэг бүрэн бүрэлдэхүүнтэй ирснийг магадлаагүй тохиолдолд явуулсан өртөөнд галт тэрэг ирсэн тухай мэдэгдэх болон ирэлтийн хориг дохио өгөхгүй байхыг хатуу анхаарч ажиллана.


4.11. Өртөөн дээр галт тэрэг бүрэн бүрэлдэхүүнтэй ирсэн тухай өртөөний жижүүр өөрийн биеэр буюу техник захирамжийн актанд заасан ажилтны илтгэлээр галт тэрэгний сүүлийн дохио, сүүлчийн вагоны дугаараар магадлана.

4.12. Галт тэрэг сүүлийн дохиогүй ирсэн бол галт тэрэгний биечилсэн хуудас болон сүүлчийн вагоны дугаартай тулган шалгана.

4.13. Өртөөний жижүүр галт тэрэг явуулахын өмнө уг замналын зам, сум руу орж хийх сэлгээний ажлыг зогсоож замнал бэлтгээд гаргах дохиог нээнэ.

4.14. Гаргах дохио нээгдэхэд зэргэлдээ өртөөнд галт тэрэг явуулсан тухай хориг дохио автоматаар өгөгдөнө. Галт тэрэг гаргах дохио өнгөрсний дараа гаргах дохио автоматаар хаагдана. Энэ үед өртөөний жижүүр зэргэлдээ өртөөний жижүүрт болон галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид галт тэрэг явуулсан жинхэнэ цаг, минутыг мэдэгдэнэ.

4.15. Гаргах дохио нээсний дараа галт тэрэг ямар нэгэн шалтгаанаар яваагүй бол өртөөний жижүүр гаргах дохиог хааж энэ тухай галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт бичлэг хийж, галт тэрэг саатсан тухай зэргэлдээ өртөөний жижүүр болон галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэнэ.



4.16. Саатсан буюу уг чиглэлд явах өөр галт тэргийг хориглосон заалттай гаргах дохиогоор явуулахдаа галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн зөвшөөрлөөр өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар явуулна. Өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалын загварыг хоёрдугаар хавсралтад үзүүлэв.

4.17. Галт тэрэг явуулсан өртөөний жижүүр зэргэлдээ өртөөний жижүүр болон галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид галт тэрэг явуулсан цаг, минутыг мэдэгдэнэ. Дараачийн галт тэргийг хагас автомат хориглолоор явуулна. Хагас автомат хориглолын ажиллагаа гэмтэлгүй үед гаргах дохио өөрөө хаагдсан /тусгаарлагдсан хэсэг хуурамчаар эзлэгдэх, гэрлэн дохионы гэрэл шатсан, гаргах дохиог эндүүрч хаасан гэх мэт/ тохиолдолд түүчээ зүтгүүрийн машинчид өртөөний жижүүрийн бүртгэлт тушаал өгч явуулна.


4.18. Нэг замт хоорондын замыг хязгаарлагч өртөөнд гаргах дохио нээсний дараа уг галт тэргийг саатуулж энэ хоорондын замд эсрэг чиглэлийн галт тэрэг явуулах шаардлага гарвал гаргах дохиог хааж галт тэрэгний зохицуулагч нь хязгаарлагч өртөөдийн жижүүрүүдээс хоорондын зам чөлөөтэй эсэх, хориг дохионы байдлыг тодруулсны үндсэн дээр хязгаарлагч хоёр өртөөнд нэгэн зэрэг дамжуулан өгөгдөх галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар зохиомол ирэлтийн хориг дохиог явуулсан өртөөнд туслах товрууны тусламжтайгаар өгч хоорондын замыг чөлөөлж гаргах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалтаар явуулна.

4.19. Нэгтгэсэн гаргах гэрлэн дохио байгаа үед галт тэрэг явуулахдаа гаргах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт болон явахад зөвшөөрөгдсөн галт тэрэгний замын дугаартай тохирсон ногоон өнгөтэй тоо бүхий гол ба хажуу чиглэлийг заасан замнал заагчийн заалтаар гүйцэтгэнэ. Гэрлэн дохион дээр явах чиглэлд замнал заагч /цагаан өнгөтэй/ гэмтсэн үед галт тэргийг нээлттэй гаргах дохиогоор явуулах бөгөөд энэ тохиолдолд өртөөний жижүүр радио холбоо, чанга яригч, өөрийн биеэр болон техник захирамжийн актанд заагдсан ажилтнаар дамжуулан заагч гэмтэлтэй байгаа ба галт тэрэг явах чиглэлд замнал бэлэн болсон тухай машинчид мэдэгдэнэ.

4.20. Явуулахад бэлэн болсон галт тэрэгний түүчээ зүтгүүр зөвшөөрсөн заалттай гаргах гэрлэн дохионоос өнгөрч, дохионы заалт нь машинчид харагдахгүй бол өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар явуулна.

4.21. Явуулах гэж байгаа галт тэрэгний зүтгүүр гаргах дохионоос өнгөрч дохио нээх боломжгүй бол хагас автомат хориглолын ажиллагааг зогсоож, машинчид замын утсан мэдээ олгож галт тэргийг явуулна. Явуулах замналын зохион байгуулалтгүй замаас галт тэргийг утсан мэдээгээр явуулна.

4.22. Хоорондын замаас явуулсан өртөөндөө буцаж ирэх галт тэргийг явуулахдаа хаалттай гаргах дохиог өнгөрөх, буцаж ирэх эрхийн түлхүүр-очирыг машинчид олгож гүйцэтгэнэ. Хоорондын замаас буцаж ирэх галт тэргийг явуулахын өмнө зэргэлдээ өртөөнөөс галт тэрэг явуулах зөвшөөрлийг хагас автомат хориглолын хориг аппаратаар авна.



4.23. Түлхүүр-очир гэмтсэн, хагас автомат хориглолын аппарат нь түлхүүр-очироор тоноглогдоогүй тохиолдолд явуулсан өртөөнд буцаж ирэх галт тэргийг явуулахад хориглолын ажиллагааг зогсоож утсан мэдээгээр гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд машинчид олгосон замын утсан мэдээ нь галт тэргийг хориглосон заалттай гаргах дохио өнгөрөхийг зөвшөөрнө.

4.24. Зэргэлдээ өртөө хүртэл түлхэгч зүтгүүртэй явах галт тэргийг хагас автомат хориглолоор явуулж, галт тэрэг түлхэгч зүтгүүртэй яваа тухай зэргэлдээ өртөөнд мэдэгдэнэ.

4.25. Хоорондын замаас түлхэгч зүтгүүр нь явуулсан өртөөнд буцаж ирэх галт тэргийг явуулахдаа хагас автомат хориглолоор гүйцэтгэнэ. /гаргах дохио нээлттэйгээр/. Өртөөнд буцаж ирэх эрхийн түлхүүр-очирогчид түлхэгч зүтгүүрийн машинчид гардуулан өгнө.

4.26. Явуулсан өртөөнд түлхэгч зүтгүүр нь буцаж ирэх галт тэргийг түлхүүр-очир гэмтэлтэй буюу түлхэгч зүтгүүрт өгөх түлхүүр-очироор тоноглогдоогүй тохиолдолд хагас автомат хориглолын ажиллагааг зогсоож утсан мэдээгээр явуулна.

4.27. Түлхэгч зүтгүүрийн машинчид буцаж ирэх эрхийн замын утсан мэдээ олгоно.

4.28. Замаас авагддаггүй дрезин, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүнийг хоорондын замд галт тэрэгний нэгэн адил явуулна.

ХАГАС АВТОМАТ ХОРИГЛОЛЫН ГЭМТЭЛТЭЙ ҮЕИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН

4.29. Хагас автомат хориглолын ажиллагааг зогсоох гэмтэл:

4.29.1. хоорондын зам чөлөөтэй үед гаргах гэрлэн дохио нээж болохгүй байх;


4.29.2. гаргах ба өнгөрөх гэрлэн дохиог хааж болохгүй байх;

4.29.3. хориглолын дохио аяндаа өгөгдөх;

4.29.4. хориглолын дохиог өгөх буюу авах боломжгүй болох;

4.29.5. удирдлагын аппаратын таг, сум төвлөрүүлэгч ломбогүй /гишгүүр түгжээний буюу туслах товруун дээрхээс бусад ломбо/ байх.

4.30. Энэхүү журмын 4.29-т дурдсан бүх тохиолдолд болон хориглолын байгууламжийг шинэчлэн тоноглох, зөөж байрлуулах, засварлах, турших, хагас автомат хориглолын байгууламжийг солих, түр зогсоох шаардлагатай үед хагас автомат хориглолыг хааж, галт тэрэгний хөдөлгөөнийг утсан холбоогоор удирдана.



4.31. Хагас автомат хориглолын аппаратад цахилгаан механикч үзлэг, үйлчилгээ хийх үед хориглолын ажиллагаа зогсохгүй. Хориг аппарат нээлттэй байх үед өртөөний жижүүр, цахилгаан механикч нар хориглолын байгууламж зөв ажиллаж байгаа эсэхийг онцгой анхааралтайгаар ажиглах үүрэгтэй.

4.32. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн удирдлагын пульт-табло, хориг аппаратад үзлэг, үйлчилгээ хийж дуусаад цахилгаан механикч өртөөний жижүүртэй хамтран хянах хэрэгслүүдийн заалт, хагас автомат хориглолын дохиолол нь бодит байдалтай тохирч байгааг шалгаж өөрийн дугаартай ломбыг тавина.

4.33. Хориг аппаратыг үзлэг, засвар хийхээр онгойлгох бүрд, мөн ажил дууссаны дараа холбооны механикч "Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр"-т заавал бичлэг хийнэ.

4.34. Утсан холбоонд шилжих, галт тэрэгний хөдөлгөөнийг хагас автомат хориглолоор сэргээхийг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь хоорондын замын чөлөөтэй эсэхийг өртөөний жижүүрээр магадлуулсны дараа тушаал өгч гүйцэтгүүлнэ.

4.35. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбооны ажиллагаа тасарсан үед хагас автомат хориглол гэмтвэл утсан холбоонд дараахь маягаар шилжинэ.

4.35.1. хагас автомат хориглолын гэмтлийг илрүүлсэн өртөөний жижүүр галт тэрэгний хөдөлгөөний дэвтрийн бичлэг болон зэргэлдээ өртөөнөөс хоорондын зам чөлөөтэйг магадлаад зэргэлдээ өртөөнд галт тэрэгний утсан мэдээ өгнө.


"..... өртөөдийн хооронд хагас автомат хориглол ажиллахгүй байна. Танайхаас хамгийн сүүлд ...-р галт тэрэг ирсэн. Танайд хамгийн сүүлд ...-р галт тэрэг явуулсан. Утсан холбоонд шилжүүлнэ үү. Өртөөний жижүүр /гарын үсэг/"

4.35.2. зэргэлдээ өртөөний жижүүр хоорондын зам чөлөөтэйг мөн магадлаад дараахь хариуг өгнө.

"Танайхаас хамгийн сүүлд...-р галт тэрэг ирсэн. Танайд хамгийн сүүлд ...-р галт тэрэг явуулсан. Хоорондын зам чөлөөтэй. Утсан холбоо тогтоов. Өртөөний жижүүр /гарын үсэг/"

4.36. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоо тасарсан үед галт тэрэгний хөдөлгөөнийг хагас автомат хориглолоор сэргээхдээ дараахь маягаар гүйцэтгэнэ.

4.36.1. хагас автомат хориглолын гэмтлийг арилгасны дараа "зам суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр"-т бичлэг байгаа нөхцөлд өртөөний жижүүр зэргэлдээ өртөөнд утсан мэдээ өгнө.



"..... өртөөдийн хооронд хагас автомат хориглолын гэмтлийг арилгасан. Танайхаас хамгийн сүүлд ... -р галт тэрэг ирсэн. Танайд хамгийн сүүлд ... -р галт тэрэг явуулсан. Галт тэрэгний хөдөлгөөнийг хагас автомат хориглолоор сэргээнэ үү. Өртөөний жижүүр /гарын үсэг/"

4.36.2. зэргэлдээ өртөөний жижүүр хоорондын зам чөлөөтэйг шалгаад дараахь хариуг өгнө.

"Танайхаас хамгийн сүүлд ...-р галт тэрэг ирсэн. Танайд хамгийн сүүлд ... -р галт тэрэг явуулсан. Хоорондын зам чөлөөтэй. Галт тэрэгний хөдөлгөөнийг хагас автомат хориглолоор сэргээв. Өртөөний жижүүр /гарын үсэг/"

4.37. Хагас автомат хориглолын ажиллагааг зогсоож утсан холбоонд шилжсэн үед галт тэргийг зэргэлдээ хэсэглэх газар хүртэл явуулахын тулд машинчид замын утсан мэдээг гардуулан өгнө.

4.38. Замналын гэрлэн дохио нээгдэхгүй үед галт тэргийг хориглосон заалттай замналын гэрлэн дохио өнгөрч зөвшөөрсөн заалттай гаргах дохио хүртэл явах зөвшөөрлийг өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар өгнө.

4.39. Галт тэрэг хос зүтгүүртэй, хоорондын замын туршид явах түлхэгч зүтгүүртэй яваа үед хоорондын зам эзлэх эрхийн зөвшөөрлийг зөвхөн түүчээ зүтгүүрийн машинчид гардуулна. Энэ тохиолдолд хос ба түлхэгч зүтгүүрийн машинч нар түүчээ зүтгүүрийн машинчийн өгсөн дохиог удирдлага болгоно.

4.40. Өртөө хоорондын шууд холбоо ажилгүй болсон тохиолдолд галт тэргэнд зам авах, өгөх, галт тэрэгний хөдөлгөөнтэй холбогдсон яриаг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоогоор дамжуулан гүйцэтгэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЦАХИЛГААН ОЧИРЫН СИСТЕМТЭЙ ҮЕИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН


5.1. Цахилгаан очирын системтэй үед галт тэрэг хоорондын зам эзлэх зөвшөөрөл нь хоорондын замд хамаарах очир болно.

5.2. Цахилгаан очирын системийн байгууламж нь очирын аппаратаас нэгэн зэрэг нэгээс илүү очир авах боломжгүйгээр хийгдсэн байна.

5.3. Очир бүр дэс дугаар, сери ба хоорондын замыг хязгаарлагч өртөөний нэртэй байна. Хоорондын зам бүрт тохирсон өөрийн серийн очиртой байна.

5.4. Очирын ижил серитэй аппаратыг гурваас цөөнгүй хоорондын зам алгасуулсаны дараа байрлуулж болно.

5.5. Хоорондын замд галт тэрэггүй үед уг хоорондын замыг хязгаарлаж байгаа хоёр өртөөний очирын аппарат дахь очирын тооны нийлбэр нь тэгш тоотой байна.



5.6. Хоорондын замаас явуулсан өртөөндөө буцаж ирэх түлхэгч зүтгүүртэй галт тэрэг явуулдаг өртөөний очирын аппарат нь түлхүүр очир бүхий хэрэгслээр нэмж тоноглогдсон байна.

5.7. Түлхүүр очир бүхий нэмэгдэл хэрэгсэлтэй очирын аппарат нь үндсэн очирог аваагүй байхад түлхүүр очирог авч болохгүй, түлхүүр очирог авсан байхад үндсэн очир авагдахгүйгээр тоноглогдсон байна.

5.8. Галт тэргийг түлхэгч зүтгүүртэйгээр зэргэлдээ өртөө хүртэл явуулдаг өртөөний очирын аппарат нь салдаг очироор тоноглогдсон байна. Салдаг очир бүр нь "очир" ба "билет" гэсэн хоёр хэсгээс бүрдсэн байна.

5.9. Салдаг очир бүхий очирын аппаратыг галт тэрэгний хөдөлгөөнийг цаг хугацаагаар зааглан зохион байгуулах нөхцөлд хэрэглэнэ.

5.10. Очирог механик очир солигчийн тусламжтай буюу гараар бол өртөөний жижүүрийн байрны дэргэдээс солилцоно.

5.11. Очирог гараар солих үед очир нь очир өгөгчид хийгдсэн байна. Галт тэрэг зогсолтгүйгээр өнгөрүүлэх үед гаргах сумын бэлчир дээр очир солилтыг гүйцэтгэхгүй байхыг хатуу анхаарна.

5.12. Хоорондын замын цахилгаан очирын системийн үед дараахь зүйлийг анхаарч ажиллана.

5.12.1. зогсолтгүйгээр өнгөрөх буюу цагийн хуваариар таван минутаас дээшгүй зогсохоос бусад явахад бэлэн болоогүй галт тэргэнд очир авах зөвшөөрөл шаардах;

5.12.2. хэрэглэгдэж байгаа очирог аппаратад хийлгүй хадгалах;

5.12.3. ирсэн галт тэрэгнээс хүлээн авсан очирог аппаратад хийлгүйгээр уг хоорондын замд эсрэг чиглэлд явах галт тэрэгний машинчид шилжүүлэн өгөх;

5.12.4. очирог зэргэлдээ хоорондын зам руу хэтрүүлж авч явах.

ГАЛТ ТЭРЭГ ХҮЛЭЭН АВАХ, ЯВУУЛАХ

5.13. Өртөөний жижүүр галт тэрэг ирэхийн өмнө замналд орсон сэлгээний ажлыг зогсоож, хүлээн авах замналыг бэлтгэж, оруулах дохиог нээнэ. Галт тэрэг өртөөнд ирмэгц очирог өртөөний жижүүрт хүлээлгэн өгөх ба жижүүр галт тэрэг бүрэн бүрэлдэхүүнтэй ирснийг магадлан, ирсэн очирог тэр хоорондын замд хамаарагдах эсэхийг шалгаад, галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт очирог дугаарыг тэмдэглэн, очирог аппаратад хийж, явуулсан өртөөнд нь галт тэрэг ирсэн тухай утсаар мэдэгдэнэ.



5.14. Галт тэрэг түлхэгч зүтгүүртэй ирмэгц өртөөний жижүүр галт тэрэгний зүтгүүрийн машинчаас очирын нэгдүгээр хэсгийг, түлхэгч зүтгүүрийн машинчаас хоёрдугаар хэсгийг хүлээн аваад хоёр хэсгийг нэгтгэж очирын аппаратанд хийнэ.

5.15. Өртөөний жижүүр галт тэрэг явуулахын тулд галт тэрэг очих өртөөний жижүүрийн зөвшөөрлийг утсаар дараахь маягаар асууна.

“.....-р галт тэргийг явуулж болох уу”

5.16. Өртөөний жижүүр галт тэрэг хүлээн авахад саад тотгор байхгүй бол дараахь маягаар утсаар зөвшөөрөл өгнө.

“.....-р галт тэргийг хүлээе” гээд очир авахыг зөвшөөрч индуктор эргүүлж өгнө.

5.17. Явуулах өртөөний жижүүр нь аппаратаас очирыг аваад, галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт, түүний дугаарыг тэмдэглэх үүрэгтэй. Явах галт тэрэгний машинчид очирыг гардуулан өгнө. Сумчны постонд тавигдсан очирын аппараттай өртөөнд сумчин өөрийн авсан очирын дугаарыг өртөөний жижүүрт мэдэгдэнэ.

5.18. Гаргах гэрлэн дохиотой замаас цахилгаан очирын системээр тоноглогдсон хоорондын зам руу галт тэргийг явуулах бол тухайн хоорондын замын очирыг өгөх ба гэрлэн дохионы улаан гэрэл нь унтарсан байна.

5.19. Улаан гэрлийг унтраах боломжгүй тохиолдолд галт тэрэг явуулахыг очироор гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд өртөөний жижүүр улаан гэрлийг унтраах боломжгүй ба явуулах замнал бэлэн болсныг машинчид өөрийн биеэр, сумчин буюу дохиочин, радио холбоогоор мэдэгдэнэ.


5.20. Галт тэрэг явуулахаар очир авсны дараа уг галт тэрэг ямар нэг шалтгаанаар яваагүй бол өртөөний жижүүр очирыг аппаратад буцааж хийх үүрэгтэй бөгөөд зэргэлдээ өртөөний жижүүрт энэ тухайгаа мэдэгдэх ба галт тэрэгний хөдөлгөөний ширээний дэвтэрт тэмдэглэлийг “...-р галт тэрэг саатсан” гэж бичнэ.

5.21. Хоорондын замаас явуулсан өртөөнд буцаж ирэх галт тэргийг явуулахдаа зүтгүүрийн машинчид очирыг олгоно.

5.22. Зэргэлдээ өртөөний жижүүрт болон галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид галт тэрэг явуулсан болон хоорондын замаас буцаж ирсэн тухай мэдэгдэнэ.

5.23. Галт тэрэг явуулах өртөөний жижүүр зэргэлдээ өртөөний жижүүрээс зам авахаар асуухдаа түлхэгч зүтгүүртэй галт тэрэг явуулах гэж байгаагаа мэдэгдэнэ.

5.24. Очирын аппарат салдаг очироор тоноглогдоогүй бол хоорондын замын туршид бүрэлдэхүүнд холбогдохгүй явах түлхэгч зүтгүүртэй галт тэргийг явуулах шаардлага гарвал очирын системийн ажиллагааг зогсоож, галт тэрэгний хөдөлгөөнийг утсан холбоогоор гүйцэтгэнэ.



5.25. Хоорондын замаас явуулсан өртөөнд буцаж ирэх түлхэгч зүтгүүртэй галт тэргийг явуулахад түүчээ зүтгүүрийн машинчид очир, түлхэгчийн машинчид түлхүүр-очирыг олгоно.

5.26. Очирын аппарат түлхүүр-очиороор тоноглогдоогүй бол хоорондын замаас явуулсан өртөөнд буцаж ирэх түлхэгч зүтгүүртэй галт тэрэг явуулах шаардлага гарвал очирын системийн ажиллагааг зогсоож, галт тэрэгний хөдөлгөөнийг утсан холбоогоор гүйцэтгэнэ.

ЦАХИЛГААН ОЧИРЫН СИСТЕМ ГЭМТЭЛТЭЙ ҮЕИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН БА ОЧИРЫН АППАРАТАД ОЧИРЫН ТООНЫ ТОХИРУУЛГА ХИЙХ

5.27. Цахилгаан очирын системийг гэмтэлтэйд тооцох нөхцөл:

5.27.1. хоорондын зам чөлөөтэй байхад очирыг аппаратад хийж болохгүй ба түүнийг аппаратаас авч болохгүй байвал;

5.27.2. хоорондын замд хамаарагдах очир гээгдсэний улмаас очирын тоо сондгой болсон;

5.27.3. очирын аппарат буюу индуктор ломбогүй байвал;

5.27.4. индукторын бариул гэдрэг эргэх /якорийн хамт/;


5.27.5. зэргэлдээ өртөө цахилгаан гүйдэл өгөөгүй байхад очирын аппаратын гүйдэл заагчийн зүү хөдлөх буюу хонх дуугарч байх эдгээр болно.

5.28. Энэхүү журмын 5.26-д дурдсан тохиолдолд болон очирын аппаратыг засварлах, шилжүүлэх, өөрчлөн солих үед цахилгаан очирын системийг ашиглахыг зогсоож, галт тэрэгний хөдөлгөөнийг утсан холбоогоор удирдана.

5.29. Галт тэрэгний хөдөлгөөнийг холбооны нэг хэрэгслээс нөгөө хэрэгсэлд шилжүүлэх, холбооны үндсэн хэрэгслийг сэргээхэд галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь хоорондын зам чөлөөтэй ба аппаратанд очир бүрэн байгааг өртөөний жижүүрээр дамжуулан магадласны дараа тушаал өгч гүйцэтгэнэ.

5.30. Очирын системийн үеийн өртөө хоорондын шууд холбоо гэмтэж очирын аппаратын ажиллагаа хэвийн ажилтай байх үед галт тэрэгний хөдөлгөөнийг цахилгаан очирын системээр гүйцэтгэж, яриаг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоогоор явуулна.

5.31. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоо гэмтэлтэй үед цахилгаан очирын системийн гэмтлийг илрүүлсэн өртөөний жижүүр нь энэ тухай "Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр"-т бичлэг хийгээд зэргэлдээ өртөөний жижүүрт галт тэрэгний утсан мэдээг өгөхдөө:



“Очирын систем гэмтэлтэй. Танайхаас хамгийн сүүлд ...-р галт тэрэг ирсэн. Танайд хамгийн сүүлд ...-р галт тэрэг явуулсан. Надад ... ширхэг очир байна. Утсан холбоонд шилжинэ үү. Өртөөний жижүүр /гарын үсэг/” гэнэ.

5.32. Зэргэлдээ өртөөний жижүүр хүлээн авсан мэдээллийг шалгаад өөртөө байгаа очирогч тоолж хоёр өртөөний аппарат дахь очирын тоо тэгш байвал дараахь хариуг өгнө.

“Танайхаас хамгийн сүүлд ... -р галт тэрэг ирсэн. Танайд хамгийн сүүлд ...-р галт тэрэг явуулсан. Надад ... ширхэг очир байна. Хоорондын зам чөлөөтэй. Утсан холбоонд шилжлээ. Өртөөний жижүүр /гарын үсэг/”

5.33. Очир гээгдсэн, ирсэн ба өнгөрсөн галт тэрэгнээс очир аваагүй тохиолдолд өртөөний жижүүр “Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр”-т бичлэг хийж, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид илтгэнэ.

5.34. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч хоорондын замын чөлөөтэйг болон түүнийг хязгаарлагч өртөөдийн аппаратад байгаа очирын тоог магадлаад утсан холбоонд шилжих тухай тушаал өгнө.

5.35. Өртөөний жижүүр цахилгаан очирын системийн ажиллагааг сэргээхийн тулд цахилгаан механикчийг аппаратаас дахин нэг очир авахыг шаардана.


5.36. Аппаратаас авсан очир нь цахилгаан механикчид хадгалагдана. Очир авсан тухай цахилгаан механикч ба өртөөний жижүүр галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид илтгэх үүрэгтэй бөгөөд үүний дараа цахилгаан очирын системийн ажиллагаа сэргээгдэнэ.

5.37. Гээгдсэн очир олдвол өртөөний жижүүр энэ тухай цахилгаан механикчид мэдэгдэж, цахилгаан механикч олдсон очирогч түрүүчийн гаргаж авсан очирын хамт аппаратад хийх хүртэл өөртөө хадгалах ба очирогчид аппаратад хийсний дараа энэ тухай “Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр”-т бичлэг хийнэ.

5.38. Хязгаарлагч аль нэг өртөөний аппарат дахь очирын тоо хоорондын замын хоёр аппаратад байгаа нийт очирын тооны дөрөвний нэгээс бага байвал өртөөний жижүүр очирын тоог тохируулах шаардлагатай болсон тухай цахилгаан механикчид мэдэгдэнэ.

5.39. Цахилгаан механикч нь зэргэлдээ өртөөнд очиж өртөөний жижүүрийг байлцуулан очирын аппаратыг онгойлгон тэгш тооны очирогч авч, “Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр”-т авсан очирын тоо, дугаарыг заасан бичлэгийг өртөөний жижүүртэй хамтран хийнэ.

5.40. Цахилгаан механикч нь авсан очирогчид очирын тоог тохируулах шаардлагатай болсон өртөөнд жижүүрийг байлцуулан очирын аппаратад хийх ба



хийсэн очирын тоо, дугаарыг заасан бичлэгийг “Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр бичнэ.

5.41. Очирын тохируулга хийсэн тухай цахилгаан механикчийн тэмдэглэл нь өртөөний жижүүрийн гарын үсэг зурснаар батлагдана.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХОЛБООНЫ УТСАН ХЭРЭГСЛИЙН ҮЕИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН

6.1. Холбооны утсан хэрэгслийн үед галт тэрэг хоорондын зам эзлэх зөвшөөрөл нь зүтгүүрийн машинчид өгөх замын утсан мэдээ болно. Замын утсан мэдээ олгохын өмнө жижүүр зэргэлдээ өртөөний жижүүрээс галт тэрэг явуулах зөвшөөрөл авна.

6.2. Өртөөний жижүүр галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоогоор зэргэлдээ өртөөний жижүүртэй албан ярилцлага хийж, утсан мэдээний дэвтэрт тэмдэглэсний дагуу утсан мэдээний маягт бөглөнө. Тэгш чиглэлийн галт тэргэнд хөх өнгийн, сондгой чиглэлийн галт тэргэнд цагаан өнгийн утсан мэдээний маягт хэрэглэнэ. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоо гэмтэлтэй үед өртөө хоорондын холбоогоор албан ярилцлага хийгдэнэ.

6.3. Өртөө хоорондын холбоо, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоо гэмтэлтэй тохиолдолд галт тэрэгний хөдөлгөөний талаар хийгдэх яриаг өөр төрлийн холбоогоор явуулж болно. Замын утсан мэдээний маягыг өртөөний жижүүр өөрөө галт тэрэгний утсан мэдээний дэвтэрт бичигдсэний дагуу бөглөж бичнэ.

6.4. Холбооны утсан хэрэгслийн үеийн галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулахад дараахь зүйлийг хатуу анхаарч ажиллана.

6.4.1. хоорондын зам эзэлгээтэй байхад галт тэрэг явуулахаар зөвшөөрөл хүсэх;

6.4.2. замын утсан мэдээний маягыг зэргэлдээ өртөөнөөс галт тэрэг хүлээн авах зөвшөөрлийн утсан мэдээ авахаас өмнө бөглөж бичих;

6.4.3. өөрөөс явуулах замын утсан мэдээг галт тэрэгний утсан мэдээний дэвтэрт бичихээс өмнө ба өртөөний жижүүрийн гарын үсэггүйгээр дамжуулах.

6.5. Замын утсан мэдээ нь машинчид зэргэлдээ өртөөний оруулах дохио хүртэл галт тэрэгтэй явах эрхийг олгоно. Замын утсан мэдээний загварыг гуравдугаар хавсралтад үзүүлэв.

6.6. Замын утсан мэдээ олгосон үед гаргах гэрлэн дохиотой замаас галт тэрэг явуулахад хориглосон заалттай дохио өнгөрөх эрх нь замын утсан мэдээ болно.



6.7. Галт тэргийг хос зүтгүүртэй буюу хоорондын замын туршид явах түлхэгч зүтгүүртэй явуулах үед замын утсан мэдээг түүчээ зүтгүүрийн машинчид өгнө.

6.8. Хоорондын замаас буцаж ирэх түлхэгч зүтгүүртэй галт тэрэг явуулах үед замын утсан мэдээг түүчээ ба түлхэгч зүтгүүрийн машинчид олгоно.

ГАЛТ ТЭРЭГНИЙ УТСАН МЭДЭЭНИЙ ДЭВТЭР ХӨТЛӨХ

6.9. Холбооны утсан хэрэгслээр галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах үед өртөө бүрт галт тэрэгний утсан мэдээний дэвтэр хөтлөгдөнө. Хөтлөгдөж байгаа утсан мэдээний дэвтрээс тухайн хоорондын замын чөлөөтэй буюу эзэлгээтэй байдал нь тодорхой харагдаж байна.

6.10. Нэг замт хоорондын замыг хязгаарлагч өртөөдөд хоорондын замын тоогоор дэвтэр хөтөлнө. Утсан мэдээний бичлэгийг дараалсан байдлаар гүйцэтгэнэ.

6.11. Галт тэрэгний утсан мэдээний дэвтрийг өртөөний жижүүр өөрөө хөтөлж гарын үсэг зурж баталгаажуулна. Галт тэрэгний утсан мэдээний дэвтэрт бичих бичлэгийн хугацааг түргэтгэхийн тулд суурь бүтэц эзэмшигчийн шийдвэрийн дагуу галт тэрэгний утсан мэдээний эх бичлэг бүхий тусгай тэмдгийг хэрэглэж болно.

6.12. Явуулж байгаа галт тэрэгний утсан мэдээний дугаарлалтыг хоног бүрийн 00:00 цагаас нэгээс эхлэн дугаарлаж тухайн хоорондын зам бүрт утсан мэдээний дэвтэрт бүртгэнэ.

6.13. Дохиолол холбооны үндсэн хэрэгслийн гэмтэл хоногийн дотор дахин давтагдан утсан холбоонд шилжсэн бол анхны шилжилтээр эхлэн бүртгэсэн замын утсан мэдээний дугаарлалтын дарааллыг хэвээр хадгална.

6.14. Галт тэрэгний утсан мэдээнд ямар нэгэн засвар нэмэлт хийж, баллаж үл болно.

6.15. Галт тэрэгний утсан мэдээний маягтыг буруу бичих, засвар хийсэн тохиолдолд чагтлан зурж, "хүчингүй" гэсэн тэмдэглэл хийж шинээр бичнэ. "Хүчингүй" гэсэн тэмдэглэлтэй утсан мэдээг дугаарлахгүй.

6.16. Өртөөний жижүүр ээлж хүлээн авах ба хүлээлгэн өгөхдөө галт тэрэгний утсан мэдээний дэвтэртэй танилцан гарын үсэг зурна.

ТАНИЛЦАВ:

"Сар, өдөр, цаг, минут,

Ээлж хүлээн авсан. Өртөөний жижүүр

/гарын үсэг/

Ээлж хүлээлгэж өгсөн. Өртөөний жижүүр

/гарын үсэг/"



6.17. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах үндсэн хэрэгслийн ажиллагаа алдагдаж холбооны утсан хэрэгсэлд шилжсэн нөхцөлд өртөөний жижүүр ээлж хүлээлцэхдээ галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн ... тоот тушаалаар холбооны утсан хэрэгсэлд шилжсэн гэсэн тэмдэглэл хийж зэргэлдээ өртөөний жижүүрт өөрийн нэрийг хэлж утсан мэдээний дэвтэрт хүлээлцсэн тухай бичлэгийн дор тэмдэглүүлнэ.

“Сар, өдөр, цаг, минут

Зохицуулагчийн... дугаар тушаалтай... утсан холбоотой ээлж хүлээлгэж өгсөн.
Өртөөний жижүүр /гарын үсэг/”

6.18. Галт тэрэгний утсан мэдээ нэвтрүүлэхийн өмнө өртөөний жижүүр нэг нь нөгөөдөө өөрсдийн албан тушаал, нэрийг мэдэгдэнэ. Утсан мэдээг дамжуулах талаар өртөөний жижүүрүүдийн хоорондох яриа нь зөвхөн галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоогоор явагдана.

6.19. Галт тэрэгний утсан мэдээг дамжуулсаны дараа түүний шалгалтыг утсан мэдээг хүлээж авсан ажилтнаар эх бичлэгийн үг нэг бүрээр давтуулах замаар гүйцэтгэнэ. Хүлээн авсан өртөөнөөс дамжуулсан бичлэг нь дамжуулсан өртөөний жижүүр “зөв” гэсэн үгээр нотлосны дараа хоёр өртөөний галт тэрэгний утсан мэдээний дэвтэрт утсан мэдээг дамжуулсан ба хүлээн авсан цаг, минутыг тэмдэглэж өртөөний жижүүр гарын үсэг зурж баталгаажуулна. Галт тэрэгний хөдөлгөөний үеийн утсан мэдээний загваруудыг дөрөвдүгээр хавсралтад үзүүлэв.

6.20. Галт тэрэг хүлээн авах ба явуулах үед галт тэрэгний утсан мэдээний үндсэн загварыг хэрэглэнэ.

6.21. Явуулсан өртөөнд буцаж ирэх галт тэрэг явуулах үед галт тэрэгний утсан мэдээ нэвтрүүлэх горимыг дөрөвдүгээр хавсралтад заасан байдлаар мөрдөнө:


6.21.1 зэргэлдээ өртөө хүртэл явах түлхэгчтэй галт тэрэг явуулах үед утсан мэдээ 1, 2, 3, 4 дүгээр загвараар “түлхэгчтэй” гэдэг үг нэмж дамжуулагдана.

6.21.2 галт тэрэг явуулсан тухай мэдэгдлийг 3 дугаар загвараар, харин түүний буцаж ирсэн тухайг 7 дугаар загвараар нэвтрүүлнэ.

6.21.3 явуулсан өртөөндөө түлхэгч зүтгүүр нь хоорондын замаас буцаж ирэх галт тэрэг явуулна.

6.21.4 галт тэрэг явуулсан тухай мэдэгдлийг 3 дугаар загвараар “..... дугаар километрээс буцаж ирэх түлхэгчтэй” гэсэн үгнүүд нэмж дамжуулна.

6.21.5 галт тэрэг ирсэн мэдэгдлийг 4 дүгээр загвараар, түлхэгч буцаж ирсэн тухай 10 дугаар загвараар нэвтрүүлнэ.



6.22. Галт тэрэг зөрүүлж явуулах үед эсрэг чиглэлд явуулах галт тэрэгтэй өртөөний жижүүр 4 ба 1 дүгээр загварыг нэгтгэн галт тэрэг ирсэн тухай зэргэлдээ өртөөнд мэдэгдэхийн хамт галт тэрэг явуулах асуултыг тавина.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ДОХИОЛОЛ ХОЛБООНЫ ТОГТООСОН БҮХ ХЭРЭГСЛИЙН АЖИЛЛАГАА ТАСАРСАН ҮЕИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН

7.1. Дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасарсан үед галт тэрэгний хөдөлгөөнийг бичгэн мэдэгдлийн тусламжтайгаар зохицуулна.

7.2. Хоорондын замыг хязгаарлагч өртөөдийн жижүүр, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн хооронд галт тэрэгний хөдөлгөөний тухай албан яриаг тэдгээрийн мэдэлд байгаа холбооны бүх хэрэгслээр явуулах бололцоогүй тохиолдолд галт тэрэгний хөдөлгөөнийг бичгэн мэдээгээр тогтооно.

7.3. Дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасарсан үед галт тэрэг хоорондын зам эзлэх эрх нь өртөөний жижүүр машинчид олгох цагаан өнгийн хуудсан дээр улаан бичгээр бичигдсэн зөвшөөрөл болно.

7.4. Энэ үед явуулсан галт тэрэг зэргэлдээ өртөөнд хүрсэн тухай мэдээ байхгүй бол өмнө нь яваа галт тэрэгний сүүлч хамгаалагдаагүй байж болох тул машинч хоорондын замд сонор сэрэмжтэй нэн даруй зогсоход бэлэн явна.

7.5. Дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасарсан үед явуулахыг хориглох галт тэрэг:

7.5.1. зорчигч ба хүмүүсийн;

7.5.2. тэсрэх дэлбэрэх аюултай, хэтрүү овортой ачаатай ба урт бүрэлдэхүүнтэй;

7.5.3. сэргээн босгох, галын галт тэрэг, туслах зүтгүүрээс бусад хоорондын замд зогсож ажиллах;

7.5.4. хоорондын замд нийлсэн зам руу явах.

7.6. Түлхэгч зүтгүүр зэргэлдээ өртөө хүртэл хоорондын замыг гүйцэт туулж очно.

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН

7.7. Дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасарсан үед хоорондын замд галт тэрэгний хөдөлгөөнийг бичгэн мэдээгээр тогтоох хүртэл нэг замт хэсэгт давуутай чиглэл болох сондгой чиглэлийн галт тэргийг явуулж болно.



7.16. Нэг чиглэлд явах галт тэрэгнүүдийг урьд нь явуулсан галт тэрэгний хоорондын замыг туулах хугацаан дээр гурван минутыг нэмж тооцоод явуулна.

7.17. Холбоо тасрахаас өмнө хэсэглэх газар гэж тооцогдон ажиллаж байсан замын постууд галт тэрэгний хөдөлгөөнд оролцохгүй.

7.18. Дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасрахаас өмнө давуутай чиглэлийн галт тэргийг өртөөнөөс хоорондын замд нийлсэн зам руу явуулсан бол тухайн галт тэрэг хүрсэн ба түүнийг татаж авсан тухай туслах постын жижүүрээс мэдэгдэл аваагүй тохиолдолд уг галт тэрэг туслах постод хүрэх, нийлсэн замд галт тэргийг татаж авахад шаардагдах бүх хугацаан дээр 3 минут нэмсэн бүх нийлбэрийг хоорондын зам эзэлгээтэй байх хугацаа гэж тооцно.

7.19. Дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасарсан бүхий л хугацааны турш галт тэргийг цагаан өнгийн хуудсан дээр улаанаар бичигдсэн зөвшөөрлөөр явуулна.

7.20. Өртөө хоорондын холбоог таслахгүйн тул дөртөөний жижүүрүүд байгууламжийн ажиллагааг сэргээх хүртэл тэгш болон сондгой чиглэлд явж байгаа галт тэрэг бүрийн түүчээ зүтгүүрийн машинчаар галт тэрэг хэрхэн явуулж байх тухай бичгэн мэдээг "А" буюу "Б" маягтаар илгээх үүрэгтэй. Тус бичгэн мэдээний "А" буюу "Б" маягтын загварыг тавдугаар хавсралтад үзүүлэв.


7.21. "А", "Б", "В" маягтаар бичигдсэн мэдээнүүд нь хоёр өртөөний галт тэрэгний утсан мэдээний дэвтэрт бичигдэнэ.

7.22. Дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасрахаас өмнө давуутай чиглэл болох сондгой талын өртөөний жижүүр тэгш чиглэлээс галт тэрэг хүлээж авах зөвшөөрөл өгсөн бол энэ галт тэрэг ирэх хүртэл буюу зэргэлдээ өртөөнөөс /постоос/ галт тэрэг явуулахаа больсон тухай мэдээ хүлээн авах хүртэл хоорондын замыг эзэлгээтэйд тооцно.

7.23. Нийлсэн замын постонд тэгш чиглэлд галт тэрэг явуулах зөвшөөрөл өгсөн бол галт тэрэг ирсэн ба түүнийг нийлсэн зам руу татаж авсан тухай мэдэгдэл постоос хүлээн авах хүртлээ хоорондын замыг эзэлгээтэйд тооцно.

7.24. Дохиолол холбооны тогтоосон бүх хэрэгслийн ажиллагаа тасрахаас өмнө туслах постын жижүүрт сондгой чиглэлийн галт тэргийг нийлсэн замаас явуулах зөвшөөрөл өгсөн ба түүнээс уг галт тэргийг явуулсан тухай мэдээ хүлээн авсан бол холбоо тасарсаны дараа давуутай чиглэлийн галт тэрэг хоорондын замд явуулах өртөөний жижүүр постоос өртөө хүртэлх хоорондын замын хэсгийг явж өнгөрөхөд шаардагдах хугацаан дээр 3 минутыг нэмж, дараа нь энэ чиглэлд зэргэлдээ өртөө рүү анхны галт тэрэг явуулахыг зөвшөөрнө.

7.25. Нийлсэн замын постоос сондгой галт тэрэг явуулсан тухай мэдэгдэл хүлээн аваагүй бол постын жижүүрээс сумыг гол замд тавьсан тухай буюу галт тэргийг явуулаагүй саатуулсан тухай мэдэгдэл хүлээн авах хүртэл хоорондын замыг эзэлгээтэйд тооцно.



НАЙМДУГААР БҮЛЭГ

СЭРГЭЭН БОСГОХ ГАЛТ ТЭРЭГ, ДРЕЗИН, ГАЛЫН ГАЛТ ТЭРЭГ БА ТУСЛАХ ЗҮТГҮҮРИЙН ХӨДӨЛГӨӨН

8.1. Сэргээн босгох, галын галт тэрэг, дрезин, туслах зүтгүүрийг замд зогсож саатсан галт тэрэгний түүчээ зүтгүүрийн машинч, /туслах машинч/ төмөр замын ажилтан нараас хүлээн авсан тусламж хүссэн тухай /бичгээр, утсаар, радио холбоогоор дамжуулсан/ хүсэлтийг үндэслэн хоорондын замд явуулна.

8.2. Сэргээн босгох ба галын галт тэргийг дуудах ажлыг суурь бүтэц эзэмшигчийн баталсан зааврын дагуу гүйцэтгэнэ.

8.3. Хоорондын замд зогссон галт тэрэгний машинч /туслах машинч/ тусламж шаардах үедээ өртөөний жижүүр буюу галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид галт тэрэгний зүтгүүр хэддүгээр километрийн, хэддүгээр зуутад ямар шалтгаанаар зогссон тухай мэдэгдэнэ.

8.4. Өртөөний жижүүр буюу галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчтай утсан ба радио холбоо байхгүй үед өртөөнд бичгэн шаардлага хүргэж өгөхийн тулд галт тэрэгний зүтгүүрийг шаардлагатай тохиолдолд ашиглаж болно. Зүтгүүрийг бүрэлдэхүүнээс салгахын өмнө вагонуудыг өөрөө өнхрөхөөс хамгаалан тооцоот тоормосны ивүүр буюу гар тоормосоор бэхэлсний дараа зүтгүүр салгахыг зөвшөөрнө.

8.5. Зүтгүүрийг бүрэлдэхүүнээс салгахын өмнө үлдэж байгаа вагоны төгсгөлийн краныг бүрэн онгойлгож автомат тоормосыг ажиллагаанд оруулсан байна.


8.6. Замын хэвгийн байдлаас болж зогссон газарт нь орхих галт тэрэгний бүрэлдэхүүнийг бэхлэхэд вагон бэхлэх хэрэгсэл нь хүрэлцэхгүй бол зүтгүүрийг бүрэлдэхүүнээс салгахгүй байхыг анхаарч ажиллана.

8.7. Хоорондын замаас тусламж хүссэн машинч нь өртөөний жижүүрт мэдэгдсэн бол галт тэргийг тусламж хүссэн километр, зуутаас хөдөлгөхгүй байхыг хатуу анхаарна.

8.8. Хоорондын замд аргагүйдэн зогссон галт тэргийг тусламж ирэх хүртэлх хугацаанд Дохиолол холбооны журмын 4.9-т зааснаар хамгаалалт хийнэ.

8.9. Өртөөний жижүүр сэргээн босгох, галын галт тэрэг, туслах зүтгүүр илгээх тухай хүсэлтийг хүлээн авангуут нэн даруй галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид илтгэнэ. Утсаар буюу радио холбоогоор хүлээж авсан хүсэлтийг галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт тэмдэглэнэ.

8.10. Сэргээн босгох ба галын галт тэрэг, туслах зүтгүүрийг тусламж хүссэн хэсэгт явуулахыг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар гүйцэтгэнэ.



8.11. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч тусламж үзүүлэх тухай хүсэлтийг хүлээж аваад ээлжийн ахлах зохицуулагчид мэдэгдэнэ. Ээлжийн ахлах зохицуулагч нь хөдөлгөөн зохицуулагч нартай хамтран хоорондын замыг хязгаарлагч аль өртөөнөөс тусламж үзүүлэх, аль өртөө рүү хөдлөх бүрэлдэхүүнийг авахыг тогтооно.

8.12. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь сэргээн босгох, галын галт тэргийг яаралтай явуулах болсон тухай сэргээн босгох болон галын галт тэрэгний даргад мэдэгдэнэ.

8.13. Сэргээн босгох, галын галт тэрэг ба туслах зүтгүүрийг бусад бүх галт тэрэгний хөдөлгөөнд хаагдаж байгаа хоорондын замд энэ журмын 10.30-д заасны дагуу явуулна.

8.14. Зүтгүүрийн машинчид ташуу улаан зураастай цагаан өнгийн маягт дээр бичигдсэн зөвшөөрлийг олгоно. Маягтанд сэргээн босгох, галын галт тэрэг буюу туслах зүтгүүр хэддүгээр километрийн, хэддүгээр зуут хүртэл явж очих газрыг заасан байна. Галт тэрэгний сүүл талаас тусламжийг үзүүлэх бол өртөөний жижүүр галт тэрэгний уртыг тооцож, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч хянаснаар тухайн тусламж хүсэгч хэддүгээр километрийн, хэддүгээр зуутад хамгаалалт хийснийг тогтооно.

8.15. Саадтай газрын дэргэд галт тэрэгний хөдөлгөөнд зориулан түр пост нээсэн тохиолдолд машинчид ташуу улаан зураастай цагаан өнгийн маягт дээр бичсэн зөвшөөрлийг олгоно. Энэ үед сэргээн босгох, галын галт тэрэг, туслах зүтгүүрийн хөдөлгөөнийг хоорондын замыг хязгаарлагч өртөөдийн жижүүр, постын жижүүртэй урьдчилан тохиролцооноор гүйцэтгэнэ.

8.16. Тусламж шаардсан галт тэрэгний зүтгүүр болон сүүлийн вагон зогсож байгаа км зуутаас 2 тийш тус бүр 1000 метрт зогссон байхаар тооцож туслах зүтгүүрийн машинчид ташуу улаан зураастай маягтыг олгоно.

8.17. Хаалттай хоорондын замд явуулж байгаа сэргээн босгох, галын галт тэрэг, тусламжийн зүтгүүр бүрийг өртөөний дарга, түүний эзгүйд орлогч буюу ажлаас чөлөөтэй байгаа өртөөний жижүүрийн аль нэг нь дагалдаж явна. Дагалдаж явах ажилтан нь галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчаас галт тэрэг зогсож байгаа километр, зуутыг тодруулж, өртөөний жижүүрийн өгч байгаа маягтанд заасан километр, зуут зөв байгааг магадлана.

8.18. Тусламжийн зүтгүүрийн бригад ташуу улаан зураастай цагаан өнгийн зөвшөөрлийн маягтанд заасан километр, зуутад зогсоно. Дагалдан яваа ажилтны удирдлаганд тусламж шаардсан галт тэрэг /бүрэлдэхүүн/-д зүтгүүрийг холбож, бүрэлдэхүүнийг бэхэлсэн ивүүрийг бүрэн авсныг магадлан галт тэргийг зөвшөөрлийн маягтанд заасан өртөө, зөрлөгт явуулна.

8.19. Хөдлөх бүрэлдэхүүн замаас гараагүй, замын байгууламж төхөөрөмж эвдрээгүй бол тусламжийн зүтгүүрийн машинч, дагалдан явсан ажилтан өртөөнд галт тэргийг бүрэн бүрэлдэхүүнтэй орж ирсний дараа галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт бичлэг хийж хоорондын замыг бүх галт тэрэгний хөдөлгөөнд сэргээлгэнэ.



8.20. Тусламж үзүүлэхээр хоорондын замд явж байгаа зүтгүүрийн машинч нь ташуу улаан зураастай цагаан өнгийн маягт дээр бичигдсэн зөвшөөрөлд заагдсан газраас 2 километрийн өмнө хурдаа бууруулж 25 км/цагаас ихгүй хурдтай явж саад тохиолдвол нэн даруй зогсоход бэлэн сонор сэрэмжтэй явна.

8.21. Хоорондын замд сэргээн босгох, галын галт тэрэг, тусламжийн зүтгүүр, дрезин явуулсан ба буцаж ирсэн цаг, минутыг өртөөний жижүүр галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт тэмдэглэж зэргэлдээ өртөөний жижүүр, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэнэ.

8.22. Хоорондын замд гарсан аливаа саад бэрхшээлийг арилгахад оролцож ажилласан замын мастераас багагүй албан тушаалтны мэдэгдлийг /бичгээр, утсаар, радио холбоогоор дамжуулсан/ өртөөний жижүүрийн дамжуулснаар галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч хоорондын замыг нээх тушаал өгнө. Тушаалын заалтыг галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт тэмдэглэнэ. Утсаар болон радио холбооны хэрэгслээр мэдэгдэл өгсөн бол тухайн ажилтан ажил дууссаны дараа өртөөний жижүүрт хөтлөгдөх галт тэрэгний хөдөлгөөний дэвтэрт бичлэг хийж гарын үсэг зурна.

8.23. Галт тэрэг хоорондын замд салсан /тасарсан/ үед машинч дараахь үүргийг гүйцэтгэнэ.

8.23.1. галт тэрэгний бүрэлдэхүүн салсан, тасарсан тухай хоорондын замын хязгаарлагч өртөөдийн жижүүрт мэдэгдэнэ.

8.23.2. туслах машинчаар бүрэлдэхүүний байдал, салсан вагонуудын холбох төхөөрөмжийг шалгуулж, тэдгээр нь гэмтэлгүй бол туслах машинчийн дохиогоор галт тэрэгний салсан бүрэлдэхүүнийг 3 км/цагаас илүүгүй хурдтай ухарч холбоно.


8.23.3. тоормосны эвдэрсэн хийн зөөлөн хоолойг нөөцөөс буюу сүүлчийн вагоноос эсвэл зүтгүүрийн өмнө талаас авч солино. Суурь бүтэц эзэмшигчээс баталсан авто тоормосын зааврын дагуу тоормосын товчилсон туршилт хийнэ.

8.23.4. туслах машинч нь бүрэлдэхүүнийг холбосны дараа хөдөлгөөнийг сэргээхийн өмнө галт тэрэгний бүрэлдэхүүн бүрэн эсэхийг сүүлчийн вагоны дугаар, сүүлийн дохиогоор магадлана.

8.24. Дараахь нөхцөлд хоорондын замд галт тэрэгний тасарсан бүрэлдэхүүнийг хооронд нь холбохгүй байхыг анхаарна.

8.24.1. байгаль, цаг агаарын тохиромжгүй нөхцөлд дохиог ялгахад хүндрэлтэй байвал;

8.24.2. тасарсан бүрэлдэхүүн 0.0025-аас огцом хэвгий дээр зогссон нь холбох үед түлхэлтээс өөрөө галт тэрэгний хөдөлгөөний эсрэг зүг хөдлөх магадлалтай байвал.



8.25. Тасарсан хэсэг нь хэвгий дээр үлдсэн бол бүрэлдэхүүнийг хооронд нь холбох, тусламж шаардахаас өмнө машинчийн заалтаар өөрөө өнхрөхөөс нь болгоомжлон зүтгүүрийн тоормосны ивүүр буюу гар тоормосоор бэхлэнэ.

8.26. Бүрэлдэхүүнийг хооронд нь холбох боломжгүй бол машинч салсан бүрэлдэхүүний хоорондын зайг тоймлон тусламж хүсэхдээ өртөөний жижүүрт мэдэгдэж, энэхүү журмын 8.3-8.8 ба 8.23-т заасны дагуу сэргээн босгох галт тэрэг буюу тусламжийн зүтгүүрийг шаардана.

8.27. Шаардлагатай тохиолдолд энэхүү журмын 8.3-8.8-т дурдсанаар тусламж хүссэн тухай бичгэн шаардлагыг өртөөнд хүргэхээр галт тэрэгний зүтгүүрийг ашиглаж болно /вагонтой буюу вагонгүй/. Зүтгүүрийн сүүлийн дохиог Дохиолол холбооны журмын 8.1.2-8.1.4-т зааснаар тогтооно.

8.28. Хүн суулгасан ба тэсрэх дэлбэрэх, аюултай ачаатай бүрэлдэхүүнийг төмөр замын ажилтны хамгаалалтгүйгээр хоорондын замд үлдээхгүй байхыг анхаарч ажиллана.

8.29. Цахилгаан очирын системээр тоноглогдсон хоорондын замд тусламж шаардахаар өртөө рүү явж байгаа зүтгүүрийн машинч галт тэргийг орхисон хоорондын замын очирыг өртөөний жижүүрт дамжуулан өгнө.


8.30. Хоорондын замыг чөлөөлж хөдөлгөөнийг сэргээтэл өртөөний жижүүр очирыг аппаратад хийлгүй хадгална.

8.31. Хагас автомат хориглолоор тоноглогдсон хоорондын замд сүүлийн хэсгийг бүрэн бүтэн ирснийг магадлах хүртэл ирэлтийн мэдээг өгөхгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

8.32. Хоорондын замыг хаах ба хоорондын замд салсан галт тэргэнд тусламж үзүүлэхийн тулд зүтгүүр буюу галт тэрэг явуулах ажиллагааг энэхүү журмын 10.30-т зааснаар гүйцэтгэнэ.

8.33. Галт тэрэгний сүүлээс тусламж үзүүлэх үед сүүлийн хэсэг хаана байгаа нь мэдэгдээгүй бол тусламжийн зүтгүүрийн машинчид /сэргээн босгох галт тэрэгний/ ташуу улаан зураастай цагаан өнгийн маяганд бичсэн зөвшөөрлөөс гадна "хоорондын замд салсан вагонууд байгаа газар мэдэгдээгүй" гэсэн анхаарамж олгоно. Тусламж үзүүлэх зүтгүүрийн машинч хоорондын замд онц сонор сэрэмжтэй, саад тохиолдох үед зогсоход бэлэн явна.

8.34. Алсын удирдлагатай зөрлөгт хэвийн бус нөхцөл үүссэн тохиолдолд удирдах өртөөнөөс алсын удирдлагатай зөрлөг рүү удирдлагын бүсийг хөдөлгөөн хариуцсан салбарын даргын тушаалаар шилжүүлнэ. Уг тушаалыг үндэслэн алсын удирдлагатай зөрлөгийн жижүүр бие даан жижүүрийн үүрэг гүйцэтгэнэ. Удирдлага шилжүүлсэн тохиолдолд удирдах өртөөний жижүүр алсын удирдлагатай зөрлөгийн жижүүрт галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой захирамж өгөхгүй байхыг анхаарч ажиллана.



8.35. Удирдлагын бүсийг 12 цаг ба түүнээс дээш хугацаагаар шилжүүлэх тохиолдолд ээлжийн жижүүрийг томилон ажиллуулна.

8.36. Хэвийн бус нөхцөл үүссэн тохиолдолд багц дүрмэнд заасны дагуу хөдөлгөөнийг зохицуулна.

ХООРОНДЫН ЗАМААС ГАЛТ ТЭРЭГ ЯВУУЛСАН ӨРТӨӨНДӨӨ БУЦАЖ ИРЭХ

8.37. Галт тэрэг хоорондын замд зогссоны дараа цаашид хөдөлгөөнөө үргэлжлүүлж чадахгүй, явуулсан өртөөнд буцаж ирэх шаардлага гарвал машинч өөрөө буюу туслах машинчаар дамжуулан энэ тухай /бичгээр, утсаар/ өртөөний жижүүр, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэнэ.

8.38. Мэдээ хүлээн аваад галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч энэхүү журмын 8.39-т заасны дагуу галт тэргийг явуулсан өртөөнд нь буцаан ирүүлэх дарааллыг тогтооно.

8.39. Хоорондын замд зогссон галт тэргийг өртөөний оруулах дохио хүртэл 5 км/цагаас хэтрэхгүй хурдтай ухраана. Хэрэв уг галт тэрэг 1 секцийн түлхэгч зүтгүүртэй тохиолдолд зүтгүүрүүдийн радио холбооны найдвартай ажиллагааг хэвийн үед 40км/цагаас ихгүй хурдтай, 2 секцийн зүтгүүртэй бол тогтоосон хурдаар өртөөний оруулах дохио хүртэл ухраана.

8.40. Галт тэрэг ухарч яваа талын эхний вагоны тоормосны талбай, тусгай гишгүүр дээр туслах машинч эсвэл машинчийн заавраар төмөр замын байгууллагын өөр ажилтан явж болно.

8.41. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар хоорондын замыг бүх галт тэрэгний хөдөлгөөнд хаах ба зогссон галт тэрэгний машинчид өртөөний орох дохио хүртэл ухрах тушаалыг утсан болон радио холбоо, тогтоосон маягтаар дамжуулна.


8.42. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн бүртгэлт тушаалын маягт:

"...км... зуутад зогсож цааш явж чадахгүй болсон тухай ... дугаар галт тэрэгний машинч ... -ийн мэдэгдлийг үндэслэн ... хоорондын замыг ... цаг ... минутаас эхлэн уг галт тэрэгнээс бусад бүх галт тэрэгний хөдөлгөөнд хаав. ... дугаар галт тэргийг ... өртөөний оруулах дохио хүртэл ухраахыг зөвшөөрөв.

Галт тэрэгний зохицуулагч:

/ДНЦ/....."

8.43. Хоорондын замыг хаах тухай галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаал өгсний дараа зогссон галт тэрэг, өртөө хооронд утсан ба радио холбоо ажиллахгүй бол өртөөний жижүүр машинчид ташуу улаан зураастай цагаан өнгийн маягтанд бичсэн зөвшөөрлийг олгож галт тэргийг ухраана.



8.44. Хоорондын замаас өртөөнд буцаж ирж байгаа галт тэргийг оруулах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалттай дохиогоор буюу энэхүү журмын 11.35-11.37-д заасны дагуу хүлээн авна.

8.45. Явуулж байгаа галт тэрэгний сүүл өртөөний хязгаараас гараагүй зогссон тохиолдолд галт тэргийг зайлшгүй ухраах шаардлагатай бол энэхүү журмын 13 дугаар бүлэг /Өртөөнд хийгдэх сэлгээний ажил/-т заасны дагуу өртөөний жижүүрийн захирамжаар гүйцэтгэнэ. Өртөөний жижүүрийн захирамжийн маягтын загварыг зургадугаар хавсралтад үзүүлэв.

ХООРОНДЫН ЗАМААС ГАЛТ ТЭРГИЙГ ХЭСЭГЛЭН ЗӨӨХ

8.46. Хоорондын замаас галт тэргийг хэсэглэн зөөх шаардлага гарсан тохиолдолд машинч өөрөө буюу туслах машинчаар дамжуулан энэ тухай /бичгээр, утсаар/ өртөөний жижүүр, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэнэ.

8.47. Мэдээ хүлээн авсан галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь ахлах хөдөлгөөн зохицуулагчтай хамтран галт тэргийг хэсэглэн зөөх дарааллыг тогтооно.

8.48. Галт тэрэгний машинч нь Техник ашиглалтын журмын 17.3.1-т заасныг баримтлан ажиллана.

8.49. Галт тэрэгний машинч нь үлдсэн хэсгийг энэхүү журам болон Дохиолол холбооны журмын дагуу бэхлэж хорио хамгаалалт тавьсан тухай, бүрэлдэхүүний эхлэл, төгсгөл зогсож буй км зууцыг бодит байдлаас нь тодорхойлж хязгаарлагч өртөөний жижүүр болон галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэнэ.

8.50. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь машинчийн мэдэгдлийг үндэслэн уул хоорондын замыг туслах зүтгүүрээс бусад бүх галт тэрэгний хөдөлгөөнд хаана.

8.51. Галт тэрэгний эхний хэсгийг оруулах дохионы зөвшөөрсөн заалтаар өртөөнд хүлээн авна. Үлдсэн хэсгийг татаж авахдаа хоорондын замд аргагүйдэн суусан галт тэргэнд тусламж үзүүлэхтэй нэгэн адил гүйцэтгэнэ.

8.52. Хоорондын замаас үлдсэн хэсгийг татан авсан дараа хоорондын замын чөлөөтэй, ивүүр бэхэлгээг бүрэн авсан зэргийг тусламжинд явсан ажилтны илтгэлийг үндэслэн уг хоорондын замыг бүх галт тэрэгний хөдөлгөөнд нээх тушаалын галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч өгнө.



ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ДРЕЗИНИЙ ХӨДӨЛГӨӨН

9.1. Төмөр замаар явдаг замаас авагддаггүй замын моторт тээврийн хэрэгсэл ашиглалтын дор дурдсан зааврыг төмөр замын тээврийн бүх үйлдвэрийн газар, аж ахуйн нэгж, түүнчлэн төмөр замаар явах эрх бүхий дрезин, моторт тэрэг ба автоматорисыг ашигладаг бусад газрууд заавал биелүүлнэ.

9.2. Бусдын эзэмшилд байгаа дрезин, моторт тэргийг шаардлагатай тохиолдолд суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрөлтэйгээр төмөр замаар явуулах бөгөөд тэгэхдээ уг зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа болон хөдлөх нэгжийн явах газрыг тэр зөвшөөрөлдөө заасан байна.

9.3. Техникийн нөхцөл болон батлагдсан төсөлд тохирох бүтэц бүхий дрезин, моторт тэрэг, автоматорисыг төмөр замд ашиглана. Тэдгээрийн бүтцэд төслийг баталсан байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

9.4. Дрезин, моторт тэрэг, автоматорис нь төмөр замын Техник ашиглалтын журамд заасан тэмдэг, бичигтэй байх бөгөөд бусдын эзэмшилд байгаа дрезин, моторт тэрэг, автоматорис нь тухайн эзэмшигчийн ялгах тэмдэгтэй байна.

9.5. Дрезин, моторт тэрэг автоматорис бүр дээр техникийн паспорт хөтлөх бөгөөд түүнд үйлдвэрээс гарсан, ашиглалтад орсон он, сар, өдөр, гүйлт, бүтцийн өөрчлөлт, хөдөлгүүр сольсон эсэх, хугацаат засварын тухай бусад шаардлагатай мэдээллийг тэмдэглэнэ.


9.6. Төмөр замд ашиглагдаж байгаа дрезин, моторт тэрэг, автоматорисийг хэний эзэмшилд байгаагаас үл хамааран суурь бүтэц эзэмшигчийн мэргэжлийн комиссоос олгосон замын моторт тээврийн уг нэгжийг жолоодох эрхийн үнэмлэхтэй, энэхүү журам, Техник ашиглалтын журам, Дохиолол холбооны журам, Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам болон аюулгүй ажиллагааны дүрмийн шалгалт өгсөн хүн жолоодно.

9.7. Өргүүрээр төхөөрөмжлөгдсөн дрезинийг суурь бүтэц эзэмшигчийн заалтаар жолооч, түүний туслах үйлчилнэ.

9.8. Хоорондын замд явуулж байгаа дрезин, моторт тэрэг ба автоматорис нь галт тэрэгний нэгэн адил явах эрхтэй.

9.9. Замаас авагддаггүй тээврийн моторт нэгжийг хоорондын замд явуулах ажлыг өртөөний жижүүр зөвхөн галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ.

9.10. Анхны өртөөнөөс явуулахдаа жолоодох эрхийн үнэмлэх ба аж ахуйн зохих нэгжээс олгосон замналын хуудас, түүнчлэн бусад газрын мэдэлд байгаа



дрезин, моторт тэрэг ба автоторисын төмөр замаар явах зөвшөөрөл жолоочид нь байгаа эсэхийг өртөөний жижүүр шалгана.

9.11. Хоёроос доошгүй тооны дрезин, моторт тэрэг ба автоторисыг холбож явуулахыг зөвшөөрнө. Замын моторт тээврийн нэгжид залгагдах хөдлөх нэгжийн тоог паспортанд заасан тоормосны хэрэгсэл байгаа эсэх, баримтлах уруудуур дээр явах зөвшөөрөгдсөн хурд зэргийг харгалзан суурь бүтэц эзэмшигч тогтооно.

9.12. Зөвхөн дрезин /ДГКУ, АСГ/, автоторис /АГВ ба АГМ/-ийг галт тэрэгний бүрэлдэхүүнд тээвэрлэхийг зөвшөөрнө. Тэдгээрийг тээвэрлэхийг энэхүү журам болон Төмөр замаарч ачаа тээвэрлэх журамд зааснаар гүйцэтгэнэ.

9.13. Дрезиний тэвшинд ба автоторис, моторт тэрэгний бүхээгт паспортанд зааснаас илүү тооны хүн /үйлчлэх бригадын ажилтан нараас бусад/ авч явахгүй байхыг анхаарна. Дрезин /АГМУ/ дээр 3-аас, дрезин /ДГКУ/ дээр 4-өөс илүүгүй ажилтан, дрезин нь хүн суухад зориулагдан хийгдсэн суудлаар тоноглогдсон бол зохих тооноос илүү ажилтан авч явахгүй байхыг анхаарна.

9.14. Дрезин, моторт тэрэг, автоторист холбосон тавцант вагонд ажилтан тээвэрлэхгүй байхыг анхаарна. Дрезин, моторт тэрэг чиргүүлээ түрж явахаас өөр бололцоогүй үед /ачаа буулгасны дараа хоорондын замаас өртөө рүү буцах үед, ирэх өртөөнд сэлгээ хийх зэрэг тохиолдол/ жолоочийн туслах буюу томилогдсон дохиочингоос өөр хүн чиргүүл дээр явахгүй байхыг анхаарна.


9.15. Ажиллаж байгаа дрезин, моторт тэрэг ба автоторис нь дараахь тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

а. гол сэлбэг хэрэгсэл ба эд хогшил, бензинээр ажилладаг хөдөлгүүртэй бол сэнсний оосор, агшаагуур, бүрэн тооны очлуур, асаалтын ороомог, дамжуулах гинж /нэг ажиллагаатай бол/ буюу чагтан голт, тоормосны иж бүрдэл, бензиний хоолойг үлээлгэж цэвэрлэхэд зориулсан автомашины шахуурга;

- дизель хөдөлгүүртэй бол сэнсний хийн шахуургын дамжлагын ременүүд тус бүр 3 ширхэг буюу хийн шахуургын кардан, дамжуулгын, түлшний шахуургыг форсунктай холбогч хоолойнууд /2 ширхэг/;
- түлш шахаж нэмэх хөөргө иж бүрдлээрээ;
- бүх дрезин, моторт тэрэг ба автоторист цэнэглэгдсэн гал унтраагч, тулгууртай шурган буюу шахуурган өргүүр, /20 тонны даацтай/, тоормосны ивүүр, нэг ширхэг прожекторын ба арын дэнлүүний бүх чийдэнгүүд.

б. дохионы багаж, хэрэгслүүд;

- бүрээ, дохионы дөрвөн ширхэг дарцаг /2 ширхэг улаан ба 2 ширхэг шар өнгөтэй/ 6 ширхэг бялт, гар дэнлүү 2 ширхэг тус тус байна. Дрезин,



моторт тэрэг ба автомоторист нь хөдөлгөөний хурд ба гүйлтийг заагч хурд хэмжигчээр тоноглогдсон байна.

9.16. Замын моторт тээврийн нэгжийг тэдний тасралтгүй ажиллагаа ба хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангаж чадахуйц бүрэн бүтэн байдалд байлгаж байх ёстой. Гэмтэлтэй дрезин моторт тэрэг автомоторис ба чиргүүлийг хоорондын замд гаргахгүй байхыг хатуу анхаарна. Тэдгээрт тавигдсан халаалтын багажууд нь галын аюулгүй ажиллагааны зааврын шаардлагыг бүрэн хангасан байна.

9.17. Өртөөнөөс явахын өмнө жолооч нь моторт хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн эсэхийг шалгаж, үзлэг хийх үүрэгтэй бөгөөд тэгэхдээ мотор, явах анги, тоормосны байгууламж, нуман зүүлт, өргүүрийн төхөөрөмж ба угсрах өргөгчийн байдалд онцгой анхаарал тавьж чиргүүлтэйгээ зөв холбогдсон, ачаа зөв ачигдаж бэхлэгдсэн эсэхийг мөн түүнчлэн өргөгч ба эргэх тавцан найдвартай бэхлэгдсэн, энэхүү журмын 9.15 (б)-т заасан дохионы хэрэгслүүд, сэлбэг хэрэгсэл ба жижиг хэсгүүд байгаа эсэхийг шалгана.

9.18. Дрезин, моторт тэрэг, автомоторисын жолооч нар нь ажилд гарах үедээ:

9.18.1. төмөр замын техник ашиглалтын журам, Төмөр замын дохиолол холбооны журам, Төмөр замын галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам, аюулгүй ажиллагааны заавар, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангахад чиглэгдсэн замын хэмжээний бүх тушаал, цахилгааны шаардлагыг баримтлах;


9.18.2. замын моторт тээврийн зохих нэгжийг жолоодох тогтоосон зааврын эрхийн үнэмлэх /техникийн үзлэгийн акт, албан ёсоор бөглөсөн замын хуудас зэргийг биедээ авч явна. Бусдын эзэмшилд байгаа замын моторт тээврийн нэгжийн жолооч нь дээр дурдсан зүйлээс гадна Техник ашиглалтын журмын мэдлэгээр шалгалт өгсөн тухай үнэмлэх биедээ авч явах ба замаар явах зөвшөөрөлтэй байна.

9.19. Төмөр замаар тогтмол явдаг, түүнчлэн төмөр замын бус байгууллагын эзэмшилд байгаа өөрөө явагч техник хэрэгслүүдэд жил бүр техникийн шалгалт, үзлэг туршилтыг заавал хийх бөгөөд ашиглалтад тэнцсэн тухай гэрчилгээтэй байна.

9.20. Замын моторт тээврийн техникийн үйлчилгээний үед техникийн паспорт байгаа эсэх, түүнийг бөглөлт зөв эсэхийг шалгана.

9.21. Замын моторт тээврийн техникийн хяналтын үзлэгийг замын аж ахуйн салбарын даргын томилсон /замын моторт тээврийн мэргэжилтэн/ ажилтан гүйцэтгэнэ. Үзлэгийн үр дүн, туршилтын аяллын актыг тогтоосон маягтаар бүрдүүлнэ.

9.22. Замаас авагддаггүй нэгжийг ашиглах үед зам төмөр хэлхээгээр тоноглогдсон хэсгүүдэд түүний жолооч нь хос дугуйн өнхрөх гадаргуу цэвэр байгаа эсэхийг нягтлан шалгана. Зам төмрийн толгой мазут, цас, элс бусад материалаар бүрхэгдэн шунт алдагдуулж болзошгүй бол энэ зам дээр дрезин, моторт тэрэг, автомоторисыг зогсоохгүй байхыг анхаарна.



9.23. Автомат хаалт буюу гэрлэн дохионы дохиоллоор тоноглогдсон гарамд ойртох үед жолооч нь онц сэрэмжтэй явна.

9.24. Жил бүрийн үзлэгийн актгүй, засварын хугацаа дууссан замын моторт тээврийн хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглахгүй байхыг анхаарна.

9.25. Өөрийнхөө мэдэлд замын моторт тээврийн нэгжтэй аж ахуйн нэгжийн дарга нар нь дрезин, моторт тэрэг, автоматогдсон хугацааг чанд баримтлах, тэдгээрийн байдал, жолооч нар тэдгээрийн туслахын техник ашиглалтын журам, хэсгийн огтлол зураг, дохио, заагч, мөн түүнчлэн чиргүүлтэй болон бусад хөдлөх бүрэлдэхүүнтэй явах, өртөө, хоорондын замд ачааг ачих, буулгах журмын мэдлэгийг тогтмол шалгана.

9.26. Дрезин /ДГКУ, АСГ/ ба угсран сэргээн босгох автоматогдсон /АГВ, АГВМ/-ийг ачааны галт тэргэнд өөрийн гол дээрх ачааны адилаар илгээнэ.

9.27. Түлхэгчгүй явах галт тэрэгний бүрэлдэхүүнд /ДГКУ ба АГВ/, автоматогдсон /АГМУ/-ыг сүүлийн дөрвөн голт вагоны өмнө холбоно.

9.28. Бүрэлдэхүүнд нь дрезин /ДГКУ, АСГ/ ба автоматогдсон /АГВ, АГМУ/ орсон галт тэргийг түлхэхгүй байхыг хатуу анхаарна.

9.29. дрезин /ДГКУ, АСГ/ ба угсран сэргээн босгох автоматогдсон /АГВ ба АГМУ/-ыг ачааны галт тэргэнд илгээх үед тэдгээр дрезинүүдийн техник тоноглол ба тээвэрлэлтийн зааврыг мэддэг, эрхтэй жолооч дагалдана. Жолооч нарт ачааны галт тэргэнд дрезинийг хэрхэн тээвэрлэх зааварчилгаа өгсөн байна. Зааварчилгаа өгсний дараа акт бүрдүүлнэ.

9.30. Ялгах довоос дрезин /ДГКУ, АСГ/ ба автоматогдсон /АГВ АГМУ/-ыг буулгахгүй байхыг анхаарна.

9.31. Заагдсан дрезиний гол дээрх ачаалалтын ялгавар 2 тонноос хэтэрч болохгүй. Дрезин /ДГКУ, АСГ/, автоматогдсон /АГВ, АГМУ/-ыг, тээвэрлэлтэд бэлтгэхдээ дээр нь тохируулан замын чигчээс ачих, очих газар руу тээвэрлэх зөвшөөрөл авахын тулд илгээгч нь явуулах өртөөний жижүүрт захиалгаа өгөх бөгөөд явахад бэлэн болсон эсэхийн шалгалтыг суурь бүтэц эзэмшигчийн томилсон комисс үзнэ.

9.32. Дрезин /ДГКУ, АСГ/, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүн, автоматогдсон /АГМУ/-ыг галт тэрэгний бүрэлдэхүүнд явуулахын өмнө тэдгээрийг тээвэрлэлтэнд бэлэн болгосон тухай акт бүрдүүлнэ. Актыг 4 хувийг үйлдэх, илгээж байгаа дрезин, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний техникийн бичиг баримтанд 1 хувийг хавсаргана. Актын 2 хувь нь ачааны бичиг баримтанд хавсаргахаар өртөөнд дамжуулна. Үлдсэн 1 хувь нь ачаа илгээгчийн хэрэгт үлдэнэ.

9.33. Замын моторт тээврийн арчилгаа, ашиглалтын дэглэмийг суурь бүтэц эзэмшигч тогтооно.



АРАВДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН ТӨХӨӨРӨМЖ, БАЙГУУЛАМЖ, ЗАМ ДЭЭР АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН

10.1. Төхөөрөмж, байгууламж, зам дээр засвар хийхдээ хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангаж, галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг зөрчихгүй байна. Ихээхэн хэмжээний барилга, зам засварын ажлыг гүйцэтгэхэд зориулан галт тэрэгний хөдөлгөөний зурмагт “цонх” гаргаж, уг ажлын улмаас хурд хязгаарлагдахыг харгалзаж байвал зохино.

10.2. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт заагдаагүй зам, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбооны байгууламж, бусад төхөөрөмжийн засварын ажлыг галт тэрэгний хөдөлгөөний аль бага байгаа үед хоорондын замыг хаахгүйгээр гүйцэтгэнэ.


10.3. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт заагдаагүй зам, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбооны байгууламж, бусад төхөөрөмжийн засварын ажлыг гүйцэтгэхэд галт тэрэгний хөдөлгөөнийг тасалдуулахад хүргэхээр байвал уг ажлыг эхлэх, дуусгах цагийг хөдөлгөөн хариуцсан салбарын дарга ажил удирдагчтай хамтран тогтооно.

10.4. Техник ашиглалтын журмын 8.2.1-8.2.5-д заасны дагуу ажил удирдагч нь хөдөлгөөнийг тасалдуулахад хүргэх ажил гүйцэтгэхэд хөдөлгөөний зурмагт “цонх” гаргасан үед галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчтай байнгын холбоогоор хангагдсан байна.

10.5. Өөрийн шинж байдлаар хоорондын замыг хаахыг шаардсан зам, барилга засварын ажлыг гүйцэтгэхэд суурь бүтэц эзэмшигчээс зөвшөөрөл авсан байна. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт ажил хийхээр “цонх” урьдчилан төлөвлөгдөөгүй бол ажил гүйцэтгэх заавар ба хоорондын замыг хаах, нээх хугацааг тохиолдол бүрд нь урьдчилан уг ажлыг гүйцэтгэх салбарын дарга суурь бүтэц эзэмшигчидтэй тохиролцоно. Хоорондын замыг хаах, нээх ажиллагааг ажил эхлэхийн өмнө, ажил дууссаны дараа галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар гүйцэтгэнэ.

10.6. Ажил гүйцэтгэх тухай суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрөлд хоорондын зам хаахаар тогтоосон хугацаа, ажлыг нэгдсэн удирдлагаар хангах ажил удирдагчийн нэрийг заасан байна. Ажил удирдагчийн нэр, албан тушаалыг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч хоорондын замыг хязгаарлагч өртөөдийн жижүүрт мэдэгдэнэ.

10.7. Хоорондын замыг хаахын өмнө ажил удирдагч нь хоорондын замыг хязгаарлагч өртөөдийн жижүүр, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нарт хаалттай хоорондын замд аж ахуйн галт тэрэг, замын машин механизмуудыг явуулах захиалга өгнө.



10.8. Захиалгад аж ахуйн галт тэрэг, замын машин механизмуудыг явуулах дараалал, тэдгээрийн хаалттай хоорондын замд тус бүрийн зогсох анхны зогсолтын километр, зуут, ажил дууссаны дараа эдгээр галт тэргийг хаашаа буцаан явуулах талаар заасан байна. Аж ахуйн галт тэрэгний хувьд найрлагын бүдүүвчийг заасан байна.

10.9. Хоорондын замд ажил эхлэх хугацаа болоход галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч хоорондын зам галт тэрэгнээс чөлөөлөгдсөн болохыг тогтоогоод дараа нь хоорондын замыг хязгаарлагч өртөөдийн жижүүрт болон ажил удирдагчид зам хаах тухай тушаал өгнө.

10.10. Ажил хийх газарт галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчтай утсан холбоо байхгүй тохиолдолд ажил хийх газарт ойролцоо байгаа өртөөний жижүүр нь хоорондын зам ба өртөөний замыг хаасан тухай тушаалыг ажил удирдагчид дамжуулна. /утсаар буюу ажил хийх газраас томилсон хүнээр/ галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалыг /бичгээр буюу утсаар/ хүлээн авч, ажил хийх газраа тогтоосон дохиогоор хамгаалахаас өмнө ажил удирдагч ажлаа эхлэхгүй байхыг хатуу анхаарна.

10.11. Байгууламж, төхөөрөмжийг засварлахын тулд хаалттай хоорондын замд аж ахуйн галт тэрэг, дрезин, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүн, машин, агрегатыг ташуу улаан зураастай цагаан өнгийн маяганд бичсэн зөвшөөрлөөр явуулна. Энэ зөвшөөрөлд ажил удирдагчийн захиалгын дагуу хоорондын замд галт тэрэг бүрийн зогсох газрыг /километр, зуутыг/ заана.

10.12. Хаалттай хоорондын замд нэгэн зэрэг хэд хэдэн аж ахуйн галт тэрэг, дрезин, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүн, замын машин түүнчлэн бусад байгууллагын машин, механизмыг оролцуулан ажиллуулж болох боловч энэхүү журмын 10.6-д зааснаар нэг ажилтны удирдлаганд ажиллана. Машин, агрегат, аж ахуйн галт тэрэг бүрийн зүтгүүрийн машинч нь ташуу улаан зураастай цагаан өнгийн маяганд бичсэн зөвшөөрөлд заагдсан газар хүртэл явна.

10.13. Анхны галт тэрэг тогтоосон хурдтай, дараачийн галт тэрэг 20 км/цагаас дээшгүй хурдтай явах бөгөөд галт тэрэг хоорондын зай 1 километрээс багагүй байвал зохино.

10.14. Зэргэлдээ хэсэглэх газраас хаалттай хоорондын замд өөд өөдөөсөө явж байгаа аж ахуйн галт тэрэг нь зөвхөн зөвшөөрөл /ташуу улаан зураастай цагаан/-д заасан бөгөөд ажил удирдагчийн тушаалаар зогсох зөөврийн дохио тавигдсан газар хүртэл явна.

10.15. Эсрэг чиглэлд зогссон галт тэрэг хоорондын зай 1 километрээс багагүй байна. Зогссоны дараа аж ахуйн галт тэрэг, машин, агрегатын явах цаашдын хөдөлгөөнийг ажил удирдагчийн заалтаар гүйцэтгэнэ.

10.16. Аж ахуйн галт тэрэгний зогсох километр, зуут нь өртөөний заагт байгаа тохиолдолд өртөөний замаас ажил удирдагчийн мэдэлд ажиллахаар маягт олгоно.



10.17. Хоорондын зам нь явалтын хугацаа ихтэй тахир тойруу, хэвгий болон үзэгдэх орчны хувьд таатай бол галт тэрэгний зохицуулагчийн зөвшөөрснөөр урьд нь явуулсан ачааны галт тэрэгний араас гэхдээ 5-аас доошгүй минутын дараа хоорондын замыг хаахыг хүлээлгүйгээр анхны аж ахуйн галт тэрэг, замын машин механизмуудыг хойноос нь явуулж болно. Энэ тохиолдолд эхний аж ахуйн галт тэрэг 20 км/цагаас ихгүй хурдтай явна.

10.18. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн бүртгэлт тушаалаар хоорондын замыг хязгаарлагч өртөөний жижүүрт болон ажил удирдагчид дараахь маягаар зөвшөөрлийг өгнө.

“... хоорондын замыг хаахтай холбогдуулан ажил гүйцэтгэхээр энэ хоорондын замд ... дугаар галт тэргийг ... өртөөнөөс ... дугаар галт тэрэгний араас суурь бүтэц эзэмшигчийн ...-р шийдвэрийн үндсэн дээр мөрдүүлэн явуулахыг зөвшөөрөв. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч..... /гарын үсэг/”

10.19. Аж ахуйн галт тэрэг буюу машин, агрегатыг ташуу улаан зураастай цагаан өнгийн маяганд бичигдсэн зөвшөөрлөөр явуулна. Ажил удирдагчийн захиалгын дагуу зөвшөөрөлд галт тэрэг бүрийн хоорондын замд анхны зогсолт хийх газар, километр, зууцыг заана. Анхны аж ахуйн галт тэрэгний машинчид анхаарамжийг өгнө. Үүнд:


“Таны өмнө ... цаг ... минутанд ... дугаар галт тэрэг явуулсан. Түүнийг хүрсэн тухай мэдээ хүлээж аваагүй”

10.20. Дараагийн аж ахуйн галт тэрэг хоорондын замд явах үедээ энэхүү журмын 10.12-10.16-д заасныг мөрдөнө. Явуулсан галт тэрэг зэргэлдээ өртөөнд хүрмэгц хоорондын замыг галт тэрэгний хөдөлгөөнд хаасан тушаалыг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч өгнө.

10.21. Хоорондын замд нэгэн зэрэг ажиллуулахаар өртөөнөөс явуулсан нэг галт тэргэнд байгаа аж ахуйн галт тэрэг, замын машин, механизм нь ажил удирдагчийн заалтаар хоорондын замд салгагдах буюу холбогдож болно. Галт тэргэнд өөрөө хөдлөгч нэгжүүд байрлуулах дэглэмийг ажил удирдагч тодорхойлох бөгөөд тэр нь замын ажил гүйцэтгэх үед галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангах зааврын дагуу тогтоогдоно.

10.22. Ажил удирдагчийн заалтаар хоорондын замд ажил гүйцэтгүүлэхээр өөр хооронд нь холбосон хэд хэдэн аж ахуйн галт тэргийг өртөөнөөс явуулах үед галт тэрэг бүрийн машинчид ташуу улаан зураастай цагаан өнгийн маяганд бичсэн зөвшөөрлийг олгоно.

10.23. Аж ахуйн галт тэрэг, замын машин, механизм хоорондын замд буюу өртөөний хязгаарт ажил гүйцэтгэх үед ажил удирдагч буюу түүний томилсон ажилтан дагалдаж явна. Суурь бүтэц эзэмшигчийн шийдвэрээр шаардлагатай үед аж ахуйн галт тэрэгний ажил удирдагчийг томилж болно.



10.24. Галт тэрэгний хөдөлгөөнийг зогсоож ажил гүйцэтгэхдээ тогтоосон хугацаанд ажлыг бүрэн дуусгаж, төхөөрөмж байгууламжийг галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангахуйц байдалд оруулан, шаардлагатай бол хурд бууруулах дохио үлдээгээд зогсох дохиог хурааж авна.

10.25. Аж ахуйн галт тэрэг, замын машин, механизмыг хоорондын замаас явуулахыг ажил удирдагч, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчтай урьдчилан зөвшилцсөнөөр гүйцэтгэнэ.

10.26. Аж ахуйн галт тэргийг хоорондын замаас өртөөнд ирэх дэглэмийн тухай галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч хязгаарлах өртөөдийн жижүүрт мэдэгдэнэ.

10.27. Аж ахуйн галт тэрэг, замын машин, механизмын ажил дуусмагц ажил удирдагч эсвэл түүний томилсон ажилтан зам болон ажил хийгдсэн орчин, бүх төхөөрөмжүүдэд үзлэг хийж хөдөлгөөний хэвийн ажиллагаанд саад болох дутагдлыг нэн даруй арилган, замын хажууд байгаа шинэ хуучин сэлбэг материал тогтоосон оврын хязгаарт багтаж байгаа эсэхийг шалгана.

10.28. Хоорондын замд ажил хийгээд буцаж яваа аж ахуйн галт тэрэг, машин, агрегатын /анхныхаас бусад/ хурд 20 км/цагаас ихгүй байх бөгөөд тэдгээрийн хоорондын зай нь 1 километрээс багагүй байна.

10.29. Хоорондын замыг нээхийг зам, хиймэл байгууламжийн ажил дуусч, хоорондын замд аж ахуйн галт тэрэг, замын машин, механизм үлдээгүй болон ямар байгууллага ажил гүйцэтгэснийг үл харгалзан галт тэрэгний хөдөлгөөнд нөлөөлөх бусад саад тотгорууд байхгүй болсон тухай замын мастераас доошгүй албан тушаалтны мэдэгдлийг үндэслэн /бичгээр, утсаар буюу радио холбоогоор/ галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар гүйцэтгэнэ.

10.30. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч мэдэгдэл хүлээн авч хоорондын замыг хязгаарлагч өртөөдийн жижүүрт тушаал өгнө.

10.31. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбоо, эрчим хүчний байгууламжийн ажиллагааг сэргээх ажлыг ахлах цахилгаан механикч, эрчим хүчний диспетчерийн мэдэгдлийг хүлээн авснаар гүйцэтгэнэ.

10.32. Ажил дууссаны дараа хоорондын замаас хойно хойноосоо буцаж яваа аж ахуйн галт тэрэг, замын машин, механизмыг тус бүрд нь хүлээж авах замгүй бол өртөөний нэг зам дээр хүлээж авахыг зөвшөөрнө. Анхны галт тэргийг оруулах дохио нээж хүлээн авна. Дараачийн аж ахуйн галт тэрэг, машин, агрегат бүрийг өртөөнд оруулахдаа замын тодорхой хэсэг дээр билет газарчаар хүлээн авна.

10.33. Галт тэрэг, машин, агрегатыг өртөөний анхны суман шилжүүлгийн өмнө зогсоож, цааш нь өртөөний жижүүрийн захирамжаар тухайн зам руу оруулна.

10.34. Галт тэрэг өртөөнд орох үед машинч нь онц сонор сэрэмжтэй зогсоход бэлэн явна.



10.35. Хоорондын замыг хаах шаардлагагүй замын байгууламж, төхөөрөмжийн засварын ажлыг галт тэрэгний хөдөлгөөний хоорондох чөлөөтэй хугацаанд хийнэ. Энэ үеийн хөдөлгөөний аюулгүй ажиллагааг суурь бүтэц эзэмшигчээс тогтоосон зам засварын ажлыг гүйцэтгэх үед галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах заавраар тогтооно.

10.36. Байгууламж, төхөөрөмжинд засварын ажил хийхэд хоорондын зам хаах шаардлагагүй бол аж ахуйн галт тэрэг, дрезин, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүнийг хоорондын замд явуулахдаа галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн шийдвэрээр гүйцэтгэнэ.

10.37. Аж ахуйн галт тэрэг, дрезин, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүнийг хоорондын замд зохих дохиолол холбооны тогтоосон хэрэгслийн зөвшөөрлөөр явуулна.

10.38. Ажил удирдагч ба машинчид галт тэрэг өртөөнд ирэх /буцаж ирэх/ цагийн тухай анхаарамж олгоно.

10.39. Хоорондын замыг анхаарамжинд заагдсан хугацаанаас хэтрүүлж эзлэхгүй байхыг хатуу анхаарна.

10.40. Ажил удирдагч нь аж ахуйн галт тэрэг хоорондын замд гарахын өмнө хөдөлгөөнд нөлөөлөх саад тотгор байгаа эсэхийг магадлана.

10.41. Өртөөний зам дээр хийгдэх ажлыг Техник ашиглалтын журам ба Дохиолол холбооны журмын шаардлагыг мөрдлөг болгон гүйцэтгэнэ.

10.42. Өртөөний жижүүр нь ажил удирдагчийн “Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр”-т хийсэн бичлэгтэй танилцаад ажил хийж буй зам, замын тодорхой хэсэг рүү орохгүй байх, эдгээр замаар бууруулсан хурдтай, онцгой сонор сэрэмжтэй явах тухай заалтыг өртөөний хязгаарт ажиллаж байгаа постын жижүүр, дохиочин, сумчин, найруулагч, зүтгүүрийн машинч нарт өгөх ба галт тэрэг явуулах, өнгөрүүлэх, сэлгээний ажил хийхийн өмнө өртөөн дээр албан үүргээ гүйцэтгэж байгаа ажилтнуудад паркийн холбоо, чанга яригчаар урьдчилан анхааруулж мэдэгдэнэ. Засварын ажил гүйцэтгэж байгаа зам дээр галт тэрэг хүлээж авах шаардлагатай бол ажил удирдагч, машинчид анхааруулж мэдэгдэнэ.

10.43. Суурь бүтцэд шинэчлэлт, засвар үйлчилгээний ажил хийж дууссаны дараа гүйцэтгэлийн чанарыг шалгах, байнгын ашиглалтанд хүлээн авах журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.



АРВАННЭГДҮГЭЭРБҮЛЭГ

ГАЛТ ТЭРЭГ ХҮЛЭЭН АВАХ БА ЯВУУЛАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

11.1. Өртөөний байгууламж, төхөөрөмжийг ашиглах аргыг техник захирамжийн актаар тогтооно. Өртөөнд галт тэргийг осол аюулгүй, саадгүй хүлээн авах, явуулах, өнгөрүүлэх, сэлгээний ажлын ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж байхаар техник захирамжийн актыг зохионо.

11.2. Техник ашиглалтын журмын 14.1.1 ба 14.1.2-т заасны дагуу техник захирамжийн актыг төмөр замын байгууллагын бүх ажилтан /галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой/ заавал биелүүлнэ.

11.3. Сум, дохионы төвлөрүүлэлтээр тоноглогдсон өртөөнд дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийг ашиглах заавар, техник захирамжийн актанд заасны дагуу галт тэрэг хүлээн авах, явуулах, өнгөрүүлэх замнал бэлдэх үйл ажиллагааг өртөөний жижүүр гүйцэтгэнэ.

11.4. Төвлөрүүлэгдээгүй суман шилжүүлэгтэй өртөөнд галт тэрэг хүлээн авах, явуулах замнал бэлтгэхдээ өртөөний жижүүр бүх сумчдад нэгэн зэрэг албан ярианы тогтоосон дэглэмийг баримтлан тодорхой, ойлгомжтой захирамж өгнө.

11.5. Төвлөрүүлэгдсэн суман шилжүүлэгтэй сумтай өртөөний жижүүр галт тэрэг хүлээн авах, явуулах замналыг цаг хугацаанд нь бэлтгэх бөгөөд дохио нээхдээ ирж, явж байгаа галт тэрэгний машинч дохионы заалтыг цаг тухайд нь зөв хүлээн авч тогтоосон хурдаараа сааталгүй явах нөхцөлийг тооцсон байна.

11.6. Төвлөрүүлэгдээгүй сумтай өртөөний жижүүр галт тэрэг хүлээн авах, явуулах, өнгөрүүлэх замнал бэлтгэх захирамжийг сумчин нарт өгөхдөө замнал бэлтгэж дуусаад дохиог цагт нь нээсэн байх боломжийг урьдчилан тооцсон байна.

11.7. Төмөр замын буудал, зорчигчийн галт тэрэг хооронд байгаа зам дээр ачааны галт тэрэг зогсоохгүй байхыг хатуу анхаарна. Шаардлагатай тохиолдолд төмөр замын буудал, зорчигчийн галт тэрэг хооронд байгаа зам дээр ачааны галт тэрэг зогсох үед зорчигчдод нэвтрэх боломж олгон дамжих гүүр буюу хонгилгүй бол ачааны галт тэргийг хоорондуур нь салгаж тавина.

11.8. Зогсож байгаа зорчигчийн галт тэрэг, төмөр замын буудлын хооронд байгаа замаар галт тэрэг, сэлгээний бүрэлдэхүүн, зүтгүүр өнгөрүүлэх шаардлага гарвал өртөө ба буудлын жижүүр зорчигчдыг буулгах, суулгах үеийн аюулгүй ажиллагааг хангахаар дараахь арга хэмжээг авах үүрэгтэй.

11.8.1. зүтгүүрийн бригадад урьдчилан анхааруулах;

11.8.2. зорчигчдод өртөө /буудал/-ний чанга яригчаар зарлах.

11.9. зорчигчийн галт тэрэг зогсдог замаар галт тэрэг, сэлгээний бүрэлдэхүүн өнгөрүүлэхийг өртөөний техник захирамжийн актаар тогтооно.



11.10. Хүлээн авах, явуулах зам нь зам төмөр хэлхээгээр тоноглогдоогүй өртөөний жижүүр зорчигчийн, ачаа-зорчигчийн, хүмүүсийн галт тэргийг хүлээн авахын өмнө аль зам дээр хүлээж авах тухайгаа галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид илтгэнэ.

11.11. Өртөөний техник захирамжийн актанд галт тэрэг хүлээж авах, явуулахаар заагдаагүй замаар галт тэрэг хүлээн авах, явуулахыг зөвхөн шаардлагатай тохиолдолд суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрснөөр галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд өртөөний жижүүр хүлээн авах, явуулах зам чөлөөтэй замналд орсон сумын байдал зөв эсэхийг хянах самбар байхгүй бол өртөөний дарга түүний орлогч, постын ба паркийн жижүүрээр газар дээр нь шалгуулна.

ГАЛТ ТЭРЭГ ХҮЛЭЭН АВАХ

11.12. Өртөөнд галт тэрэг хүлээн авахдаа Техник ашиглалтын журмын 15.2.3-т заасны дагуу өртөөний техник захирамжийн актанд заасан чөлөөтэй зам дээр нээлттэй оруулах дохиогоор хүлээн авна. Галт тэргийг хүлээн авахдаа жижүүр машинчтай албан ярилцлага хийнэ. Өртөөний жижүүр галт тэргийг цаг тухайд нь саадгүй хүлээн авахын тулд хүлээн авах замыг чөлөөтэй байлгах үүрэгтэй.

11.13. Техник ашиглалтын журмын 15.2.7-д заасны дагуу өртөөний жижүүр сум түгжээтэй, хүлээн авах зам чөлөөтэй, хүлээн авах замналын суман дээр сэлгээ хийхийг зогсоосон, галт тэрэг хүлээн авах замнал бэлэн болсныг магадлахгүйгээр оруулах дохио нээхгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

11.14. Өртөөний жижүүр галт тэргийг аюул осолгүй хүлээж авахын тулд дараахь ажлыг гүйцэтгэх үүрэгтэй.

11.14.1. өртөөний техник захирамжийн актаар тогтоосон зориулалттай, хөдлөх бүрэлдэхүүнээр эзлэгдээгүй зам дээр хүлээн авах;


11.14.2. ирж байгаа галт тэргээр замыг эзлүүлэх дарааллыг урдаас төлөвлөх ба түүндээ тохируулан галт тэрэг бүрийг хүлээж авах зам бэлтгэх;

11.14.3. дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн хянах самбараар замуудын эзэлгээтэй эсэхийг хянах ба энэ нь ээлжийн ажлын гүйцэтгэсэн зурмагтай тохирч байгааг магадлах.

11.15. Төвлөрүүлэгдээгүй суман шилжүүлэгтэй өртөөд дээр өртөөний жижүүр, сумчин галт тэрэг хүлээн авахдаа замналыг дараахь байдлаар бэлтгэнэ.

11.15.1. галт тэрэг хүлээн авах замналыг бэлтгэх тухай захирамжийг сумчинд өртөөний жижүүр өгнө. Өгсөн захирамжаа давтуулан зөв ойлгосон болохыг магадлаад “гүйцэтгэ” гэсэн үгээр өртөөний жижүүр батлана.

11.15.2. захирамж авсан сумчин нь тухайн замнал руу орж хийгдэх сэлгээний ажлыг зогсоож, техник захирамжийн актанд зааснаар хүлээн авах замын чөлөөтэй



эсэхийг шалгаж, сумыг шаардлагатай байдалд нь шилжүүлж, замналд орсон сум бүрийн шорыг жааз зам төмөрт нягт наалдсаныг шалгаж, цоожлоно.

11.15.3. сумчин зам чөлөөтэй, замнал зөв бэлтгэгдсэн тухай өртөөний жижүүрт илтгэнэ.

10.15.4. өртөөний жижүүр замнал бэлтгэх талаар өгсөн өөрийн захирамж, сумчны илтгэл зөв болохыг сумын байдлыг хянах удирдах аппаратын заалтаар магадлана.

11.15.5. зам чөлөөтэй замнал зөв бэлтгэгдсэнийг магадлаад өртөөний жижүүр оруулах дохиог нээх буюу дохионы удирдлага сумчны постонд байдаг бол түүнийг нээх захирамжийг сумчинд өгнө.

11.15.6. галт тэрэг хүлээн авсны дараа сумчин бүрэн бүрэлдэхүүнтэй, сүүлийн дохио байгаа, бүрэлдэхүүн хязгаарын шонд багтсан эсэхийг шалгаад өртөөний жижүүрт илтгэнэ.

11.15.7. галт тэрэг ирсний /өнгөрсний/ дараа сумчин захирамж хүлээлгүйгээр сумыг хэвийн байдалд нь тавина.

11.16. Оруулах дохио нэгэнт нээсэн бол өртөөний жижүүр галт тэрэг хүлээн авах замналыг өөрчлөх тухай заалт өгөх эрхгүй.

11.17. Галт тэргийг чөлөөтэй өөр замд хүлээн авахын тулд замнал өөрчлөх шаардлагатай бол өртөөний жижүүр оруулах дохиог хааж, өгөгдсөн замналыг өөрчлөх ба зөвхөн үүний дараа техник захирамжийн актанд зааснаар замнал бэлтгүүлэхээр шинээр захирамж өгнө.

11.18. Галт тэрэг хүлээн авахын өмнө замын чөлөөтэй эсэхийг өртөөний техник захирамжийн актанд заасны дагуу шалгана.

11.18.1. хүлээн авах, явуулах замыг зам төмөр хэлхээгээр тоногдсон өртөөнд удирдах аппаратын хяналтын хэрэгслээр;

11.18.2. сумчны байр бүрт хүлээн авах замын тодорхой хэсгийг бэхэлсэнээр, замын энэ хэсгийн чөлөөтэй эсэхийг шалгахдаа сумчин нь шалгаж байгаа бүх хэсгийн үзэгдэлт сайн үзэгдэх газар хүртэл явж гүйцэтгэнэ;

11.18.3. сумчин буюу тусгай томилогдсон ажилтан хүлээн авах замын дагууд нэвт явснаар.

11.19. Урт бүрэлдэхүүнтэй, тэсрэх дэлбэрэх аюултай, хэтрүү овортой ачаатай галт тэргийг өртөөний техник захирамжийн актанд заагдсан замаар хүлээн авна.

11.20. Урт бүрэлдэхүүнтэй, тэсрэх дэлбэрэх аюултай, хэтрүү овортой ачаатай галт тэргийг хүлээж авах, явуулах үед мөрдөх аюулгүй ажиллагааг хангах явдлыг



Төмөр замаар ачаа тээвэрлэх журам болон Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмаар тогтооно.

ГАЛТ ТЭРЭГ ЯВУУЛАХ

11.21. Техник ашиглалтын журмын 15.2.3 ба 15.2.7-д заасны дагуу өртөөний жижүүрт галт тэрэг явуулах замнал бэлэн болсон, сумнууд түгжигдсэн, явуулах замналын суман дээр сэлгээ хийхийг зогсоосон, бүрэлдэхүүний техникийн үйлчилгээний болон ачаа тээврийн үзлэг дууссан болохыг магадлахгүйгээр гаргах дохио нээх, хоорондын зам эзлэх өөр зөвшөөрөл олгохгүй байхыг анхаарна.

11.22. Галт тэрэг найруулсан болон галт тэрэгний бүрэлдэхүүнд вагон холбох, салгах ажил хийсэн өртөөнөөс галт тэрэг явуулахдаа өртөөний жижүүр Техник ашиглалтын журмын 15.2.7-д зааснаар гаргах дохио нээх буюу зүтгүүрийн машинчид хоорондын зам эзлэх зөвшөөрөл олгохын өмнө сүүлчийн вагонд галт тэрэгний сүүлийн дохио байгаа эсэхийг магадлана.

11.23. Гаргах дохиогүй замаас хоорондын зам эзлэх, гаргах дохионы хориглосон заалттай үед галт тэрэг явуулах зөвшөөрлийг өртөөний жижүүр техник захирамжийн актанд заасан хөдөлгөөний ажилтнаар дамжуулан түүчээ зүтгүүрийн машинчид өгнө.

11.24. Машинч хоорондын зам эзлэхээр авсан зөвшөөрлөө зөв болохыг Техник ашиглалтын журмын 15.3.12-д зааснаар магадлах үүрэгтэй.

11.25. Төвлөрүүлэгдээгүй суман шилжүүлэг бүхий өртөөний жижүүр, сумчид галт тэрэг явуулахаар замнал бэлтгэхдээ дараахь зарчмыг баримтлана.


11.25.1. өртөөний жижүүр явуулах замнал бэлтгэхдээ бүх сумчдыг дуудаж тэдэнд замнал бэлтгэх тухай захирамж өгнө.

11.25.2. өртөөний жижүүр аль нэг сумчнаар захирамжийг давтуулах ба бусад сумчид нь түүнийг хүлээн авсныг "зөв" гэдэг үгээр батална. Өгсөн захирамжаа давтуулаад зөв ойлгосон болохыг магадлаад "гүйцэтгэ" гэдэг үгээр өртөөний жижүүр батална.

11.25.3. захирамж авсан сумчин галт тэрэг явуулах замналыг бэлтгэж сумыг зохих байдалд нь шилжүүлнэ. Сумын түлхүүрийг аппаратад хийж бариулыг замналын байдалд тавьж замнал бэлтгэсэн тухай өртөөний жижүүрт илтгэнэ.

11.25.4. өртөөний жижүүр нь замнал зөв бэлтгэгдсэнийг аппаратын тусламжтай хянан замналыг түгжиж, зэргэлдээ өртөөний жижүүрээс галт тэрэг явуулах зөвшөөрөл авч гаргах дохиог нээх буюу хоорондын зам эзлэх зөвшөөрлийг машинчид олгоно.

11.25.5. явуулах замнал бэлтгэх болон түүний бэлэн болсон тухай өртөөний жижүүрт өгөх илтгэлтэй холбогдсон бүх ажиллагаа нь хүлээн авах замнал бэлтгэх зарчимтай нэгэн адил явагдана.



11.25.6. өртөөний жижүүр нь хоорондын зам чөлөөтэй, явуулах замнал зөв бэлтгэгдсэн, зэргэлдээ өртөөний жижүүрийн зөвшөөрөл байгааг магадлаад гаргах дохио нээх буюу машинчид хоорондын зам эзлэх зөвшөөрөл өгнө.

11.25.7. сумчид нь өртөөний техник захирамжийн актанд заасан газар тогтоосон дохиогоор галт тэргийг үдэж явуулна.

11.25.8. сумчин нь галт тэрэг үдэж явуулахдаа сүүлчийн вагонд дохио байгааг магадлаад өртөөний жижүүрт галт тэрэг бүрэн бүрэлдэхүүнтэй явсан тухай илтгэнэ.

11.25.9. галт тэрэг явсны дараа сумыг хэвийн байдалд тавих ба зам эзэлгээтэй тохиолдолд чөлөөтэй зам руу тавина.

11.26. Галт тэрэг явуулахаар гаргах дохио нээсний дараа өртөөний жижүүр өөр галт тэрэг явуулахын тулд дохиог хааж замнал өөрчлөх тухай захирамж өгөхгүй байхыг анхаарч ажиллана. Шаардлагатай тохиолдолд галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалаар гаргах дохио хааж замнал өөрчилж болно. Энэ тухай явах галт тэрэгний машинчид мэдэгдэнэ.

11.27. Зөвхөн галт тэрэг хүлээн авах үед сумын байдлыг хянах зориулалт бүхий замнал хянах байгууламжтай өртөөнд энэ байгууламжийг боломжтой бол явуулах замналд орсон сумын байдлыг хянахад ашиглах ёстой. Энэ тохиолдолд өртөөний жижүүр нь замнал бэлтгэх тухай захирамжийг сумчны постод дамжуулсан ба түүнийг сумчид биелүүлсний дараа замналд орсон сумнууд зөв тавигдсан эсэхийг хориг цонх, замналын бариулаар шалгана.


11.28. Галт тэргийг өртөөний замаас гаргах гэрлэн дохионы хориглосон заалттай буюу гаргах дохиогүй замаас явуулах бол өртөөний жижүүр явуулах замнал бэлэн болсныг магадлахгүйгээр галт тэрэг явуулах тухай заалт машинчид өгөх, зохих ажилтанд явуулах дохио, заалт дамжуулахгүй байхыг анхаарч ажиллана. Явуулах замнал бэлэн болоогүй байхад галт тэрэгний явдал дунд хоорондын зам эзлэх зөвшөөрөл машинчид гардуулж өгөхгүй байхыг анхаарч ажиллана.

11.29. Төвлөрүүлэгдээгүй суман шилжүүлэгтэй өртөөгөөр галт тэрэг өнгөрүүлэх үед сумчид галт тэрэг хүлээн авах, явуулах замнал бэлтгэж бэлэн болсон тухай өртөөний жижүүрт илтгэнэ.

ОРУУЛАХ ГЭРЛЭН ДОХИОНЫ ХОРИГЛОСОН ЗААЛТТАЙ ҮЕД ӨРТӨӨНД ГАЛТ ТЭРЭГ ХҮЛЭЭН АВАХ

11.30. Оруулах гэрлэн дохионы үндсэн гэрэл унтарсан, хориглосон заалттай байх үед өртөөнд галт тэргийг урих дохио, билет газарч, өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар хүлээн авна.

11.31. Өртөөнд урих дохио, билет газарч, өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар галт тэрэг хүлээн авах үед түүний хурд 20 км/цагаас илүүгүй байх бөгөөд машинч сонор сэрэмжтэй, цаашдын хөдөлгөөнд саад тохиолдвол нэн даруй



зогсоход бэлэн байдлаар жолоодож, явах замын дагууд дараачийн дохио хүртэл сэрэмжлэх дохиог байн байн өгнө.

11.32. Оруулах гэрлэн дохионы хориглосон заалттай үед галт тэргийг дараахь тохиолдолд хүлээн авахыг зөвшөөрнө.

11.32.1. төхөөрөмжийн гэмтлийн улмаас оруулах дохио нээх боломжгүй;

11.32.2. галт тэргийг техник захирамжийн актанд заагдаагүй зам дээр хүлээж авахад оруулах дохио нээх боломжгүй;

11.32.3. түлхэгч зүтгүүрийг замын тодорхой хэсэг дээр хүлээж авах;

11.32.4. сэргээн босгох ба галын галт тэрэг, туслах зүтгүүр, вагонгүй зүтгүүр, цас цэвэрлэгч, дрезин, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүн мөн түүнчлэн аж ахуйн галт тэрэг, замын машиныг /хаалттай хоорондын замд ажил гүйцэтгэсэн үед/ өртөөний замын тодорхой хэсэг дээр хүлээн авах.

11.33. Оруулах гэрлэн дохионы хориглосон заалттай үед өртөөнд дараахь аргаар галт тэргийг хүлээж авна. Үүнд:

11.33.1. урих дохиогоор;

11.33.2. билет газарчаар;

11.33.3. өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар.


11.34. Оруулах, гаргах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт нь байгууламжийн хамаарал алдагдаагүй шалтгаанаар хориглосон заалтанд гэнэт шилжихэд галт тэрэг оруулах, гаргах гэрлэн дохио өнгөрч зогссон бол галт тэргийг өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар явуулна.

11.35. Оруулах гэрлэн дохионы хориглосон заалттай үед галт тэргийг билет газарчаар хүлээж авахдаа газарч нь оруулах гэрлэн дохионы өмнө 50 метрээс багагүй зайд хөдөлгөөний чиглэлийн баруун гар талд ирж байгаа галт тэрэгний зүг газарч зогсоох дохиог өгнө.

11.36. Зогсох дохиог машинч ойлгож хурд бууруулан газарчийн дэргэд зогсоно. Энэ үед газарч нь машинчид билет газарчийг өгнө.

11.37. Билет газарчаар галт тэрэг хүлээн авах ажилтныг техник захирамжийн актаар тогтооно.

11.38. "Билет-газарч" зөвшөөрлийг өнгөт металлаар хийнэ. Билет газарчийг цоожтой саванд хадгалах бөгөөд тоог өртөө хоорондын зам тус бүрт тэгш чиглэлд тэгш, сондгой чиглэлд сондгой дугаартай байхаар өртөөний техник захирамжийн актанд тусгаж өгнө. "Билет-газарч"-ийн загварыг долдугаар хавсралтад үзүүлэв.



11.39. Техник ашиглалтын журмын 15.2.3-15.2.6-д заасны дагуу өртөөний замын тодорхой хэсэг дээр түлхэгч зүтгүүрийг хүлээж авахыг өртөөний техник захирамжийн актанд зааснаар гүйцэтгэнэ.

11.40. Оруулах гэрлэн дохионы хориглосон заалттай үед өртөөний замын тодорхой хэсэг дээр сэргээн босгох болон галын галт тэрэг, туслах зүтгүүр, вагонгүй зүтгүүр, цас цэвэрлэгч ба дрезин, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүнийг энэхүү журмын 11.32-д заасны дагуу хүлээн авна.

11.41. Өртөөний замын тодорхой хэсэг дээр галт тэрэг хүлээн авах үед галт тэрэгний машинч, дрезин, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүний жолооч нь анхны суман шилжүүлгийн өмнө зогсох ба цаашид сэлгээний зарчмаар тухайн зам руу орно.

11.42. Галт тэрэг хүлээн авах, явуулах замнал бэлтгэхээр өртөөний жижүүрээс өгч байгаа захирамж, илтгэл нь суурь бүтэц эзэмшигчийн баталсан албан ярианы дэглэмээр явагдана.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАГЧИЙН АЖИЛ

12.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь суурь бүтэц эзэмшигчдийн галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зурмаг, нэгдсэн технологийн горимд нийцүүлэн удирдах, хяналт тавих, үйлчлүүлэгчийн тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг хангах, тэдгээрийн ажлын харилцан уялдаа холбоог сайжруулах, зэргэлдээ төмөр замуудтай галт тэрэг солилцох, хилийн өртөөнд галт тэрэг боловсруулах ажиллагааг хурдасгах ажлыг оновчтой зохион байгуулах чиг үүрэгтэй.

12.2. Хэсгийн хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зөвхөн нэг ажилтан, тухайлбал өөрийн үйлчилж байгаа хэсгийн хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагаа, зурмагийн биелэлтийг хариуцах үүрэг бүхий галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч удирдана.

12.3. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн тушаалыг уг хэсэгт галт тэрэгний хөдөлгөөнд шууд холбоотой ажилтнууд шууд биелүүлнэ.

12.4. Хэсгийн хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөний талаар галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчаас бусад ажилтан шуурхай даалгавар өгөхгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

12.5. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн үүрэг:

12.5.1. ачаа ба зорчигчийн урсгалд тохирсон тооны галт тэргийг явуулах, галт тэрэгнүүдийн хөдөлгөөнийг хурдасгах, өртөөнд галт тэрэг боловсруулах хугацааг



багасгах, техник хэрэгсэл, хөдлөх бүрэлдэхүүний парк, тээх, нэвтрүүлэх чадварыг дээд зэргээр ашиглах;

12.5.2. өртөө, зөрлөгийн ажилд хяналт тавих, галт тэрэгний хөдөлгөөний зурмаг, төлөвлөгөөний дагуу галт тэрэг найруулан явуулах даалгаврыг биелүүлэх;

12.5.3. галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой захирамжийг өртөөдийн жижүүр, галт тэрэгний зүтгүүрийн машинчид өгөх;

12.5.4. өртөөн дээр галт тэрэг хүлээн авах, явуулах ажлыг хянах, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбооны байгууламжийн хэвийн ажиллагаа зөрчигдсөн, зорчигчийн, ачаа-зорчигчийн, хүмүүсийн, урт бүрэлдэхүүнтэй, хүнд жинтэй, тэсрэх дэлбэрэх аюултай, хэтрүү овортой ачаатай галт тэрэг явуулах үед хөдөлгөөний зурмагийг биелүүлэх, галт тэргийг хоорондын замаар өнгөрүүлэхэд хяналт тавих;

12.5.5. галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчын төвлөрүүлэлтэнд байгаа хоорондын болон өртөөдийн замын байдал, сум, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбооны байгууламжийн хэвийн ажиллагаа, хөдлөх бүрэлдэхүүний бэхэлгээ, хэсэг дэх хүчин төгөлдөр анхаарамж зэргийг шалгах.

12.6. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь ээлжинд гарахдаа галт тэрэгний байдалтай танилцаад, өөрийн хэсгийн бүх өртөөдийг дуудаж, өртөөний жижүүр ээлж бүрэн байгааг шалгах, цагаа тохируулах зөв цагийг мэдэгдэх, өртөөдийн байдал, хэсэг дэх хүчин төгөлдөр анхаарамжтай танилцах, хийгдэх ажлын тухай шаардлагатай захирамж заалтыг өгнө.


12.7. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь өөрийн хэсгийн өртөө, зөрлөгүүдэд ирж байгаа галт тэргийг хүлээн авч байгаа замын дугаар, галт тэрэг бүрийн ирсэн, явсан, өнгөрүүлсэн цагийн мэдээг хүлээн авч байхдаа тэсрэх дэлбэрэх аюултай ба хэтрүү овортой ачаатай, хүнд жинтэй, урт бүрэлдэхүүнтэй галт тэргэнд тогтоосон дугаар мөрдөгдөж байгаа эсэхэд онцгой анхаарна.

12.8. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагийг хөтлөх бөгөөд түүн дээр галт тэрэгний хөдөлгөөний тухай мэдээ, мөн түүнчлэн хэсэг дээр хэвийн ажиллагаа алдагдсан бүх зөрчил, шалтгааныг тэмдэглэнэ.

12.9. Хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмаг дээр дараахь мэдээ, тэмдэглэл бичигдсэн байвал зохино:

12.9.1. галт тэрэг ба зүтгүүрийн дугаар, машинчийн нэр, галт тэрэгний цэвэр, бохир жин, томъёолсон урт, хэсгээр өнгөрүүлэх онцгой нөхцөл шаардах галт тэрэг /тэсрэх дэлбэрэх аюултай, хэтрүү овортой ачаатай галт тэрэгний дугаар, хэтрүү овортой зэрэг шинжийг заасан/, урт бүрэлдэхүүнтэй, хүнд жинтэй, тусгай галт тэргийг зохих нэмэгдэл үсгүүдийн хамт хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагт тэмдэглэнэ;

12.9.2. хэсэг дэх өртөөдөөр галт тэрэг явсан, ирсэн, өнгөрсөн цаг;



12.9.3. зүтгүүр ашиглалт ба зүтгүүрийн бригадын ажлын цагийн мэдээ;

12.9.4. өртөөдийн галт тэрэгний ба ачааны ажлын хоногийн мэдээ;

12.9.5. завсарын өртөөнд хүлээн авах, явуулах замыг нэг буюу бүлэг вагоноор эзлүүлсэн байдал;

12.9.6. хурд бууруулахыг шаардсан хүчинтэй анхаарамж;

12.9.7. хоорондын зам, өртөөний зам бусад байгууламжийг хаасан байдал;

12.9.8. галт тэрэгний сүүлчийн вагоны дугаар, сүүлийн дохиотой эсэхийг тэмдэглэнэ.

12.10. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь өөрийн хэсэг дээр галт тэрэгний хөдөлгөөний талаар өгөх бүх захирамжийг зохицуулагчийн тушаалын дэвтэрт бүртгэж, өртөөний жижүүр, галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой бусад ажилтанд дамжуулна.

12.11. Хэсэглэлийн хэмжээнд өгөгдсөн урт бүрэлдэхүүнтэй галт тэрэгний тушаалыг өөрчлөх шаардлага гарсан тохиолдолд тухайн өртөөний жижүүрт хүлээн авч явуулах замын дугаарыг өөрчлөх захирамжийг амаар өгч болно.

12.12. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой бусад тушаалуудыг зөвхөн тушаалаар өөрчлөнө.

12.13. Галт тэрэгний зохицуулагчийн холбоогоор ярьж буй бүх яриа бичлэгийн төхөөрөмжид бичигдэнэ.

12.14. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн дэвтэрт бүртгэгддэг дараахь тушаалыг өгнө:

12.14.1. хоорондын зам, түүний зарим хэсгийг хаах, нээх тухай;


12.14.2. галт тэрэгний хөдөлгөөний үеийн дохиолол холбооны нэг хэрэгслээс нөгөөд шилжих үед;

12.14.3. зорчигчийн, ачаа зорчигчийн, хүмүүсийн галт тэргийг өртөөний техник захирамжийн актаар заагдаагүй замаар хүлээж авах, явуулах үед;

12.14.4. зурмагт заагаагүй галт тэргийг явуулах, өөрчлөх;

12.14.5. тэсрэх дэлбэрэх аюултай, хэтрүү овортой ачаатай, урт бүрэлдэхүүнтэй, хүнд жинтэй галт тэрэг явуулах;

12.14.6. хэсэг дэх галт тэрэгний хөдөлгөөний зохион байгуулалттай холбоотой, зохицуулагчаас өгөгдөх бусад тушаал.



- 12.15. Хэсгээр ганц зүтгүүр, дрезин, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүн, аж ахуйн галт тэрэг өнгөрүүлэх тушаалыг бүртгэхгүй байж болно.
- 12.16. Галт тэрэгний зүтгүүрийн машинчид өгөгдөх бүх тушаал зэргэлдээ хэсгийн зохицуулагчид хаяглагдсан байна.
- 12.17. Зохицуулагчаас тушаал бичих хугацааг хэмнэхийн тулд суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр олон удаа өгөгдөх тушаалын загвар бүхий хэв тэмдэг хэрэглэж болно.
- 12.18. Зохицуулагчийн захирамжийн дэвтэрт галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчдын ээлж хүлээлгэн өгсөн ба хүлээн авсныг бүртгэнэ.
- 12.19. Зохицуулагчаас өгсөн бүртгэлт тушаалыг өртөөний жижүүр нь зохицуулагчийн тушаалын дэвтэрт, зүтгүүрийн машинч замналын хуудсанд бичиж авна.
- 12.20. Зохицуулагчийн тушаалыг бичиж авсан өртөөний жижүүр, машинч нь өөрийн нэрийг хэлж, тушаалын агуулгыг зохицуулагчид үг бүрээр давтана.
- 12.21. Тушаалыг зөв хүлээн авсан цаг, минут, ажилтны нэрийг зохицуулагчийн, өртөөний жижүүрийн тушаалын дэвтэрт тэмдэглэнэ.
- 12.22. Тушаалыг зөв хүлээж авсныг магадлаад зохицуулагч, өртөөний жижүүр "гүйцэтгэ" гэсэн үгээр батлана.
- 12.23. Машинчид хаяглагдсан тушаал өртөөний жижүүрээр дамжигдана. Галт тэрэгний зохицуулагчийн төвлөрүүлэлтэнд холбогдсон үед машинчид шууд дамжигдана.
- 12.24. Зохицуулагч буюу өртөөний жижүүр нь дамжуулсан тушаалыг машинчаас зөв ойлгосныг магадлана.
- 12.25. Машинчийн нэр, тушаал дамжуулсан цаг, минутыг зохицуулагчийн ба өртөөний жижүүрийн тушаалын дэвтэрт тэмдэглэнэ.
- 12.26. Зохицуулагчийн тушаал хэд хэдэн өртөөнд хаяглагдсан байвал түүнийг давтахдаа зохицуулагчийн сонгосон өртөөний жижүүр уншиж бусад нь зөв бичигдсэн эсэхийг тулган шалгана.
- 12.27. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь дараахь үндэслэлээр хоорондын замыг хаана:
- 12.27.1. суурь бүтэц эзэмшигчийн шийдвэрээр зам засварын, барилгын ажлыг гүйцэтгэх үед;
- 12.27.2. замд зогссон галт тэрэгний машинчаас тусламж хүссэн хүсэлт, зам, дохиолол холбоо, эрчим хүчний засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн



ажилтнаас хоорондын зам дахь төхөөрөмжүүдэд гэнэтийн эвдрэл гэмтэл гарч галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагаа алдагдахад хүрсэн үед.

12.28. Галт тэрэгний зохицуулагч нь хүлээн авсан шаардлага, мэдэгдсэн цаг, минут, ямар ажилтан мэдээлсэнийг зааж галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тэмдэглэнэ.

12.29. Бүх бичгэн шаардлага, мэдэгдэл, цахилгаан, утсан мэдээнүүд зохицуулагчийн дэвтэрт хамт хадгалагдана.

12.30. Хоорондын зам хаасан тухай тушаалыг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч хоорондын замыг хязгаарлагч өртөөдөд дараахь үлгэрчилсэн загварын аль нэгээр өгнө.

12.30.1. хоорондын замд аргагүйдэн зогссон галт тэрэгний машинчид тусламж үзүүлэх туслах зүтгүүр явуулах тушаалын загвар:

“...өртөөнөөс ... цаг ... минутад явсан ...-р зүтгүүртэй галт тэрэг ... өртөө хоорондын замын ... км ...-р зуутад ... шалтгаанаар галт тэрэгний түүчээ зүтгүүр зогссон. Галт тэрэг цааш явж чадахгүй болж туслах зүтгүүр дуудсан мэдэгдлийг ... -р галт тэрэгний машинч ... нэр ... өртөөний жижүүрт ... цаг ... минутад өгсөн тул уул хоорондын замыг туслах зүтгүүрээс бусад бүх галт тэрэгний хөдөлгөөнд хааж, тусламжаар явах-р галт тэргийг ... км ... зуут хүртэл яваад зогс, цаашид ... тушаалтай ... удирдлаганд туйлын сонор сэрэмжтэй ажиллаж ... -р галт тэрэгний бүрэлдэхүүнийг ... өртөөнд татаж авчрах, /түлхэж очих/ -аар явуулахыг зөвшөөрөв.

... өртөөний жижүүр ... -р галт тэрэгний машинчаас хаалт хамгаалалт хийсэн мэдэгдлийг авч галт тэрэгний хөдөлгөөний зохицуулагчид илтгэсний дараа маягтыг анхаарамжийн хамт олгож явуул.


Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч..... /гарын үсэг/ /нэр/”

12.30.2. хоорондын замд гарсан саадыг арилгах зорилгоор аж ахуйн галт тэргийг явуулахаар хоорондын замыг хаах тушаалын загвар:

“...хоорондын замын ... дугаар километрийн... зуутад... шалтгааны улмаас ... хоорондын замыг ...галт тэрэгнээс бусад бүх галт тэрэгний хөдөлгөөнд хааж дугаар галт тэргийг дугаар километрийн ... зуутад байгаа дохиочны мэдэлд очиж ажиллаад ..., өртөөнд очихоор /буцаж ирэхээр явуулахыг зөвшөөрөв.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч..... /гарын үсэг/ /нэр/”

12.30.3. галт тэрэгний хөдөлгөөний зурмагт “цонх” гаргаж зам барилга, их засварын ажил хийхээр суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр хоорондын замд ажил гүйцэтгэх үед хоорондын замыг хаах тушаалын загвар:



а. “Суурь бүтэц эзэмшигчийн ... тоот цахилгаанаар дугаар километрийн ... дугаар зуутаас дугаар километрийн дугаар зуут хүртэл ... ажил гүйцэтгэхээр ... хоорондын замыг аж ахуйн галт тэрэгнээс бусад бүх галт тэрэгний хөдөлгөөнд ... цаг ... минутаас эхлэн ... цаг минут хүртэл ... цагийн хугацаагаар хоорондын замыг хаав”.

б. “Хаалттай хоорондын замд ажилллах аж ахуйн галт тэрэг болон ажиллагсдын аюулгүй ажиллагааг хангаж уг ажлыг тогтоосон цагт гүйцэтгэхийг ... ажил удирдагч ... тушаалтай даалгасугай.”

/нэр/

в. “Ажил удирдагчийн бичгэн захиалганд заагдсан дохиочны мэдэлд очиж ажиллахаар энэхүү журмыг мөрдлөг болгон явуулна.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч..... /...../”
/гарын үсэг/ /нэр/

12.31. Хоорондын замыг хаах тухай тушаалыг дамжуулахын өмнө галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь хоорондын замыг хязгаарлагч өртөөдийн жижүүрийг дуудаж, зам хаах гэж байгаа тухайгаа анхааруулж ажил удирдагчийн нэр, албан тушаал, бусад шаардлагатай мэдээллийг дамжуулна.

12.32. Хоорондын замыг нээх ажлыг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч гарсан саад тотгорыг арилгасан, ажил дууссан, хоорондын замыг чөлөөлсөн тухай энэхүү зааварт заасны дагуу мэдэгдлийг хүлээн авсны дараа гүйцэтгэнэ.

12.33. Хоорондын замыг нээх тухай тушаалыг галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч хоорондын замыг хязгаарлагч өртөөдөд дараахь загвараар өгнө.


“...хоорондын замын...дугаар километр,... -р зуутаас.....-р километр ... -р зуутад хийсэн ажил дууссан галт тэрэгний хөдөлгөөнд саадгүй тухай ... албан тушаалтай ... -ны мэдэгдлээр уг хоорондын замыг.....оны.....дугаар сарын.....-ны өдрийн.....цаг.....минутаас эхлэн бүх галт тэрэгний хэрэгсэлээр сэргээж галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн ... тоот тушаалыг хүчингүй болгов.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч /ДНЦ/

12.34. Галт тэрэгний зурмагт заагдаагүй /хүмүүс буулгах, суулгах, ачилт буслгалт хийх/ зогсолттой галт тэрэг зэргэлдээ өртөө хүртэл эсвэл явуулсан өртөөндөө буцаж ирэх бол хоорондын замд явуулах цаг, минут, хоорондын зам эзлэх хугацааг заасан зөвшөөрөл өгнө. Зүтгүүрийн машинч, хүмүүс буулгах, суулгах, ачилт буулгалтын ажлыг удирдагч ажилтан нарт зохих анхаарамж олгоно.

12.35. Хоорондын замд зогссоны дараа машинч, удирдагч ажилтны дохиогоор хөдөлгөөнийг үргэлжлүүнэ.

12.36. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч хоорондын замын хагас автомат хориглол гэмтсэн тухай мэдээ аваад тушаалын дэвтэрт бичиж, хоорондын замын



чөлөөтэй эсэхийг өртөөдийн жижүүрээр дамжуулан магадлаад, хөдөлгөөнийг холбооны утсан хэрэгслээр зохицуулах тушаалыг дараахь маягаар өгнө.

“...өртөөд хоорондын замын хагас автомат /өртөө хоорондын/ хориглолд ... гэмтэл гарч ажиллахгүй болсон талаар ... өртөөний жижүүр... -н мэдэгдлийг үндэслэж...оны...дугаар сарын...-ны өдрийн...цаг...минутаас эхлэн уг хоорондын замын хагас автомат /өртөө хоорондын/ хориглолын ажиллагааг зогсоож замын утсан холбоогоор галт тэрэгний хөдөлгөөнийг удирдахаар тогтов.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч /ДНЦ/.....”

12.37. Дохиолол холбооны тогтоосон хэрэгслийн ажиллагааг сэргээсэн тухай мэдэгдэл хүлээн авсны дараа галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь түүнийг өөрийн тушаалын дэвтэрт бичиж авах ба хоорондын зам чөлөөтэй эсэхийг өртөөдийн жижүүрээр дамжуулан магадлаад хоорондын замын хязгаарлагч өртөөдөд дараахь маягаар тушаал өгнө.

“...өртөөд хоорондын замын хагас автомат хориглол /өртөө хоорондын/ хэвийн ажиллагаатай болсон талаар... тушаалтай...мэдэгдлийг үндэслэж... уг хоорондын замыг...оны...дугаар сарын...-ны өдрийн ... цаг ... минутаас эхлэн галт тэрэгний хөдөлгөөнийг хагас автомат /өртөө хоорондын/ хориглолоор удирдахаар сэргээж галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн... тоот тушаалыг хүчингүй болгов.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч /ДНЦ/

12.38. Урт бүрэлдэхүүнтэй, тэсрэх дэлбэрэх аюултай, хэтрүү овортой ачаатай галт тэрэг явуулах тухай тушаалыг дараахь загвараар өгнө.

“...өртөөнөөс... дугаар галт тэрэг томъёолсон вагонтой урт бүрэлдэхүүнтэй яваа тул... өртөөд...-р замаар хүлээн авч хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангаж ажилла.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч /ДНЦ/.....”


“...өртөөнөөс ... цаг ... минутанд явуулах ... дугаар галт тэрэг тэсрэх дэлбэрэх аюултай ачаатай” яваа тул техник захирамжийн актанд заасан замаар хүлээн авч галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангаж өнгөрүүл.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч /ДНЦ/

“...өртөөнөөс ... цаг ... минутанд явуулах ... дугаар галт тэрэг хэтрүү оврын хажуугийн ... дугаар зэрэгтэй яваа тул өртөөний техник захирамжийн актанд заасан замаар хүлээн авч галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангаж өнгөрүүл.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч /ДНЦ/

12.39. Тушаалуудыг нэгтгэн өгч болно.





12.40. Хоногийн туршид ажилладаггүй хэсэглэх газрууд, туслах постуудыг нээх, хаах ажлыг суурь бүтэц эзэмшигчээс баталсан заавраар гүйцэтгэх, хоорондын замыг хязгаарлагч өртөөдөд өгөх хөдөлгөөн зохицуулагчийн тушаалыг дараахь маягаар өгнө.

"..... километрийн постын ажиллагааг ... оны ...-р сарын ...-ны өдрийн ... цаг ... минутаас нээв/хаав."

12.41. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоо гэмтэлтэй үед сэргээх хүртэл баримтжуулан бичих төхөөрөмжөөр тоноглогдсон холбооны хэрэгсэлийг ашиглана.

12.42. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоо гэмтэлтэй үед "Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр"-т бичлэг хийнэ.

12.43. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоо хэвийн болсон тухай галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч өөрийн хэсгийн бүх өртөө, зөрлөгт нийтийн тушаалаар мэдэгдэнэ.

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ

ӨРТӨӨНД ХИЙГДЭХ СЭЛГЭЭНИЙ АЖИЛ

13.1. Сэлгээний ажил нь өртөөний ажлын технологи ба төлөвлөгөөний дагуу хийгдэх бөгөөд дараахь шаардлагыг хангасан байна.

13.1.1. галт тэргийг цаг тухайд нь найруулж явуулах;

13.1.2. ачааны ажиллагаанд вагоныг цаг тухайд нь тавьж өгөх, татаж авах;

13.1.3. вагоныг боловсруулахад хамгийн бага хугацаа зарцуулах;


13.1.4. техник хэрэгсэл, байгууламжуудын хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглах;

13.1.5. галт тэргийг өртөөнд тасралтгүй хүлээж авах;

13.1.6. хөдөлгөөний аюулгүй ажиллагаа, сэлгээний ажилд холбоотой ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, хөдлөх бүрэлдэхүүн, ачааны бүрэн бүтэнг хангах.

13.2. Олон замтай, сэлгээний ажил ихтэй өртөөдөд зам сумыг сэлгээний бүс болгон хувааж, тэдэнд сэлгээний зүтгүүр ба бригад бэхлэн ажиллуулна.

13.3. Сэлгээний бүсийн хязгаарт нэг сэлгээний зүтгүүр ажиллана. Зарим бүсэд шаардлагатай үед хоёр буюу түүнээс дээш сэлгээний зүтгүүр ажиллуулж



болно. Энэ тохиолдолд галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангаж ажиллах зарчмыг өртөөний техник захирамжийн актаар тогтооно.

13.4. Сэлгээний ажилд өгч байгаа зүтгүүр нь гэмтэлгүй, тогтоосон дохио, багаж хэрэгсэл, хяналтын төхөөрөмжтэй, зүтгүүрийн радио холбооны байгууламж, тэжээлийн төхөөрөмж нь хэвийн ажиллагаатай байна.

13.5. Сэлгээний хөдөлгөөний үед сум шилжүүлэх явдлыг сэлгээний ажил удирдагч өөрөө буюу түүний шийдвэрээр сумчин гүйцэтгэнэ.

13.6. Цахилгаан төвлөрүүлэлттэй өртөөдөд сэлгээний хөдөлгөөний үед сум шилжүүлэх явдлыг өртөөний жижүүр гүйцэтгэнэ сумыг төвийн удирдлагаас суурин удирдлагад шилжүүлэх, мөн түүнчлэн сумчин үйлчилдэггүй төвлөрүүлэгдээгүй сум дээр сэлгээ хийх үед сумыг найруулагчийн бригадын ажилтан, зүтгүүр ба вагон депогийн сумчин /паркийн жижүүр, өртөөний жижүүр/ шилжүүлнэ.

13.7. Сум шилжүүлэх зааврыг өртөөний техник захирамжийн актаар тогтооно.

13.8. Цахилгаан төвлөрүүлэлтийн үед суман шилжүүлэг нь хөдлөх бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн эсэхийг удирдах аппарат дээрх хянах хэрэгслийн заалтаар магадлана. Эдгээр хэрэгслүүд гэмтэлтэй буюу түр салгасан, сумыг суурин удирдлаганд шилжүүлэх үед суман шилжүүлэг хөдлөх бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн эсэхийг хэрхэн шалгах талаар өртөөний техник захирамжийн актаар тогтооно.


13.9. Сэлгээний үед гар сумыг замналын зохих байдалд шилжүүлж цүүгээр түгжинэ. Төвлөрүүлэгдсэн сумыг сум шилжүүлэх түлхүүрээр шилжүүлсэн тохиолдолд мөн цүүг тавьж зүүдэг цоожоор цоожилсон байна.

13.10. Зүсэгдсэн суманд замын мастер, цахилгаан механикч нар үзлэг хийж Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэрт зохих бичлэг хийгээгүй бол хөдлөх бүрэлдэхүүн гаргахгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

13.11. Шаардлагатай тохиолдолд цахилгаан механикч, замын мастер зүсэгдсэн суманд үзлэг хийж цахилгаан шилжүүлэгчийг салгаж сумын шорыг зохих байдалд нь тавьж жааз зам төмөрт нягт шахсан нөхцөлд зүүдэг цоожоор цоожлох буюу хадаж хөдлөх бүрэлдэхүүнийг өнгөрүүлэхийг зөвшөөрнө.

13.12. Өртөөний болон салбар зам дээр хөдлөх бүрэлдэхүүнийг хоёр хязгаарын шонгийн хооронд багтаан байрлуулна.

13.13. Өртөөнд зогсож байгаа вагоныг өөрөө өнхрөхөөс нь болгоомжилж өөр хооронд нь холбож гар тоормос, тоормосны ивүүрээр найдвартай бэхэлсэн байна. Өртөөнд зогсож байгаа, ачих буулгах ажиллагаанд ороогүй, цэвэрлэх, ариутгах, засварлах ажил хийгдээгүй байгаа вагоны хаалгыг хаасан байна.



13.14. Хөдлөх бүрэлдэхүүнийг энэхүү журмын 2 дугаар хавсралтанд заасан нормын дагуу бэхлэх бөгөөд 0.0025-аас огцом хэвгийтэй зам дээр орхихгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

13.15. Хөдлөх бүрэлдэхүүнийг бэхлэх, орон нутгийн нөхцөлөөс нь шалтгаалж ямар зам дээр тэдгээрийг өөрөө хөдлөхөөс хамгаалан тооцоот ивүүрээр бэхлэх, энхүү ажиллагааг хэн гүйцэтгэх, бүрэлдэхүүн доороос бэхэлсэн ивүүрийг хэн авахыг өртөөний техник захирамжийн актаар тогтооно.

13.16. Хэвгийтэй зам дээр хөдлөх бүрэлдэхүүнийг орхих үед өөрөө өнхрөхөөс хамгаалсан бэхэлгээг зүтгүүр салгахас өмнө хийсэн байна. Энэ үед тоормосны ивүүрийн хошуу нь дугуйн дор дарагдсан байх ёстой. Ирсэн галт тэрэгний зүтгүүрийн машинч бүрэлдэхүүнийг зүтгүүрээс салгахын өмнө /бүх нөхцөлд/ автомат тоормосоор тоормослосон байна.

13.17. Хэвгийтэй зам дээр бэхэлгээ хийсэн мэдээ хүлээн авахгүйгээр, бэхэлгээ хийсэн эсэхийг магадлахгүйгээр бүрэлдэхүүнээс зүтгүүрээ салгахыг зүтгүүрийн бригад хатуу анхаарч ажиллана.

13.18. Зорчигчийн вагоны үйлчлэгч ба хөргүүрт хөдлөх бүрэлдэхүүнээс бүрдсэн галт тэрэгний ажилтан бүрэлдэхүүнээ удаан хугацаагаар зогсоолд /бэлтгэлд, ачилт, буулгалтанд тавьж өгөх, хүлээлгэнд болон бусад/ тавигдах үед вагоны гар тоормосыг ажиллагаанд оруулна.

13.19. Бүлгээр нь илгээж байгаа ажиллагаагүй зүтгүүрийн хүргэгч тэдгээрийг түүчээ зүтгүүргүй орхих бүрд гар тоормосыг ажиллагаанд оруулах ба түүчээ зүтгүүр залгасны дараа тэдгээрийг суллана.

13.20. Хүчтэй салхи болох мэдээ хүлээж авсан бол өртөөдийн ажилтан бүр хөдлөх бүрэлдэхүүнийг өөрөө хөдлөхөөс хамгаалж бэхэлгээ найдвартай байгааг шалгах, шаардлагатай тохиолдолд нэмэгдэл бэхэлгээ хийнэ. Салбар замд зогсож байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг нэмэгдэл ивүүрээр бэхлэхийг салбар замд вагон тавьж өгөх татаж авах заавраар тогтооно.

13.21. Хөдлөх бүрэлдэхүүнийг удаан хугацаагаар зогсоох шаардлагатай үед тэдгээрийг тооцоот ивүүрээр найдвартай бэхэлснийг өртөөний дарга, түүний орлогч буюу өртөөний жижүүр шалгана.

13.22. Хөдлөх бүрэлдэхүүн өөрөө явах аюул бий болсон үед өртөөний ажилтан түүнийг зогсоохын тулд өөрийн мэдэлд байгаа бүх хэрэгслийг нэн даруй ашиглах үүрэгтэй.

13.23. Хөдлөх бүрэлдэхүүн хоорондын замд өөрөө явсан үед өртөөний жижүүр өөрийн мэдэлд байгаа холбооны хэрэгслийг ашиглан, хоорондын замд явж байгаа галт тэрэгний машинч, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид, замын пост, зэргэлдээ өртөө, гармын жижүүрт нэн даруй мэдэгдэж, өөдөөс нь явах галт тэргийг саатуулах, өөрөө явсан хөдлөх бүрэлдэхүүнийг зогсоох талаар арга хэмжээ авах үүрэгтэй.



13.24. Галт тэргэнд болон найруулагдсан бүрэлдэхүүнд ороогүй тэсрэх аюултай ачаатай вагон, шахсан шингэрүүлсэн хийтэй цистернийн зогсоолыг ялгалтын зам дээр хуримтлагдаж байгаагаас өөр нөхцөлд өртөөний техник захирамжийн актаар заагдсан тусгай зам дээр байрлуулна. Эдгээр вагон нь хоорондоо холбогдсон, тоормосны ивүүрээр найдвартай бэхлэгдсэн, зөөврийн зогсоох дохиогоор хамгаалагдсан байна. Эдгээр вагоны зогсдог замын сум нь уг зам руу орох боломжийг үгүйсгэсэн байдалд тавигдаж зүүдэг цоожоор цоожлогдсон байна.

13.25. Тэсрэх дэлбэрэх аюултай ачаатай вагон, шахсан шингэрүүлсэн хийтэй цистерн ялгалтын зам дээр хуримтлагдсан үед урьдчилан сэргийлэх шаардлагатай доорх арга хэмжээг мөрдөнө.

13.25.1. сэлгээний зохицуулагч, довын жижүүр нь тэсрэх дэлбэрэх аюултай ачаатай вагон, шахсан шингэрүүлсэн хийтэй цистерн байгаа замын бүртгэлийг хөтлөнө.

13.25.2. тэсрэх дэлбэрэх аюултай ачаатай вагон, шахсан шингэрүүлсэн хийтэй цистерн байгаа зам руу сэлгээ оруулах үед энэхүү журмын 13.103-13.105-т заагдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

13.26. Тэсрэх дэлбэрэх аюултай ачаатай вагон, шахсан шингэрүүлсэн хийтэй цистерн байгаа зам руу сэлгээний зүтгүүр оруулах шаардлагатай үед өртөөний жижүүр, сэлгээний зохицуулагч, довын жижүүр, найруулагч нар сэлгээний машинчид тус тус анхааруулан сэлгээг бүртгэлийн хуудсаар /бичгэн наряд/ гүйцэтгэнэ.

13.27. Өртөө болон салбар замд сэлгээг дор дурдсанаас ихгүй хурдтай гүйцэтгэнэ:

13.27.1. вагон чирсэн зүтгүүр чөлөөтэй замаар явахад 40 км/цаг;


13.27.2. зүтгүүр чөлөөтэй замаар вагон түрэхэд /..... км/цаг/;

13.27.3. суман шилжүүлгээр хажуугийн зам руу орох үед тухайн суман шилжүүлэгт тогтоосон хурдаар;

13.27.4. суурь бүтэц эзэмшигчийн тогтоосон жагсаалтын дагуу хүн суулгасан, тэсрэх аюултай ачаа, шахсан ба шингэрүүлсэн хий, бусад аюултай ачаа, дээд, доод хажуугийн 3-6 дугаар зэргийн хэтрүү овортой ачаа ачсан вагонтой сэлгээ хийх үед 15 км/цаг;

13.27.5. зүтгүүр /вагонтой буюу вагонгүй/ вагонд залгахаар ойртох хурд 3 км/цагаас ихгүй;

13.27.6. зүтгүүр болон сэлгээний бүрэлдэхүүн пүү, хяналтын төхөөрөмж дээгүүр явах хурдыг пүүний техникийн паспортанд зааснаар суурь бүтэц эзэмшигч тогтооно;



13.27.7. довын бэлийн паркад салгасан вагон тухайн ялгалтын зам дээр байгаа хөдлөх бүрэлдэхүүнд ойртох хурд нь 5 км/цагаас ихгүй, харин онцгой болгоомж шаардагдах ангиллын ачаатай вагонд бол 3 км/цагаас ихгүй байна.

13.28. Зорчигчийн галт тэрэг явуулж байгаа замаар уг галт тэрэг явж зам бүрэн чөлөөлөгдөх хүртэл зүтгүүр ба сэлгээний бүрэлдэхүүнийг оруулахгүй байхыг анхаарч ажиллана. Зорчигчийн галт тэргээр эзлэгдсэн замд байгаа зүтгүүрийн машинч нь уг замыг чөлөөлөгдөх хүртэл явж байгаа зорчигчийн галт тэрэгний хойноос хөдлөхгүй байхыг анхаарч ажиллана.

13.29. 0.0025-аас огцом хэвгий дээр байгуулагдсан мөн түүнчлэн сумнаас хоорондын зам тал руу уруудууртай өртөөдөд татах мухар зам байхгүй бол сэлгээ хийхгүй байхыг хатуу анхаарч ажиллана. Шаардлагатай тохиолдолд сэлгээний ажлыг зөвхөн зүтгүүрийг уруудуурын талаас оруулж, вагоны автомат тоормосыг залгасан нөхцөлд хийж болно. Зүтгүүрийг уруудуурын талаас оруулах бололцоогүй үед сэлгээний ажлыг бүрэлдэхүүнээ ухраах замаар хийх бөгөөд вагоны автомат тоормосыг залгаж туршсан байвал зохино.

13.30. Хэвгий бүхий зам дээр сэлгээ хийх бүх тохиолдолд салгасан вагоныг сэлгээний бүрэлдэхүүнтэй мөргөлдөх, галт тэрэгний замнал руу, сэлгээний өөр хэсэг рүү вагон өөрөө явахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна.


13.31. Сэлгээний үед вагон өөрөө хөдөлж хоорондын замд гарах, галт тэрэгний зохион байгуулагдсан замнал буюу сэлгээний бусад бүс руу аюул үүсгэж болохоор хэвгий дээр байрлагдсан зам ба хэсгийн жагсаалт, мөн түүнчлэн сэлгээний үед энэ хэсэгт хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангахын тулд мөрдөгдөх ёстой нэмэгдэл арга хэмжээг өртөөний техник захирамжийн актаар тогтооно.

13.32. Сэлгээ хийх үед онцгой болгоомж шаардах зарим ачаатай вагон нь зохих халхлалттай байна.

13.33. Онцгой болгоомж шаардагдах зарим ангиллын ачаатай вагон бүхий галт тэрэг ба сэлгээнд тавигдах халхлалтын нормыг ачааны бичиг баримтанд тусгай тэмдгийг дарж заах бөгөөд түүнд халхлалтын вагоны хамгийн цөөн тоог, тоогоор тэмдэглэн заана. Жишээ нь: 3/0.1.3.1.

- 3/0 - түүчээ зүтгүүрээс халхлах вагоны тоо /хүртвэрт хатуу түлштэй зүтгүүр, хувиарт бусад зүтгүүрээс/
- 1 - түлхэгч зүтгүүрээс халхлах вагон тоо
- 3 - хүн суусан вагоноос халхлах вагоны тоо
- 1 - сэлгээний ажлын үед зүтгүүрээс халхлах вагон тоог тус тус тэмдэглэнэ.

13.34. Вагон ба зүтгүүрийн депогийн засварын зам дээрх сэлгээний хөдөлгөөнийг салбар нэгжийн удирдах ажилтны удирдлага, хяналтын дор гүйцэтгэнэ. Зорчигчийн вагон депогийн зам дээрх сэлгээний ажлыг депогийн сэлгээний зохицуулагч удирдана.



13.35. Өртөөний замууд дээр аж ахуйн галт тэрэг, замын машин ашиглан хийх ажил тухайн салбар нэгжийн /замын, дохиолол холбооны ба бусад/ ажил удирдагчийн удирдлаган дор явагдана.

13.36. Заагдсан галт тэрэг, машиныг өртөөний нэг замаас нөгөө рүү буюу өөр бүс рүү хийх хөдөлгөөн нь зөвхөн өртөөний жижүүрийн зөвшөөрлөөр гүйцэтгэгдэнэ. Шаардлагатай тохиолдолд заагдсан галт тэрэг, замын машины сэлгээний хөдөлгөөнийг удирдуулахаар өртөөний даргын шийдвэрээр зохих ажилтныг томилно.

13.37. Вагоныг гараар хөдөлгөхийг шаардлагатай тохиолдолд зөвхөн хэвгийгүй тэгш зам дээр зөвшөөрч болно.

13.38. Өртөөний гол болон хүлээн авах, явуулах зам дээр вагоныг гараар хөдөлгөхгүй байхыг анхаарч ажиллана.

13.39. Вагоныг гараар хөдөлгөх үед хатуу анхаарах зүйлүүд:

13.39.1. 3 км/цагаас илүү хурдтай хөдөлгөх;

13.39.2. гол ба хүлээн авах, явуулах замын чиглэлд хязгаарын шонг өнгөртөл хөдөлгөх;

13.39.3. тоормосны ивүүргүй байхад хөдөлгөж эхлэх;

13.39.4. тоормослохын тулд дугуйн дор дэр мод, чулуу, лоом ба бусад зүйлийг ивэх;

13.39.5. хүн суулгасан, тэсрэх дэлбэрэх аюултай ачаатай вагоныг хөдөлгөх.


13.40. Дагнасан болон нийтийн хэрэгцээний зам эзэмшигч нь тухайн зам дээрээ сэлгээ хийх суурин хэрэгсэлтэй байж болох бөгөөд сэлгээ хийх үйл ажиллагааг суурь бүтэц эзэмшигчтэй хамтран тогтооно.

13.41. Галт тэрэгний бүрэлдэхүүний тоормосны зөөлөн хоолойг салгах ба өлгөх ажлыг дараахь нөхцлүүдэд хийнэ. Үүнд:

13.41.1. зүтгүүрийн бригад бүрэлдэхүүнээс галт тэрэгний зүтгүүрийг салгах үед;

13.41.2. техник үйлчилгээний газрын ажилтнууд бүх ялгах, ачааны ба хэсгийн өртөөд дээр техник үйлчилгээний газрын ажлын технологийн горимын дагуу үйлчилгээ хийх вагоныг салгах үед;

13.41.3. найруулагчийн бригад сэлгээний үед салгах.



13.42. Өртөөн дээр байгаа радио холбоо, паркийн хоёр талын чанга яригчийн холбооны төхөөрөмж нь бүрэн бүтэн, гэмтэлгүй байж сэлгээний ажлыг зохион байгуулах, хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангахад ашиглагдана.

13.43. Радио холбоо, паркийн хоёр талын чанга яригчийн холбоогоор дамжуулагдсан заалт нь товч бөгөөд ойлгомжтой байна. Өгөгдсөн заалтыг сэлгээний зүтгүүрийн машинч зөв хүлээж авсан эсэхийг /заалтыг товчоор давтуулан сонсох, зүтгүүрийн шүгэл, радио холбоогоор өгөх хариу дохиог хүлээн авах/ өртөөний жижүүр магадлана.

13.44. Салбар зам руу хэт хэтрүү овортой ачаатай вагоныг тавьж өгөх татаж авахдаа суурь бүтэц эзэмшигчийн баталсан зааврын дагуу гүйцэтгэх бөгөөд энэ талаар техник захирамжийн актанд тодорхой тусгасан байна.

СЭЛГЭЭНИЙ АЖЛЫН УДИРДЛАГА БА БҮРЭЛДЭХҮҮН

13.45. Өртөөний зам дээр хийх сэлгээний ажлыг дор нэр дурьдсанаас зөвхөн аль нэг ажилтан удирдана.

а/ өртөөний жижүүр;

б/ сэлгээний зохицуулагч;

в/ ялгах довын жижүүр;

г/ паркийн жижүүр;

д/ галт тэрэгний зохицуулагч /галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн төвлөрүүлэлтээр тоноглогдсон хэсэгт/.

13.46. Сэлгээний ажилтай холбоотой захирамж өгөх талаар ажилтнуудын ажил үүргийн хуваарилалтыг өртөөний техник захирамжийн актанд заасан байна.

13.47. Ялгах дов дээр сэлгээний зүтгүүрийн хөдөлгөөнийг довын жижүүр удирдана.

13.48. Сэлгээний ажлыг найруулагч буюу туслах найруулагч гүйцэтгэнэ.

13.49. Орон нутгийн байдлаас хамааран сэлгээний ажлыг ганц найруулагчаар гүйцэтгүүлэхийг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

13.50. Сэлгээний үед туслах найруулагч нь найруулагч, зүтгүүрийн бригадад харагдахаар байрлаж өгч байгаа дохиог дамжуулж байна.

13.51. Сэлгээний зүтгүүрийг ганц машинчаар үйлчлүүлэхийг зүтгүүрийн төрөл, орон нутгийн байдлаас хамааран суурь бүтэц эзэмшигчийн баталсан заавраар тогтооно.

13.52. Түүвэр галт тэргэнд ажилладаг, сэлгээний ажил хийхэд зориулан гаргасан зүтгүүрийн бригад, найруулагчийн бригад нь өртөөн дээр сэлгээний ажил хийх талаар техник захирамжийн актаар тогтоосон заалтыг мөрдлөг болгоно.



13.53. Зүтгүүрийн болон найруулагчийн бригадыг өртөөний техник захирамжийн актанд заасан сэлгээний ажлын байдалтай танилцуулах зарчмыг хөдөлгөөн хариуцсан салбарын дарга тогтооно.

13.54. Найруулагчийн бригад, аж ахуйн галт тэрэгний бригад сэлгээний ажлын даалгаврыг зөвхөн өртөөний жижүүрээс хүлээн авна.

13.55. Сэлгээний ажлын төлөвлөгөө нь тодорхой, ойлгомжтой өгөгдөх ба түүнийг сэлгээний удирдагч оролцож байгаа ажилтан бүрт мэдэгдсэн байна.

13.56. Сэлгээ хийх явц дунд ажлын төлөвлөгөөг өөрчлөх шаардлага гарвал энэ өөрчлөлтийг сэлгээнд оролцож байгаа бүх ажилтанд урьдчилан танилцуулсан байна.

13.57. Сэлгээний нэг бүсээс нөгөөд сэлгээний зүтгүүрийн /вагонтой буюу вагонгүйгээр/ хийх хөдөлгөөнийг зөвхөн өртөөний жижүүр, довын жижүүр, сэлгээний хөдөлгөөн зохицуулагчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

13.58. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч, өртөө, паркийн жижүүр нь дараахь нөхцлүүдэд сэлгээний хориглосон заалттай дохиог өнгөрөхийг зөвшөөрч сэлгээ хийж болно.

13.58.1. дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын төхөөрөмжийг шинэчлэх, засвар үйлчилгээ хийх;

13.58.2. дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын төхөөрөмж гэмтсэн;

13.58.3. тухайн замналын ашигтай уртад хөдлөх бүрэлдэхүүн багтаагүй байх;

13.58.4. сэлгээний гэрлэн дохиогоор тоноглогдоогүй өртөө, зэрлэг.

13.59. Энэхүү журмын 13.58.1, 13.58.2-т заасан тохиолдолд өртөөний жижүүр найруулагчийн бригад эсвэл өртөөний техник захирамжийн актад заагдсан ажилтан замнал бэлдэж зүүдэг цоожоор цоожлон замнал хамгаална.

13.60. Энэхүү журмын 13.58.3, 13.58.4-т заасан тохиолдолд өртөөний жижүүр цахилгаан төвлөрүүлэлтийн байгууламжийн хянах хэрэгсэлээр замнал хянагдаж байгаа үед суман шилжүүлгүүдийг зохих байдалд нь тавьж сэлгээний дохиогоор, сумын бариулыг зохих байдалд тавих, улаан таг өлгөх аргаар хамгаална.

13.61. Хориглосон заалттай дохиогоор сэлгээний ажил хийх дараалал:

13.61.1. зүтгүүр, мотовоз зэрэг өөрөө явагч хөдлөх нэгж зогсож байгаа газрыг тодорхойлно.

13.61.2. замнал зөв бэлтгэгдсэн эсэхийг шалгаж, шалгуулж магадлана.

13.61.3. бэлтгэсэн замналыг хамгаална.



13.61.4. хориглосон заалттай дохио өнгөрч болох тухай тушаал өгч өртөөний жижүүр ба сэлгээний зүтгүүрт байдаг дэвтэрт, галт тэрэгний зүтгүүрт бол машинчийн замналын хуудсанд өртөөний жижүүр, машинч тушаалаа бичнэ.

13.61.5. тушаал зөв авсан эсэхийг давтуулна.

13.61.6. албан ярилцлага хийж сэлгээний хөдөлгөөнийг эхлүүлнэ.

13.62. Бусад тохиолдолд гэрлэн дохионы хориглосон заалттай дохиогоор сэлгээ хийхгүй байхыг хатуу анхаарна.

13.63. Галт тэрэгний найруулагчийн үүрэг:

13.63.1. галт тэрэг найруулах төлөвлөгөө, төмөр замын хэмжээнд мөрдөгдөж байгаа бусад журам, зааврын шаардлагад нийцүүлэн галт тэргийг найруулах;

13.63.2. сэлгээний ажилд оролцож байгаа бүх ажилтанд сэлгээний ажлын төлөвлөгөө ба түүнийг гүйцэтгэх аргыг танилцуулсаны үндсэн дээр тэдгээрийн үйл ажиллагааг зөв зохицуулан хуваарилах;

13.63.3. сэлгээний ажлын төлөвлөгөөг цаг тухайд нь биелүүлэх;

13.63.4. сэлгээний ажилд оролцож байгаа ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, хөдөлгөөний аюулгүй ажиллагаа, ачаа ба хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн байдлыг хангасан байхаар сэлгээний ажлыг зохион байгуулах. Хүн суулгасан, хэтрүү овортой, тэсрэх аюултай ачаатай вагоныг болгоомжтой сэлгэж байх.

13.64. Найруулагчийн бригад ээлжинд гарахын өмнө өртөө болон салбар замд байгаа хөдлөх бүрэлдэхүүний байрлал ба бэхэлгээгтэй танилцана.

13.65. Галт тэрэгний найруулагч сэлгээний ажил эхлэхийн өмнө гүйцэтгэх үүрэг:


13.65.1. сэлгээнд оролцогч бүх ажилтан, түүний дотор зүтгүүрийн бригад өөрсдийн ажлын байранд байгаа эсэхийг магадлах;

13.65.2. сэлгээнд оролцож байгаа зүтгүүрийн бригадад болон өртөөний бусад ажилтанд сэлгээний төлөвлөгөө, түүнийг биелүүлэх ажиллагааг танилцуулах;

13.65.3. сэлгээний хөдөлгөөнийг эхлэхэд саад болох зүйлүүд байгаа эсэхийг шалгах.

13.66. Сэлгээний үед зүтгүүрийн жолоодлогыг машинч гүйцэтгэнэ. Зүтгүүрийн жолоодлогыг зааварлагч машинчаас тухайн туслах машинчийн маягтад /формулярт/ бичсэн зөвшөөрлийн дагуу машинч өөрийн хяналтан дор өгч болно.

13.67. Сэлгээ хийх үеийн галт тэрэгний найруулагч ба түүний туслахын үүрэг:



13.67.1. вагон өөр хоорондоо болон зүтгүүртэй холбогдсоныг магадлахгүйгээр сэлгээний бүрэлдэхүүнийг хөдөлгөөнд оруулахгүй байхыг хатуу анхаарна;

13.67.2. холболт эхлэхийн өмнө вагоны салгах хөшүүргэн бариулын байдлыг зөв эсэхийг шалгах, салгалтын дараа эдгээр бариулыг хэвийн байдалд тавих;

13.67.3. хөдлөх бүрэлдэхүүнийг довоос буулгахын өмнө салгах хөшүүргээр авто угсрааг салгаж уг хөшүүргийг буцааж хэвийн байдалд тавих;

13.67.4. сэлгээний хөдөлгөөнд замналыг бэлтгэж байгаа сумчдад зүтгүүрийн машинчийн өгч байгаа дохио зөв өгөгдөж байгаа эсэхийг анхаарах;

13.67.5. сэлгэж байгаа бүрэлдэхүүний үзэгдэлт сайн газар байрлах ба машинч, туслах машинчид өгч байгаа дохио харагдаж байх;

13.67.6. замын тахир хэсэгт урт бүрэлдэхүүнтэй, үзэгдэлт муутай нөхцөлд /манан будан, цасан шуурга ба бусад/ сэлгээ хийх үед дохионы заалтыг радио холбоо, паркийн хоёр талын холбоогоор давтан дамжуулах. Тоон системийн радио холбоотой үед дохионы хэрэгсэлийн нэгэн адил ашиглаж болно;

13.67.7. бүрэлдэхүүн рүү ойртохын өмнө хаах дохио байгааг магадлах;

13.67.8. ачилт, буулгалтын газарт /түлээ, модон материал, тоосго, чулуун нүүрс, хүдэр ба бусад/ сэлгээний бүрэлдэхүүнийг хөдөлгөхийн өмнө хөдөлгөөнд нөлөөлөх саад тотгор байгаа эсэхийг магадлах;

13.67.9. ачилт буулгалтын ажиллагаа дуусаагүй вагонуудад сэлгээний ажил хийхдээ овор хэмжээ гаргуулж, ачиж буулгах ажиллагааг удирдаж байгаа ажилтантай сэлгээний ажил хийх талаар тохиролцон ажлыг бүрэн зогсоож хүмүүсийг аюулгүй зайд холдуулсаны дараа сэлгээний ажлыг гүйцэтгэх;

13.67.10. зүтгүүр салгахаас өмнө хөдлөх бүрэлдэхүүнийг ивүүрээр бэхэлнэ.

13.68. Засварын бригад ажиллаж байгаа гарам, ачааны агуулах, ачих буулгах анги, вагоны ба зүтгүүрийн депогийн болон зорчигчийн тавцангийн ойролцоох зам, засварын бусад зам суман дээр сэлгээ хийх үед найруулагчийн ба зүтгүүрийн бригад онц сонор сэрэмжтэй байж, бүрэлдэхүүн ойртох үед замын дэргэд буюу тавцан дээр байгаа хүмүүст мэдэгдэх дохио өгч явахын зэрэгцээ зам, вагон засаж, ачаа ачиж буулгаж байгаа хүмүүст хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөний талаар анхааруулж байна.

13.69. Вагоноо чирж яваа үед найруулагч сүүлийн вагон дээр, туслах найруулагч бүрэлдэхүүний дунд хэсэгт байрлана.

13.70. Хориглосон заалттай сэлгээний гэрлэн дохиог өнгөрч сэлгээ хийх үед найруулагч замналыг шалгаж зүтгүүрийн эхний гишгүүр дээр байрлаж явна.



13.71. Өртөө зөрлөгөөс 3 км ба түүнээс дээш алслагдсан салбар замуудад сэлгээний ажил хийхээр бүрэлдэхүүнийг чирж яваа тохиолдолд бүрэлдэхүүн бүрэн холбогдсон, сүүлийн вагонд агаар ирж байгааг магадлан найруулагчийн бригад нь зүтгүүрийн бүхээгт байрлана. Алслагдсан салбар замуудын жагсаалтыг техник захирамжийн актаар тогтооно.

13.72. Вагоноо өмнөө түрж яваа хөдөлгөөний үеийн бүх тохиолдолд галт тэрэгний найруулагч хөдөлгөөний дагуу анхны вагоны гишгүүр дээр байрлана. Оворгүй газруудад сэлгээний хөдөлгөөнийг явганаар удирдана. Оворгүй газруудын жагсаалтыг техник захирамжийн актаар тогтооно.

13.73. Холбох буюу татах замаар дамжих бүрэлдэхүүнийг нэг паркаас нөгөөд шилжүүлэн тавих үеийн аюулгүй ажиллагааг хангах нөхцөлийг өртөөний техник захирамжийн актаар тогтооно.

13.74. Сэлгээний үед найруулагч замын нөгөө төгсгөл талын хязгаарын шонгоос /тусгаарлагч уулзвар буюу дохио/ цааш бүрэлдэхүүнийг гаргахгүй.

13.75. Хийгдэж байгаа сэлгээний ажлын тухай замын нөгөө төгсгөл талд байрласан постын сумчинд мэдэгдсэн байх ба хязгаарын шонгоос цааш хөдлөх бүрэлдэхүүн гарах боломжийг үгүйсгэсэн байна.

13.76. Өртөөний жижүүр, сэлгээний хөдөлгөөн зохицуулагч, довын жижүүр хүн суулгасан, тэсрэх дэлбэрэх аюултай ачаа ачсан вагонтай сэлгээ хийх шаардлагатай үед энэ тухай найруулагчид мэдэгдэх бөгөөд найруулагч өөрийн туслах, зүтгүүрийн бригадад мэдээлнэ.

13.77. Сэлгээ хийх үед зүтгүүрийн бригадын үүрэг:

13.77.1. сэлгээний ажлын төлөвлөгөөг цаг тухайд нь биелүүлэх;

13.77.2. өгөгдөж байгаа дохиог анхааралтай ажиглаж дохионы заалтыг тухай бүр биелүүлж байх;


13.77.3. зам дээр байгаа хүмүүс, сумын байдал, хөдлөх бүрэлдэхүүний байрлалыг анхааралтай ажиглаж байх;

13.77.4. сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;

13.77.5. сэлгээний хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн байдлыг хянах;

13.77.6. сэлгээний ажлын үед дан зүтгүүрээр хөдөлгөөн хийх тохиолдолд явах чиглэлд зүтгүүрийн удирдлагыг шилжүүлж, бүхээгийг заавал сольж байна;

13.77.7. зогсох дохио гэнэт өгөгдөх буюу саад гэнэт тохиолдох үед Техник ашиглалтын журмын 14.3.7-д заасны дагуу яаралтай тоормослох бүх арга хэрэгслийг ашиглан сэлгээний бүрэлдэхүүнийг тухайн газарт тогтоосон тоормосны замаас илүүгүй зайд зогсооно.



13.78. Машинч зүтгүүр хөдөлгөөнд оруулахын өмнө өгөгдөж байгаа дохио, радио холбоо, паркийн хоёр талын чанга яригчийн холбоогоор хүлээн авсан захирамжийг зүтгүүрийн шүглээр, радио холбоогоор товч давтан батална.

13.79. Машинч дохио ба захирамж зөв эсэхэд эргэлзсэн, сэлгээний ажлын төлөвлөгөөг мэдээгүй байгаа бол бүрэн тодруулж, магадласны дараа хөдөлгөөнд орно.

13.80. Машинч сэлгээний ажил удирдагчийн тушаалыг радио холбоо, паркийн хоёр талын чанга яригчийн холбоогоор аваагүй, гар дохионы хэрэгслээр өгч байгаа дохио харагдаагүй нөхцөлд зүтгүүрийг хөдөлгөөнд оруулахгүй байхыг хатуу анхаарна.

13.81. Машинч төвлөрүүлэгдсэн сумтай сэлгээний замнал руу орохын өмнө ажил удирдагчийн тушаал, сэлгээний гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт байгаа эсэхийг магадлана.

13.82. Машинч төвлөрүүлэгдээгүй сум руу гарах бол замнал бэлэн болсон тухай сумчны дохио буюу мэдэгдлийг авна.

13.83. Сум, дохионы цахилгаан төвлөрүүлэлт бүхий өртөөдөд сумыг төвийн удирдлагаас суурин удирдлагад шилжүүлсэн үед сум руу гарч сэлгээ хийхийг ажил удирдагчийн дохиогоор гүйцэтгэнэ.

13.84. Вагоноо өмнөө түрж яваа үед хэрэв машинчид замнал бэлэн болсон тухай өгч байгаа дохио, сэлгээний гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт харагдаагүй байгаа бол сэлгээний удирдагчаас дохионы нээлттэй байдлыг лавлаад сэлгээний удирдагчийн дохиогоор явна.

13.85. Найруулагчийн бригад дагалдаагүй ганц зүтгүүр өртөөний замаар хөдлөхдөө зүтгүүрийн машинчид шууд дамжуулагдаж байгаа өртөөний жижүүр ба сумчингийн дохио буюу сэлгээний гэрлэн дохионы зөвшөөрсөн заалтыг удирдлага болгоно.

13.86. Сэлгээ хийх үеийн сумчны үүрэг:

13.86.1. сэлгээний хөдөлгөөнд өгөгдөж байгаа заалт, дохиог анхааралтай ажиглаж тэдгээрийн шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;

13.86.2. өгч буй дохиог машинч, найруулагчид цаг тухайд тодорхой дамжуулах;

13.86.3. дохио өгөх, сэлгээний бүрэлдэхүүний хөдөлгөөний тухай мэдээ дамжуулахын өмнө замналд орсон сумын байдал зөв эсэхийг шалгах;

13.86.4. сумыг шилжүүлсний дараа түүнийг цүүгээр нь түгжих, шор нь жааз төмөртөө нягт наалдсаныг магадлах.



ЯЛГАХ ДОВ, ТАТАХ ЗАМ ДЭЭРХ СЭЛГЭЭ

13.87. Вагоныг ялгахад зориулсан довын байгууламжтай өртөөнд сэлгээний ажлыг суурь бүтэц эзэмшигчийн баталсан зааврын дагуу гүйцэтгэнэ.

13.88. Ялгах довоос вагоныг тараахын өмнө довын жижүүр дараахь үүргийг гүйцэтгэнэ.

13.88.1. ялгах замууд дов талаас хэр зэрэг чөлөөтэй байгаа, тэдгээр замуудад вагон оруулах боломж байгаа эсэхийг шалгах;

13.88.2. вагон ялгах ажлын төлөвлөгөө, салгах бүлэг вагон /салгалт/-ны байрлал, салгах дараалал, салгалт бүр дэх вагоны тоо, довоос буулгах вагоны явах ангийн хэв байдал ба онцгой болгоомж шаардсан болон урт баазтай вагон байгаа зэрэг шаардлагатай мэдээлэлтэй танилцах;

13.88.3. өртөөнд тогтоосон зааврын дагуу вагонуудыг ялгах ажиллагаанд оролцож байгаа бусад ажилтан /галт тэрэгний найруулагч, туслах найруулагч, ивүүрчид ба бусад/-д ажлын шинж байдлыг танилцуулах.

13.89. Довын жижүүр, галт тэрэгний найруулагч, ивүүрчин нар тараалтын ажиллагааны үед ялгах замууд вагоноор эзлэгдсэн байдал, салгасан вагонууд сум ба довын бэлийн замуудаар дээгүүр өнхөрч байгаа байдал, нэг салгалтаар хэдэн вагон салгаж байгаа, ялгах замууд руу вагон буулгах давтамж зэргээс хамааруулан дов руу түрэх хурдыг болон довоос өнхөрсөн вагоны зогсоох тоормослолтыг тохируулна.

13.90. Довын жижүүр нь тараалтын явцад салгасан вагоны хөдөлгөөн, вагон буулгавал зохих зөв зам руу явж байгааг ажиглахын зэрэгцээ дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавина.

13.91. Тараалтын явцад довын жижүүр, найруулагч нь онцгой болгоомж шаардагдсан ачаа бүхий вагон зогсож байгаа зам руу довоос салгалт хийн вагон буулгаж байгаа үед ивүүрчид ба сумчид тараалтын аюулгүй ажиллагаа, хөдлөх бүрэлдэхүүний болон ачааны бүрэн бүтэн байдлыг хангах талаар онцгой анхаарч ажиллана.

13.92. Задлан тараагдаж байгаа бүрэлдэхүүнд болон ялгах паркийн зам дээр онцгой болгоомж шаардагдах тусгай ангиллын ачаатай вагон байгаа тухай өртөөний ажилтан нарт мэдээллэхийг орон нутгийн заавраар тогтооно.

13.93. Доорх бүрэлдэхүүнийг огцом түлхэж сэлгээ хийх дов, хагас довоос тараахгүй байхыг хатуу анхаарна:

13.93.1. ачаа хүргэгчтэй вагоноос бусад хүн суулгасан вагон;



13.93.2. тэсрэх дэлбэрэх аюултай ачаа, шахсан шингэрүүлсэн хий, суурь бүтэц эзэмшигчээс тогтоосон жагсаалтанд заагдсан зарим зэрэглэлтэй ачаа бүхий вагон, шингэрүүлсэн хийнээс суларсан хоосон цистерн;

13.93.3. хэтрүү овортой, хүнд ачаатай тавцант ба хагас вагон, транспортер;

13.93.4. ажиллаагүй байгаа зүтгүүр, төмөр замаар өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүн, хөргүүрт вагон ба секц, хөргүүрт хөдлөх бүрэлдэхүүн бүхий галт тэрэгний бүрэлдэхүүн, зоогийн вагон, зорчигчийн вагон, төмөр замаар явдаг кран;

13.93.5. тусгай /радио, цахилгаан станц, эмнэлэг, клуб, хүчний хэмжүүр, зам хэмжүүр, пүүний гэх мэт/ вагон болон "довоос бүү буулга" гэсэн бичигтэй бусад вагон.

13.94. Энэхүү журмын 13.93-д дурдсан хөдлөх бүрэлдэхүүнд дов дээр сэлгээний ажил гүйцэтгэхдээ зөвхөн ухраан суулгах аргаар хийнэ.

13.95. Ялгах довоос вагоныг довын гэрлэн дохионы зөвшөөрсөн заалтаар тараах хурдыг довын техник тоноглол, орон нутгийн нөхцөлийг харгалзан суурь бүтэц эзэмшигч тогтооно.

13.96. Ялгах довоос буулгахыг хориглосон буюу буулгах үед онцгой болгоомж шаардах ачаатай вагоны ачааны жагсаалтыг суурь бүтэц эзэмшигч тогтооно. Жагсаалтанд орсон вагоны бичиг баримт дээр "довоос бүү буулга" гэсэн бичлэгтэй тэмдэг дарна.

13.97. Ачаа дагалдагч, үйлчлэгчтэй /баг/ буюу мал, амьтан ачсан хүргэгчтэй вагоныг довоос тараахын өмнө галт тэрэгний найруулагч сэлгээ хийх тухай вагоны үйлчлэгч, хүргэгч /баг/ нарт урьдчилан мэдэгдсэн байна.

13.98. Тараалтын явцад ивүүрчин бүр ялгах зам дээр байгаа вагоныг ажиглах ба зам вагоноор дүүрсэн үед энэ тухай довын жижүүр, найруулагчид урьдчилан мэдэгдэнэ.

13.99. Ялгах довын аюулгүй ажиллагааг хангахын тулд ивүүрчин дараахь үүргийг гүйцэтгэнэ.

13.99.1. бүрэлдэхүүнийг тарааж эхлэх үед өөрийн хариуцсан зам дээр байх;

13.99.2. салгалтын тухай довын жижүүр, галт тэрэгний найруулагч, зүтгүүрийн машинчийн өгч байгаа дохиог анхааралтай ажиглах;

13.99.3. ялгах замын багтаамжийг бүрэн ашиглахын зэрэгцээ, ялгах паркад зогсож байгаа вагон руу довоос буулгасан вагон ойртохдоо хүчтэй мөргөлдөхгүй байх, залгалтын үеийн аюулгүй ажиллагааг бүрэн хангах тооцоотойгоор вагоныг тоормослуулна. Олон вагонтой салгалтыг довоос тараах үед нэмэгдэл тоормосны ивүүрийг дунд талын вагоны хос дугуйн дор тусгай сэрээний тусламжтай тавина;



13.99.4. тараасан вагоныг зогсоосны дараа ивүүрийг вагон дороос зориулалтын багажаар авах;

13.99.5. зэргэлдээ ажлын бүсэд салгалт ихээр хийгдэж байгаа үед тэдгээр замыг хариуцан ажиллаж буй ивүүрчинд туслах үүрэгтэй.

13.100. Өртөөний зам дээр вагоныг бэхлэх үед дараахь газруудад тоормосны ивүүр тавихгүй байхыг анхаарна.

13.100.1. зам төмрийн уулзварын өмнө ба зам төмрийн уулзвар дээр;

13.100.2. суман шилжүүлгийн шор нийлсэн жааз зам төмөр дээр;

13.100.3. тахирын гадна талын зам төмөр дээр;

13.100.4. вагоны тэргэнцэрийн хос дугуйн хооронд;

13.100.5. суман шилжүүлгийн тоонолжийн өмнө.

13.101. Гэмтэлтэй /толгой нь хагарсан, ул нь мурийсан, цуурсан, эмтэрсэн ба бусад/ тоормосны ивүүрийг хэрэглэхгүй байхыг хатуу анхаарна.


13.102. Тоормосны ивүүрийг /ялгарах өнгөөр/ будаж, түүн дээр өртөөний тэмдэг, дугаарыг цохиж тавина. Ивүүрийг цоожтой бат бэх найдвартай саванд хадгална. Ивүүрийг бүртгэх, дугаарлах, шилжүүлэх, ашиглах, хяналт тавих, устгах зааврыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

13.103. Довын жижүүр, найруулагч хоорондоо урьдчилан тохиролцохгүйгээр ялгах паркад /довын талаас буюу паркийн замын нөгөө талаас/ вагоныг ухраах ба холбохгүй байхыг хатуу анхаарна.

13.104. Найруулагчийн бригад нь бүрэлдэхүүнийг ухраахын өмнө вагон доогуур ивүүр байхгүй, авто угсрааны хөшүүргийн бариул хэвийн байдалд байгааг магадлана.

13.105. Ялгах зам дээр тэсрэх дэлбэрэх аюултай ачаатай вагон байгаа үед найруулагч нь вагоныг хөдөлгөхийн өмнө хөдөлгөөнд саад болох зүйл байгаа эсэхийг магадлана. Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл /хүчтэй салхи, манан будан, цасан болон шороон шуурга/, гэрэлтүүлэгдээгүй зам дээр сэлгээний ажлыг онцгой сонор сэрэмжтэй, шаардлагатай тохиолдолд бууруулсан хурдтай гүйцэтгэх бөгөөд сэлгээний хөдөлгөөнийг зогсоох хүртэл арга хэмжээг авна.

13.106. Ялгах довын хэвийн ажиллагаа алдагдсан, өмнөх бүлэг вагон сумын хоолойд зогссон, дараагийн бүлэг вагон мөргөх зэрэг эрсдэл үүссэн тохиолдолд жижүүр, найруулагч, ивүүрчин, сумчин дараагийн салгалтыг зогсоох арга хэмжээг авна.



ГОЛ БА ХҮЛЭЭН АВАХ, ЯВУУЛАХ ЗАМД ХИЙХ СЭЛГЭЭ

13.107. Өртөөний хүлээн авах, явуулах паркард хийх сэлгээг зөвхөн өртөөний жижүүрээс найруулагчид сэлгээний ажлын төлөвлөгөө өгөх үедээ заасан тэр зам дээр /сум дээр/ гүйцэтгэж болно. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч болон зэргэлдээ өртөөний жижүүрийн зөвшөөрөлгүйгээр машинч хоорондын зам эзлэх эрхгүйгээр өртөөний заагаас гадагш хоорондын зам руу бүрэлдэхүүн гаргаж сэлгээ хийхгүй байхыг хатуу анхаарна.

13.108. Сэлгээний бүрэлдэхүүн өртөөний заагаас гадагш хоорондын замд гарч болох бөгөөд дараахь зөвшөөрлийг авна:

13.108.1. хагас автомат хориглолтой үед уг хоорондын замд хамаарагдах түлхүүр-очир, түүнийг байхгүй үед замын утсан мэдээ;

13.108.2. цахилгаан очирын системийн үед уг хоорондын замд хамаарагдах очир буюу түлхүүр-очир;

13.108.3. утсан холбооны үед замын утсан мэдээ, түүнд хоорондын замд гарч сэлгээ хийхийг зөвшөөрсөн зэргэлдээ өртөөний жижүүрийн зөвшөөрөл;

13.108.4. өртөө хоорондын хориглолтой үед уг хоорондын замд хамаарагдах түлхүүр-очир, түүнийг байхгүй үед замын утсан мэдээ.

13.109. Өртөөний заагаас бүрэлдэхүүн гарах үед сэлгээний машинчид олгох замын утсан мэдээний дээд талд нь “өртөөний заагаас гарч сэлгээ хийнэ” гэсэн тэмдэглэл хийгдэнэ.

13.110. Сэлгээний зүтгүүрийн машинчид замын утсан мэдээ олгон хоорондын замд өртөөний заагаас гарч сэлгээ хийх тухай өртөөдийн жижүүрийн хооронд явагдах яриа бүх тохиолдолд галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн холбоогоор түүний хяналтын дор гүйцэтгэгдэх ба галт тэрэгний утсан мэдээний дэвтэрт тэмдэглэгдэнэ.

13.111. Ачилт буулгалт, засварт ба бусад ажиллагаанд тавихаар галт тэрэгнээс салгагдсан вагоноор хүлээн авах, явуулах замыг эзлүүлэхгүй байхыг анхаарна. Завсарын өртөөний жижүүр хүлээн авах, явуулах замыг зөвхөн галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн зөвшөөрлөөр саланги болон бүлэг вагоноор түр эзлүүлж болно.

13.112. Барих мухар замыг ямар ч хөдлөх бүрэлдэхүүнээр, хамгаалах мухар замыг зорчигчийн ба хүн суулгасан ачааны вагон, тэсрэх дэлбэрэх аюултай ачаатай вагоноор эзлүүлэхгүй байхыг анхаарна.

13.113. Сэлгээний ажил хийхэд сэлгээний бүрэлдэхүүн хүлээн авах буюу явуулах зам руу гарч хийгдвэл өртөөний жижүүр нь галт тэрэг хүлээн авч явуулах гэж байгаа талаар сэлгээний бригадад радио холбоо, паркийн хоёр талын чанга яригч холбоо, сумчнаар дамжуулан урьдчилан мэдэгдсэн байна.



НАЙРУУЛАГЧИЙН БРИГАД СУМЫГ ШИЛЖҮҮЛЖ СЭЛГЭЭНИЙ АЖИЛ ХИЙДЭГ БҮС

13.114. Ачих буулгах анги, хэсэг, нүүрсний агуулах, вагон, зүтгүүрийн депогийн ба дагнасан хэрэглээний салбар зам эзэмшигчийн зам руу сэлгээний зүтгүүр орох шаардлагатай үед өртөөний жижүүр, галт тэрэгний найруулагч нар вагон тавьж өгөх, татаж авах боломжийн талаар тухайн байгууллага, нэгжийн ажил удирдагчтай урьдчилан тохиролцоно. Хэрхэн тохиролцож байх тухай өртөөний Техник захирамжийн актад заасан байна.

13.115. Найруулагчийн бригад сумыг шилжүүлж сэлгээний ажил хийдэг хэсэг зам руу сэлгээний бүрэлдэхүүн оруулахын өмнө найруулагчийн бригад сэлгээний бүрэлдэхүүнийг зогсоож зам, сумын байдлыг шалгах ба хөдөлгөөний аюулгүй байдалд саад учрах хүчин зүйл байгаа эсэхийг магадлана.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АНХААРАМЖ ОЛГОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

14.1. Галт тэрэг аялалд явах үед зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын онцгой анхааралтай явах нөхцөлийг хангах, зам дээр хүмүүс ажил гүйцэтгэж байгааг урьдчилан анхааруулах зорилгоор галт тэрэгний машинчид бичгэн анхаарамжийг олгоно.

14.1.1. зам, гармын дохиолол, хиймэл болон бусад байгууламж эвдэрсэн, мөн түүнчлэн хурд бууруулах замд зогсох шаардлагатай барилгын болон засварын ажил хийх үед;

14.1.2. гэрлэн дохио, семафорыг шинээр ашиглалтанд оруулах, хуучин байсныг шилжүүлэн байрлуулах, хураан авах, гэрлэн дохио, семафорын зөвшөөрсөн заалт хориглосон байдалд шилжихгүй гэмтсэн үед;


14.1.3. ачилтын овор хэмжээнээс хэтэрч илүү гарсан ачаатай, хагас ачаатай цистерн вагонтой галт тэргийг явуулах үед;

14.1.4. тухайн хэсэгт тогтоосон хурдтай явж чадахгүй хөдлөх бүрэлдэхүүнийг галт тэргэнд холбосон үед;

14.1.5. замаас авагддаг хөдлөх нэгжийг үзэгдэлт муутай нөхцөлд ажиллуулах, мөн түүнчлэн замын тэргэнцэрээр хүнд ачаа тээвэрлэх үед;

14.1.6. зүтгүүрийн автомат дохиоллын замын байгууламж гэмтсэн үед;

14.1.7. техник ашиглалтын журмын 17.1.7-д заасны дагуу хурд бууруулах, галт тэрэг зогсоох шаардлагатай газар мөн түүнчлэн галт тэрэгний явах онцлог нөхцөл байдлын тухай зүтгүүрийн ба галт тэрэгний бригадад анхааруулах шаардлагатай бүх тохиолдолд;



14.1.8. хос замтай хоорондын замд цас цэвэрлэгч машин, чиг залагч, чигжигч машин, зам тавигч кран, төмөр замын кран, чигжээс цэвэрлэгч машин, бусад машин ажиллах үед.

14.2. Бүх анхаарамж 4 төрөлд хуваагдана. Үүнд:

14.2.1. гүйцэтгэх ажлын нөхцөл байдлаас хамааран уг ажлын удирдагч нь түүнийг дуусгах хугацааг тодорхой тогтоож чадахгүй бол тогтоосон агшнаас эхлэн өөрчлөх хүртэл хүчинтэй байх;

14.2.2. анхаарамж олгох захиалганд заагдсан, ажил удирдагчийн тогтоож өгсөн тодорхой хугацааны туршид хүчинтэй байх;

14.2.3. зарим галт тэргийг өнгөрүүлэхэд онцгой нөхцөл шаардлагатай үед тогтоогдох /галт тэрэг тогтоосон хурдтай явж чадахгүй ачаатай хөдлөх бүрэлдэхүүн байгаа, цагийн хуваарьт тусгагдаагүй зогсолттой явуулах гэх мэт/;

14.2.4. суурь бүтцийн төхөөрөмж байгууламжийг шинэчлэх, засвар үйлчилгээ хийх үед.

14.3. Урьдчилан төлөвлөгдсөн ажил гүйцэтгэхийн тулд анхаарамж олгох тухай захиалгыг дараахь албан тушаалтан дор дурьдсан хугацаагаар өгнө.

14.3.1. замын мастер, шугам сүлжээний хэсгийн мастер, дохиолол холбооны цахилгаан механикч нар түр хугацаагаар ажил гүйцэтгэхдээ 1 хоногоос илүүгүй;

14.3.2. зам, дохиолол холбоо, эрчим хүч, ус хангамжийн засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн дарга нар 3 хоногийн давтамжтайгаар 10 хүртэл хоног;

14.3.3. суурь бүтэц эзэмшигч ба тасгийн дарга 10 хүртэл хоног.


14.4. Энэхүү журмын 14.3-т зааснаас их хугацаатай анхаарамжийг суурь бүтэц эзэмшигчийн тушаалаар тогтооно. Анхаарамж тогтоох тухай тушаалаар суурь бүтэц эзэмшигчээс зохих удирдлагуудад гүйцэтгэх ажлыг дуусгах, хэвийн хурдыг сэргээсний дараа анхаарамжийг хүчингүй болгох эрх олгоно.

14.5. Замын мастер, цахилгаан механикч, эрчим хүчний мастер дараахь тохиолдолд анхаарамж олгох тухай захиалгыг өгнө.

14.5.1. үзэгдэлт муутай нөхцөлд замаас авагддаг хөдлөх нэгжүүд ажиллах үед;

14.5.2. замын бригадын даргын удирдлагаар замын тэргэнцрээр хүнд ачаа зөөх үед.

14.6. Урьдчилан төлөвлөгдсөн зам засварын ажлыг гүйцэтгэх тухай анхаарамжийг олгох захиалгыг замын мастер өгнө.



14.7. Анхаарамж олгох урьдчилан төлөвлөгдсөн ажлын жагсаалтыг Замын ажил гүйцэтгэх үед галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангах заавраар тогтооно.

14.8. Хөдөлгөөний аюулгүй ажиллагаанд аюул учруулж болох замын байгууламжинд илэрсэн гэмтлийг арилгахын тулд зогсоох дохиогоор хаах, хурд бууруулах дохиогоор хамгаална. Урьдчилан төлөвлөгдөөгүй ажлыг /гэмтэлтэй хавчаар, сумын шор, тонолжийн хэсэг, зам төмрийн нэгчилсэн солилт хийх, тэдгээрийг засварлах, замын овоолтыг засах гэх мэт/ хийхийн тулд анхаарамж олгох захиалгыг замын мастер /түүнийг байхгүйд замын бригадын дарга/ шугам сүлжээний хэсгийн мастер, цахилгаан механикч өгнө. Энэ тухай зам, эрчим хүч, ус хангамж, дохиолол холбооны засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн дарга нарт мэдэгдэнэ.

14.9. Анхаарамж олгох захиалгыг бичгээр, цахилгаанаар, утсаар, факсаар суурь бүтэц эзэмшигчийн тогтоосон анхаарамжийг олгох өртөөдийн жижүүрт, анхаарамж олгогдох хоорондын замыг хязгаарлагч өртөөдийн жижүүрт хаяглаж өгнө. Анхаарамж олгох өртөөдөд өгөгдсөн бичгэн захиалга, тогтоогдсон бусад хаягаар явуулах цахилгаан, утсан мэдээ нь албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.


14.10. Анхаарамж олгох цахилгааныг уг анхаарамж хүчин төгөлдөр болж мөрдөгдөхөөс 3-аас доошгүй цагийн өмнө хүлээн авсан байхаар өгнө. Урьдчилан төлөвлөгдөөгүй ажил хийхийн тулд анхаарамж олгох тухай захиалга, анхаарамж тогтоосон хоорондын замыг хязгаарлагч өртөөний жижүүрт шууд дамжуулагдсан /бичгээр буюу утсаар/ бол уг өртөөний жижүүр нь энэ захиалгын агуулгыг зэргэлдээ өртөөний жижүүр, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нарт дамжуулах үүрэгтэй бөгөөд галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь өртөөний жижүүрт явж байгаа галт тэрэгнүүдээс урьдчилан төлөвлөгдөөгүй анхаарамжийг ямар галт тэргэнд олгохоор өртөөн дээр зогсоохыг мэдэгдэнэ. Анхаарамж хүлээн авсан өртөөний жижүүр галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн шийдвэрээр уг галт тэргийг зогсоож анхаарамжийг машинчид олгоно.

14.11. Анхаарамж тогтоох ба өөрчлөх, захиалга, цахилгаан, утсан мэдээг шуурхай дамжуулах, заасан хаягаар хүргэх зааврыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.

14.12. Ажил удирдагч анхаарамж олгохыг хүссэн захиалга хүчин төгөлдөр болсон эсэхийг баталж магадлалгүйгээр ажил эхлэхгүй байхыг хатуу анхаарна. Захиалга хүчин төгөлдөр болсныг дараахь баримтаар батлана:

14.12.1. цахилгаан /утсан мэдээг/-ыг тогтоосон хаягаар дамжуулахаар хүлээн авсан цаг хугацааг бичсэн, телеграфын ажилтаны гарын үсэг бүхий цахилгааны /утсан мэдээ/ хувь. Телеграф байхгүй бол өртөөний жижүүр цахилгааныг хүлээн авч гарын үсэг зурна.

14.12.2. анхаарамж олгох өртөөний жижүүр нь бичгэн захиалгыг хүлээн авч анхаарамжийн дэвтэрт бичиж гарын үсэг зурна.



14.12.3. анхаарамж олгох захиалгыг факсаар явуулахын өмнө тухайн хүлээн авагчид урьдчилан мэдэгдсэний дараа факсыг илгээнэ. Хүлээн авсан эсэхийг магадлана.

14.13. Зам, хиймэл төхөөрөмж, байгууламжид үүссэн хөдөлгөөний аюулгүй ажиллагаанд аюул учруулж болохуйц гэмтлийг арилгах ажлыг тухайн газрыг Дохиолол холбооны журмын дагуу бүрэн хамгаалсны дараа хийнэ.

14.14. Анхаарамж олгох тухай захиалгад бичигдвэл зохих зүйлүүд:

14.14.1. анхаарамж үйлчлэх хоорондын замын километр, зуут, өртөө, зөрлөгийн нэр зам ба сумын дугаар;

14.14.2. галт тэрэгний хөдөлгөөний үед сэргийлэх арга хэмжээ;

14.14.3. анхаарамж эхлэх ба дуусах хугацаа;

14.14.4. анхаарамж олгох болсон шалтгаан.

14.15. Өртөөний жижүүр бүх анхаарамж, анхаарамжийн захиалга ба үйлчлэх хугацааг анхаарамжийн дэвтэрт бичиж дугаарлана. Анхаарамж тогтоосон хоорондын замын хязгаарлагч өртөөдийн жижүүр захиалга хүлээн авсан тухай галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид илтгэнэ.

14.16. Анхаарамжийн дугаарлалтыг сар бүрийн эхний хоногийн 00:00 цагаас 1-ээр эхлэн дугаарлан хөтлөнө. Сар бүрийн эхний хоногийн 00 цагаар хүчинтэй байгаа бүх анхаарамжийг шилжүүлэн бичнэ. Дэвтэр дэх бүх бичлэгийг техник захирамжийн актанд заасан ажилтан хийж болох бөгөөд жижүүр хянаж гарын үсэг зурна. Өртөөний дарга түүний орлогч анхаарамжийн дэвтрийг тогтмол шалгаж байна.


14.17. Хэсгийн ба техникийн өртөөдөөс явах бүх галт тэргэнд өгөгдсөн анхаарамжийг олгоно.

14.18. Галт тэргэнд анхаарамж олгодог өртөөдийн жагсаалтыг суурь бүтэц эзэмшигч тогтооно. Өртөөдөд зэргэлдээ төмөр замын хил залгаа хэсгээс анхаарамж тогтоосон тухай цахилгааныг хаяглаж ирүүлсэн байна.

14.19. Тухайн хэсэгт тогтоосон хурдаар явж чадахгүй онцгой нөхцөл шаардсан ачаатай вагон, хөдлөх бүрэлдэхүүн холбосон галт тэргэнд, найруулсан болон зүтгүүрийн бригад солилцдог өртөөнд анхаарамж олгоно.

14.20. Анхаарамжийг ташуу шар зураастай цагаан өнгийн давхар гардаг тусгай цаасан дээр хэвлэгдсэн маягтанд техник захирамжийн актанд заагдсан ажилтан бичиж өртөөний жижүүр шалгаж гарын үсэг зурна.

14.21. Өртөөний жижүүр, өртөөний техник захирамжийн актанд заасан ажилтан үлдэх хувьд гарын үсэг зуруулж машинчид олгоно. Машинч анхаарамжийн



агуулгатай туслах машинчийг танилцуулах үүрэгтэй. Туслах машинч харилцан хяналт тавьж явахын тулд анхаарамжийн агуулгаас хуулбар хийж авсан байна.

14.22. Олгогдож байгаа анхаарамжийн маягтын дугаар анхаарамжийн дэвтэрт бүртгэгдсэн дугаартай тохирч байна.

14.23. Өртөөний жижүүрээс анхаарамжийн маягтыг урьдчилан бичиж /галт тэрэгний дугаараас бусад/ гарын үсэг зурна.

14.24. Анхаарамжийн маяганд бичигдсэн зүйл нь тодорхой бөгөөд ойлгомжтой байна.

14.25. Анхаарамжийн маяганд явуулах галт тэрэгний дугаарыг машинчид олгохын өмнө бичнэ. Галт тэрэг хос зүтгүүртэй явах үед анхаарамжийг түүчээ зүтгүүрийн машинчид олгоно. Түүчээ зүтгүүрийн машинч нь анхаарамж байгаа тухай хоёрдугаар зүтгүүрийн машинчид мэдэгдэнэ.

14.26. Өртөөний жижүүр галт тэргэнд олгосон анхаарамжийг зүтгүүрийн машинчтай тулгаж шалгана.

14.27. Галт тэрэг түлхэгч зүтгүүртэй яваа үед анхаарамжийг түүчээ ба түлхэгч зүтгүүрийн машинчид олгоно. Хот дүүргийн, зөөврийн, дамжуулах галт тэрэг болон түлхэгч зүтгүүрт анхаарамж олгох журмыг суурь бүтэц эзэмшигч тогтооно.


14.28. Анхаарамж олгогдсон анхны галт тэрэгний дугаарыг олгосон өртөөний жижүүр галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэнэ. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмаг дээр тэмдэглэнэ.

14.29. Анхаарамж тогтоосон хоорондын замыг хязгаарлагч өртөөний жижүүр хүчинтэй хугацаа эхлэхээс өмнө галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчаас галт тэрэгний машинчид анхаарамж олгогдсон эсэхийг тодруулна. Галт тэргэнд анхаарамж олгогдоогүй бол олгохоор зогсооно. Урьдчилан төлөвлөгдөөгүй анхаарамж гарч ирсэн үед энэхүү журмын 14.10-т зааснаар анхаарамж олгоно.

14.30. Анхаарамж өөрчлөх хүртэл гэж тогтоогдсон бол хүчингүй болгосон тухай мэдэгдэл хүлээн автал галт тэргэнд олгогдоно. Тодорхой хугацаатай тогтоогдсон анхаарамжийг дурдсан хугацаанд галт тэргэнд олгоно. Ийм анхаарамжийг хүчингүй болгох тухай мэдэгдэл өгөгддөггүй. Ажил удирдагчаас анхаарамжийн хугацааг сунгах шаардлагатай болсон тухай мэдэгдэл хүлээн аваагүй бол анхаарамжийг галт тэргэнд олгохыг зогсооно.

14.31. Ажил удирдагч анхаарамжинд заагдсан ажлаа хугацаанд нь дуусгаж чадаагүй бол хугацаа дуусахаас өмнө ажил удирдагч өөрөө хоорондын замын хязгаарлагч өртөөдийн жижүүрт анхаарамж сунгах захиалгыг шинээр өгнө.

14.32. Өртөөний жижүүр захиалга хүлээн аваад галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэх бөгөөд ямар галт тэргэнд анхаарамж олгогдоогүйг



тодруулж, нэмэгдэл захиалганд заагдсан хугацааг дуусах хүртэл анхаарамжийг олгоно.

14.33. Өөрчлөх хүртэл хүчин төгөлдөр тогтоосон анхаарамжийг зөвхөн түүнийг тогтоосон ажилтан, шууд удирдах дарга хүчингүй болгох эрхийг эдлэнэ. Анхаарамж тогтоодог албан тушаалтан нь зохих ажлыг гүйцэтгэсний дараа тогтоосон анхаарамжийг хүчингүй болгох буюу анхаарамжаар тогтоосон галт тэрэгний хөдөлгөөний хурдыг нэмэгдүүлэхийг өөрийн удирдлаганд байдаг салбар нэгжийн даргад даалган өгч болно. Ийм даалгаврын тухай анхаарамж олгох захиалгад заасан байна.

14.34. Өөрчлөх хүртэл хүчин төгөлдөр тогтоосон анхаарамжинд заасан шалтгааныг арилгамагц анхаарамж тогтоосон ажилтан анхаарамж олгосон хаягаар цахилгаан өгч өөрчилнө. Анхаарамжийг буулгахдаа тухайн захиалга өгсөн ажилтан хүчингүй болгож болно.


14.35. Өртөөний жижүүр, анхаарамжийг хүчингүй болгосон тухайн мэдэгдлийг аваад анхаарамжийн дэвтэрт байгаа тэмдэглэлийн эсрэг талд хэнээс хэдийд /цаг, минут ба өдөр/ ирснийг зааж бичнэ. Анхаарамжийг хүчингүй болгосон, хугацаанаасаа өмнө буусан тухай мэдэгдлийг хүлээн авсан өртөөний жижүүр галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэнэ.

14.36. Галт тэрэгний зүтгүүрийн машинч хэсгээр явах үедээ олгогдсон анхаарамжийг баримталж, тавигдсан зөөврийн дохионы шаардлагыг биелүүлнэ.

14.37. Анхаарамжинд заасан хугацаанаас өмнө буюу хойно ажил хийж байсан газраар өнгөрөх үед зам дээр зогсоох буюу хурд бууруулах дохио байхгүй бол галт тэрэгний явах хурдыг бууруулахгүй.

14.38. Хоорондын замын байгууламж, төхөөрөмжинд гэмтэл гарсныг илрүүлсэн тухай мэдэгдлийг хүлээж авсан өртөөний жижүүр нь төхөөрөмжийг үйлчлэх ажилтанд /замын мастер, цахилгаан механикч, эрчим хүчний хэсгийн мастер/ даруй мэдэгдэнэ. Хоорондын замаар явж байгаа зүтгүүрийн машинч гэмтлийг илрүүлбэл хурдаа бууруулах, шаардлагатай бол галт тэргийг зогсоох ба ойролцоо өртөөний жижүүр буюу галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид гэмтэл саатлын байдал ба илрүүлсэн газар /километр, зуут/-ыг зааж мэдэгдэнэ.

14.39. Хүлээж авсан /машинчаас буюу өөр хүнээс/ мэдэгдэл нь галт тэрэгний хэвийн хөдөлгөөнд нөлөөлөх саад тотгортой байгааг гэрчилж байвал өртөөний жижүүр хоорондын замд явж байгаа галт тэрэгний машинчид заагдсан мэдэгдлийг дамжуулна. Мэдэгдлийн шинж байдал нь галт тэрэгний хөдөлгөөнийг явуулах боломжгүй байвал уг саад тотгорыг арилгасан тухай мэдэгдэл хүлээн авах хүртэл хөдөлгөөнийг зогсоох эрхтэй. Өртөөний жижүүр хоорондын зам хаах тухай тушаалыг хүлээлгүйгээр зэргэлдээ өртөөний жижүүрт хоорондын замд галт тэрэг явуулахгүй байхыг мэдэгдэнэ.



14.40. Хоорондын замд яваа галт тэрэгний машинч нь хүлээн авсан мэдэгдлээс хамааран аюултай газраар онц сонор сэрэмжтэй, бууруулсан хурдтай зогсоход бэлэн явах ба шаардлагатай тохиолдолд галт тэргийг зогсооно.

14.41. Саад тотгорыг арилгасаны дараа хөдөлгөөнийг сэргээж болно.

14.42. Хөдөлгөөний хэвийн ажиллагаанд нөлөөлөх саад тотгортой хоорондын замаас мэдэгдэл хүлээж аваад анхны галт тэргийг зөвхөн замын мастер, түүний эзгүйд замын бригадын даргыг дагуулан явуулж болно. Энэ галт тэрэгний машинчид гэмтлийг илрүүлсэн газраас нэг километрийн зайтай дөхөж зогсох бичгэн анхаарамж олгоно. Галт тэрэг дагалдагч ажилтан дараачийн галт тэрэг өнгөрүүлэх дэглэмийг тогтоох бөгөөд галт тэргэнд анхаарамж олгох захиалгыг өгнө.

14.43. Суурь бүтэц эзэмшигчийн тушаалаар олгогдох анхаарамж нь зохих салбар, аж ахуйн нэгжийн дарга нарт хаяглагдах ба анхаарамж тогтоосон хэсгийн галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч, зааварлагч машинч, машинч, өртөөний жижүүр, замын мастер, бригадын дарга нарт мэдэгдэж гарын үсэг зуруулна.

14.44. Тушаал нь өртөөний жижүүр, зүтгүүрийн депогийн ажлын байранд байх ба анхаарамжийн дэвтэрт хавсрагдсан байна. Депогийн дарга тушаал хүлээж авмагц 3 хоногийн дотор зүтгүүрийн бригадад суурь бүтэц эзэмшигчийн тушаалыг танилцуулах ба энэ тухай анхаарамж олгох өртөөдийн дарга нарт мэдэгдэнэ. Үүний дараа галт тэргэнд бичгэн анхаарамж олгохгүй байж болно.

14.45. Аадар бороо орж байгаа үед анхаарамж ба дохио байгааг үл харгалзан суурь бүтэц эзэмшигчийн тушаалаар заасан газраар өнгөрөхдөө зүтгүүрийн бригад нь онцгой сонор сэрэмжтэй явах ба шаардлагатай үед хурдаа бууруулж зогсоход бэлэн явна.


14.46. Анхаарамжийн үйлчлэх хугацааг галт тэрэгний тоогоор тодорхойлсон тохиолдолд гэнэтийн анхаарамжийн нэгэн адил олгох ба галт тэрэгний хөдөлгөөний зохицуулагчийн тушаалд заагдсан тооны галт тэрэг өнгөрсөний дараа хүчингүйд тооцно. Анхаарамжийн маягтыг наймдугаар хавсралтад үзүүлэв.

АРВАНТАВДУГААР БҮЛЭГ

ӨРТӨӨНД ДОХИОЛОЛ, ТӨВЛӨРҮҮЛЭЛТ, ХОРИГЛОЛЫН БАЙГУУЛАМЖИЙН ХЭВИЙН АЖИЛЛАГАА АЛДАГДСАН НӨХЦӨЛД ГАЛТ ТЭРЭГ ХҮЛЭЭЖ АВАХ БА ЯВУУЛАХ

15.1. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжинд гарсан гэмтлийг илрүүлэх үед өртөөний жижүүр Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэрт зохих тэмдэглэл хийх ба гэмтлийн тухай цахилгаан механикчид мэдэгдэнэ.

15.2. Гэмтлийг арилгаж байгууламжийн ажиллагааг байгууламжийн хамаарлын бодит байдалтай тулган шалгаж, Зам, суман шилжүүлэг, дохиолол,



төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэрт цахилгаан механикч зохих бичлэг хийх хүртэл өртөөний жижүүр галт тэрэгний байдлыг үл харгалзан гэмтэлтэй байгууламжийн хяналтын хэрэгслийн заалтыг удирдлага болгон байгууламжийг ашиглахгүй байхыг хатуу анхаарна.

15.3. Дээрх тохиолдолд зам, сумын чөлөөтэйг шалгах, галт тэрэг хүлээж авах, явуулах, замнал бэлтгэх ажиллагааг өртөөний техник захирамжийн актаар тогтооно.

15.4. Гэмтлийн шинж байдлаас хамааран өртөөний жижүүр нь цахилгаан механикч ирэхийг хүлээлгүйгээр дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн хэвийн ажиллагаа алдагдсан шалтгааныг тодруулахын тулд тухайн зам, суманд гадна талын үзлэгийг техник захирамжийн актанд заагдсан албан тушаалтнаар хийлгэнэ. Уг албан тушаалтан дараахь шалгалтыг хийнэ:

15.4.1. зам, сумын тусгаарлагдсан хэсэгт хуурамч эзэлгээтэй заалт гарсан үед зам төмрийн хэлхээний бүрэн бүтэн байдал, бусад зүйлээр холбогдсон эсэх;

15.4.2. тухайн хэсгийн зам төмөр хугарч гэмтсэн эсэх;

15.4.3. сум удирдах пультнээс шилжүүлэгдэхгүй бол шор ба жааз зам төмрийн хооронд ямар нэг зүйл орсон эсэх.

15.5. Гадна талын үзлэгээр байгууламжийн хэвийн ажиллагааг алдагдуулсан шалтгааныг тогтоож арилгасан бол өртөөний жижүүрт байгууламжийн ашиглалтыг сэргээхийг зөвшөөрнө. Байгууламжийн ажиллагааг алдагдуулсан шалтгаан тэдгээрийг арилгасан тухай өртөөний жижүүр Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэрт бичлэгийг хааж тэмдэглэл хийнэ.


15.6. Цахилгаан механикч нь байгууламжийн хэвийн ажиллагаа алдагдсан тухай мэдээ хүлээн аваад дохио ашиглахаар буюу ашиглахгүйгээр гэмтэлтэй байгууламжийг хамаарлаас гаргах шаардлагатай эсэхийг тодорхойлох, энэ тухай зохих бичлэгийг Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэрт бичнэ.

15.7. Цахилгаан механикчийн хатуу анхаарах зүйл:

15.7.1. өртөөний жижүүрийн зөвшөөрөлгүйгээр, Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэрт тэмдэглэл хийхгүйгээр өртөөний дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн гэмтлийг арилгах ажил эхлэх;

15.7.2. ажил нь түр тасалдсан төхөөрөмжийн засвар буюу гэмтлийг арилгаж дуусаад удирдлагын аппарат дээрх хянах хэрэгслийн заалт байгууламжийн бодит байдалтай тохирч байгааг өртөөний жижүүртэй хамтран шалгаж магадлахгүйгээр уг байгууламжийг ажиллагаанд оруулах;

15.7.3. тусгаарлагдсан хэсгийг дохио ашиглахаар хамаарлаас гаргах.



15.8. Төвлөрүүлэгдсэн суман шилжүүлэг, сумын хяналтын цоож, бусад байгууламжийг дохио ашиглахаар хамаарлаас гаргасан үед замналд орсон салгагдсан байгууламжийн бодит байдлыг шалгах ажлыг өртөөний техник захирамжийн актаар тогтоосны дагуу гүйцэтгэнэ. Шалгалтын дараа галт тэрэг хүлээн авах ба явуулах ажиллагааг оруулах ба гаргах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалтаар гүйцэтгэнэ.

15.9. Цахилгаан механикч нь /түлхүүрийн хамааралтай үед монтёр/ дохио ашиглахгүйгээр, дохио ашиглахаар байгууламжийг дараахь хугацаагаар салгах эрхтэй.

15.9.1. өртөөний дарга, дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын хэсгийн инженер буюу дохиолол холбооны засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн удирдлагын зөвшөөрлөөр 8 цаг хүртэл;

15.9.2. хөдөлгөөн хариуцсан салбарын даргын зөвшөөрлөөр 8 цагаас дээш 3 хоног хүртэл;

15.9.3. суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр 3-аас дээш хоногоор.

15.10. Сум, тусгаарлагдсан хэсгийг дохио ашиглахаар хамаарлаас гаргах ажлыг ахлах инженер, ахлах цахилгаан механикчийн хяналтын дор цахилгаан механикч гүйцэтгэнэ.


15.11. Дохио ашиглахаар суман шилжүүлгийг, тусгаарлагдсан хэсгийг хамаарлаас гаргах тохиолдол бүрт цахилгаан механикч нь өртөөний жижүүртэй хамтран хянах хэрэгслээр салгагдсан сум мөн болохыг магадлан Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэрт бичлэг хийж шалгана.

15.12. Дохио ашиглахгүйгээр тусгаарлагдсан хэсэг, төвлөрүүлэгдсэн сум, сумын хяналтын цоож, бусад байгууламжийг салгасан үед галт тэрэг хүлээн авах, явуулах ажиллагааг оруулах, гаргах гэрлэн дохионы хориглосон заалттай үед гүйцэтгэх бөгөөд замналд орсон сум бүрийн зөв тавигдсан байдал, хүлээн авах замын чөлөөтэйг шалгах ажиллагааг өртөөний техник захирамжийн актанд тогтоосноор гүйцэтгэнэ.

15.13. Сум, тусгаарлагдсан хэсгийг хамаарлаас гаргахын өмнө өртөөний жижүүр нь салгасан сум, тусгаарлах хэсэгт орсон сумын бариул /товруу/-д улаан өнгийн хамгаалалтын таг углана.

15.14. Цахилгаан төвлөрүүлэлтийн суман шилжүүлгийг удирдлагын аппаратаас шилжүүлж болохгүй үед тэдгээрийг дохио ашиглахгүйгээр хамаарлаас гаргах ба сум шилжүүлэх түлхүүрийн тусламжтайгаар гараар шилжүүлнэ.

15.15. Сум шилжүүлэх түлхүүрээр сум шилжүүлэх ажиллагааг өртөөний жижүүр өөрөө буюу түүний томилсон хөдөлгөөний ажилтан гүйцэтгэнэ.



15.16. Сум шилжүүлэх түлхүүрээр шилжүүлсэн сумын байдлын хяналт удирдлагын аппарат дээр өгөгдөж байвал өртөөний жижүүр нь замнал зөв бэлтгэгдсэн эсэх, сумыг шилжүүлсэн ажилтны илтгэлээр болон удирдлагын аппаратын хянах хэрэгслийн заалтаар магадлана.

15.17. Сум шилжүүлэх түлхүүрээр шилжүүлсэн сумын байдлын цахилгаан хяналт алдагдвал зохих замналд орсон сумыг зүүдэг цоожоор цоожилно. Түлхүүр нь өртөөний жижүүр буюу түүний томилсон хөдөлгөөний ажилтанд хадгалагдана. Замналд орсон сумын байдал, түгжилтийг өртөөний жижүүр нь томилогдсон ажилтны илтгэлээр магадлана.

15.18. Сумын засвар, гэмтлийн үед шорын хоорондын механик холбоос /шорууд/ салсан сумыг төвлөрүүлэлтээс /хамаарлаас/ гаргана. Харин сумын шор тогтоосон байдалд бэхлэгдэнэ /хадагдана/. Шорыг бэхлэх ажиллагааг өртөөний жижүүрийн захирамжаар замын засвар хариуцсан байгууллагын ажилтан гүйцэтгэх ба Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэрт бичлэг хийнэ.

15.19. Засвар, гэмтэлтэй сумаар галт тэрэг, сэлгээний бүрэлдэхүүн өнгөрүүлэх шаардлага гарвал өртөөний жижүүр нь шорыг бэхэлсэн тухай замын засвар хариуцсан байгууллагын ажилтны мэдэгдлийн дараа замналд орсон сумын байдлын зөв эсэхийг өөрөө буюу томилогдсон ажилтны илтгэлээр магадлана.


15.20. Шорыг шилжүүлэгчээс салгасан үед сумыг зүүдэг цоожоор цоожлох, цоожлогдох боломжгүй үед шахагдсан шорыг хадгуулна.

15.21. Сумын тусгаарлагдсан хэсэг хуурамч эзэлгээтэй үед сумыг туслах товруугаар шилжүүлж болно. Сумыг шилжүүлэх бүрийн өмнө өртөөний жижүүр нь түүнийг хөдлөх бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн болохыг магадлана. Туслах товруугаар шилжүүлсэн сум замналд орсон бол галт тэрэг хүлээн авах ба явуулах ажиллагааг оруулах буюу гаргах гэрлэн дохионы хориглосон заалттай гүйцэтгэнэ.

15.22. Хүлээн авах зам хуурамчаар эзэлгээтэй заагдсан үед өртөөний жижүүр өөрөө буюу техник захирамжийн актанд заасан ажилтнаар дамжуулан хөдлөх бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн эсэхийг магадлах үүрэгтэй. Хуурамч эзэлгээтэй заасан замд галт тэрэг хүлээж авах ажиллагаа нь оруулах гэрлэн дохионы хориглосон заалттай үед гүйцэтгэнэ.

15.23. Өртөөний жижүүр өртөөний зам, сумын тусгаарлагдсан хэсэг эзэлгээтэй үед удирдах аппаратын хянах хэрэгсэл хуурамчаар чөлөөтэй зааж байгааг илрүүлбэл энэ тухай "Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр"-т бичлэг хийж цахилгаан механикчийг дуудна.

15.24. Гэмтлийг арилгатал тухайн зам ба сумнууд /хамгаалах оворгүй хэсгүүдийг оролцуулан /орсон замналыг нэн даруй тодорхойлно. Хуурамчаар чөлөөтэй зааж байгаа сумын тусгаарлагдсан хэсэг хөдлөх бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн эсэхийг өртөөний жижүүр өөрийн биеэр буюу техник захирамжийн



актанд заасан ажилтнаар шалгаж, чөлөөтэй тохиолдолд өртөөний жижүүрт дохио нээхийг зөвшөөрнө.

15.25. Нээлттэй оруулах гэрлэн дохионы зөвшөөрсөн заалт өөрөө хориглосон заалтад шилжвэл өртөөний жижүүр сумын байдал, тусгаарлагдсан хэсэг ба хүлээн авах зам чөлөөтэй эсэхийг магадлах ба үүний дараа оруулах гэрлэн дохиог дахин нээнэ. Оруулах гэрлэн дохио хэвийн нээгдэж байвал түүнийг цаашид ашиглахыг зөвшөөрнө. Дохио өөрөө хаагдсан тухай өртөөний жижүүр “Зам, суман шилжүүлэг, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбооны байгууламжийн үзлэгийн дэвтэр”-т бичлэг хийж цахилгаан механикчид мэдэгдэнэ.

15.26. Оруулах гэрлэн дохио өөрөө хаагдсаны дараа сумын байдал зөв, тусгаарлагдсан хэсэг, хүлээн авах зам чөлөөтэй байхад /удирдлагын аппаратын хянах хэрэгслийн заалтаар шалгахад/ гэрлэн дохио дахин нээгдэхгүй байвал гэмтлийг илрүүлэх болон арилгатал энэхүү журмын 11.33-11.34-т заасны дагуу замналыг шалгаж галт тэргийг хүлээж авна.

15.27. Гаргах гэрлэн дохио өөрөө хаагдсан үед өртөөний жижүүр энэхүү журмын 4.15-4.16-д заасан шаардлагыг удирдлага болгоно.

15.28. Түлхүүрийн хамаарлаар тоноглогдсон сумын хяналтын цоож гэмтэлтэй үед цахилгаан механикч ба монтер нь засварлахын тулд авсан бол /дохио ашиглахаар/ түлхүүрийг сумчинд дамжуулна. Галт тэрэг хүлээн авах, явуулах замналд орсон сумыг зохих байдалд тавьсны дараа зүүдэг цоожоор цоожлоно. Замнал бэлэн болсон тухай өртөөний жижүүрт сумчин илтгэсний дараа хяналтын цоожны түлхүүрийг өртөөний жижүүрийн заалтаар постон дахь гүйцэтгэх аппаратад замналыг түгжихийн тулд хийнэ.


15.29. Цахилгаан төвлөрүүлэлтээр тоноглогдсон өртөөний оруулах гэрлэн дохио хориглосон заалттай үед өртөөний жижүүр нь урих дохионы товруу дарж, галт тэрэг хүлээж авах, хориглосон заалттай гаргах дохиогоор галт тэрэг явуулах зөвшөөрөл олгохоос өмнө доорх үүргийг гүйцэтгэнэ.

15.29.1. замналд орсон сумын байрлалд тохирсон байдалд сумын бариулыг /товруу/ тавих ба хянах хэрэгслээр тогтоосон замналын зөв эсэхийг магадлах, замналд орсон бүх сумын бариулд /товруу/ улаан таг углах;

15.29.2. замналд орсон сумын байдлыг шалгасны дараа галт тэрэг явах замналын дагуу зам, сумын тусгаарлагдсан хэсэг чөлөөтэй эсэхийг өртөөний жижүүр өөрөө буюу томилогдсон ажилтан магадлана;

15.29.3. галт тэргийг урих дохиогоор хүлээн авахад сэлгээний дохиог нээж замналыг түгжинэ. Сэлгээний дохиогоор тоноглогдоогүй өртөө, зөрлөгт галт тэргийг урих дохиогоор авахын өмнө замналд орсон сумыг зүүдэг цоожоор цоожилно.

15.30. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламж гэмтэлтэй, үзлэг засвар хийх үед байгууламжийг хамаарлаас гаргах, оруулах ажлыг суурь бүтэц эзэмшигчээс тогтоосон Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн



засвар, техникийн үйлчилгээний ажлыг гүйцэтгэх үед галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зааварт заасны дагуу гүйцэтгэнэ.

АРВАНЗУРГАДУГААР БҮЛЭГ

ОНЦГОЙ БОЛГООМЖ ШААРДСАН АЧААТАЙ ВАГОН БА ТУСГАЙ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ГАЛТ ТЭРГЭНД БАЙРЛУУЛАХ

16.1. Онцгой болгоомж шаардсан ачаатай вагон бүрийг галт тэргэнд холбохдоо зүтгүүр, хүн суулгасан вагоноос хооронд нь халхлалт хийнэ. Халхлах вагоны тоо, мөн тухайн ачааны үндсэн шинж чанарыг тодорхойлсон мэдээг ачааны бичиг баримтанд ачаа илгээгч заана.

16.2. Онцгой болгоомж шаардсан ачааг тээвэрлэх нөхцөлийн тухай мэдээ болон уг ачааны талаар Төмөр замаар ачаа тээвэрлэх журамд тусгасан байна.

16.3. Хэтрүү оворын VI дүгээр зэрэг, мөн түүнчлэн хэт хэтрүү овортой ачаатай вагоныг галт тэргэнд холбож явуулахад, хяналтын жаазтай вагоныг холбоход замын мастераас доошгүй албан тушаалтай ажилтныг дагалдуулна.

16.4. Замын ажилтан нь галт тэрэгний хөдөлгөөний үед хяналтын жаазын өнгөрөлтийн байдалд ажиглалт хийнэ.

16.5. Хяналтын жаазтай вагон нь зүтгүүрийн ард, хэтрүү овор нь VI дугаар зэрэглэлтэй ба хэт хэтрүү овортой ачаатай вагон галт тэрэгний дунд хяналтын жаазтай вагоноос 35-аас цөөнгүй вагоны цаана ба галт тэрэгний сүүлээс нэгээс доошгүй вагоны өмнө явна.

16.6. Хэтрүү овор нь IV дүгээр зэрэгтэй, мөн үүнээс дээш зэрэгтэй хэтрүү овортой ачаатай вагоныг урт бүрэлдэхүүнтэй галт тэргэнд холбохгүй байхыг хатуу анхаарна.


16.7. Найм ба түүнээс дээш голтой хоосон транспортерыг 3000 тонноос илүү жинтэй галт тэргэнд тэдгээрийг явуулах үед галт тэрэгний бүрэлдэхүүний сүүлийн 1/4 хэсэгт тавихыг зөвшөөрнө.

16.8. Галт тэрэгний жин нь 3000 тонноос бага үед заагдсан транспортерыг галт тэрэгний бүрэлдэхүүний аль ч хэсэгт тавьж болно.

16.9. Ачааны галт тэргэнд шаардлагатай үед зорчигчийн нэг буюу бүлэг вагоныг аль ч хэсэгт холбож болох бөгөөд галт тэрэгний жин нь 3000 тонноос бага бол зорчигчийн вагоныг зүтгүүрийн ард холбоно.

16.10. Зорчигчийн вагоныг ачааны галт тэрэгний дунд хэсэгт холбосон тохиолдолд тухайн вагоноос хойших хэсгийн жин нь 3000 тонноос ихгүй байна.

16.11. Зорчигчийн вагоныг ачааны галт тэргэнд холбосон тохиолдолд зохих халхлалтыг хийнэ.



16.12. Зам засварын ажилд ашигладаг технологийн зориулалттай тусгай хөдлөх бүрэлдэхүүнийг галт тэргэнд байрлуулах, тээвэрлэх, ашиглах зааврыг үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн паспортоор тогтооно.

16.13. Хоппер-тугнуурыг төмөр замаар зөвхөн үйлчлэгч бригадын хүмүүсийн амрах байрын хамтаар эргэх бүрэлдэхүүнээр тогтмол явуулахыг зөвшөөрнө.

16.14. Тогтмол явах эргэх бүрэлдэхүүнд байгаа хоосон ба ачаатай хоппер тугнуур нь галт тэрэгний тогтоосон урт ба жингээс бага тохиолдолд эдгээрийг ганцаар буюу бүлгээр нь /хоппер-тугнуурыг уг эргэх бүрэлдэхүүнээс салгахгүйгээр/ галт тэрэгний бүрэлдэхүүнд галт тэрэг найруулах төлөвлөгөөний дагуу нэмж болно.

16.15. Хөдөлгөөний зөвшөөрөгдсөн хурдтай эргэх бүрэлдэхүүнийг явуулах үед механик нь хоппер-тугнуурын буулгах, тугнах, төхөөрөмжийг шалгасан, тээвэрлэлтийн байдалд бүрэн оруулж үзлэг шалгалт хийсэн тухай ачааны бичиг баримтанд тэмдэглэл хийсэн байна. Энэхүү тэмдэглэлийг эргэх бүрэлдэхүүн ачаатай явж байгаа бол падаан дээр, хоосон явж байгаа бол илгээх хүснэгтийн ар талд хийнэ.

16.16. Хоппер-тугнуурын тугнах төхөөрөмжийн техникийн арчилгаа үйлчилгээг механикчийн бригад хийнэ. Вагоны техник үзлэг засварыг техник үйлчилгээний газрын ажилтан гүйцэтгэнэ.

16.17. Хоппер-тугнуурыг явуулахын өмнө илгээгч тэдгээрийг тээвэрлэлтийн бүрэн байдалд оруулж явуулахад бэлэн болсон ба хөдөлгөөний зөвшөөрөгдсөн хурдын тухай явуулах өртөөн дээр зохих тэмдэглэлийг илгээх бичиг баримт дээр хийсэн байна. Хоппер-тугнуурыг засварт явуулахын өмнө механик ачааг буулгасан ба түүний дараа тээвэрлэлтийн байдалд бэлтгэсэн байна.

16.18. Төмөр замын краныг галт тэргэнд холбохын өмнө ачаа илгээгч кранд байвал зохих үйлдвэрлэгчийн паспорт буюу зарим төрлийн краны тусгай зааврыг бүрдүүлнэ.

16.19. Краныг галт тэргэнд явуулахад бэлэн болсныг суурь бүтэц эзэмшигчийн томилсон комисс шалгана.

16.20. Краныг галт тэргэнд холбож явуулахдаа краны ашиглалтын тусгай заавар буюу явуулах бэлтгэлийг шалгасан комиссын актанд заасны дагуу гүйцэтгэнэ.

16.21. 6 тонноос 8.5 тоннын даацтай төмөр замын краныг галт тэрэгний сүүлийн 1/3 дэх хэсэгт байрлуулна.

16.22. Ачааны галт тэрэгний тогтоосон хурдаас бага хурдаар краныг явуулах, өнгөрүүлэх шаардлагатай үед өөрийн замын хил дотор явуулах тусгай зөвшөөрлийг суурь бүтэц эзэмшигч өгнө. Зөвшөөрлийн хуулбарыг краны тээвэрлэлтийн бичиг баримтад хавсаргасан байна.



16.23. Краныг ажилгүй байдлаар 10 хүртэл тоогоор нэгтгэн тусгай зүтгүүртэй илгээж болно. Краныг нэгтгэн явуулах бэлтгэлийг галт тэргэнд явуулахтай нэгэн адилаар гүйцэтгэнэ.

16.24. Ажиллагаагүй байдалд байгаа зүтгүүрийг тэдгээрийн техникийн байдлыг шалгасан тухай акт тавьсны дараа зүтгүүрийн депогийн даргын захиалгаар явуулна. Явуулах өртөөний даргад захиалгыг актын хамт өгнө. Актанд зүтгүүрийн явах зөвшөөрөгдсөн хурд заагдсан байна. Актын хоёрдугаар хувийг зүтгүүрийн хүргэгчид гардуулна.

16.25. Ажиллагаагүй байдалтай явуулах илчит тэргийг ачааны галт тэргэнд түүчээ зүтгүүрийн ард хоёр секцтэй бол 1, нэг секцтэй бол 2-оос илүүгүйг холбоно.

16.26. Олон тооны зүтгүүрийг явуулах, мөн түүнчлэн үйлдвэрлэсэн үйлдвэрээс ирүүлэх үед нэг бүрэлдэхүүнд таваас илүүгүйг нэгтгэж явуулахыг зөвшөөрнө. /түүчээ зүтгүүрийг тоолохгүйгээр/. Өгөгдсөн хэсгээр аялахад сери нь тохирч байвал эдгээр зүтгүүрийн аль нэг нь түүчээ зүтгүүр байж болно.


16.27. Хүнд маягийн замын машиныг тээвэрлэх нөхцөлийг /зам тавих машин, буталмал чулуу цэвэрлэгч, цас цэвэрлэгч/ замын ажил гүйцэтгэх үеийн галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зааварт заасан байна. Замын машиныг галт тэргэнд буюу тусгай зүтгүүртэй явуулахад бэлэн болсныг суурь бүтэц эзэмшигчээс томилсон комисс шалгана. Эдгээр машиныг илгээх үед механик нь туслахын хамт дагалдана.

16.28. Хөдлөгч цахилгаан-төхөөрөмж, эрчим хүчний галт тэрэг буюу тусгай нэгжийг краны нэгэн адил явуулна.

16.29. Хагас ачаатай цистерн вагоныг галт тэрэгний сүүлд холбож 50 км/цагаас ихгүй хурдтай явуулна.

--- о О о ---





Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
..... дүгээр тушаалын Галт тэрэгний хөдөлгөөний
удирдлагын журмын нэгдүгээр хавсралт

ӨРТӨӨНИЙ ЖИЖҮҮРИЙН БҮРТГЭЛТ ТУШААЛЫН ЗАГВАР

Огноо Дугаар

..... өртөөний дугаар замаас шалтгаанаар гаргах /замналын/ дохио унтарсан /унтраасан/ хоорондын зам эзлэгдсэн Галт тэрэг явуулах өртөөнд хориг дохионы хяналтын гэрэл /Тэгш чиглэлд явуулах (ЧО), Сондгой чиглэлд явуулах (НО) / ассан. Хүрэх өртөөнд хориг дохионы хяналтын гэрэл /Тэгш чиглэлээс ирэх (ЧП), Сондгой чиглэлээс ирэх (НП) ассан. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч (ДНЦ) тоот тушаалыг үндэслэн ... дугаар замаас ... дугаар галт тэргийг хориглосон заалттай дохио өнгөрч яв. Замналыг аргаар түгжсэн. /шаардлагагүйг дар/

Тушаал өгсөн: Өртөөний жижүүр /ДСП/

Тушаал авсан Зүтгүүрийн машинч /ТЧМ/

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАГЧИЙН ТУШААЛЫН ЗАГВАР

Огноо: Дугаар

..... өртөөний жижүүр -ийн мэдэгдлээр дугаар замаас явуулахаар нээсэн дугаар дохио шалтгаанаар унтарсан /унтраасан/ галт тэрэг явуулах..... өртөөний пультэнд хориг дохионы хяналтын гэрэл /Тэгш чиглэлд явуулах (ЧО), Сондгой чиглэлд явуулах (НО), хүрэх өртөөний пультэнд хориг дохионы хяналтын гэрэл /Тэгш чиглэлээс ирэх (ЧП), Сондгой чиглэлээс ирэх (НП) асч хоорондын зам эзлэгдсэн өртөөний жижүүр-ийн мэдэгдлээр дугаар замаас гаргах замналыг аргаар түгжсэн тухай илтгэлийг үндэслэж дугаар галт тэргийг өртөөний жижүүрийн бүртгэлт тушаал дугаар замаас явуул. /шаардлагагүйг дар/

Өгсөн Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч /ДНЦ/:

Авсан Өртөөний жижүүр /ДСП./:





Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дүгээр тушаалын Галт тэрэгний хөдөлгөөний
удирдлагын журмын хоёрдугаар хавсралт

ӨРТӨӨНИЙ ЖИЖҮҮРИЙН БҮРТГЭЛТ ТУШААЛЫН ЗАГВАР

Огноо Дугаар

..... өртөөний дугаар замаас шалтгаанаар гаргах /замналын/ дохио унтарсан /унтраасан/ хоорондын зам эзлэгдсэн галт тэрэг явуулах өртөөнд хориг дохионы хяналтын гэрэл Галт тэрэг явуулах зам /ПО/ ассан. Хүрэх өртөөнд хориг дохионы хяналтын гэрэл Галт тэрэг ирүүлэх зам /ПП/ ассан. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч /ДНЦ/ тоот тушаалыг үндэслэн ... дугаар замаас ... дугаар галт тэргийг хориглосон заалттай дохио өнгөрч яв. Замналыг аргаар түгжсэн. /шаардлагагүйг дар/

Тушаал өгсөн Өртөөний жижүүр /ДСП/.....

Тушаал авсан Зүтгүүрийн машинч /ТЧМ/.....


ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАГЧИЙН ТУШААЛЫН ЗАГВАР

Огноо Дугаар

..... өртөөний жижүүр -ийн мэдэгдлээр дугаар замаас явуулахаар нээсэн ... дугаар дохио шалтгаанаар унтарсан /унтраасан/ галт тэрэг явуулах..... өртөөний пультэнд хориг дохионы хяналтын гэрэл Галт тэрэг явуулах зам /ПО/ хүрэх өртөөний пультэнд хориг дохионы хяналтын гэрэл Галт тэрэг ирүүлэх зам /ПП/ асч хоорондын зам эзлэгдсэн Өртөөний жижүүр-ийн мэдэгдлээр дугаар замаас гаргах замналыг аргаар түгжсэн тухай илтгэлийг үндэслэж дугаар галт тэргийгөртөөний жижүүрийн бүртгэлт тушаал дугаар замаас явуул. /шаардлагагүйг дар/

Өгсөн Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч /ДНЦ/:

Авсан Өртөөний жижүүр /ДСП/:







Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дүгээр тушаалын Галт тэрэгний хөдөлгөөний
удирдлагын журмын гуравдугаар хавсралт

ЗАМЫН УТСАН МЭДЭЭНИЙ МАЯГТ

<p>Замын утсан мэдээний үлдэх хувь № /сондгой талын галт тэргэнд/ Өртөө /тэмдэг/ 20..... оны-р сарын-ны өдрөөс-аас № цаг минут</p> <p>Өртөөний жижүүр Зүтгүүрийн машинчгарын үсэг /цагаан өнгөтэй/</p>	<p>Машинчид Замын утсан мэдээ № /сондгой талын галт тэргэнд/ Өртөө /тэмдэг/ 20..... оны-р сарын-ны өдрөөс-аас № цаг минут</p> <p>Өртөөний жижүүр Зүтгүүрийн машинчгарын үсэг</p>
---	---

<p>Замын утсан мэдээний үлдэх хувь № /тэгш талын галт тэргэнд/ Өртөө /тэмдэг/ 20..... оны-р сарын-ны өдрөөс-аас № цаг минут</p> <p>Өртөөний жижүүр Зүтгүүрийн машинчгарын үсэг /цайвар хөх өнгөтэй/</p>	<p>Машинчид Замын утсан мэдээ № /тэгш талын галт тэргэнд/ Өртөө /тэмдэг/ 20..... оны-р сарын-ны өдрөөс-аас № цаг минут</p> <p>Өртөөний жижүүр Зүтгүүрийн машинчгарын үсэг</p>
--	--





Зам. тээврийн хөгжлийн сайдын
 2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
 дүгээр тушаалын Галт тэрэгний хөдөлгөөний
 удирдлагын журмын дөрөвдүгээр хавсралт

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЕИЙН УТСАН МЭДЭЭНИЙ ЗАГВАРУУД

Галт тэрэг хүлээн авах ба явуулах үед галт тэрэгний утсан мэдээнд дараахь үндсэн загваруудыг хэрэглэнэ.

Явуулах өртөө

1-р загвар

/..... дугаар галт тэргийг явуулж болох уу?/

..... /гарын үсэг/

Хүлээн авах өртөө

2-р загвар

/..... дугаар галт тэргийг хүлээе/

..... /гарын үсэг/

3-р загвар

..... дугаар галт тэрэгцаг.....минутанд явлаа.

..... /гарын үсэг/

4-р загвар

.....дугаар галт тэрэгцаг.....минутанд ирлээ.

..... /гарын үсэг/


Тайлбар: Энэ загварын дугаар нь нэвтрүүлэх ярианы загварын дугаарт хамаарахгүй.

Явуулсан өртөөнд буцаж ирэх галт тэрэг явуулах үед галт тэрэгний утсан мэдээ нэвтрүүлэх горимыг доорх байдлаар мөрдөнө.

5 дугаар загвар

..... дугаар галт тэргийг дугаар километр хүрээд буцахаар явуулж болох уу? /гарын үсэг /

6 дугаар загвар



..... дугаар галт тэргийг дугаар километр хүртэл явуулаад буцааж болно. / гарын үсэг/

Галт тэрэг явуулсан тухай мэдэгдлийг 3 дугаар загвараар, харин түүний буцаж ирсэн тухайг 7 дугаар загвараар нэвтрүүлнэ.

7 дугаар загвар

..... дугаар галт тэрэг цаг минутанд буцаж ирлээ. /гарын үсэг/

Явуулсан өртөөндөө түлхэгч зүтгүүр нь хоорондын замаас буцаж ирэх галт тэрэг явуулах үед:

8 дугаар загвар

..... дугаар галт тэргийг дугаар километрээс буцаж ирэх түлхэгчтэй явуулж болох уу? /гарын үсэг/

9 дүгээр загвар


..... дугаар галт тэргийг дугаар километрээс буцаж ирэх түлхэгчтэй хүлээе. /гарын үсэг/


Галт тэрэг явуулсан тухай мэдэгдлийг 3 дугаар загвараар “..... дугаар километрээс буцаж ирэх түлхэгчтэй” гэсэн үгнүүд нэмж дамжуулна.

Галт тэрэг ирсэн мэдэгдлийг 4 дүгээр загвараар, түлхэгч буцаж ирсэн тухай 10 дугаар загвараар нэвтрүүлнэ.

10 дугаар загвар

..... дугаар галт тэрэгний түлхэгч цаг минутанд буцаж ирлээ. /гарын үсэг/





Зам, тээврийн хөгжлийн сайдын
 2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
 дүгээр тушаалын Галт тэрэгний хөдөлгөөний
 удирдлагын журмын тавдугаар хавсралт

**ӨРТӨӨ ХООРОНДЫН ХОЛБООГ ТАСЛАХГҮЙН ТУЛ МАШИНЧААР
 БИЧГЭН МЭДЭЭ ДАМЖУУЛАХ ЗАГВАР**

Өртөө хоорондын холбоог таслахгүйн тул өртөөний жижүүрүүд байгууламжийн ажиллагааг сэргээх хүртэл аль аль чиглэлд явж байгаа галт тэрэг бүрийн түүчээ зүтгүүрийн машинчаар галт тэрэг хэрхэн явуулж байх тухай бичгэн мэдээг “А” буюу “Б” маягтаар илгээнэ.

БИЧГЭН МЭДЭЭ


Мэдээний үлдэх хувь №	Мэдээ №
Өртөө /тэмдэг/	Өртөө /тэмдэг/
20 оны сарын-ны өдөр	20 оны сарын-ны өдөр
Дохиолол холбооны бүх хэрэгсэл тасарсан үеийн галт тэрэгний хөдөлгөөний тухай	№ цаг.....минут.....
Өртөөний жижүүр-нд	Өртөөний жижүүр-нд
Өртөөний жижүүр	Өртөөний жижүүр
Хүлээж авсан машинч	/цагаан өнгөтэй/


Албан яриа баримтжуулан бичих төхөөрөмжинд холбогдсон суурин утасны мэдэгдэл

Зөвшөөрлийн үлдэх хувь №	Машинчид Зөвшөөрөл №
20 оны сарын-ны өдөр	20 оны сарын-ны өдөр
Өртөө /тэмдэг/	Өртөө /тэмдэг/
..... дугаар галт тэргэнд дугаар галт тэргэнд
өртөөнөөс хаалттай /постоос/ гаргах дохиогоор	өртөөнөөс хаалттай /постоос/ гаргах дохиогоор
..... өртөөний оруулах дохио хүртэл /постын/ явахыг зөвшөөрнө. Дохиолол холбооны бүх хэрэгсэл тасарсан. өртөөний оруулах дохио хүртэл /постын/ явахыг зөвшөөрнө. Дохиолол холбооны бүх хэрэгсэл тасарсан.



Анхаарамж	Анхаарамж
Таны өмнө цаг минутанд галт тэрэг явуулсан. өртөөнд хүрсэн тухай мэдээ	Таны өмнө цаг минутанд галт тэрэг явуулсан. өртөөнд хүрсэн тухай мэдээ
Бий	Бий
Үгүй	Үгүй
Өртөөний жижүүр	Өртөөний жижүүр
Постын	Постын
Хүлээж авсан машинч /хэрэггүй зүйлийг дарна/ /цагаан өнгөтэй, улаан бичигтэй/	






Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дүгээр тушаалын Галт тэрэгний хөдөлгөөний
удирдлагын журмын зургадугаар хавсралт


Галт тэргийг зайлшгүй ухраах нөхцөл

Явуулж байгаа галт тэрэгний сүүл өртөөний хязгаараас гараагүй зогссон тохиолдолд галт тэргийг зайлшгүй ухраах шаардлагатай бол энэхүү журмын 13 дугаар бүлэг /Өртөөнд хийгдэх сэлгээний ажил/-т заасны дагуу өртөөний жижүүрийн захирамжаар гүйцэтгэнэ.

Өртөөний жижүүрийн захирамж

Зөвшөөрлийн үлдэх хувь №	Машинчид Зөвшөөрөл №
Өртөө /тэмдэг/	Өртөө /тэмдэг/
20.... оны сарын-ны өдөр	20.... оны сарын-ны өдөр
дугаар зүтгүүрийн галт тэргэнд	дугаар зүтгүүрийн галт тэргэнд
..... хоорондын замд хоорондын замд
..... дугаар км хүртэл дугаар км хүртэл
.....
тулд явуулахыг зөвшөөрөв. Энэ явах зөвшөөрөл нь өртөөний хориглосон заалттай гаргах дохиог өнгөрөх эрхийг олгоно.	тулд явуулахыг зөвшөөрөв. Энэ явах зөвшөөрөл нь өртөөний хориглосон заалттай гаргах дохиог өнгөрөх эрхийг олгоно.
Өртөөний жижүүр	Өртөөний жижүүр
/гарын үсэг/	/гарын үсэг/
Хүлээж авсан машинч	Хүлээж авсан машинч
/гарын үсэг/	/гарын үсэг/
<i>/ташуу улаан зураастай, цагаан өнгөтэй/</i>	





Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дүгээр тушаалын Галт тэрэгний хөдөлгөөний
удирдлагын журмын долдугаар хавсралт


БИЛЕТ-ГАЗАРЧ

“Билет-газарч”-ийн зөвшөөрлийг өнгөт металлаар хийнэ. Билет газарчийг цоожтой саванд хадгалах бөгөөд тоог өртөө хоорондын зам тус бүрт тэгш чиглэлд тэгш, сондгой чиглэлд сондгой дугаартай байхаар өртөөний техник захирамжийн актанд тусгаж өгнө.

Билет-газарчийн маягт

<p>БИЛЕТ ГАЗАРЧ № Тэгш чиглэлийн галт тэрэг хүлээн авах замын өртөө Код</p>

<p>БИЛЕТ ГАЗАРЧ № Сондгой чиглэлийн галт тэрэг хүлээн авах замын өртөө Код</p>
--





Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дүгээр тушаалын Галт тэрэгний хөдөлгөөний
удирдлагын журмын наймдугаар хавсралт

АНХААРАМЖИЙН ЗАГВАР

Анхаарамжийн үйлчлэх хугацааг галт тэрэгний тоогоор тодорхойлсон тохиолдолд гэнэтийн анхаарамжийн нэгэн адил олгох ба галт тэрэгний хөдөлгөөний зохицуулагчийн тушаалд заагдсан тооны галт тэрэг өнгөрсөний дараа хүчингүйд тооцно.

Анхаарамжийн загварыг бөглөх

Анхаарамжийн үлдэх хувь №

..... дугаар галт тэргэнд анхаарамж хүлээн авсан оны сарын-ны өдөр. Машинч /туслах машинч/

Өртөө /тэмдэг/

..... оны дугаар сарын-ны өдөр


Анхаарамж
.....-р галт тэрэг


1	2	3	4	5
км-үүд	Анхаарамж хүчинтэй байх хугацаа	Хурд км/цаг-аас ихгүй	Улаан дохионы дэргэд зогсох, харин түүнийг байхгүй бол км/цаг-аас ихгүй хурдтай явах	Галт тэрэг явах бусад онцгой нөхцөлүүд

Өртөөний жижүүр
/ташуу шар зураастай, цагаан өнгийн/

АНХААРАМЖИЙН МАЯГТЫГ БӨГЛӨЖ БИЧИХ ТАЙЛБАР

I багана	-	Дамжуулагдсан анхаарамжийн километр, зуутыг өөрчлөхгүйгээр бичнэ.
II багана	-	Анхаарамжийн хугацааг тэмдэглэнэ. Анхаарамж тодорхой хугацааны дотор хүчинтэй бол цаг хугацааг бичнэ. Жишээ нь: 8-16 гэдэг нь анхаарамж хүчинтэй хугацаа нь 8-аас 16 цаг болохыг заана. Өөрчлөх хүртэл хугацаагаар тогтоосон анхаарамжийн маягтанд “өөрчлөх хүртэл” гэж бичнэ.
III багана	-	Анхаарамжаар тогтоосон хурдыг бичнэ.
IV багана	-	Улаан дохио байх заалттай нөхцөлд улаан дохио, байхгүй үед галт тэрэг тогтоосон хурдаар явахыг зөвшөөрсөн бол “тогтоосон” гэсэн үгээр тэмдэглэл хийнэ. Хурд заасан бол заасан хурдыг бичнэ.
V багана	-	Хэсгээр галт тэрэг явах үед бусад нөхцөлийг тэмдэглэнэ.







Зам, тээврийн хөгжлийн сайдын
 2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
 дүгээр тушаалын Галт тэрэгний хөдөлгөөний
 удирдлагын журмын есдүгээр хавсралт

**ДОХИОЛОЛ ХОЛБООНЫ ТОГТООСОН ХЭРЭГСЛИЙН ҮЕД ӨРТӨӨНӨӨС
 ГАЛТ ТЭРЭГ ЯВУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ЖАГСААЛТ**

Галт тэрэг явуулах үеийн нөхцөлүүд	Хоорондын зам эзлэхэд машинчид олгогдох зөвшөөрлийн хэлбэр	Гаргах дохио нээх буюу хоорондын зам эзлэх зөвшөөрөл олгох үндэс
А. Хагас автомат хориглол		
Тус бүрдээ гаргах дохиотой замаас галт тэрэг явуулах	Гаргах дохионы зөвшөөрсөн заалт	Зэргэлдээ өртөөний зөвшөөрлийн хориг дохио
Гаргах дохио хаагдсаны дараа /өөрөө хаагдсаныг оролцуулан/ саатсан буюу энэ чиглэлд өөр галт тэрэг явуулах	Өртөөний жижүүрийн бүртгэлт тушаал	Зэргэлдээ өртөөний зөвшөөрлийн хориг дохио
Гаргах дохио хаагдсаны дараа эсрэг чиглэлээс галт тэрэг явуулах	Маягтын дээд талд нь "хориглол ажиллахгүй байна" гэсэн тэмдэглэлтэй замын утсан мэдээ	Хориглолыг хаасан ба утсан холбоонд шилжсэн тухай зохицуулагчийн тушаал, зэргэлдээ өртөөнөөс галт тэрэг хүлээн авах зөвшөөрөл бүхий галт тэрэгний утсан мэдээ
Явуулах замын замнал заагчаар тоноглогдсон нэгтгэсэн гэрлэн дохиогоор галт тэрэг явуулах	Замнал заагч дээр явуулах замын дугаарын тоотой /ногоон өнгийн/ гаргах дохионы зөвшөөрсөн заалт	Зэргэлдээ өртөөний зөвшөөрлийн хориг дохио
Нэгтгэсэн гэрлэн дохио дээрх явуулах замын замнал гэмтэлтэй тохиолдолд нэгтгэсэн гэрлэн дохиогоор галт тэрэг явуулах	Өртөөний жижүүрийн бүртгэлт тушаал	Зэргэлдээ өртөөний зөвшөөрлийн хориг дохио
Явуулах галт тэрэгний зүтгүүр нь зөвшөөрсөн заалттай гаргах гэрлэн дохионы цаад талд байгаа бол	Өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар	Зэргэлдээ өртөөний зөвшөөрлийн хориг дохио
Явуулах галт тэрэгний зүтгүүр нь хориглосон заалттай гаргах гэрлэн дохионы цаад талд байгаа бол	Утсан мэдээний маягт	Хориглолыг хаасан ба утсан холбоонд шилжсэн тухай зохицуулагчийн тушаал ба зэргэлдээ өртөөнөөс галт тэрэг




		хүлээн авах зөвшөөрөл бүхий галт тэрэгний утсан мэдээ
Гаргах дохио нээх боломжгүй үед галт тэрэг явуулах	Маягтын дээд талд нь "хориглол ажиллахгүй байна" гэсэн тэмдэглэлтэй замын утсан мэдээ	Хориглолыг хаасан ба утсан холбоонд шилжсэн тухай зохицуулагчийн тушаал ба зэргэлдээ өртөөнөөс авсан галт тэрэг хүлээн авах зөвшөөрөл бүхий галт тэрэгний утсан мэдээ
Хоорондын замаас буцаж ирэх галт тэрэг явуулах	Гаргах дохио хаалттай үед түлхүүр-очир	Зэргэлдээ өртөөний зөвшөөрлийн хориг дохио мөн түүнчлэн буцаж ирэх галт тэрэг явуулах тухай зохицуулагчийн зөвшөөрөл
Хоорондын замын туршид явах түлхэгч зүтгүүртэй галт тэрэг явуулах	Гаргах дохионы зөвшөөрсөн заалт	Зэргэлдээ өртөөний зөвшөөрлийн хориг дохио
Галт тэрэг буюу түлхэгч зүтгүүрт олгох түлхүүр-очир байхгүй буюу байгаа нь гэмтэлтэй бол хоорондын замаас буцаж ирэх галт тэрэг түлхэгчийг явуулахыг зөвхөн холбооны утсан хэрэгсэлд шилжсэний дараа гүйцэтгэнэ.		
Б. Цахилгаан очирын систем		
Цахилгаан очирын систем гэмтэлтэй үед галт тэрэг явуулах	Замын утсан мэдээ	Зэргэлдээ өртөөнөөс авсан утсан мэдээ
Цахилгаан очирын систем хэвийн ажилтай үед	Хоорондын замд хамаарагдах очир	Зэргэлдээ өртөөнөөс очир авах зөвшөөрөл
Хоорондын замаас буцаж ирэх галт тэрэг явуулах	Түлхүүр-очир	Зэргэлдээ өртөөнөөс очир авах зөвшөөрөл
Бүрэлдэхүүнд хоорондын замын туршид явах түлхэгч зүтгүүртэй галт тэрэг явуулах	Хоорондын замд хамаарагдах очир	Зэргэлдээ өртөөнөөс очир авах зөвшөөрөл
а. Салдаг очиртой үед	Очир	Зэргэлдээ өртөөнөөс очир авах зөвшөөрөл
б. Салдаг очир байхгүй үед	Утсан холбооны маягт	Зэргэлдээ өртөөнөөс утсаар авсан зөвшөөрөл
Очирын систем гэмтэлтэй тохиолдолд галт тэрэг явуулах	Замын утсан мэдээ	Зэргэлдээ өртөөнөөс утсаар авсан зөвшөөрөл
В. Өртөө хоорондын хориглол		
Тус бүрдээ гаргах дохиотой замаас галт тэрэг явуулах	Гаргах дохионы зөвшөөрсөн заалт	
Гаргах дохио нээгдсэний дараа гэрлэн дохионы гэрэл шатсан шалтгаанаар хаагдсаны дараа энэ чиглэлд галт тэрэг явуулах	Өртөөний жижүүрийн бүртгэлт тушаал	
Гаргах дохио нээсний дараа замнал өөрчилж галт тэрэг явуулах	Гаргах дохионы зөвшөөрсөн заалт	
Гаргах дохио хаагдсаны дараа эсрэг чиглэлээс галт тэрэг хүлээн авах	Зэргэлдээ өртөөний гаргах дохионы зөвшөөрсөн заалт	




Явуулах галт тэрэгний зүтгүүр нь зөвшөөрсөн заалттай гаргах гэрлэн дохионы цаад талд байгаа бол	Өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар	
Явуулах галт тэрэгний зүтгүүр нь хориглосон заалттай гаргах гэрлэн дохионы цаад талд байгаа бол	Утсан мэдээний маягт	Хориглолыг хаасан ба холбооны утсан хэрэгсэлд шилжсэн тухай зохицуулагчийн тушаал ба зэргэлдээ өртөөнөөс галт тэрэг хүлээн авах зөвшөөрөл бүхий галт тэрэгний утсан мэдээ
Гаргах дохио нээх боломжгүй үед галт тэрэг явуулах	Утсан мэдээний маягт	Хориглолыг хаасан ба холбооны утсан хэрэгсэлд шилжсэн тухай зохицуулагчийн тушаал ба зэргэлдээ өртөөнөөс авсан галт тэрэг хүлээн авах зөвшөөрөл бүхий галт тэрэгний утсан мэдээ
Хоорондын замаас буцаж ирэх галт тэрэг явуулах	Гаргах дохионы зөвшөөрсөн заалт буюу түлхүүр-очир	Буцаж ирэх галт тэрэг явуулах тухай зохицуулагчийн зөвшөөрөл
Хоорондын замаас түлхэгч зүтгүүр буцаж ирэх	Гарах дохионы зөвшөөрсөн заалт	
Хоорондын замын туршид явах түлхэгч зүтгүүртэй галт тэрэг явуулах	Гаргах дохионы зөвшөөрсөн заалт	

Холбооны утсан хэрэгсэл:

Утсан холбоотой үед галт тэргэнд утсан холбооны маягтанд бичигдсэн мэдээ олгогдоно. Хаалттай хоорондын замд сэргээн босгох, галт тэрэг, туслах зүтгүүр, аж ахуйн галт тэрэг ба бусад галт тэрэг явуулах үеийн бүх тохиолдолд ташуу улаан зураастай цагаан өнгийн маягтан дээр бичигдсэн зөвшөөрөл олгоно. Бүх төрлийн холбоо тасарсан үед галт тэргэнд улаанаар бичигдсэн цагаан өнгийн маягтан дээр бичсэн зөвшөөрөл олгоно.





Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 8 дүгээр сарын 14-ны өдрийн
... дүгээр тушаалын Галт тэрэгний хөдөлгөөний
удирдлагын журмын аравдугаар хавсралт

ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТООРМОСНЫ ИВҮҮР, ГАР ТООРМОСОСР БЭХЛЭХ НОРМ

1. Өртөөний зам дээр вагоныг бэхлэхдээ энэхүү журмын 13.12-13.15-д заасан шаардлагатай тооцоот хамгийн бага нормыг удирдлага болгоно.

2. Хэвгийтэй зам дээр ачаатай бүлэг вагоныг бэхлэх тооцоог гаргахдаа дараахь томъёог ашиглан гаргана.

n - голын тоо
 i - хэвгий
2 - тогтмол тоо
200 - тогтмол тоо

Хэвгийн тоон дээр тогтмол 2 гэсэн тоог нэмж нийлбэрийг гарган тухайн зам дээр бэхлэгдэх вагоны голын тоогоор үржүүлж 200 гэсэн тогтмол тоонд хувааж гарна.

Жишээлбэл нь: 25 ачаатай вагоныг 1,5 мянганы хэвгийтэй зам дээр 2 ивүүрээр бэхлэнэ.

$n = 100$
 $i = 1.5$

3. Хэвгийтэй зам дээр хоосон бүлэг вагоныг бэхлэх тооцоог гаргахдаа дараахь томъёог ашиглан гаргана.


n = голын тоо
 i = хэвгий
3 = тогтмол тоо
200 = тогтмол тоо

Хэвгийн тоон дээр 3 гэсэн тогтмол тоог нэмж нийлбэрийг гарган бэхлэгдэх вагоны голын тоогоор үржүүлж 200 гэсэн тогтмол тоонд хувааж гаргана.

Жишээлбэл нь: хоосон 25 вагоныг 1,5 мянганы хэвгийтэй зам дээр 3 ивүүрээр бэхлэнэ.

$n = 100$
 $i = 1.5$

4. Ачаатай бүлэг вагон эсвэл ачаатай ба хоосон вагоноос бүрдсэн бүлэг вагоныг бэхлэхдээ гол тутамд 10 тонноос багагүй даралттай ачаатай вагоны дор тоормосны ивүүр тавина. Хоосон вагон буюу хөнгөн ачаатай / автомашин хоосон



чингэлэг гэх мэт/ вагоны дор тоормосны ивүүрийг ивэхдээ бүлэг хоосон вагоны нормоор ивүүрийн тоог бодож гаргана.

5. Тоормосны ивүүр нь гэмтэлгүй бөгөөд ивүүрийг вагон тус бүрийн эхний тэргэнцэр дор ивүүрийн үзүүр нь дугуйны мөөрөнд дарагдсан байхаар бэхлэнэ. Тоормосны ивүүрийг тогтмол хэрэглэдэг газарт элстэй хайрцаг тавьсан байвал зохино. Элсийг мөс, хяруутай үед хэрэглэнэ.

6. Ивүүрийг тэгш зам дээр бүрэлдэхүүний 2 талаас бэхлэнэ. Хэвгийтэй бол хэвгийтэй талаас нь тооцоот ивүүрээр ивнэ.


7. Өнхөрч болзошгүй талаас бэхэлж байгаа бүлэг вагоны захынх нь биш вагоны дор тоормосны ивүүрээр бэхэлсэн бол энэ вагонтой энэ бүлгийн бусад бүх вагон нь найдвартай холбогдсон эсэхийг дахин шалгасан байна.

8. Вагонууд өнхөрч болзошгүй хүчтэй салхины /15 м/сек хүртэл/ чиглэл тохирсон үед тооцоот ивүүрийг нэгээр, бүр хүчтэй салхитай /15 м/секундээс дээш/ үед хоёроор нэмэгдүүлж бэхлэнэ.

9. Өртөөний зам дээр вагоныг бэхлэхдээ хоосон бүлэг вагоныг бэхлэхэд хэрэглэдэг тоормосны нэг ивүүрийг гар тоормосны 2 голоор орлуулж болох бөгөөд ачаатай бүлэг вагоныг бэхлэхэд хэрэглэдэг нэг ивүүрийг гар тоормосны 3 голоор орлуулж болох тооцоог ашиглаж болно.

--- о О о ---





Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн
264 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралт

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР ДЭХ ОСОЛ, ГОЛОГДЛЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, төмөр замын тээвэрт оролцогчдын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарсан сүйрэл, осол, гологдлыг /цаашид "сүйрэл, осол, гологдол" гэх/ шинжлэн судлах, шалтгааныг нь тогтоох, бүртгэх, мэдээлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Үйлдвэрлэлийн ослыг шинжлэн судлахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

1.3. Сүйрэл, осол, гологдлыг эрүүгийн болон захиргааны хариуцлага, хөдөлмөрийн харилцаатай холбогдуулан шалгаж байгаа эсэхээс үл хамааран шинжлэн судлах, шалтгааныг нь тогтоох, мэргэжлийн дүгнэлт гаргах, бүртгэх, байнгын болон байнгын бус ажлын хэсэг томилох, ажиллуулахыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

1.4. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь энэ журамд нийцүүлэн тухайн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд гарсан сүйрэл, осол, гологдлыг судлан бүртгэх, ажилтан, салбар нэгжийн ажлын үр дүнг тооцох, мэргэжлийн дүгнэлт гаргах, шалтгаан, үр дагаврыг арилгах үйл ажиллагааг зохицуулсан дотооддоо үйлчлэх дүрэм, журам, зааврыг батлан мөрдүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

СҮЙРЭЛ, ОСОЛ, ГОЛОГДОЛ


2.1. Зорчигчийн болон ачааны галт тэрэг нь өөр галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн болон хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсны улмаас хүний амь нас хохирсон, хөдлөх бүрэлдэхүүн эвдэрч дахин ашиглах боломжгүй болсон нөхцөл байдал үүссэнийг сүйрэлд тооцно.

2.2. Осолд дараахь нөхцөл байдал үүссэнийг тооцно:

2.2.1. зорчигчийн галт тэрэг өөр галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн;

2.2.2. зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн замаас гарсан;

2.2.3. ачааны галт тэрэг өөр ачааны галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн буюу хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсны улмаас энэхүү журмын 2.1-д



заасан хор хохирол учраагүй бөгөөд хөдлөх бүрэлдэхүүн их засварт орохоор эвдэрсэн;

2.2.4. сэлгээ, зэхэлтийн болон бусад хөдөлгөөний үед хөдлөх бүрэлдэхүүн мөргөлдсөн буюу замаас гарсны улмаас хүний амь нас хохирсон, хүний эрүүл мэндэд хохирол учирсан, хөдлөх бүрэлдэхүүн их засварт орохоор эвдэрсэн;

2.2.5. аюултай ачаа тээвэрлэх явцад хөдлөх бүрэлдэхүүн болон бусад шалтгааны гэмтлийн улмаас аюултай ачаа асгарч хүний эрүүл мэнд, байгаль орчин, бусдын өмч хөрөнгөд их хэмжээнээс дээш хохирол учирсан.

2.3. Гологдолд дараахь нөхцөл байдал үүссэнийг тооцно:

2.3.1. хөдлөх бүрэлдэхүүн мөргөлдсөн-Хоорондын зам болон өртөө, зөрлөгт галт тэрэг өөр галт тэрэгтэй буюу хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн, сэлгээ, зэхэлт, бусад хөдөлгөөний үед хөдлөх бүрэлдэхүүн өөр хоорондоо мөргөлдсөн, эсвэл хязгаарын шонгийн гадна нэг хөдлөх бүрэлдэхүүн нөгөөгийн хажуугаас мөргөснөөс болж энэ журмын 2.1, 2.2-т заасан хохирол учраагүй боловч хөдлөх бүрэлдэхүүнийг засварлаж болохуйц гэмтсэн бүх тохиолдол;

2.3.2. хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсан-Галт тэрэгний бүрэлдэхүүнээс хоорондын зам, өртөө, зөрлөгийн замд түүнчлэн салбар замд сэлгээ, зэхэлт, бусад хөдөлгөөний үед хөдлөх бүрэлдэхүүний хос дугуй зам төмрийн толгойноос унаж замаас гарсанаас энэ журмын 2.1, 2.2-т заасан хохирол учраагүй бүх тохиолдол;


2.3.3. эзэлгээтэй замаар галт тэрэг хүлээн авсан-Нээлттэй оруулах буюу урих дохиогоор эсвэл Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журамд тогтоосноор өртөөнд орох зөвшөөрөл авсан галт тэрэг нь оруулах дохио өнгөрсөн үед замнал нь хөдлөх бүрэлдэхүүнээр эзлэгдсэн зам руу орж байх тохиолдол;

2.3.4. эзэлгээтэй хоорондын замд галт тэрэг явуулсан-Хагас автомат хориглолын үед галт тэрэг буюу хөдлөх бүрэлдэхүүнээр эзлэгдсэн хоорондын зам руу гаргах дохио нээж эсвэл хоорондын зам эзлэх зөвшөөрөл машинчид өгч явуулснаас өртөөний хоорондын замын гаргах дохио /гаргах дохиогүй бол хязгаарын шон/-г хөдлөх бүрэлдэхүүний аль нэг хэсгээр өнгөрсөн тохиолдол;

2.3.5. бэлэн бус замналаар галт тэрэг хүлээн авсан-Өртөөнд ирж байгаа галт тэргийг хүлээн авахдаа аливаа зам дээр замналын бэлэн байдлыг хангаагүй нөхцөлд оруулах, дохионы хориглосон заалтыг өнгөрөх эрх олгож оруулсан бүх тохиолдол;

2.3.6. бэлэн бус замналаар галт тэрэг явуулсан-Өртөөнөөс зэргэлдээ өртөө рүү галт тэрэг явуулахаар замналыг бэлтгэх үед явах галт тэрэгний зам дээр замналын бэлэн байдлыг хангаагүй байж, тухайн галт тэргэнд хоорондын зам эзлэх эрх олгож явах тушаал өгөх, явуулах зэрэг тохиолдол;

2.3.7. хориглосон дохио өнгөрсөн-Галт тэрэг буюу ганцаар яваа зүтгүүр, замаас авагддаггүй нэгжүүдийг өртөөнд хүлээн авах, явуулах болон сэлгээний үед



хориглосон заалттай дохиог /зөөврийн зогсох дохио бүрийг/, дохиогүй өртөөдөд хязгаарын шонг өнгөрсөн тохиолдол;

2.3.8. хөдлөх бүрэлдэхүүн дор сум эргэсэн-Цахилгаан төвлөрүүлэлтийн төхөөрөмж гэмтсэнээс буюу сумын секц хөдлөх бүрэлдэхүүнээс бүрэн чөлөөлөгдсөнийг магадлалгүйгээр албадан гуйвуулсан буруу үйл ажиллагааны улмаас, эсвэл зам төмрийн хэлхээний мэдрэмж алдагдсанаас /зэвэрсэн, элс, шороо, тосонд дарагдсан гэх мэт/ сум хөдлөх бүрэлдэхүүн дор эргэж тухайн замналаас өөр замнал бэлтгэгдсэн тохиолдол;

2.3.9. хөдлөх бүрэлдэхүүн өөрөө хөдөлсөн-Өртөөний болон салбар замд хөдлөх бүрэлдэхүүн өөрөө хөдөлсөн;

2.3.10. хөдлөх бүрэлдэхүүний эд анги хугарсан-Хөдлөх бүрэлдэхүүний хос дугуйн гол, голын хүзүү буюу дугуй, хажуу арал, нумын дээд дам нуруу, ноён нуруу хугарсан, тасарсан, хагарсан тохиолдол;

2.3.11. зорчигчийн вагон салгасан-Аялалын замд зорчигчийн галт тэрэгнээс явуулах болон хүрэх өртөөнөөс бусад бүх өртөөд дээр, галт тэрэгний цаашдын хөдөлгөөнд саад болох гэмтлийн улмаас вагон салгасан тохиолдол;

2.3.12. галт тэргэнд эд юмс дайрагдсан-Галт тэрэг болон сэлгээний бүрэлдэхүүнд хөдлөх бүрэлдэхүүний эд анги, тоормосын ивүүр, замаас авагддаг нэгжүүд, замын дээд цогцын материал /чигжээсээс бусад/ замын багажууд, ачаа бараа дайрагдсан, шүргэгдсэн бүх тохиолдол. Ивүүртэй явуулсан тохиолдол энэ ангилалд орно;


2.3.13. тээврийн хэрэгсэл дайрагдсан-Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн болон бусад тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөж, сүйрэл, ослын хэмжээний үр дагавар гараагүй тохиолдол;

2.3.14. дохиолол төвлөрүүлэлт хориглол, эрчим хүч тасалдсан-Дохиолол төвлөрөл, хориглолын төхөөрөмж, зам төмрийн хэлхээ, эрчим хүч шугамын гэмтлээс өртөө хоорондын хориглол, хагас автомат хориглол зургаа болон түүнээс дээш цагаар хаагдсан. Мөн эрчим хүч тасарсан үед нөөцийн цахилгаан станц ажиллахгүйгээс өртөө хоорондын хориглол, хагас автомат хориглол хоёр ба түүнээс дээш цагаар хаагдсан тохиолдол;

2.3.15. төгсгөлийн кран хаалттай явуулсан-Галт тэрэгний хөдлөх бүрэлдэхүүн хооронд төгсгөлийн кран хаалттай явуулсан тохиолдол;

2.3.16. зорчигчийн галт тэрэгний зүтгүүр эвдэрсэн-Зорчигчийн галт тэрэгний зүтгүүрт техникийн гэмтэл гарч хоорондын зам буюу завсарын өртөөнд тусламж авсан, зүтгүүр сольсон тохиолдол;

2.3.17. усанд автах, элс, цасанд дарагдах, гал түймэрт өртөх-Суурь бүтцийн бүрэн бүтэн байдал алдагдсан, газрын доорх усны болон урсгал усны түвшин нэмэгдснээс суурь бүтэц усанд автсан, санаатай болон санамсаргүй үйлдлээс



гарсан гал түймэр зэргээс болж галт тэрэгний хөдөлгөөнийг нэг цагаас дээш хугацаагаар бүрэн зогсоосон тохиолдол;

2.3.18. зорчигчийн галт тэрэг цуцалсан, зорчигч буулгасан-Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний техникийн гэмтлээс шалтгаалж галт тэрэг явуулах өртөөнөөс зорчигчийн галт тэрэгний явуулалтыг цуцалсан буюу завсарын өртөөнд зорчигчдийг буулгасан тохиолдол;

2.3.19. вагон, чингэлэг дэх ачаа шатах-Хоорондын зам, өртөө, зөрлөг, салбар замд вагон, чингэлэгт ачсан ачаа шатсан бүх тохиолдол;

2.3.20. хөдлөх бүрэлдэхүүний эд анги зам дээр унасан-Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөний явцад түүний эд анги зам дээр /зам төмрийн цариг дотор, замын хажуу захад/ унасны улмаас цаашид хөдөлгөөн үргэлжлүүлэх боломжгүй болсон, төмөр замын бусад тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан тохиолдол;

2.3.21. аялалын үед зам дээр ачаа унасан-Шингэн болон нурмаг ачаанаас бусад ачаа /чингэлэг/ эсвэл тэдгээрийн аль нэг хэсэг зам дээр унах, бэхэлгээ тасарч ачаа байрнаас хөдөлж тогтоосон ачилтын овороос хэтэрсэн тохиолдол;

2.3.22. дохио буруу дохиолсон-Гэрлэн дохионы хориглосон заалт нь зөвшөөрсөн заалт руу эсвэл хурд бууруулахыг шаардсан заалт нь илүү зөвшөөрсөн заалт руу хуурамчаар шилжсэн тохиолдол;

2.3.23. галт тэрэгний авто угсраа тасарсан, салсан-Галт тэрэгний авто угсраа тасарсан болон салсан бүх тохиолдол;

2.3.24. сум зүссэн-Өртөө, зөрлөг, салбар зам дээр сум зүсэгдсэн бүх тохиолдол;

2.3.25. вагон салгасан-Гүүшин халсны улмаас техник үзлэгийн нэгж бүхий өртөөд болон баталгаат мөрийн төгсгөлийн өртөөнөөс бусад бүх өртөөн дээр ачааны галт тэрэгнээс вагон салгасан тохиолдол;

2.3.26. ачааны нөхцөлөөс хамаарч вагон салгасан-Ачаа, тээш, ачаан тээшийн ачилтын техникийн нөхцөлүүдийг зөрчсөний улмаас ачаа, ачааны зарим хэсэг зам дээр унаж болзошгүй, түүнчлэн ачаа ачилтын овороос хэтэрсний улмаас хэсгийн өртөөнөөс бусад бүх өртөөд дээр галт тэрэгнээс вагоныг салгасан тохиолдол;

2.3.27. хос дугуй гацсан-Гүүшин буюу татах цахилгаан хөдөлгүүр гацсан, хос дугуйн гадаргууд зөвшөөрөгдөх хэмжээнээс их чирэг, шаваас гарсан бүх тохиолдол;

2.3.28. зам төмөр ухсан-Зүтгүүрийн болон бусад өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүний хос дугуйгаар зам төмрийг зөвшөөрөгдсөн хэмжээнээс ихээр ухаж солих хэмжээнд хүргэсэн тохиолдол;

2.3.29. зам төмөр хугарсан-Энэхүү журмын 2.3.28-д зааснаас бусад шалтгаанаар зам төмөр хугарсан бүх тохиолдол;



2.3.30. галт тэргэнд мал дайрагдсан-Өртөө, зөрлөг, гарам, хоорондын болон салбар замд бод мал, биеэр том ан амьтан галт тэргэнд, сэлгээнд дайрагдсан бүх тохиолдол.

2.4. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид нь энэхүү журмын 2.1-2.3-т зааснаас бусад төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдсан зөрчил, дутагдал гарсан тохиолдолд байгууллагын дотоод журмаар тусгайлан бүртгэж, тэдгээрт хяналт-шинжилгээ хийж, дахин давтагдахгүй байх арга хэмжээг авч ажиллана.

ГУРАВДУААР БҮЛЭГ

СҮЙРЭЛ, ОСОЛ, ГОЛОГДЛЫГ МЭДЭЭЛЭХ

3.1. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь дараахь нөхцөл байдал бий болсныг мэдсэн даруйд энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шуурхай мэдээлнэ:

3.1.1. энэ журмын 2.1, 2.2, 2.3.1-д заасан нөхцөл байдал бий болсон;

3.1.2. энэ журмын 2.3.2-т заасан нөхцөл байдлын улмаас хүний амь нас хохирсон, эрүүл мэндэд хохирол учирсан;

3.1.3. энэ журмын 2.3.2-т заасан нөхцөл байдал тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нэг буюу түүнээс дээш этгээдийг хамарсан;

3.1.4. галт тэргэнд хүн дайрагдсан.

3.2. Энэхүү журмын 2.1, 2.2, 2.3.1, 2.3.13, 2.3.17, 2.3.19, 3.1.4-т заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд Төмөр зам дахь цагдаагийн газар болон орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн жижүүрт шуурхай мэдээлнэ.


3.3. Шуурхай мэдээлэл нь ямар үйл явдал болсон, тухайн сүйрэл, осол, гологдол болсон газар, огноо, цаг, үүссэн хохирлын шинж чанар, хэр хэмжээ, холбогдох тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн нэр, холбогдох утас, цахим хаяг зэргийг багтаасан байна.

3.4. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь энэ журмын 3.1-д заасан мэдээллийг баталгаажуулж тухайн нөхцөл байдал бий болсноос хойш ажлын 12 цагийн дотор энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу бичмэл мэдээллийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад тус тус хүргүүлнэ.

3.5. Сүйрэл, осол, гологдол гарсан тохиолдолд тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч дараахь үүрэг хүлээнэ:

3.5.1. хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалж анхан шатны тусламж үзүүлэх;

3.5.2. хамгийн ойр орших эмнэлгийн байгууллага, суурь бүтэц эзэмшигч болон Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвд мэдэгдэх;



3.5.3. сүйрэл, осол, гологдлын шалтгаан, нөхцөлийг тогтооход ашиглагдаж болох баримт бичиг, замын байгууламж болон хөдлөх бүрэлдэхүүний эд анги, бүрдэл хэсэг, эд зүйлийг хэвээр нь хадгалж, хамгаалах, баримтжуулах;

3.5.4. хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, сүйрэл, осол, гологдлоос урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай бол сүйрэл, осол, гологдлын улмаас эвдэрч гэмтсэн хөдлөх бүрэлдэхүүн, барилга, байгууламж, эд зүйлсийг эвдэх, задлах, нээх, замаас зайлуулах, аюултай ачааны хор хөнөөлийг саармагжуулах зэрэг шуурхай арга хэмжээ авах;

3.5.5. хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бусад шуурхай арга хэмжээ авах.

3.6. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь гарсан сүйрэл, осол, гологдлын шалтгаан, үр дагаварыг арилгах, энэ журмын 3.5-д заасныг зөрчихгүйгээр хөдөлгөөнийг сэргээх арга хэмжээг авч эхлүүлнэ.

3.7. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчоос бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сүйрэл, осол, гологдол болсон тухай холбогдох байгууллагуудад мэдээлэл ирүүлбэл тэдгээр мэдээллийн үнэн, бодитой эсэхийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нар нягтлан шалгасны үндсэн дээр шинжлэн судална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

СҮЙРЭЛ, ОСОЛ, ГОЛОГДЛЫГ ШИНЖЛЭН СУДЛАХ

4.1. Шинжлэн судлах ажиллагаа нь хараат бус, бие даасан байж, сүйрэл, осол, гологдол гарсан шалтгаан, нөхцөлийг үнэн, зөв тогтоох, цаашид давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилготой байх ба хэн нэгэн этгээдийн гэм бурууг тогтоох, хариуцлага тооцоход чиглэгдэхгүй байна.

4.2. Сүйрэл, осол, гологдлыг шинжлэн судлах, шалтгааныг нь тогтоох, бүртгэх үйл ажиллагаа нь мэдээлэл цуглуулах, холбогдох баримт бичиг бүрдүүлэх, судлан шинжлэх, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, мэдээлэх, архивлах гэсэн ерөнхий дарааллаар явагдана.

4.3. Энэ журмын 2.1, 2.2-т заасан нөхцөл байдал бий болсон, мөн 2.3-т заасан нөхцөл байдалд тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч хэд хэдэн этгээд холбогдсон буюу хүний амь нас хохирсон, хүний эрүүл мэндэд хохирол учирсан бол төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон ажлын хэсэг удирдамжийн дагуу шинжлэн судалж, шалтгааныг нь тогтооно. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч, харьяалах суурь бүтэц эзэмшигч, холбогдох төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагын төлөөллийг хамруулсан байна.

4.4. Энэхүү журмын 4.7-д заасан судалгаа болон холбогдох материал, баримт бичгийг үндэслэн сүйрэл, осол, гологдол гарсан газарт нэвтрэн, шинжлэн судлах, шалтгааныг тогтоох ажиллагааг явуулна.



4.5. Энэ журмын 4.3-т зааснаас бусад гологдлыг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагын томилсон ажлын хэсэг шинжлэн судална.

4.6. Шаардлагатай бол төмөр замын тээврийн хяналтын улсын ахлах байцаагчийн шийдвэрээр энэ журмын 3.1.1, 3.1.2, 3.1.3-т зааснаас бусад гологдлыг төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагчаар ахлуулсан ажлын хэсэг шинжлэн судалж болно.

4.7. Сүйрэл, осол, гологдол гарсан үед тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь ажлын хэсэг томилогдон ажиллаж эхлэх хүртэл, эсхүл ажлын хэсгийн ахлагчийн даалгаснаар сүйрэл, осол, гологдлын шинж чанараас хамааран дараахь ажил үүргийг гүйцэтгэнэ:

4.7.1. хурд хэмжигчийн тууз, галт тэрэгний хөдөлгөөний мэдээллийг бүртгэх төхөөрөмж /мэдээлэл хадгалагч/, галт тэрэгний биечилсэн хуудас, тоормосны хангамжийн мэдээлэл, хурд хязгаарласан тухай анхаарамж, зүтгүүрийн ширээний журнал, бусад баримт бичгийг шалгаж, шаардлагатай бол эхээр нь буюу хуулбарлан авах;

4.7.2. сүйрэл, осол, гологдол гарсан газар, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд үзлэг хийсэн тухай акт үйлдэх;

4.7.3. суурь бүтэц, замын байгууламж болон хөдлөх бүрэлдэхүүний гэмтлийг тодорхойлох;

4.7.4. сүйрэл, осол, гологдлын нөхцөл байдал, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний байдал, эвдрэл гэмтэл, гадны болон ойр орчимд байгаа эд зүйлс зэргийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах;

4.7.5. сүйрэл, осол, гологдолд холбоотой ажилтан, гэрчийн этгээдээс бичгээр тодорхойлолт авч, шаардлагатай бол дуу болон дүрсний бичлэгээр баталгаажуулах;

4.7.6. сүйрэл, осол, гологдол болсныг баталгаажуулах зорилгоор авсан гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, ослын дараахь суурь бүтцийн тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний гэмтэл, арчлалтын норм хэмжээний өөрчлөлт, хөдлөх бүрэлдэхүүний байршил ба замаас гарсан эхлэл төгсгөлийн ул мөр зэргийг заасан бүдүүвч зураг гаргах;

4.7.7. сүйрэл, осол, гологдол гарах үед цаг агаарын байдал ямар байсан тухай тэмдэглэл хийж, шаардлагатай бол холбогдох баримтыг авна.

4.8 Ажлын хэсэг шинжлэн судлах, шалтгааныг нь тогтоох ажиллагааг хийж, дүгнэлтийг ажлын 14 хоногт багтаан гаргана. Нэмэлт баримт, мэдээлэл, шалган турших ажиллагаа шаардлагатай бол шинжлэн судлах ажиллагааг ажлын 10 хоногийн хугацаагаар сунгаж болно.



4.9. Дүгнэлтийг хамтын шийдвэрээр гаргаж ажлын хэсгийн бүх гишүүд гарын үсэг зурах ба дүгнэлттэй санал нийлэхгүй гишүүн тэр тухайгаа тэмдэглэн гарын үсэг зурж хавсаргана.

4.10. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн томилсон ажлын хэсгийн дүгнэлт зохих ёсоор хийгдэж, шаардлага хангасан эсэхийг улсын байцаагч, улсын байцаагчийн ахалсан ажлын хэсгийн дүгнэлтийг улсын ахлах байцаагч тус тус хянаж, шаардлагатай гэж үзвэл дүгнэлтийг хүчингүй болгож, дахин дүн шинжилгээ хийлгэх арга хэмжээ авна.

4.11. Дахин хийгдэх дүн шинжилгээнд тухайн дүн шинжилгээг анх хийсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс оролцуулахгүй.

4.12. Сүйрэл, осол, гологдлын шалтгааныг нь тогтоохдоо нотлох баримт, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн тэдгээрийн эд анги, техник, тоног төхөөрөмжийг эвдэж гэмтээхгүй, үрэгдүүлэхгүй, сөрөг нөлөөлөл үзүүлэхгүйгээр ажиллах, шаардлагатай бол томоохон эд анги болон аюултай ачааг зөөвөрлөн саадгүйгээр шилжүүлэхдээ шинжээчдийн хяналтан дор, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор гүйцэтгүүлнэ.

4.13. Сүйрэл, осол, гологдлыг шинжлэн судлах, шалтгааныг нь тогтоох явцад дараахь мэдээллүүдийг өөр зорилгоор бусдад ашиглуулахгүй, мөн задруулахгүй. Үүнд:

4.13.1. аливаа этгээдээс авсан тайлбар, тодорхойлолт;


4.13.2. энэхүү журмын 4.7.1-4.7.6-д заасан ажил үүрэг, /акт, тодорхойлолт, зураг, дуу, дүрс бичлэг, ослын дараахь суурь бүтцийн тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний гэмтэл, арчлалтын норм хэмжээний өөрчлөлт, хөдлөх бүрэлдэхүүний байршил ба замаас гарсан эхлэл төгсгөлийн ул мөр зэргийг заасан бүдүүвч зураг/;

4.13.3. сүйрэл, осол, гологдолд өртсөн хүмүүсийн эрүүл мэнд, хувь хүний болон хувийн амьдралын талаарх мэдээллүүд;

4.13.4. гарсан сүйрэл, осол, гологдлыг шинжлэн судлах ажиллагаанд оролцогчдын илэрхийлсэн санал, дүгнэлт, тэдгээртэй холбоотой мэдээллүүд;

4.13.5. гарсан сүйрэл, осол, гологдлыг шинжлэн шалгагч нарын хүрээнд болсон бодит хяналтын төхөөрөмжийн бичлэгийн талаарх аливаа үнэлэлт, тодорхойлолт, дүгнэлт.

4.14. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарсан сүйрэл, осол, гологдлын шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага төлөвлөн хэрэгжүүлнэ.



4.15. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд гарсан сүйрэл, осол, гологдлыг дахин давтахгүй байх ажлыг зохион байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

СҮЙРЭЛ, ОСОЛ, ГОЛОГДЛЫН ДҮГНЭЛТЭД ХАВСАРГАХ БАРИМТ, МЭДЭЭЛЭЛ

5.1. Ажлын хэсгийн дүгнэлтэд энэ журмын 4.6-д заасан ажиллагааг хийж цуглуулсан мэдээллээс гадна дараахь баримт, мэдээллийг хавсаргасан байна:

5.1.1. гэмтсэн, хохирсон, хүмүүсийн нэрсийн жагсаалт, гэмтлийн байдлын талаарх эмнэлгийн урьдчилсан дүгнэлт;

5.1.2. хохирлын хэмжээг тодорхойлсон баримт;

5.1.3. шаардлагатай тохиолдолд хийгдсэн шалган турших ажиллагааны акт, дүгнэлт;

5.1.4. галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагийн хуулбар;

5.1.5. суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын үеийн техникийн баримт бичиг, бүртгэл, тайлангийн хуулбар /сүйрэл, осол, гологдлын шалтгааныг тогтооход шаардлагатай бол/;

5.1.6. сүйрэл, осол, гологдол болсныг баталгаажуулах зорилгоор авсан гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, ослын дараахь суурь бүтцийн тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний гэмтэл, арчлалтын норм хэмжээний өөрчлөлт зэргийг заасан бүдүүвч зураг;

5.1.7. тухайн үеийн цаг уурын байдлын талаарх лавлагаа;

5.1.8. техникийн мэдлэгийн шалгалтын баримт, ажлын байрны тодорхойлолт, дадлага туршлагын байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаанд хамрагдсан эсэх, эмнэлгийн үзлэгт орсон тухай магадлагаа, ажил, амралтын дэглэмийн тухай мэдээлэл;

5.1.9. шаардлагатай бусад баримт.



ЗУРГАДУГААР БҮЛЭГ

СҮЙРЭЛ, ОСОЛ, ГОЛОГДЛЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭ ГАРГАХ

6.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сүйрэл, осол, гологдлын нэгдсэн бүртгэлийг хөтөлж, холбогдох мэдээ, баримтыг хадгална.

6.2. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь сүйрэл, осол, гологдол болон төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааны явцад хүний амь нас хохирсон, эрүүл мэндэд хохирол учирсан нөхцөл байдлыг бүртгэн мэдээ, баримтыг хадгална.

6.3. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь энэ журмын 6.2-т заасан сүйрэл, осол, гологдлын мэдээг Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмын 1.4-т заасан хугацаанд, тогтоосон маягтын дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвд хүргүүлнэ.

6.4. Улсын байцаагч тодорхой нэр заасан гологдлын мэдээ, дүгнэлт ирүүлэхийг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчоос шаардаж болно.

6.5. Сүйрэл, осол, гологдлын жилийн мэдээ, баримтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хадгална.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА



7.1. Энэхүү журмын хэрэгжилтэд төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зам, тээврийн хяналт хариуцсан нэгж, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нар тус тусын бүрэн эрхийн хэмжээнд хяналт тавина.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---



Зам, тээврийн хөгжлийн сайдын
 2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
 дүгээр тушаалын Төмөр замын тээвэр
 дэх сүйрэл, осол, гологдлыг судлан
 бүртгэх журмын нэгдүгээр хавсралт




Мэдээлэл дамжуулах байгууллага	Товчилсон нэр
"Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв" УТҮГ	RTCC
Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэг	UBTZ
"Монголын төмөр зам" ТӨХК	MTZ
"Болд төмөр Ерөө гол" ХХК	BTEG
Бусад	OTHER

Мэдээллийн хэлбэр:

- Утсаар /message/
- Факсаар
- Цахим шуудангаар
- Албан бичгээр

ТАЙЛБАР:

- Сүйрэл, осол, гологдлыг мэдсэн даруйд Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны ХШУДАГ /ЗТХХ/, ТЗДТБХЗГ-ын дарга, төмөр замын тээврийн хяналтын мэргэжилтэн нарт нэн даруй мэдээлнэ.
- Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас холбогдох байгууллагад авах арга хэмжээний талаар чиглэл өгнө.
- Мэдээллийг факс, албан бичиг, цахим шуудангаар ирүүлэхдээ тухайн байгууллагын товчилсон нэр, мэдээлэл дамжуулсан албан тушаалтны овог нэр, гарсан газар /өртөө, хоорондын зам, км/. огноо, цаг минут, нөхцөл байдлын талаар тодорхой бичнэ.





Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дүгээр тушаалын Төмөр замын тээвэр
дэх сүйрэл, осол, гологдлыг судлан
бүртгэх журмын хоёрдугаар хавсралт

ШУУРХАЙ МЭДЭЭЛЭЛ /БИЧМЭЛ/

/Сүйрэл, осол, гологдол/

1. Гарсан газар /өртөө, хоорондын зам, км/
.....
2. Огноо цаг, минут
3. Үүссэн хохирлын шинж байдал, хэр хэмжээ
4. Галт тэрэг саатсан, галт тэрэг, байгууламж өртсөн эсэх
5. Хүний амь нас хохирсон, эрүүл мэндэд хохирол учирсан эсэх
6. Байгаль орчин, бусдын эд хөрөнгө, үйл ажиллагаанд хохирол учирсан эсэх
7. Сэргээн босгох талаар авсан арга хэмжээ, одоогийн байдал
8. Шалтгаан /урьдчилсан байдлаар/
9. Бусад тайлбар

Шуурхай мэдээлэл өгсөн:


.....
/Байгууллага, албан тушаалтны овог нэр, гарын үсэг, гарын үсгийн тайлал, холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаяг/

... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Анхаарах асуудал:

1. Сүйрэл, осол, гологдлын аль нь болохыг доогуур зурна.
2. Асуултад аль болох дэлгэрэнгүй бичнэ, товчилсон үг хэрэглэхгүй.
3. Шаардлагатай тохиолдолд фото зураг, бусад нэмэлт баримт хавсаргана.

--- о о о ---



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дүгээр тушаалын тавдугаар хавсралт

1118268953 5019487 СБТ9513

ТӨМӨР ЗАМААР АЧАА ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Төмөр замын тээврийн тухай хууль, Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн төмөр замаар ачаа тээвэрлэхтэй холбоотой суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төмөр замаар ачаа тээвэрлэгч, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, илгээгч, хүлээн авагч болон тээвэр зуучлагч нар энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү журамд хэрэглэгдсэн нэр томъёо, тодорхойлолтыг Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төмөр замын техник ашиглалтын дүрэм болон MNS 6387-1,2,3,4:2013 “Төмөр зам, замын, автоматик, телемеханикийн, хөдлөх бүрэлдэхүүний, тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томъёо, тодорхойлолт”-д тус тус заасан утгаар ойлгож хэрэглэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АЧААНЫ ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ, ЗӨВШИЛЦӨХ

2.1. Ачааны захиалга хүлээн авах:

2.1.1. тээвэрлүүлэгч төмөр замаар ачаа тээвэрлүүлэх захиалгыг орон нутгийн харилцаанд ачаа илгээх өртөөнд, олон улсын харилцаанд тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад ирүүлэх;

2.1.2. ачаа тээвэрлүүлэх захиалга, хүрэх өртөөний нэр, код, салбар замын нэр, код ачааны нэр, түүний уялдуулсан код, илгээлтийн төрөл, вагон, чингэлгийн эзэмшигч байгууллагын нэр, ачааны жин, тоо хэмжээ, сав, баглаа, боодлын төрөл, илгээгч, хүлээн авагч, түүний хаяг, харилцааны төрөл /төмөр замын шууд харилцаа, холимог харилцаа гэх мэт/ зэрэг өгөгдлийг ачаа тээвэрлүүлэх захиалгад тусгах;

2.1.3. олон улсын харилцаанд тээвэрлэгдэх ачааны захиалгад хилийн дамжин өнгөрөх өртөөдийг заах;

2.1.4. чингэлгээр тээвэрлэгдэх ачааны захиалгад чингэлгийн төрөл /их, дунд, бага даац, хөргүүртэй г.м./-ийг заах;





2.1.5. ачаа тээвэрлүүлэх захиалгад илгээлтийн төрөл /вагон, чингэлэг, жижиг илгээлт, өөрийн гол дээр тээвэрлүүлэх/-ийг заана.

2.2. Захиалгыг тээвэрлэгч хүлээн авах, зөвшилцөх:

2.2.1. илгээгч, тээвэр зуучлагч ачаа тээвэрлүүлэх захиалгыг орон нутгийн харилцаанд тээвэрлэх сар эхлэхээс 10 хоногийн өмнө, олон улсын харилцаанд 15 хоногийн өмнө тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад ирүүлэх;

2.2.2. захиалга өгсөн огноог тээвэрлэгчийн хүлээн авсан өдрөөр тогтоох бөгөөд тээвэрлэгч нь өгсөн захиалгын хуудсанд бүртгэлийн дугаарыг бичих;

2.2.3. ачаа тээвэрлүүлэх захиалгын хуудсанд хүчинтэй хугацааг заах;

2.2.4. ачаа тээвэрлүүлэх захиалгыг тээвэрлэгчид албан бичгээр биечлэн эсвэл шуудангаар ирүүлнэ. Талууд урьдчилан тохиролцсон тохиолдолд бусад хэлбэр /факс, цахим хэлбэр зэрэг/-ээр захиалгыг ирүүлэх;

2.2.5. ачаа тээвэрлүүлэх захиалгыг цахим хэлбэрээр ирүүлэх бол талууд цахим хэлбэрээр бичиг баримт солилцох гэрээ байгуулж, цахим болон тоон гарын үсгээр баталгаажуулсан байна. Талууд тохиролцоноор тээвэрлэгч ачаа илгээгчийг захиалгын маягтаар хангах;

2.2.6. ирүүлсэн захиалга нь 3 хувь байх бөгөөд хувь бүр дээр ачаа илгээгч гарын үсэг зурж, тэмдэг тавьж баталгаажуулсан байна. Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, ачаа илгээгч/тээвэр зуучлагчид тус бүр 1 хувь захиалга очих;

2.2.7. цахим хэлбэрээр ирүүлсэн захиалгыг 3 хувь хэвлэж, гарын үсэг зуруулан тэмдэг дарж баталгаажуулах;

2.2.8. ачаа илгээгч нь дайвар үйлчлүүлэгч байвал салбар зам эзэмшигчтэй тохиролцсоны дараа захиалгын хуудсанд "Зөвшилцсөн" гэсэн тэмдэглэл хийлгэсэн байх;

2.2.9. захиалгад заагдсан мэдээллийн үнэн зөв эсэхийг ачаа илгээгч хариуцна. Захиалга нь компьютерээр бичигдсэн байх ба ямар нэгэн засваргүй, товчлохгүй, тодорхой бичигдсэн байх;

2.2.10. энэ журмын шаардлага хангаагүй захиалгын хуудсыг тээвэрлэгч нь ачаа илгээгчид буцаах;

2.2.11. тээвэрлэгч нь ирсэн захиалгыг нэг хоногийн дотор судлан тээвэрлэлтийг гүйцэтгэх боломжтой гэж үзвэл захиалгын хуудасны "тээвэрлэгчтэй зөвшилцсөн" мөрөнд "зөвшөөрөв", "хэсэгчлэн зөвшөөрөв" гэсэн тэмдэглэгээг хийж, тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан гарын үсэг зурна.

2.2.12. зөвшөөрсөн болон хэсэгчлэн зөвшөөрсөн захиалгыг суурь бүтэц эзэмшигчид зөвшилцөхөөр явуулах.



2.2.13. хэсэгчлэн зөвшөөрөх гэдэг нь тээвэрлэгч өгсөн захиалгын тээвэрлэгдэх ачааны хэмжээг төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний төрөл, чиглэл зэргийн боломжийг үндэслэн өөрчлөхийг хэлнэ.

2.3. Тээвэрлэгч нь дараахь тохиолдолд ачаа тээвэрлүүлэх захиалгыг зөвшилцөхөөс татгалзах эрхтэй:

2.3.1 ачаа тээвэрлэх чиглэлд ачаа ачихыг хязгаарласан, зогсоосон;

2.3.2 суурь бүтэц эзэмшигч захиалгыг зөвшилцөхөөс татгалзсан;

2.3.3 тээвэрлэлтийг гүйцэтгэх техник технологийн бодит боломжгүй;

2.3.4 хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр татгалзсан тохиолдолд "захиалгыг зөвшөөрсөн огноо" гэсэн мөрөнд "татгалзсан" гэсэн тэмдэглэл хийж, шалтгааныг зааж ачаа илгээгчид буцаана.

2.4. Захиалгыг суурь бүтэц эзэмшигч хүлээн авах, зөвшилцөх:

2.4.1. суурь бүтэц эзэмшигчийн эрх бүхий албан тушаалтан нь тээвэрлэгчээс ирүүлсэн ачаа тээвэрлүүлэх захиалгыг олон улсын төмөр замын шууд болон шууд бус, холимог харилцаанд тээвэрлэх бол 10 хоногийн дотор зөвшилцөн, захиалгыг зөвшилцсөн үр дүнгийн талаар тэмдэглэл хийж буцаана. Орон нутгийн харилцаанд тээвэрлүүлэх бол Суурь бүтэц эзэмшигчийн эрх бүхий албан тушаалтантай зөвшилцсөнөөр өртөөний болон ачиж буулгах ангийн дарга 2 хоногийн дотор үр дүнгийн талаар тэмдэглэл хийнэ;

2.4.2. суурь бүтэц эзэмшигч нь ачаа тээвэрлүүлэх захиалгын өгөгдлийг бусад суурь бүтэц эзэмшигч, бусад төрлийн тээврийн байгууллага болон гадаад орны төмөр замтай зөвшилцөнө;

2.4.3. суурь бүтэц эзэмшигч нь захиалгыг хянаж захиалгын хуудасны зөвшилцсөн тусгай хүснэгтэд "зөвшөөрөв", "хэсэгчлэн зөвшөөрөв", "татгалзав" гэсэн тэмдэглэл хийж огноог, суурь бүтэц эзэмшигчийн эрх бүхий албан тушаалтан гарын үсгээ зурж тэмдэг дарна.

2.5. Суурь бүтэц эзэмшигч нь дараахь тохиолдолд тээвэрлэгчээс ирүүлсэн захиалгыг зөвшилцөхөөс татгалзах эрхтэй:

2.5.1. суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн хооронд гэрээ байгуулаагүй;

2.5.2. холимог тээвэр гүйцэтгэх тээврийн байгууллага тээвэрлэлтийн захиалгыг зөвшилцөхөөс татгалзсан;


2.5.3. гадаад орны холбогдох суурь бүтэц эзэмшигч захиалгыг зөвшилцөхөөс татгалзсан;

2.5.4. бусад суурь бүтэц эзэмшигч захиалгыг зөвшилцөхөөс татгалзсан;

2.5.5. ачаа тээвэрлэх чиглэлд /замнал/ ачаа ачихыг хориглосон, хязгаарласан;

2.5.6. тээвэрлэлтийг гүйцэтгэх техник технологийн бодит боломжгүй;

2.5.7. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл зэрэг болно.



2.6. Тээвэрлэгч нь ачаа тээвэрлүүлэх захиалгын хуудсыг суурь бүтэц эзэмшигчээс хүлээж авсны дараа захиалгын хуудасны "Захиалгыг зөвшилцсөн огноо, мөрөнд "зөвшөөрөв", "хэсэгчлэн зөвшөөрөв", "татгалзав" гэсэн тэмдэглэл хийж он, сар, өдрийг зааж тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан гарын үсгээ зурж огноог бичнэ.

2.7. Тэмдэглэл хийгдсэн ачаа тээвэрлүүлэх захиалгын хуудсыг ачаа илгээгчид ачилт эхлэхээс 3 хоногийн өмнө ирүүлнэ. Тээвэрлэлтийг татгалзсан болон хэсэгчлэн зөвшөөрсөн тохиолдолд ачаа илгээгчид шалтгааныг зааж явуулна.

2.8. Хэсэгчлэн зөвшөөрсөн ачаа тээвэрлүүлэх захиалгыг ачаа илгээгч зөвшөөрөхгүй бол тээвэрлэлт эхлэхээс 2 хоногийн өмнө энэ тухайгаа тээвэрлэгчид, тээвэрлэгч нь суурь бүтэц эзэмшигчид мэдэгдэнэ. Энэ тохиолдолд тооцооны хуудас бүрдүүлэхгүй бөгөөд ачаа тээвэрлүүлэх захиалга биелүүлээгүй торгуулийг ачаа илгээгч, тээвэрлэгчээс нэхэмжлэхгүй. Хэсэгчлэн зөвшөөрсөн захиалгыг татгалзсан хариу ачаа илгээгчээс ирүүлээгүй бол тээвэрлэгч захиалгыг биелүүлж эхэлнэ.

2.9. Ачаа илгээгч нь тээвэрлэгчид зөвшилцсөн ачаа тээвэрлүүлэх захиалгад өөрчлөлт оруулах талаар бичгээр хандаж болох ба үүнд суурь бүтэц эзэмшигчтэй зөвшилцсөнөөр ачаа хүрэх өртөөдөөр нь өөрчлөн хуваарилах, илгээх өртөөг өөрчилж болно. Хаяг сольсны хураамжийг ачаа илгээгч тээвэрлэгчид төлнө.

2.10. Тээвэрлэгч хүлээн авсан захиалгын нөхцөлийг тооцооны хуудсанд бичнэ.

2.11. Тээвэрлэгч нь ачаа тээвэрлүүлэх захиалгад заасан төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний төрлийг энэхүү журамд заагдсан бусад төрлийн хөдлөх бүрэлдэхүүнээр сольж өгөх эрхтэй бөгөөд энэ тухайгаа ачаа илгээгчид вагон ачилтад тавьж өгөхөөс өмнө мэдэгднэ.

2.12. Олон улсын төмөр замын шууд болон шууд бус харилцаанд мөн далайн боомтоор тээвэрлэгдэх ачааны хөдлөх бүрэлдэхүүнийг сольж өгөх бол суурь бүтэц эзэмшигчтэй зөвшилцөнө.


2.13. Гэр ахуйн хэрэгцээний болон бусад арилжааны бус шинжтэй ачааны захиалгыг тээвэрлэлт эхлэхээс 3 хоногийн өмнө тээвэрлэгчид өгч болно.

2.14. Цэргийн ачаа тээвэрлүүлэх захиалгыг Цэргийн тээвэрлэлт гүйцэтгэх журмын дагуу хүлээн авна.

2.15. Ачаанд тооцооны хуудас бичих, дүгнэх:

2.15.1. тооцооны хуудсыг тээвэрлэлтийн захиалгыг гүйцэтгэхэд тогтоосон маягтын дагуу хөтөлнө;

2.15.2. тооцооны хуудсанд тайлант хоног бүрийн төгсгөлд тээвэрлэгч, ачаа илгээгч гарын үсэг зурж баталгаажуулна. Тооцооны хуудсанд заасан мэдээллийг ачаа илгээгч зөвшөөрөхгүй бол "Зөвшөөрөхгүй" гэж тэмдэглэл хийнэ;



2.15.3. тээвэрлэгч ба ачаа илгээгчийн тооцооны хуудсыг цахим хэлбэрээр хөтлөх үед харилцах нөхцөл журмыг тэдгээрийн хоорондох цахим хэлбэрээр бичиг баримт солилцох тухай гэрээг үндэслэн хөтөлнө;

2.15.4. тооцооны хуудасны загварыг тээвэрлэгч тогтооно;

2.15.5. тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан тооцооны хуудсыг 3 хувь үйлдэх бөгөөд захиалгын хүчинтэй хугацаа дуусгавар болоход дүгнэж 1 хувийг ачаа илгээгчид өгнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АЧААГ ТЭЭВЭРЛЭЛТЭД ХҮЛЭЭН АВАХ

3.1. Ачаа илгээгч нь төмөр замаар тээвэрлүүлэх ачааны сарын захиалгыг сар эхлэхээс 10 хоногийн өмнө, улирлаар хуваарилсан жилийн захиалгыг тухайн жил эхлэхээс 2 сарын өмнө тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад албан ёсоор ирүүлнэ. Ачаа илгээгч захиалгадаа ачааны нэр, төрөл, жин, илгээх ба хүрэх өртөө /зам/, экспортын ачаа очих улсын, орон нутгийн тээвэр очих замын нэрийг тодорхой заах ба эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.


3.2. Тээвэрлэгч /суурь бүтэц эзэмшигч/ нь экспортын ачааны хэмжээг очих ба дамжин өнгөрөх орны төмөр замтай сар бүр тохиролцно.

3.3. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллага нь дамжин өнгөрөх болон очих орны төмөр зам тухайн сард хүлээн авах боломжтой ачааны нэр, төрөл, тоо хэмжээнд нийцүүлэн ачилт хийхийг зөвшөөрсөн шуурхай шийдвэрийг тээвэрлэх төмөр замуудын харьяа тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга нарт өгч тээвэрлэлтийг зохион байгуулна. Энэхүү шуурхай шийдвэрийг үндэслэн ачаа илгээгч нь ачилтад вагон тавиулах захиалгаа илгээх тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргад өгнө. Илгээгчийн захиалгад ачих ачааны нэр, төрөл, тоо хэмжээ, вагон тавиулах салбар замын нэр, ачилт эхлэх хугацаа зэргийг тодорхой заасан байна.

3.4. Ачааг вагон, чингэлэг, жижиг илгээлтүүдээр тээвэрлэлтэд хүлээн авна.

3.5. Ачаа илгээгч нь орон нутагт төмөр замаар ачаа тээвэрлүүлэхэд захиалгын хуудас, /байгууллага бол албан бичиг/ падаан, орлох падааны хамт бөглөж, тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргаас зөвшөөрөл авч тооцооны газарт өгнө. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад тухайн ачааг ачиж дуусах хүртэл падаан нь ачаа илгээгчид байна.

3.6. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга нь илгээгчийн ачааг ачихад бэлэн эсэхийг тодруулж зөвшөөрөл өгөх үүрэгтэй. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын тооцооны ажилтан илгээгчээс захиалгыг хүлээн аваад "Захиалга хүлээн авах дэвтэр"-т бүртгэж өртөөний ачааны зохицуулагч, зохицуулагчгүй өртөөнд өртөөний жижүүрт бүртгүүлэхээр мэдэгдэнэ. Өртөөний ачааны зохицуулагч ба жижүүрт "Ачилтад вагон тавих захиалгын бүртгэлийн дэвтэр" хөтлөгдөнө.



3.7. Зайлшгүй тохиолдолд вагоны зогсолтыг багасгах зорилгоор зарим ачааны орон нутгийн тээвэрлэлтийг эрх бүхий албан тушаалтны шуурхай шийдвэрээр зохицуулж болно.

3.8. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч-ачаа илгээгч нь экспортын ачааны тээврийн падаанд үнийн баримт /счёт фактур/ заавал хавсаргахын дээр шаардлагатай бол баглаа, боодлын болон бусад онцлог шинжийг тодорхойлсон баримт /ачааны гарал үүслийн болон чанарын гэрчилгээ /-ыг хавсаргана.

3.9. Ачаа илгээгч нь мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн, малын тэжээл зэрэг ачааг экспортод тээвэрлүүлбэл мал эмнэлгийн гэрчилгээг орос, англи, эсхүл хүлээн авагч орны хэл дээр үйлдэж, падаанд хавсаргана. "Мал амьтан" гэдэгт гэрийн тэжээмэл болон зэрлэг амьтан, мөн түүнчлэн циркийн болон туршилт судалгааны зориулалттай амьтад багтана. "Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн" гэдэгт ангийн олдвор, ангийн арьс, мах, махан бүтээгдэхүүн, малын арьс шир, ноос ноолуур, дэл сүүл, хөөвөр, хялгас, яс, яс ба цусны гурил зэрэг орно. Өвс, хивэг, будаа, багсармал тэжээл зэргийг малын тэжээл гэнэ.

3.10. Ачаа илгээгч нь ургамлын гаралтай бүтээгдэхүүн болох төрөл бүрийн ургамал, хүнсний ногоо, жимс, ургамлын үр зэрэг ачааг төмөр замаар тээвэрлүүлэхэд ургамал хорио цээрийн гэрчилгээ /зөвшөөрөл/-г холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагаас зохих журмын дагуу авч тээврийн падаанд хавсаргана.

3.11. Тээврийн падаанд хавсаргасан баримтууд /зөвшөөрөл, гэрчилгээ, сертификат/ дээр бичсэн бичлэг, тоо, тэмдэглэл нь ямар нэг засваргүй, тод, уншигдахуйц байхын зэрэгцээ мэргэжлийн хяналтын байгууллагын тэмдэг, албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна. Хавсралт бичиг баримтны бүрдүүлэлтэд тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын тооцооны ажилтан хяналт тавина.

3.12. Ачаа ачих вагон ба чингэлгийн төрлийг тээвэрлүүлэгч сонгоно.

3.13. Тээвэрлэгчийн мэдлийн вагон, чингэлгийг тээвэрлэлтэд бэлтгэхийг тээвэрлэгч хариуцах ба тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээгээр ачаа илгээгч хариуцан гүйцэтгэж болно. Хэрэв вагон ба чингэлэг нь төмөр замын эзэмшлийн бус бол ачаа илгээгч тэдгээрийг тээвэрлэлтэд бэлтгэх үүргийг хүлээнэ.

3.14. Тээвэрлүүлэгч нь тухайн ачааг тээвэрлэхэд зориулагдсан тусгай зориулалтын нэмэлт тоноглолоор тоноглогдсон вагон, чингэлэгтэй байж болох ба тээвэрлэгчтэй гэрээ байгуулан тээвэрлэгчийн эзэмшлийн вагонд нэмэлт тоноглол хийж болно.

3.15. Ачааг вагонд ачсаны дараа ачилт гүйцэтгэсэн тал нь вагон, чингэлгийн гадна хана, вагоны явах анги, авто угсрааны хэсэгт байгаа ачааны үлдэгдлийг цэвэрлэнэ.



3.16. Ачаа тээвэрлэхээр сонгосон вагон ба чингэлэг нь тухайн ачааг ачиж тээвэрлэхэд тэнцэх, эсэхийг ачилт хариуцан гүйцэтгэж байгаа тал тогтооно. Үр тариа, мал, амьтан, ургамлын гаралтай хорио цээрийн тусгай зөвшөөрөл шаардсан ачааг энэхүү журмын 10 дугаар бүлэг /Хорио цээртэй ачааг тээвэрлэх/-т заасны дагуу тээвэрлэнэ.

3.17. Тээвэрлэгч ачаа илгээгчийн тухайн ачаа тээвэрлэхэд зориулсан вагон ба чингэлэг нь техникийн гэмтэлгүй, ачаа тээврийн зөрчилгүй, урьд өмнө ачсан ачааны бэхэлгээг авч, цэвэрлэгдсэн байна. Өртөө нь ачаа ачих вагоныг ачаа тээврийн болон техникийн үзлэгт оруулах ба уг вагон ачилтад тэнцсэн тохиолдолд тавьж өгнө.

3.18. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ачаа тээврийн ажилтан вагоныг ачилтад тавьж өгмөгц вагонд санамж нээж ачаа илгээгчид хүлээлгэн өгч, санамжид гарын үсэг зуруулна.

3.19. Ачаа илгээгч нь тээвэрлүүлэх ачаагаа MNS EN 12507:2015, MNS EN 13876:2015 стандартын /ачилтын техникийн нөхцөл/ дагуу баглаж боох, хайрцаг, торхонд хийх, савлаж уутлахаас гадна тоолох боломжтойгоор урьдчилан бэлдэх үүрэгтэй. Ачааг тээвэрлэлтэд бэлтгэхэд вагонд ачаа ачих, бэхлэх техникийн нөхцөлийн шаардлагыг баримтална.

3.20. Экспортод ачаа тээвэрлэхэд вагоныг гаалийн хяналтын талбайд тавьж ачуулна. Ачаа илгээгч нь гаалийн хяналтын бус талбайгаас ачилт хийлгэх бол гаалийн байгууллагад албан ёсоор хүсэлт гаргана. Гаалийн байгууллагын удирдах ажилтан илгээгчийн хүсэлтийн дагуу гаалийн байцаагч томилж, тэмдгээр баталгаажуулсан тохиолдолд төмөр замын байгууллага вагоныг гаалийн хяналтын бус талбайд тавьж экспортын ачааг ачуулна.

3.21. Аюултай ачааг тээвэрлүүлэхэд ачаа илгээгч нь Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журамд нийцүүлэн вагон, чингэлэг, ачааны байрт аюулын зэрэг, тэмдэглэгээний наадас заавал тавьсан байна.

3.22. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, вагон ба чингэлэг, ачааг гэмтээхгүй байх, ачих буулгах ажлыг механикжуулах боломжтой нөхцөлийг хангасан байхаар ачааг вагон ба чингэлэгт ачиж бэхэлнэ.

3.23. Вагон ба чингэлэгт ачаа ачихад зайлшгүй шаардагдах бэхэлгээний болон дагалдах хэрэгсэл /ачааг баглах боох утас, модон хаалт, зуух г.м/-ийг илгээгч бэлдэх ба эдгээрийг ачилтыг хариуцан гүйцэтгэж байгаа тал вагонд бэхэлж байрлуулна.

3.24. Нэг вагон ба чингэлэгт өөрийн шинж чанараараа нэг нь нөгөөгөө муутгах, гэмтээх ачааг хамт ачихгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

3.25. Вагон ба чингэлэгт ачааг ачихад ачилтын техникийн нормыг баримтална. Ачилтын техникийн норм нь тогтоогдоогүй ачааг вагон ба чингэлэгийн багтаамжийг дүүртэл ачих ба даац хэтрүүлж болохгүй.



3.26. Ачааг тээвэрлэлтэд өгөхдөө ачаа илгээгч падаанд ачааны жин, ширхэгийн ачаа бол ачааны байрын тоог заана. Ачааны жинг ачилтыг хариуцан гүйцэтгэж байгаа тал тодорхойлж падаанд заана. Вагон ба чингэлэгт ачсан ачааг жинлэх, стандартын сав баглаатай бол ачааны байр тус бүр дээр заасан жингийн нийлбэрээр тооцоолох эсвэл хэмжих хэрэгсэл ашиглах зэргээр тогтооно. Ачаа илгээгч нь ачааны жинг тодорхойлоход "тооцоолох", "хэмжих", "стандарт хэмжээгээр бодох" зэрэг аргыг хэрэглэнэ.

3.27. Вагонд ачсан ачаа нь өөрийн шинж чанараараа вагоны даацаас хэтэрч болзошгүй, мөн түүнчлэн овоолмог, нурмаг ачааны жинг заавал вагон пүүгээр тодорхойлно. Вагон пүүгүй бол 3.26 заалтыг мөрдөнө.

3.28. Цистернд ачсан шингэн ачааны төвшинг хэмжиж, эзлэхүүнийг нарийн хэмжүүрийн /калибровкийн/ тусгай хүснэгтийг ашиглан ачааны жинг тодорхойлно. Энэ үед илгээгч нь цистерн дэх ачааны төвшний өндөр, тухайн өдрийн температур, нягтыг падаанд тодорхой бичнэ.


3.29. Чингэлэг дэх ачааны жинг илгээгчийн тодорхойлсон жингээр тээвэрлэлтэнд хүлээн авах ба шаардлагатай үед жинлэж болно.

3.30. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааны байр бүрт төмөр замын тэмдэглэгээг /хүртвэрт нь явуулах ачааг тээвэрлэлтэд хүлээж авах дэвтэрт бүртгэсэн дэс дугаарыг бичиж зураас татаад байрын тоог бичиж, хуваарьт нь илгээх өртөөний кодыг бичнэ/ үйлдэнэ.

3.31. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ажилтан нь вагонд ачилт хийсний дараа вагоны хаалга, нээлхий хаагдсан, ачааг зөв ачиж бэхэлсэн, ломбодсон, ачааны нэр, төрөл нь падаанд заасантай тохирч байгаа зэргийг шалгаж вагоны хуудас бөглөнө. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ажилтан вагоны хуудсанд битүү вагон, цистерн, хоппер вагоны ломбоны тухай болон задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачсан ачаа бол "Ачааг зөв ачиж бэхэлсэн" гэсэн тэмдэглэл хийж нэрээ бичиж гарын үсэг зурна. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ажилтан нь тээвэрлэлтэд тэнцэхгүй сав, баглаатай болон техникийн нөхцөлийн шаардлага баримтлаагүй ачсан ачааг тээвэрлэлтэд хүлээн авахгүй бөгөөд зөрчлийг арилгатай санамжийг нээлттэй хэвээр үлдээнэ.

3.32. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ачаа тээврийн ажилтан нь вагоны хуудсыг санамжийн хамт тооцооны газарт тушааж, санамж хүлээлцэх дэвтэрт зохих бичлэг хийнэ. Санамж дээрх "ачиж дууссан" гэсэн хүснэгтийг бөглөхгүй бөгөөд ачаа илгээгч тээвэрлэлттэй холбоотой төлбөр тооцоог хийх үед нь тооцооны ажилтан хааж холбогдох тооцоог хийнэ. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ажилтан нь тээвэрлэлтэд тэнцэхгүй сав, баглаатай болон техникийн нөхцөлийн шаардлага баримтлаагүй ачсан ачааг тээвэрлэлтэд хүлээн авахгүй.

3.33. Экспортын ачааны падаанд "Гаалийн хяналтад байгаа" болон гаалийн байцаагчийн тэмдэг дарагдсан тохиолдолд явуулах өртөөнд тооцооны ажилтан хавсралт бичиг баримтын мэдээллийг үндсэн бичиг баримттай тулгаж шалган



вагоны хуудас, санамж, падааныг үндэслэн замын хүснэгт үйлдэж, тээврийн тооцоо хийнэ.

3.34. Илгээх өртөөнд ачаа илгээгч тээвэрлэлттэй холбоотой төлбөрөө төлсний дараа падаан, орлох падааны зохих хүснэгтэд илгээх өртөөний хуанлийн дардас дарж, орлох падааныг ачаа илгээгчид өгнө. Энэ нь тээвэрлэлтийн гэрээ байгуулсан нотолгоо болно.

3.35. Ачаа илгээгчийн хүсэлтээр ачааг тээвэрлэлтэд үнэ зарлаж хүлээн авч болно.

3.36. Задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачигдсан авто машин, техник болон өөрөө явагч техникийг тээвэрт хүлээн авахдаа тухайн ачааны амархан авагдах эд анги болон ломбоны тоог заасан жагсаалтыг 3 хувь бичүүлж, 1 хувийг нь кабины шилэнд дотор талаас нь харагдахуйцаар наана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ


ОРОН НУТГИЙН ХАРИЛЦААНЫ ТЭЭВРИЙН БИЧИГ БАРИМТ БҮРДҮҮЛЭХ

4.1. Тээврийн бичиг баримтад падаан, замын хүснэгт, орлох падаан, вагоны хуудас болон нөхөн илгээлтийн бичиг багтана. Энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан тээврийн бичиг баримтыг төмөр замаар орон нутгийн харилцаанд ачаа тээвэрлэхэд бүрдүүлж бичнэ. Төмөр замын тээвэрлэлтэд шаардагдах бичиг баримтуудыг бүрдэл болгосны дараа тээврийн бичиг баримтын маягт, хүснэгтийг асуултын дагуу тод, цэвэр гаргацтай бичиж гарын үсэг зурж тамга, тэмдэгээр баталгаажуулсан байна. Ачаа илгээгчээс тээвэрлэлтэд шаардагдах падаан болон хавсралт бичиг баримтыг хүлээн авч вагон хуудас, замын хүснэгтийг үйлдэнэ. Дээрх баримтуудыг цахим хэлбэрээр үйлдэж болох бөгөөд энэ тохиолдолд тоон гарын үсгээр баталгаажуулна. Цахим бичиг баримт нь цаасан падаантай ижил үүрэг гүйцэтгэнэ.

Нэгдүгээр хүснэгт

Орон нутгийн харилцааны тээврийн баримт бичиг

Хуудас №	Хуудсны нэр	Хэнд зориулсон	Хуудсны зориулалт
1	Эх падаан	Хүлээн авагчид	Ачааг хүрэх өртөө хүртэл дагалдана.
2	Орлох падаан	Илгээгч	Тээвэрлэлтийн гэрээ хийж дуусмагц ачаа илгээгчид олгоно.
3	Замын хүснэгт	Тээвэрлэгчид	Ачааг хүрэх өртөө хүртэл дагалдана.
4	Замын хүснэгтийн үлдэх хувь	Тээвэрлэгчид	Ачааг тээвэрт хүлээн авсан өртөөнд



4.2. Төмөр замаар орон нутгийн харилцаанд ачааг тээвэрлэх тээврийн бичиг баримт нь дараахь баримтуудаас бүрдэнэ:

4.2.1. "Падаан" нь ачаа илгээгч тээвэрлэгчийн хооронд байгуулсан гэрээ болно. Ачаа илгээгч нь нүүрэн талын тод шугамаар хүрээлсэн хэсгийг бичиж тээвэрлэгчид хүлээлгэж өгнө. Энэ падаан нь хүрэх өртөө хүртэл ачааны хамт дагалдан очиж хүлээн авагчид олгогдоно. Энэ олголтоор тээвэрлэлтийн гэрээ дуусгавар болно.

4.2.2. "Замын хүснэгт" нь замын хүснэгт, үлдвэр гэсэн 2 хуудаснаас бүрдэнэ. Падааныг үндэслэж замын хүснэгтийг үйлдэх бөгөөд эх хувь нь тээвэрлэгчид үлдэж хүрэх өртөөнд ачааны хамт очно. Ачааг олгох өртөө нь ачаа олгосон тухай замын хүснэгтийн зохих хүснэгтэд тэмдэглэл хийж ачаа хүлээлцсэнийг нотлож хүлээн авагчаар гарын үсэг зуруулна. Замын хүснэгтийн эх хувийг буулгалтын тайлантай үлдвэр хувийг ачилтын тайлантай тус тус тээвэрлэгчийн санхүү бүртгэл хариуцсан эрх бүхий байгууллагад явуулна.

4.2.3. "Орлох падаан" нь ачааг тээвэрлэгч тээвэрт хүлээн авсныг нотлох баримт болно. Орлох падааныг ачаа илгээгч, падааны хамт бөглөж тээвэрлэгчид өгнө. Орлох падааны тод хар хүснэгт дэх асуултуудыг ачаа илгээгч бөглөнө. Орлох падаанд илгээх өртөөний хуанлийн дардас дарж тээвэрлэгч нь ачаа илгээгчид өгнө.

4.2.4. "Вагон хуудас" нь тээвэрлэгчийн хувьд тээврийн бичиг баримтын нэг хэсэг байх болно. Вагон хуудсанд тухайн тээвэрлэгдэх ачаатай холбоотой өгөгдлүүд бичигдэнэ.

4.3. Тээврийн бичиг баримт засвартай балласан байж болохгүй. Тээвэрлэгч тээврийн бичиг баримтад өөрчлөлт хийх бол гарын үсэг болон өртөөний тэмдгээр баталгаажуулсан байна.

4.4. Падаан, орлох падааныг ачаа илгээгч үнэн зөв бичсэн эсэхийг тээвэрлэгч шалгах үүрэгтэй.

4.5. Тээвэрлэгч тээврийн бичиг баримтын маягтаар ачаа илгээгчийг хангана.

4.6. Падаан, орлох падаан, замын хүснэгт, замын хүснэгтийн үлдвэрийн бүх асуултуудыг үнэн зөв бөглөх бөгөөд тэдгээрт зориулагдсан хүснэгтэд багтаан бичнэ. Падааныг орлох падаантай, замын хүснэгтийг замын хүснэгтийн үлдвэртэй хамт бичнэ.

4.7. Дараахь ачаанд нэг тээврийн бичиг баримт үйлдэж болохгүй:

4.7.1. өөрийн шинж чанараар нэг вагонд тээвэрлэж болохгүй ачаануудад,

4.7.2. урьдчилан сэргийлэх тусгай нөхцөл сахих шаардлагатай ачаануудад,

4.7.3. ариун цэвэр, мал эмнэлэг болон бусад журмыг сахих шаардлагатай ачаануудад.

4.8. Тогтмол дулаант тусгай зориулалтын вагонд хялбар муудах ачааг тээвэрлэхэд ачааны вагон бүрт тээврийн бичиг баримт үйлдэнэ.

4.9. Тээврийн бичиг баримтын хүснэгт бүрт код бичихэд зориулагдсан тусгай нүд байна.



4.10. Ачаа илгээгч, тээвэрлэгч тээврийн бичиг баримтыг бүрдүүлнэ:

4.10.1. илгээгч орон нутгийн харилцааны тээврийн бичиг баримтын 2, 10-18, 21-24 хүснэгтийг доорх байдлаар бичнэ;

4.10.2. "2. хурд" хүснэгтэд "их", буюу "бага" /"ачааны"/ гэж бичнэ. Тухайн илгээлтийн ачаа их хурдтай тээвэрлэгдэж байвал тээврийн бичиг баримтын дээд, доод ирмэг нь улаан өнгийн эмжээртэй байна;

4.10.3. "10. явуулах өртөө" хүснэгтэд тээвэрлэгчийн тарифт заасан илгээх өртөөний бүтэн нэрийг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжинд өртөөний кодыг бичнэ;

4.10.4. "11. хүрэх өртөө" хүснэгтэд тээвэрлэгчийн тарифт заасан хүрэх өртөөний бүтэн нэрийг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжинд өртөөний кодыг бичнэ;

4.10.5. "12. илгээгч, түүний хаяг" хүснэгтэд илгээгчийн нэр ба түүний шуудангийн хаягийг товчлолгүйгээр тодорхой заана. Илгээгч нь иргэн буюу хуулийн этгээд байх бол түүний регистр, утасны дугаарыг бичнэ;


4.10.6. "13. хүлээн авагч, түүний хаяг" хүснэгтэд хүлээн авагчийн нэр ба түүний шуудангийн хаягийг товчлолгүйгээр тодорхой заана. Хүлээн авагч нь иргэн буюу хуулийн этгээд байх бол түүний регистр, утасны дугаарыг бичнэ;

4.10.7. "14. илгээгчийн марк, тэмдэг" хүснэгтэд тээвэрт хүлээлгэн өгөх ачаан дээр илгээгчийн марк тэмдэглэлийг хийсэн бол тухайн марк тэмдгийг заана. Ачааг чингэлгээр болон хоосон чингэлэг тээвэрлэх бол чингэлгийн төрөл, сери, дугаарыг бичнэ;

4.10.8. "15. байрын тоо" хүснэгтэд илгээлтэд орсон ачааны байрны тоог зааж бичнэ. Хэрэв илгээлтийг чингэлгээр тээвэрлэвэл хүртвэрт чингэлгийн тоо, даацыг хуваарьт чингэлэгт орсон ачааны байрын тоог бичнэ. Хэрэв задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан ачааны байрын тоо 100-гаас дээш бол "овоолмог", нурмагаар ачсан бол "нурмаг", юүлж ачсан шингэн ачааг "юүлмэг" гэж тус тус заана. Ачааг ачмагаар ачихад хүртвэрт ачмагийн тоог, хуваарьт нэг ачмагт орсон ачааны ширхэгийн тоог бичнэ;

4.10.9. "16. баглааны төрөл" хүснэгтэд ачааны сав, боодлын төрлийг заана. Жишээ нь: "хайрцаг", "торх", "сагс", "ачмаг" г.м. Ачааг чингэлгээр тээвэрлэвэл хүртвэрт "чинг" хуваарьт чингэлэгт ачсан ачааны сав, баглааны төрлийг заана;

4.10.10. "17. ачааны нэр" хүснэгтэд ачааны нэрийн нэгдсэн жагсаалт болон тарифт заасан ачааны нэрийг тодорхой зааж бичнэ. Тээвэрлэлтийн хэрэгсэл ашиглаж ачилт хийх үед ачааны нэрийн дор тусдаа мөрөнд хэрэглэсэн тээвэрлэлтийн хэрэгслийн нэр болон тоог бичнэ. Мөн ачааг илгээгчийн үйлчлэгчтэй тээвэрлэх үед үйлчлэгчийн нэр, регистрийн дугаарыг бичнэ. Цистерн болон бункерт вагонд шингэн ачаа тээвэрлэвэл ачааны өндөр, нягтрал, ачааны хэм зэргийг бичнэ. Чингэлэгтэй ачаа болон хоосон чингэлэг тээвэрлэвэл "чинг/ачааны нэр", "хоосон



чинг" гэж бичнэ. Аюултай ачаа тээвэрлэвэл тухайн ачааны ослын картын дугаар, аюултай ачааны мэдэгдэл, ачааны шифрийг ачааны нэрийн дор бичнэ;

Зөвлөмж: Ангиллын шифр 2112. Хэтрүү овортой ачаа бол оврийн индексийг бичнэ, жишээ нь индекс Н-223. Ачаа эзэмшигчийн буюу түрээсийн вагонд ачаа эзэмшигчийн зүтгүүрээр ачаа тээвэрлэвэл ачааны нэрийн дор "өөрийн вагонд", "түрээслэсэн вагонд", "ачаа эзэмшигчийн зүтгүүртэй вагонд" гэх мэтээр зааж бичнэ. Тээвэрлэгчийн хөдлөх бүрэлдэхүүн, вагоныг тоноглон ачаа тээвэрлэвэл энэ тухай /нэр, тоо, жин/ бичнэ. Мөн ачаа тээвэрлэлтийн дүрэм, тарифын мөрдлөг, ачаа байрлуулах болон бэхлэх техникийн нөхцөлд дурдсан бусад мэдээллийг заана. Хэрэв эдгээр мэдээллүүд нь энэхүү хүснэгтэд багтахгүй бол падааны "Илгээгчийн тэмдэглэл" хүснэгтэд бичнэ. Энэхүү хүснэгтийн баруун дээд буланд ачааны кодыг бичнэ;

4.10.11. "18. ачааны жин" хүснэгтэд ачааны жинг илгээгч тодорхойлсон бол илгээгч, төмөр замын байгууллага тодорхойлсон бол төмөр зам гэсэн зохих хүснэгтийг бичнэ. Чингэлэг, ачмаг буюу тээвэрлэлтийн бусад хэрэгсэл ашиглаж тээвэрлэх бол тэдгээрийн жин болон нийт жинг зааж бичнэ. Нэг илгээлтээр зөвшөөрөгдсөн хэд хэдэн ачаа тээвэрлэвэл ачаа тус бүрийн жин болон нийт жинг бичнэ;

4.10.12. "21. байрын тоо" /үсгээр/ хүснэгтэд тээврийн бичиг баримтын 18-р хүснэгтэд бичсэн байрын тоог үсгээр бичих буюу нурмаг, овоолмог, юүлмэг гэж байвал тэдгээрийг бичнэ;

4.10.13. "22. жингийн дүн" /үсгээр/ хүснэгтэд тээврийн бичиг баримтын 21-р хүснэгтэд заасан жингийн дүнг үсгээр бичнэ;


4.10.14. "23. жинг тодорхойлсон арга" хүснэгтэд жинг пүүлж эсвэл жинг тооцоолох аргаар тодорхойлсон аль нь болохыг бичнэ;

4.10.15. "24. илгээгчийн төлөөлөгч" хүснэгтэд тээврийн бичиг баримтад бичсэн зүйлийн үнэн зөвийг баталж илгээгчийн төлөөлөгч нэрээ бичиж, гарын үсэг зурна.

4.11. Тээвэрлэгч орон нутгийн харилцааны тээврийн бичиг баримтын хүснэгтийг доорх байдлаар бичнэ: /1, Ачаа хүргэх хугацаа, 3-9, 19-20, 25-32, тээвэрлэлтийн зай, 34-48/

4.11.1. "1. онцгой тэмдэглэл" хүснэгтэд тээвэрлэлтийн үед онцгой нөхцөл шаардагдан тээвэрлэдэг мэдэгдлүүдийг бичнэ. Жишээ нь: "Хамгаалалт", "Нөхөн илгээлт", "Довоос буулгаж болохгүй", "Халхлалттай", "Түргэн гэмтэх" гэх мэт;

4.11.2. "3. илгээлтийн төрөл" хүснэгтэд "| вагон | чингэлэг | жижиг |" эдгээр бичээсээс хэрэггүй зүйлийг чагталж дарна. Бүтэн вагоноор тээвэрлэх ачааг вагон илгээлтээр бол вагон, тусдаа вагон шаардлагагүй 5000 кг –аас бага жинтэй ачаа жижиг илгээлтээр бол "жижиг", чингэлэгт ачсан ачааг чингэлгийг илгээлтээр "чингэлэг" гэж тус тус бичнэ;



4.11.3. "4. төлөвлөгөөт гэрээний №" хүснэгтэд өртөөнд хөтөлж байгаа сарын төлөвлөгөө гэрээ буюу захиалгын дугаарыг заана;

4.11.4. "5. ачихыг зөвшөөрсөн" хүснэгтэд ачааг ачихыг зөвшөөрч огноог зааж тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга буюу орлогч гарын үсэг зурна;

4.11.5. "6. вагоны дугаар" хүснэгтэд вагоны арал дээрх дугаар болон вагон эзэмшигчийн товчилсон нэрийг бичнэ;

4.11.6. "7. вагоны төрөл" хүснэгтэд

Битүү вагоныг	кр	
Хагас вагоныг	пв	
Тавцант вагоныг	пл	
Цистерн вагоныг	цс	
Чингэлэг тээвэрлэгчийг	кт	
Хоппер вагоныг	хп	
Бусад төрлийн вагоныг	пр	гэж тус тус тэмдэглэнэ.

4.11.7. "8. даац" хүснэгтэд вагоны ханан дээр бичсэн даацыг бичнэ;

4.11.8. "9. голын тоо" хүснэгтэд тухайн ачаа тээвэрлэх вагоны голын тоог бичнэ;

4.11.9. "19. төмөр замын марклал" хүснэгтэд тээвэрт хүлээн авч байгаа ачаан дээр төмөр зам марклал хийсэн бол түүнийг бичнэ. Хийгээгүй бол бөглөхгүй;

4.11.10. "20. ачаалсан ачаалалтын техникийн норм" хүснэгтэд ачааг төмөр замын байгууллага ачаалсан бол "төмөр зам", илгээгч ачаалсан бол "илгээгч" гэж бичнэ. Мөн ачаа ачилтын техникийн нормыг тонноор заана;

4.11.11. "25. илгээхэд хураасан" хүснэгтэд ачааг илгээхэд хураасан хураамжийн дүнг үсгээр бичнэ;

4.11.12. "26. тооцооны хэлбэр" хүснэгтэд ачаа илгээх үед тооцоог бэлэн мөнгөөр хийсэн бол "бэлнээр", "бэлэн бусаар" хийсэн бол чек болон шилжүүлгийн дугаарыг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжинд кодыг бичнэ;


4.11.13. "27. тооцооны ажилтан" хүснэгтэд ачаа илгээх үед тээврийн хөлсний тооцоо хийсэн ажилтан нэрээ бичиж гарын үсэг зурна;

4.11.14. "28. олгоход хураасан" хүснэгтэд ачаа олгох үед хураасан хураамжийн дүнг үсгээр бичнэ;

4.11.15. "29. тооцооны хэлбэр" хүснэгтэд ачаа олгох үед тооцоог бэлэн мөнгөөр хийсэн бол "бэлнээр", "бэлэн бусаар" хийсэн бол чек болон шилжүүлгийн дугаарыг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжинд кодыг бичнэ;

4.11.16. "30. тооцооны ажилтан" хүснэгтэд ачаа олгох үед тээврийн хөлсний тооцоо хийсэн тооцооны ажилтан нэрээ бичиж гарын үсэг зурна;

4.11.17. "31. хавсаргасан баримтууд" хүснэгтэд ачаа илгээгчийн тээврийн бичиг баримтанд хавсаргасан бүх дагалдах баримтыг зааж хавсаргахаас гадна



хаягдал төмөрт тэсэрч дэлбэрэх зүйлгүй гэсэн тодорхойлолт, мал амьтанд мал эмнэлгийн бичиг, ургамлын гаралтай ачаанд ургамал хорио цээрийн бичиг, мод модон материалд байгаль орчны байцаагчийн зөвшөөрөл, хүнсний хялбар муудах ачаанд чанарын тодорхойлолт, баталгаа зэргийг тээвэрлэгч илгээгчээс шаардаж хавсаргана;

4.11.18. "32. тарифын бүлэг" хүснэгтэд тарифын мөрдлөгт заасан тухайн ачааны бүлгийг заана;

4.11.19. "тээвэрлэлтийн зай" хүснэгтэд тээврийн хөлсийг тарифын хамгийн богино зайгаар бодож тооцоолсон зайг бичнэ;

4.11.20. "34. илгээх үед" хүснэгтэд ачааг илгээх үед хураасан тээврийн хөлс, бусад хөлс хураамжийн нэрийг бичиж дүн болон бүгд дүнг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжин дотор кодыг бичнэ;

4.11.21. "35. олгох үед" хүснэгтэд ачааг олгох үед хураасан тээврийн хөлс, бусад хөлс хураамжийн нэрийг бичиж дүн болон бүгд дүнг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжин дотор кодыг бичнэ;


4.11.22. "36. ачих бэхлэх тухай" хүснэгтэд ачааны ачилтыг хариуцан хийсэн байгууллага энэ хүснэгтийг бичнэ. Вагонд ачааг ямар зураг техникийн нөхцөл, MNS 3084:2013 стандарт баримталж ачиж бэхлэснийг зааж, ачилтыг хариуцан хийлгэсэн албан тушаалтан түүний үнэн зөвийг баталж нэрээ бичиж гарын үсэг зурна;

4.11.23. "37. ломбоны тухай тэмдэглэл" хүснэгтэд тээвэрлэгч, илгээгчийн аль ломбодсон нь вагон, чингэлэг, автотехник, битүүмжилсэн ачаанд тавьсан ломбоны тоо, хяналтын тэмдэг, ломбыг хаана зүүснийг тус тус зааж бичнэ;

4.11.24. "38. төмөр замын тэмдэглэл" хүснэгтэд тээвэрлэлтийн явцад өртөөдөд гарсан саатал, сэлгэн ачилт хийсэн, ачааны бэхэлгээг зассан гэх мэт тэмдэглэгээг зааж бичнэ;

4.11.25. "39. илгээгчийн тэмдэглэл" Хэрвээ илгээгч ачааг үнэ зарлалттай тээвэрт хүлээлгэн өгсөн бол үнэ зарласан тухай тэмдэглэл хийх бөгөөд энэ тохиолдолд холбогдох тарифт заасны дагуу хураамж төлнө. Мөн энэ хүснэгтэд хүснэгтэд илгээгч зөвхөн ачаа хүлээн авагчид хамааралтай бусад тэмдэглэлийг хийнэ. Энэ нь төмөр замд ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээлгэхгүй. Жишээ нь: тээврийн бичиг баримтад засвар хийсэн тухай, үнэ зарлалттай ачаанд үнэ зарлалгүй тээвэрт хүлээлгэж өгсөн, түргэн гэмтэх ачааны тээвэрлэлтийн нөхцөл зэргийг зааж бичнэ. Мөн ачааг хаана, хэнд яаж олгох, ямар зам дээр олгох гэх мэт заалтыг илгээгч бичнэ;

4.11.26. "40. актын тухай тэмдэглэл" хүснэгтэд тээврийн болон ерөнхий маягтын акт тогтоох үед бичнэ. Тээврийн акт тогтоосон огноо, актын дугаар, ачааны ямар байдал /дутсан, гэмтсэн, муудсан/-д тогтоосныг бичнэ. Ерөнхий маягтын акт тогтоосон бол актын дугаар, огноог бичнэ;



4.11.27. "41. хаяг сольсон тухай тэмдэглэл" хүснэгтэд ачааны хаяг соливол хэдийд ямар шийдвэрээр хаяг сольсон тухай бичнэ. Шийдвэр өгсөн хүний албан тушаалыг товчилсон байдлаар, шийдвэрийн дугаар, огноог тооцооны ажилтан бичнэ;

4.11.28. "42. вагоныг буулгалтад тавьсан он, сар, өдөр, цаг" хүснэгтэд вагоныг салбар замд вагон тавьж өгөх, татаж авах гэрээгээр буулгалтад тавьж санамж нээсэн огноо, цагийг бичнэ. Тооцооны ажилтан санамжийг үндэслэн бичнэ;

4.11.29. "43. вагон, чингэлгийг буулгаж дууссан он, сар, өдөр, цаг" хүснэгтэд вагон чингэлгийг буулгаж дууссан огноог тээвэрлэгчийн эрх бүхий ачаа тээврийн ажилтны мэдэгдлээр тооцооны ажилтан санамжийг үндэслэн бичнэ;

4.11.30. "44. ачааг олгох үед хийсэн тэмдэглэл" хүснэгтэд ачааг ямар байдалтай олгосон тухай тэмдэглэлийг хийнэ. Ачааг бүрэн бүтэн олгосон бол "Ачааг бүрэн бүтэн олгосон" гэсэн тэмдэглэлийг хийнэ. Хэрэв олгох үед ачаа дутсан гэмтсэн муудсан бол тэр хэсгийг шалгаж ямар байдлаар олгосныг тогтоож тээврийн буюу ерөнхий маягтын акт тогтоож олгох ба хүрэх өртөөнд тогтоосон актын дугаарыг бичнэ;

4.11.31. "45. илгээх өртөөний хуанлийн тэмдэг" хүснэгтэд илгээх өртөөний хуанлийн дардсыг тооцоо хийсэн тооцооны ажилтан тод дарсан байна;

4.11.32. "46. хүрэх өртөөний хуанлийн тэмдэг" хүснэгтэд хүрэх өртөөний хуанлийн дардсыг ачааг өртөөнд ирмэгц хүрэх өртөөний тээврийн бичиг баримт хүлээн авч буй албан тушаалтан харагдахуйцаар дарна;


4.11.33. "47. ачаа ирсэн тухай мэдэгдэл" хүснэгтэд ачаа ирмэгц төмөр замаар ачаа тээвэрлэх журамд заасны дагуу ачаа хүлээн авагчид мэдэгдээд хэнд, ямар утсаар, хэзээ мэдэгдсэн тухай тэмдэглэлийг хийнэ;

4.11.34. "48. ачаа олгосон тухай тэмдэглэл, хуанлийн тэмдэг" хүснэгтэд хүлээн авагчид ачаа олгосон болон падаан /тээвэрлэлтийн гэрээний үндсэн баримт/ хүлээлгэж өгснийг нотлох баримт болгож хүрэх өртөөний хуанлийн дардас дарж, ачаа хүлээн авагч нэрээ бичиж гарын үсгээ зурна. Ачаа хүрэх өртөөний тооцооны ажилтан энэхүү хүснэгтийн тэмдэглэлийг заавал хийлгэх ба хийлгээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

4.12. Вагоны хуудас нь тээврийн бичиг баримттай тээвэрлэгдэх илгээлт тус бүрт үйлдэгдэх тээврийн бичиг баримтын салшгүй нэг хэсэг байна.

4.12.1. вагоны хуудсыг тухайн вагонд ачаа ачих үед тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ачаа тээврийн ажилтан үйлдэнэ;

4.12.2. вагоны хуудсан дахь илгээсэн өртөө, хүрэх өртөө, илгээгч, хүлээн авагчийн хаяг, онцгой буюу тусгай тэмдэглэл, вагонд ачсан ачааны жинхэнэ тоо хэмжээ, жин гэх мэт мэдээллийг үнэн зөв бөглөнө;



4.12.3. вагоны хуудсыг тээврийн бичиг баримтын хамт ачааг тухайн вагоноос буулгах хүртэл ачааг дагалдаж явуулна. Ачааг тухайн вагоноос буулгах буюу шилжүүлэн ачвал уг вагоны хуудас энэ ажиллагааг гүйцэтгэсэн тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын албан хэрэгт үлдэнэ;

4.12.4. вагоны хуудсыг тээврийн бичиг баримтад хавсаргана.

4.13. Нөхөн илгээлтийн бичиг баримтыг дараахь тохиолдолд үйлдэнэ:

4.13.1. олон улсын болон орон нутгийн харилцаанд тээврийн нэг бичиг баримтаар тээвэрлэж байгаа хэд хэдэн вагоноос техникийн болон ачаа тээврийн зөрчил, бусад шалтгаанаар үндсэн бичиг баримтаас саатуулах тохиолдолд саатуулагдсан вагонд, мөн зам зуурын өртөөнд нэг вагоны ачааг 2 вагонд шилжүүлэн ачих тохиолдолд 2 дахь вагонд нөхөн илгээлтийн бичиг баримт үйлдэнэ;

4.13.2. нөхөн илгээлтийн бичиг баримтад замын хүснэгтийг бөглөх бөгөөд замын хүснэгт нь ачааг дагалдаж хүрэх өртөөнд очно. Замын хүснэгтийн үлдэх хувь нь ачааг тээвэрлэгчид буюу нөхөн илгээлтийг хийсэн өртөөнд үлдэж тайланд оруулж тээвэрлэгчийн санхүү хариуцсан эрх бүхий байгууллагад хүргэгдэнэ.

4.14. Нөхөн илгээлтийн замын хүснэгтийг дараахь байдлаар бөглөнө:

4.14.1. замын хүснэгтийн "Онцгой тэмдэглэл" хүснэгтэд "Нөхөн илгээлт" гэж харагдахуйц бичнэ;

4.14.2. "онцгой тэмдэглэл" хүснэгтийг үндсэн илгээлтээс авч бичнэ;

4.14.3. "хурд" хүснэгтэд "их, бага" буюу "ачааны" гэж бичнэ;

4.14.4. замын хүснэгтийн 3-5 дахь хүснэгтийг бөглөхгүй;

4.14.5. замын хүснэгтийн 6-9 дэх хүснэгтийг энэхүү журмын 4.11.6, 4.11.7, 4.11.8, 4.11.9-т заасныг баримтлан бичнэ;

4.14.6. "илгээх өртөө" хүснэгтэд нөхөн илгээлт үйлдсэн өртөөний нэрийг бичнэ;

4.14.7. "хүрэх өртөө" хүснэгтийг энэхүү журмын 4.10.4-д зааснаар бичнэ;

4.14.8. "илгээгч, түүний хаяг" хүснэгтэд "Өртөөний дарга" гэж бичнэ. /нөхөн илгээлт үйлдсэн өртөөний дарга байна/;

4.14.9. "хүлээн авагч, түүний хаяг" хүснэгтэд "Өртөөний дарга" буюу "ДС" гэж бичнэ. Энэ нь хүрэх өртөөний дарга байна;

4.14.10. "ачааны нэр" хүснэгтэд "Ачаа хүлээн авагчийн нэр, хаяг, үндсэн илгээлтийн дугаар"-ыг бичнэ. Мөн тээврийн акт, ерөнхий маягтын акт, ломбоны тухай бичнэ;



4.14.11. "илгээх өртөөний хуанлийн дардас" хүснэгтэд нөхөн илгээлт хийсэн өртөөний хуанлийн дардсыг нөхөн илгээлт хийсэн огноогоор дарна;

4.14.12. нөхөн илгээлтийн замын хүснэгтийн 46, 47, 48 дахь хүснэгтийг энэхүү журмын 4.11.32, 4.11.33, 4.11.34-д заасны дагуу хүрэх өртөөнд бөглөнө;

4.14.13. энэхүү журмын 4.14.1-4.14.12-т заагдаагүй нөхөн илгээлтийн замын хүснэгтийн өгөгдлүүдийг бөглөхгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМААР БҮЛЭГ ВАГОНЫГ ТЭЭВРИЙН НЭГ БИЧИГ БАРИМТААР ТЭЭВЭРЛЭХ

5.1. Өртөө, илгээгч, хүлээн авагч нь ижил нэг төрлийн ачаатай бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар орон нутгийн харилцаанд тээвэрлэхэд энэ журмыг мөрдлөг болгоно.

5.2. Бүлгээр тээвэрлэгдэх ачааны тээврийн бичиг баримтад дагалдах хүснэгтийг хавсаргана.

5.3. Орон нутгийн харилцаанд нэг төрлийн ачаатай бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар ачаа илгээгчийн захиалгын дагуу тээвэрт хүлээн авна:

5.3.1. нэг төрлийн ачаатай бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар тээвэрт хүлээн авахдаа тээврийн бичиг баримтын 7-10 дахь хүснэгтэд "хавсралт хүснэгтийг үз" гэсэн бичилтийг хийнэ;


5.3.2. бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар тээвэрлэхдээ падааны хавсралт хүснэгтийг илгээгчээр бичүүлж илгээх өртөө хуанлийн дардас дарна;

5.3.3. "бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар тээвэрлэх хүснэгт" нь тээврийн бичиг баримтын салшгүй хэсэг байх ба падаан, орлох падаан, замын хүснэгт болон замын хүснэгтийн үлдвэрт тус тус хавсаргана;

5.3.4. тээврийн бичиг баримтын ачааны жин буюу 18 дахь хүснэгтэд тухайн бүлэг вагоны ачааны нийт жинг бичнэ;

5.3.5. аяллын явцад тээврийн нэг бичиг баримтаар тээвэрлэж байгаа бүлэг вагоноос техникийн болон ачаа тээврийн зөрчлөөр салах тохиолдолд хавсралт хүснэгтэд дурдсан салсан вагоны дугаарыг уншигдахаар дараад "38. Төмөр замын тэмдэглэл" хүснэгтэд актын дугаар болон ямар шалтгаанаар салсныг бичиж акт тогтооно;

5.3.6. вагон салгасан өртөө нь уг вагоныг нөхөн илгээлтээр үндсэн илгээлтийн араас явуулахын тулд бүх холбогдох мэдээллийг актнаас авч нөхөн илгээлтийн замын хүснэгтэд бичнэ;



5.3.7. тээврийн актын тухай үндсэн бичиг баримтад тэмдэглэл хийж актыг хавсаргаж явуулна;

5.3.8. бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар тээвэрлэх явцад хавсралт хүснэгтүүд үрэгдсэн тохиолдолд хүснэгтийг нөхөн хийж явуулна. Хүснэгтийг нөхөн хийсэн өртөө хуанлийн дардсыг дарна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРТ ЗАДГАЙ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН ДЭЭР АЧАА ТЭЭВЭРЛЭХ

6.1. Задгай хөдлөх бүрэлдэхүүн /хагас вагон, тавцант вагон/ дээр ачих ачаа нь тээвэрлэгчийн зөвшөөрч батлагдсан ачаа байна.

6.2. Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачих ачааны жагсаалтыг тээвэрлэгч гаргана.

6.3. Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачааг дараахь нөхцөлөөр тээвэрлэнэ:

6.3.1. хэмжээ, жингээрээ бусад төрлийн вагон, чингэлэгт тээвэрлэх боломжгүй савтай, ширхэгийн ачаа эсвэл хур тунадаснаас хамгаалах шаардлагагүй нурмаг ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр тээвэрлэнэ;

6.3.2. хур тунадасны нөлөө болон гадны хүчин зүйлээс болж гэмтэх, устах, вагоны эд ангийг гэмтээх, зам төмрийн хэлхээг таслах, ослын нөхцөл байдал бий болгохуйц шинж чанартай ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр тээвэрлэхгүй;

6.3.3. ачааны шинж чанар, түүнийг ачиж буулгах төхөөрөмжөөс хамааран ачаа илгээгч хөдлөх бүрэлдэхүүнийг сонгоно;

6.3.4. задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачааг ачиж бэхлэх техникийн нөхцөл, ачиж буулгах ерөнхий шаардлагуудыг баримтлан, вагоны бүрэн бүтэн байдлыг хангаж ачна;

6.3.5. задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачих ачаа нь техникийн нөхцөл, ачааны бүрэн бүтэн байдлыг хангахуйц сав, баглаа, боодолтой байна. Сав, баглаа, боодол, хучлага нь амархан шатах материалаар хийгдсэн байж болохгүй;

6.3.6. аюултай ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачихад Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмыг баримтална;

6.3.7. хар болон өнгөт металл, тэдгээрийн хайлшны хаягдал, үлдэгдлийг задгай хөдлөх бүрэлдэхүүнээр тээвэрлэхэд аюултай ачаа тээвэрлэх MNS 6276:2011, MNS EN 12561-1,2,3,4,5,6:2016 стандартын шаардлага хангасан байна.



Өнгөт металл болон тэдгээрийн хайлшны хаягдал, үлдэгдлийг 300 кг-аас багагүй жинтэйгээр шахаж багцлах буюу тусгай чингэлэгт тээвэрлэнэ;

6.3.8. жижиг ширхэглэл агуулсан ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачихын өмнө төмөр зам болон хүрээлэн байгаа орчныг бохирдуулахгүй, уг ачааны хорогдолгүй гэсэн баталгааг ачаа илгээгч гаргаж өгнө. Хагас болон тавцант вагоны хийцийн завсраар ачаа асгарч гоожихоор байвал ачаа илгээгч ачааны бүрэн бүтэн байдлыг хангах нэмэгдэл арга хэмжээг авна;

6.3.9. жижиг ширхэглэл агуулсан ачааг малгайлж ачихад ачааг хийсэх, нурахаас сэргийлж вагоны тэвшийг өндөрлөн тоноглож ачна. Ачаа илгээгч тоноглолын хийцийг ачааны төрлөөр нь гаргаж өгнө. Баяжуулах үйлдвэрт ялгалтад явж байгаа ачааны гадаргууг /ялгасан буюу ердийн нүүрснээс/ бусад бүх тохиолдолд ачаа илгээгч тээвэрлэлтийн нөхцөлд заасны дагуу чигжиж нягтруулж ачна. Энэ нөхцөлд малгайлалт нь трапец хэлбэртэй нуруулдаж ачсан байна. Малгайлалтын доод нягтруулсан хэсэг нь вагоны тэвшний дээд ирмэгээс илүү гарахгүй;

6.3.10. ачааг нягтруулах, чигжихэд механикжсан болон бусад аргыг хэрэглэж болно;

6.3.11. эрдэс, барилгын материалыг вагоны тэвшнээс дээш гарган ачих тохиолдолд малгайлалтын доод суурийн хэсэг нь вагоны тэвшний дээд ирмэгээс доош 50 мм-ээс багагүй зайд байна;

6.3.12. ачааны нягтруулалтыг механик болон бусад аргаар хийхэд ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж байна.


ДОЛДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМААР НУНТАГ, НУРМАГ БА ОВООЛМОГ АЧАА ТЭЭВЭРЛЭХ

7.1. Төмөр замаар тээвэрлэгдэх нунтаг, нурмаг ба овоолмог ачааны жагсаалтыг тээвэрлэгч тогтооно. "Нунтаг, нурмаг ба овоолмог" ачаа гэж үр тариа, нүүрс, жонш гэх мэт ачааны тоо, ширхэг, байрын тоог тогтоох боломжгүй ачааг хэлнэ.

7.2. Нунтаг, нурмаг ба овоолмог ачааны шинж чанар, баглаа, боодлоос хамааран тээвэрлэх хөдлөх бүрэлдэхүүний төрлийг сонгоно.

7.3. Нэг вагонд овоолмогоор тээвэрлэхээр мэдүүлсэн ачааны байрын тоо 100 ширхэгээс их болон байрын тоог тодорхойлох боломжгүй ачааг овоолмогоор хүлээн авна.



7.4. Хур тунадас, чийг ба тоос шорооноос хамгаалах шаардлагатай ачаа /гурил, үр тариа, цемент, эрдэс бордоо зэрэг/-г тусгай зориулалтын битүү вагон, тусгай зориулалтын чингэлэгт тээвэрлэнэ. Баглаа, боодолтой овоолмог ачааг тээвэрлэхэд битүү вагон ашиглаж болно. Битүү вагонд овоолмогоор тээвэрлэх ачааг илгээгч хаалганы хаалтыг тавьж суурилуулсан тохиолдолд тээвэрлэнэ. Битүү вагоны хаалганд овоолмог ачааг зайлуулахаар нурахаас хамгаалж хаалга хоорондын хөндийд сараалж, самбар, хаалт, хашлагыг бат бөх материалаар чанартай хийнэ.

7.5. Хур тунадас, чийгнээс хамгаалах шаардлагагүй ачааг тусгай зориулалтын вагон /думпкар, хоппер-дозатор зэрэг/-д нунтаг, нурмаг ба овоолмогоор тээвэрлэнэ. Тусгай зориулалтын вагонд ачааг тээвэрлэх ба түүн дотор битүү тэвштэй хагас вагон бол төмөр замын тээврийн бичиг баримтны "Илгээгчийн тэмдэглэл" хүснэгтэд "Тусгай зориулалтын вагонд _____/ачааны нэрийг заана/ тээвэрлэхээр хүлээн авагчтай тохиролцсон. Буулгах тоног төхөөрөмжтэй." гэж тэмдэглэнэ.

7.6. Нунтаг, нурмаг ачаа тээвэрлэх вагоны тэвш, ачих буулгах төхөөрөмж, нээлхийн тагийг ачаа гоожиж, асгарахгүйгээр нягт шахаж хаасан байна. Урьд тээвэрлэсэн ачааны үлдэгдлийг бүрэн цэвэрлэсэн, ломбодож битүүмжлэх төхөөрөмж нь гэмтэлгүй, нээлхий онгойхоос хамгаалсан төхөөрөмжийг хаасан байна. Нунтаг, нурмаг ачааг ачихын өмнө илгээгч ачаа гоожихгүй байхаар вагоныг чигжиж битүүлнэ.


7.7. Улсын мал эмнэлэг, хорио цээрийн хяналтан дор тээвэрлэх ачааг 10 дугаар бүлэг /Хорио цээртэй ачааг тээвэрлэх/-т зааснаар тээвэрлэнэ.

7.8. Үр тариа зэрэг чийгшилтэй тээвэрлэгдэх ачааг улсын MNS EN 12798:2015 стандартыг баримтлан тээвэрлэнэ.

Зөвлөмж: Үр тарианы тээвэрлэлтийг 17 хувь хүртэлх чийгшлээр нь тооцно. Үүнд: Үр тариа, шошны төрлийн ургамал-17 хувь хүртэл, хонхорцог хаягдал-15 хувь хүртэл, тослогт ургамлын үр - 10 хувь хүртэл, наранцэцгийн үр-8 хувь хүртэл бүх нөхцөл.

7.9. Нунтаг, нурмаг ба овоолмог ачааны тээвэрлэлтийн тээврийн бичиг баримтыг бүрдүүлэхэд эх падааны "Байрын тоо" хүснэгтийн алинд нь хамаарахыг ачаа илгээгчийн тодорхойлсноор "нунтаг нурмаг" буюу "овоолмог" гэж бичнэ.

7.10. Бага хэмд хөлдөх ачааг төмөр замаар тээвэрлэхэд ес дүгээр бүлэгт /Түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх/-т заасныг баримтална.



7.11. Бага хэмд хөлдөх, чийгшилтэй, овоолмог ба нунтаг, нурмаг ачааг хүйтний улиралд тээвэрлэхэд вагонд наалдахаас хамгаалах арга хэмжээ авна.

7.12. Овоолмог ба нунтаг, нурмаг ачааг хагас вагонд тээвэрлэхдээ нэг нээлхий дээрх ачааны даралтыг 6 тонноос ихгүй, нээлхийгээр буух ачааны хэмжээ 400x400 мм-ээс бага хэмжээтэй ачааг вагоны шалаар жигд тарааж трапец хэлбэрээр нуруулдаж ачна.

7.13. Овоолмог ба нунтаг, нурмаг ачааг тээвэрлэхээр ачилтыг хийж гүйцэтгэхдээ ачааны хэм нь хагас вагонд 100⁰С, битүү вагонд 80⁰С, тусгай зориулалтын бусад хоппер-дозатор, думкарт 100⁰С-аас тус тус ихгүй байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ЧИНГЭЛЭГТ АЧАА ТЭЭВЭРЛЭХ

8.1. Өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замаар бүх төрлийн чингэлгийн тээвэр гүйцэтгэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Зөвлөмж: Овор хэмжээ, хэв бичээс, дугаар, бохир жин, хийц нь стандартын дагуу хийгдсэн, ачаа ачих зориулалттай, ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж, нэг болон хэд хэдэн төрлийн тээврийн хэрэгслээр тээвэрлэж болох, ачиж буулгах, шилжүүлэн ачих үед механикжсан хэрэгсэл ашиглаж болохуйц тээврийн хэрэгслийг чингэлэг гэж ойлгоно.


8.2. Чингэлгүүдийг их, дунд, бага даацын гэж ангилахаас гадна түгээмэл ба тусгай зориулалтын гэж ангилна. Түгээмэл зориулалтын чингэлгээр ширхэгийн сав баглаа боодолтой олон нэр төрлийн ачаа, тусгай зориулалтын чингэлгээр зөвхөн 1 төрлийн болон тусгай нөхцөл шаардсан ачааг /цемент, шингэн, нурмаг г.м./ тээвэрлэнэ.

8.3. Чингэлгийн дугаар, хэв бичээс нь 2 мөрөөр бичигдсэн байна:

8.3.1. дунд даацын чингэлэг дэх эхний мөрний дугаар нь 9 оронтой тооноос бүрдэнэ. Эхний нэг оронтой тоо чингэлгийн төрөл хэмжээг, дараачийн 7 оронтой тоо нь чингэлгийн дэс дугаарыг, сүүлчийн 9 дэх орон нь хяналтын тоо /дугаар зөв бичигдсэнийг шалгах/-г тус тус заана. Хоёр дахь мөр нь 5 оронтой тооноос бүрдэх бөгөөд эхний 3 орон нь хэний эзэмшил болохыг, дараачийн 2 орон нь хийц, зориулалтыг харуулна.

Жишээ нь: 3 1999900 6;
804 00.

Тайлбар: 3 - бохир жин /3 тонн/;
1999900 - серийн дугаар;



6 - хяналтын тоо.

804- Украины эзэмшлийн чингэлэг;
00- хийцийн онцлог.

8.3.2. их даацын чингэлэг дэх эхний мөрөнд чингэлэг эзэмшигчийг тодорхойлох 4 үсгээс бүрдсэн товчилсон нэр, түүний дараа 6 оронтой тооноос бүрдсэн чингэлгийн дугаар, 7 дахь орон нь хяналтын тоог заана. 4 үсгэн бичээсийн сүүлчийн "U" үсэг нь ачааны чингэлэг гэсэн шинж чанарыг заана. Эхний 3 үсэг нь чингэлэг эзэмшигчийн олон улсын бүртгэлд албан ёсоор бүртгэгдсэн нэрийг заана. Хоёр дахь мөрөнд дугаар нь 2 хэсгээс бүрдэх ба үсгэн ба тоон гэсэн үсгээр тэмдэглэсэн хэсэг нь латин үсгээр эзэмшигч орны товчилсон нэрийг заана.

Жишээ нь: RZDU 1234569;
RU 2310.

Тайлбар: RZD - эзэмшигч төмөр замын код /Оросын төмөр зам/;
U - ачааны чингэлэг гэсэн шинж чанарыг агуулна;
123456 - чингэлгийн дэс дугаар;
9 - хяналтын тэмдэг.
RU - улсын код /Оросын Холбооны Улс/;
23 - чингэлгийн хэмжээсүүдийг харуулах код /2-урт-6058 мм, 3-өндөр-2591мм/;
10 - чингэлгийн төрөл /10-түгээмэл зориулалтын/

8.3.3. чингэлэг дээр дараахь хэв бичээсүүд байна:


- Хаалган дээр-Дээд бохир жин /MGW/, чингэлгийн өөрийн жин /TARE/ килограммаар /kg/, фунтаар /lb/ бичсэн байна. Жишээ нь: ICC төрлийн чингэлгийн дээд бохир жинг 24000 кг биш харин 24384 кг. Энэ нь фунтыг кг-д нарийвчлалтайгаар шилжүүлсэнтэй холбоотой ба зөвшөөрөгдөх хэмжээнд нөлөөлөхгүй.
- Хажуугийн ханан дээр: Ээлжит их засвар хийгдсэн хугацааг /он, сар/ бичнэ.

8.5. Чингэлгийн гадна, дотор талын хэмжигдэхүүнийг энэхүү журмын 3 дугаар хавсралтад үзүүлэв.

8.6. Чингэлгээр тээвэрлэх ачааг тээвэрт хүлээн авах

8.6.1. их болон дунд даацын чингэлгээр ачаа тээвэрлэхэд багц дүрмийг баримтлан тээвэрлэнэ;

8.6.2. тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ачаа тээврийн ажилтан ачаа илгээгчээс өгсөн захиалгын дагуу тээвэрлэх ачаанд нь тохирох чингэлгийг ачилтад



тавьж өгч ачуулна. Дунд, их даацын түгээмэл чингэлгээр жижиг илгээлтийн ширхэгийн ачааг савлалгүйгээр, буюу хялбарчилсан савлалттайгаар, анхдагч сав, баглаа, боодлоор тээвэрлэнэ. Боодлын хатуулгатай цаасан уут, картон хайрцаг, модон жийрэг, сараалжин модон хайрцаг зэргээр дараахь нэр төрлийн барааг чингэлгээр тээвэрлэж болно. Үүнд: өргөн хэрэглээний төрөл бүрийн бараа /бэлэн хувцас, бөс даавуу, сүлжмэл эдлэл, жижиг бараа, төрөл бүрийн чихэр, эмийн бараа, радио болон цахилгаан бараа, ном гэх мэт/, үйлдвэрлэлийн зориулалтын бүтээгдэхүүн /машины сэлбэг хэрэгсэл, багаж, будгийн зүйлс, химийн хайрцаглаж савласан бүтээгдэхүүн, овор хэмжээ багатай тоног төхөөрөмж/, иргэдийн гэр ахуйн хэрэглэл орно;

8.6.3. ачих ачаа нь чингэлгийг гэмтээж бохирдуулахааргүй байвал зохино. Эвгүй үнэртэй, нойтон давсалсан арьс шир зэргийг ачихгүй байхыг хатуу анхаарна;

8.6.4. чингэлэгт ачиж байгаа ачаа нь сав баглаа боодолтой, хэд хэдэн төрлийн ачааг хамт ачсан тохиолдолд бусад ачааг гэмтээхгүй, бохирдуулахгүй байх шаардлагыг хангасан байна;

8.6.5. сэлбэг хэрэгсэл, зэврэлтээс хамгаалж тосолгоо хийсэн, материал техникийн хангамжийн төмөрлөг эдлэхүүнийг ачихын өмнө ачаа илгээгч нь зузаан цаас, зориулалтын бусад зүйлээр чингэлгийн хана, шалыг доторлож бохирдолт, гэмтлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй. Чингэлгийн хана, шалыг бохирдуулах гэмтээж болох ачаа ачсан тохиолдолд шаланд нь дэвсгэр, хананд нь жийрэг бүтээлэг хэрэглэнэ;


8.6.6. шингэн ачааг чингэлэгт тээвэрлэхэд сав /модон, төмөр торх, хуванцар сав/ нь эвдрэхгүй байх давуу талыг харгалзана. Шилэн савтай шингэн ачааг тээвэрлэхэд гадна талд нь хатуу цаасан хайрцаг, модон сагс бусад баглаа боодлыг хэрэглэнэ;

8.6.7. их даацын чингэлэгт ачих ачааны нэг байрын жин 1500 кг-аас ихгүй байна. Дунд даацын чингэлэгт ачих ачааны жин нь 120 кг-аас хэтрэхгүй байна;

8.6.8. чингэлэгт түргэн муудах ачаа тээвэрлэхэд энэхүү журмын ес дүгээр бүлэг /Түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх/-т заасныг баримтална;

8.6.9. чингэлэгт аюултай ачаа тээвэрлэхэд Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмыг баримтална;

8.6.10. чингэлэгт ачсан ачааны жинг чингэлгийн даац /хэв бичээст заасан даац/-аас хэтрүүлэхгүйгээр ачуулна. Чингэлэгт ачих ачааны жинг ачаа илгээгч тодорхойлох бөгөөд үнэн зөв мэдүүлнэ. Шаардлагатай бол төмөр замын байгууллага ачааны жинг тодорхойлж болно;



8.6.11. чингэлэгт ачаа ачиж дууссаны дараа чингэлгийг энэхүү журмын 18 дугаар бүлэг /Вагон, чингэлэг ломбодох/-т заасны дагуу ломбодно;

8.6.12. чингэлгээс ачааг буулгасны дараа тээвэрлүүлэгчээр ачааны үлдэгдэл, сав, баглаа боодол, бэхэлгээний үлдэгдлийг цэвэрлүүлж хүлээн авна;

8.6.13. чингэлэгт ачаа ачихын өмнө үзлэг хийж техникийн байдлыг тодорхойлно. Суурь бүтэц эзэмшлийн чингэлэгт ачаа ачих үед техникийн болон ачаа тээврийн үзлэгийг тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан хийж ачилтанд өгнө. Ямар нэгэн гэмтэл илэрвэл акт тогтоох ба тухайн ачаанд тохирохгүй бол өөр чингэлэг сольж өгнө;

8.6.14. чингэлгээр үнэ зарласан ачааг тээвэрлэхэд энэхүү журмын 15 дугаар бүлэг /Үнэ зарласан ачааг тээвэрлэх/-т заасныг баримтална;

8.6.15. чингэлэгт тээврийг чингэлэг тээвэрт нээлттэй өртөөдийн хооронд гүйцэтгэх ба чингэлэг тээвэрт хаалттай өртөөнд зөвхөн онцгой нөхцөлд ачаа хаяглаж болох бөгөөд тээвэрлүүлэгчийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр гүйцэтгэнэ. Чингэлэг тээвэрт нээлттэй өртөөдийн жагсаалтыг суурь бүтэц эзэмшигч тогтооно;

8.6.16. чингэлэгт ачааг ачихад хана, шаланд өгөх даралт жигд, гулсахгүй, чингэлгийн хаалга чөлөөтэй хаагдаж, нээгдэж байхаар ачаална;

8.6.17. нийтийн хэрэглээний салбар зам, талбайд ачилт, буулгалтын ажиллагааг төмөр замын хүч хэрэгсэлээр, дагнасан хэрэглээний салбар замд ачих, буулгах ажлыг илгээгч, хүлээн авагчийн хүч хэрэгсэлээр гүйцэтгэнэ Ачааг чингэлэгт ачих, буулгах ажлыг илгээгч, хүлээн авагч өөрсдөө гүйцэтгэнэ. Чингэлгийг вагон буюу автомашинд ачих, буулгах ажлыг тээвэрлэгч гүйцэтгэнэ;

8.6.18. илгээгч чингэлэгт ачаа ачихад ачаа тус бүрийн үнэ, байр бүрт байгаа ачаа барааны нэрийг нэг бүрчлэн үнэн зөв бичсэн жагсаалт үйлдэж, чингэлэг болгоны дотор хийх бөгөөд энэ жагсаалт нь илгээгчийн гарын үсэг, тэмдгээр баталгаажсан байна;

8.6.19. ачаа илгээгчийн агуулахаас ачигдаж ирсэн ачаатай чингэлгийг нийтийн хэрэглээний зам, талбайд хүлээн авахад чингэлэгт гадна үзлэг хийж, чингэлгийн байдал, ломбо зэргийг шалган хүлээж авна;

8.6.20. вагонд чингэлгийг иж бүрдлээр ачна. Вагоны багтаамжийг боллоцоогоор нь бүрэн ашиглана;

8.6.21. вагонд ачих чингэлгийн иж бүрдлийг техникийн нөхцөлийн дагуу бүрдүүлнэ.



8.7. Чингэлгийн тээвэрлэлтийн падаан бөглөх.

8.7.1. ачаатай явах чингэлэг бүрт илгээгч падаан бичнэ. Падаан нь чингэлгийн тээвэрлэлтийн үндсэн бичиг баримт /гэрээ/ мөн. Ачаа илгээгч болон тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ачаа тээврийн ажилтан падааны бүх хүснэгтийг бүрэн бөглөсөн байна.

8.7.2. чингэлгийн падааныг энэхүү журмын 4 дүгээр бүлэг /Орон нутгийн харилцааны тээврийн бичиг баримт бүрдүүлэх/-т заасны дагуу гүйцэтгэнэ.

8.7.3. олон улсын харилцаанд хоосон их даацын чингэлгийг тээвэрлэх үед тээврийн бүрэн бичиг баримттайгаар тээвэрлэнэ.

8.7.4. орон нутгийн харилцаанд хоосон чингэлэг тээвэрлэхэд тээврийн бичиг баримт үйлдэн тээвэрлэнэ.

8.7.5. Чингэлэг ачсан вагон бүрт вагоны хуудас бичнэ.

8.8. Ачаа илгээгч, хүлээн авагч чингэлгээр тээвэрлэх ачааны хүрэх өртөөг өөрчлөх тухай бичгэн хүсэлт тээвэрлэгчид ирүүлснээр энэхүү журмын 20 дугаар бүлэг /Илгээлтийн хаяг солих/-т заасны дагуу хаягийг солино.

8.9. Чингэлэгтэй ачаа нь хүргэх хугацаандаа ирээгүй тохиолдолд хүлээн авагчийн хүсэлтийн дагуу эрэл хийж чингэлэг байгаа газар, саатсан шалтгааныг тодруулж хариу өгнө.

8.10. Чингэлэгтэй ирсэн ачааг олгох, авто тээврээр үйлчлэх

8.10.1. чингэлгээр тээвэрлэн ирсэн ачааг олгохдоо чингэлгийн ломбыг шалгаж ачаа хүлээн авагчид хүлээлгэн өгөх ба ачаа хүлээн авагч хүсвэл тээвэрлэгчийн эрх бүхий ачаа тээврийн ажилтан байлцуулан тоолж хүлээлгэж өгнө.

8.10.2. ачаа нь дутсан, гэмтсэн байвал тээврийн акт тогтооно.

8.10.3. чингэлгээр ирсэн ачааг хүлээн авагчийн хүсэлтээр автотээврийн хэрэгслээр тухайн байгууллагын ачаа буулгах байр, агуулах хүртэл хүргэж өгч болно.

8.10.4. гаалийн бүрдүүлэлт хийгдэх бол гаалийн байгууллага шалгаж ачааг эзэнд нь олгохыг зөвшөөрсөн тухай тэмдэглэл хийгдсэний дараа олгоно.

8.10.5. чингэлэгтэй ачааг холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, төлбөр тооцоог хийж дууссаны дараа талбайгаас гаргана.

8.10.6. байгууллагаас татаж авчрах чингэлгийг ачааны үлдэгдлээс цэвэрлүүлж, техникийн үзлэг хийж хүлээн авна.



8.11. Чингэлгээр ачаа тээвэрлэх үед тээврийн хөлс болон бусад хураамжийг тогтоосон тарифын дагуу хураана.

8.11.1. тээвэрлэлтийн болон нэмэгдэл төлбөрийн тооцоог ачаа илгээх, хүрэх өртөөнд хийх ба хөлсийг бэлэн мөнгө, шилжүүлэг, төлбөрийн карт, нэхэмжлэлээр тооцно;

8.11.2. олон улсын төмөр замын ачааны харилцаанд чингэлэг ашигласны төлбөрийг Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагаас баталсан Вагон эдэлгээний дүрмийн дагуу тээвэр зуучлагчтай тооцно;

8.12. Чингэлгээр ачаа тээвэрлэх захиалгыг энэхүү журмын 2 дугаар бүлэг /Ачааны захиалга хүлээн авах, зөвшилцөх/-т заасны дагуу байгууллага, иргэдээс хүлээн авна.

8.13. Чингэлэг тээвэрлэлтийн тайланг тээвэрлэгч сар, улирал, жилээр гаргана.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ТҮРГЭН ГЭМТЭЖ, МУУДАХ АЧААГ ТЭЭВЭРЛЭХ

9.1. Түргэн гэмтэж, муудах ачааг тусгай зориулалтын /хөргүүрт, тогтмол дулаант зэрэг/ болон тээвэрлэлтийн шаардлага хангасан битүү вагонд тээвэрлэнэ.

Зөвлөмж: Түргэн гэмтэж, муудах ачаа гэж төмөр замаар тээвэрлэх үед гадны температурын нөлөөлөл, арчилгаа үйлчилгээний хүчин зүйлийн улмаас гэмтэж чанар нь алдагдах эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүнийг ойлгоно.

9.2. Олон улс болон орон нутгийн тээврээр түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэхдээ Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээрийг мөрдөнө.

9.3. Ачаа илгээгч нь ачааг тээвэрлэлтэд хүлээлгэж өгөхдөө ачаа тээвэрлэх хугацаа, тээвэрлэх үеийн цаг агаарын нөхцөл, байдлыг харгалзан тухайн төрлийн ачааг тээвэрлэх хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг сонгоно.

9.4. Түргэн гэмтэж, муудах ачааны сав, баглаа, боодолд дараахь шаардлагыг тавина.

9.4.1. тээвэрлэлтэд хүлээлгэн өгөх ачаа MNS EN 12798:2015 стандарт, чанарын шаардлага хангасан байна;

9.4.2. тээвэрлэлтэд хүлээлгэн өгөх ачааны сав, баглаа, боодол нь бат бөх, гэмтэж, бохирдоогүй, ачаа асгарч гоожсон шинж тэмдэггүй, гар болон механикжсан аргаар ачих буулгах боломжийг хангасан байна;



9.4.3. түргэн гэмтэж, муудах ачааны сав, баглаа, боодол дээр давхарлаж хураах тоо, хадгалалтын нөхцөл зэргийг тогтоосон тэмдэглэлүүд байх шаардлагатай;

9.4.4. түргэн гэмтэж, муудах ачааг модон буюу хатуу цаасан хайрцаг, сагс, тор, тусгай тавиур, бидон, торх гэх мэтийн сав, баглаа, боодолтой тээвэрлэнэ. Тухайлбал, төмс, лууван, манжинг хайрцаг болон шуудай савтай, улаан лооль, манжин, сармис, өргөст хэмх, алим, усан үзэм, нимбэг, бэрсүүт жүржийг хайрцагтай тээвэрлэнэ;

9.4.5. түргэн гэмтэж, муудах ачааг хураах өндрийг тогтоохдоо илгээгчийн заалтыг үндэслэнэ. Ачаа илгээгчийн зөвшөөрөлтэйгээр төмс, манжин, тарvas зэрэг ачааг битүү вагон дотор овоолж хурааж тээвэрлэхийг зөвшөөрнө;

9.4.6. Ачаа илгээгч нь тээврийн бичиг баримтад, чанарын гэрчилгээ, холбогдох бусад бичиг баримтыг хавсаргаж, тээвэрлэх нөхцөлд тохирох тухай тодорхойлолтыг тээвэрлэгчид гаргаж өгнө;

9.4.7. түргэн гэмтэж, муудах ачаа илгээгч нь падааны "илгээгчийн онцгой тэмдэглэл" гэсэн хүснэгтэд түргэн гэмтэж муудах ачаа гэсэн тэмдэглэл хийж, тээвэрлэх нөхцөлийг заасан байна;

9.4.8. ачаа илгээгч нь вагон тавиулахаар захиалсан хугацаанд ачаагаа ачуулах газарт зөөвөрлөж ирүүлсэн байна;

9.4.9. ачаа илгээгч ачааг өртөөнд зөөвөрлөж ирүүлэх үед хөлдөх, хэт халахаас хамгаалсан байна;

9.4.10. вагоныг ачих буулгах үед ариутгалыг ачаа илгээгч болон хүлээн авагчийн хүч, хэрэгслээр гүйцэтгэнэ.


9.5. Түргэн гэмтэж, муудах ачааг зориулалтын вагонд тээвэрлэнэ.

9.5.1. Түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэхэд битүүмжлэл сайтай, ачааны үлдэгдлээс бүрэн цэвэрлэгдсэн, хаалга нь бүрэн хаагддаг, хана шалан дээр хадаасгүй, агааржуулах нээлхий нээгддэг, бүрэн бүтэн вагоныг ачилтад тавьж өгнө;

9.5.2. Вагоны ариутгалыг тээвэрлүүлэгчийн хүч, хэрэгслээр гүйцэтгэнэ;

9.5.3. Ачаа илгээгч нь вагон, чингэлгийн их бие дээр түргэн гэмтэж, муудах ачааны наадас наана.

9.6. Ачааг тээвэрлэлтэд хүлээн авах.





9.6.1. тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан нь тээвэрлэлтэд хүлээж авах үед ачааны чанар, байдлыг гадаад үзлэгээр шалгаж, муудаж чанар нь алдагдсан эвгүй үнэртэй, исэлдсэн, хөлдсөн, сав баглаа боодол гэмтсэн эсэх, асгарч гоожсон зэрэг шинжүүд илт мэдэгдэж буй ачааг тээвэрлэлтэд хүлээн авахаас татгалзах эрхтэй;

9.6.2. ачааны байранд үзлэг хийх үед сав, баглаа, боодлыг задлах, үзлэг дууссаны дараа битүүмжлэх, дахин хураах ажиллагааг ачаа илгээгчийн хүч, хэрэгслээр гүйцэтгэнэ;

9.6.3. нэг вагон болон чингэлэгт шинж чанар болон тээвэрлэх нөхцөлийн хувьд хоорондоо харшлахгүй, эвгүй үнэргүй ачааг хамт тээвэрлэхийг зөвшөөрнө. Хамт тээвэрлэхийг хориглосон ачааны жагсаалтыг тээвэрлэгч тогтооно;

9.6.4. хамт ачиж болохгүй ачааг илгээгч тээвэрлэлтэд өгвөл ачилт хүлээн авах, тээвэрлэлт хийхээс татгалзах эрхтэй;

9.6.5. тээвэрлэлтийн өөр өөр нөхцөл шаардагдах түргэн гэмтэх муудах ачааг нэг вагон болон чингэлэгт тээвэрлэхгүй байхыг хатуу анхаарна.

9.7. Түргэн гэмтэж, муудах ачааг ачих

9.7.1. хайрцаг савтай ачааг тээвэрлэлтийн замд нурж унахааргүй, тогтвортой байрлуулж, шаардлагатай тохиолдолд бэхэлж /ачааг вагон, чингэлэгт ачих, бэхлэх техникийн нөхцөлийн шаардлагын дагуу/ вагонд ачна.;

9.7.2. илгээгч хүссэн тохиолдолд агааржуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хураалтын эгнээ хооронд тодорхой хэмжээний зайтай хураах ба ачааны байр эгнээ хооронд нурж унахаас хамгаалсан зөв өрөлт эсвэл нэмэлт бэхэлгээтэй байна;


9.7.3. хураалтын эгнээний багц хооронд 150 мм-ээс илүү зайтай байвал бэхэлгээ хийнэ;

9.7.4. бэхэлгээ хийх үед вагон, чингэлгийн төмөр хананд хадаас хадахгүй байхыг хатуу анхаарна;

9.7.5. сав баглаатай ачааг вагоны хаалганаас 25 см зайтай хураана. Хаалганы зайд ачаа нурахаас хамгаалж 4 см-ээс багагүй зузаантай банзаар хашлага хийнэ;

9.7.6. вагон, чингэлэгт ачих ачааны жин нь тээврийн хэрэгслийн тэвш дээр тэмдэглэсэн даацаас хэтрээгүй байна.

9.8. Түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх



9.8.1. өртөөний дарга нь түргэн гэмтэх муудах ачаатай вагоны сэлгээний ажлыг шуурхай гүйцэтгэх болон тээврийн бичиг баримт бэлэн болсноос хойш эхний галт тэргээр явуулах, илгээгч хүссэн тохиолдолд ачааны хурдан галт тэргэнд холбох ажлыг шуурхай зохион байгуулах үүрэгтэй;

9.8.2. түргэн гэмтэж, муудах ачаатай вагоныг галт тэрэгний бүрэлдэхүүнээс тээвэрлэлтийн замд салгахгүй байхыг хатуу анхаарч ажиллана. Вагонд гарсан гэмтлийг аль болохоор галт тэрэгний бүрэлдэхүүнээс салгахгүйгээр засварлах бөгөөд зайлшгүй салгах шаардлагатай бол тээвэрлэгчийн эрх бүхий ажилтны шийдвэрээр гүйцэтгэхийг зөвшөөрнө;

9.8.3. түргэн гэмтэж муудах ачааны хаяг солихдоо ачаа хүргэх хугацааг харгалзан тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр энэхүү журмын 20 дугаар бүлэг /Илгээлтийн хяаг солих/-т заасны дагуу гүйцэтгэнэ;

9.8.4. түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх хурдыг ачаа илгээгч тодорхойлно;

9.8.5. ачаа илгээгч нь дулааны улиралд тээвэрлэлтийн замд ачааны агааржуулалтыг хангах зорилгоор хажуугийн нээлхийнүүдийг онгойлгож, сараалжин төмрийг вагоны дотор талаас онгойхооргүй бэхэлсэн байна.

9.9. Түргэн гэмтэж, муудах ачааг олгох

9.9.1. гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу түргэн муудах ачаатай вагон ирэх тухай ачаа хүлээн авагчид урьдчилан мэдэгдэж, вагон өртөөнд ирснээс хойш 2 цагийн дотор ачаа хүлээн авагчийн хүлээн авч буулгах зам дээр тавьж өгсөн байна;

9.9.2. шилэн сав болон лаазалсан савлагаатай бүтээгдэхүүний сав, баглааны битүүмжлэл бүрэн бүтэн ирсэн нөхцөлд задалж шалгахгүйгээр тоо ширхэгийн дагуу хүлээлгэн өгнө;

9.9.3. түргэн гэмтэж, муудах ачааг ачаа хүлээн авагчийн агуулах, талбайд хадгална. Зайлшгүй шаардлагатай бол зөвхөн ачаа илгээгч болон хүлээн авагчийн хүсэлтээр тээвэрлэгчийн агуулахад хадгалахыг зөвшөөрнө. Ачаа илгээгч, хүлээн авагч нь тогтоосон хугацаанд ирж агуулахаас ачаагаа аваагүйн улмаас ачаа гэмтэж муудсан бол тээвэрлэгч хариуцлага хүлээхгүй;

9.9.4. вагонд хийгдсэн нэмэлт тоноглол бэхэлгээг вагон, чингэлгээс салгах, буулгах, мөн түүнчлэн суларсан вагоныг цэвэрлэх, ариутгах ажиллагааг ачаа хүлээн авагчийн хүч хэрэгслээр гүйцэтгэнэ.

9.10. Түргэн гэмтэж, муудах ачааг хүйтний улиралд тээвэрлэх



9.10.1. тээвэрлүүлэгчийн хүч хэрэгслээр дулаалга хийж бэлдсэн битүү вагонд тээвэрлэхийг зөвшөөрнө. Хүйтний улиралд дулаалгатай болон ердийн вагон, чингэлэгт тээвэрлэсний улмаас ачаа гэмтэж муудсан тохиолдолд, хохирлын нэхэмжлэлийг гаргахгүй тухай ачаа илгээгчийн ирүүлсэн бичгэн мэдэгдлийг /баталгааг/ үндэслэн тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтан нь ачилтын талаар шийдвэр өгнө;

9.10.2. хүйтний улиралд түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх зорилгоор зуух тавьсан галлагаатай вагоныг явуулах бол, уг вагоны тээвэрлэлтэд тэнцэх эсэхийг тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагууд, /тээвэрлэлт, хамгаалалт, засвар үйлчилгээ/ оролцсон комисс тогтоож акт үйлдэнэ. Галлагаатай вагоныг зөвхөн тээвэрлэгчийн эрх бүхий байгууллага /тээвэрлэлт, ачих буулгах ажил хариуцсан/ тусгай байдлаар тоноглож, тээврийг зохион байгуулж, галын аюулгүй байдалд хяналт тавина;

9.10.3. галлагаатай вагоны ачаа хүргэгч нь өөрийн хариуцаж яваа вагоны ачааны бүрэн бүтэн байдал, галын аюулгүй байдлыг хариуцна;

9.10.4. тээвэрлэгчийн хамгаалалт хариуцсан эрх бүхий байгууллага нь улиралд нэг удаа галлагаатай вагоны галын аюулгүй байдалд хяналтын үзлэг хийнэ.


АРАВДУГААР БҮЛЭГ ХОРИО ЦЭЭРТЭЙ АЧААГ ТЭЭВЭРЛЭХ

10.1. Энэхүү журмыг төмөр замын тээврээр ургамлын тэдгээрийн гаралтай түүхий эд, бараа, бүтээгдэхүүнийг /цаашид хорио цээртэй гэнэ/ тээвэрлэхэд дагаж мөрдөнө.

10.2. Хорио цээрийн халдвар дамжуулах өвчин үүсгэгч байж болох хорио цээртэй ачааг төмөр замаар тээвэрлэхдээ Монгол Улсын мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчийн хяналтан дор тээвэрлэнэ.

10.3. Тогтоосон журмын дагуу нэрс нь бүртгэлд орсон хорио цээрийн үндсэн ачаануудыг Монгол Улсын нутаг импортлох болон экспортлох, дамжин өнгөрүүлэхдээ Мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл авч гүйцэтгэх.

10.4. Хорио цээртэй ачааг буулгасны дараа ачаа хүлээн авагч нь вагон чингэлгүүдийг цэвэрлэх бөгөөд ачааны үлдэгдэл хогийг мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчийн зааврын дагуу тусгайлан заасан газар устгана.



10.5. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд хорио цээртэй ачаа буусны дараа мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн улсын байцаагчийн заавраар вагон чингэлгүүдэд халдваргүйжүүлэх ажил хийнэ.

10.6. Ачаа болон тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх ажлыг, мэргэжлийн байгуулагаар гүйцэтгүүлнэ. Зардлыг бараа, бүтээгдэхүүн тээвэрлүүлэгч хариуцна. Хорио цээртэй ачааг буулгасны дараа вагон, чингэлгийг халдваргүйжүүлсэн тухай тээвэрлэгч байгууллагад үзүүлэх эрүүл ахуй ариун цэврийн акт баримтыг бүрдүүлнэ.

10.7. Хорио цээрийн ариутгалын бүсээс хорио цээртэй ачааг тээвэрлэх


10.7.1 монгол Улсын хил хязгаар дотор хорио цээрийн ариутгалын бүсээс гаралтай хорио цээртэй ачааг төмөр замаар тээвэрлэхээр хүлээн авах ажил нь ачаа илгээгч, ургамал хорио цээрийн улсын байцаагчийн олгосон гэрчилгээг үзүүлсэн тохиолдолд зөвшөөрөгдөнө;

Зөвлөмж: Хорио цээр ариутгалын бүс нь хорио цээрийн объектууд илэрснээс үүдэн хорио цээр, ариутгалын дэглэм тогтоосон газар нутаг байна. Хорио цээр ариутгалын дэглэм нь хорио цээр ариутгалын бүсэд тогтоосон хорио цээр ариутгалын арга хэмжээнүүд байна.

10.7.2. тээвэрлэгч нь Монгол Улсын ургамал хорио цээрийн улсын байцаагчаас хорио цээр, ариутгалын бүсүүд, мөн түүнчлэн тээвэрлэлтэд нь хязгаарлалт тавигдсан хорио цээртэй ачаануудын нэрс бүхий албан ёсны мэдэгдлийг хүлээн авсан үед энэ тухай бусад тээвэрлэгчид яаралтай мэдэгдэнэ. Үүний сацуу ачааг тээвэрлэлтэд хүлээн авах бүх газруудад хорио цээрийн гэрчилгээгүй бол ямар төрлийн хорио цээртэй ачаануудыг тээвэрлэлтэд хүлээн авахгүй тухай заасан зарлалыг нүдэнд үзэгдэх газруудад байрлуулна;

10.7.3. вагон, чингэлэг бүр дэх ачаа нь хорио цээрийн гэрчилгээтэй байх эсвэл нэг вагон, чингэлэгт хэд хэдэн илгээлтийн ачаатай үед хорио цээртэй ачаатай илгээлт бүрд уг гэрчилгээг авсан байна. Ачаа илгээгч нь олгосон сар, өдөр ба дугаарыг нь заасан хорио цээрийн гэрчилгээний хавсралтын тухай тэмдэглэл падаанд оруулна. Хорио цээрийн гэрчилгээ нь гарын үсэг болон тэмдэггүй, баллаж засвар хийсэн, мөн түүнчлэн хорио цээрийн гэрчилгээн дээр бичсэн ачааны нэр бодит байдал дээрх ачаатай тохирохгүй байвал тээвэрлэлтэд хүлээн авахгүй. Хорио цээрийн гэрчилгээнд заасан хугацаа нь ачаа хүргэх хугацаанд багтах шаардлагатай;

10.7.4. хорио цээртэй ачааг илгээгч нь зөвхөн хорио цээрийн гэрчилгээнд заасан өртөө, хүлээн авагчид илгээхээр тээвэрлэлтэд өгнө;



10.7.5. хорио цээр ариутгалын бүсээс ирсэн хорио цээртэй ачааг хүлээн авагч зөвхөн Монгол Улсын ургамал хорио цээрийн улсын байцаагчийн зөвшөөрлөөр буулгана;

10.8. Импорт, экспортын ба транзит хорио цээртэй ачааг тээвэрлэх

10.8.1. экспортлох бараа, бүтээгдэхүүн мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон баталгаажуулалтын гэрчилтээтэй, импортлох бараа импортын мэдэгдэлтэй байна;

10.8.2. улсын хилийн нэвтрэх цэг бүрт ургамал хорио цээрийн улсын байцаагч Монгол Улс руу хорио цээртэй бараа, бүтээгдэхүүн нэвтрэх, шууд нэвтрүүлэхийг зөвшөөрсөн тэмдгийг падаанд дарна;


10.8.3. импортын хорио цээртэй ачаа, хилийн өртөөнд /дамжуулах/ ирэх бүрт тээвэрлэгч энэ тухай мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж хяналт, шалгалтад хамруулна;

10.8.4. хорио цээртэй ачаанд Монгол Улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр шилжүүлэн ачилт хийгдэнэ. Хорио цээр ариутгалын хяналт шалгалтын үйл ажиллагаа нь өртөөний ажлын технологийн горимд заасан хугацаанаас хэтрэхгүй байна;

10.8.5. хилийн дамжуулах өртөөнд тээвэрлэгч болон гаалийн байгууллагын төлөөлөгчдийг байлцуулан ургамал хорио цээрийн улсын байцаагч хорио цээр ариутгалын хяналт шалгалтыг хийнэ;

10.8.6. хорио цээрийн объектуудаар халдварласан эсвэл хорио цээрийн улсын байцаагчийн зааврыг зөрчиж тээвэрлэсэн /хорио цээр, ариутгалын нөхцөл шаардлагыг зөрчсөн/ хорио цээртэй ачааг тээвэрлүүлэгчийн зардлаар халдваргүйжүүлж хураан авч, устгаж эсвэл ачаа илгээгчид буцаана. Ургамал, хорио цээрийн улсын байцаагч, импортын хорио цээртэй ачааг буцаасан, хураасан, устгасан, халдваргүйжүүлсэн тухай улсын хорио цээрийн хяналт шалгалтын акт үйлдэж гаалийн байгууллага болон тээвэрлэгчид олгоно;

10.8.7. улсын хилээр нэвтрэн өнгөрөх цэгүүд болон хилийн өртөөдөд шилжүүлэн ачилт хийгдэхгүй экспортод гарч байгаа хорио цээртэй ачааг илгээгч, ариун цэвэр эрүүл ахуйн гэрчилгээг шалгуулсан тохиолдолд тээвэрлэлтэд хүлээн авна. Уг гэрчилгээг Монгол Улсын мал эмнэлэг, ургамал, хорио цээрийн улсын хяналтын газраас ачилт хийж байгаа вагон чингэлэг бүрт эсвэл нэг вагон чингэлэгт хэд хэдэн илгээлт байвал хорио цээртэй ачаатай илгээлт бүрт олгоно;



10.8.8. илгээгч нь хорио цээртэй ачааг экспортод тээвэрлэхэд эрүүл ахуй, ариун цэврийн гэрчилгээг нь бараатай дагадлах бичиг баритад хавсаргаж зохих тэмдэглэл хийнэ;

10.8.9. хорио цээртэй ачаатай вагон ба чингэлэгт эвдрэл гэмтэл, ачаа алдагдсан ул мөр илэрсэн бүх тохиолдолд энэ тухай тээвэрлэгч нь мэргэжлийн хяналтын байгууллагад шуурхай мэдэгдэх үүрэгтэй.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМААР МАЛ, АМЬТАН ТЭЭВЭРЛЭХ

11.1. Төмөр замаар мал, амьтныг мах комбинат, боловсруулах үйлдвэрт хүргэх, бордох, цирк, худалдаа, үзэсгэлэн, үржил, экспорт болон импортын зориулалтаар тээвэрлэх үед мөрдөгдөнө.

11.2. Мал, амьтныг вагон илгээлтээр тээвэрлэх, ачих, буулгах ажиллагааг ачаа тээвэрлэлтэд нээлттэй өртөөдийн хооронд гүйцэтгэнэ.

11.3. Мал, амьтныг ердийн битүү вагонд тээвэрлэж болно. Ачаа илгээгч ердийн битүү вагоныг мал, амьтан ачих зориулалтаар тоноглох үүрэгтэй.


11.4. Мал, амьтан тээвэрлэх вагон нь техникийн хувьд бүрэн бүтэн, салхивчтай, хаалга нь битүүмжлэгдэж, ломбо тавих боломжтой, вагоны дотор хана, шаланд гэмтээж болзошгүй гагнаас, нөхөөс, хадаасгүй байхаас гадна цэвэрлэгдэж, угаагдаж ариутгагдсан байна.

11.5. Ачаа илгээгч нь мал, амьтан тээвэрлэхийн өмнө тухайн орон нутгийн засаг захиргаа, мал эмнэлгийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авсан байна. Энэхүү баримтуудыг падаанд хавсаргана. Мал эмнэлгийн гэрчилгээ нь олгосон өдрөөс хойш 7-14 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

11.6. Вагон илгээлтээр мал, амьтан ачихад нийтийн болон дагнасан хэрэглээний өндөрлөсөн тавцантай замд өдрийн цагт гүйцэтгэнэ. Хэрвээ ачилт, буулгалтын зам нь шаардлага хангагдсан гэрэлтүүлэгтэй бол шөнийн цагаар гүйцэтгэж болно.

11.7. Ачаа илгээгч нь тээвэрлэгчтэй тохиролцсоны үндсэн дээр ачилт, буулгалтыг нийтийн хэрэглээний замд гүйцэтгэж болно.

11.8. Ачаа илгээгч нь ачилт хийхээс 24 цагаас доошгүй хугацааны өмнө мал эмнэлгийн байгууллагад мэдэгдэж мал эмнэлгийн эрх бүхий ажилтныг ачилт, буулгалтын үед заавал оролцуулна. Мал эмнэлгийн гэрчилгээнд тээвэрлэхийг зөвшөөрсөн тухай тэмдэглэл хийж, ачаа илгээгч болон тээвэрлэгчид мэдэгдэх үүрэгтэй.



11.9. Тээвэрлэх нөхцөл:

11.9.1. мал, амьтныг төмөр замаар тээвэрлэхэд тэдгээрийн төрөл, нас, биеийн жин, өвөрмөц онцлогийг харгалзан нэг вагонд дараахь тоо толгойгоор ачна;

Хоёрдугаар хүснэгт

Мал, амьтныг төмөр замаар тээвэрлэх

Мал, амьтны нэр	Толгой
• Нас гүйцсэн үхэр	16-24
• Идэр насны үхэр /бяруу, шүдлэн/	24-28
• Тугал	36-50
• Хонь, ямаа	80-100
• Тэмээ	8-аас илүүгүй
• Гахай 80 кг хүртэл жинтэй	50-60
• Гахай 80-100кг жинтэй	44-50
• Гахай 100-150 кг жинтэй	28-44
• Гахай 150 кг-с дээш жинтэй	20-28
• Адуу	18-24
• Адуу /хурдны, сайн үйлдвэрийн, экспортлох, импортлох, циркийн сургуультай гэх мэт/	Тээвэрлүүлэгч, тээвэрлэгч, мал эмнэлгийн байгуулагатай зөвшилцөн тоо толгойг тогтоож болно.

11.9.2. бод ба бог малыг нэг вагонд хамт ачихгүй. Зайлшгүй ачих шаардлага гарвал хооронд нь хайсаар тусгаарлаж тээвэрлэнэ;


11.9.3. мал, амьтан ачсан вагоныг эхний галт тэргээр явуулна. Вагонд ачилт хийхэд нэг мал, амьтан багтах хэмжээний зай үлдээнэ;

11.9.4. өвлийн улиралд агаарын температур -25°C -ээс доош хүйтэн, зуны улиралд $+25^{\circ}\text{C}$ -ээс дээш халуун үед 100 кг-аас дээш жинтэй гахайг тээвэрлэхгүй байхыг хатуу анхаарч ажиллана. Өвлийн улиралд мал, амьтныг тээвэрлэхэд вагоны дулаалгыг илгээгч хийж гүйцэтгэнэ;

11.9.5. жижиг амьтдыг тээвэрлэхэд үл нэвчих ёроолтой салхивч бүхий битүү хайрцаг, сараалж болон торонд хийж хэд хэдэн давхар эгнээгээр байрлуулан тээвэрлэнэ. Хайрцаг, торыг вагоны хананаас 20 см-ийн зайтайгаар хананы дагуу байрлуулж хөдөлгөөнгүй бэхэлнэ;

11.9.6. үслэг ан амьтныг тэдгээрийн төрлөөс шалтгаалан төмөр буюу бат бэх модон хайрцагт хийж, түгжээ, цоожтойгоор тээвэрлэнэ;

11.9.7. ачаа илгээгч нь тээвэрлэгдэж байгаа мал, амьтныг ачихын өмнө вагоны шаланд шивтэр бага шингээх зорилгоор 10-15 см-ээс багагүй зузаантай



үртэс, сүрэл дэвсэж замын турш хэрэглэгдэх сайн чанарын өвс тэжээл, усаар хангах үүрэгтэй;

11.9.8. вагонд тээвэрлэх мал, амьтны нөөц тэжээл, ус, дэвсгэр материалыг вагоны хаалга хоорондох зайд буюу тэжээлийн тавиур дээр байрлуулна;

11.9.9. хоногт нэг толгой мал, амьтан услахад зарцуулах уусмалын дундаж хэмжээг дараахь байдлаар тогтооно;

Гуравдугаар хүснэгт

**Хоногт нэг толгой мал, амьтан услахад зарцуулах
уусмалын хэмжээ**

• Адуу	8-12 л
• Үхэр	10-12 л
• Тэмээ	20-25 л
• Хонь, ямаа	1-2 л
• Гахай	1,5-2 л


11.9.10. мал, амьтан ачсан вагонд сэлгээ хийхэд түрэгдэж шахагдахаас сэргийлэн огцом түлхэх, хэвгий газар зогсоох зэргээс онцгой болгоомжлох шаардлагатай. Сэлгээ хийхэд сэлгээний бригад нь ачаа хүргэгчдэд заавал урьдчилан мэдэгдэнэ;

11.9.11. мал, амьтан хүргэгч нь маллагааны аргыг эзэмшиж, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангагдсан байна. Ачаа хүргэгч нь мал амьтан хордох, өвчлөх, тэжээл усандаа дургүйцэх тохиолдолд илчит тэрэгний бригадаар дамжуулан тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргад мэдэгдэж, мал эмнэлгийн байгууллагаар холбогдох арга хэмжээг авахуулна;

11.9.12. төмөр замаар мал, амьтан тээвэрлэх үед малын халдварт өвчин гарсан тохиолдолд тээвэрлэгчийн мэдэгдлээр холбогдох мал эмнэлгийн байгууллага нь улсын мал эмнэлгийн хууль, дүрэм, журам, зааврын дагуу тээвэрлэнэ;

11.9.13. мал, амьтан ачсан вагонд техникийн гэмтэл тохиолдох үед өртөөний техник үзлэгийн газар уул вагоныг яаралтай засварлах, засварлах боломжгүй тохиолдолд шилжүүлэн ачих арга хэмжээг авна. Мал, амьтан ачсан вагон ачаа хүлээн авах өртөөнд ирсэн тухай өртөөний холбогдох ажилтан ачаа хүлээн авагчид мэдэгдэнэ;

11.9.14. мал, амьтан тээвэрлэж ирсэн вагоныг суларсны дараа 12 цагийн дотор ачаа хүлээн авагчийн хүч хэрэгслээр вагоныг угааж ариутгана;



11.9.15. хорио цээрийн дэглэм тогтоогдсон нөхцөлд тээвэрлэгч нь тухайн өртөөнөөс мал амьтан ачих буулгахыг даруй зогсоох арга хэмжээ авна. Хорио цээр тогтоогдсон өртөөн дээр мал, амьтан ачигдан ирэх тохиолдолд мал эмнэлэг ариун цэврийн асуудал хариуцсан улсын байцаагч, эмчийн шийдвэрээр өөр өртөөнд шилжүүлэн буулгах арга хэмжээ авна;

11.9.16. мал, амьтан экспортлох, импортлох үйл ажиллагааг хүнс, хөдөө аж, ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр улсын мал эмнэлгийн эрх бүхий байгууллагын хяналтын дор, хилийн боомтын мал эмнэлгийн салбар бүхий төмөр замын өртөөгөөр дамжуулан гүйцэтгэнэ. Гадаад улсаас худалдан авч буй мал, амьтан нь илгээсэн орны мал эмнэлгийн байгууллагын гэрчилгээтэй байна;

11.9.17. төмөр замаар ачигдаж яваа мал, амьтанд хийгдэх мал эмнэлгийн үзлэг шалгалт нь тогтоогдсон цаг хугацаанд багтаж хийгдэнэ. Харин малд эмчилгээ хийх, хорио цээр тогтоосноос болж тээвэрт гарсан саатлын талаар тухайн хилийн боомтын мал эмнэлгийн байгууллагаас акт үйлдэж ачааны падаанд хавсаргана;

11.9.18. төмөр замаар мал, амьтан тээвэрлэхэд олон улсын ба хоёр улсын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу мал эмнэлгийн үзлэг шинжилгээг хийлгэж илгээлт тус бүрт 2 хувь гэрчилгээ авсан байна. Гэрчилгээнд тээвэрлүүлэгчийн нэр, хаяг, мал амьтны тоо, гэрчилгээ олгосон мал эмнэлгийн байгууллагын хаяг, эмчийн гарын үсэг зэргийг засваргүйгээр тодорхой бичиж, тэмдэг дарсан байна;

11.9.19. мал, амьтан ачсан вагоныг өртөөнд ирмэгц хүлээн авагчийн буулгах замд тавьж өгөх бөгөөд хүлээн авагч нь вагон тавьж өгснөөс хойш нэн даруй буулгана.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ

ЖИЖИГ ИЛГЭЭЛТИЙН АЧАА ТЭЭВЭРЛЭХ


Жижиг илгээлт гэдэг нь хэмжээгээрээ вагоны эзлэхүүний 1/3-ээс хэтрэхгүй, жингээрээ 5000 кг-аас ихгүй ачааг хэлнэ.

12.1. Жижиг илгээлтийн 1 байр /ачмагтай болон боодолтой ачаа/-ын жин нь:

- битүү вагоноор тээвэрлэхэд 20 кг-аас багагүй, 1500 кг-аас ихгүй;
- задгай вагонд тээвэрлэхэд 1500 кг-аас багагүй 5000 кг-аас ихгүй.

12.2. Чингэлэг тээвэрлэхэд:

- их даацын чингэлгээр 20 кг-аас багагүй, 1500 кг-аас ихгүй;



- дунд даацын чингэлгээр 20 кг-аас багагүй, 120 кг-аас ихгүй байна.

12.3. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааны урт нь:

- битүү вагонд 2м -ээс ихгүй;
- задгай вагонд ачилтын техникийн нөхцөлд тохирсон;
- энэхүү журмын 8 дугаар бүлэг /Чингэлэгт ачаа тээвэрлэх/-т заасан шаардлагад нийцсэн байна.

12.4. Жижиг илгээлтийн тээврийг энэ төрлийн тээвэрт нээлттэй өртөөдийн хооронд тарифын бодлоготой нийцүүлэн гүйцэтгэнэ.

12.5. Вагон болон чингэлгээр тээвэрлэх жижиг илгээлтийн ачаа нь жижиг илгээлтийн ачаа тээвэрлэх гэрээний дагуу гүйцэтгэгдэнэ.

12.6. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааг нийтийн хэрэглээний болон дагнасан хэрэглээний салбар замуудаас тээвэрлэгчид өгсөн захиалгыг үндэслэн хүлээн авна. Жижиг илгээлтээр тээвэрлэх захиалгын хуудсыг энэхүү журмын 2 дугаар бүлэг /Ачааны захиалга хүлээн авах, зөвшилцөх/-т заасны дагуу ачаа илгээгчид олгоно.

12.7. Ачаа илгээгч нь энэхүү журмын 4 дүгээр бүлэг /Орон нутгийн харилцааны тээврийн бичиг баримт бүрдүүлэх/-т заасны дагуу жижиг илгээлт бүрт падаан үйлдэнэ.


12.8. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааг ачаа илгээгч нь тээвэрлэлтийн нөхцөл, зохих MNS EN 12798:2015, MNS EN 13876:2015 стандартын шаардлагыг хангасан сав, баглаа, боодолтой байлгах үүрэг хүлээнэ.

12.9. Жижиг илгээлтийн ачааны байр бүр дээр ачаа илгээгчийн болон төмөр замын марклалыг ачаа хүлээн авах журмын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

12.10. Жижиг илгээлтээр тээвэрлэх аюултай ачааг Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмын дагуу хүлээн авна.

12.11. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааг хүлээн авах агуулах, талбай нь тусгай зориулалтын байж болно:

- хүнд болон урт хэмжээний ачааг зориулалтын газарт гадна талд нь хураана;
- ачмагтай болон боодолтой ачааг жингээс нь хамааран хэд хэдэн давхар хураана;



- ачааны хураалт нь байрын тоог тодорхойлох, төмөр замын марклалыг шалгаж болохуйцаар хураагдсан байна.

12.12. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааг хэсэгчлэн тээвэрлэгчид хүлээлгэн өгч болно. Тээвэрлэгч нь ачаа хүлээн авах актад болон падааны зохих хүснэгтэд хүлээн авсан ачааны тухай тэмдэглэл хийнэ. Ачаа хүлээн авах актын маягыг тээвэрлэгч тогтооно.

12.13. Вагон, чингэлэг нь жижиг илгээлтээр ачаа тээвэрлэхэд тэнцэх эсэхийг илгээгчийн захиалгыг үндэслэн тээвэрлэгч тогтооно.

12.14. Жижиг илгээлтийн ачааг вагон, чингэлэгт ачих буулгах ажлыг нийтийн хэрэглээний салбар замд тээвэрлүүлэгч эсвэл тээвэрлэгч болон гэрээт тал гүйцэтгэж болно.

12.15. Задгай хөдлөх бүрэлдэхүүнд тээвэрлэгдэх жижиг илгээлтийн ачааны байрлал нь зам зуурын өртөөдөд буух ачааг буулгахад бусад ачааг хөдлөхгүйгээр байрлуулсан байна.

12.16. Жижиг илгээлттэй ачаатай вагон, чингэлэгт ломбо тавих нь энэхүү журмын 18 дугаар бүлэг /Вагон, чингэлэг ломбодох/-т заасны дагуу хийгдэнэ.

12.17. Жижиг илгээлтээр тээвэрлэсэн ачааг энэхүү журмын 25 дугаар бүлэг /Ачааг хүлээн авагчид олгох/-т заасны дагуу хүлээн авагчид олгоно.

12.18. Түргэн муудах жижиг илгээлтийн ачааг төмөр замаар энэхүү журмын 9 дүгээр бүлэг /Түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх/-т заасны дагуу гүйцэтгэнэ.


АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ АЧАА ХҮРГЭХ ХУГАЦААГ ТООЦОХ

13.1 Тээвэрлэгч ачааг хүрэх өртөөнд тогтоосон хугацаанд нь хүргэх үүрэгтэй.

Ачааг хүргэх хугацааг түүнийг тээвэрт хүлээн авч бичиг баримт үйлдэж, замын хүснэгтэд /илгээх өртөөний хуанлийн дардас/ огноо дарсан өдрийн дараахь хоногийн 00 цагаас эхлэн тооцно.

13.2. Хүргэх хугацааны дуусгавар болох өдрийг тээвэрлэгч падаанд тэмдэглэнэ.

13.3. Ачаа болон тээвэрлэгчийн эзэмшлийн бус хоосон вагон ба чингэлгийн хүргэх хугацааны нормыг тооцохдоо /цаашид хүргэх хугацаа гэх/ илгээх өртөөнөөс тарифын мөрдлөгөөр тогтоосон зай, чиглэл, тээврийн хөлс төлөлт, илгээлтийн төрөл зэргээс хамааруулан тогтооно. Нэг хоног хүрэхгүй хугацааг бүтэн хоногт тооцно.



13.4. Вагон, чингэлэг, жижиг илгээлтийг ачааны хурдаар тээвэрлэх тарифын зайн хэмжээгээр /их, бага хурдаар/ тогтооно. Ачаа тээвэрлүүлэх хурдыг тээвэрлүүлэгч сонгож, падаанд тэмдэглэл хийнэ.

13.5. Ачаа хүргэх хугацааг дараахь байдлаар тодорхойлно.

13.5.1. их хурдаар тээвэрлэх ачаа:

Дөрөвдүгээр хүснэгт

Их хурдаар тээвэрлэх ачаа

▪ Ачаа илгээх хугацаа	1 хоног;
▪ Жижиг илгээлтээр ачаа тээвэрлэх хугацааг тээвэрлэлтэд оролцох төмөр замын хязгаарт эхэлсэн тарифын 200 км тутамд	1 хоног;
▪ Вагон илгээлт буюу их даацын чингэлэг илгээлтээр ачаа тээвэрлэх хугацааг тээвэрлэлтэд оролцох төмөр замын хязгаарт эхэлсэн тарифын 320 км тутамд	1 хоног;
▪ Зорчигчийн галт тэргээр тээвэрлэж байгаа вагон буюу их даацын чингэлэг илгээлтээр ачаа тээвэрлэх хугацааг тээвэрлэлтэд оролцох төмөр замын хязгаарт эхэлсэн тарифын 420 км тутамд	1 хоног.

13.5.2. Бага хурдаар тээвэрлэх ачаа:

Тавдугаар хүснэгт

Бага хурдаар тээвэрлэх ачаа


▪ Ачаа илгээх хугацаа	1 хоног;
▪ Жижиг илгээлтээр ачаа тээвэрлэх хугацааг тээвэрлэлтэд оролцох төмөр замын хязгаарт эхэлсэн тарифын 150 км тутамд	1 хоног;
▪ Вагон илгээлт буюу их даацын чингэлэг илгээлтээр ачаа тээвэрлэх хугацааг тээвэрлэлтэд оролцох төмөр замын хязгаарт эхэлсэн тарифын 200 км тутамд	1 хоног;

13.6. Дараахь тохиолдолд ачаа хүргэх хугацаа нэмэгдэнэ:

Зургадугаар хүснэгт

Ачаа хүргэх хугацаа нэмэх нөхцөл

▪ Ачааг тээвэрт хүлээн авч, явуулах ажиллагаа	2 хоног;
▪ Хэд хэдэн суурь бүтэц дамжих ажиллагаанд	1 хоног;
▪ Өөр төрлийн тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачилт хийхэд	1 хоног;
▪ Ачааг өөр царигийн вагонд шилжүүлэн ачилт хийхэд	2 хоног;
▪ Илгээлтийн хаяг солилт	1 хоног;
▪ Ачааг тээвэрлэх 1000 км тутамд /техникийн ажиллагаанд/	1 хоног;



▪ Вагоны явах ангийг өөр царигийн явах ангиар солих ажиллагаа	1 хоног;
▪ Хилийн өртөөнд хийгдэх гааль, хорио цээр болон хилийн хяналт шалгалт	1 хоног;
▪ Ачааны жинг тодорхойлох	1 хоног;
▪ Аюултай ачаа тээвэрлэх	1 хоног;

13.7. Ачаа хүргэх хугацааг доорх тохиолдолд саатсан хугацаагаар нэмэгдүүлнэ:

13.7.1. хяналт шалгалт хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шаардлагаар шалгалт хийсэн;

13.7.2. ачаа илгээгчийн буруугаас ачилтыг буруу гүйцэтгэсэн, шилжүүлэн ачсан буюу зам зуурт зассан;

13.7.3. тээвэрлэгчээс хамааралгүйгээр техникийн гэмтэл зөрчлөөр болон ачаа тээврийн гэмтлээр саатсан;

13.7.4. байгалийн давагдашгүй хүчин зүйлээс саатсан;

13.7.5. мал, амьтан, өртөөн дээр услахаар болон вагоноос гаргаж мал эмнэлгийн үзлэг хийхэд саатсан.

13.8. Энэхүү журмын 13.4-т заасан тохиолдлуудаар ачаа болон вагон чингэлэг саатсан бол тээвэрлэгч ерөнхий маягтын акт тогтооно. Энэ тохиолдолд тээврийн бичиг баримтын зохих хүснэгтэд тэмдэглэл хийнэ.

13.9. Тээврийн бичиг баримтын "тээвэрлэгчийн тэмдэглэл" гэсэн хүснэгтэд ачааны нэрийн доод талд ерөнхий маягтын акт тавьсан шалтгаанаа бичнэ. Хэрвээ хэт хэтрүү овортой ачаа ачсан тохиолдолд хүргэх огноог бичихгүй.

13.10. Хэтрүү овортой ачааны хүргэх хугацааг дараахь нормыг баримтлан тодорхойлно.

Долдугаар хүснэгт

Хэтрүү овортой ачааны хүргэх хугацаа

▪ I-IV зэргийн овортой ачааг 100 км	▪ 1 хоног;
▪ V зэргийн овортой ачааг 80 км	▪ 1 хоног;
▪ VI болон хэт хэтрүү овортой ачаанд	▪ тогтоохгүй

13.11. I-V зэргийн хэтрүү овортой ачаанд хүргэх хугацааг доорх хугацаагаар нэмэгдүүлэн тогтооно.



14.3.3. төмөр замаар энэхүү журмын 9 дүгээр бүлэг /Түргэн гэмтэж, муудах ачаа тээвэрлэх/-т заагдсан ачаа хүргэх хугацаанаас илүү хугацаатай түргэн муудах ачаа тээвэрлэх;

14.3.4. төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг ашиглаж тээвэрлэхэд заагдаагүй зарим төрлийн ачааг тээвэрлэх.

14.4. Онцгой нөхцөлийг баримтлан тээвэрлэгдэх ачааны тухай илгээгчийн хүсэлтийг хүлээн авах, хянан шийдвэрлэх, гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтны нэрсийн жагсаалтыг тээвэрлэгч тогтооно.

14.5. Онцгой нөхцөл баримтлан тээвэрлэх ачааны бичиг баримт:

14.5.1. төмөр замын тээврийн падааны 1 дэх хүснэгтэд ачаа илгээгч "Онцгой нөхцөлийг баримтлах тээвэрлэлт. Ачаа хүлээн авагчтай зөвшилцсөн ...оны... сарын ... өдрийн № ... тоот гэрээ" гэсэн тэмдэглэл хийнэ;


14.5.2. онцгой нөхцөл баримтлан ачаа тээвэрлэх үед ачаа илгээгч тээвэрлэгчид бичгэн мэдэгдлээр ачааг тээвэрлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Энэ хугацааны дотор тээвэрлэгч онцгой нөхцөлийг баримтлан ачаа тээвэрлэх боломжийг судалж, тухайн тээвэрлэлт хийх боломжтой бол гарын үсэг зурж, 2 хувь гэрээг ачаа илгээгчид өгнө. Онцгой нөхцөлийг баримтлан ачаа тээвэрлэх тээвэрлэлтийг хийх боломжгүй тохиолдолд тээвэрлэгч нь шалтгааныг дурдан татгалзсан хариуг ачаа илгээгчид өгнө. Ачаа илгээгч нь тээвэрлэгчийн гарын үсэг зурсан 2 хувь гэрээг хүлээж аваад гарын үсгээ зурж, баталгаажуулан 1 хувийг тээвэрлэгчид буцааж өгнө;

14.5.3. тээвэрлэгч нь онцгой нөхцөлийг баримтлан ачаа тээвэрлэх үед батлагдсан гэрээний дагуу цахилгаанаар өөрийн мэдлийн хэсэглэлд энэ тээвэрлэлтийн үндсэн нөхцөлийг мэдэгдэнэ. /илгээх өртөө, хүрэх өртөө, ачааны төрөл, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний төрөл, талуудын харилцан хүлээх хариуцлага, онцгой нөхцөлийн үйлчлэх хугацаа болон бусад зүйлийг зааж өгнө/;

14.5.4. тээвэрлэгч нь онцгой нөхцөлийг үндэслэн ачаа тээвэрлэх гэрээний нөхцөл, энэхүү журмыг баримтлан ачааг тээвэрлэсэн тохиолдолд ачаатай холбогдож гарсан маргааныг хариуцахгүй;

14.5.5. онцгой нөхцөл баримтлан ачаа тээвэрлэх гэрээнд заагдаагүй асуудлаар тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд гарсан маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ;

14.5.6. шууд холимог тээвэрлэлтэд онцгой нөхцөлийг баримтлан ачаа тээвэрлэх, түргэн гэмтэж, муудах ачаа тээвэрлэх нөхцөлийг тухайн тээврийн төрлийн ачаа тээвэрлэхтэй холбогдсон дүрэм, журмаар зохицуулна.



15.2.3. бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар тээвэрт өгөхөд ачаа нь өөр өөр үнэ зарласан бол тэдгээрийн ялгагдах шинж тэмдэг, байрын тоо, зарласан үнэ зэргийг ачааны жагсаалтад тусад нь мөрөнд зааж өгнө;

15.2.4. үнэ зарласан ачааны жагсаалтыг 3 хувь үйлдэж, 1 хувийг ачаа илгээгчид, 1 хувийг тээвэрлэгчид, 1 хувийг вагон буюу чингэлэг дотор хананд харагдахаар газарт наана. Ачааг жижиг илгээлтээр тээвэрлэхэд тухайн илгээлтийн аль нэг ачаанд наана. Шингэн болон нурмаг ачаанд наадас наах боломжгүй тул 2 хувь бичнэ;

15.2.5. тээвэрлэгч тухайн ачааны жагсаалтад заасан ачааны байрын тоо тохирч байгаа эсэхийг шалгана;

15.2.6. иргэний, гэр бүлийн хэрэгцээний, ахуйн болон арилжааны бус шинжтэй ачааг тээвэрт хүлээн авах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна;

15.2.7. тээврийн бичиг баримтыг бүрдүүлэх үед тээвэрлэгч нь ачаа илгээгчийн бичсэн үнэ зарласан ачааны жагсаалтыг зөв эсэхийг шалгаж түүнд падааны дугаарыг бичиж гарын үсгээ зураад хуанлийн дардас дарна. Үнэ зарласан ачааны жагсаалт хэд хэдэн хуудастай бол хуудас бүрт ачаа илгээгч тээвэрлэгчийн гарын үсэг болон хуанлийн дардсыг дарна;

15.2.8. үнэ зарласан ачааг тээвэрлэх вагон болон чингэлгийг ломбодож битүүмжлэхийг энэхүү журмын 18 дугаар бүлэг /Вагон, чингэлэг ломбодох/-т зааснаар зохицуулна;

15.2.9. ачааны зарласан үнийн дүнг илгээгч падааны зохих хүснэгтэд "төгрөг"-өөр бичих бөгөөд энэ нь нийлүүлэгчийн нэхэмжлэхэд зааснаас эсвэл жинхэнэ үнээс хэтрэх ёсгүй;

15.2.10. ачааг тээвэрлэлтэд хүлээн авахад зарласан үнийн хэмжээ нь түүний өртөгтэй зохицох эсэхийг шалгана. Тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд зарласан үнийн талаар маргаан гарвал түүний илгээх өртөөнд тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ.

15.3. Үнэ зарласантай холбогдон гарах хариуцлага:

15.3.1. ачаа илгээгчийн ачааны зарласан үнэ тухайн ачааны жинхэнэ өртгөөс хэтрэх ёсгүй;

15.3.2. зарласан үнэтэй ачааны тээвэрлэлтийн үед тээвэрлүүлэгчид учирсан хохирлыг зарласан үнийн хэмжээнд тээвэрлэгч нь нөхөн төлнө;

15.4. гомдол гаргах



15.4.1 үнэ зарласан ачаа алдагдах, гэмтэх, тоо ширхэг, жин дутах үед тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчид гомдол гаргана;

15.4.2. тээвэрлүүлэгч нь бодит хохирлын нотлох баримтуудыг гомдол гаргах үедээ тээвэрлэгчид гаргаж өгөх үүрэгтэй;

15.4.3. гомдол хүлээн авсан тээвэрлэгч нь гомдлыг Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, түүний албан заавар, энэхүү журмын дагуу шийдвэрлэн хохирлыг барагдуулах буюу зохих хариу өгнө.

АРВАНЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХЭТРҮҮ ОВОРТОЙ, УРТ ХЭМЖЭЭТЭЙ, ХҮНД ЖИНТЭЙ АЧАА ТЭЭВЭРЛЭХ

16.1. Төмөр замаар хэтрүү овортой, хүнд жинтэй ачааг тээвэрлэхэд задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачаа ачиж бэхлэх техникийн нөхцөл, Төмөр замын техник ашиглалтын журам, Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

16.2. Ачилтын овор, хэтрүү овортой ачааны ангилал:


16.2.1. төмөр замаар тээвэрлэх ачаа нь "Задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачаа ачиж бэхлэх техникийн нөхцөл" /цаашид "техникийн нөхцөл" гэх/-д тусгагдсан ачилтын оврын хэмжээнээс хэтрэхгүй байна;

16.2.2. урт ачаа гэдэгт вагоны 2 талын төгсгөлийн ялуунаас 400 мм ба түүнээс илүү гарсан ачааг тооцно;

16.2.3. тэгш шулуун зам дээр зогсож байгаа задгай хөдлөх бүрэлдэхүүний тууш тэнхлэг нь замын тууш тэнхлэгтэй нэг босоо хавтгайд давхцаж байхад түүн дээр ачсан ачаа нь баглаа, боодол, бэхэлгээнийхээ хамтаар ачилтын оврын хязгаар хүрэнээс хэтрээгүй байвал түүнийг оворгүй ачаа гэнэ. Урт хэмжээтэй ачаанд зөвшөөрөгдөх, ачилтын оврын хөндлөнгийн хэмжээг техникийн нөхцөлийн дагуу тогтооно;

16.2.4. зам төмрийн толгойн түвшингөөс задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачсан ачааны доод цэг хүртэлх хамгийн бага зөвшөөрөгдөх зай нь 150 мм-ээс багагүй байна;

16.2.5. тэгш шулуун зам дээр зогсож байгаа задгай хөдлөх бүрэлдэхүүний тууш тэнхлэг замын тууш тэнхлэгтэй давхцаж байхад түүн дээр ачсан ачаа нь баглаа, боодол, бэхэлгээнийхээ хамтаар ачилтын оврын хэмжээнээс илүү гарч байвал түүнийг хэтрүү овортой ачаанд тооцно. Мөн түүнчлэн замын тахир хэсэг дээр 17 м баазтай, 24 м урттай вагонд ачигдсан ачаа нь тооцоот вагоны геометр хэтрэлтээс илүү гарч байвал хэтрүү овортой ачаанд тооцно. Ачаа ба хөдлөх



бүрэлдэхүүний геометр хэтрэлт гэж замын тахир хэсэг дээр хөдлөх бүрэлдэхүүний ба ачааны тууш тэнхлэг нь замын тэнхлэгээс хажуу тийш шилжих шилжилтийг хэлнэ;

16.2.6. ачаа нь зам төмрийн толгойн түвшингөөс дээш ямар өндөрт ачилтын оврын хязгаарын хүрээнээс хэтэрч байгаагаас хамааруулан ачааны хэтрүү оврыг гурван төрлийн бүсэд хуваана.


Есдүгээрхүснэгт


Ачилтын оврын хязгаарын төрөл

Д/д	Хэтрүү овор тодорхойлогдох бүс	Зэрэг	Зам төмрийн толгойн түвшингөөс дээш хэтрүү оврын тодорхойлогдох өндөр, мм	Замын тэнхлэгээс, мм
1	Доод	1	480-1400	1626-1700
		2	480-1400	1701-1760
		3	1230-1400	1761-1850
		4	1230-1400	1851-2000
		5	1230-1400	2001-2080
		6	1230-1400	2081-2240
2	Хажуу	1	1401-4000	1626-1700
		2	1401-4000	1701-1800
		3	1401-4000	1801-1850
		4	1401-3700	1851-2000
		5	1401-3400	2001-2080
		6	1401-2800	2081-2240
3	Дээд	1	4001-5300	621-880
		2	4001-5300	881-1080
		3	4001-5300	1081-1120

16.2.7. ачилтын оврын хүрээнээс илүү гарах ачааны хэтрэлт, түүнийг төмөр замын төхөөрөмж, байгууламжаар нэвтрүүлэн өнгөрүүлэх боломж нөхцөлөөс хамааруулан бүс тус бүрийг зэргүүдэд хуваана. Ачааны хэтрүү оврын зэргийг тогтоохдоо түүнийг зөвхөн тэгш шулуун зам дээр байна гэж үзэх төдийгүй замын тахир дээгүүр өнгөрөх нөхцөлийг давхар тооцно. Тооцоот хэтрүү оврыг тээвэрлүүлэгч дор дурдсан тохиолдолд тодорхойлно:

- ачааны уртыг хөдлөх бүрэлдэхүүний баазад харьцуулсан харьцаа нь 1.41-ээс их байх урт хэмжээтэй ачаа;
- ачааг угсраа тавцан вагонуудад тээвэрлэх үед;
- ачааг 17 м ба түүнээс урт баазтай транспортерт тээвэрлэх үед тус тус тодорхойлно.






2 дугаар зураг. Хэтрүү оврын бүс ба зэрэглэл

1-ээр ачилтын овор, зураг 2-оор хэтрүү оврын бүс ба зэргүүдийг, зураг 3-аар доод хэтрүү оврын 6 зэргийг тус тус үзүүлэв.

16.2.9. ачаа нь хөндлөнгөөрөө дээд III зэрэг, хажуугийн IV зэрэг /зам төмрийн толгойн түвшингөөс 3700-4000 мм өндөрт/, V зэрэг /зам төмрийн толгойн түвшингөөс 3400-3700мм өндөрт/, VI зэрэг, доод II зэрэг /зам төмрийн толгойн түвшингөөс 380-1400 мм өндөрт/, VI зэргийн хэтрүү овруудын хязгаарын хүрэнээс илүү гарах болон III-VI зэргийн доод хязгаараас /зам төмрийн толгойн түвшингөөс 1230 мм-ээс доош/ илүү гарсан ачаа, мөн 5300 мм-ээс дээш өндөрт ачилтын оврын хүрэнээс тус тус гадагш илүү гарч байвал түүнийг хэт хэтрүү овортой ачаа гэнэ. 5300 мм-ээс дээш өндөртэй хэт хэтрүү овортой ачааг босоо хэт хэтрүү овортой ачаа гэнэ;

16.2.10. хэт хэтрүү овортой, доод болон хажуугийн VI зэргийн хэтрүү овортой ачааг хяналтын жаазтайгаар тээвэрлэнэ. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд галт тэрэгний аяллын замд овор хэмжээнд үл нийцэх төхөөрөмж байгууламж байгаа



болон тэдгээрийн бодит хэмжээнээс хамааран тээвэрлэгчийн шийдвэр дээр зааснаас бага зэрэгтэй хэтрүү овортой ачааг хяналтын жаазтайгаар тээвэрлэнэ.

16.3. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг ачих, хүлээн авах, тээвэрлэлтэд бэлтгэх:

16.3.1. тээвэрлүүлэгч нь хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг төмөр замаар тээвэрлэхийн өмнө 3 үе шаттайгаар тээвэрлэгчтэй тохиролцоно:

- тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтантай ачаа тээвэрлэх боломж аргыг урьдчилан тохиролцох;
- ачаа ачилтын зураг, тооцооны баримт бичгүүдийг тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтантай тохиролцох;
- тусгай хөдлөх бүрэлдэхүүн транспортер дээр ачих ачаа болон хэтрүү овортой ачааг ачих ачааны зураг, тооцооны баримт бичгийг тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтнаар батлуулах.

16.3.2. тээвэрлүүлэгч болон тээвэр зуучлагч нь суурь бүтэц эзэмшигчтэй урьдчилан зөвшилцөхдөө тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад илгээх ачааныхаа 3 хавтгай дээрх /хажуу, дээр, урдаас харсан/ 4 хувь зургийг захиалгын хамт ирүүлнэ;

16.3.3. ачааны жин, урт, вагоны шаланд өгөх ачаалал нь 4 голт вагонд техникийн нөхцөлийн дагуу тогтоосон хэмжээ, вагоны нэг гол дээрх даралтыг тогтоосон нормоос хэтэрч байвал түүнийг хүнд жинтэй ачаанд тооцох бөгөөд транспортер вагонд тээвэрлэнэ;

16.3.4. тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчээс ачаа тээвэрлэх зөвшөөрлийг авсны дараа ачилтын бичиг баримтыг бүрдүүлнэ. Ачилтын бичиг баримт нь ачилтын зураг, хэтрүү оврын тооцоо, ачааны байрлал, бэхэлгээ, тогтворжилт, шаардлагатай бол хяналтын жаазны зургаас бүрдэнэ.

16.3.5. ачилтын зураг нь 1:20, 1:25, 1:50 масштабээр үйлдэгдэх ба хөдлөх бүрэлдэхүүн дээрх ачааны байрлал, бэхэлгээний 3 хавтгай дээрх зургийг агуулсан байна. Нарийн төвөгтэй хэлбэр дүрс бүхий тооцоот хэтрүү овортой, урт хэмжээтэй ачааны хөндлөн огтлолын нэмэлт зургууд байх ба хэт хэтрүү овортой ачааны зургийг 1:20, 1:10 масштабээр үйлдэнэ. Хяналтын жаазны зургийг 1:20 эсвэл 1:10 масштабээр үйлдэнэ. Ачилтын зурагт овор хэтэрсэн хэсэг дэх цэгүүдийг үсгээр тэмдэглэх ба дор дурдсан координатыг заана:

- хөдлөх бүрэлдэхүүний тууш тэнхлэгээс эхтэй хөндлөн хэмжээ /X/;
- зам төмрийн толгойн түвшингөөс эхтэй босоо хэмжээ /Y/;



- тавцан ба хагас вагоны хамгийн ойрын чиглүүлэгч огтлол хүртэлх хэмжээ.
- ачилтын зурагт ачааны хүндийн төвийн байрлал, түүний бэхэлгээтэй болон бэхэлгээгүй үеийн жин, хөдлөх бүрэлдэхүүний төрөл, замын шулуун хэсэг дэх хэтрүү оврын болон тооцоот хэтрүү оврын бүс, зэрэг, нэг гол дээрх болон нэг метр урт зам төмөр дээрх ачаалал, ялгах довоор хэрхэн өнгөрүүлэх нөхцөл зэргийг заасан байна.
- тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчид хүнд жинтэй, хэтрүү овортой ачааны жин, хэмжээг үнэн зөв өгөх бөгөөд буруу өгснөөс гарах хариуцлагыг хүлээж учирсан хохирлыг барагдуулна.
- доор дурдсан аргаар ачааг нэгтгэж холбосон транспортер дээр тээвэрлэх үед тээвэрлэгчид ирүүлэх тооцоонд ачаатай транспортерийн тогтворжилтыг шалгаж хэтрүү оврыг тодорхойлно.
- транспортер дээр ачааг ачаанд гагнасан сэнжнээс тогтоож бэхлэх; /Жишээлбэл: трансформаторт/
- ачааг түүнд бэхэлсэн тусгай төхөөрөмжийг ашиглан транспортер дээр байрлуулах; /Жишээлбэл: уурын генератор/
- транспортер дээр бэхлэгдсэн нэвт хөндлөвч дамнуур дээр ачааг суурилуулж байрлуулах.

16.3.6. ачааг тээхэд хэрэглэх тусгай жааз, сэнж, тусгай төхөөрөмж, хөндлөвч, дамнуурын бат бэхийн тооцоог ачаа илгээгч тогтоосон нормоор гүйцэтгэх ба шалгаж үзнэ;

16.3.7. хүнд жинтэй, хэтрүү овортой ачааны байрлал, бэхэлгээний тооцоо бүдүүвч зурагтайгаа тохирч байгаа эсэхийг тээвэрлэгч тогтооно;

16.3.8. хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг тээвэрлэх задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачиж бэхлэх техникийн нөхцөлийн зураг схем, түүний тооцоог батлуулж ачаа илгээгч ачилтын сар эхлэхээс 20 хоногийн өмнө захиалгаа тээвэрлэгчид ирүүлнэ;

16.3.9. хэтрүү болон хэт хэтрүү овортой ачааг тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр ачна.

16.4. Ачаа илгээгчийн хүлээх үүрэг:

16.4.1. хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг техникийн нөхцөлийн шаардлагад бүрэн нийцүүлж тээвэрлэлтэд бэлтгэнэ;



16.4.2. батлагдсан зурагт нийцүүлж ачилтыг хийх ба ачилт дууссаны дараа арилахгүй тод өнгийн будгаар вагоны шал, ачаан дээр хяналтын зураас тавих ба мөн ачаан дээр түүний хэтрүү оврын индекс, довоос буулгахыг хориглох зэргийг заасан тэмдэглэл хийнэ;

16.4.3. шаардлагатай тохиолдолд хяналтын жаазыг үйлдэж вагонд байрлуулах ба онцгой үед ачааны явах замналыг урьдчилан түүний биет загвараар шалгах бол ачааны биет загварыг хийнэ;

16.4.4. ачигдсан вагоныг комиссын үзлэгт оруулахад бэлэн болсон тухай тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргад мэдэгдэнэ.


16.5. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачааны байрлал бэхэлгээг шалгах

16.5.1. хүнд жинтэй ба хэтрүү овортой ачааг байрлуулж бэхэлсэн бодит байдал төмөр замын байгууллагын баталсан зураг, тооцоотой тохирч байгаа эсэхийг дараахь бүрэлдэхүүнтэй комисс шалгана. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга буюу орлогч дарга замын засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн ажилтан болон вагоны техник үйлчилгээний нэгжийн дарга буюу ахлах вагон үзэгч байхаас гадна тээврийн бусад мэргэжлийн хүнийг оролцуулж болно.

16.5.2. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг хэрхэн байрлуулж бэхэлснийг комисс шалгаж дор дурьдсан зүйлийг тодорхойлно;

- хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдал;
- транспортерын ачилтын талбайн болон вагоны шалны ачаатай байдал дахь өндрийн хэмжээ;
- ачааны байрлал, бэхэлгээ, хүндийн төв ачилтын зурагт заасантай тохирч байгаа эсэх;
- ачааны хэтрүү оврыг тодорхойлж буй цэгүүдийн жинхэнэ координат /X,Y/;
- ачаан дээр түүний хэтрүү оврыг заасан хяналтын зураас түүнчлэн довоос буулгахыг хориглосон ба довоор нэвтрүүлэхийг заасан бичиглэл байгаа эсэх;
- тээвэрлүүлэгч хяналтын жаазыг зөв хийж, зөв байрлуулсан эсэх.

16.5.3. ачааг шалгасны дараа хэтрүү овортой, хүнд жинтэй ачааны байрлал бэхэлгээг шалгасан тухай актыг 2 хувь үйлдэх бөгөөд 1 хувь нь ачааны бичиг баримтад хавсрагдаж явах ба 2 дахь хувь нь тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад хадгалагдана.



16.5.4. тээвэрлэгч ачаа дайран өнгөрөх бүх өртөө зөрлөгүүдэд түүнийг хэрхэн нэвтрүүлэх тухай бүртгэлт тушаалыг өгнө;

16.5.5. ачаа нь галт тэрэгний хөдөлгөөнд аюул учруулахаар шилжиж хөдөлсөн ба бэхэлгээ нь зөрчилтэй бол вагоныг галт тэрэгний бүрэлдэхүүнээс салгах ба ачааг галт тэрэгнээс салгасан тухай ачилт хийсэн өртөө болон тээвэрлэгчид цахилгаанаар мэдэгдэнэ. Ачааг салгасан даруйд энэхүү журмын 16.5.1-д заасан комисс шалгах бөгөөд уг комисс зөрчлийг арилгасны дараа шалгалтыг дахин хийж ачааг явуулна.

16.6. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг хоорондын зам болон өртөөгөөр нэвтрүүлэх:

16.6.1. I-II зэргийн доод, хажуугийн I-III, дээд I-II зэргийн хэтрүү овортой ачааг ердийн нөхцөлөөр явуулна;

16.6.2. III-VI зэргийн доод, хажуугийн IV-VI зэрэг, III зэргийн дээд хэтрүү овортой болон хэт хэтрүү овортой ачааг нэвтрүүлэн өнгөрүүлэх үед хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна;


16.6.3. өртөөний замаар IV-VI зэргийн хажуугийн ба доод хэтрүү овортой ачаатай галт тэргийг өнгөрүүлэхдээ зэргэлдээ зам дээрх хөдлөх бүрэлдэхүүн хязгаарын шонгоос дотогш 10 м-ээс доошгүй зайд байна;

16.6.4. өртөөний замаар IV-VI зэргийн хажуугийн ба доод хэтрүү овортой болон хэт хэтрүү овортой ачаатай галт тэргийг өнгөрүүлэх үед өртөөний зам дээр ажиллаж байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хангахад зайлшгүй мөрдөгдөх арга хэмжээг тээвэрлэгчийн шийдвэрээр тогтооно;

16.6.5. өртөөн дээр хэтрүү овортой ачаатай вагон байгаа бол өртөөний жижүүр /сэлгээний диспетчер/ ачааны байрлал бэхэлгээг шалгасан актад тусгагдсан заалтыг энэ тухай галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэнэ;

16.6.6. галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч ямар галт тэргэнд хүнд жинтэй, хэтрүү овортой ачаатай вагоныг холбох, галт тэрэгний явах цаг зэргийг товлон. Галт тэрэгний дугаар дээр хэтрүү оврын индексийг нэмж бичнэ;

16.6.7. хэтрүү оврын индекс нь хэтрүү овруудын индексийг заасан 3 оронтой тооноос бүрдэх бөгөөд эхний тоо нь доод хэтрүү овор, хоёр дахь тоо нь хажуугийн хэтрүү овор, сүүлийн тоо нь дээд хэтрүү оврын зэргүүдийг тус тус заана. Жишээ нь: Н-2030-ын Н-хэтрүү овортой /негабаритный/, 2-доод II зэргийн хэтрүү овор, 0 - хажуугийн хэтрүү оворгүй, 3-дээд III зэргийн хэтрүү овортойг зааж байна;



16.6.8. хэтрүү оворгүй бол 0 гэсэн тоогоор илэрхийлнэ. Хэрэв галт тэргэнд хэтрүү овортой хэд хэдэн ачаа байгаа бол хэтрүү оврын индексийг овор тус бүрийн хамгийн дээд зэргүүдийг заасан тоогоор илэрхийлж бичнэ;

16.6.9. галт тэргэнд хэт хэтрүү овортой ачаатай вагон байгаа бол хэтрүү оврын индексэд 8 гэсэн тоогоор тэмдэглэнэ. Жишээлбэл: Н-8538 гэсэн индексийн 8 нь доод хэт хэтрүү овор, 5 нь хажуугийн V зэрэг, 3 нь дээд III зэрэг, 8 нь босоо хэт хэтрүү овортой ачаа байгааг заана;

16.6.10. галт тэрэгний биечилсэн хуудас үйлдэж буй өртөөний ажилтан галт тэргэнд хэтрүү овортой ачаа байгаа бол хэтрүү оврын индексийг биечилсэн хуудсанд бичнэ;

16.6.11. хэрэв тухайн хэтрүү овортой ачааг зам болон дохиоллын засвар үйлчилгээ хариуцсан ажилтан дагалдан явах бол галт тэрэгний зохицуулагч зохих засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжүүдийн удирдлагад мэдэгдэнэ;

16.6.12. галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч хүнд жинтэй хэтрүү овортой ачаатай галт тэргийг явуулахын өмнө дараахь үүргийг хүлээнэ:

- уул галт тэргийг өнгөрүүлэхэд өртөөд бэлэн эсэхийг шалгах;
- доод, хажуу IV-VI зэрэгтэй, хэт хэтрүү овортой ачаа явуулах тухай шийдвэрээр замын засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн удирдлага шаардлагатай бол бусад байгууллагын удирдлагад мэдэгдэнэ.

16.6.13. ачааг хяналтын жаазтайгаар явуулахад замын мастераас доошгүй албан тушаалтан дагалдах бөгөөд шаардлагатай үед бусад байгууллагын ажилтныг дагалдуулж болно. Ачаа дагалдах этгээд нь зүтгүүрийн арын кабинаас ачааг хянаж явах бөгөөд шаардлагатай үед хяналтын жаазанд барилга байгууламж хүрсэн тохиолдолд галт тэргийг зогсоох дохиог машинчид өгнө. Хяналтын жаазтай ачаатай явж байгаа үед төхөөрөмж байгууламжийн хажуугаар өнгөрөхдөө галт тэрэгний хурд 40 км/цагаас ихгүй байна;

16.6.14. хэт хэтрүү овортой ачааг хяналтын жаазтайгаар тээвэрлэх галт тэрэг хоорондын замд 50 км/цагаас ихгүй хурдтай явна;

16.7. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачаа ачсан вагон, транспортеруудад сэлгээний ажил хийх, тэдгээрийг галт тэргэнд байрлуулах;

16.7.1. доод ба хажуугийн IV-VI зэрэгтэй хэтрүү овортой ачаа ачсан вагон ба транспортеруудад сэлгээний ажлыг 15 км/цагаас илүүгүй хурдтай гүйцэтгэнэ;



16.7.2. доод ба хажуугийн I-III зэрэгтэй хэтрүү овортой ачаанаас бусад хэтрүү овортой ачааг урт бүрэлдэхүүнтэй галт тэргэнд холбохгүй байхыг хатуу анхаарч ажиллана;

16.7.3. хяналтын жаазтай вагоныг галт тэргэнд холбохдоо зүтгүүрийн ард буюу түүний дээд үзэгдэлтийг сайжруулахын тулд хоосон нэг тавцант вагоноор тусгаарлана. Доод ба хажуугийн VI зэрэгтэй хэтрүү овортой ачаа болон хэт хэтрүү овортой ачаатай вагоныг галт тэрэгний дунд хэсэгт хяналтын жаазтай вагоноос 20-иос доошгүй вагоны зайтай байрлуулна;

16.7.4. хяналтын жаазтайгаар тусгай галт тэргээр тусдаа зүтгүүртэй хэтрүү болон хэт хэтрүү овортой тээвэрлэхэд хяналтын жаазнаас 5 вагоноос ойргүй зайд байх ёстой. Тухайн ачааг галт тэрэгний төгсгөлөөс хоосон ба овор хэмжээнд багтсан 1-ээс доошгүй вагоноор халхалсан байна;

16.7.5. доод ба хажуугийн IV-V зэргийн хэтрүү овортой ачааг галт тэрэгний толгой ба сүүлээс 1-ээс доошгүй хоосон буюу оворт багтсан вагоноор халхална;

16.7.6. 12 болон түүнээс олон голтой ачаатай транспортеруудийг /120 тн даацтай угсраа транспортеруудаас бусад/ галт тэргэнд байрлуулахад түүний 2 талд нь 40 тн-оос илүүгүй жинтэй 4 голт 2-оос доошгүй ачаатай буюу хоосон вагоноор халхална;

16.7.7. хоосон болон ачаатай 4 голт угсраа 120 тоннын даацтай транспортерийг галт тэргэнд халхалтгүй тавина;

16.7.8. найм ба түүнээс олон голтой хоосон транспортеруудыг 3000 тонноос дээш жинтэй галт тэргэнд сүүлийн 1/4 хэсэгт байрлуулна. Бага жинтэй галт тэргэнд дээрх транспортерийг аль ч хэсэгт байрлуулж болно.


АРВАНДОЛДУГААР БҮЛЭГ

ЦИСТЕРН БОЛОН БУНКЕРТ ВАГОНД ШИНГЭН АЧАА ТЭЭВЭРЛЭХ

17.1. Цистерн болон бункерт вагонд юүлмэгээр тээвэрлэх ачааны жагсаалтыг тээвэрлэгч тогтооно. Уг жагсаалтад заагдаагүй бусад шингэн ачааг илгээгчийн гаргасан батламжаар тээвэрлэж болох бөгөөд уг батламжийг ачааг тээвэрлэхээс 6 сараас багагүй хугацааны өмнө тээвэрлэгчид ирүүлнэ.

17.2. Тээвэрлэлтэд ирүүлэх ачаа нь тухайн бүтээгдэхүүний зохих MNS EN 12561-1,2,3,4,5,6:2016 стандарт ба техникийн нөхцөлийг хангасан байна.

17.3. Төмөр замын тээврийн падаанд ачааны нэр, онцгой тэмдэглэл, ачааны шинж чанарын тухай мэдээллийг буруу бичсэнээс ачаа тээвэрлэх хөлс буурсан, төмөр замын тээврийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдалд аюул үүсгэх нөхцөл



бүрдсэн болон төмөр замын тээврээр тээвэрлэхийг хориглосон ачааг явуулснаас учирсан хохирлыг төлсөн эсэхийг үл харгалзан ачааг гэрээнд заасан торгуулийг тээвэрлэгчид ачаа илгээгч төлнө.

17.4. Тээвэрлүүлэгч, тээвэрлэгч, суурь бүтэц эзэмшигчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хор хохирлын хариуцлагыг буруутай этгээд хүлээнэ.

17.5. Цистерн ба бункерт вагонд тавигдах шаардлага:

17.5.1. шингэн ачааг тээвэрлэхэд тээвэрлэгч, ачаа илгээгч, хүлээн авагчийн эзэмшлийн буюу тээвэрлэгчээс түрээслэн авсан техникийн гэмтэлгүй тусгай цистерн /цаашид "эзэмшлийн цистерн", "түрээсийн цистерн" гэх/, бункерт хагас вагоныг ашиглана;


17.5.2. бункерт вагонд зөвхөн өтгөн /унжрамтгай/ нефть бүтээгдэхүүн ба нефтийн коксыг тээвэрлэнэ. Ийм вагонд хатуу маркийн нефть, битум тээвэрлэхийг зөвшөөрөхгүй;

17.5.3. даац нь 120 ба 125 тонн, торхны багтаамж нь 140 ба 161 куб.м /калибрын хэв 61 ба 71/ "Бензин", "Тунгалаг нефть бүтээгдэхүүн" хэв бичээстэй найман голтой цистерн, түүнчлэн даац нь 68 тонн, торхны багтаамж нь 85.6 куб.м /калибрын хэв 53/ "Бензин" хэв бичээстэй цистернийг зөвхөн бензин, керосин, дизелийн түлш болон бусад тунгалаг нефть бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд хэрэглэнэ;

17.5.4. аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээгүй цистернийг нийтийн хэрэглээний төмөр замын тээвэрт аялуулахгүй байхыг хатуу анхаарч ажиллана;

17.5.5. цистерн, бункерт вагонд дараахь тохиолдолд ачаа тээвэрлэхгүй байхыг хатуу анхаарна:

- төлөвлөгөөт засвар буюу торх болон торхны суурь магадлагаа хийхэд 1 сараас бага хугацаа үлдсэн байвал;
- үйлдвэрлэсэн үйлдвэрийн хэв бичээс болон вагоны дугаар нь тод бус байвал;
- вагоны гадна шат /вагоны хийцэд дурдсан байвал/, дамжих тавцан, ажлын талбай, хамгаалах хайс байхгүй буюу гэмтэлтэй байвал;
- цистерны торх, бункерт хагас вагонд гоожилт, сэргийлэх оньс, цутгах юүлэх торхны суурийн гэмтэл, цистерн, бункерт хагас вагоны уурын цамц цоорхой байвал;
- цутгах болон юүлэх нээлхийний таг дээр цууралт байвал;



- цистерны ачаалах нээлхийн тагны 2 болон түүнээс дээш боолт гэмтэлтэй эсвэл байхгүй, нээлхийн тагийг ломбодоход зориулсан сүвэгч байхгүй байвал;
- цистерны ачааны нээлхийн тагны нягтруулах чигжээс байхгүй бол;
- аюулын бичээс, тэмдэг, хэв бичээс, ялгах будалт байхгүй тохиолдод.

17.5.6. цистернийг үйлдвэрлэсэн үйлдвэрийн хүснэгтийн зэрэгцээгээр торх нь онцлох аюулын тэмдэг, бичээс болон будалттай байна.

17.5.7. эзэмшлийнхээ цистерны ёроол, жаазыг ногоон өнгөөр, торхыг тойруулж 300 мм өргөн цагаанаар будна.

Эзэмшлийн болон түрээсийн цистерны ёроолд:

“ _____ -нд даруй буцаана”,
/өртөө болон бүртгэлтэй суурь бүтцийн нэрийг заана/

харин доор нь “ _____ түрээслэн авсан
/түрээслэгч эсхүл эзэмшигчийн нэрийг заана/

буюу эзэмшлийн _____ оны” гэсэн хэв бичээс тавина.

17.5.8. энэхүү журамд дурдсан шаардлагатай бичээс, хэв бичээс, түүнчлэн будалт, цистерны торхны онцолсон будалтыг эзэмшлийн болон түрээслэн авсан цистерныг эзэмшигч, түрээслэгч, тээвэрлэгчийн цистерныг тээвэрлэгч тус тус хийнэ;

17.5.9. энэхүү журмын дагуу цистерн вагонд шингэн ачааг тээвэрлэхэд аюултай ачаа тээвэрлэх нийтлэг нөхцөлийг дагаж мөрдөнө.

АРВАННАЙМДУГААР БҮЛЭГ


ВАГОН, ЧИНГЭЛЭГ ЛОМБОДОХ

18.1. Энэхүү бүлгээр төмөр замаар тээвэрлэхээр ачигдсан вагон болон чингэлгүүдийг битүүмжлэх ажиллагааг зохицуулна.

18.2. Ломбо нь ачааг битүүмжлэх баталгаа болно. Вагон, чингэлэгт тавьсан ломбо нь вагон, чингэлгээс түүний битүүмжлэлийг эвдэлгүйгээр авч болохооргүй байна.

18.3. Ломбодох нөхцөл:

18.3.1. вагоныг ломбодохын өмнө 2 талын хаалганы цүүг 250-260 мм-ээс багагүй урттай 6 мм-ийн голчтой зөөлрүүлсэн төмөр утсаар тусгай зориулалтын түдүүл тавьж зориулалтын багажаар мушгин эрчилнэ. Төмөр утсыг хаалганы цүүг вагоны яс модны цуурганы хамт бариулан үзүүрийг дээш харуулан эрчлэн мушгих



ба эрчлээсийн тоо 9-өөс доошгүй байна. Чингэлгийг ломбодохын өмнө хаалганы бариулыг үүрэнд нь оруулан бүтэн оньсолж түгжээд 240-250 мм-ийн урттай 4мм-ийн голчтой зөөлрүүлсэн төмөр утсаар эрчилсний дараа ломбоны үзүүрийг хаалганы цүү цуурга хоёрын нүхээр нэвт сүвлэж ломбоны хоногонд шахаж оруулна. Түгжигдсэн эсэхийг утаснаас татаж шалгана. Ломбыг зүүхээс өмнө бүрэн бүтэн байдлыг шалгаж үзэх ба гэмтэлтэй ломбоор вагон, чингэлгийг ломбодохгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

18.3.2. вагон, чингэлгийг ломбодоод вагоны хуудсанд ломбоны тоо, хяналтын тэмдэглэл хийнэ. Вагон, чингэлгийн ломбо бүртгэлийн дэвтэрт энэ тухай тэмдэглэл хийнэ:

- ачааг тээвэрлэгчийн хүч хэрэгслээр ачсан бол тээвэрлэгчийн ломбоор;
- ачааг илгээгчийн хүч хэрэгслээр ачсан бол илгээгчийн ломбоор тус тус ломбодно.

18.3.3. илгээгчийн хүсэлтийн дагуу ачилтын дараа вагон, чингэлгийг төмөр замын байгууллагын ломбоор ломбодож болох ба хүсэлтийг бичгээр гарган ачилт хийх тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга, орлогчоос зөвшөөрөл авна. Ийм тохиолдолд төмөр замын байгууллагын ломбыг илгээгчийн ломбо гэж тооцно;

18.3.4. ачаа нь суларсан вагон, чингэлгийг ачааны үлдэгдлээс бүрэн цэвэрлэж, хоосон вагон, чингэлэгт /битүү вагоны цүүг нэгдүгээр шүдэнд нь түгжиж/ эрээс тавина;

- тээвэрлэгчийн хүч хэрэгслээр буулгалтыг хийсэн бол тээвэрлэгч;
- ачаа хүлээн авагч буулгалтыг хийсэн бол ачаа хүлээн авагч тавина.

18.3.5. вагон, чингэлэгт ломбыг:

- битүү вагоны хоёр талын хаалга тус бүрт;
- цистерний ачаа юүлэх таганд;
- тогтмол дулаант вагоны ломбодох төхөөрөмж бүрт;
- хопперийг дээд нээлхий болон буулгах төхөөрөмж бүрт;
- чингэлгийг, дардаг хаалганы түгжээний бариул тус бүрт тавина.

18.3.6. ачаа алдагдаж болзошгүй гэж үзвэл битүү вагоны дээд, хажуугийн болон хаалганы нээлхийд, цистерний агааржуулагч, ачааг юүлэх тагны нугас, доод хүйсэнд нэмж ломбо тавьж болно.



18.3.7. вагон, чингэлгийг дэс дараалсан дугаартай ломбоор ломбодно.

18.3.8. илгээх өртөөнд вагон, чингэлгийг задлан шалгах шаардлага гарсан тохиолдолд ачаа илгээгчийг заавал оролцуулах бөгөөд шалгаж дууссаны дараа дахин ломбодоход энэхүү журмын 18.3.1-т заасныг баримтална.

18.3.9. илгээх өртөөнөөс гэмтэлтэй ломботой болон буруу ломбодсон вагон, чингэлгийг явуулахыг хориглох ба тээвэрлэгч тээвэрт хүлээн авахаас татгалзах эрхтэй.

18.3.10. зам зуурын өртөө болон хүрэх өртөөнд ломбоны зөрчил гэмтэлтэй вагон, чингэлэг ирсэн тохиолдолд ломбыг сольж ломбодон ерөнхий маягтын акт тогтоох ба энэ тухай вагоны хуудсанд тэмдэглэл хийж, тээвэрлэгчийн эрх бүхий холбогдох байгууллагуудад цахилгаанаар мэдэгдэнэ.

18.3.11. хүрэх өртөөнд вагон чингэлгийн тээврийн бичиг баримтан дах ломбоны тэмдэглэл биет байдалтай зөрөх, түүнчлэн зам зуурын өртөөнд сольсон ломботой ачааг хүлээн авагчид олгохдоо тээвэрлэгчийн төлөөлөгчийг оролцуулна.

18.3.12. илгээгчийн ломботой вагон, чингэлэгтэй ачаанд тээвэрлэлтийн явцад хууль хяналт, гааль, мал эмнэлэг, хорио цээрийн байгууллагаас шалгалт хийж ломбо сольсон бол зохих актыг тогтоож, тээврийн бичиг баримтны зохих хүснэгтэд-тэмдэглэл хийнэ. Хүрэх өртөөнд уг ачааг хүлээн авагчид ломбоор нь хүлээлгэн өгнө.

18.3.13. задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан машин техник, тоног төхөөрөмжийн битүүмжлэгдсэн хэсгүүд болон амархан авагдах эд ангиудийг хийж битүүмжилсэн хайрцаг, савыг илгээгчийн ломбоор ломбодно.

18.3.14. хилийн өртөөдөд экспорт, импортоор болон транзитаар тээвэрлэгдэж байгаа вагон, чингэлгийн ломбыг Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээрт заасны дагуу хүлээлцэнэ.

18.4. Ломбыг дараахь тохиолдолд зөрчил, гэмтэлтэй гэж үзнэ:

18.4.1. ломбоны утас тасархай байх;

18.4.2. ломбо хоногондоо дутуу орсон эсхүл огт ороогүй байх;


18.4.3. ломбоны дугаар, хяналтын тэмдэг, код балархай, тод бус байх;

18.4.4. ломбо хагарч цуурсан, бүрэн бүтэн байдал нь алдагдсан байх;

18.4.5. өөр өөр ломботой байх;

18.4.6. гадны нөлөөтэй байж болзошгүй зөрчил зэрэг болно.

18.5. Вагон, чингэлгээс ломбо эрчлээс төмрийг авах:



18.5.1. вагон, чингэлгээс троссон ломбыг авахдаа ломбоны утасны үзүүр орсны эсрэг талын угаар зориулалтын хайчаар тасалж авна. Ломбыг гэмтээж болзошгүй зүйлээр цохиж тасалж авахгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

18.5.2. вагон, чингэлгээс тугалган ломбыг авахад утсыг ломбоноос 3-4 см-ийн зайд тайрч авна;

18.5.3. вагон, чингэлгээс эрчлээс төмрийг авахад зориулалтын хайчаар эрчлээсийн угаар тасалж авна.

18.6. Ломбон дээр дараахь тэмдэглэгээ байна.

- тээвэрлэгчийн эсвэл илгээгчийн товчилсон нэр;
- хяналтын тэмдэг ба тоо;
- ломбоны төрөл.

18.6.2. үйлдвэрлэгч, тээвэрлэгч, ачаа хүлээн авагч, илгээгчийн ломбоны дугаар нь хатуу хяналтад байна.

АРВАНЕСДҮГЭЭР БҮЛЭГ

АЧАА ХАМГААЛАХ

19.1. Төмөр замаар заавал харуул хамгаалалтад авах шаардлагатай ачааны тээвэрлэлтийг энэхүү бүлгээр зохицуулна.


19.2. Байнгын болон төлбөртэй хамгаалалттайгаар тээвэрлэгдэх ачааны хамгаалалтын хөлсийг тогтоож мөрдөх асуудлыг энэхүү журам болон нийтлэг багц дүрэмтэй уялдуулна.

19.3. "Паркийн харуул" гэж өртөөний зам, паркад ачаа, вагоныг хянаж, хамгаалах үүрэгтэй тээвэрлэгчийн эрх бүхий хамгаалалтын байгууллагын ажилтныг хэлнэ.

19.4. "Ачаа хамгаалагч" гэж хоорондын замд ачаа, вагоныг хянаж, хамгаалах үүрэгтэй тээвэрлэгчийн эрх бүхий хамгаалалтын байгууллагын ажилтныг хэлнэ.

19.5. "Ерөнхий маягтын акт" гэж ачаа тээвэрлэх явцад зөрчил илэрсэн тохиолдол бүрт үйлдэж байгаа тээвэрлэгчийн эрх бүхий ажилтны баримт бичгийг ойлгоно.

19.6. Төмөр замаар илгээх болон хилийн өртөөнөөс хүлээн авснаас эхлэн хүрэх болон хилийн өртөөнд хүлээлгэн өгөх хүртэл тээвэрлэгчийн баталсан



шийдвэр, жагсаалтад байгаа ачааны бүрэн бүтэн байдлыг хамгаалалтын эрх бүхий байгууллага хариуцна.

19.7. Ачааны бүрэн бүтэн байдлыг паркийн харуултай өртөөнд паркийн харуулаас ачааг хүлээн авч салбар замд хүлээлгэн өгөх хүртэл, салбар замаас ачааг хүлээн авч паркийн харуулд хүлээлгэн өгөх хүртэл өртөө хариуцна. Паркийн харуулгүй өртөөнд ачаа ирснээс эсвэл ачааг хамгаалагчаас хүлээн авч салбар замд хүлээлгэн өгөх хүртэл, салбар замаас хүлээн авснаас ачаа хамгаалагчид хүлээлгэн өгөх хүртэл өртөө хариуцна. Хамгаалалттай ачааг хүлээлцэх дэвтэрт бичсэн замналын хуудас, актаар хариуцлагыг тодорхойлно.

19.8. Ачаа, вагон хүлээлцэгч санамжид гарын үсэг зуралцсан агшнаас тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд ачааг хүлээлцсэнд тооцно. Ачаа хүлээлцэхэд ачааны бүрэн байдал алдагдсан /ломбо гэмтэлтэй, сав боодол задарсан, вагоны хана, шал нээлхий, хаалга гэмтэлтэй онгорхой гэх мэт/ байдал илэрвэл энэ тухай санамжид тэмдэглэл хийж хүлээлцэнэ.

19.9. Харуул хамгаалалттай ирсэн ачаа хүлээлцэхэд түүний бүрэн бүтэн байдал алдагдсан зөрчил илэрвэл энэ тухай ерөнхий маягтын актыг 3 хувь бичнэ. Ерөнхий маягтын актын хувиудыг өртөө, эрх бүхий хамгаалалтын байгууллага тээврийн бичиг баримтад хавсаргана. Шаардлагатай тохиолдолд ерөнхий маягтын актыг 3-аас дээш хувь үйлдэж болно.

19.10. Хамгаалалттай ирсэн ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан шинж, тэмдэг бүхий гэмтлүүд /ломбо тасарсан, гэмтсэн, сав баглаа задарсан, вагоны хана, хаалга, шал, нээлхий, цүү цуурга гэмтсэн гэх мэт/ илэрвэл тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын болон цагдаагийн ажилтанг заавал байлцуулан акт тавина.

19.11. Хилийн өртөөгөөр дамжих тэсэрч дэлбэрэх "ВВ", хортой "ЯВ" ачааг тээвэрлэгчийн хамгаалалтын байгууллагад хүлээлгэн өгөх ачааг хамгаалагч бүх л замын турш дагалдан хамгаалж, ачаа хүлээн авагчид хүлээлгэн өгнө.

19.12. Хамгаалалттай ачаатай зөрчилгүй чингэлгүүдийг вагонд ам дарж ачигдсан үед хамгаалалтад авах шаардлагагүй. Хамгаалалттай тээвэрлэх ачааны жагсаалтад ороогүй ачааг ачсан цистерн, их дунд даацны чингэлгүүдийг нэг удаагийн троссон ломбоор ломбодно. Хамгаалалтгүй ачаанд ачаа тээврийн ямар нэгэн зөрчил илэрсэн тохиолдолд тухайн галт тэргэнд явсан ачаа хамгаалагч, машинч нар холбогдох мэдээллийг тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. Вагон болон чингэлгүүдийг түдүүл тавьж 4-6 мм төмөр утсаар эрчлэн зөвхөн нэг удаагийн ломбоор ломбодож вагон хуудас болон тээврийн бичиг баримтад хяналтын дугаарыг тэмдэглэнэ. Ломбоны дугаар, хяналтын тэмдэг нь ижил байх шаардлагагүй.



19.22.4. хамгаалалттай ачааг галт тэргэнд холбож илгээх үед галт тэрэгний биечилсэн хуудсанд тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан "хамгаалалттай" гэсэн тэмдэглэл хийж ачаа хамгаалагчаар гарын үсэг зуруулж, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэн хамгаалалттай вагоны дугаар, хамгаалагчийн нэрийг бичнэ;

19.22.5. хамгаалалттай тээвэрлэгдэх ачаа бүхий галт тэргэнд харуул хамгаалалттай холбогдон гарсан зөрчлийг арилгаагүй, эсвэл ачаа хамгаалагчийг оройтуулан дуудаж, хүрэлцэн ирээгүй байхад галт тэргийг өртөөнөөс явуулахгүй байхыг хатуу анхаарч ажиллана;

19.22.6. өртөөний жижүүр нь хамгаалалттай ачаа явуулах тухай галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэж, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчаас шийдвэр авмагц 1 цаг 30 минутын өмнө хамгаалагч дуудах шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагын жижүүрт утсаар мэдэгдэж, шийдвэрийн дэвтэрт мэдээлэл хүлээн авсан, өгсөн хүний нэр, албан тушаал, огноог тэмдэглэнэ;


19.22.7. ачаа хамгаалагч нь хамгаалах ачааг паркийн харуултай өртөөнд паркийн харуулаас, паркийн харуулгүй өртөөнд тээвэрлэгчийн эрх бүхий ажилтнаас хүлээн авна;

19.22.8. задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан ачааны сав, баглаа, боодол нь бүрэн бүтэн байдалтайгаар тоо ширхэгийг нь зааж паркийн харуул болон ачаа хамгаалагчид хүлээлгэн өгнө;

19.22.9. өртөөнд ачаа тээврийн болон техникийн зөрчилтэй шалтгаанаар удаан зогсож байгаа ачаатай вагонуудыг шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй зам дээр тавьж зөрчлийг арилган паркийн харуулд хүлээлгэж өгнө. Зөрчлийг арилгах боломжгүй тохиолдолд ачаа, вагоны зөрчлийн байдлыг зааж ерөнхий маягтын актаар тодорхойлж паркийн харуулд хүлээлгэж өгнө;

19.22.10. паркийн харуул байхгүй өртөөнд ямар нэгэн шалтгаанаар вагон удаан хугацаагаар зогсоход хүрвэл өртөөний дарга галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэж харуул буюу ачаа хамгаалагч дуудуулж хамгаалалтад өгнө;

19.22.11. хамгаалалттай тээвэрлэгдэж буй ачааны бүрэн бүтэн байдал алдагдвал энэ тухай ачаа хамгаалагч нь өртөөний удирдлагад мэдэгдэх бөгөөд тээвэрлэгчийн эрх бүхий ажилтнууд хамтран ачаа, вагоны байдлыг тодорхой тусгасан тээврийн буюу ерөнхий маягтын акт тогтоож, энэ тухай тээврийн бичиг баримтад тэмдэглэл хийж, актын 1 хувийг хавсаргана;



19.22.12. хүрэх өртөө паркийн харуултай байвал ачаа хамгаалагч ачааг шууд паркийн харуулд өртөөний ажилтны оролцоогүйгээр хүлээлгэн өгнө. Харин ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан болон ачаа тээврийн зөрчил илэрсэн тохиолдолд өртөөний ажилтны оролцоотойгоор хүлээлцэнэ;

19.22.13. хүрэх өртөөнд паркийн харуулгүй бол хамгаалалттай ирсэн ачааг тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан ачаа хамгаалагчаас хүлээн авч түүний замналын хүснэгтэд ачаа хүлээн авсан тухай тэмдэглэл хийж гарын үсэг зурна. Хамгаалагчаас ачаа хүлээн авахад ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан, эвдэрсэн, гэмтсэн ул мөр илэрвэл ачаа хүлээн авсан өртөөний ажилтан, хамгаалагч нар ерөнхий маягтын акт тогтоож гарын үсэг зурах бөгөөд ачааг хүлээн авагчид олгоход эрх бүхий ажилтныг заавал оролцуулна;

19.22.14. хамгаалалттай тээвэрлэгдэх ачааны нэрсийн жагсаалтад заасан ачааны тээврийн падааны дээд талд болон вагон хуудсанд "хамгаалалттай" гэсэн тэмдгийг тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан тавина;

19.22.15. өртөө бүр өөрийн нэр кодтой, "хамгаалалттай" гэсэн нэг загварын дардастай байна. Өөр төрлийн "хамгаалалттай" гэсэн тэмдэглэлийг хүчингүйд тооцно.

19.23. Тээвэрлэгдэх ачааны бүрэн бүтэн байдлыг хангахад галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч дараахь үүргийг гүйцэтгэнэ:


19.23.1. галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь өртөөнөөс хамгаалалттай ачаа явуулахаас 1 цаг 30 минутын өмнө тухайн өртөөний жижүүрт галт тэрэг явах цаг, минутыг тодорхой зааж хамгаалагч дуудаж явуулах шийдвэр өгнө;

19.23.2. галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч нь хамгаалалттай ачааны тухай галт тэрэгний хөдөлгөөний зурмагт вагоны дугаар, хамгаалагчийн нэр, "хамгаалалт" гэсэн тэмдэглэл хийж аялалын явцад хяналт тавина;

19.24. Тээвэрлэгдэх ачааны бүрэн бүтэн байдлыг хангахад хамгаалалтын эрх бүхий байгууллага дараахь үүргийг хүлээнэ:

19.24.1. эрх бүхий байгууллага нь ачаа хамгаалагч болон паркийн харуулын ажил үүргийн хуваарийг зохион байгуулж зэвсэгт харуулаар хангана;

19.24.2. ачаа хамгаалагч болон паркийн харуулууд нь хоорондын замд болон өртөө зөрлөгүүд дээр хамгаалж буй ачаанд зөрчил гарвал эрх бүхий ажилтанд мэдэгдэж, үзлэг шалгалт хийлгэн ерөнхий маягтын акт тогтоолгон, боломжтой бол уг зөрчлийг арилгуулна;



19.24.3. ачаатай, битүү болон цистерн вагоныг хүлээн авахад вагоны тэвш, дээвэр, шал, духны хана цоорхой эсэх, дотор талаас нь нөхсөн эсэх, хажуугийн болон дээд нээлхий бүрэн бүтэн, хаалга, цуурга зөв түгжигдсэн эсэх, эрээс утас, ломбоны утас шаардлага хангасан эсэх, хяналтын тэмдгүүд тодорхой зэргийг нарийвчлан шалгана;

19.24.4. задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан машин тоног төхөөрөмж, бусад техникүүдийн ломбоны жагсаалтуудыг үндэслэн хүлээж авна. Машин бусад техникийн амархан авагдах эд ангийн байдал, түүний дагалдах хэрэгсэл, тоо, хаана байрласныг тодорхой шалгаж авна;

19.24.5. вагоныг хамгаалалтад хүлээн авахдаа ямар нэг зүйлээр ханыг цохиж болохгүй. Машин болон ломбонд үзлэг хийхдээ машины бүхээг, тэвш, бусад эд ангийг зурагдахаас болгоомжилбол зохино;

19.24.6. ачааны бичиг баримтад вагонд ачигдсан машин, хайрцагны тоог заасан байна;


19.24.7. эрх бүхий байгууллагын хамгаалах ачаа нь гэмтэлгүй бүтэн ломботой байх шаардлагатай;

19.24.8. эрх бүхий байгууллагын ажилтан өртөөний "хамгаалалтад ачаа хүлээлцэх дэвтэр"-т гарын үсэг зурсан агшнаас ачааг хамгаалалтад хүлээн авсанд тооцно;

19.24.9. энэхүү журмын хамгаалалттай тээвэрлэгдэх ачааны жагсаалтад заагдаагүй боловч тээвэрлэгчийн шийдвэр болон тээвэрлүүлэгчийн хүсэлтээр төлбөртэйгээр ямар ч төрлийн ачааг хамгаалж болно.

19.25. Хоорондын замд хамгаалалттай тээвэрлэх ачааны жагсаалт:

- бүх төрлийн ашиглагдаагүй шинэ автомашин, трактор, машин механизм тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, бүх төрлийн чиргүүл;
- тэсэрч дэлбэрэх "ВВ", хортой "ЯВ", шингэрүүлсэн хий;
- ноос, ноолуур, савхи, торго түүгээр хийсэн өргөн хэрэглээний бараа;
- арьс, нэхий, ангийн үс;
- бүх төрлийн архи, дарс, спирт;
- галт зэвсэг, төрөл бүрийн ангийн буу, түүний сум хэрэгсэл;
- гадаад улсын төлөөлөгч болон дипломат байгууллагын ачаа;



- машины болон цахилгаан хөдөлгүүр, цахилгаан хэрэгсэл;
- хүнсний ачаа /үр тарианаас бусад/;
- тусгай тоноглол бүхий вагон;
- молибдены баяжмал.

19.26. Энэ жагсаалтад ороогүй боловч хамгаалах шаардлагатай гэж үзсэн ачааг тээвэрлэгчийн шуурхай шийдвэрээр хамгаалалтад өгнө.

19.27. Паркийн зам дээр хамгаалах ачааны жагсаалт:

- бүх төрлийн ашиглагдаагүй шинэ автомашин, трактор, машин механизм тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, бүх төрлийн чиргүүл;
- тэсэрч дэлбэрэх "ВВ", хортой "ЯВ", шингэрүүлсэн хий;
- ноос, ноолуур, савхи, торго, түүгээр хийсэн өргөн хэрэглээний бараа;
- арьс, нэхий, ангийн үс;
- бүх төрлийн архи, дарс, спирт;
- галт зэвсэг, төрөл бүрийн ангийн буу, түүний сум хэрэгсэл;
- гадаад улсын төлөөлөгч болон дипломат байгууллагын ачаа;
- машины болон цахилгаан хөдөлгүүр, цахилгаан хэрэгсэл;
- хүнсний ачаа /үр тарианаас бусад/ ;
- тусгай тоноглол бүхий вагон;
- бензин, дизелийн түлш;
- молибдены баяжмал.


19.28. Энэ жагсаалтад ороогүй боловч хамгаалах шаардлагатай гэж үзсэн ачааг тээвэрлэгчийн шуурхай шийдвэрээр хамгаалалтад өгнө.

ХОРЬДУГААР БҮЛЭГ

ИЛГЭЭЛТИЙН ХАЯГ СОЛИХ

20.1. Илгээлтийн хаяг солиулах тухай хүсэлтэд дараахь өгөгдлүүдийг тодорхой тусгасан байна:

- ачааны нэр, жин /нэрийн код/;



- вагон болон илгээлтийн /падааны/ дугаар;
- илгээх өртөөний нэр /код/;
- анхны хүрэх өртөө, хүлээн авагчийн нэр /код/;
- ачаа илгээгчийн нэр, хаяг /код/;
- хүрэх зам, өртөөний нэр /код/;
- шинээр хүрэх зам, өртөөний нэр /код/;
- шинэ хүлээн авагчийн нэр хаяг /код/;
- тээвэрлэгчийн нэр /код/;
- хэтрүү овортой ачаа бол оврын зэрэг.

20.2. Тээвэрлүүлэгч нь хаяг солих болсон шалтгаан, ачааны шинэ хүлээн авагч ачааг хүлээн авах тухай бичгэн зөвшөөрлийг хавсаргана.

20.3. Хаяг солих өртөөн дээр ямар байгууллага болон албан тушаалтан хаяг солих ачааны бичиг баримтыг бүрдүүлэх, тээврийн тооцоог хэрхэн хийх тухай заалтыг бичнэ.

20.4. Тээвэрлүүлэгч хуулийн этгээдийн илгээлтийн хаяг солих хүсэлтэд улсын бүртгэлийн гэрчилгээ, албан бичгийн маягт /бланк/ дээр бичигдсэн байхаас гадна байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг, тэмдгээр баталгаажсан байна.

20.5. Илгээлтийн хаяг солилт хийхдээ тээвэрлүүлэгчийн иргэн, хуулийн этгээдийн бичиг баримт, регистрын дугаар, шуудангийн хаяг, харилцах утасны дугаар, орлох падаан зэргийг бүрдүүлнэ.

20.6. Хаяг солих:

20.6.1. тээвэрлэгч нь илгээлтийн хаяг солих үйл ажиллагааг хаяг солих эрх бүхий этгээдийн зөвшөөрөл, хүсэлтийн үндсэн дээр зохион байгуулна;

20.6.2. хаяг солих, тээврийн бичиг баримт дахин үйлдэх ажиллагааг хүрэх өртөө, зам зуур болон орох хилийн өртөөдийн тооцооны газарт гүйцэтгэнэ;

20.6.3. илгээлтийн хаяг солилтыг шинэ буюу хуучин бичиг баримтаар солино. Хуучин бичиг баримтаар хаяг солиход зөвхөн чиглэлийн дагуу солино;



20.6.4. хэтрүү овортой болон аюултай /ВВ/ илгээлтийн хаяг солихыг зөвхөн тээвэрлэгч тухайн хүрэх өртөө нь аюултай ачааны тээвэрлэлтэд нээлттэй, зориулалтын замтай тохиолдолд зөвшөөрнө;

20.6.5. илгээлтийн хаяг солихыг дараахь тохиолдолд зөвшөөрөхгүй:

- давтан буюу буцах чиглэлд /гэр ахуйн хэрэглэлээс бусад/;
- хөргүүрт галт тэргэнд тээвэрлэгдэж буй ачааны агааржуулалтын болон температурын дэглэм алдагдсан, ачаа гэмтсэн, муудсан, ломбоны зөрчилтэйн улмаас зам зуурын өртөөнд акт тавигдсан.

20.6.6. илгээлтийн хаяг солих хүсэлтийг биечлэн, эсвэл цахим хэлбэрээр тээвэрлэгчид ирүүлж болно. Хүсэлт гаргахад энэ журмын 20.1-д заасан өгөгдлийг заавал хамт өгнө;

20.6.7. хувийн эзэмшлийн болон түрээсийн хоосон вагоны хаягийг солиход ердийн журмаар гүйцэтгэнэ;

20.6.8. нэг падаан /илгээлт/-тай бөгөөд вагонд бүлгээр ачигдсан болон замналаар тээвэрлэх ачааг нийтэд нь хаяг солиход ердийн журмаар гүйцэтгэнэ. Нэг падаантай бөгөөд тээш, ахуйн хэрэглээний бараанаас бусад ачаа ачсан чингэлэг, вагон болон замналаар тээвэрлэж байгаа ачаанаас ганц нэгээр нь салгаж хаяг солихгүй байхыг хатуу анхаарч ажиллана. Энэ тохиолдолд ачаа хүрэх өртөөнд очсоны дараа хаяг солихыг зөвшөөрнө;

20.6.9. шинээр хаяг сольсон хүрэх өртөөнд очиход сертификат буюу чанарын гэрчилгээнд заасан хугацаа нь хэтрээгүй тохиолдолд түргэн муудах, хялбар гэмтэх ачааны хаяг солихыг тээвэрлэгч зөвшөөрч болно;

20.6.10. илгээлтийн хаяг солиход ачаа хүргэх хугацааг тооцохдоо багц дүрэм, Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээрийн зохих заалтыг харгалзан үзнэ.

20.6.11. хүрэх өртөөнд ирсэн вагонтой ачааг өөр хүлээн авагчид хаяг солих бол ачаа хүлээн авахыг зөвшөөрсөн бичгэн хүсэлтийг анхны ачаа хүлээн авагч нь тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтанд өгснөөр гүйцэтгэнэ.

20.6.12. илгээлтийн хаяг солих тохиолдолд тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны албан тоотын дугаар, гарын үсэг бүхий бичгэн зөвшөөрлийг хаяг солих өртөөнд хаяглан шуурхай шийдвэрийг өгнө. Орох хилийн өртөөнд болон зам зуурт илгээлтийн хаяг сольсон бол тээврийн бичиг баримтын зохих хүснэгтэд тэмдэглэл хийж явуулна.

20.7. Тээврийн бичиг баримт бүрдүүлэх, төлбөр тооцоо хийх:



20.7.1. ачааны хүрэх өртөө, хүлээн авагчийн хаяг өөрчилснөөс үүсэх төлбөр /үйлчилгээний хөлс, хураамж/ тооцоог тээврийн тарифын дагуу хийнэ;

20.7.2. ачааны хүрэх өртөө, хүлээн авагчийн хаяг өөрчлөн олгох үед ачаа хүлээн авагч бүх тооцоог хийж тээврийн бичиг баримтыг зарлагадсаны дараа шинэ хүлээн авагчид ачаатай вагоныг тавьж өгнө. Вагоны тавилт, таталтын тооцоог шинэ хүлээн авагчийн нэр дээр нээж вагоны тавилт, таталт болон ачааны ажиллагаанд зогсоосон вагоны төлбөр /үйлчилгээний хөлс, хураамж/-ийг хурааж авна. Өртөөн доторх салбар замын сонголтын хөлсийг мөрдөгдөж буй тарифыг үндэслэн тооцно. Төлбөрийг авах үндэс нь өртөөний эрх бүхий албан тушаалтны цохолттой бичгэн хүсэлт болно. Хүсэлтийг өртөөний бичиг хэрэгт хадгална;

20.7.3. падаанд заасан хүлээн авагч нь ачаа хүрэх өртөөнд байхгүй бол илгээгчийн заалтаар ачааны хаягийг хуучин бичиг баримтаар солих бөгөөд тээврийн хөлс, хураамжийг шинээр хүрэх өртөөнд хүлээн авагчаас хурааж авна;

20.7.4. орох хилийн өртөө буюу зам зуурт яваа ачааны хаяг солиход хаяг солилтын хураамж болон бусад ажил үйлчилгээний хөлсийг ачаа хүлээн авагчаас авна;

20.7.5. вагоныг буулгалтад тавьсны дараа хаяг солих шийдвэрийг авбал буулгалтад вагон тавьсан агшнаас хаяг солих шийдвэр авч бичиг баримт бүрдүүлэх хүртэл вагон ашиглалтын хөлс болон бусад хураамжийн хөлсийг тарифын дагуу тооцож хураана. Ачаа хүрэх өртөөнд ирсэн вагоныг хаяг солиулах тухай хүлээн авагч хүсэлт гарган өгсөн агшнаас хаяг солих шийдвэр хүлээн авч, илгээгч шинээр бичиг баримт бүрдүүлэх хүртэл хугацааны вагон ашиглалтын хөлсийг авна;

20.7.6. шинэ бичиг баримтаар хаяг солилт хийхэд хүсэлт гаргасан этгээд хуучин бичиг баримтаар төлбөр тооцоог хийж дуусгасны дараа шинэ бичиг баримт үйлдэх ба тооцоог хийнэ.

20.8. Импортын ачааны хаяг солих нэмэлт нөхцөл:

20.8.1. импортын ачааны хаяг солиход олон улсын ачааны харилцааны хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ. Улсын хилээр орж ирэх импортын ачааны хаягийг солихдоо энэ журмын 20.5.11-д зааснаар ачааны хаяг солих шийдвэрийг өртөөнд урьдчилан өгөх ба хаяг солилтыг гаальд мэдүүлэхээс өмнө гүйцэтгэнэ;

20.8.2. ачааг гаальд мэдүүлж ачааны манифест бичигдэж гаалийн хяналт хийгдсэний дараа хаяг солилт хийгдэх бол хүлээн авагчийн хүсэлтээр манифестэнд хийсэн гаалийн байгууллагын тэмдэглэл зөвшөөрлийг үндэслэн гүйцэтгэнэ. Энэ тухай төмөр замын байгууллага тээврийн бичиг баримтад тэмдэглэл хийнэ;



20.8.3. импортын ачааны хаягийг орох хилийн өртөөнд солиход гаалийн хяналтын тэмдгээр хуучин бичиг баримтаар, хүрэх өртөөнд ачааг олгох гаалийн байгууллагын зөвшөөрсөн тухай зохих тэмдэг тээврийн бичиг баримтад дарагдсаны дараа шинэ бичиг баримтаар тус тус солино;

20.8.4. тээвэрлэх ачаа нь хүний эрүүл мэнд, амь нас, байгаль орчин, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд аюул учруулах болон төмөр замын тээврийн тасралтгүй үйл ажиллагааг саатуулахаар бол аливаа учирч болзошгүй аюул, хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор мэргэжлийн хяналтын болон гаалийн байгууллагууд, ачаа илгээгч, хүлээн авагчтай урьдчилан тохирохгүйгээр тээвэрлэгчийн шийдвэрээр хаяг сольж буулгуулна. Ачааны хаягийг сольж буулгуулах болсон талаар тээвэрлэгч нь мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гаалийн байгууллага, хүлээн авагч, илгээгчид болон илгээсэн өртөөнд яаралтай мэдэгдэнэ;

20.8.5. шаардлагатай тохиолдолд экспортын ачааны хаяг солиход тухайн ачаа явж буй төмөр замын хилийн болон холбогдох өртөө, эрх бүхий газарт нь цахилгаан явуулж асуудлыг шийдвэрлүүлнэ;

20.8.6. шинэ бичиг баримтаар хаяг солиход вагоны ломбо хөндөгдөөгүй тохиолдолд илгээгчийн ломбыг авах шаардлагагүй. Энэ тохиолдолд тээврийн падааны "ачааны нэр" гэсэн хүснэгтэд ачааны хаяг солиулж буй этгээдээр илгээгчийн ломбо өөрчлөөгүй гэсэн тэмдэглэл хийлгүүлнэ. Гэхдээ хаяг солиулах этгээд болон гааль, хяналтын байгууллага ачааг шалгах шаардлагаар вагоныг онгойлгосон тохиолдолд өртөө болон салбар зам эзэмшигч нь шинэ ломбо тавина.


ХОРИННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАМ, АГУУЛАХ, ТАЛБАЙД АЧАА ХАДГАЛАХ

21.1. Нийтийн хэрэглээний зам, агуулах, талбайд ачааг тээвэрлэлтэд хүлээн авах, буулгах, олгох задгай болон битүү агуулахад хадгалах ажиллагааг тээвэрлэгч буюу суурь бүтэц эзэмшигч үйлчлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна. Гэрээний үлгэрчилсэн загварыг тээвэрлэгч буюу суурь бүтэц эзэмшигч тогтооно.

21.2. Нийтийн хэрэглээний зам, талбайн задгай агуулахад хадгалагдах ачааны жагсаалтыг тээвэрлэгч буюу суурь бүтэц эзэмшигч тогтооно.

21.3. Нийтийн хэрэглээний зам, агуулах, талбайд аюултай ачаа ачих, буулгах, хадгалах ажиллагааг Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмаар зохицуулна.



21.4. Нийтийн хэрэглээний замд ачилт буулгалтын ажиллагааг тээвэрлэгч, суурь бүтэц эзэмшигчийн болон ачилт буулгалтын машин механизмтай иргэн, хуулийн этгээдийн хүчээр ачаа илгээгч, хүлээн авагчтай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэнэ.

21.5. Тээвэрлэгч, ачаа болон чингэлгийг нийтийн хэрэглээний замд тавьж буулгаснаас 24 цагаас дээш хугацаанд тарифт заасны дагуу ачаа хүлээн авагчаас хадгаламжийн хураамж авна.

21.6. Нийтийн хэрэглээний замд тусгай зориулалтын хөргүүрт вагон болон чингэлгээр ирсэн түргэн гэмтэх, муудах ачааг ачаа хүлээн авагчид шууд олгоно.

21.7. Нийтийн хэрэглээний зам, агуулах, талбайд ачаа хадгалуулагч нь гэрээнд заасан хугацаанд ачаагаа татаж авахгүй хүндрэл учруулбал гэрээнд заасан хэмжээгээр торгуулийн хариуцлага хүлээлгэж, тээвэрлэгчийн тогтоосон тарифын дагуу хураамжийг нөхөн төлүүлнэ.

ХОРИНХОЁРДУГААР БҮЛЭГ

ДАГНАСАН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАМД ВАГОН ТАВЬЖ ӨГӨХ, ТАТАЖ АВАХ

22.1. Дагнасан хэрэглээний зам бүхий байгууллага аж ахуй нэгж, иргэд болон тээвэрлэгчийн хоорондын харилцаа /салбар зам ашиглах, вагон тавих, татах, ачаа вагон хүлээлцэх, сэлгээ хийх гэх мэт/ гэрээгээр зохицуулагдана.


22.2. Дагнасан хэрэглээний салбар зам ашиглах гэрээ ба вагон тавих татах гэрээний үлгэрчилсэн загварыг тээвэрлэгч тогтооно.

22.3. Дагнасан хэрэглээний салбар зам ашиглах гэрээ болон вагон тавих татах гэрээг 1 жилээс илүүгүй хугацаагаар байгуулна.

22.4. Дагнасан хэрэглээний зам ашиглах, вагон тавих, татах гэрээний хүчинтэй хугацаа дуусахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө эзэмшигч буюу дайвар үйлчлүүлэгчтэй хамтран тээвэрлэгч шинэ гэрээний төсөл боловсруулж эхэлнэ.

22.5. Дагнасан хэрэглээний зам дээр байрласан төхөөрөмж, байгууламж, цогцолборууд нь тээвэрлэлтийн хэмжээнд тохирох сэлгээний болон ялгах, ачаа ачих, буулгах ажиллагааг жигд явуулах, түүнчлэн хөдлөх бүрэлдэхүүн болон ачааны бүрэн бүтэн байдлыг хангахуйц байх ёстой. Эдгээр төхөөрөмж, байгууламж, цогцолборууд нь барилга ойртолтын оврын шаардлагад нийцсэн байна.

22.6. Дагнасан хэрэглээний зам эзэмшигчийн ачих, буулгах талбай нь шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй байна.



22.7. Дагнасан хэрэглээний замд вагон тавьж өгөх, татаж авах ажиллагаа:

22.7.1. дагнасан хэрэглээний салбар замд вагон тавих, татах ажиллагааг тээвэрлэгчийн, зам эзэмшигчийн эсхүл түрээсийн зүтгүүрээр гүйцэтгэнэ;

22.7.2. тээвэрлэгчийн зүтгүүрээр үйлчилж байгаа үед вагон тавих, татах ажиллагааг гэрээнд заасны дагуу гүйцэтгэнэ;

22.7.3. салбар замд вагон тавих, татах ажиллагааг тээвэрлэгч зам эзэмшигчтэй тохиролцсон хүлээлцэх замд гүйцэтгэх ба уг зам нь нийтийн болон дагнасан хэрэглээний байж болно;

22.7.4. салбар замд вагон тавьж өгсөн, татаж авсаны хөлсийг тухайн өртөөний тэнхлэгээс эхлэн үйлчилсэн зайгаар бодож ачаа тээвэрлэх тарифын дагуу авна.

22.8. Дагнасан хэрэглээний замын ажлын технологийг өөрчлөхөд гэрээнд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулна. Дагнасан хэрэглээний зам эзэмшигч өөрчлөгдөхөд гэрээг шинэчлэн хийнэ.

22.9. Дагнасан хэрэглээний замд ажиллах төмөр замын ажилтан төмөр замын тээврийн хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн мэдлэгийг эзэмшиж, шалгалтад хамрагдсан байна.

22.10. Дагнасан хэрэглээний зам болгон техникийн паспорт, хавтгай, дагуу огтлол, цогцолборын зурагтай байна. Техникийн паспортонд гэрчилгээнд замын дээд бүтэц, төхөөрөмж, пүү, вагон ачаалах, буулгах, цэвэрлэх, угаахад зориулсан болон түүнчлэн үйлдвэрийн төмөр замын өртөө, дов, довцог, татах зам, галт тэрэг, сэлгээний ажилд хэрэглэж буй дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламж бусад туслах байгууламж, механизмын техникийн шинж төрхийг заасан байна.

22.11. Шинэ объект, тоног төхөөрөмж ашиглалтад оруулах, татан буулгахад дагнасан хэрэглээний зам эзэмшигч тухайн замын техникийн паспортонд зохих өөрчлөлтийг оруулна. Техникийн паспортын нэг хувийг тээвэрлэгчийн болон суурь бүтэц эзэмшигчид өгнө. Тухайн өртөөний техник захирамжийн актын хавсралт, дагнасан хэрэглээний замын хүснэгтэд суурь бүтэц эзэмшигч өөрчлөлт оруулна.

22.12. Төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч дагнасан хэрэглээний зам, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдал, төмөр замын тээврийн ашиглалтын үйл ажиллагаа, вагон, чингэлэгт ачаа ачих, буулгах ажлыг гүйцэтгэлд хяналт шалгах хийх эрхтэй. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулахаар тавьсан шаардлагыг суурь бүтэц эзэмшигчийн зохих албан тушаалтан заавал биелүүлнэ.



22.13. Дагнасан хэрэглээний зам дээр хөдөлгөөний аюулгүй байдал, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн техникийн болон ачааны бүрэн бүтэн байдалд нөлөөлөхүйц гэмтэл, зөрчлийг илрүүлбэл улсын байцаагч акт тавина.

22.14. Улсын байцаагчийн тавьсан актын үндсэн дээр суурь бүтэц эзэмшигчийн зохих албан тушаалтан гэмтлийг арилгаж дуустал тухайн салбар зам дээр эсвэл уг актанд заасан хэсэгт хөдлөх бүрэлдэхүүн тавьж өгөхгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

22.15. Өртөө, зөрлөгийн замд өөр салбар замаар дамжин холбогдож буй нийтийн болон дагнасан хэрэглээний зам бүхий иргэн, хуулийн этгээдийн замд вагон тавьж өгөх, татаж авахад үндсэн буюу эхний хэрэглэгч нь дайвар буюу дараагийн хэрэглэгчдийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр ажлыг гүйцэтгүүлнэ.


22.16. Эзэмшигчийн буюу бусдын эзэмшлийн дагнасан хэрэглээний замд өөрийн эзэмшлийн агуулах талбайтай иргэн, хуулийн этгээдийн вагон, чингэлгийг тавьж, татах ажиллагааг үндсэн эзэмшигч хоорондын хэлцлийг үндэслэн зохицуулна.

22.17. Вагон, чингэлгийн эргэлтийн технологийн хугацаа, вагонд ачаа ачих, буулгах үлгэрчилсэн технологийн нормыг боловсруулах, тодорхойлох зааврыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

22.18. Дагнасан хэрэглээний зам эзэмшигч нь нэг өртөөнд хэд хэдэн дагнасан хэрэглээний замтай байвал зам тус бүрт болон нэгдсэн гэрээ байгуулж болно.

22.19. Гэрээг дахин байгуулахад маргаантай асуудал гарсан тохиолдолд түүнийг шийдтэл урьд нь байгуулсан гэрээний хүчинтэй хугацааг сунгах тухай талуудын хэлэлцээр байвал урьд байгуулсан гэрээгээр бүх асуудлыг зохицуулна.

22.20. Тээвэрлэгч нь дагнасан хэрэглээний зам ашиглах гэрээ, вагон тавих, татах гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг болон гэрээ байгуулах эрхийг нийтлэг гэрээний үндсэн дээр суурь бүтэц эзэмшигчид шилжүүлж болно. Энэ тохиолдолд суурь бүтэц эзэмшигч нь дагнасан хэрэглээний зам ашиглах гэрээ, вагон тавих, татах гэрээний үүргийн дагуу тээвэрлэгчийг төлөөлөн ачаа илгээгч, хүлээн авагч, дагнасан хэрэглээний зам эзэмшигчтэй харилцана.



ХОРИНГУРАВДУГААР БҮЛЭГ

САНАМЖ ХӨТЛӨХ

23.1. Үйлчлүүлэгч иргэд, байгууллага, хуулийн этгээдийн ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд зориулж вагоныг нийтийн болон дагнасан хэрэглээний замд ачилт, буулгалтад тавьж өгөх, татаж авах үед Монгол Улсын MNS-3084-2013 стандартыг хэрэгжүүлэн ажиллах, санамжийг үнэн зөв хөтөлнө.

23.2. Санамж нь вагон чингэлгийн ачилт, буулгалт /хүлээлгэх/-д байсан болон сэлгээний ажиллагаанд зарцуулсан хугацааг зөв тодорхойлох төлбөр тооцооны анхан шатны баримт болно. /Дөрөвдүгээр хавсралт/.

23.3. Салбар замд вагоныг ачилт, буулгалтад тавьж өгөх, санамж нээх:

23.3.1. санамжийг тээвэрлэгч байгууллагын эрх бүхий ажилтан үйлдэнэ. Санамжийг 3 хувь үйлдэх бөгөөд нэг хувийг вагон таталт тавилтын хүснэгтэд хавсаргаж, хоёр дахь хувийг ачаа хүлээн авагч, илгээгчид өгч, үлдэх хувь өртөөний тооцооны газарт үлдэнэ;


23.3.2. санамжид вагон, чингэлгийн дугаар, вагоныг тавьж өгсөн, татаж авсан зүтгүүрийн эзэмшигч, салбар замын нэр, ачаа илгээгч, хүлээн авагчийн нэр, вагоныг ачилт, буулгалтад тавьж өгсөн, ачиж буулгаж дууссан болон сэлгээ хийсэн цагийг заана;

23.3.3. өөрийн эзэмшлийн салбар замтай ачаа хүлээн авагчийн хаягаар ирсэн вагоныг ачилт, буулгалтад тавьсан цагаар, импортоор ирсэн ачаатай гадаад паркийн вагоныг өртөөнд ирсэн цагаас технологит цагийг хасаж санамж нээж тээвэрлэгч болон тээвэрлүүлэгчийн эрх бүхий ажилтан нар харилцан гарын үсэг зурж баталгаажуулна;

23.3.4. салбар замд вагон, чингэлгийг тавих үед техникийн болон ломбо, задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан ачааны байдал, зөрчил гэмтэлтэй эсэхийг тээвэрлэгч, тээвэрлүүлэгч талууд хамтран шалгаж, гэмтэлтэй бол зөрчлийн талаар заасан тэмдэглэлийг санамжид эрх бүхий ажилтнууд хийнэ. Зөрчилгүй бол тэмдэглэл хийхгүй;

23.3.5. нийтийн хэрэглээний замд бүлгээр ачилт буулгалтад тавигдсан вагоны ачаа хүлээн авагч, илгээгч нь өөр байвал тус бүр дээр санамж нээнэ;

23.3.6. нийтийн хэрэглээний замд ачилт буулгалтад тавьж өгөх вагоныг тавьсан, татсан жинхэнэ цагаар санамж нээх, хаах бөгөөд энэ тухай өртөө, ачих буулгах ажил хариуцсан эрх бүхий байгууллагуудын хооронд байгуулсан вагон тавилт, таталтын гэрээнд тодорхой тусгасан байна.



б. салбар зам нь эвдрэлтэй, техникийн гэмтэлтэй, арчилгаа, үйлчилгээ хийгээгүйгээ, техникийн шаардлага хангахгүй байгаагаас сэлгээний хөдөлгөөнд хаасан;

в. ачаа илгээгч, хүлээн авагчийн салбар замтай агуулахад ачилт буулгалтын фронтын хэмжээгээр вагоныг тавиад цаана нь хүлээгдэж байгаа үлдэгдэл вагонд;

г. гааль, худалдаа, мал эмнэлэг, ургамал хорио цээрийн байгууллагаас улсын хилээр оруулахыг хориглосон ачаа хилээр орж ирэх, импортоор ирсэн ачааны гааль, худалдааны татвар, тээвэрлэлтийн хөлс төлөгдөөгүй болон бусад шалтгаанаар хилийн болон бусад өртөөдөд саатуулагдан зогсож байгаа вагонуудад;

д. ачаа ирэх үед хүлээн авагч нь олдохгүй хаяг тодорхойгүй эсвэл ачаа нь хүлээн авагчийн ажлын бус цагаар /нийтээр амрах баяр, амралтын өдөр/ ирснээс ачаа ирсэн тухай мэдэгдэх боломжгүй болсон тохиолдолд ачаа ирсэн тухай падааны зохих хүснэгтэд тэмдэглэл хийж 12 цагийн дараа санамж нээнэ.

23.5.2. тээвэрлэгч нь ачилт, буулгалтад ирсэн вагонуудыг цаг тухайд нь тавьж өгч чадаагүй, өртөөн дээр зогсоох тохиолдолд хүлээлгийн санамж нээнэ. Санамжийн "тайлбар" гэсэн хүснэгтэд Ерөнхий маягтын актны дугаарыг бичнэ.


23.6. Төлбөр тооцоо хийх:

23.6.1. байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн буюу тээвэрлэгчийн эзэмшлийн салбар зам, өртөө хоорондын зам, ачааны ажиллагаа хийгддэггүй өртөө, зөрлөгт ачилт буулгалтад вагоныг тавьж өгөх, татаж авахад санамжийг үйлдэж тарифын мөрдлөгийн дагуу холбогдох төлбөр, тооцоог бодож авна;

23.6.2. санамж нь ямар ч засваргүй хөтлөгдөх бөгөөд гарын үсгүүд нь бүрэн зурагдаж зөв бичигдсэн эсэхийг тооцооны ажилтан шалган хүлээн авч тээврийн төлбөр тооцоог хийнэ;

23.6.3. тээвэрлэгч нь вагонуудыг ачилт, буулгалтад тавьж өгч чадаагүй хүлээлгэн саатуулсан тохиолдолд ерөнхий маягтын актыг үйлдэн санамжийн цагаас хасаж тооцно. Ерөнхий маягтын актад өртөөний удирдах албан тушаалтан хяналт тавина;

23.6.4. бүлэг вагонд нэг санамж нээсэн тохилдолд "Салбар замд вагон тавих, татах гэрээ"-нд вагоныг хэсэгчлэн татаж авах тухай заасан бол санамжийг хэсэгчлэн хаасан вагон тус бүрээр тавилт, таталтын хөлсийг тооцон авна;



23.6.5. энэхүү журмын 23.5.1-ийн “а, б, в, д”-д заасан үндэслэлээр хүлээлгийн санамж нээсэн тохиолдолд тарифын мөрдлөгийн дагуу холбогдох төлбөр, тооцоог илгээгч буюу хүлээн авагч хариуцан төлнө;

23.6.6. энэхүү журмын 23.5.1-ийн г-д заасан үндэслэлээр хилийн өртөөнд вагон саатуулсан тохиолдолд буруутай байгууллага, иргэн, хуулийн этгээд вагон ашиглалтын хөлсийг төлнө.

ХОРИНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АЧАА ИРЭЛТИЙН МЭДЭГДЭЛ

24.1. Төмөр зам нь хүрэх өртөөнд ачаа ирсэн тухай 12 цагийн дотор ачааны нэр, вагоны болон чингэлгийн тоог дурьдаж ачаа хүлээн авагчид мэдэгдэнэ.

24.2. Ачаа ирсэн тухай мэдээллийг утас, факс, электрон шуудангаар тус тус дамжуулж болно.

24.3. Ачаа ирэлтийн тухай мэдээллийг ачаа хүлээн авагчид салбар зам ашиглалтын болон салбар замд вагон тавьж өгөх, татаж авах тухай гэрээнд заасны дагуу мэдэгдэнэ. Мэдэгдэлд вагоны дугаар, илгээлтийн дугаар, ачааны нэр, ирсэн огноо, цагийг зааж бичнэ.

24.4. Ачааны мэдэгдлийг тусгай дэвтэрт тэмдэглэнэ.


24.5. Мэдэгдлийн дэвтэрт мэдэгдэл хүлээн авсан огноо, цаг минут, албан тушаалтны нэр, утасны дугаарыг бичиж тэмдэглэнэ.

24.6. Ачаа ирсэн тухай мэдэгдэж тээврийн бичиг баримтад тэмдэглэл хийж хуанлийн дардас дарна.

ХОРИНТАВДУГААР БҮЛЭГ

АЧААГ ХҮЛЭЭН АВАГЧИД ОЛГОХ

25.1. Тээвэрлэлттэй холбогдсон бүх төлбөр тооцоог ачаа хүлээн авагч хийж дууссаны дараа тухайн байгууллагын баталгаажсан итгэмжлэлтэй төлөөлөгчид итгэмжлэл болон орлох падааныг үндэслэн ачааг олгоно. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хаягаар ирсэн ачааг авах эрхийг нотолсон нэг удаагийн буюу байнгын итгэмжлэхийг өөрийн төлөөлөгчид өгч тээвэрлэгчид ирүүлнэ. Итгэмжлэлд байгууллага, аж ахуйн нэгж, компанийн дарга /захирал/, ерөнхий нягтлан бодогч нар гарын үсэг зурж тэмдэг дарж баталгаажуулсан байна. Нэг удаагийн итгэмжлэлийг байгууллага, аж ахуйн нэгж тодорхой илгээлтийн ачаа авахад олгох бөгөөд түүнийг өртөө замын хүснэгтэд хавсаргана. Тодорхой хугацаагаар олгогдсон итгэмжлэл нь итгэмжлэгдсэн хүний фото зурагтай, хугацаа заасан байх бөгөөд төмөр замын



байгууллагад 2 хувийг ирүүлнэ. Тодорхой хугацаагаар олгогдсон итгэмжлэлийн 1 хувийг өртөөний хэрэгт хадгалах ба хоёр дахь хувийг эзэнд нь буцааж өгнө. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ажилтан итгэмжлэлийг хувийн үнэмлэхтэй нь тулган шалгаж хүлээн авагчид ачааг олгоно.

25.2. Ачаа хүлээн авагч тээвэрлэлтийн тооцоог хийж дууссаны дараа падаан, замын хүснэгтэд гарын үсэг зуруулж, падааныг түүнд олгох бөгөөд замын хүснэгтэд ачаа олгосон огноо, итгэмжлэхийн дугаар, түүнчлэн тооцооны дансны дугаар, банкны нэрийг бичнэ. Замын хүснэгтийн зохих хүснэгтэд "ачааг тээвэрлэлтийн бичиг баримтаар бүрэн олгов" тэмдэглэл хийж ачаа хүлээн авагчаар гарын үсэг зуруулж хүрэх өртөөний хуанлийн тэмдэг дарна. Зам зуурын тээврийн актанд бичсэн мэдээлэл үнэн зөв бол "ачаагөртөөнд-ны өдөр тогтоосон дугаарын актаар олгов" тэмдэглэл хийнэ.


25.3. Ачаатай вагоныг нийтийн хэрэглээний ба дагнасан хэрэглээний зам, талбайд тээвэрлэгчийн ба дагнасан хэрэглээний зам эзэмшигчийн зүтгүүрээр тавьж өгөх, татаж авах, ачааг хүлээлцэх, бичиг баримт үйлдэх, ачаа хамгаалах талаар салбар зам ашиглах болон вагон тавьж өгөх, татаж авах гэрээнд тусгасан байна.

25.4. Импортын ачааг олгохдоо гаалийн байгууллагын олгох зөвшөөрлийг заавал авсан байна. Импортоор орж ирэх ачааг гаалийн хяналтын талбайгаар буулгуулах ажлыг тээвэрлэгч зохион байгуулна. Гаалийн хяналтын бус талбайд ачааг буулгах тохиолдолд ачаа хүлээн авагчийн гаалийн байгууллагад гаргасан хүсэлтийг гаалийн байгууллагын дарга зөвшөөрч, байцаагч томилсон тухай тэмдэглэгээ хийгдсэн байна. Энэхүү бичгийг үндэслэн ачааг олгох ба энэ талаар тооцооны ажилтан нь тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга, ачааны диспетчер, жижүүрт мэдэгдэнэ. Тооцооны ажилтан тээврийн бичиг баримтад дарагдсан "Гаалийн байгууллага зөвшөөрсөн" тэмдгийг үндэслэж тээврийн тооцоо хийнэ.

25.5. Ачааг олгоход падаан, замын хүснэгтэд өртөөний хуанлийн тэмдэг дарах ба энэ нь ачаа олгосон хугацааг илэрхийлнэ. Ачааг тээвэрлэгчийн хүчээр буулгасан үед агуулахаас ачаа татаж авч дууссан, эсвэл нийтийн ба дагнасан хэрэглээний замд вагоныг ачаа хүлээн авагчийн хүчээр буулгуулахаар тавьж өгсөн өдрийг ачааг жинхэнэ олгосон өдөр гэж үзнэ.

25.6. Иргэний хаягаар ирсэн ачааг хүлээн авагчийн иргэний үнэмлэх, оршин суугаа газраа нотолсон бичиг баримтыг үзэж олгох ба замын хүснэгтэд ачаа олгосон огноо, паспорт, иргэний үнэмлэх, түүнийг орлох баримт бичгийн дугаар, регистрийн дугаар бичиж хүлээн авагчаар гарын үсэг зуруулна.

25.7. Ачаа хүлээн авагчийн итгэмжлэхийн үндсэн дээр ачааг өөр байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд шилжүүлэн олгож болно. Ийм тохиолдолд итгэмжлэхэд



ачааг шилжүүлэн олгох байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нэр, хаяг, регистрийн дугаарыг тодорхой заасан байна.

25.8. Ачаа хүлээн авагчийн хэрэгслээр ачааг буулгах үед түүний хүсэлтээр дагнасан хэрэглээний замд тавьж хүлээлцэх ажлыг /шилжүүлэлт/ шууд буулгасан газарт нь гүйцэтгэх бөгөөд санамжид хүлээлцсэн огноо, цагийг бичиж хүлээн авагч хүлээлгэн өгөгч талуудын төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулна.


25.9. Ачаатай вагон ба чингэлэг ачсан вагонуудыг хүлээлцэх болон олгоход ачаа хүлээн авагч ба тээвэрлэгч талууд нь гадна талын үзлэг хийж вагон болон чингэлгийн техникийн бүрэн бүтэн байдал, ломбоны байдал, тоо, хяналтын тэмдэг, тэмдэглэгээ нь вагоны хуудсанд бичсэнтэй тохирч байгаа эсэхийг шалган магадлах үүрэгтэй. Ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр тээвэрлэсэн үед ачаа алдагдсан, гэмтсэн, сав баглаа боодол, хяналтын тууз нь бүрэн бүтэн байгаа эсэхийг шалган магадлана. Ачаа хүлээлцэх явцад ачаа тээврийн зөрчилд илэрвэл ерөнхий маягтын акт, техникийн зөрчил илэрвэл техникийн гэмтлийн актаар тодорхойлж энэ тухай санамжид хүлээн авч байгаа тал тэмдэглэл хийнэ. Ачаа, вагон, чингэлэг хүлээлцэх үед илэрсэн зөрчлийн тухай санамжид тэмдэглэл хийгээгүй бол ачааг бүрэн бүтэн хүлээлцсэн гэж үзнэ.

25.10. Тээвэрлэгчийн эрх бүхийн байгууллагад ирсэн вагон ба чингэлэг нь тээвэрлэгчийн ломботой байх эсхүл ачаатай ирсэн вагон ба чингэлэгт техникийн гэмтэл болон ачаа тээврийн зөрчил илэрсэн тохиолдолд тээвэрлэгчийн ажилтан вагон, чингэлэг нээх, ачаа олгох үйл ажиллагаанд оролцож, ачааны жин байдлыг шалгаж олгоно.

25.11. Ачааны сав, баглаа, боодлын гэмтэл болон ачааны байдалд нөлөөлж болох бусад нөхцөл байдлыг илрүүлсэн үед тээвэрлэгч нь падаанд заасны дагуу зөвхөн гэмтсэн байрыг задалж ачааг шалгана. Хэрэв шаардлагатай бол бүгдийг шалгаж болно.

25.12. Ачаа илгээсэн өртөөнд тодорхойлогдсон жин, ачаа хүлээн авсан өртөөнд ачаа олгох үед гарсан жингийн зөрүү нь стандартчилал хэмжил зүйн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас тогтоосон жинлүүрийн заалтын зөрүүгийн норм, Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээрийн дагуу тухайн ачааны жингийн хэвийн хорогдлын нормоос хэтрэхгүй байвал ачааны жин тохирсонд тооцно. Ачааг олгоход ачаанд хавсаргаж ирсэн ачааны чанарын тодорхойлолт, баглаа боодлын сертификат зэргийг заавал үзэж актад тусгана.

25.13. Хүрэх өртөөнд ачааны жин байдлыг шалгахад ачаа дутсан, гэмтсэн энэ нь зам зуурт тогтоосон тээврийн актаар баталгаажиж байвал тээвэрлэгч ачааны дутсан гэмтсэний жинхэнэ хэмжээг тодорхойлох, хүлээн авагчид тээврийн акт өгөх үүрэгтэй. Ачааг олгох үед шаардлагатай бол тээвэрлэгчийн төлөөлөгчөөс гадна



хүлээн авагчийн төлөөлөгч оролцсон комисс ачааны жин, байдал, байрын тоог шалгана. Комисс нь шалгалтын дүнгийн талаар акт бичиж тэр дор нь тухай нэгжийн удирдлагад мэдэгдэх үүрэгтэй. Ачааны дутагдал, гэмтэл илэрсэн нэгж нь шаардлагатай гэж үзвэл дутагдсан, гэмтсэн ачааг газар дээр нь очиж дахин нягтлан судалж үзэж, энэ тухай 4 цагийн дотор тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

25.14. Ачааг хүлээн авагчид олгох үед ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан нь илэрсэн тохиолдолд комисс томилж, ачаа дутсан, гэмтсэн хэмжээг тодорхойлох, тээврийн акт тогтоох зэрэг үйл ажиллагааг тээвэрлэгч нь Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр болон энэхүү журмын 27 дугаар бүлэг /Төмөр замаар тээвэрлэгдсэн ачаанд акт тогтоох, бүртгэх/-т заасныг баримтлан зохион байгуулна.


25.15. Ачаа гаалийн хяналтад байгаа бол гаалийн байгууллагад мэдэгдэнэ.

25.16. Шаардлагатай гэж үзвэл тээвэрлэгч өөрийн санаачилгаар болон хүлээн авагчийн захиалгаар зохих салбарын магадлан шинжлэгч, мэргэжилтэн урьж акт тогтоолгоно. Магадлан шинжилгээний /экспертийн/ акт гаргахад тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга буюу түүний орлогч, тээвэрлэгчийн ажилтан заавал оролцоно. Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр болон энэхүү журмын 27 дугаар бүлэг /Төмөр замаар тээвэрлэгдсэн ачаанд акт тогтоох, бүртгэх/-т заасныг баримтлан тээвэрлэгчээс тогтоосон "Тээвэрлэгч ачаа тээвэрлэлтийн ажиллагаанд мөрдөх акт гомдлын ажлын заавар" /цаашид "акт гомдлын ажлын заавар"/-ыг удирдлага болгон шаардлага хангахуйц акт тавьсан байна. Магадлан шинжилгээ хийсэн, магадлан шинжилгээний акт хавсаргасан тухай тээврийн актын зохих хүснэгтэд тэмдэглэл заавал хийнэ.

25.17. Техникийн гэмтэлгүй ба ачаа тээврийн зөрчилгүй вагонд ачааг илгээгчийн хүчээр ачсан бөгөөд ачаа илгээгчийн тавьсан ломбо нь гэмтэлгүй, мөн түүнчлэн ачаа илгээгч нь ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүнд ломбогүй тээвэрлэхийг зөвшөөрсөн тохиолдолд дутагдсан, гэмтсэн эвдэрсэн шинж тэмдэггүй ирсэн ачааг шалгахгүйгээр хүлээн авагчид олгоно.

25.18. Ачаа хүлээн авагч нь ачааны жин, байдал, тоо хэмжээг шалгуулах хүсэлтээ албан бичгээр ирүүлэх бөгөөд тээвэрлэгчийн төлөөлөгчийг ачааг шалгахад ажиллуулсаны хөлсийг тээвэрлэгчийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тарифт заасан хэмжээгээр төлнө.

25.19. Хүрэх өртөөнд нийтийн ба дагнасан хэрэглээний зам, талбайд ачаа буулгах үед тээврийн баримт бичигт заасан ачааны байрын тооноос илүү ачааны байр илэрсэн болон тээвэрлэгчийн ачиж, жинг тодорхойлсон ачаанаас жингээр илүү гарсан тохиолдолд ачааг доорх байдлаар олгоно:



- нийтийн хэрэглээний замд савтай ба ширхгийн илүү гарсан ачааг тэдгээрийн эзнийг тогтоох хүртэл саатуулна. Хэрэв импортын ачаа бол тээвэрлэгч гаальд мэдэгдэнэ;
- задгай /овоолмог, нурмаг/ буюу шингэн байдлаар тээвэрлэсэн илүү гарсан ачаанд акт тогтоож хүлээн авагчид олгоно;
- илүү гарсан ачаанд тээврийн акт тогтоож, ачааг олгосон тухай тэмдэглэл хийнэ.

25.20. Ачаа илүү гарсан болох нь нотлогдсон тохиолдолд тээвэрлэгч нь акт гомдлын ажлын зааварт зааснаар тээврийн акт бүрдүүлнэ. Мөн тээвэрлэгч энэ тухай ачаа хүлээн авагчид, ачаа илгээсэн орон, шаардлагатай бол гааль болон бусад мэргэжлийн байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.

25.21. Аюултай, хортой ачаа гэмтэлтэй вагонд буюу ломбогүй, эсвэл гэмтэлтэй ломботой ирсэн тохиолдолд ачааны байдал, байрны тоо, жинг ачаа хүлээн авагч нь өөрийн агуулахад тээвэрлэгчийн төлөөлөгчийг байлцуулан шалгана.


25.22. Хайрцаг, чемодан, сагс, чингэлэг бусад савтай болон жижиг илгээлтээр тээвэрлэсэн гэрийн эд хогшлыг олгоход өртөө нь ачааны байр, жинг данстай нь тулгаж шалгана. Энэ тохиолдолд хүлээн авагч нь илгээсэн өртөөний хуанлийн дардас дарж баталгаажуулсан гэрийн эд хогшлын жагсаалтыг ирүүлэх /үзүүлэх/ үүрэгтэй.

25.23. Өртөөнд вагон чингэлгээр ирсэн ачаа нь тээвэрлүүлэгчийн хүргэгчтэй ирсэн бол ачааг тээвэрлэгч шалгахгүйгээр олгоно.

25.24. Ачааг дагнасан хэрэглээний замд буулгаж, олгох үед тээвэрлэгчийн эрх бүхий ажилтны оролцоотойгоор өртөөний вагон пүүн дээр буюу өөрийн эзэмшлийн пүүн дээр ачааны жинг шалгах хүсэлтийг ачаа хүлээн авагч вагоныг салбар замд тавихаас өмнө ирүүлнэ. Хүрэх өртөөн дээр ачааны жинг илгээх өртөөнд пүүлсэн пүүтэй ижил маягийн пүүн дээр шалгана.

25.25. Дагнасан хэрэглээний замд ачаа буулгах үед ачааны жин байдлыг шалгахад тээвэрлэгч оролцсон тохиолдолд ачаа хүлээн авагч нь буулгах ачааг дахин шалгах боломжтой байхаар хураах үүрэгтэй. Энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан нь ачааг шалгах ачаа татгалзаж энэ тухай өөрийн удирдлагад мэдэгдэх үүрэгтэй.

25.26. Ачаа олгогч нь ачааг үнэ төлбөргүй хадгалах хугацаа дууссаны дараа олгохоор бол ачаа хадгаламжийн хөлс төлсөн эсэхийг шалгах үүрэгтэй. Ачааг үнэ



төлбөргүй хадгалах хугацаа нь 24 цаг бөгөөд үүнийг ачаа буулгасны дараахь хоногийн 00.00 цагаас эхлэн тоолно.

25.27. Нөхөн илгээлтээр ирсэн ачааг дараахь байдлаар олгоно:

- тээврийн үндсэн баримт /падаан/-тай ирсэн ачааны хэсгийг олгохдоо үндсэн бичиг баримтаар тээврийн тооцоо хийж тээврийн акт тогтооно. Тээврийн актыг үндсэн падааны хамт ачаа хүлээн авагчид олгоно.
- нөхөн илгээлтээр ирсэн хэсгийг хүлээн авагчид байгаа үндсэн падаан, тээврийн акт, эцсийн тооцоог үндэслэн олгоно. Тээврийн актыг ачаа хүлээн авагчаас хураан авч тээвэрлэгчид үлдээнэ.

25.28. Ачааны бичиг баримт үрэгдсэн тохиолдолд эрэл хийнэ. Эрэл үр дүнгүй байвал ачаа олгох хуудас /орлох падаан/ болон бусад холбогдох баримтыг үндэслэн олгоно.

25.29. Ямар ч тохиолдолд буулгаж олгосон ачаа /вагон ба чингэлэг/-ны тугалган ломбыг 20 см, бусад ломбыг 2 см-ын үзүүр гарган гэмтээлгүйгээр таслан авч, хатуу цаасанд бэхлэн /нэг удаагийн ломбыг хатуу уутанд хийж/ вагоны хуудсанд хавсарган өртөөний архивт 2 жилийн хугацаатай хадгална. Тээврийн акт тогтоосон тохиолдолд ломбо, вагоны хуудсыг тээврийн актанд хавсаргана.

25.30. Тээвэрлэгч хүрэх өртөөн дээр ачааны жин байдал, байрын тоог шалгахад ачаа нь падаанд заасан мэдүүлэгтэй тохирч байвал падааны зохих хүснэгтэд ачааг олгоход шалгасан падаанд заасантай тохирсон, хэвийн хорогдлын хэмжээнд г.м тэмдэглэл хийж гарын үсэг зурж хуанлийн тэмдэглэл дарна. Замын хүснэгтэд мөн адил дардас хийнэ.


25.31. Ачааг олгохын өмнө тооцооны газарт тээврийн үнэлгээг шалгаж нэмэгдэл төлбөрийг барагдуулна.

ХОРИНЗУРГАДУГААР БҮЛЭГ

АЧААГ БУУЛГАСНЫ ДАРАА ВАГОН, ЧИНГЭЛГИЙГ ЦЭВЭРЛЭХ, УГААХ

26.1. Вагон ба чингэлэгтэй ачааг буулгасны дараа гадна, дотор талаас нь цэвэрлэх бөгөөд бэхэлгээний үл авагдах хэрэгслээс бусад ачааны бэхэлгээг авч ачаа хүлээн авагч тээвэрлэгчид бэхэлгээнд зориулсан үл авагдах хэрэгслийг бүрэн бүтэн техникийн байдалд нь оруулж тээвэрлэгчид өгнө.

26.2. Ачааг буулгасны дараа вагоны кузов /тэвш/ ба чингэлгийн дотор, гадна талд үлдсэн буюу дагтаршсан бүх үлдэгдлийг арилгаж мөн түүнчлэн вагоны явах ангиуд дээрх /дам нуруу, тэргэнцэр, нээлхийн тагууд гэх мэт/ болон ачаатай хамт олгодоггүй вагоны үл авагдах тоноглолоос бусад вагон хоорондын холбоосуудыг



цэвэрлэсэн нөхцөлд вагон ба чингэлгүүдийг /цистерн-вагон, бункерт, хагас вагонуудаас бусад/ цэвэрлэгдсэнд тооцно.

26.3. Хэрвээ цистерний торх буюу бункерийн дотор ба гаднах гадаргуу дээр ачааны үлдэгдэл байхгүй нөхцөлд цистерн вагон ба бункерт хагас вагоныг цэвэрлэгдсэн гэж үзнэ. Цистернээс ачааг дээгүүр нь /дээд юүлэх хэрэгсэлтэй/ юүлэх үед буугдаагүй ачааны үлдэгдэл 1 см-ээс илүүгүй байж болно.

26.4. Замналаар мөн түүнчлэн өөрийн ба түрээсийн вагонуудад нунтаг болон овоолмог ачааг тээвэрлэх үед буулгасны дараа вагонд байж болох ачааны үлдэгдлийг тээвэрлүүлэгч, тээвэрлэгчийн зөвхөн бичгээр зөвшилцсөн ёсоор хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах шаардлагыг үндэслэн тогтооно. Вагон ба чингэлгийн гадна гадаргуу, явах ангийн цэвэрлэгээг бүх тохиолдолд тэдгээр нь хэнд харьяалагдахаас үл хамааран хийнэ.

26.5. Цэвэрлэсэн вагонд бага зэргийн цас байхыг бохирдсон гэж үзэхгүй.

26.6. Вагон, чингэлэг ба вагоны арал дээрх таних тэмдэг, дугаар ба бусад бичиглэл нь уншигдахаар тод байна.


26.7. Вагон ба чингэлгийн гадна, дотно гадаргуу нь хамгаалалтын хальс, үл уусагч шингэн бодис /эмульст/ мөн түүнчлэн наалт, хаяг, зүүлт, шохойн тэмдэглэл зэрэг вагоныг бохирдуулагчаас цэвэрлэгдсэн байна. Харин тухайн вагон болон чингэлэгт Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр болон энэхүү журмаар өөр ачааг тээвэрлэх үед зөвшөөрөгдсөн хоосон вагон дээрх хаяг, зүүлтийг цэвэрлэхгүй байж болно.

26.8. Вагон ба чингэлгийг цэвэрлэх бүх арга нь тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хангаж орчин тойрныг бохирдуулахгүй байна.

26.9. Буулгалтын дараа вагон, чингэлэгт өмнө нь тээвэрлэж байсан ачааны үлдэгдэл илрүүлбэл хэний хүч, хэрэгслээр буулгалт гүйцэтгэсэнээс үл хамааран ачаа хүлээн авагч буюу тээвэрлэгч вагон, чингэлгийг бүх ачааны үлдэгдлээс бүрэн цэвэрлэх үүрэгтэй.

26.10. Ачаа хүлээн авагч нь цэвэрлэгдээгүй вагон, чингэлэгт түүний хаягаар ачаа ачсан ачаа илгээгчид гомдол гаргах эрхтэй. Тухайн тохиолдолд ачаа хүлээн авагчийн хүсэлтээр ерөнхий маягтын акт тогтооно.

26.11. Ачаа хүлээн авагч нь ачаа илгээгчид тээвэрлэсэн ачааны үлдэгдэл байсан талаар гомдол гаргаж акт тавьж болох бөгөөд ачаа хүлээн авагчийн хүсэлтээр тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан актанд гарын үсэг зурж болно.



26.12. Нийтийн хэрэглээний зам, талбайд ачаа хүлээн авагчийн хүч, хэрэгслээр ачааг буулгах үед вагон, чингэлгийн цэвэрлэгээнээс үлдсэн хог, ачаа, бэхэлгээ, баглаа боодол ба бусад материалын үлдэгдлийг тухайн газраас /өртөө/ ачааныхаа хамт ачаа хүлээн авагч зөөж зайлуулна.

26.13. Ачаа хүлээн авагч нь буулгалт хийсний дараа тээвэрлэсэн ачаанаас вагоныг бохирдуулсан ба эвгүй үнэртэй болгосон тохиолдолд ачаа хүлээн авагч уг вагонд угаалга хийж арилгана.

26.14. Буулгалтын дараа битүү вагоныг заавал угаах ачааны жагсаалтыг гаргасан байна. Үр тариа тээвэрлэх зориулалттай вагонд өөр төрлийн /үр тарианаас бусад/ ачаа тээвэрлэснийг буулгасны дараа ачаа хүлээн авагч нь уг вагоныг угаалгаж авна. Арвайн соёолж буулгасны дараа ачаа хүлээн авагч нь онцгой үнэрийг нь арилгах зорилгоор үр тарианы вагоныг агааржуулна.

26.15. Тээвэрлэсний дараа тээвэрлэгчийн зүгээс ачаа хүлээн авагчийн хүч хэрэгслээр тусгай зориулалтын тогтмол дулаант, хөргүүрт, битүү вагоныг угаалгаж, мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн боловсруулалт хийлгэнэ. Түргэн муудах ачааны жагсаалтыг Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээрээр тодорхойлно.

26.16. Буулгалтын дараа вагон, чингэлгийг цэвэрлэх, угаах, уураар утах ба халдваргүйжүүлэх шаардлагатай аюултай, түүний дотор юүлэх ачааны жагсаалтыг төмөр замаар тээвэрлэх аюултай ачааны ба цистерн вагонд тээвэрлэх юүлэх /шингэн/ ачаа, бункерт хагас вагонд тээвэрлэх, нефтийн хар тосны тээвэрлэлтийг энэхүү журмаар тодорхойлно.

26.17. Тээвэрлэлтийн дараа вагоныг угааж мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн ариутгал хийх шаардлагатай бөгөөд улсын мал эмнэлгийн хяналтын байгууллагын хяналтад байх ачааны жагсаалтыг улсын мал эмнэлгийн хяналтын дор энэхүү журмын 11 дүгээр бүлэг /Төмөр замаар мал, амьтан тээвэрлэх/-т зааснаар тогтооно.

26.18. Ачаа хүлээн авагч нь вагоныг угаах боломжгүй бол тээвэрлэгчээр вагон угаах, ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж болно.

26.19. Ачаа ба тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх ажлыг ачаа хүлээн авагч буюу мэргэжлийн хяналтын холбогдох байгууллагууд гүйцэтгэнэ.

26.20. Тээвэрлэгч нь угаагдсан вагоныг шалгасан тухай вагон дугаарыг заасан акт үйлдэнэ.



26.21. Амьтан, шувуу, тэдгээрийн түүхий эдийг буулгасны дараа битүү ба тогтмол дулаант вагоны угаалга, мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн ариутгалыг ачаа хүлээн авагчийн хүч хэрэгсэл, зардлаар гүйцэтгэнэ.

26.22. Тусгай хэрэгцээний вагон, чингэлгийн угаалга, мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн ариутгалыг тохиролцсон талууд байхгүй бол ачаа хүлээн авагч гүйцэтгэнэ.

26.23. Вагон, чингэлгийн цэвэрлэгээний хөлс:

26.23.1. ачаа хүлээн авагч нь вагоныг цэвэрлэж, угааж ариутгах шаардлагыг зөрчсөн үед тээвэрлэгч нь ачаа хүлээн авагчаас дээрх шаардлагыг биелүүлэх хүртэл вагон, чингэлгийн ачааг буулгасан буюу юүлэн авсны дараа вагоныг тавьж өгөх, татаж авах гэрээнд зааснаар вагон чингэлгийг хүлээн авахгүй байх эрхтэй. Энэ тохиолдолд нэр заагдсан этгээдээс вагон ба чингэлэг ашигласны төлбөрийг вагоныг буулгалтын зам дээр тавьж өгсөн цагаас эхлэн тэдгээрийг зогсоосон бүх хугацаанд тооцож нэхэмжилнэ;


26.23.2. ачаа илгээгчийн зөвшөөрснөөр тээвэрлэгч хаалга, нээлхий нь онгорхой, ачааны бэхэлгээнд зориулсан хэрэгсэл нь авагдаагүй, цэвэрлэгдээгүй, хоосон вагоныг ачилтад тавьж өгсөн тохиолдолд вагон цэвэрлэх хугацааны ашиглалтын хөлсийг санамжийн нээх хугацаанаас хасч тооцно;

26.23.3. хоосон вагоныг мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн ариутгалыг хоёр ба гуравдугаар зэрэглэлээр хийхээр явуулахад тээврийн бичиг баримт үйлдэнэ;


26.23.4. хоосон битүү вагоныг угаалга ба мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн ариутгалд нэгдүгээр зэрэглэлээр /ангилал/ хийхээр явуулахад буцааж илгээх падаанаар, харин тогтмол дулаант вагонуудыг тээврийн бичиг баримтаар явуулна.

26.24. Дараахь ачаанаас суларсан вагоныг цэвэрлэнэ:


- жижиглэсэн ба нунтагласан шохойн зуурмаг алебастр /гипс/;
- аргилит;
- асбест /галд тэсвэртэй огсорхог материал/;
- хүнд шпат /Барит/;
- эрдэст хөвөн;
- ногоо /выжики овощные/;



- шохойн зуурмаг /гипс/;
- төрөл бүрийн шавар;
- шаварлаг хөрс /Глинозём/;
- кальц агуулсан минерал бодис /Доломит/;
- хар бал /графит/;
- ваннанд зориулсан хар шавар /Грязи/;
- тэжээлийн хөрөнгө /дрожжи кормовые/;
- төмсний ба манжингийн хальс шахдас /Жам картофельный и свекловичный/;
- төрөл бүрийн үнс;
- бүх төрлийн шатсан хаягдал /изгарь/;
- цагаан шавар /каолин/;
- галд тэсвэртэй хатуу цаас /Асбестон картон/;
- төрөл бүрийн дэгдэмхий бодис;
- багсармал тэжээл
- идэвхжүүлсэн хүнсний бэлдмэл /Концентрат апативовый/;
- нурмаг барилгын материал, /концентрат нефелиновый/;
- будаг ба хуурай будагч;
- будаа /хэрэглэгчийн баглаа боодол гэмтсэн үед/;
- төрөл бүрийн шохой;
- зуурмаг /Мертели/;
- модны ногоон навчаар хийсэн витаминлаг гурил;
- кальцит гурил;
- төрөл бүрийн тэжээлийн гурил
- төрөл бүрийн хүнсний гурил;
- шилмүүст витаминлаг гурил;
- өнгөт металлын үртэс;



- төрөл бүрийн хаягдал;
- /Пегматий/;
- хар тосны нунтаг /порошок асфальтовый/;
- шохойн нунтаг /порошок известковый/;
- төмөрлөг магнезийн нунтаг;
- галд тэсвэртэй шаврын нунтаг /порошок шамотный/;
- төрөл бүрийн тоос;
- янжуур тамхи /баглаа, сав нь гэмтсэн үед/;
- хүнсний ба техникийн боловсруулсан давс;
- угаалгын нунтаг;
- техникийн барилгын шил /хагарсан үед/;
- өнгөт металл ба тэдгээрийн хайлшны зоргодос;
- төрөл бүрийн сульфат /аюултайгаас бусад/;
- түүхий тамхи ба макорн;
- төрөл бүрийн тамхи /навчит ба үндэстэй, хамрын, боловсруулсан/;
- нунтагласан ба хэсэглэсэн цагаан нунтаг /тальк/;
- төрөл бүрийн шилэн уут, сав /хагарсан үед/;
- хүлэр ба хүлрийн бүтээгдэхүүн /торф/;
- органик ба иж бүрдлийн бордоо;
- химийн ба минералийн бордоо;
- хатаасан махан таташ /ууттай/ ;
- төмрийн хайлш /ферросплавы/;
- төрөл бүрийн цемент;
- хэсэглэсэн галд тэсвэртэй шавар /шамот/;
- амьтны хоол, тэжээл;
- мал амьтан;
- ноос, арьс, шир, малын түүхий эд.



ХОРИНДОЛДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМААР ТЭЭВЭРЛЭГДСЭН АЧААНД АКТ ТОГТООХ, БҮРТГЭХ

27.1. Тээвэрлэлтийн үед тээвэрлэгч, тээвэрлүүлэгчид эд материалын хариуцлага хүлээлгэх үндэс нь тээвэрлэгчийн тогтоосон тээврийн акт байна.

27.2. Тээврийн актыг доорх нөхцөл, байдлыг нотлох зорилгоор тогтооно:

- тээврийн бичиг баримтанд дурдсан ачаа буюу тээшийн нэр, жин, байрын тоо, хүрэх өртөө, хүлээн авагчийн хаяг ачааны марклал, дугаар жинхэнэ байгаа байдалтай тохироогүй;
- ачаа гэмтсэн, муудсан;
- тухайн ачааны падаан ирээгүй эсхүл тухай падааны ачаа ирээгүй, тээврийн бичиг баримтны хуудас дутуу;
- алдагдсан ачааг тээвэрлэгчид бүрэн эсхүл дутуу тушаах.


27.3. Тээврийн актыг ачааг шалгаж буулгасан тээвэрлэгчийн эрх бүхий ажилтны бичсэн илтгэх хуудасны дагуу тогтооно. Илтгэх хуудсанд тээврийн акт тогтооход шаардагдах бүх мэдээллийг оруулсан байна. Илтгэх хуудасны агуулгыг өртөөний тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга шалгаж тээврийн акт тогтоох эсэх тухай эцсийн шийдвэрийг гаргана.

27.3.1. тээврийн актны мэдээг тээвэрлэгчийн эрх бүхий дээд шатны байгууллагад 24 цагийн дотор өгнө;

27.3.2. тээвэрлэгчийн эрх бүхий байгууллага тээврийн актыг 3 хувь үйлдэж, нэгдүгээр хувийг тээвэрлэгчийн эрх бүхий дээд шатны байгууллагад хавсралт баримтуудын хамт, хоёрдугаар хувийг ачаа хүлээн авагчид, гуравдугаар хувийг тухайн тээврийн актыг тогтоосон тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын хэрэгт тус тус хадгална. Шилжүүлэн ачилттай дамжуулах өртөөнд ачааг шалган хүлээлцэх үед тээврийн актыг 5 хувь үйлдэнэ. Тээврийн актны 2 хувийг хавсралтын хамт акт үйлдсэн тээвэрлэгчид үлдэж, 1 хувийг падаанд хавсаргаж хүрэх өртөөнд явуулах ба үлдсэн 2 хувийг хүлээлгэн өгсөн тээвэрлэгчид дамжуулна;

27.3.3. тээврийн актны хувь бүрт өртөөний тэмдэг дарж, акт тогтооход оролцсон албан тушаалтан, ажилтан гарын үсэг зурна;

27.4. Тээврийн актыг бүртгэлийн хатуу тооцоот маягтан дээр үйлдэнэ. Бүртгэлийн хатуу тооцоот тээврийн актны маягтыг буруу бөглөвөл актны хувь бүрийг чагталж зураад "Хүчингүй" гэсэн тэмдэглэл хийж өртөөний тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын хэрэгт хадгална. Энэ тухай тээвэрлэгчийн эрх бүхий дээд



шатны байгууллагын албан тушаалтанд 24 цагийн дотор мэдэгдэнэ. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллага тээврийн актыг хуулбарлахдаа хэвлэлийн дугааргүй маягт дээр буулгана;

27.5. Тээврийн актыг илгээх өртөө буюу зам зуурын өртөөнд тогтоосон тохиолдолд актны 2 дахь хувийг тээврийн бичиг баримтанд хавсарган хүрэх өртөөнд явуулна. Тээврийн актыг тогтоосон өртөө падаан дахь "Тээврийн актны тэмдэглэгээ" гэсэн хүснэгтэд тухайн өртөөний тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын холбогдох ажилтан, тогтоосон актны дугаар, огноо, акт тогтоосон шалтгааныг бичиж гарын үсэг зурж, өртөөний хуанлийн дардсаар баталгаажуулна. Падаанд "тээврийн акттай" гэсэн тэмдэглэгээтэй боловч тээврийн бичиг баримтад тухайн акт хавсрагдаж ирээгүй бол шаардлагатай тохиолдолд ачааг буулгаж олгох үед тээврийн актыг тогтооно.


27.6. Илгээх болон зам зуурын өртөөний тээврийн акттай ачаанд хүрэх өртөөнд шинээр акт тогтоох шаардлагагүй бол өртөөний акт бүртгэлд бүртгэн авч тус тээврийн актны хатуу дугаарын хуваарьт бүртгэлийн дугаарыг бичиж дугаарлана. Зам зуурын өртөөний тээврийн актад "тээврийн акттай тохирсон" гэсэн тэмдэглэл хийж өртөө, ачиж буулгах ажил хариуцсан байгууллагын тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга, тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан, ачаа хүлээн авагч гарын үсэг зурж, өртөөний хуанлийн тэмдгээр баталгаажуулан тээвэрлэгчийн эрх бүхий дээд шатны байгууллагад явуулна. Зам зуурын тавигдсан тээврийн ачаа хүлээн авагчид өгсөн бол актаар тээвэрлэгчид хариуцлага тооцож ачаа илгээгчид өгсөн бол актны хуулбарыг тээвэрлэгчийн эрх бүхий дээд шатны байгууллагад явуулна. Хүрэх өртөөнд тээврийн акт дахин тогтоосон тохиолдолд зам зуурын өртөөний тээврийн актны хуулбарыг уг тээврийн актад хавсаргаж тээвэрлэгчийн эрх бүхий дээд байгууллагад явуулна.

27.7. Хүрэх өртөөнд тээврийн актыг хуулбарлахдаа ямар нэг өөрчлөлт засвар хийхгүй. Тээврийн актад бичигдсэн зүйлтэй ачааны жинхэнэ байгаа байдал тохирохгүй байх эсхүл зам зуурын өртөөдөд хоёр буюу түүнээс олон акт тогтоогдсон бол уг ачааг хүрэх өртөөн дээр заавал шалган буулгаж, байгаа байдлаар нь тээврийн актыг дахин тогтооно. Энэ тохиолдолд хүлээн авагчид зөвхөн сүүлд тогтоосон тээврийн актны хувийг өгнө.

27.8. Тээврийн актыг ачааны бүрэн бүтэн байдал алдагдсаныг илрүүлсэн тухайн өдөрт нь илгээлт тус бүрээр тогтооно.

27.9. Ачаа шалгасан дүнг тээврийн актад бичих:

27.9.1. тээврийн актны зохих хүснэгтүүдийг асуултын дагуу бүрэн бөглөж, ачааны тоо ширхэг, жин, сав, баглаа, боодлын эвдэрч гэмтсэн байдлыг тодорхой бичих, ямар нөхцөлд ачааны бүрэн бүтэн байдлын алдагдал илэрснийг заана.



Ачааны бүрэн бүтэн байдлын алдагдлын шалтгаан, илгээгч, тээвэрлэгчийн буруутайг заасан ямар нэг таамаглал, дүгнэлтийг актад дурьдахгүй. Харин дүгнэлтийг тээврийн актны дагуу ачааны бүрэн бүтэн байдлын алдагдлыг бүрэн судалсны эцэст хийнэ;

27.9.2. ачаа алдагдах, гэмтээхэд хүргэсэн вагон, чингэлгийн гэмтлийг /шал, хаалга, дээврийн цоорхой, шонгийн хугаралт, нээлхийн гэмтэл буюу дутуу хаагдалт, хаалганы цүүний гэмтэл г.м./ техникийн гэмтлийн актад тусгана. Ачааг хулгайлахаар санаатайгаар вагон, чингэлгийн дээвэр, шал, ханыг цоолсон болон ул мөрөө арилгахаар оролдсон нь тогтоогдвол энэ тухай актад тодорхой заана;


27.9.3. тээврийн актад, вагон доторх ачааны ачилт, байрлуулалтаас шалтгаалсан ачааны гэмтлийн тохиолдол бүрт, ачааг зөв ачиж байрлуулсан эсэх, илгээгч эсхүл тээвэрлэгчийн хүч хэрэгслээр ачсан болохыг тодорхойлно. Ачилт, техникийн нөхцлийг зөрчиж хийгдсэн байвал энэ тухай актад тодорхой заана;

27.9.4. тээврийн актад ачааны жингийн тухай дараахь зүйлсийг тодорхой заана;

- ачааны жинг ямар аргаар тодорхойлсон /стандартаар, тооцоолох аргаар, пүүлсэн/ болохыг;
- илгээх өртөөн дээр илгээгч болон тээвэрлэгчийн аль нь ачааны жинг тодорхойлсон болохыг;
- "ачааны бохир жин", "вагоны хоосон жин хэв бичээсээс авсан" эсхүл "вагоны хоосон жинг шалгасан", "ачааны жин" зэрэг болно.

27.9.5. ачааны сав, баглаа, боодол болон ачаа гэмтэхэд хаана ямар хэсэгт чухам ямар гэмтэл байгааг тодорхой заана. Тухайлбал:

- баглаа боодол гэмтсэн буюу задалсан ул мөртэй эсэх, гэмтсэн ачааны баглаа боодол нь бүрэн бүтэн эсэх;
- баглааны татлага утас, хяналтын тууз бүтэн эсэх, татлага утас хяналтын туузыг гэмтээлгүйгээр ачааг гарган авч болох эсэх;
- ачаа вагон дотроо асгарсан эсэх, асгарсан бол хэдий хэмжээтэй асгарсан эсэх;
- ачааны дотоод баглаа нь бүтэн эсэх, жийрэглэсэн материал нь хүрэлцээтэй эсэх, баглааг засаж янзалсан бол засварын шинж тэмдэгтэй эсэх, мөн гэмтэлтэй байр вагоны аль хэсэгт байсныг.



27.9.6. ачаа гэмтэх, дутах үед ачаа болон баглаа боодлын байдлыг "Ачаа гэмтсэн", "сав эвдэрсэн" гэх мэтээр ерөнхийлөн бичихгүй.

27.9.7. гэмтэлтэй байр бүрийн ачааны болон баглаа боодлын байдлыг тодорхой бичнэ. Төрөл бүрийн нэр бүхий ачааг нэг падаантай тээвэрлэх үед ачаа гэмтэж алдагдсан тохиолдолд, ачаа тус бүрээр нь байрын тооны дагуу ялгалт хийж, жинг шалгаад тээврийн актад бичнэ. Баглаа, боодол дээр нь ачааны жинг заасан буюу MNS EN 13876:2015 стандартаар тодорхойлсон байвал зөвхөн гэмтэлтэй байрыг пүүлж бүтэн байрын жинг шалгаагүй гэж актад тусгана. Гэмтэлтэй байрын жинг тусад нь бичнэ.

- торхтой ачаанд гэмтсэн, дутсан байдал илэрвэл актад торхны гэмтэл /ёроол нь унасан, бүслүүр нь суларсан/, мөн бөглөөтэй талыг нь хааш нь харуулж ачсан, ачаа нь гоожсон эсэх, вагоны шалан дээр гоожсон ачааны ул мөр ямар байгаа эсэхийг заана. Торхыг бөөрөөр нь хэвтүүлж ачсан бол вагоны дагуу эсвэл хөндлөнгөөр нь ачсан эсэх, торхны хооронд зай, хөдөлгөөнгүй байлгах ивүүрийг вагоны шаланд бэхэлсэн эсэх, торхыг дангаар болон давхарлаж ачсан, завсарт нь жийрэг хийж ачсан эсэхийг тодорхойлно.
- цаас болон хуйлаастай ачаа гэмтвэл /огтлогдох, үрэгдэх холгогдох, цоорох, байр нь норох/ тээврийн актад баглааны төрөл, хэлбэр /модон, цаасан хайрцаг ба боодол/, баглаа нь тууз, төмөр утсан бүслүүртэй эсэх, гадаад дотоод баглааны гэмтлийн хэмжээ, ачааг вагон, чингэлэгт байрлуулсан байдал зэргийг заана. Хуйлаастай ачаа гэмтэхэд тээврийн актад аль хэсэгт ямар хэмжээтэй урагдсан, холгогдсон, гэмтсэн болохыг тодорхой заана.
- сав, баглаа, боодол /шуудай, цаасан хайрцаг, г.м/ гэмтэлтэй тохиолдолд ачаа дутвал тээврийн актад баглаа боодлын материалын тухай, сав, баглаа, боодолд нь ачааны жинд тохирч байгаа эсэх, ачааны байр нь хоорондоо адил эсэхийг заана. Сав, баглаа, боодлыг илгээгчийн ломбоор битүүмжилсэн бол акт тогтоохдоо ломбоны байдал, ломбыг гэмтээлгүйгээр ачааг гарган авч болох эсэхийг заана.
- ачаа /гурил, ёотон, элсэн чихэр г.м/ норсон тохиолдолд тээврийн актад уг ачааны гадна талын бүх шинж тэмдгийг тодорхой заана. Үүнд: норсон ачааны байрын тоо, ачаа хатуурч хатсан гэх мэт. Түүнчлэн норсон ачаа вагоны хаана /хаалга, нээлхийний ойролцоо, вагоны дунд хэсгээс, ачааны дээд дунд доод үеэс г.м/ ямар байдалтай байсныг заана. Сав, боодол нь чийгтэй, толботой байвал вагонд цас борооны ус нэвчсэн ул мөртэй /вагоны шал, хана/ эсэхийг заана.



27.9.8. битүү вагонд тээвэрлэж байгаа ачаанаас дутагдал илрэхэд тээврийн актад вагоныг багтаамжийг ашиглан даацанд нь хүртэл ачсан эсэх, дутсан ачаа вагонд багтах эсэхийг заана.

27.9.9. задгай хөдлөх бүрэлдэхүүнээр тээвэрлэсэн ачаа дутсан, гэмтсэн байвал тээврийн актад:

- тээвэрлэгдсэн ачааны угсралт, байрлуулалт, ивүүр, бүтээлэг, татлага зэрэг ачилттай холбогдолтой бүх зөрчлийг;
- ачааны сав, баглаа боодол нь ачааны жин, шинж чанарт тохирч байгаа эсэх;
- ачааг овоолон ачиж тээвэрлэсэн бол ачааны гадаргууд хөндөгдсөн шинж бий эсэхийг;
- ачилтын техникийн нөхцөл зөрчигдсөн, хяналтын зураас, тэмдэглэгээ арилсан, өөрчлөгдсөн эсэхийг тус тус заана.

27.9.10. битүү вагонд хаалганы хашлагатай тээвэрлэсэн ачаанаас дутвал тээврийн актад хашлага нь вагоны хана, шаланд нягт шахагдсан, гэмтэлтэй, зөв байрласан эсэхийг бичнэ.

27.9.11. цистернд тээвэрлэсэн ачаанаас дутвал ачааны юүлэлтийн өндөр, цистерны загвар, ачааны хувийн жин, орчны агаарын температур, түүнчлэн гоожиж байсан эсэхийг актад тодорхой заана. Ачаа гоожиж байгаа бол урсан гоожиж байгаа эсэх, дусалж байгаа бол минутанд хэдэн дусал дусалж байгааг бичнэ.

27.9.12. хөргүүрт вагон, чингэлэгт тээвэрлэж байгаа хялбар муудах ачааг шалгаад тээврийн актад дараахь зүйлүүдийг тодруулж бичнэ. Үүнд:

- баглаа, савгүй овоолж буюу баглаа, савтай ачааг ачмагтай, ивүүртэй, тавиур дээр болон өлгөж ачсан зэрэг ачилтын аргыг заахаас гадна хураалт нь техникийн нөхцөлтэй тохирч байгаа эсэх;
- сав, баглааны төрөл, түүний гэмтсэн эсэх, гэмтлийн шалтгаан зэрэг;
- вагоны шалан дээр муудсан ачаанаас гоожсон ул мөр байсан эсэх, муудсан ачаа вагоны аль хэсгээс илэрсэн болох;
- вагоны хана, хаалганы түгжээ гэмтэлтэй болон засвартай эсэх;
- өвөл, зуны аль ч улиралд гаднах агаарын температурын хэмжээ, тээвэрлэлтийн үед температурын дэглэмийг баримталсан эсэх;
- вагон, чингэлгийн хөргүүр нь хэвийн ажиллагаатай байгаа эсэх.



27.9.13. тээвэрлэсэн мал амьтдад өвчин, хорогдол тохиолдвол тэр үед нь хүргэгч байсан эсэх, вагоныг сараалж болон бусад хэрэгслээр зөв тоногдсон эсэх, энэхүү журмын 11 дүгээр бүлэг /Төмөр замаар мал амьтан тээвэрлэх/-т заасныг хүргэгч зөрчсөн эсэхийг актад бичнэ.

27.9.14. хэд хэдэн илгээлттэй нэг илгээгчийн нэг хүлээн авагчтай нэг төрлийн ачаанд ижил төрлийн гэмтэл илэрсэн тохиолдолд нэг тээврийн акт тогтоож болно.

27.9.15. нэг илгээгчээс нэг хүлээн авагчийн хаягаар явуулсан нэг төрлийн хэд хэдэн вагонтой шингэн, нурмаг, овоолмог ачааг бүгдийг нь нэг зэрэг олгон шалгахад бүх ачааний хэвийн хорогдлоос хэтэрсэн дутагдал болон илүүдэл илэрсэн, жингийн заалтын зөрүүгийн нормоос буюу ачааны жинг тодорхойлох нэгдсэн нормоос ачаа дутсан болон илүүдсэн тухай нэгдсэн нэг тээврийн акт тавьж болно. Энэ тохиолдолд ачаа нь дутсан, илүүдсэн, зөв жинтэй байсан гэж ялгалгүйгээр шалгаж олгосон бүх вагоныг актад бичнэ.


27.9.16. задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр тээвэрлэсэн автомашин, трактор, өөрөө явдаг машин техникийн амархан авагддаг эд анги, багаж гэмтэж дутахад тээврийн актад дараахь зүйлүүдийг тодруулж бичнэ. Үүнд:

- ачилтын бэхэлгээг буруу болон дутуу хийснээс эд ангийг эвдэрч гэмтэхэд хүргэсэн байж болзошгүй талаар;
- ломбыг гэмтээлгүйгээр техник болон машины кабин доторх эд анги, сэлбэгний хайрцаг доторх зүйлийг авагдахуйцаар ломбодсон зөрчлийн талаар;
- машинаас хялбар салгаж болох болон хагалж болох эд ангийг салган авч хаалт хамгаалалт хийх зааврыг ачаа илгээгч зөрчсөн талаар;
- эд ангийн жагсаалтын хуудсанд дурдсан зүйлсээс дутаж байгаа эд ангийн нэр, тоо, тэдгээрийн байрлалыг тус тус заана.


27.10. Ерөнхий маягтын акт нь ачаа тээвэрлэлтэд нөлөөлсөн эсвэл нөлөөлж болзошгүй шалтгааныг тогтоосон тээвэрлэгчийн бичиг баримт болно.

27.10.1. ерөнхий маягтын актыг доорх тохиолдолд тогтооно:

- энэхүү журмын дагуу илгээгчийн падаанд хавсаргасан бичиг баримт дутвал;
- илгээгчээс үнийг нь зарласан ачааны үнэ ачааныхаа жинхэнэ үнээс хэтэрсэн үед тээвэрлэгч ачаа тээшийг хүлээн авахаас татгалзах;




- ачааны сав, баглаа нь эвдэрхий, эсвэл гэмтэж муудсаны улмаас тээвэрлэлтэд хүлээн авахаас татгалзах; Энэ тохиолдолд ачаа илгээгчийн шаардлагаар акт тогтооно.
- хүргэгчтэй яваа ачаатай вагоноос хэрэгсэл дутах, эсвэл вагон нь гэмтэх;
- буулгалтад тавигдах ачаатай вагон болон чингэлгийг өртөөнөөс тавьж олгохыг саатуулах;
- техникийн нөхцөлийг зөрчиж бэхэлгээ буруу хийсэнд;
- ачаа хүлээн авагч болон дагнасан хэрэглээний зам эзэмшигчээс шалтгаалан ачаатай вагон буулгалтад тавигдахгүй хүрэх өртөөн дээр саатахад;
- ачаа хүлээн авагч, дагнасан хэрэглээний зам эзэмшигчээс, түүнчлэн хүрэх өртөөнд вагон хуримтлагдсанаас шалтгаалан вагон хүлээж авах техникийн боломжгүйгээс завсрын өртөөдөд вагон саатахад;
- ачаатай вагон болон чингэлгийн бодит жин нь вагон болон чингэлгийн зөвшөөрөгдсөн дээд даацаас хэтэрсэн тохиолдолд;
- ачаа илгээгч болон дагнасан хэрэглээний зам эзэмшигчээс шалтгаалан захиалгын дагуу хоосон вагон ачилтад тавигдахгүй саатахад;
- ачаа хүлээн авагчийн хүчээр ачааг буулгасны дараа вагон болон чингэлгийг цэвэрлээгүй тохиолдолд;
- цистерн болон бункерт вагоны ачилт буулгалтын дараа вагоны гадна талыг цэвэрлээгүй тохиолдолд;
- тээвэрлэгч бохир вагон, чингэлгийг ачаа илгээгчид ачилтад тавьж өгөхөд;
- вагон, чингэлгийн ломбо байхгүй, гэмтэлтэй байх эсвэл солигдсон байх, ломбоны хяналтын тэмдэг нь падаанд бичсэн тэмдэглэгээтэй тохирохгүй байх;
- тээвэрлүүлэгчийн мэдэгдлийн дагуу вагоны тавилт таталт хийхээр ирсэн зүтгүүрийг тээвэрлүүлэгчийн болон дагнасан хэрэглээний зам эзэмшигчийн буруугаар саатуулахад;
- энэхүү журмын 13 дугаар бүлэг /Ачаа хүргэх хугацааг тооцох/-т заасны дагуу зам зуурт ачааг саатуулахад;



- тээвэрлүүлэгчийн ачаа хүргэгчийг солих тохиолдолд зам зуурт ачааг саатуулахад;
- хөдөлгөөний аюулгүй байдал болон ачааны бүрэн бүтэн байдалд саад болохуйц /ломбо байхгүй эсвэл гэмтэлтэй байх, вагоны нээлхий, вагон болон чингэлгийн ханаар ачаанд халдлага орсон шинжтэй/ вагоны, чингэлгийн гэмтэл илрүүлсэн тохиолдолд зам зуурт ачааг саатуулахад;
- вагон, чингэлгийн гэмтэлд;
- тээвэрлүүлэгч болон бусад байгууллагын эзэмшлийн вагон, чингэлгийг тээвэрлэгч буюу төмөр замын байгууллага дур мэдэн ашигласан тохиолдолд;
- тээвэрлэгчийн вагон, чингэлгийг тээвэрлүүлэгч болон бусад байгууллага дур мэдэн ашигласан тохиолдолд;
- ачаа хүлээн авагч тээврийн хөлс болон бусад хураамжийг төлөхөөс зайлхийсэн тохиолдолд тээвэрлэгч вагон, чингэлгийг буулгалтанд тавихгүй саатуулахад;
- тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр хоорондын замд, хэсэглэх газар болон ачаа тээврийн ажиллагаанд хаалттай өртөө, зөрлөгт вагоны ачилт буулгалтын ажиллагаа дуусахыг хүлээх үед тээвэрлэгчийн зүтгүүрийн сул зогсолт гарахад;
- тээвэрлүүлэгч, дагнасан хэрэглээний зам эзэмшигч болон бусад хуулийн этгээд төмөр замын тээврийн ажлын технологит заагдсан баримтуудад /тээврийн бичиг баримт болон тооцооны хуудас, тээврийн захиалгыг гүйцэтгэсэн баримт, вагоны гэмтлийн акт, чингэлгийн гэмтлийн тухай акт, санамж, тавилт таталтын хүснэгт г. м/ гарын үсэг зурахаас зайлсхийх, татгалзахад;
- хилийн өртөөдөд хил, гааль, мэргэжлийн хяналтын болон хүчний байгууллага ачаатай вагон саатуулахад;
- төмөр замын тээврийн ажлын технологи, энэхүү журмаар заагдсан бусад тохиолдолд.

27.10.2. ерөнхий маягтын актыг 3-аас доошгүй хувь үйлдэж, 2-оос цөөнгүй ажилтан оролцож гарын үсэг зурна.

27.11. Магадлан шинжилгээний дүнг бүрдүүлэх:



27.11.1. ачааны алдагдал, гэмтлийн шалтгаан, хохирлын хэмжээг тогтоохын тулд тээвэрлэгч буюу тээвэрлүүлэгчийн санаачлагаар магадлан шинжээч, өртөө болон ачиж буулгах ажил эрхэлсэн тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ажилтан, хүлээн авагч нарыг байлцуулж магадлан шинжилгээний акт тогтооно;

27.11.2. магадлан шинжилгээг тээвэрлэгчийн санаачлагаар хийх тохиолдолд ачаа гэмтэж ирсэн хөдлөх бүрэлдэхүүн дотор нь эсхүл ачааг буулгах үед актыг тогтооно.

27.11.3. магадлан шинжилгээний дүгнэлтэд тээвэрлэгч байгууллагын ажилтан доорх зүйлийг оруулахыг шаардана:

- ачааны гэмтэл, муудалтын зэрэг;
- гэмтсэн ачааг засаж болох эсэх, засахад гарах зардлын хэмжээ, гэмтсэн ачааны үнийг хэдэн хувиар бууруулах, бүрэн болон хэсэглэн хэрэглэж болох эсэх;
- ачааны гэмтлийн шалтгаан, ачааны төрөлд тохироогүй баглаанаас болсон эсэх, эсхүл ачааны өөрийн онцлог чанараас болж гэмтсэн муудсан эсэх, гэмтсэн хэсгийг нь сольж болох эсэх.

27.11.4. шингэн ачаа гоожсон тохиолдолд савны магадлан шинжилгээгээр доорх зүйлийг тогтооно. Үүнд:

- ямар шалтгаанаар шингэн ачаа асгарч гоожиход хүргэсэн шалтгаан;
- сав нь зориулалтын болон тогтоосон стандартад тохирсон эсэх.

27.11.5. шинжээч нь сав, баглаа болон ачаа муудсан гэмтсэнийг тодорхойлж чадахгүйд хүрвэл өртөөний тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга тодорхойлж чадахгүй байгаа шалтгааныг бичихийг шаардана.


27.11.6. ачаа шалгасан тухай магадлан шинжилгээний акт тогтоож, магадлан шинжилгээнд оролцсон албан тушаалтнууд гарын үсэг зурна. Магадлан шинжилгээний акт тогтоосон тухай тээврийн актад тэмдэглэл хийнэ.

27.11.7. шинжээчийн дүгнэлтийг өртөөний тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга үл зөвшөөрвөл шалтгаанаа заасан тэмдэглэл актад хийнэ.

27.11.8. магадлан шинжилгээ хийхэд гарсан зардлыг буруутай тал төлнө.

ХОРИННАЙМДУГААР БҮЛЭГ

ГОМДОЛ ГАРГАХ, ХЯНАН БАРАГДУУЛАХ



28.1. Гомдол гаргагч нь ачаа үрэгдсэн, дутсан, гэмтсэн буюу муудсанаас үүссэн хохирол түүнчлэн тээврийн хөлсний зөрүүг буцааж олгох болон ачаа хүрэх хугацааг хожимдуулсан зэрэг гомдлыг падаан тус бүрээр гаргана.

28.2. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллага нь гаргасан гомдлыг хянан үзэж, түүнийг хүлээн зөвшөөрөх эсвэл татгалзах тухай Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, түүний албан заавар, энэхүү журмын дагуу заасан хугацааны дотор гомдол гаргагчид мэдэгдэх үүрэгтэй.

28.3. Ирсэн гомдлын материалыг шалгаж хүлээн авахдаа:

- тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад гомдол зөв хаяглагдсан эсэх,
- гомдол гаргах эрх болон итгэмжлэл байгаа эсэх,
- гомдол гаргах хугацааг баримталсан эсэх,
- гомдолд хавсаргасан бичиг баримт нь гомдол гаргах нотлох баримт мөн эсэх, уг бичиг баримт нь зохих гомдолдоо хамаарах эсэх,
- хавсаргасан материалын эх хувь нь байгаа эсэх,
- гомдол гаргасан бичиг баримт нь буруутай этгээдэд эд материалын хариуцлага хүлээлгэх болон хохирлын хэмжээг нотлох үндэс болж чадах эсэхийг нягтлана.

28.4. Гомдлын материал бүрэн бүрдээгүй өргөдлийг судлалгүйгээр, хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор гомдол мэдүүлэгчид буцаана.

28.5. Гомдол гаргах хаяг:


28.5.1. ачаа үрэгдсэн, дутсан, муудсан, гэмтсэн тухай гомдол гаргагчийн хүсэлтийг Олон улсын төмөр замын ачаа харилцааны хэлэлцээр болон энэхүү журмын дагуу тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад хаяглана;

28.5.2. гомдлыг буруу хаяглан ирүүлсэн байвал уг гомдлыг хянан үзэхгүйгээр хавсаргасан баримтын хамт ирснээс хойш 15 хоногийн дотор гомдол мэдүүлэгчид буцаах бөгөөд гомдол мэдүүлэгчид гомдол гаргах хаягийг зааж бичгээр мэдэгдэнэ.

28.6. Гомдол мэдүүлэх эрх:

28.6.1. гомдол мэдүүлэх эрхийг энэ журмын дагуу холбогдох бичиг баримт бүхий тээвэрлүүлэгч эдэлнэ;

28.6.2. тээвэрлүүлэгч болон тээвэр зуучлагч тээврийн падааныг үндэслэн төмөр замын байгууллагад гомдол гаргаж болно;



28.6.3. гомдлын хүсэлтэд холбогдох бичиг баримтыг хавсаргаагүй бол уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн хугацаанд тээвэрлэгч гомдол мэдүүлэгчид буцаана. Энэ тохиолдолд гомдол мэдүүлэгч тогтоосон хугацааны дотор шаардлагатай материалыг хавсарган гомдлоо дахин гаргах эрхтэй.

28.7. Гомдол мэдүүлэх хугацаа:

28.7.1. ачаа үрэгдсэн, дутсан, муудсан, гэмтсэн тухай гомдлыг тээвэрлэгчид ачаа хүлээн авснаас хойш 9 сарын дотор, ачаа хүргэх хугацааны тухай гомдлыг 2 сарын дотор гаргана. Өргөдлийг шуудангаар илгээсэн өдрийг нь тогтоохын тулд шуудангийн дугтуйг бичиг баримтын нэг адил үзэж гомдлын хэрэгт хадгална;

28.7.2. ачаа олгосон огноог падааны "Ачаа олгосон өдөр" гэсэн хүснэгтэд дарсан өртөөний хуанлийн дардсаар тогтооно;

28.7.3. Энэхүү журмаар тогтоосон хугацааг баримтлаагүй ирүүлсэн гомдлыг буцааж, энэ тухай гомдол мэдүүлэгчид мэдэгдэнэ.

28.8. Нотлох бичиг баримт:

28.8.1. гомдлын хүсэлтэд тээврийн үндсэн падаан, тээврийн акт, магадлан шинжээчийн акт, ачааны үнийг нотлох баримт болох ачаа илгээгчийн нэхэмжлэл буюу худалдааны гэрээний үнэ болон бусад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлсэн байна;

28.8.2. гомдлыг урьдчилан хянах явцад энэхүү журамд заасан бичиг баримтаас гадна өөр бичиг баримт шаардлагатай байвал гомдлыг буцаахгүйгээр уг баримтыг нэмж ирүүлэхийг шаардана;

28.8.3. гомдол мэдүүлэгч нь тээвэрлэгч тээврийн акт тогтоохоос татгалзсаныг нотлох гэж байгаа бол хүсэлтдээ өртөөнд акт тогтоолгохыг хүссэн тухай бичигт өртөөний тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргаас өгсөн хариу бичиг, хариу бичиг аваагүй бол өртөөний тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргад явуулсан албан бичгийг хүлээн авсан ажилтны гарын үсэг эсхүл шуудангийн тасалбарыг хавсаргавал зохино.

28.9. Гомдлыг хянан барагдуулахын тулд:

- гомдлын дагуу хийсэн судалгааны материал бичиг хэрэгт бүрэн байгаа эсэхийг шалгах;
- тээвэрлэлтийн явцад ачаа хэдий хэмжээгээр үрэгдсэн гэмтсэн болохыг шалган тогтоох;



- чухам ямар нөхцөлд ачаа үрэгдсэн, гэмтсэн болохыг шалган тогтоох, шаардлагатай гэж үзвэл ачааны үрэгдэл гэмтлийн талаар дахин хяналт хийх;
- гомдол мэдүүлэгчийн гаргасан тооцоог шалгаж, ачаа үрэгдсэн, гэмтсэн хохирлын хэмжээг тодорхойлох;
- гомдолд хавсаргасан бичиг баримт үндсэн эхээрээ /ачааны падаан, тээврийн акт, шинжээчийн акт, нэхэмжлэх/ байгаа эсэхийг шалгах, түүнчлэн эдгээр бичиг баримтад ямар нэгэн нэмэлт засвар оруулаагүй болохыг тогтоох шаардлагатай.

28.10. Тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хүлээх хариуцлага:

28.10.1. зохих илгээлтийн ачаа нь төмөр замын байгууллагын буруугаас болж үрэгдсэн, гэмтсэн болох нь нотлогдвол гомдол гаргагчийн гаргасан тооцоог шалган үзэж, үрэгдсэн гэмтсэн ачааны хэмжээг тогтоосны үндсэн дээр уг гомдлыг хүлээн зөвшөөрнө;

28.10.2. гомдлын дагуу хохирлын хэмжээг тодорхойлохын өмнө чухам ямар нөхцөл байдалд үрэгдсэн, дутсан, муудсан, гэмтсэн болохыг шалган үзээд энэхүү журмын дагуу тээвэрлэлтийн үед үүссэн уг хохирлыг төмөр замын байгууллага нөхөн төлөх эсэхийг тогтооно;

28.10.3. гомдол гаргагч тээвэрлэгчийн буруугаас ачаа үрэгдсэн, муудсан, гэмтсэн болохыг нотлож чадаагүй болон энэхүү журмын дагуу ачаа үрэгдсэн гэмтсэний хариуцлагыг тээвэрлэгч хүлээхээргүй байх шалтгааны аль нэгний улмаас ачаа үрэгдсэн гэмтсэн, муудсан болох нь тогтоогдсон бол энэ тухай хариу албан бичигт тодорхой заана.


28.11. Тээвэрлэлтийн үед үрэгдсэн гэмтсэн ачааны бодит хэмжээ:

28.11.1. ачааны дутагдал, гэмтлийн бодит хэмжээг тээврийн акт, түүнд хавсаргаж ирүүлсэн дагалдах баримтуудыг үндэслэн тогтоох бөгөөд түүнчлэн хохирлын хэмжээг ачаа илгээгч, хүлээн авагчийн хооронд хийсэн гэрээ болон нэхэмжлэлийг үндэслэн тогтооно;

28.11.2. шаардлагатай тохиолдолд ачаа олголтын үед магадлан шинжээчийг оролцуулан хохирлын бодит хэмжээг тогтооно.

28.12. Ачааны жингийн хэвийн хорогдлын нормыг тооцоолох, хэрэглэх:

28.12.1. жингээр нь тооцож үнийг тооцдог ачааны жин, тээвэрлэлтийн явцад дутвал тухайн ачаанд тогтоосон жингийн хэвийн хорогдлын нормоор багасгаж бодит дутагдлын хэмжээг тогтооно;



28.12.2. хэвийн хорогдлын нормыг падаан дахь ачааны нийт жинд тулгуурлан бодно. Төрөл бүрийн ачааг тээвэрлэлтэд хүлээн авахдаа тус бүрийн жинг заасан байвал жингийн хэвийн хорогдлын нормыг ачаа тус бүрээр бодно. Нэг буюу хэд хэдэн байр ачаа гэмтсэн, алдагдсан шинжтэй бөгөөд жингийн нийт дутагдал гэмтсэн ачааны жингийн дутагдлаас хэтрэхгүй байсан ч жингийн дутууг хэвийн хорогдлын нормонд тооцож болохгүй;

28.12.3. ачаа бүхэлдээ үрэгдсэн буюу тусдаа байр үрэгдсэн үед ачааны хэвийн хорогдлын нормыг хэрэглэхгүй;

28.12.4. нэг тээврийн акт тогтоогдсон хэд хэдэн илгээлттэй нэг төрлийн ачааны дутагдлыг тооцохдоо хэвийн хорогдлын нормыг зөвхөн дутсан илгээлтүүдийн падаанд заасан жингээс тооцно. Холимог тээвэр болон шилжүүлэн ачилт хийгдсэн хэд хэдэн илгээлттэй нэг төрлийн ачаанд хүрэх өртөөнд тээврийн акт тогтоогдсон бол жингийн хэвийн хорогдлын нормыг нийт жингээс тооцно.


28.13. Хохирлыг барагдуулах мөнгөн дүнг тодорхойлох:

28.13.1. дутсан, гэмтсэн үрэгдсэн ачааны хохирлыг барагдуулах үнийн дүнг тодорхойлохдоо холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно. Гомдлын хүсэлтэд дутсан, гэмтсэн, алдагдсан ачааны үнэ өртгийг зөв тогтоосон эсэхийг шалгана. Тээвэрлэгч нь үнэ зарласан ачааны дутагдлын үнийн хэмжээг жинхэнэ үрэгдсэн ачааны өртгөөр, гэмтсэн ачааны өртгийг буурсан хэмжээгээр тус тус тогтооно;

28.13.2. бараа нийлүүлэгч буюу илгээгч ачсан ачааныхаа хэмжээ, үнийг заасан баримтыг тээврийн бичиг баримтад хавсаргасан бол энэ нь ачаа хүлээн авагчийн хувьд ачааны жинхэнэ үнэ болно. Үрэгдсэн ачааны үнийг зөв тодорхойлохын тулд нэхэмжлэл гаргасан үнэд арилжааны ашиг тооцоогүй эсэхийг тогтооно;

28.13.3. нэхэмжлэлийг гэрээний үнээр гаргасан байвал уг үнээр гомдлыг барагдуулна. Нэхэмжлэлийг жижиглэн худалдаалах үнээр гаргасан байвал гомдлын үнээс ашиг тооцсон хэсэг, бусад нэмэгдлийг хасч тооцно. Гомдлыг барагдуулахдаа төлөөгүй тээврийн хөлс, гүйлгээний татварыг нэхэмжлэхгүй. Гомдол мэдүүлэгч нэхэмжлэлд нэг ачааны хэд хэдэн зэрэг дугаарыг тоочиж төрөл бүрийн үнэ заасан боловч тээврийн актаар чухам ямар зэрэг дугаартай ачаа үрэгдсэнийг тогтоогоогүй бол үрэгдсэн ачааны өртгийг нэхэмжлэлд заасан тухайн ачааны доод үнээр барагдуулна.

28.13.4. үнэ зарласан ачааны хохирлыг барагдуулах хэмжээг падаан, бусад бичиг баримтанд заасан болон энэ талаар хамааралтай мэдэгдлийг үндэслэн дараахь байдлаар тогтооно:



- бүх ачааг үрэгдүүлбэл ачааны падаанд заасан зарласан үнээр хохирлыг бүрэн төлнө;
- зарим хэсгийг үрэгдүүлбэл үрэгдсэн ачааны зарласан үнээр ширхэг тус бүрт;
- зарим ширхэгийн зүйлийг үрэгдүүлбэл зарласан үнийн жагсаалтаар, жагсаалт хийгээгүй байвал тухайн байрын зарласан үнэ, жингээс үндэслэн нэг кг-ын дундаж өртгөөр.

28.13.5. энэхүү журмын 28.13.4-т заасан мэдэгдлүүд байхгүй бол падаанд заасан нийт зарласан үнэ, ачааны нийт жинг үндэслэн тогтооно. Ачааны зарласан үнэ ачааны жинхэнэ үнээс хэтэрч байгааг төмөр замын байгууллага нотолж чадвал тээвэрлэлтийн явцад үүссэн хохирлыг жинхэнэ өртгөөр нь төлнө;

28.13.6. ачааг гэмтээсэн хохирлыг тээврийн акт болон шинжээчийн актыг үндэслэн тогтооно. Гэмтсэн ачааг олгоход хохирлыг нь тодорхойлоогүй байвал нөхөн төлөх хэмжээг гэмтсэн ачааны буюу түүний хэсгийн өртгийн жинхэнэ буурсан үнээр тодорхойлно;

28.13.7. тээвэрлэлтэд үнэ зарлаагүй хүлээн авсан иргэний /гэрийн хэрэглэл г.м./ ачааны үрэгдсэн ачааны өртгийг барагдуулахад гаргасан гомдлын үнийн дүнг ачааг хүлээлгэн өгөх тухайн үеийн зах зээлийн үнийн дүнтэй харьцуулан тооцно.

28.14. Хүлээн авагчид хүрээгүй ачааны талаарх гомдлыг хянан барагдуулах:


28.14.1. тээвэрлэлтийн явцад бусдад шилжүүлсэн, хаяг сольж өөр хаягаар олгосон, үрэгдүүлсэн, саатуулсан түүнчлэн тодорхой бус шалтгаанаар эзэндээ хүрээгүй ачааны талаарх гомдлыг энэхүү журмын дагуу барагдуулна;

28.14.2. ачаа хүрэх зам, уг ачааг замд нь хямд үнээр шилжүүлснийг тогтоовол ачаа борлуулсан үнийн дүнгээр гомдлыг барагдуулна;

28.14.3. хаяг сольж өөр хүлээн авагчид ачааг олгосон шалтгаанаар ачаа нь анхныхаа эзэнд хүрээгүй тухай гомдлыг хэрэгсэхгүй. Гомдол мэдүүлэгчид ачааг хэнд, хаана олгосныг албан бичгээр хариу өгч, хүсэлтэд хавсаргасан баримтын хамт буцаана;

28.14.4. ачааг өөр хүлээн авагч авсан нь баримтаар нотлогдвол эзэндээ хүрээгүй ачааны гомдлыг энэхүү журмын 28.14.3-т заасны адилаар шийдвэрлэнэ;

28.14.5. ачаа алга болсон тухай гомдлыг барагдуулах хугацаанд ачаа байгаа газар, хэнд олгосныг тогтоогоогүй бол ачааг бүхэлд нь үрэгдсэнд тооцож, гомдлыг зохих журмын дагуу барагдуулна;



28.14.6. эрлийн явцад ачаа үрэгдээгүй харин замд яваа нь тогтоогдвол, ачааг хүлээн авагчид хүргэхийг хурдасгах арга хэмжээ авах бөгөөд энэ тухай гомдол мэдүүлэгчид мэдэгдэнэ.

28.15. Хүлээн зөвшөөрсөн гомдлыг барагдуулах:

28.15.1. тээвэрлэгч хүлээн зөвшөөрсөн гомдлын хэргийн төлбөрийн үнийн дүнг шалгаж тогтоосны дараа тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргана. Шийдвэрийн дагуу төлбөрийг барагдуулна;

28.15.2. гомдлыг бүхэлд нь эсвэл заримыг нь хэрэгсэхгүй болговол гомдол мэдүүлэгчид хэрэгсэхгүй болгосон үндэслэлийг тодорхой зааж хариуг албан бичгээр өгнө. Гомдол мэдүүлэгчид ирүүлсэн баримтыг буцаана. Шаардлагатай бол гомдлын материалд эдгээр баримтын хуулбар болон шаардлагатай зарим хэсгийг хавсаргана;

28.15.3. хүлээн зөвшөөрсөн гомдолд хавсаргасан баримтуудыг буцаалгүйгээр ачаа тээвэрлэлтийн албаны тээвэрлэгчийн эрх бүхий дээд байгууллагын акт гомдлын хэрэгт хадгална.


28.16. Тээвэрлэгчийн барагдуулсан гомдлын хариуцлагыг салбар нэгжтэй тооцох


28.16.1. тээвэрлэгч төлбөрийг барагдуулахаар шийдвэрлэгдсэн ачааны бүрэн бүтэн байдал алдагдсанаас үүссэн хохирлын төлбөрийг буруутай байгууллага, аж ахуйн нэгжтэй тооцно;

28.16.2. өртөөдийн хариуцлагад тооцсон ачааны бүрэн байдлын алдагдлын төлбөрийг тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр, салбар нэгжийн бурууг тогтооход санал зөрсөн тохиолдолд тээвэрлэгчийн шийдвэрээр тус тус тогтооно;

28.17. Төмөр замын байгууллага нь ирүүлсэн гомдлыг хянаж үзээд түүнийг барагдуулсан буюу хэрэгсэхгүй болсон тухай хариуг байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд 3 сарын дотор өгнө.

--- о О о ---





Зам тээврийн хөгжлийн сайдын
2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
..... дүгээр тушаалын Төмөр замаар ачаа
тээвэрлэх журмын нэгдүгээр хавсралт


Нүүрэн тал

**ОРОН НУТГИЙН ХАРИЛЦААНЫ ТЭЭВРИЙН
ПАДААН №**

Байгууллагын нэр:

- Онцгой тэмдэглэл
- Хурд _____
- Илгээлтийн төрөл _____

<ul style="list-style-type: none"> • Төлөвлөгөө гэрээний № • Ачихыг зөвшөөрсөн 20... он 	<ul style="list-style-type: none"> • Вагоны дугаар 	6.1	<ul style="list-style-type: none"> • Вагоны төрөл 	<ul style="list-style-type: none"> • Даац (тонн) 	<ul style="list-style-type: none"> • Голын тоо 																				
<ul style="list-style-type: none"> • Илгээх өртөө • Хүрэх өртөө 																									
<ul style="list-style-type: none"> • Илгээгч, түүний шуудангийн хаяг • Хүлээн авагч, түүний шуудангийн хаяг 																									
<ul style="list-style-type: none"> • Илгээгчийн марк тэмдэг 	<ul style="list-style-type: none"> • Байрын тоо 	<ul style="list-style-type: none"> • Баглааны төрөл 	<ul style="list-style-type: none"> • Ачааны нэр 	<ul style="list-style-type: none"> • Ачааны жин 		<ul style="list-style-type: none"> • Төмөр замын марк 																			
							Илгээгч	Төмөр зам																	
<ul style="list-style-type: none"> • Ачаалсан ачаалалтын техникийн норм 																									
<ul style="list-style-type: none"> • Байрын тоо (үсгээр) 			<ul style="list-style-type: none"> • Жинг тодорхойлсон арга 		<ul style="list-style-type: none"> • Тарифын бүлэг _____ 																				
<ul style="list-style-type: none"> • Жингийн дүн (исгээр) 			<ul style="list-style-type: none"> • Илгээгчийн төлөөлөгч (гарын үсэг, нэр) 		<ul style="list-style-type: none"> • Зай км _____ 																				
<ul style="list-style-type: none"> • Илгээхэд хураасан (дүн үсгээр) 	<ul style="list-style-type: none"> • Илгээх үеийн хураамж <table border="1" style="width: 100%; height: 100%;"> <tr><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td></tr> <tr><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td></tr> <tr><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td></tr> <tr><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td></tr> </table>																								
<ul style="list-style-type: none"> • Тооцооны хэлбэр (бэлэн/бэлэн бус) 																									
<ul style="list-style-type: none"> • Тооцооны ажилтан (гарын үсэг, нэр) 																									
<ul style="list-style-type: none"> • Олгоход хураасан 																									




(дүн үсгээр)		Бүгд хураасан	
• Тооцооны хэлбэр (бэлэн/бэлэн бус)	• Олгох үеийн хураамж		
• Тооцооны ажилтан (гарын үсэг, нэр)			
• Падаанд хавсаргасан баримтууд			
		Бүгд хураасан	

Ар тал

Ачиж бэхлэх тухай			
Дагуу ачиж бэхэлсэн			
(албан тушаалын гарын үсэг)			
(Батлагдсан ямар зураг, техникийн нөхцөл, стандартыг үндэслэн бэхэлснийг заана)			
37. Ломбоны тухай тэмдэглэл			
	Төмөр замын	Илгээгчийн	Ломбо зүүсэн нь (Ломбо хаана зүүснийг заана)
Ломбоны тоо			
Ломбоны хяналтын тэмдэг			
38. Төмөр замын тэмдэглэл		39. Илгээгчийн тэмдэглэл	
40. Актын тухай тэмдэглэл		41. Хаяг сольсон тухай тэмдэглэл	
42. Вагоныг буулгалтанд тавьсан он, сар, өдөр, цаг	43. Вагоныг буулгаж дууссан он, сар, өдөр, цаг	44. Ачааг олгох үед хийсэн тэмдэглэл	
45. Илгээх өртөөний хуанлийн тэмдэг	46. Хүрэх өртөөний хуанлийн тэмдэг	47. Ачаа ирсэн тухай мэдэгдэл	48. Ачаа олгосон тухай тэмдэглэл хуанлийн тэмдэг Хүлээн авсан (гарын үсэг, нэр)

ТАЙЛБАР: Орлох падаан нь падаантай адилхан байна.



**ОРОН НУТГИЙН ХАРИЛЦААНЫ ТЭЭВРИЙН ПАДААН
ЗАМЫН ХҮСНЭГТ №**

Байгууллагын нэр:


1. Онцгой тэмдэглэл _____

- Хурд _____
- Илгээлтийн төрөл _____

<ul style="list-style-type: none"> • Төлөвлөгөө гэрээний № _____ • Ачихыг зөвшөөрсөн 20... он _____ 	<ul style="list-style-type: none"> • Вагоны дугаар 6.1 	<ul style="list-style-type: none"> • Вагоны төрөл _____ 	<ul style="list-style-type: none"> • Даац (тонн) _____ 	<ul style="list-style-type: none"> • Голын тоо _____ 	
Өртөөний дарга _____					
<ul style="list-style-type: none"> • Илгээх өртөө _____ 		<ul style="list-style-type: none"> • Хүрэх өртөө _____ 			
<ul style="list-style-type: none"> • Илгээгч, түүний шуудангийн хаяг _____ 		<ul style="list-style-type: none"> • Хүлээн авагч, түүний шуудангийн хаяг _____ 			
<ul style="list-style-type: none"> • Илгээгчийн марк тэмдэг _____ 	<ul style="list-style-type: none"> • Байрын тоо _____ 	<ul style="list-style-type: none"> • Баглааны төрөл _____ 	<ul style="list-style-type: none"> • Ачааны нэр _____ 	<ul style="list-style-type: none"> • Ачааны жин _____ 	<ul style="list-style-type: none"> • Төмөр замын марк _____
		<ul style="list-style-type: none"> • Илгээгч _____ 	<ul style="list-style-type: none"> • Төмөр зам _____ 		
					<ul style="list-style-type: none"> • Ачаалсан ачаалалтын техникийн норм _____
<ul style="list-style-type: none"> • Байрын тоо _____ (үсгээр) 		<ul style="list-style-type: none"> • Жинг тодорхойлсон арга _____ 		<ul style="list-style-type: none"> • Тарифын бүлэг _____ 	
<ul style="list-style-type: none"> • Жингийн дүн _____ (үсгээр) 		<ul style="list-style-type: none"> • Илгээгчийн төлөөлөгч (гарын үсэг, нэр) _____ 		<ul style="list-style-type: none"> • Зай км _____ 	
<ul style="list-style-type: none"> • Явуулахад хураасан (дүн үсгээр) 		<ul style="list-style-type: none"> • Хүлээлгээх үеийн хураамж 			
<ul style="list-style-type: none"> • Тооцооны хэлбэр (бэлэн/бэлэн бус) 					
<ul style="list-style-type: none"> • Тооцооны ажилтан (гарын үсэг, нэр) 					
<ul style="list-style-type: none"> • Олгоход хураасан (дүн үсгээр) 					
<ul style="list-style-type: none"> • Тооцооны хэлбэр (бэлэн/бэлэн бус) 		<ul style="list-style-type: none"> • Олгох үеийн хураамж 			
<ul style="list-style-type: none"> • Тооцооны ажилтан (гарын үсэг, нэр) 					
<ul style="list-style-type: none"> • Падаанд хавсаргасан баримтууд 					
				Бүгд хураасан	

МОНГОЛ УЛСЫН
 ЯАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
 ЭХ ХУВЬ
 Сайд Төрийн нарийн бичгийн дарга 2018 оны 2 сар 24 өдөр тушаал


Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 22 ны өдрийн
26 дүгээр тушаалын Төмөр замаар ачаа
тээвэрлэх журмын хоёрдугаар хавсралт



Ачааны битүүмжлэл, бүртгэл, тэмдэглэгээ

		Вагоны төрөл Род вагоны				Вагон даац Подъёмная сила
м 20 ... он ... сар өдөр Ст 20 ... г ... месяц ... число						
Онцгой тэмдэглэл / Особые заявления						
Битүүмжлэлийн тухай Ведения о пломбах	Битүүмжлэгч станц Станция положения пломб					
	Ломбоны тоо Число пломб Месяц и число на пломбах					
	Шалгах тэмдгүүд Контрольные знаки					
Падааны № № наклада	Явуулах станц Станция отправления	Хүрэх станц Станция назначения	Хүрэх зам Дорога назначен	Баглааны төрөл Род упаковки	Ачааны нэр Наименование груза	Жин кг-аар Вес в кг
1	2	3	4	8	9	10
					НИЙТ БОХИР ЖИН /ВСЕГО БРУТТО	
Вагоныг ачилтанд өгсөн цаг мин өдөр сарын Вагон подан под выгрузку час мин числа месяца					Буулгасан цаг мин өдөр тоот барааны газарт Выгружен час, мин числа, пакта №	
Средсвами АВХ:					АВХ	
Хянасан ААВХ:					Присмосдатчик	

№	Илгээлт №							Илгээлт №			
	6-Вагон, 6-Вагон олгосон, 7- вагоны төрөл, 8-Вагоны даац, 9-Гол, 10-Вагоны жин, 11-Цистерний төрөл							37. Ломбо		38.Тээвэрлэгчийн тэмдэглэл	
	6	6.1	7	8	9	10	11	Темпе- ратура, С-Хэм	Т/см³ – Нягт	Тоо	Тэмдэг, гэмдэглэгээ
1											
2											




Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
..... дүгээр тушаалын Төмөр замаар ачаа
тээвэрлэх журмын гуравдугаар хавсралт

1115266053 5919437 СБТБ513

Чингэлгийн гадна, дотор талын хэмжигдэхүүний үзүүлэлт

Төрөл	фут		Чингэлгийн хэмжээ /гадна тал/			Чингэлгийн хэмжээ /дотор тал /		
			урт	өргөн	өндөр	урт	өргөн	өндөр
1EEE	45HC	L2G0	13716	2438	2896	13542	2330	2655
1EE	45 DC	L5G0			2591			2350
1AAA	40HC	45G0	12192	2438	2896	11998	2330	2655
1AA	40DC	42G0			2591			2350
1A	40DC	40G0			2438			2197
1AX								
1BBB	30HC	35G0	9125	2438	2896	8391	2330	2655
1BB	30DC	32G0			2591			2350
1B	30DC	30G0			2438			2197
1BX					<2438			
1CC	20DC	22G0	6058	2438	2591	5867	2330	2350
1C	20DC	20G0			2438			2197
1CX					<2438			
1D	10DC	10G0	2991	2438	2438	2802	2330	2197
1E			1968	2438	2438		2197	2330
1F	5		1460	2438	2438	1270	2197	2330

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2018 он 06 дугаар тушаал



Зам, тээврийн хөгжлийн сайдын
 2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
 дүгээр тушаалын Төмөр замаар ачаа
 тээвэрлэх журмын дөрөвдүгээр хавсралт

**ВАГОН АЧИЛТ, БУУЛГАЛТ, ХҮЛЭЭЛГЭНД ТАВЬЖ ӨГСӨН,
 ХҮЛЭЭЛЦСЭН, БУУЛГАЖ ДУУССАН САНАМЖ /сери дугаар/**

20..... оны.....-р сарын өдөр

Үйлчлүүлэгч байгууллагын нэр: _____

Салбар замын нэр, дугаар: _____

Д/д	Вагон Дугаар /О,П/	Хүлээлэг				Тавьж өгсөн		Ачиж, буулгаж дууссан		Сэлгээ хийсэн хугацаа	Тайлбар
		эхэлсэн		дууссан		сар, өдөр	цаг, минут	сар, өдөр	цаг, минут		
		сар, өдөр	цаг, минут	сар, өдөр	цаг, минут						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
2											
3											
4											
5											
6											
7											
8											

**Үйлчлүүлэгч байгууллагын
төлөөлөгч**

Хүлээн авсан: _____
 /гарын үсэг, нэр/
 огноо.....цаг.....минут
 Тушаасан: _____
 /гарын үсэг, нэр/
 огноо.....цаг.....минут

Төмөр замын төлөөлөгч

Тушаасан: _____
 /гарын үсэг, нэр/
 огноо.....цаг.....минут
 Хүлээн авсан: _____
 /гарын үсэг, нэр/
 огноо.....цаг.....минут



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 28 ны өдрийн
264 дүгээр тушаалын зургадугаар хавсралт

1113269063 5819487 СБТ9513

ТӨМӨР ЗАМААР ЗОРЧИГЧ, ТЭЭШ, АЧААН ТЭЭШ ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Төмөр замын тээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд тээвэрлэлтийн үйл ажиллагааны нийтлэг зарчимд тулгуурлан зорчигч, тээш, ачаан тээшийг түргэн шуурхай, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж тээвэрлэхэд оршино.

1.2. Энэхүү журмыг орон нутгийн зорчигч харилцаанд оролцогч ажилтан болон зорчигч, тээш, ачаан тээш илгээгч ба хүлээн авагч нарын үйл ажиллагаанд мөрдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

2.1. Зорчих тасалбар худалдах ба тасалбар худалдах газрын үйл ажиллагаа нь зорчих тасалбарыг зорчигчдод аль болох түргэн шуурхай худалдаж, галт тэргэнд хоосон байр гаргахгүй байхаар зохион байгуулагдана.

2.2. Зорчих тасалбарыг дор заасан хугацаанаас эхлэн худалдана:

2.2.1. урьдчилан тасалбар худалдах газарт галт тэрэг явахаас 2 сарын өмнө;

2.2.2. өдөр тутмын тасалбар худалдаалалтыг тухайн тасалбар худалдах газрын нээгдэх цагаас;

2.2.3. завсрын өртөөдөд галт тэрэгний чөлөөтэй байрын тухай мэдээг хүлээн авсан цагаас эхлэн галт тэрэг ирэхээс 1 цагийн өмнө тус тус худалдана;

2.2.4. тасалбар худалдах ажиллагааг галт тэрэг хөдлөхөөс 15 минутын өмнө зогсооно. Тасалбар худалдах газрын байршилтаас хамаарч эрх бүхий ажилтан дээрх хугацааг өөрчилж болно.

2.3. Тасалбар худалдах газартай өртөө, зөрлөгөөс галт тэргэнд тасалбаргүй суусан зорчигчид тасалбар худалдах явуулын нярав /цаашид "явуулын нярав" гэх/ тасалбарыг нэмэгдэлтэй тарифаар худалдана. Нэмэгдлийн хэмжээг төмөр замын байгууллагын дарга тогтооно.

2.4. Хот, дүүргийн галт тэрэгний тасалбар худалдах газрын ажиллах цагийг галт тэрэгний цагийн хуваарьтай уялдуулан эрх бүхий ажилтан тогтооно.



2.5. Галт тэргээр зорчих тасалбарт явах хүрэх өртөөний нэр, галт тэрэг, вагон, зорчих байрын дугаар, явах огноо, цаг минут, хүний тоо, тариф үнэлгээ, зорчигчийн нэр, регистрийн дугаар, олгосон огноо, цаг, минутыг тус тус бичнэ. Тасалбарын ар талд зорчигчид зориулсан санамж байна. Тухайн тээвэрлэгчээс нийтэд зарласан нэмэлт үйлчилгээний мэдээлэл байж болно.

2.6. Маягтын бүсийн хэлбэр, загварыг зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх эрх бүхий этгээд тогтоож, нийтэд мэдээлнэ.

2.7. Маягтын бүсийн тасалбарын бичилтийг гаргацтай, үгийг товчлохгүйгээр бичиж, тэмдэг дарна. Маягтын бүсийн тасалбарын бичлэгийг баллаж, засварлахгүйгээр бичсэн байна.

2.8. Зорчих тасалбарыг 5-12 насны хүүхдэд хөнгөлөлттэй олгоно:

2.8.1. тусгай байр эзлэхгүй бол асран хамгаалагчийн хамт 0-5 насны 3 хүүхдийг зорчигч үнэ төлбөргүй авч явахыг зөвшөөрнө;

2.8.2. зорчигчийн хамт 5 хүртэлх насны 3-аас дээш тооны хүүхэд зорчвол 4 хүүхдээс эхлэн хөнгөлөлттэй тасалбар худалдан авна;

2.8.3. суух байр бүхий нийтийн хатуу вагонд хүүхдийн тасалбар олгоходоо том хүний нэгэн адилаар байр олгоно;

2.8.4. дагалдах хүнгүйгээр 8 хүртэлх насны хүүхдийг зорчигчийн галт тэргэнд явахгүй байх;

2.8.5. Зорчигчийн хамт яваа 5-12 хүртэлх насны 1 хүүхдийг унтлагын байр эзлэхгүйгээр авч явахыг зөвшөөрнө;

2.8.6. насанд хүрсэн хүнтэй хамт яваа 5-12 насны 2 хүүхдийн дунд унтлагын 1 байр эзлэхийг зөвшөөрч болох ба нэмэгдэл хөлсийг 1 унтлагын байрны тарифаар тооцон авна;

2.8.7. хүүхдийн тасалбар олгоходоо тасалгааны ба унтлагын байрны нэмэгдэлийг 5-12 хүртэлх насны хүүхэд зөвхөн тусгай байр эзэлсэн нөхцөлд авна.

2.9. Буудлын дотор болон гадна зорчигчдод зориулан галт тэрэг ирэх, явах цагийн хуваарь, зорчигч ба тээш, ачаан тээш тээвэрлэлтийн тариф, зорчих тасалбар, тээш олгох газрын ажиллах цагийн хуваарь, тасалбар худалдах ажилтны нэр, санал гомдлын дэвтэр, гэнэтийн ослын даатгалын хураамжийн үнэлгээ, үйлчилгээний газрууд /зоогийн газар, амрах байр, үсчин, зурагчин, шуудан холбоо, эмнэлгийн цэг ба эмийн сан, лавлах товчоо, лавлах утасны дугаар зэрэг/-ын бүдүүвч зураг, зорчигч болон тээш тээвэрлэхтэй холбоотой дүрэм, журам, шинээр хэрэгжүүлсэн нэмэлт үйлчилгээ, тэдгээрийн хураамж, цаг үеийн шуурхай мэдээ мэдээллийн самбар байрлуулсан байна.

2.10. Галт тэргээр зорчих тасалбар нь тээвэрлэгч, зорчигч хоёрын хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох бичиг баримт бөгөөд батлагдсан маягтын дагуу бичигдсэн байна.



2.11. Зорчих тасалбарыг бэлэн ба бэлэн бусаар эсвэл тээвэрлэгчийн зөвшөөрлөөр зээлээр олгож болно.

2.12. Зорчигчийн вагоны байрны тооноос илүү тасалбарыг худалдахгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

2.13. Хурал, зөвлөлгөөний төлөөлөгчид, тойрон аялагчид, жуулчид, жүжигчид, тамирчид, оюутан сурагчид зэрэг зохион байгуулалттай бүлгээр явах зорчигчдын урьдчилан өгсөн захиалгыг үндэслэн өртөө ба буудлын эрх бүхий ажилтны зөвшөөрлөөр тасалбарыг олгоно.

2.14. Нийтийн вагоны тасалбар худалдаж авсан зорчигч хүсвэл явах чиглэлийнхээ дагуу унтлагын байрны нэмэгдэл төлж, очих өртөө хүртлээ зорчиж болно. Харин нэмэгдлийг шилжин суух эхний өртөөнөөс авах ба шууд харилцааны вагонд бол уг вагон хүрэх өртөө хүртэл авна.

2.15. Зорчигч тасалбараа үрэгдүүлсэн, гээгдүүлсэн тохиолдолд тасалбар худалдан авсан зорчигчийн талаарх мэдээлэл тасалбар худалдаалалтын баазад хадаглагдан үлдсэнийг тодорхойлсон нөхцөлд иргэний биеийн байцаалтыг мэдүүлсэний үндсэн дээр тасалбарын үнийг дахин төлөхгүй байж болох ба тасалбар нөхөн олгохтой холбогдуулан нэмэлт үйлчилгээний хураамжийг төлж тасалбар дахин авч болно.

2.16. Зорчих тасалбарт нэр нь бичигдсэн зорчигч уг тасалбараар үйлчлүүлнэ. Аялалын дундуур зорчих тасалбарыг дур мэдэн өөр зорчигчид шилжүүлэхгүй ба хэрэв шилжүүлсэн бол хүчингүйд тооцно.

2.17. Энэхүү журмын 2.16 дахь заалт цахим тасалбар худалдаалах үйлчилгээгээр үйлчлүүлсэн тохиолдолд хамаарахгүй.

2.18. Тасалбар худалдах газар нь доорх тохиолдолд зорчих тасалбар худалдахаас татгалзах эрхтэй:

2.18.1. галт тэргэнд чөлөөтэй байр байхгүй;

2.18.2. иргэний үнэмлэх эсхүл бусад биеийн байцаалтгүй;

2.18.3. асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй дараахь этгээд:

- хүнд өвчтэй зорчигч;
- согтууруулах ундаа хэрэглэсэн этгээд;
- мансуурсан этгээд.

2.19. Зорчих тасалбарын хүчинтэй хугацаа:

2.19.1. зорчих тасалбарт тэмдэглэсэн хугацаанд, аялал эхлэх өртөөнөөс дуусах өртөө хүртэл тухайн галт тэрэг, вагонд хүчинтэй;



2.19.2. өртөө, буудлын эрх бүхий ажилтан буюу тасалбар худалдах газрын эрхлэгч тасалбарын хугацааг доорх тохиолдолд сунгах эрхтэй:

а. шилжин суух галт тэргэнд чөлөөтэй байргүй бол дараагийн галт тэргэнд байр авах хүртэлх хугацаанд;

б. зорчих ёстой галт тэрэг нь шилжин суух өртөөнд батлагдсан хуваариас хожимдож ирсэн бол аяллаа үргэлжлүүлэх хүртэлх хугацаанд;

в. зорчигчид хүндэтгэн үзэх шалтгаан тохиолдсоныг тодорхойлсон бичиг баримтын дагуу;

г. галт тэргэнд /хот, дүүргийнхээс бусад/ зорчих тасалбартай боловч эзлэх ёстой байрыг олгоогүй бол зохих байр олгох бололцоотой дараагийн галт тэргээр явах хүртэл;

д. зорчигч хоорондын өртөө, зөрлөгт түр буух бол 10-аас дээшгүй хоногоор сунгаж болох ба тасалбарт сунгасан тухай тэмдэглэл хийнэ;

е. Бусад тохиолдолд зорчих тасалбарын хүчинтэй хугацааг сунгахгүй.

2.20. Төлбөрийг буцаан олгох:

2.20.1. төмөр замын байгууллага дараахь тохиолдолд ашиглаагүй зорчих тасалбар, тээвэрлээгүй тээш, ачаан тээшийн тээврийн төлбөрийг нотлох баримт болон шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн өгсөний үндсэн дээр тээвэрлэгчийн эрх бүхий ажилтаны шийдвэрээр буцаан олгож болно:

- галт тэргэнд зорчих тасалбарын дагуу зохих байрыг олгоогүй тохиолдолд зорчигчийн шаардлагаар явах өртөөний холбогдох ажилтан тэмдэглэл үйлдэн, зорчих тасалбар, тээвэрлээгүй тээшийн тээврийн хөлсөнд төлсөн бүх төлбөрийг зорчигчид буцааж өгч, тэмдэглэлийн ар талд гарын үсэг зуруулна. Зорчигчид байр олгосон бол зөвхөн тээврийн хөлсийг буцааж олгоно;
- буцах тасалбартай зорчигч зорчин явж чадахгүйд хүрч галт тэрэг хөдлөхөөс 24 цагийн өмнө зорчих тасалбар дээр төмөр замаар тэмдэглэл хийлгэсэн тохиолдолд нийтийн вагонд бол зорчилтын хөлс, тасалгаат вагонд бол зорчилтын хөлс ба унтлагын байрны хөлсний хамт, галт тэрэг хөдлөхөөс 24 цаг хүртэлх хугацааны өмнө тэмдэглэл хийлгэсэн тохиолдолд зохих суутгал хийлгэж тасалбарын үнийг буцааж авна;
- галт тэрэгний хөдөлгөөн ямар нэг шалтгаанаар саатсан үед зорчигч аялалаа үргэлжлүүлэхээс татгалзвал төмөр зам нь зорчигчийн мэдүүлгийн үндсэн дээр зорчоогүй зайн үнийг буцааж олгоно. Үүнийг зорчигчоос гаргасан бичгэн мэдүүлгийн үндсэн дээр шийдвэрлэнэ;
- өвчтэй ба хүндэтгэх шалтгааны улмаас зорчигч аялалаа бүр зогсоовол зорчоогүй зайн тасалбарын үнийг буцааж олгоно.



2.20.2. зорчих тасалбарын үнийг зорчигчийн явах тухайн өртөөний тасалбар олгох газраас буцааж олгоно;

2.20.3. зорчих тасалбарын үнийг буцаах бүх тохиолдолд дор дурьдсан хэмжээний үйлчилгээний хөлсийг суутган авна;

- галт тэрэг хөдлөхөөс 2 түүнээс дээш цагийн өмнө буцаавал нийт буцаах үнийн дүнгийн 10 хувийг;
- галт тэрэг хөдлөхөөс 2 хүртэл цагийн өмнө ба галт тэрэг хөдлөхийн өмнө буцаавал нийт буцаах үнийн дүнгийн 20 хувийг;
- галт тэрэг хөдөлснөөс хойш 30 хүртэл минутын дотор буцаавал нийт буцаах үнийн дүнгийн 50 хувийг тус тус суутгаж олгоно. /Тэмдэглэл хийсэн хугацааг баримтлан буцаалт хийнэ/.

2.21. Зорчих нөхцөл:

2.21.1. зорчигч тасалбар худалдах газартай өртөөнөөс зорчих тасалбар авч галт тэргэнд суух ба тасалбараа аялалын хугацаа дуустал өөртөө хадгалж, шалгагч /эрх бүхий албан тушаалтан/-ийн шаардлагаар үзүүлэх үүрэгтэй;

2.21.2. зорчигчийг вагонд суулгахад нь вагоны үйлчлэгч зорчих тасалбарын хүчинтэй эсэх, биеийн байцаалттайгаа тохирч буй эсэх, согтуурсан, мансуурсан эсэх, тогтоосон хэмжээний гар тээштэй эсэхийг шалгах бөгөөд зөрчсөн нөхцөлд тээвэрлэлтийн гэрээнээс татгалзана;


2.21.3. зорчих тасалбаргүй болон тогтоосон овор, хэмжээнээс хэтэрсэн гар тээштэй зорчигч, согтууруулах ундаа, мансуурах зүйл хэрэглэсэн этгээдтэй тээвэрлэлтийн гэрээ байгуулахгүй.

2.21.4. галт тэрэг 2 хүртэл минутын зогсолттой өртөө, зөрлөгт зорчигчийг галт тэрэгний аль ч вагонд оруулж болно;

2.21.5. вагоны үйлчлэгч зорчигчид зорчих тасалбарт заасан вагондаа суухад нь зохих туслалцаа үзүүлнэ;

2.21.6. тасалбар худалдах газар зорчих тасалбарыг буруу үйлдсэн буюу вагонд чөлөөтэй байргүй үед зорчигчдод зорчих тасалбар олгосон зорчих байр давхардуулан бичсэн байвал галт тэрэгний дарга, вагоны үйлчлэгч, тасалбар худалдах газрын эрх бүхий ажилтны оролцоотойгоор галт тэргэнд байр олж өгөх буюу буруу үйлдсэн тасалбарыг залруулах арга хэмжээ авна. Хэрэв зорчих тасалбар буруу олгосон нь аялалын явцад илэрвэл галт тэрэгний дарга, вагоны үйлчлэгч, явуулын нярав хамтран тэмдэглэл үйлдэн холбогдох арга хэмжээ авна;

2.21.7. төмөр замын ажилтны буруугаас зорчигч тасалбарт зааснаас өөр чиглэлийн галт тэргэнд суусан эндүүрэл гарсан тохиолдолд түүнд торгууль ноогдуулахгүй бөгөөд ойролцоох өртөөнд буулгаж үндсэн өртөө хүртэл үнэгүй зорчихыг зөвшөөрнө. Буруутай ажилтанд хариуцлага тооцно;



2.21.8. зорчигч нь тасалбарт заасан хугацаанаас өмнө галт тэргэнд суусан тохиолдолд тасалбарыг хүчингүйд тооцож, уг зорчигч дахин тасалбар худалдан авна;

2.21.9. зорчигч нь зорчих тасалбарт заасан байрыг аялалын хугацаанд ашиглах эрхтэй;

2.21.10. завсрын өртөөнд буух зорчигч тухайн вагонд цааш аяллаа үргэлжлүүлэхийг хүсвэл энэ тухайгаа вагоны үйлчлэгчид мэдэгдэх ба явуулын нярав сул байр байгаа эсэхийг тодруулсны дараа цааш зорчих хөлсийг нэмж авна;

2.21.11. вагоны үйлчлэгч зорчигчдод галт тэрэг ямар өртөө, зөрлөгт хүрэлцэн ирж буйг урьдчилан мэдэгдэх үүрэгтэй;

2.21.12. зорчигч буух буюу шилжин суух өртөөнд буулгүй өнгөрсөн тохиолдолд дахин зорчих тасалбар авна;

2.21.13. зорчигч өөр чиглэлийн галт тэргээр зорчихоор болсон тохиолдолд өмнө худалдаж авсан тасалбараа эргүүлэн өгч, тарифын зөрүүг төлсөнөөр шинэ тасалбар авна;

2.21.14. зорчигч галт тэрэгнээс хоцорвол энэ тухайгаа тасалбар худалдах газарт мэдэгдэж тэмдэглэл хийлгэнэ. Хүндэтгэх шалтгаанаар хоцорсон бол энэхүү журмын 2.19.2-т заасны дагуу сунгалт хийж, зорчигчийг дараагийн галт тэргэнд суулгана. Бусад тохиолдолд зорчих тасалбарыг энэ журамд заасны дагуу буцаалт хийж зохих хувийг суутгана;

2.21.15. галт тэрэгнээс хоцорсон зорчигчийн гар тээш, тасалбар гэх мэт эд юмс нь уг галт тэргэнд явсан бол буудлын дарга эсвэл тасалбар худалдах газрын эрхлэгч зорчигчийн очих байсан өртөө рүү ярьж, түүний эд юмсыг авч үлдэхийг мэдэгдэнэ. Галт тэрэгний дарга /вагоны үйлчлэгч/ уг мэдээг хүлээн авмагц хоцорсон зорчигчийн эд юмсыг хамгаалах арга хэмжээ авч, хүссэн өртөөнд хүлээлгэн өгнө. Үйлчилгээний хөлсийг тарифын дагуу уг зорчигчоор төлүүлнэ;

2.21.16. вагоны үйлчлэгч зорчигч галт тэрэгнээс хоцорсныг мэдвэл энэ тухай галт тэрэгний дарга, явуулын няравт мэдэгдэж, уг зорчигчийн орхисон эд юмсыг галт тэрэгний дарга, цагдаагийн ажилтан, үйлчлэгч болон хөндлөнгийн гэрчийн этгээдийн хамт тэмдэглэл үйлдэн хадгалж, хамгаална;

2.21.17. шууд харилцааны вагон бүхий галт тэрэг хуваарьт цагаас хоцорч, уг вагоныг залган аялалыг цааш үргэлжлүүлэх галт тэрэг явснаас хойш ирсэн бол буудлын дарга зорчигчдыг аль болохоор эхний ээлжинд явуулах арга хэмжээг авна. Зорчигч унтлагын байр худалдаж авсан бол зэрэглэл бууруулалгүй сольж өгнө;

2.21.18. зорчигч зорчих галт тэрэгнээсээ өмнө явах болсон тохиолдолд өмнө нь худалдаж авсан тасалбараа тасалбар худалдах газарт буцааж, өөрийн явах галт тэргэнд дахин тасалбар худалдан авч зорчино.

2.22. Зорчих тасалбарыг буруу ашиглах:



2.22.1. нийтийн вагоноор зорчих тасалбартай зорчигч унтлагын байрны нэмэгдлийн зөрүүг төлөхгүйгээр унтлагын байранд буюу дээд зэрэглэлийн вагонд суусан бол зорчигчийг тасалбарт заасан байрандаа суухыг шаардана. Суусан вагонд нь чөлөөтэй байр байвал зохих нэмэгдлийг төлүүлснээр тухайн байранд зорчихыг зөвшөөрнө. Зорчигч тарифын зөрүүг төлөхөөс татгалзвал холбогдох хууль тогтоомжийн дагуу торгууль ногдуулж, тарифын зөрүүг төлүүлнэ;

2.22.2. зорчигч нь өөр хүний нэр бүхий тасалбар, хугацаа дууссан эсвэл хуурамч тасалбараар зорчвол тасалбарыг хүчингүйд тооцож, холбогдох хууль тогтоомжийн дагуу торгууль ногдуулж, дахин тасалбар авахыг шаардах ба татгалзвал галт тэрэгнээс буулгана;

2.22.3. зорчигч тасалбараа үрэгдүүлсэн тохиолдолд тасалбар худалдан авсан зорчигчийн талаарх мэдээлэл тасалбар худалдаалалтын баазад хадгалагдан үлдсэнийг тодорхойлсон нөхцөлд болон иргэний биеийн байцаалтыг мэдүүлсэний үндсэн дээр тасалбарын үнийг дахин төлөхгүй байж болох ба тасалбар олгохтой холбоотой нэмэлт үйлчилгээний хөлсийг төлж тасалбар дахин авч болно. Энэхүү заалт нь цахим тасалбар худалдаалах үйлчилгээгээр үйлчлүүлсэн тохиолдолд хамаарахгүй.

2.23. Зорчих тасалбар үйлдэх үед гарах зөрчлийг залруулах ба хүлээх хариуцлага:

2.23.1. төмөр замын ажилтны буруугаас хүрэх өртөөний нэр тавигдаагүй, цоолбор хийгдээгүй зэрэг бүрэн бус тэмдэглэл хийгдсэн зорчих тасалбар илэрсэн тохиолдолд тасалбарыг хүчингүйд тооцон хураан авч, энэ тухай тэмдэглэл үйлдэн зорчигчид шинээр тасалбар олгох ажиллагааг дараахь байдлаар гүйцэтгэнэ.

- тасалбарыг солих тухай тэмдэглэл галт тэрэгний дарга, байцаагч үйлдэх ба харин галт тэрэг сэлгэн суух өртөөнд нэгэнт ирсэн зорчигч аялалаа цааш үргэлжлүүлэх бол өртөө болон буудлын дарга тэмдэглэл үйлдэнэ;
- өртөөний тасалбар худалдах газар эсхүл явуулын нярав нь зохих зэрэглэлийн вагонд төлбөргүйгээр шинэ тасалбар олгох ба хүчингүй болгосон тасалбарыг тэмдэглэлд хавсаргана. Тасалбарын ар талд "хураасан тасалбарын оронд олгов" гэсэн бичилт хийнэ;
- хураагдсан тасалбарт "тээш" гэсэн тэмдэглэлтэй бол түүнийг шинээр үйлдсэн тасалбарт нөхөж бичнэ;
- шинээр олгосон тасалбар ба тэмдэглэлд тухайн зорчигчоор гарын үсэг зуруулна.

2.23.2. тэмдэглэлийг хүлээн авсан өртөө, буудлын дарга буруутай ажилтнаар буруу олгосон тэврийн хөлсийг төлүүлж, хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасанд тооцон хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

2.24. Вагоны үйлчлэгч зорчигч буух өртөөндөө хүрэлцэн ирэхийн өмнө ашиглагдсан тасалбар болон бусад тэврийн бичиг баримтыг эзэнд нь буцааж өгнө.



2.25. Цагаан хэрэглэл олгох, бусад зүйлээр үйлчлэх:

2.25.1. унтлагын байр бүхий вагонд тасалбартай зорчигчийг 22.00-06.00 цагийн хооронд, аяллын үргэлжлэх хугацаа 2 цагаас дээш үргэлжлэх нөхцөлд цагаан хэрэглэлээр заавал хангана;

2.25.2. зорчигч цагаан хэрэглэлийг аян замын туршид ашиглах ба галт тэрэгнээс буухаас 30 минутын өмнө вагоны үйлчлэгчид хураалгана;

2.25.3. цагаан хэрэглэлийг үрэгдүүлсэн буюу цаашид ашиглах боломжгүй болгосон, хими цэвэрлэгээ шаардахуйц бохирдуулсан тохиолдолд зорчигчоос цагаан хэрэглэлийн үнийг 2 дахин нэмэгдүүлж төлүүлнэ;

2.25.4. цай, цагаан хэрэглэлээ ашигласан, хоорондын замд бууж буй зорчигчын тасалбарыг сунгах болон буцаахыг зөвшөөрнө. Сунгалт хийсэн тохиолдолд дээрх төлбөрийг дахин төлнө;

2.25.5. вагоны үйлчлэгч нь зорчигчийн хүсэлтээр цай, кофе, цэвэр ус, буцалсан ус, ахуйн хэрэгцээний зүйлс, утасгүй интернет үйлчилгээ /Wi-Fi/ зэргээр тогтоосон тарифын дагуу үйлчилнэ.

2.26. Замд түр буудлах, шилжин суух:

2.26.1. зорчигч энэхүү журмын 2.19.2.д-д заасан тохиолдолд галт тэрэг ирснээс хойш 30 минутын дотор зорчих тасалбартаа тус өртөөний тасалбар худалдах газарт эрх бүхий ажилтнаар тэмдэглэл хийлгэж сунгуулан, 10 хоногийн дотор зорчих байр авна;

2.26.2. зорчигч хүсвэл аялалын явцад доод зэрэглэлийн вагонд шилжин сууж болох бөгөөд анх төлсөн тээврийн хөлсний зөрүүг буцааж олгохгүй;

2.26.3. төмөр замын байгууллагын буруугаас зорчигчийг дээд зэрэглэлийн вагон буюу галт тэргэнд шилжүүлэн суулгах шаардлага гарсан тохиолдолд галт тэрэгний дарга ба өртөө, эрх бүхий ажилтан тэмдэглэл үйлдэж, уг ажлыг зохион байгуулна;

2.26.4. энэхүү журмын 2.26.3-т заасан тохиолдолд дээд зэрэглэлийн вагонд шилжүүлэн суулгасан нэмэгдлийг зорчигчоос хураахгүй. Доод зэрэглэлийн вагонд шилжүүлэн суулгасан тохиолдолд зорчих тасалбарын үнийн зөрүүг зорчигчид буцааж олгох бөгөөд галт тэргэнд зорчигчийн зорчих тасалбарт тохирсон сул байр гармагц зорчигчийг тухайн байранд шилжүүлэн суулгана. Зорчигч татгалзсан тохиолдолд зорчих тасалбарт нь тохирсон байр эзлэхийг мэдэгдсэн өртөө хүртэл дээд зэрэглэлийн вагонд суулгасан зорчих тасалбарын үнийн зөрүүг төлөхгүй буюу мэдэгдэл өгсөн өртөөнөөс эхлэн дээд зэрэглэлийн вагоноор зорчсоны нэмэгдлийг зорчигчоор төлүүлнэ;

2.26.5. салгагдсан вагонд зорчигч цагаан хэрэглэлийн үнэ төлсөн байвал эрх бүхий ажилтан тэмдэглэл үйлдэж, гарын үсэг, буудлын тэмдгээр баталгаажуулан



нэг хувийг зорчигчид өгөх бөгөөд уг тэмдэглэлийг үндэслэн дараагийн вагонд цагаан хэрэглэлийг үнэгүйгээр олгоно;

2.26.6. салгагдсан вагоноос өөр вагонд зорчигчдыг шилжүүлэн суулгахад төмөр замын ажилтан шаардагдах туслалцаа үзүүлэх ба галт тэрэгний дарга зорчигчдын аюулгүй байдлыг хангах урьдчилсан арга хэмжээг авсан байвал зохино.

2.27. Тээвэрлэхээс татгалзах:

2.27.1. төмөр замын байгууллага дараахь тохиолдолд зорчигчийг цааш тээвэрлэхээс татгалзах, зорчигчийг галт тэрэгнээс буулгаж тээвэрлэлтийн гэрээнээс татгалзах эрхтэй:

а. зорчигч аялалын журам зөрчих буюу вагонд зорчигчдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, согтууруулах, мансууруулах зүйл хэрэглэсэн тохиолдолд;

б. бусад зорчигчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, гэм хор учруулахуйц зорчигч /сэтгэцийн хүнд өвчтэй зэрэг/ байвал түүнд тусгайлан байр гаргаж өгөх буюу байр гаргаж өгөх бололцоогүй нөхцөлд зорчигчийг эмнэлэгийн байгууллага бүхий өртөөнд галт тэрэгнээс буулгана.

2.27.2 дээрх шалтгаанаар зорчигчийг галт тэрэгнээс буулгасан тохиолдолд өртөөний жижүүр, галт тэрэгний дарга холбогдох хүмүүсийг байлцуулан тэмдэглэл үйлдэнэ.

2.27.3. энэхүү журмын 2.27.1.б-д дурдсан шалтгаанаар галт тэрэгнээс буусан зорчигчийн хүсэлтээр зорчоогүй зайн зорчих тасалбарын үнийн зөрүүг буцааж олгох буюу зорчих тасалбарын хүчинтэй хугацааг сунгах асуудлыг зорчигч буусан өртөө, буудлын эрх бүхий ажилтан шийдвэрлэнэ.

2.27.4. буусан зорчигч өөрийнхөө тээшийг зорчих тасалбарт заасан өртөө хүртэл илгээхийг зөвшөөрөөгүй тохиолдолд тээшийн тасалбарыг үндэслэн уг зорчигчийн буусан өртөөнд тээшийг олгох ба бололцоогүй бол уг тээшийг очих өртөө хүртэл илгээнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГАР ТЭЭШ ТЭЭВЭРЛЭХ НӨХЦӨЛ

3.1. Гар тээш тээвэрлэх

3.1.1. гар тээш нь сав, баглаа, боодлын байдлаас үл хамааран хэмжээгээрээ вагоны гар тээшний байранд хялбар багтах, бусад зорчигчдод саад болохооргүй байх ёстой;

3.1.2. зорчигч нь зорчих тасалбараар 36 кг-аас илүүгүй жинтэй, 5-12 хүртлэх насны хүүхдийн тасалбараар 15 кг хүртэл жинтэй 40х60х80см-ээс хэтрэхгүй хэмжээтэй нэг гар тээшийг үнэ төлбөргүй авч явах эрхтэй;



3.1.3. гар тээшинд зорчигчийн аялалын туршид хэрэглэх хүнсний болон хувийн хэрэгцээний эд зүйлс, ариун цэврийн хэрэглэл, ахуйн зориулалттай бараа орно;

3.1.4. хорио цээр тогтоосон бүс нутгаас гар тээш тээвэрлэхийг хорио цээрийн албаны зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ;

3.1.5. гар тээшийн бүрэн бүтэн байдлыг зорчигч өөрөө хариуцах үүрэгтэй;

3.1.6. вагон болон зорчигчийн эд юмсыг гэмтээх, бохирдуулах, эвгүй үнэртэй, хортой ачаа, галт зэвсэг, галын аюултай, түргэн ба өөрөө шатах, тэсрэх, дэлбэрэх, цацраг идэвхит, идэмхий болон хордуулах бодис зэрэг хууль тогтоомжоор тээвэрлэхийг хориглосон зүйлс, мөн түүнчлэн түүхий мах гэх мэт түргэн муудах эд юмсыг гар тээшинд авч явахгүй байх;

3.1.7. вагоны гар тээшний байранд багтахгүй том хэмжээний радио, телевизор, компьютер, дуу ба дүрс бичигч зэрэг эмзэг ачааг гар тээшинд хамааруулан зорчих тасалбараар үнэ төлбөргүй галт тэргэнд авч явахыг зөвшөөрнө;

3.1.8. тусгайлан хориглоогүй бол 2 хүртэл тооны гэрийн тэжээвэр амьтан /нохой, шувуу, муур, туулай, зараа зэрэг/-г зорчигчийн галт тэргэнд зохих хөлс, тээврийн бичиг баримтыг бүрдүүлэн тасалгаат вагонд авч явахыг зөвшөөрнө. Хүүхэд зорчиж буй вагонд гэрийн тэжээвэр амьтан тээвэрлэхгүй;

3.1.9. нохойг хушуувч, оосортойгоор бусдын аюулгүй байдлыг хангаж тээвэрлэнэ;

3.1.10. бусад тэжээвэр амьтан ба шувууг хайрцаг, тор зэрэг зориулалтын саванд тээвэрлэнэ;

3.1.11. тэжээвэр амьтан, шувууг зорчигчийн ба тээшийн вагонд авч явахад тээшийн тасалбар үйлдүүлж, нүүрэн талд нь "Зорчигч гартаа авч явах тээш" гэсэн тэмдэглэгээ хийлгэж тээшийн тарифаар хөлсийг төлнө;

3.1.12. тэжээвэр амьтан, шувууг тээшийн дагалдах бичиггүй, төлбөр хийлгүйгээр галт тэргэнд авч орохыг хориглох бөгөөд зөрчсөн тохиолдолд тээврийн хөлсийг нөхөн төлүүлэх бөгөөд татгалзсан тохиолдолд тээвэрлэлтийн гэрээнээс татгалзах эрхтэй. Татгалзсан шалтгааны талаар эрх бүхий этгээд тэмдэглэл үйлдэнэ.

3.2. Зорчигч тогтоосон хэмжээнээс их овор, хэмжээтэй гар тээш тээвэрлэвэл суусан өртөөнөөс очих өртөө хүртэл тээврийн хөлсийг тээшийн тарифын дагуу төлүүлнэ. Зорчигч төлбөр төлөхөөс татгалзсан тохиолдолд тээвэрлэлтийн гэрээнээс татгалзаж цагдаагийн ажилтан бүхий өртөөнд галт тэрэгнээс буулгана. Зорчигч галт тэргэнд тээвэрлэхийг хориглосон гар тээш авч явсан нь илэрвэл эрх бүхий ажилтанд мэдэгдэж холбогдох арга хэмжээ авна.

3.3. Гар тээш хадгалах ажиллагаа, нөхцөл:



3.3.1. гар тээш хадгалах байр өртөө, буудалд байна. Энэ байранд зорчих тасалбарыг үл харгалзан овор хэмжээ багатай гар тээшийг хүлээн авна. Гар тээш хадгалах байрын ажиллах цагийн хуваарийг нийтэд үзэгдэхүйц газар байрлуулна;

3.3.2. гар тээш хадгалах байранд 50 кг-аас дээшгүй жинтэй, сав, баглаа, боодолтой тээшийг байр тус бүрээр нь хүлээн авч хадгална. Энэхүү журмын 3.1.6, 3.1.8-д заасан тээш болон гэрийн тэжээвэр амьтан хүлээн авахгүй. Гар тээш хадгалах байранд зорчигчийн хадгалуулахаар өгсөн тээшин дэх түргэн муудах, гэмтэх эд юмсыг төмөр замын байгууллага хариуцахгүй;

3.3.3. хадгалах байранд гар тээш хүлээн авахдаа биеийн байцаалтыг үндэслэн сав, баглаа, боодлын бүрэн бүтэн байдлыг шалгаж, хадгалалтын бичиг баримтыг үйлдэх ба тасалбарын үлдэх хувь дээр ачааны эзнээр нотолгоо болгон гарын үсэг зуруулна;

3.3.4. бусдын эд зүйлд хор нөлөө үзүүлж болохуйц гар тээшийг хадгалуулахаар өгсөн этгээд үүсч болох бүх хариуцлагыг өөрөө хүлээнэ;

3.3.5. гар тээшийг хадгалахаар хүлээн авсан ажилтан зөвхөн гадна байдлыг шалгаж хүлээн авах эрхтэй тул хариуцлага хүлээхгүй.

3.4. Хадгалуулахаар өгөх гар тээш тус бүрт эсвэл нийтэд нь үнэ зарлаж болно. Тээшийн үнэ эргэлзээтэй байвал уул ачааны баглаа, боодлыг задлахыг эзнээс нь шаардана. Эзэн нь задлаж үзүүлэхийг эс зөвшөөрвөл уг гар тээшийг хадгалахаар хүлээж авахгүй. Ачааны эзэн тогтоосон тарифын дагуу зарласан үнэд зохих хөлсийг төлнө.

3.5. Хадгалалтын хөлс төлөх:

3.5.1. хадгалахаар хүлээн авах гар тээш тус бүрийн зарласан үнийн дүн, хүлээн авсан огноо, цаг минут, тоо ширхэг болон гар тээшийн эзний биеийн байцаалтын тухай тэмдэглэл бүхий дагалдах бичгийг олгоно;

3.5.2. гар тээшийн эзэн тээш хадгалуулсны хөлсийг тогтоосон тарифын дагуу төлнө. Хадгалуулсан гар тээшийг олгохдоо гар тээшийн эзний биеийн байцаалт болон дагалдах бичгийг шалгаж олгох ба дагалдах бичгийг хурааж авна.

3.6. Гар тээш хадгалах автомат хайрцгийг ашиглах:

3.6.1. гар тээш хадгалах автомат хайрцгуудыг буудал дотор, зорчигчдод үйлчлэх үйлчилгээний шаардлага хангасан, гэрэлтүүлэг сайтай газар байрлуулсан байна;

3.6.2. хадгалах автомат хайрцаг тус бүрийг дэс дараалан дугаарласан байна. Автомат хадгалах хайрцгийн ашиглах журмыг тод, тодорхой бичиж, нийтэд үзэгдэхүйц газар байрлуулна;

3.6.3 зорчигч тээшээ автомат хадгалах хайрцагт нууц дугаараар хадгалах ба нууц дугаарын хадгалалт, ашиглалтыг зөвхөн зорчигч өөрөө хариуцна;



3.6.4. хадгалах автомат хайрцагны ашиглалтад буудлын ажилтан хяналт тавина;

3.6.5. төмөр замын байгууллага тус бүр өөрийн ашиглаж байгаа хадгалах автомат хайрцагны ашиглах журмыг тогтооно.

3.7. Үрэгдсэн гар тээш болон дагалдах бичиг:

3.7.1. хадгалуулахаар өгсөн гар тээш үрэгдвэл өртөө ба буудлын дарга ерөнхий маягтын дагуу тэмдэглэл үйлдэж, тасалбар үзүүлэгчид зарласан үнийн хэмжээгээр хохирлыг барагдуулна. Гар тээшинд үнэ зарлагдаагүй тохиолдолд хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ;

3.7.2. алга болсонд тооцоогдсон гар тээш олдвол өмнө нь эзэнд нь төлсөн төлбөрөө эргүүлэн авч, гар тээшийг олгоно;

3.7.3. хадгалуулсан гар тээшийн дагалдах бичгийг зорчигч үрэгдүүлсэн тохиолдолд өөрийн эд зүйл болохыг нотолсон баримт бичгийг бүрдүүлэх бөгөөд түүнийг хянан үзсэний үндсэн дээр олгож болно. Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг тээвэрлэгч өөрийн дотоод журмаар зохицуулна;

3.8. гар тээшийг 5 хүртэлх хоногийн хугацаатайгаар хадгалах байранд хүлээн авна. Гар тээшээ 30 хоногийн дотор авахгүй тохиолдолд тээш хадгалалтын гэрээгээр тохиролцсон мэдээллийн хэрэгсэлээр мэдээлэл өгөх ба төмөр замын байгууллага, холбогдох мэрэгжлийн байгууллагатай хамтран комиссыг томилж, уг гар тээшийг Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу худалдан борлуулж хадгалалтын гэрээний хөлсийг нөхөн төлүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТЭЭШ ХҮЛЭЭН АВАХ БА ТЭЭВЭРЛЭХ НӨХЦӨЛ


4.1. Тээш хүлээн авах, тээвэрлэх:

Зөвлөмж: Тээш гэж зорчигч зорчих тасалбараа үзүүлж, аялах галт тэрэгнийхээ тээшний вагонд тээвэрлүүлэхээр хүлээлгэн өгсөн, энэхүү журмын 4.1.5-д заасан нөхцөлийг хангасан эд юмсыг хэлнэ.

4.1.1. зорчигчийн галт тэрэгний зогсолттой, тээш тээвэрлэлтэнд нээлттэй бүх өртөө, зөрлөгт тээш хүлээн авах, тээвэрлэх, олгох ажиллагаа явагдана;

4.1.2. зорчигчоос хүлээн авах тээш нь тээшийн вагоны хаалгаар чөлөөтэй багтах, ачих, буулгах, зөөвөрлөхөд хялбар бариултай, сав, баглаа, боодол нь тээвэрлэлтийн явцад тээшийн бүрэн бүтэн байдлыг найдвартай хангахаар зохих дүрэм, журам, зааврын дагуу бэлтгэгдсэн байвал зохино;

4.1.3. задарч эвдрэхээргүй унадаг дугуй, мотоцикл, хүүхдийн тэрэг, тахир дутуу хүний тэргэнцэр зэргийг ороолт, боодолгүйгээр тээвэрлэлтэнд хүлээн авч болно;



4.1.4. тээшийн сав, баглаа, боодол нь бат бэх, цоож нь гэмтэлгүй байх шаардлага хангасан байна;

4.1.5. нэг байр эзлэх тээш нь 75 кг-аас ихгүй байх ба нэг зорчих тасалбараар тээвэрлүүлэх тээшний нийт хэмжээ 200 кг-аас ихгүй байна;

4.1.6. бүрэн бүтэн бус сав, баглаа, боодолтой тээшийг тээвэрлэлтэд хүлээж авахгүй. Бусад тээшинд гэм хор учруулах, бохирдуулах, эвгүй үнэртэй ачаа, галт зэвсэг, галын аюултай, түргэн ба өөрөө шатах, тэсрэх, дэлбэрэх, цацраг идэвхит, идэмхий болон хордуулах бодис зэрэг хууль тогтоомжоор тээвэрлэхийг хориглосон зүйлс, мөн түүнчлэн хорио цээрийн голомтод байсан тэжээвэр амьтанг тээвэрлэхээр хүлээж авахгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

4.1.7. зорчигчийн зорчих тасалбарт заасан өртөө хүртэл тээшийг тээвэрлэх бөгөөд хүлээн авах цэгийн байрлалаас хамаарч галт тэрэг хөдлөхөөс нэг цагаас доошгүй хугацааны өмнө тээшийг тээвэрлэлтэнд хүлээн авна;

4.1.8. сав баглаа боодол нь тухайн эд зүйлийн аюулгүй тээвэрлэх шаардлагыг хангасан байх, сэлгэн ачилтын үед тээшийн бүрэн байдлыг хангахуйц байвал зохино. Тээвэрлэсэн тээшний сав, баглаа, гэмтээгүй тохиолдолд далд дутагдалын хариуцлагыг төмөр замын байгууллага хүлээхгүй. Харин хагарч эвдрэх ачааны тэмдэг наасан тээшийг анхаарал болгоомжтой тээвэрлэх үүргийг төмөр замын байгууллага хариуцна;

4.1.9. өртөөний тээш хүлээн авах, олгох газрын ажиллах цагийн хуваарь зорчигчдод үйлчлэх бүх боломжийг хангасан байна;

4.1.10. тээшийг тухайн зорчигчийн аялах галт тэргээр илгээх ба боломжгүй тохиолдолд дараагийн галт тэргээр эхний ээлжинд явуулна;

4.1.11. онцгой болгоомж шаардсан тээшийг тээвэрлэлтийн гэрээ хийхдээ талууд техникийн нөхцөл, тээвэрлэлтийн шаардлагыг харилцан тохиролцон, зохих ачааны анхааруулах тэмдэгийг нааж хүлээн авна.

4.2. Тээшийг хүлээн авах, тэмдэглэл хийх, тээвэрлэлтэнд бэлтгэх:

4.2.1. зорчигчийн тээвэрлүүлэх тээш тус бүр дээр 3x15 см-ийн хэмжээтэй цаас, картон ба даавуун наадас буюу зүүлтийг тодоор бичиж хадах үүргийг тээшийн газрын ажилтан гүйцэтгэж, зохих хөлсийг тээш илгээгчээс авна;

4.2.2. наадас буюу зүүлт дээр бичигдэх зүйл:

- тээшийн эзний овог нэр, хаяг;
- явуулах өртөөний нэр;
- хүрэх өртөөний нэр;
- тээшийн тасалбарын дугаар;
- тээшийн жин;



- байрын тоо;
- тээшийн нэр;
- илгээсэн огноо.

4.2.2. тээшийг тээвэрлэлтэнд хүлээн авч, дагалдах бичгийг үйлдэж, тээшийн тасалбарыг зорчигчид олгох ба зорчигчийн зорчих тасалбарт "тээш" гэсэн тэмдэг дарна.

4.2.3. тээш хүлээлцэгч ороож боох боломжгүй унадаг дугуй, тэргэнцэр зэргийг тээшинд хүлээж авахдаа тээшийн замын хүснэгтэнд тухайн эд зүйлийн серийн дугаар болон хонх, гэрэл гэх мэт салгаж болох эд анги нь бүрэн бүтэн эсэхийг заавал тэмдэглэж бичнэ.

4.3. Үнэ зарлах:

4.3.1. зорчигч тээшээ тээвэрлэлтэнд хүлээлгэн өгөхдөө түүнд заавал үнэ зарлах ба зохих хөлсийг тарифын дагуу төлнө. Хэд хэдэн тээш өгсөн бол тээш тус бүрд эсвэл нийтэд нь үнэ зарлаж болно. Тээшийн эзний хэлсэн үнийн дүнг тээшийн тасалбарт тоо ба үсгээр бичнэ. Харин тээш тус бүрийн жин ба үнийг тоогоор бичнэ;

4.3.2. төмөр замын ажилтан уул зарласан үнийн зөв эсэхэд эргэлзвэл тээшийг задлахыг шаардаж болох ба энэ талаар маргаан гарсан тохиолдолд өртөөний буюу буудлын эрх бүхий ажилтан асуудлыг шийдвэрлэнэ. Зорчигч нь тээшээ задлаж үзүүлэхгүй эсхүл өртөө /буудал/-ний эрх бүхий ажилтны шийдвэрийг эс зөвшөөрвөл уг тээшийг хүлээн авахаас татгалзана.

4.4. Гэрийн тэжээвэр амьтан, шувуу тээшээр тээвэрлэх:

4.4.1. гэрийн тэжээвэр амьтан, шувууг замдаа шилжүүлэн ачилтгүй шууд явах галт тэргэнд тээшээр тээвэрлэхээр хүлээн авна;

4.4.2. гэрийн тэжээвэр амьтан, шувууг бусад тээш болон вагоныг гэмтээхгүй, бохирдуулахгүй байх боломжоор хангасан контейнер, сагс, тор, саванд тээвэрлэнэ. Тор, сав нь тээвэрлэх амьтдын тоо, хэмжээнд тохирсон байх шаардлагатай бөгөөд хэт овортой байж болохгүй. Нэг байрны хэмжээ нь 50 кг-аас хэтэрч болохгүй. Гэрийн тэжээвэр амьтан, шувууг галт тэрэг хөдлөхөөс нэг цагийн өмнө тээвэрлэлтэнд хүлээн авна. Мал адгуус болон зэрлэг амьтдыг тээшээр тээвэрлэхгүй. Мал адгуусыг тээшийн вагонд тээвэрлэх тохиолдолд тусгайлсан гэрээний үндсэн дээр тээвэрлэж болно;

4.4.3. төмөр замын байгууллагын буруугаар ташаа илгээснээс бусад тохиолдолд гэрийн тэжээвэр амьтан, шувууг хооллох арчлах ажлыг эзэн нь хариуцна;

4.4.4. гэрийн тэжээвэр амьтан, шувууг тээшээр тээвэрлэж буй галт тэрэг хүргэх ёстой өртөөнд ирмэгц тээш хүлээн авагч нь заавал хүлээн авна. Хэрэв аваагүй тохиолдолд утас, факс, шуудан, цахим болон бусад хэлбэрээр мэдэгдэж,



баримтжуулан тэмдэглэгээ хийж уул амьтан, шувууг холбогдох байгууллагад тэмдэглэлээр хүлээлгэн өгнө;

4.4.5. тээшийн дагалдах бичгээ зорчигч үрэгдүүлсэн тохиолдолд өөрийн эд зүйл болохыг нотолсон баримт бичгийг бүрдүүлэх бөгөөд түүнийг хянан үзсэний үндсэн дээр олгож болно. Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг тээвэрлэгч өөрийн дотоод журмаар зохицуулна;

4.4.6. 5-аас дээшгүй гэрийн тэжээвэр амьтан, шувууг мал эмнэлгийн магадлагаатай бол нэг илгээлтээр тээвэрлэж болно.

4.5. Ургамал, суулгац тээвэрлэх:

4.5.1. бусад тээшийг бохирдуулахааргүй, сав, баглаа, боодол нь тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хангасан, хорио цээрийн бичигтэй ургамал бут, суулгац болон бусад ургамлыг тээшээр тээвэрлэж болно. Тээшийг тээвэрлэлтэнд тухайн галт тэрэг хөдлөхөөс 2 цагийн өмнө хүлээн авна. Тээш тус бүрийн хүндийн жин 50 кг, өндөр нь 2 м-ээс хэтэрч болохгүй. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрээс тээвэрлэх ургамал, суулгацыг зохих журмын дагуу хорио цээрийн албаны зөвшөөрлийг үндэслэн хүлээн авч тээвэрлэнэ.

4.6. Тээш илгээх:

4.6.1. зорчигч нь тээшээ өөр галт тэргээр илгээх тухай захиалга өгөөгүй бол тээвэрлэхээр хүлээн авсан тээшийг уг зорчигчийн аялах галт тэргээр явуулах шаардлагатай ба тээвэрлэх боломжгүй бол дараагийн галт тэргээр эхний ээлжинд явуулна;

4.6.2. тээшийг шилжүүлэн ачих нөхцөлөөр тээвэрлэлтэнд хүлээн авах үед тээш илгээгч шилжүүлэн ачилтын үйлчилгээний хөлсийг хариуцах ба төмөр замын байгууллага зорчигчийн оролцоогүйгээр ачих, буулгах ажлыг гүйцэтгэнэ;

4.6.3. хууль, хяналтын байгууллагын шийдвэрээр тээшийг хүргэх өртөөнөөс өөр өртөөнд саатуулагдахаар бол тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан, цагдаагийн ажилтан хамтран тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурж, энэ тухай тээш хүрэх өртөөнд мэдэгдэж, хүрэх өртөө нь харилцаа холбооны хэрэгсэлээр мэдээлж, баримтжуулан тэмдэглэгээ хийж, тээш илгээгч, хүлээн авагчид мэдэгдэнэ.

4.7. Аялалын замд тээш олгох:

4.7.1. зорчигч аялалын замдаа тээшээ авахыг хүсвэл галт тэрэгний даргаар дамжуулан эсвэл өөрийн биеэр тээш, түгээгчид урьдчилан мэдэгдэх шаардлагатай;

4.7.2. тээшийн вагон дахь ачааны байрлал болон өртөөн дээр галт тэрэг зогсох хугацаанд тээшийг олгох боломжтой бол түүнийг олгоод тээшийн дагалдах бичгийг зорчигчоос хурааж авна;

4.7.3. дагалдах бичгийг замын хүснэгтийн хамт тээш түгээлтийн ээлжит тайланд хавсарган төмөр замын байгууллагын санхүүд явуулахаар тээш олгосон



өртөөний эрх бүхий ажилтанд хүлээлгэн өгнө. Ийм тохиолдолд тээш тээвэрлэгдээгүй зайн хөлсийг буцааж олгохгүй.

4.8. Тээврийн хөлс төлөх:

4.8.1. тээш тээвэрлэх хөлсийг түүний дагалдах бичгийг үйлдэх үед хураана;

4.8.2. тээшийн хүндийн жин дагалдах бичигт зааснаас илүү байвал аялалын замд буюу очсон өртөөнд ерөнхий маягтын акт үйлдэн тээврийн хөлсний зөрүүг зорчигчоос шаардаж авна.

4.9. Хаягласан өртөөнд тээшийг хүлээн авах ба олгох:

4.9.1. өртөөнд ирсэн тээшийг олгохдоо тээшийн дагалдах бичгийг төмөр замын хүснэгттэй тулган тохирсон тохиолдолд хүлээн авагчид олгоно. Тээшийн хүснэгтийг тээшийн тайланд хавсарган төмөр замын харъяа холбогдох байгууллагын санхүүд явуулна;

4.9.2. тээш тээвэрлэлтийн үйл ажиллагаанд нээлттэй өртөөнд тээш хүлээлцэгчид тээшийг хүлээн авах ба хүлээлгэн өгөх бөгөөд хаалттай өртөөнд тээш түгээгч нь вагоноос шууд олгоно;

4.9.3. тээш нь хүрэх өртөөнд ирээгүй тохиолдолд зорчигчийн тээшийн дагалдах бичгийн ар талд "тээш ирээгүй" гэсэн тэмдэглэл хийж он, сар, өдрийг бичиж өртөөний буюу буудлын тэмдэг дарна. Тээш ирсэн тухайд уг зорчигчид мэдэгдэх хаяг, утасны дугаар болон мэдэгдэх арга байдлыг тодруулж авна;

4.9.4. тээш хүргэх хугацааг эзэн нь зорчиж буй тээшийн вагон бүхий галт тэрэгний эсвэл зорчигчийн хүссэн ёсоор тээшийг илгээсэн галт тэрэгний замд явах хугацаагаар тус тус тодорхойлно. Тээшийг шилжүүлэн ачилт бүхий чиглэлээр явуулсан тохиолдолд түүнийг хүргэх хугацааг тээшийн вагон буюу зорчигчийн галт тэрэгний цагийн хуваарьт заасан хугацаан дээр шилжүүлэн ачилт бүрт тус бүр нэг хоног нэмж тодорхойлоно;

4.9.5. тээш ирсэн тухай мэдэгдлийг тээш хүлээн авагчид тухайн өдөр нь хаягийн дагуу харилцаа холбооны хэрэгсэлээр мэдэгдэн баримтжуулан тэмдэглэгээ хийж тээш хүлээн авагчид мэдэгдэнэ. Хүлээн авагчтай холбогдож чадаагүй нөхцөлд тээш илгээгчид утсаар мэдэгдэнэ. Мэдэгдлийн үйлчилгээний хөлсийг хүлээн авагч төлнө.

4.10. Тээшийн гэмтэл:

4.10.1. хүлээн авагч тээшийн тоо ширхэг, жин дутсан эсхүл сав, баглаа, боодол нь эвдэрсэн байхад хүлээн авахыг зөвшөөрвөл тээшийг олгож, дагалдах бичгийг тээшийн пүүлэгчид өгөх ба замын хүснэгтийн ард "өөрөө авахыг хүсэв" гэж тэмдэглэл хийж хүлээн авагчаар гарын үсэг зуруулна. Бусад тохиолдолд дутагдал, эвдрэлийн тухай түүний овог нэр, хаяг, үнэ зарласан байвал үнийн дүн зэргийг тусгасан ерөнхий маягтын дагуу акт тогтоох ба тээврийн акт үйлдэн хуулбарыг түүнд өгнө;



4.10.2. тээшийн дутагдал төмөр замын байгууллагын буруугаас болсон бол хохирлыг тээш тус бүрийн зарласан үнийн дагуу, хэрэв зарласан нэг үнэтэй байвал дутсан тээшийн жинтэй шууд /пропорциональ/ хамаарлаар, хэрэв зорчигч тээшиндээ үнэ зарлаагүй бол дутагдсан хүндийн хэмжээгээр хохирлыг 1.0 кг тутмыг 5000 төгрөгөөр бодож төмөр замын байгууллага нөхөн төлнө;

4.10.3. тээш алга болсонд тооцогдож, эзэнд нь нөхөн төлбөр төлсний дараа уг тээш чанар, хэмжээ алдагдаагүй олдвол нөхөн төлбөр, үйлчилгээний хөлсийг суутгаж, тээшийг эзэнд нь хүлээлгэн өгнө.

4.11. Тээш болон тээшийн тасалбарыг үрэгдүүлэх:

4.11.1. зорчигч энэхүү журмын 4.9.4-д заасан тээш хүргэх хугацаа өнгөрснөөс хойш 21 хоногийн дотор уул өртөөнд тээш ирээгүй бол /эрх бүхий байгууллагын шийдвэрээр тээшийг саатуулснаас бусад тохиолдолд/ хохиролоо нөхөн төлүүлэх шаардлагаа бичгээр гаргах эрхтэй. Хохирлыг энэхүү журмын 4.10.2-т заасны дагуу эзэнд нь төлж холбогдох бичиг баримтыг бүрдүүлнэ;

4.11.2. зорчигч тээшийн дагалдах бичгээ үрэгдүүлсэн тохиолдолд түүний бичгэн мэдүүлэг болон бусад холбогдох бичиг баримтыг үндэслэн уг тээш тухайн зорчигчийнх мөн болохыг нотлох баталгааг гаргуулж тээшийг олгож болно. Өртөө, буудлын холбогдох ажилтан нь дагалдах бичиггүйгээр тээш олгосон шалтгааны талаар тээшийн замын хүснэгтэд тэмдэглэл хийж үлдээнэ.


4.12. Тээшийг дахин илгээх:

4.12.1. тээш нь тээшийн замын хүснэгтээс салж тээвэрлэгдсэн, тээврийн бичиг баримтанд заагдсанаас өөр өртөөнд хүргэгдсэн ба тээш нь зорчигчийн хамт хүрэх өртөөнд ирээгүй, түүний хүрэх хугацаа өнгөрсөн тохиолдолд уг зөрчлийг илрүүлсэн өртөө нь энэ тухай бүх өртөөнд болон зорчигч тээврийн асуудал эрхэлсэн төмөр замын байгууллагад мэдэгдэнэ. Зорчигч тээврийн асуудал эрхэлсэн төмөр замын байгууллага эрэл хийх ба тээш олдсон тохиолдолд тухайн өртөөнд дахин илгээлт хийх шийдвэр гаргана. Шийдвэр авсан өртөө ба буудлын дарга тээшийн дагалдах бичиг болон замын хүснэгтийн ар талд "тээш зохих хугацаандаа ирээгүй учир тээшийг дахин илгээх тухай мэдэгдлийг хүлээн авлаа" гэсэн тэмдэглэл хийж он, сар, өдөртэй тэмдэг дарна;

4.12.2. дахин илгээсэн тээш өртөөнд ирмэгц өртөө ба буудлын даргын нэрийн өмнөөс тээшийн хүлээн авагчийн нэр дээр бичиг баримт /ачаа тээшээр/ үйлдэж илгээнэ. Тээшийн шинэчилсэн замын хүснэгтэд түүний анхны илгээлтийн дугаарыг заана;

4.12.3. дахин илгээсэн тээшийг замын шинэчилсэн хүснэгтээр явуулж, харин тээшийн дагалдах бичиг, дахин илгээх тухай мэдэгдэл зэргийг дагалдах бичгийн үлдэх хувьтай хавсарган тайлангийн хамт төмөр замын байгууллагын санхүүд явуулна;

4.12.4. тээш ирсэн ба түүнийг дахин илгээсэн тухай анх хүргэх ёстой байсан өртөө, дахин илгээсэн цаг, нөхөн хүргэх дагалдах бичгийн дугаар зэргийг заасан



бичгээр тээш хүлээн авагчид мэдэгдэнэ. Шинээр хүргэсэн өртөө нь уг тээшийг үнэгүйгээр олгох ба анх илгээсэн тээшийн дагалдах бичгийг тээш хүлээн авагчаас хурааж авна. Дээрхээс бусад тохиолдолд тээшийг дахин илгээж болохгүй.

4.13. Тээшийг хадгалах:

4.13.1. өртөөнд ирүүлсэн тээшийг ирсэн өдрөөс эхлэн тээш хүлээн авагчид олгох хүртэлх хугацаанд хадгалсны хөлсийг төмөр замын байгууллагын даргын баталсан үнэлгээний дагуу зорчигчоос авна.

4.14. Нэхэмжлээгүй тээшийг борлуулах:

4.14.1. зорчигч, байгууллага, аж ахуйн нэгж тээшээ 30 хоногийн дотор авахгүй бол төмөр замын байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагаас оролцуулсан комиссыг томилж, уг комисс тээшийг борлуулах арга хэмжээг авна. Тээшийг худалдан борлуулснаас хойш 6 сарын дотор тээш хүлээн авагч илэрч нэхэмжилбэл борлуулалтын орлогоос төмөр замын байгууллагын ажил, үйлчилгээний хөлсийг суутгаад үлдэх хэсгийг нэхэмжлэгчид тээшийн дагалдах бичгийг үндэслэн олгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

АЧААН ТЭЭШ ХҮЛЭЭН АВАХ БА ТЭЭВЭРЛЭХ НӨХЦӨЛ

5.1. Ачаан тээш хүлээн авах, тээвэрлэх:

Зөвлөмж: Ачаан тээш гэж илгээгчээс зорчих тасалбар шаардалгүйгээр захиалгын маягтыг бөглүүлж, хүлээн авсан энэхүү журмын 5.1.3-т заасан нөхцөлийг хангасан эд юмсыг хэлнэ.

5.1.1. ачаан тээшийн сав, баглаа, боодол нь тэдгээрийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн нөхцөлийг хангасан байна;

5.1.2. ачаан тээш тээвэрлэхэд нээлттэй өртөөдөд ачаан тээш хүлээн авах, явуулах, олгох үйл ажиллагаа хийгдэнэ;

5.1.3. нэг ачаан тээшийн хүндийн жин нь 10 кг-аас бага, 100 кг-аас их байж болохгүй, тээш ачих буулгах техник хэрэгсэлтэй өртөөнд нэг ачаан тээшийн хүндийн жин 75 кг-аас 165 кг хүртэл байж болно. Гурван хэмжээсийн нийлбэр нь 500 см-ээс ихгүй, ачааг ачаан тээш тээвэрлэлтийн тарифаар тооцно;

5.1.4. дараахь ачаан тээшийг эхний ээлжид тээвэрлэнэ:

- сонин, бусад өдөр тутмын тогтмол хэвлэл;
- түргэн гэмтэж, муудах бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн;
- зөвшөөрөгдсөн гэрийн тэжээвэр амьтан, шувуу;
- гэрийн эд хогшил /замдаа шилжүүлэн ачилттай хүлээн авч болно/;
- шарил.



5.1.5. түргэн муудах хүнсний бүх төрлийн бүтээгдэхүүнийг тээшийн вагонд тээвэрлэхээр хүлээн авахдаа түүнийг тээвэрлэх хугацаа, зайг гэмтэж муудахгүй тээвэрлэгдэх боломжтой эсэхийг тооцож хүлээн авна. Жилийн дулааны болон хүйтний улирлыг дараахь байдлаар тооцно. 5 дугаар сарын 01-ээс 9 дүгээр сарын 30-ыг дуусталх хугацааг дулааны, 10 дугаар сарын 01-нээс 4 дүгээр сарын 30-ыг дуусталх хугацааг хүйтний улирал гэнэ;

5.1.6. дулааны улиралд ирсэн ачаан тээшийг төмөр замын байгууллага 6 цагаас дээш хадгалахгүй;

5.1.7. түргэн гэмтэж, муудах ачааг ачаан тээшээр тээвэрлэхэд галт тэрэг хөдлөхөөс 2 цагийн өмнө хүлээн авна;

5.1.8. хаяг нь тодорхой нөхцөлд түргэн гэмтэж, муудах ачааг тогтоосон хугацаанд нь авахыг хүлээн авагчид мэдэгдэх арга хэмжээг өртөө ба буудал мөн ачаа илгээгч аль аль тал нь хариуцна;

5.1.9. түргэн гэмтэж, муудах ачаан тээш нь гэрээт хугацаанд хүргэгдсэн боловч төмөр замаас үл хамаарах шалтгаанаар шинж чанар муудсан тохиолдолд тээвэрлэгч гэм буруугүй болохоо нотолж, хариуцлагаас чөлөөлөгдөнө;

5.1.10 тээвэрлэлтэд хүлээж авсан ачаан тээш нь гадна үзлэгээр ямар нэгэн гэмтэл учраагүй, анхааруулах тэмдэггүй мөртлөө дотор нь хялбар муудах зүйлс /мах, сүү, ногоо, жимс г.м./ хагарч эвдрэх хэврэг ачаа /шил, шаазан эдлэл, телевизор г.м./ нь гэмтсэн байвал уг хохирлыг төмөр зам тээвэрлэгч хариуцахгүй.

5.2. Тээвэрлэлтэд хүлээн авах:

5.2.1 төмөр замын байгууллага ачаан тээшийн сав, баглаа, боодол тээвэрлэлтийн шаардлага хангасан эсэхийг шалгасны дараа ачаа илгээгч захиалгын маягтыг зааврын дагуу бөглөж, захиалгыг эрх бүхий ажилтанд өгнө:

- сав, баглаа, боодлын тоо, төрөл, хүндийн жин;
- ачааны нэр, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тэмдэг, тэмдэглэгээ;
- илгээсэн өртөө, огноо;
- хүргэх өртөө, огноо;
- зарласан үнэ;
- тухайн барааг худалдан авсан үнэ;
- илгээгчийн овог нэр, хаяг, регистрийн дугаар;
- хүлээн авагчийн овог нэр, хаяг, харилцаа холбооны хэрэгсэл, регистрийн дугаар;
- хуульд заасан бусад нөхцөл.



5.2.2. ачаан тээшийг ачаан тээшийн сав баглаа, боодлыг шалган, зөвшөөрөгдсөн ачаан тээш мөн эсэхийг тогтоож, илгээгчээр захиалгын маягтын үнийг төлүүлнэ.

5.2.3. захиалгыг үндэслэн тээвэрлэлтийн бичиг баримт үйлдэнэ. Тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан ачаан тээшийг явуулах огноо, цаг минут, галт тэргийг тогтоосны дараа ачаан тээшийг тээвэрлэлтэд хүлээн авч, төлбөр төлсөн дагалдах бичгийг ачаан тээш илгээгчид олгоно;

5.2.4. ачаан тээшийн нэр зөв эсэх талаар эргэлзээ гарсан тохиолдолд төмөр замын байгууллага ачааны сав, баглаа, боодлыг задлах шаардлага тавих эрхтэй. Ачаа тээшийг задалж үзэхийг илгээгч эс зөвшөөрвөл түүнийг тээвэрлэлтэд хүлээж авахгүй;

5.2.5. илгээгч нь тогтоосон журмын дагуу ачаан тээшиндээ заавал үнэ зарлана. Тээврийн хөлс ба үнэ зарласан хураамжийг тарифт заагдсаны дагуу төлнө;

5.2.6. ачаан тээшийг замаас дахин илгээх болон замд тавьж олгохыг зөвшөөрөхгүй;

5.2.7. ачаан тээшийг тухайн зорчигчийн явах галт тэрэгний тээшийн вагоноор явуулах боломжгүй /багтаагүй зэрэг бусад шалтгаанаар/ тохиолдолд тухайн чиглэлийн дараагийн галт тэргээр явуулж болно;

5.2.8. зорчигч ачаан тээшиндээ үнэ зарлахаас татгалзвал эсвэл зорчигчийн үнэ зарласан байдал барааны нэр төрөл, тоо ширхэг нь бодит үнэтэй тохирохгүй байвал явуулах өртөө ачаан тээшийг тээвэрлэлтэд хүлээн авахаас татгалзана;

5.2.9. тээш, ачаан тээшийн агуулах, тээшийн үйлчилгээ үзүүлэх ажилтангүй боловч тээш ачаан тээш ачих боломжтой жижиг өртөө, зөрлөгүүдээс явуулж буй ачаан тээшийг тээшийн вагонд ажиллах тээш түгээгч хүлээн авах ба үнэ зарлалт ачилт, шилжүүлэн ачилт, буулгалт зэрэг нэмэгдэл хураамжийг илгээгч хариуцна.

5.3. Ачаан тээшийг тавьж олгох:

5.3.1. ачаан тээш ирсэн өртөөнд тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан ачаан тээш харилцаа холбооны хэрэгслээр мэдэгдэж баримтжуулан тэмдэглэгээ хийж хүлээн авагчтай холбогдож чадаагүй тохиолдолд илгээгчид мэдэгдэнэ. Мэдэгдэх үйлчилгээ үзүүлсэн хөлсийг хүлээн авагчаас авна;

5.3.2. албан байгууллага, компанийн нэр дээр ирсэн ачаан тээшийг хүлээн авах этгээд нь уул байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэг, тэмдэг бүхий итгэмжлэлийг иргэний үнэмлэх эсвэл бусад биеийн байцаалтын хамт шалгуулан замын хүснэгтийн ар талд гарын үсэг зурж, ачаан тээшийг хүлээн авна. Ачаан тээш хүлээн авагчаас итгэмжлэлийг авч үлдэнэ. Тодорхой хүний хаягаар ирсэн ачаан тээшийг хүлээн авагчид эсвэл түүний итгэмжилсэн этгээдэд иргэний үнэмлэх эсвэл бусад нотлох баримтыг үзэж олгох ба замын хүснэгтийн ар талд тэмдэглэл хийж гарын үсэг авна. Ачаан тээш байнга ирдэг байгууллагын хүлээн авагч байнгын итгэмжлэх бичигтэй байх шаардлагатай ба түүгээр ачаан тээшийг олгоно;



5.4. Ачаан тээшийг хадгалах, цэгцлэх:

5.4.1. ачаан тээшийн жинг шалгасны үнийг төмөр замын байгууллагын даргын тогтоосон тарифын дагуу ачаа илгээгч эсвэл ачаа хүлээн авагчаас авна;

5.4.2. ачаан тээшийн өртөөнд хадгалсан хөлсийг тээвэрлэн ирсэн өдрөөс хүлээлгэн өгсөн өдөр хүртэлх хугацаагаар тооцож, тогтоосон тарифын дагуу төлүүлнэ;

5.4.3. ачаан тээшээ 30 хоногийн дотор аваагүй бол төмөр замын байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагаас оролцуулсан комиссыг томилж, уг комисс ачаан тээшийг борлуулах шийдвэр гаргаж зохион байгуулна;

5.4.4. төмөр замын байгууллагын буруугаас ачаан тээш үрэгдэх, дутах мөн түүнчлэн хүргэх хугацаа хожимдуулсны хариуцлагыг энэ журмын дагуу төмөр замын байгууллага хүлээнэ. Ачаан тээш алга болсон тохиолдолд хохирлыг зарласан үнийн хэмжээгээр төлнө.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ


ТЭЭВЭРЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

6.1. Тээвэрлэлтэд хяналт тавих:

6.1.1. төмөр замын тээврийн аюулгүй байдал, тээвэрлэлттэй холбоотой ажил, үйлчилгээний чанар хууль тогтоомж, стандартын шаардлагад хангаж буй эсэхэд Төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч болон дотоодын хяналтын байцаагч хяналт тавина. Хяналтын байцаагч нь доорх зүйлийг шалгана:

- зорчигчийн зорчих тасалбар;
- галт тэрэгний дарга, мастер, вагоны үйлчлэгчийн гүйцэтгэх үүргийн биелэлт;
- зорчигчийн гар тээш энэ дүрмээр тогтоосон тоо, хэмжээнд байгаа эсэх;
- зорчих ба тээшийн дагалдах бичиг зохих ёсоор үйлдэгдсэн эсэх;
- зорчих тасалбар худалдах газрын үйл ажиллагаа, зохион байгуулалт;
- вагоны сул чөлөөтэй байрыг хэрхэн зохицуулсан, түүний тухай мэдээг дараагийн өртөөнд дамжуулсан эсэх;
- албаны, түрээсийн болон бусад албан байгууллагуудын вагоныг зориулалтын ажилд хэрэглэж байгаа эсэх.

6.1.2. хяналт тавих эрх бүхий этгээд нь өртөө, буудал ба галт тэргэнд тасалбар худалдах ажлын зохион байгуулалт, зорчигчдын үйлчилгээнд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна;



6.1.3. төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч болон төмөр замын байгууллагын эрх бүхий албан тушаалтан галт тэргэнд шалгалт хийх эрхтэй;

6.1.4. шалгалтын үед зорчих тасалбаргүй эсвэл хөнгөлөлттэй тасалбараар зорчиж буй зорчигчийн насны хязгаарт эргэлзвэл холбогдох бичиг баримтыг шалгаж, үнэн зөвийг тогтоох шаардлагатай.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТАРИФ БА НЭМЭГДЛИЙН ТӨРӨЛ

7.1. Зорчигч тээвэрлэлтийн тариф, нэмэгдэл:

7.1.1. тээвэрлэлтийн шууд ба орон нутгийн харилцааны бүх төрлийн галт тэргээр зорчих нийтийн тариф зорчигчдод үйлчилнэ;

7.1.2. зорчигч тээврийн хөлсийг зохих тарифын үнэлгээ ба түүний жинхэнэ зайгаар тооцно. Тарифын зайг тухайн зорчигч явах зорчигчийн галт тэрэгний чиглэлийн дагуу бодно;

7.1.3. тээвэрлэлтийн тарифын зай болон өртөөний гүйцэтгэх үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын баталсан тарифын бодлогоор тодорхойлно;

7.1.4. зорчигчийн галт тэргэнд зорчих тасалбарын үнэ нь төмөр замын байгууллагын даргын баталсан орон нутгийн харилцааны зорчигч тээврийн тарифаар тодорхойлогдох ба бусад ажил, үйлчилгээний үнэлгээг тухайн төмөр замын байгууллага тусад нь тогтооно;

7.1.5. хөнгөлөлттэй /5-12 хүртэлх насны хүүхэд/ зорчих тасалбарыг орон нутгийн харилцааны зорчигч тээврийн тарифын вагоны төрлөөс хамаарсан зохих баганад заасан тарифаар бичнэ;

7.1.6. хүн суух зориулалтаар тоногдсон ачааны вагонд зорчигчдыг тээвэрлэхэд нийтийн вагоны тарифыг 50 хувиар хямдруулан хэрэглэнэ.


7.2. Зорчигчийн даатгалын хураамж:

7.2.1. зорчигчоос гэнэтийн ослын даатгалын хураамжийг төмөр зам байгууллагаас даатгалын компанитай байгуулсан гэрээнд заасан хэмжээгээр хураана.

7.3. Зорчих тасалбаргүй аялах:

7.3.1. зорчих тасалбар худалдах газартай өртөөнөөс тасалбаргүйгээр эсхүл зөрчилтэй тасалбараар зорчиж байгаа зорчигч үнэ төлбөргүй авч орсон тээшинд нэмэгдэлтэй тарифаар галт тэргэнд тасалбар бичнэ. Нэмэгдлийн хэмжээг төмөр замын байгууллагын дарга тогтооно.

7.4. Унтлагын байрны нэмэгдэл:



7.4.1. унтлагын байртай вагонд зорчигч нь тээврийн хөлснөөс гадна унтлагын байр ашигласны нэмэгдэл хөлсийг тогтоосон тарифын дагуу төлнө;

7.4.2. энэхүү журмын 2.8.6-д зааснаас бусад тохиолдолд унтлагын байртай вагонд байр эзэлж зорчих 5-12 хүртэлх насны хүүхэд насанд хүрсэн хүний нэгэн адил нэмэгдэл хөлс төлнө.

7.5. Тасалгааны нэмэгдэл:

7.5.1. тасалгаат унтлагын вагонд зорчих зорчигч нь тээврийн хөлс ба унтлагын байрны нэмэгдэл, тасалгаа эзэмшсэний нэмэгдлийг тус тус төлнө;

7.5.2. тасалгаатай вагонд 5-12 хүртэлх насны хүүхэд тусдаа унтлагын байр эзэлж зорчиход насанд хүрсэн хүний нэгэн адил тасалгааны нэмэгдэл төлнө. 5-12 хүртэлх насны хүүхэд тусдаа унтлагын байр эзлэлгүй насанд хүрсэн хүний хамт нэг байранд зорчих тохиолдолд тасалгааны нэмэгдэл төлөхгүй.

7.6. Хурдны нэмэгдэл:

7.6.1. хурдан галт тэргээр зорчих зорчигч нь зорчих тасалбарын хөлснөөс гадна хурдны нэмэгдэл төлнө.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ТЭЭШ, АЧААН ТЭЭШ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТАРИФ БА НЭМЭГДЛИЙН ТӨРӨЛ

8.1. Тээш, ачаан тээш тээвэрлэлтийн тариф, нэмэгдэл:

8.1.1. нийтийн тээш тээвэрлэлтийн тариф нь байнгын ашиглалттай, тээш тээвэрлэлтэд нээлттэй төмөр замын бүх шугамд хэрэглэгдэнэ.

8.1.2. тээшийн вагонд тээш, ачаан тээш тээвэрлэхэд төмөр замын байгууллагын даргын баталсан тариф, нэмэгдлийг мөрдөнө.

8.2. Тээш тээвэрлэлтийн хөлс төлөх:

8.2.1. тээшийн тооцооны хамгийн бага хүндийн жинг 10 кг-аар тогтоох ба түүнээс дээших 5 кг тутамд тогтоосон тарифаар төлбөр хураана. Үечилсэн хэмжилтийн 5 кг-д хүрэхгүй тээшийг бүхэлдэж 5 кг-аар тооцно. Тээшийн тасалбарын үнийг тогтоож авна;

8.2.2. тээшийн вагоноор тээвэрлүүлэх тээшийн хүндийн жинг түүний төрөл, сав, баглаа, боодлыг үл харгалзан зөвхөн жинхэнэ хүндийн жингийн хэмжээгээр нь тооцож тээврийн хөлсийг авна.

8.3. Ачаан тээш тээвэрлэлтийн хөлс төлөх:

8.3.1. ачаан тээш тээвэрлэлтийн тарифын зайг зорчигчийн тээш тээвэрлэлтийн зайг тооцохтой нэгэн адилаар зорчигчийн галт тэрэгний аяллын чиглэлээр эрх бүхий байгууллагын баталсан тарифын бодлогоор тодорхойлно;



8.3.2. ачаан тээшийн тооцооны хамгийн бага хүндийн жинг 20 кг-аар тогтоох ба түүнээс дээших 5 кг тутамд тогтоосон тарифаар төлбөр хураана. Үечилсэн хэмжилтийн 5 кг-д хүрэхгүй тээшийг бүхэлдэж 5 кг-аар тооцно.

8.4. Үнэ зарласан төлбөр:

8.4.1. тээш болон ачаан тээшийн зарласан үнийн хэмжээнд тохируулан төмөр замын байгууллагын даргын тогтоосон үнэ зарласны төлбөрийг тээш, ачаан тээш илгээгчээс авна.

8.5. Тээш, ачаан тээшийн цэгцлэлтийн төлбөр:

8.5.1. тээш, ачаан тээш илгээгчид захиалгын маягт олгох ба пайз, наадас олгосны төлбөрийг авна.

8.6. Ачаан тээш ирсэн тухай мэдэгдэх:

8.6.1. ачаан тээш ирсэн тухай хүлээн авагчид холбооны хэрэгслээр мэдэгдэж баримтжуулан тэмдэглэгээ хийж төлбөрийг ачаа хүлээн авагчаас авна.

8.7. Бичгэн магадлагаа:

8.7.1. лавлах бичгэн магадлагаа олгохдоо байгууллагын нэр, хаяг, тэмдэг болон эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, лавлагаа олгосон огноо, дугаарыг тодорхой заасан байх ба үйлчлүүлэгчээс зохих төлбөрийг авна.

8.8. Ачаа зөөгч ажиллуулсны төлбөр:

8.8.1. зорчигчийн гар тээш, тээшийг буудлын дэргэдэх нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, хүлээлгийн танхим зэрэгт хүргэх зөөгч ажиллуулсны төлбөрийг тогтоосон тарифын дагуу авна.

8.9. Бусад үйлчилгээний төлбөр

8.9.1. дамжин өнгөрөх зорчигчийг буудалд байрлуулах, халуун ус болон бусад үйлчилгээгээр үйлчилсний төлбөрийг авна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ


БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

9.1. Цагаан хэрэглэлийн төлбөр:

9.1.1. зорчигчийн галт тэргээр зорчсон зорчигчид тавьж өгсөн цагаан хэрэглэлийн төлбөрийг авна.

9.2. Гар тээш хадгалсны төлбөр:

9.2.1. зорчигч эд юмсаа өртөө, буудлын гар тээш хадгалах байранд болон автомат хадгаламжид хадгалуулсны төлбөрийг төлнө;



9.2.2. үнэ зарласан гар тээш, мөн түүнчлэн олдсон эд юмсыг хадгалсаны төлбөрийг тухайн эд юмсын эзэмшигч төлнө.

9.3. Зорчих тасалбарыг урьдчилан захиалсаны төлбөр:

9.3.1. зорчих тасалбарын урьдчилсан захиалгад үнийн хөнгөлөлт үзүүлэх, нэмэлт хөлс авах эсэхийг төмөр замын байгууллага тогтооно.

9.4. Зорчих тасалбар хүргэсний хөлс

9.4.1. зорчигчийн зорчих тасалбарыг гэрт нь хүргэж өгөх үйлчилгээний төлбөрийг тогтоосон тарифын дагуу авна.

АРАВДУГААР БҮЛЭГ

ЗАРИМ ЗОРЧИГЧИЙГ ТЭЭВЭРЛЭХ ОНЦГОЙ НӨХЦӨЛ

10.1. Зарим зорчигчийг тээвэрлэх онцгой нөхцөл:

10.1.1. ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, олон улсын чанартай уралдаан тэмцээн, аялал жуулчлал болон бусад арга хэмжээнд зохион байгуулалттайгаар хэсэг бүлгээр олон улсын зорчигчийн галт тэргээр зорчиход хөнгөлөлт үзүүлж болно. Хөнгөлөх хэмжээг төмөр замын байгууллага тогтооно;

10.1.2. ерөнхий боловсролын сургуулийн сурагчид улсын чанартай уралдаан тэмцээнд оролцох, аялал болон хүүхдийн зусланд амрахаар орон нутгийн зорчигчийн галт тэргээр зорчиход нийтийн вагоны тасалбарын үнийн дүнгээс хөнгөлөлт үзүүлж болно. Хөнгөлөх хэмжээг төмөр замын байгууллага тогтооно;

10.1.3. өртөө, буудлын дарга хүссэн байрыг галт тэрэг явахаас нэг хоногийн өмнө олгоно. Захиалгат байрыг галт тэрэг явах цагаас 1 цаг 30 минутын өмнө хүртэл хадгална. Захиалгат нэр, албан байгууллагын хаягийг заасан байна;

10.1.4. нийтээр амрах баяр болон оюутан, сурагчдын улирлын амралтын үеэр зохион байгуулалттайгаар хэсэг бүлгээр зорчих тохиолдолд төмөр замын байгууллагын шийдвэрээр зорчих тасалбарын үнийг хямдруулж болно;


10.1.5. энэ хөнгөлөлт нь гадаадын жуулчин, аялагчид хамаарахгүй.

10.2. Жуулчдыг тээвэрлэх:

10.2.1. гадаад болон дотоодын жуулчид монгол орноор аялал жуулчлалаар явах тохиолдолд шууд ба орон нутгийн харилцааны вагонд зорчихдоо тасалбар худалдах газарт урьдчилсан захиалга өгч үйлчлүүлнэ;

10.2.2. олон улсын галт тэргээр зорчих жуулчид төмөр замын олон улсын тасалбар худалдах газарт урьдчилан захиалга өгч үйлчлүүлнэ;

10.2.3. захиалгат жуулчдын зорчих тасалбар, түүний үнэ нь дотоодын болон олон улсын гэсэн ялгавартайгаар тогтоосон үнэ ба журмын дагуу гүйцэтгэгдэнэ;



10.2.4. гадаадын аялагч, жуулчид, тэдний тээш, ачаан тээшийг орон нутгийн галт тэргээр /тусгай захиалгат вагонд/ тээвэрлэхэд тээврийн хөлсийг нь төмөр замын олон улсын суудлын тарифт зарласан хэмжээг аялах зайд дүйцүүлэн тооцож авна;

10.2.5. төлбөрийг төгрөгөөр хийх нөхцөлд тухайн үеийн Монгол банкны албан ёсны ханшаар тооцож авна;

10.2.6. олон улсын байгууллага, гадаадын жуулчдын хэрэгцээнд вагон түрээслэх бол төмөр замын байгууллагын баталсан үнэ тарифаар тооцно;

10.2.7. төмөр замаар тээвэрлэх шууданг тусгай гэрээг үндэслэн гүйцэтгэж тээврийн төлбөрийг гэрээнд тусгагдсанаар авна;

10.2.8. шуудангийн вагонд шуудангаас бусад ачааг төмөр замын бичиг баримтгүйгээр ачсан байвал тээврийн бүх зардлыг ачаан тээшийн тарифаар тооцох бөгөөд гэрээт байгууллага төлбөрийг төмөр замын байгууллагад төлнө.

10.3. Буфет ба вагон-ресторан явуулах:

10.3.1. зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд залгах вагон-ресторан, буфетийн ажиллах нөхцөл, тэдгээрийн ажилтны зорчих тухай харилцааг гэрээгээр зохицуулна.

10.4. Ачаатай вагон тээвэрлэх:

10.4.1. зорчигчийн галт тэргэнд ачааны вагон залгаж тээш, ачаан тээш тээвэрлэх тохиолдолд тээш, ачаан тээш тээвэрлэх тарифт үнэлгээгээр зохицуулна.

10.5. Шарил тээвэрлэх:

10.5.1. авсалсан шарилыг ачааны болон зорчигчийн галт тэргээр тусад нь вагонд тээвэрлэж болох бөгөөд шарил тээвэрлүүлэгч засаг захиргаа ба эмнэлгийн байгууллагын зөвшөөрөл, магадлагааг явуулах өртөөнд үзүүлнэ. Дээрх бичиг баримт нь тээврийн бичиг баримтын хамтаар очих өртөөн дэх хүлээн авагчид очно. Шарилыг сайн гагнасан төмөр авсанд буюу давирхайдсан модон хайрцагт хийж доторх хоосон зайг дүүргэх материал /үртэс, нүүрс, хүхэр, шохой зэрэг/-аар чигжсэнийг шалган хүлээн авч тээвэрлэнэ;

10.5.2. тээшийн ба шуудангийн вагоноор шарилыг тээвэрлэвэл тээвэрлэх зардлыг ачаан тээшийн тарифын үнэлгээ, 300 кг-аар тооцож төлбөрийг авна;

10.5.3. тээшийн ба шуудангийн вагоноор чандар тээвэрлэх тохиолдолд ачаан тээшийн тарифын үнэлгээ, 100 кг-аар тооцож, төлбөрийг авна;

10.5.4. шарилыг дагалдаж хүн заавал явна. Дагалдагч нь ямар нэг шалтгаанаар галт тэрэгнээс хоцорвол шарилыг саатуулах шалтгаан болохгүй. Дагалдагч нь бусад зорчигчийн нэгэн адил зорчих тасалбар худалдан авч зорчино.

10.6. Албан тээвэрлэлт:



10.6.1. зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд албаны вагон холбох захиалгыг албан бичгээр авч, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр гүйцэтгэнэ;

10.6.2. зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн дэх албаны вагоноор зорчигчид зорчих тасалбартай байхаас гадна тээштэй бол холбогдох бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Албаны вагонд ачаа тээвэрлэх асуудлыг төмөр замын байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэх бөгөөд ачаанд ачаан тээшийн тарифаар төлбөрийг төлнө;

10.6.3. тээвэрлэгчээс тогтоосон албаны вагонд зорчихтой холбогдсон журам зөрчвөл шалгагч нь илэрсэн зөрчилд акт үйлдэнэ. Акт /протокол/-ыг төмөр замын байгууллагын санхүүгээр дамжуулан төмөр замын байгууллагын дарга ба албаны вагон захиалан авсан байгууллагын харьяалах газарт явуулна.

10.7. Хувийн эзэмшлийн вагоноор зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх:

10.7.1. зорчигчийн ба ачааны галт тэрэгний бүрэлдэхүүнд хувийн эзэмшлийн вагон явах тохиолдолд төмөр замын байгууллага вагоны эзэмшигчтэй гэрээ байгуулна;

10.7.2. хувийн эзэмшлийн вагоныг ачааны, зорчигчийн ба хурдан галт тэргэнд залгасан байдлаар вагоны гүйлтийн төлбөрийг ялгавартай тогтооно;

10.7.3. хувийн эзэмшлийн вагоныг тусгай зүтгүүрээр эсвэл вагоныг дагалдсан нэмэгдэл зүтгүүртэй явуулах тохиолдолд зүтгүүрийн гүйцэтгэсэн гол км-ээр төлбөрийг тогтоож авна.

10.8. Түрээсийн вагонд зорчих:

10.8.1. зорчигчийн вагоныг түрээсээр ашиглуулах тохиолдолд түрээслэгчтэй вагон түрээслэх гэрээ байгуулж мөрдөнө;

10.8.2. вагон түрээслэх үнэлгээ, зорчигчийн болон тээшийн вагоны км тутамд ногдох гүйлтийн тарифыг төмөр замын байгууллагын даргын тушаалаар баталж мөрдөнө;

10.8.3. түрээслэгчийн хүсэлтээр тусгай зүтгүүрээр түрээсийн вагоныг тээвэрлэх тохиолдолд төмөр замын байгууллагын даргын баталсан 1 зүтгүүр км-ийн үнэлгээг тээвэрлэлтийн зайд тохируулан тооцож нэмж төлнө;

10.8.4. түрээслэгчийн хүсэлтээр түрээсийн вагоныг хурдан галт тэргэнд холбосон тохиолдолд тээврийн хөлсийг тодорхой хувиар нэмэгдүүлэн тооцно;

10.8.5. түрээсийн вагон хоногийг түрээслэх вагоныг аялалд бэлдсэн хугацаа, аяллын хугацаа, вагоныг төмөр замд буцаан хүлээлгэж өгөх бэлтгэл ажлын хугацааны нийлбэрээр тодорхойлогдоно. Бүтэн хоног хүрэхгүй хугацааг бүтэн хоногоор тооцон авна.

10.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх:





10.9.1 тээвэрлэгч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээ, аялал хийх боломж, төмөр замын буудал, зорчигчийн тавцан болон хөдлөх бүрэлдэхүүн рүү хэрхэн нэвтрэх, зорчих зэрэг мэдээллээр хангана;

10.9.2. тээвэрлэгч эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь нэмэлт төлбөргүйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төмөр замын буудал, зорчигчийн тавцан болон хөдлөх бүрэлдэхүүн рүү нэвтрэх, зорчиход нь туслах үйлчилгээ үзүүлнэ;

10.9.3. тээвэрлэгч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тасалбар урьдчилан захиалах болон худалдах үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүй нөхцөлтэйгээр үзүүлнэ;

10.9.4 төмөр замын буудал, зорчигчийн тавцан, хөдлөх бүрэлдэхүүн рүү нэвтрэх тусламж шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь товлосон аялалын талаар тухайн аялал эхлэхээс 48 доошгүй цагийн өмнө тээвэрлэгчид мэдэгдэнэ. Энэхүү хугацааг мөрдөөгүй тохиолдолд тээвэрлэгч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний тээвэрлэлтийг зохион байгуулах бүх боломжит арга хэмжээг авна;

10.9.5. тээвэрлэгч эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь явах өртөөндөө ирсэн тухайгаа мэдэгдэх болон өөрт шаардлагатай байгаа тусламжаа хэрхэн хүсэх арга хэргэслэлийг нь тогтоож өгнө;

10.9.6. тээвэрлэгч эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж үзүүлэх үед уг иргэн нь уулзахаар товолсон газарт хугацаандаа ирсэн байна;

10.9.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь гар тээшний тогтоосон жин хэмжээнээс хэтэрсэн өөрийн хөдөлгөөнд шаардлагатай төхөөрөмжийг өөртөө үнэ төлбөргүйгээр авч явах эрхтэй.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ


ЖУРАМ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

11.1. Тээвэрлэгч, зорчигчийн хүлээх эрх, үүрэг:

11.1.1. төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх журмыг үндэс болгон төмөр замын байгууллага нь зорчигчийн өмнө, зорчигч нь төмөр замын байгууллагын өмнө харилцан эрх эдэлж, үүрэг хүлээнэ;

а. төмөр замын ажилтнууд энэхүү журамд заасан хэм хэмжээг баримтлан эрх үүргээ шударгаар хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ;

б. энэхүү журамд заасан хэм хэмжээг зөрчсөн төмөр замын байгууллагын ажилтанд хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасанд тооцон хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулах ба энэ нь хуульд зааснаас бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй;



в. энэхүү журмаар зохицуулсан харилцаанд оролцогч гадны байгууллага, иргэд, зорчигчтой холбоотой зөрчил дутагдлыг энэ журам болон бусад хууль тогтоомжийн заалтын дагуу шийдвэрлэнэ.

11.2. Төмөр замын байгууллага зорчигчийг ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлж, зорьсон өртөөнд цаг хугацаанд нь хүргэх үүрэгтэй.

11.3. Төмөр замын байгууллага нь зорчигчийн тээш ба ачаан тээшийг хүлээж авснаас эхлэн олгох хүртэл тогтоосон журмын дагуу тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

11.4. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

11.5. Зорчигч тогтоосон хэмжээнээс илүү гар тээш тээвэрлэвэл тээшийн тарифаар тээврийн төлбөр авна.

11.6. Төмөр замын байгууллага тээш хүргэх хугацаа хожимдуулсны нөхөн төлбөрийг очих өртөөн дээр үйлдсэн актыг үндэслэн төлнө.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

12.1. Олон нийтийн хэв журам сахих:

12.1.1. зорчигч нь төмөр замын тээврийн хэрэгсэл болон буудлын эд хогшилд ариг гамтай хандан олон нийтийн хэв журмыг чанд сахиж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон төмөр замын байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмын талаар мэдээллийн самбар, орон нутгийн болон үндэсний шинжтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн дүрэм, журмыг биелүүлэх үүрэгтэй;

12.1.2. зорчигч энэхүү журмын 11.1.1-т заасныг зөрчсөн тохиолдолд галт тэрэгний ба буудлын дарга, цагдаагийн ажилтан асуудлыг шийдвэрлэнэ.

12.2. Маргааныг шийдвэрлэх:

12.2.1. албан үүргээ гүйцэтгэж буй төмөр замын ажилтан болон зорчигчийн хооронд гарсан маргаан, үл ойлголцлыг дараахь байдлаар шийдвэрлэнэ:

- өртөөн дээр бол өртөө буюу буудлын дарга, шаардлагатай бол цагдаагийн ажилтны тусламжтайгаар;
- галт тэрэгний аяллын явцад галт тэрэгний дарга, мастер эсвэл галт тэрэгний байцаагч, шаардлагатай тохиолдолд галт тэргэнд ажил үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн ажилтны оролцоотойгоор.

12.2.2. үйлчилгээтэй холбоотой тухайн нөхцөлд шийдвэрлэх боломжгүй асуудлыг харьяалах дээд шатны байгууллагад нь хандаж шийдвэрлүүлнэ.

12.3. Мартсан болон алдсан эд юмс:



12.3.1. төмөр замын зурвас газар буюу галт тэргэнд гээгдсэн эд юмс олдвол тухай бүрд нь түүний байдлыг тодорхойлж акт үйлдэнэ. Хэрэв эд юмс нь галт тэргэн дотроос олдсон бол тухайн вагоны үйлчлэгчийг байлцуулан галт тэрэгний дарга, өртөөн дээрээс олдсон бол өртөө ба буудлын дарга эд юмсыг олсон этгээдийг байлцуулан акт үйлдэж, цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ;


12.3.2. эд юмс нь өртөө буюу эргэлтийн өртөөнд ирсэн галт тэргэн дотроос эсвэл тус өртөөнд ирэх хоорондын замаас олдсон бол түүнийг тусгай дэвтэрт бүртгэж холбогдох ажилтан тэмдэглэл хөтөлж тээвэрлэгчийн эрх бүхий ажилтанд хүлээлгэн өгнө. Хүлээн авсан олдсон эд юмсад тэмдэглэл хөтөлж, дэс дугаар бүхий пайз зүүнэ. Олдсон эд юмс нь боодол, хайрцаг, шуудай, чемодан зэрэг тус тусдаа сав, баглаатай байвал тус бүрийг ломбодно;

12.3.3 зорчигчийн гээгдүүлсэн эд юмс /түргэн гэмтэж, муудах зүйлээс бусад/-ыг 30 хоног хадгалсны дараа холбогдох ажилтан тэмдэглэл хөтөлж борлуулна. Гээгдүүлсэн эд юмс дотор үнэт эдлэл болон үнэт цаас, бичиг баримт байвал түүнийг цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ;


12.3.4. гээгдсэн эд юмсыг авахаар нэхэмжлэгч этгээд нь эд юмсынхаа шинж чанар, хэлбэр, өнгө, дүрс, тоо ширхгийг тодорхой баримтаар өргөдөл хүсэлт гаргаж, мөн түүнчлэн онгойлгох түлхүүрийг үзүүлэх зэргээр нотлох ёстой. Гээгдсэн эд юмсын эзэн болох нь батлагдвал тэр этгээдэд хүлээлгэн өгнө. Гээгдсэн эд юмсыг холбогдох байгууллагад шилжүүлсэн байвал эзэнд нь олгох тухай мэдэгдлийг өртөө /буудал/-ний дарга бичгээр явуулна. Эзэн нь эд юмсаа авахдаа тээвэрлэлт, хадгалалт, зарлуулсан зэрэгт гарсан зардлыг төмөр замын байгууллагад төлөх ба өөрийн тодорхой хаяг, харилцаа холбооны хэрэгсэл, регистрийг тэмдэглүүлж, гарын үсэг үлдээнэ. Хадгалалт, тээвэрлэлтийн төлбөрийг тээшийн тарифаар тооцож авна;

12.3.5. зорчигч эд юмсаа вагонд орхисноо галт тэрэгнээс буусны дараа өөрөө мэдвэл тэр даруй өртөө ба буудлын даргад мэдэгдэх ёстой. Өртөө буюу буудлын дарга энэ тухай зорчигчийн бичгэн мэдэгдлийг үндэслэн галт тэрэгний дарга буюу эргэлтийн өртөө /буудал/-ний даргад уг зорчигч сууж явсан вагон, байрын дугаар, орхисон эд юмсын дүрс хэлбэр, хааш нь ирүүлэх зэргийг заасан цахилгаан явуулна. Уг эд юмсыг эзэнд нь хүргэж ирүүлэхтэй холбогдож гарсан бүх зардлыг эд юмсын эзэн хариуцан төлнө.

--- о О о ---



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 14 дүгээр сарын 28 ны өдрийн
264 дүгээр тушаалын долдугаар хавсралт



ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаанд үүсэх тээвэрлэгч, тээвэр зуучлагчийн хоорондын харилцааг Төмөр замын тээврийн тухай хууль, Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, багц дүрэм, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.2. Төмөр замын тээвэр зуучлагч /цаашид "тээвэр зуучлагч" гэх/ ба үйлчлүүлэгчийн хоорондын харилцааг Иргэний хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон тэдгээрийн хооронд байгуулсан тээвэр зуучлалын гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү журмаар зохицуулах хүрээнд хамаарахгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2.1. Төмөр замын тээвэр зуучлагч нь Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журамд заасны дагуу Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна.

2.2. Төмөр замын тээвэр зуучлагч нь үйлчлүүлэгчийг төлөөлж тээвэрлэгчтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу тээврийн гэрээ байгуулна.

2.3. Тээвэр зуучлагч нь тээвэрлэгч болон үйлчлүүлэгчийн хооронд дараахь үйлчилгээг үзүүлэхэд зуучилна.

2.3.1. зуучлалын даалгаврын дагуу тээврийн технологийн маршрут, схемийн эдийн засгийн үндэслэлийг зохиох;

2.3.2. вагон, чингэлэг захиалах, түрээслэх;

2.3.3. тээврийн бичиг баримт, түүнд дагалдах бичиг баримтуудыг бүрдүүлэх;

2.3.4. тээврийн хөлс, бусад холбогдох хөлс, хураамжийн тооцоог хийх;

2.3.5. ачааны даатгалтай холбоотой бичиг баримт бүрдүүлэлт, ачаа дутах, эвдэрч ирсэн тохиолдолд тогтоосон журмын дагуу тээврийн акт болон бусад акт тавихтай холбоотой бичиг баримтын бүрдүүлэлтэд оролцох;



- 2.3.6. төмөр замаар ачаа тээвэрлэх журамд заасны дагуу ачааны хаяг солих;
- 2.3.7. үйлчлүүлэгчид тээвэрлэлтийн явц, ачааны байршлын талаар мэдээлэл өгөх;
- 2.3.8. ачааны марклалд хяналт тавих, байгуулах тээврийн хэрэгсэл болон ачаа хадгалах агуулахыг ломбодох;

2.3.9. Бусад нэмэлт үйлчилгээ.

2.4. Тээвэр зуучлалын гэрээнд өөрөөр заагаагүй бол тээвэр зуучлагч нь үйлчлүүлэгчийн өмнөөс тээвэрлэлтийг зохион байгуулахад шаардлагатай тохиолдолд дараахь ажиллагааг гүйцэтгэнэ:

2.4.1. ачаа тээврийн захиалгыг тээвэрлэгчид өгөх, ачааг тээвэрлэх, хадгалах, тээврийн нэг төрлөөс нөгөө төрөлд шилжүүлэх болон тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай бусад асуудлыг тээвэрлэгчтэй тохиролцох;

2.4.2. тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай гаалийн болон бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

2.5. Тээвэр зуучлагч нь энэхүү журмын 2.3-т заасан төмөр замын тээвэр зуучлалын үйлчилгээг үзүүлэхдээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, MNS 5523:2013 стандарт, дүрэм журам, Монгол Улсын Олон улсын гэрээг мөрдөх ба аюулгүй, хурдан шуурхай үйлчлэх зарчмыг баримтална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТЭЭВЭРЛЭГЧ, ТЭЭВЭР ЗУУЧЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаанд үүсэх тээвэрлэгч, тээвэр зуучлагчийн эрх, үүргийг Төмөр замын тээврийн тухай хууль, Иргэний хууль, Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, багц дүрэм зэрэг холбогдох хууль, тогтоомж, олон улсын гэрээгээр зохицуулна.


ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТЭЭВЭРЛЭГЧ, ТЭЭВЭР ЗУУЧЛАГЧИЙН ХАРИУЦЛАГА


4.1. Тээвэрлэгч, тээвэр зуучлагч нь тээврийн гэрээ болон энэхүү журамд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүсэх хохирлыг Иргэний хууль болон Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, Төмөр замаар ачаа тээвэрлэх журам зэрэг холбогдох олон улсын гэрээ, хууль тогтоомжид заасны дагуу барагдуулна.

4.2. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 1-дүгээр сарын 24-ны өдрийн
264-дүгээр тушаалын наймдугаар хавсралт



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЗУРМАГ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Монгол Улсын хэмжээнд төмөр замын галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах, түүнд өөрчлөлт оруулах, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлд шинжилгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулахдаа зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлахгүй, аливаа этгээдэд давуу эрх олгохгүй, харилцан уялдаатай, нэгдмэл байх зарчмыг баримтална.

1.3. Энэхүү журамд хэрэглэсэн “галт тэрэгний хөдөлгөөний зурмаг” гэснийг “хөдөлгөөний нэгдсэн зурмаг”, “суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг” гэж тус тус ойлгох бөгөөд бусад нэр томьёо, тодорхойлолтыг Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төмөр замын техник ашиглалтын журам болон MNS 6387-1,2,3,4:2013 “Төмөр зам, замын, автоматик, телемеханикийн, хөдлөх бүрэлдэхүүний, тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томьёо, тодорхойлолт” стандартад заасан утгаар хэрэглэнэ.

1.4. Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг /цаашид “хөдөлгөөний нэгдсэн зурмаг” гэх/-ийг Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв /цаашид “Хөдөлгөөн зохицуулалтын төв” гэх/, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг тухайн суурь бүтэц эзэмшигч хөдөлгөөний нэгдсэн зурмагт нийцүүлэн тус тус боловсруулж, батална.


1.5. Хөдөлгөөний нэгдсэн зурмагийг Хөдөлгөөн зохицуулалтын төв, суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, иргэн дагаж мөрдөнө.

1.6. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь хөдөлгөөний нэгдсэн зурмаг боловсруулах, түүнд өөрчлөлт оруулах, хөдөлгөөний нэгдсэн зурмагийн хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд төрийн байгууллага болон олон нийтийг зохих мэдээллээр хангаж ажиллана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГ БОЛОВСРУУЛАХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах, түүнд өөрчлөлт оруулахад багц дүрэмд заасан болон дараахь шаардлага тавигдана.



2.1.1. галт тэрэгний хөдөлгөөний зурмаг нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр, Өрсөлдөөний тухай болон Төмөр замын тээврийн тухай хууль, багц дүрэм, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горим болон суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн хооронд байгуулсан тээвэрлэлтийн гэрээнд нийцсэн байх;

2.1.2. суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өндөр бүтээмжтэй, үр дүнтэй ашиглах, тэдгээрт засвар, үйлчилгээ, арчилгаа, хийх боломжоор хангасан байх;

2.1.3. төмөр замын тээврийг бусад төрлийн тээвэр болон хилийн боомтын үйл ажиллагаатай уялдуулсан байх;

2.1.4. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага болон иргэний санал, хүсэлтийг судлан, харгалзан үзсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГ БОЛОВСРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг боловсруулахад дараахь шаардлага тавигдана.

3.1.1. тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагт тусгуулах (тээвэрлэлт хийлгэх) саналаа Тээвэрлэгчдэд бичгээр гаргах бөгөөд дараахь материалыг хавсаргасан байна.

- тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт;
- суурь бүтэц ашиглах болон тээвэрлэлтийн гэрээ, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийн гэрээний хуулбар;
- иргэний үнэмлэхийн хуулбар /зөвхөн иргэнд хамаарна/;
- аж ахуйн нэгж, байгууллагын хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар байна.

3.1.2. тээвэрлэгч нь суурь бүтцийн хөдөлгөөний зурмагт тусгуулах тээвэрлэлтийн хэмжээний талаарх саналаа “Суурь бүтэц ашиглуулах журам” -ын гурав дугаар бүлэгт заасан дагуу хүргүүлэнэ.

3.1.3 суурь бүтэц эзэмшигч нь өөрийн суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг боловсруулахдаа захиалсан ачааны хэмжээ нь суурь бүтцийн хүчин чадлаас давсан тохиолдолд олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн дамжин өнгөрөх, экспорт, импорт, улс орны эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой ачаа зэргээс бусад ачааг захиалгат хэмжээнээс үл хамааран өөрийн суурь бүтцийн тээх нэвтрүүлэх чадварт тохируулан, шударга өрсөлдөөнийг ханган тээвэрлэсэн байхаар зурмагт тусгасан байна.



3.2. Хөдөлгөөний нэгдсэн зурмаг боловсруулах

3.2.1. суурь бүтэц эзэмшигч нь хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгуулах саналаа Хөдөлгөөн зохицуулалтын төвд бичгээр гаргах бөгөөд дараахь материалыг хавсаргасан байна.

- суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн төсөл;
- суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн төсөлд тусгуулахаар тээвэрлэгч болон бусад үйлчлүүлэгч этгээдээс ирүүлсэн зорчигч, ачаа тээвэрлэлтийн захиалга, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай товч тайлбар;
- зэргэлдээ суурь бүтэцтэй солилцох /хүлээлгэн өгөх буюу хүлээн авах/ галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүн, нэвтрүүлэх зорчигч, ачааны боломжит дээд хэмжээний тухай санал, түүний үндэслэл, тооцоо, судалгаа.

3.3. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь хөдөлгөөний нэгдсэн зурмагийн үндэсний аюулгүй байдал, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөлөл, Олон улсын төмөр замын харилцааны зорчигч, ачаа тээвэрлэлт болон эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой тээвэрлэлт, суурь бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар, тээвэрлэгчдийн ашиг сонирхлын зөрчил зэрэг шалтгаанаар тээвэрлэлтийн үйл ажиллагаа, галт тэрэгний аяллын мөрний хуваарилалтад хуульд заасан үндэслэлээр аливаа хязгаарлалт, давуу эрх, дараалал тогтоох харилцааг холбогдох олон улсын болон үндэсний гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомж, багц дүрэмд нийцүүлэн боловсруулан баталж, мөрдөж ажиллана.


3.4. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах, түүнд өөрчлөлт оруулах, тэдгээртэй хамааралтай мэдээллийг цуглуулахад суурь бүтэц эзэмшигч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага болон иргэний гаргасан санал, зөвлөмжийг нээлттэй хүлээн авна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГИЙН ЦАГЛАБАР

4.1. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг өвлийн ба зуны гэж ангилна.

4.2. Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг дараахь цаглабарын дагуу боловсруулж, батална:

- суурь бүтэц эзэмшигч нь тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, иргэнээс өвлийн суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагт тусгуулах саналыг жил бүрийн 8 дугаар сарын 05-ны дотор, зуны суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагт тусгуулах саналыг 3 дугаар сарын 05-ны дотор авах ба санал авах тухай 21-ээс доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарласан байх;
- суурь бүтэц эзэмшигч нь суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагт тусгуулахаар ирүүлсэн саналыг нэгтгэн, өвлийн суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг



жил бүрийн 8 дугаар сарын 25-ны дотор, зуны суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг 3 дугаар сарын 25-ны дотор боловсруулах;

- суурь бүтэц эзэмшигч нь өөрийн суурь бүтэц дэх хөдөлгөөний өвлийн зурмагийн төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор, зуны зурмагийн төслийг 3 дугаар сарын 31-ний дотор Хөдөлгөөн зохицуулалтын төвд тус тус ирүүлэх.
- суурь бүтэц эзэмшигч нь нэгдсэн зурмаг батлагдсанаас хойш 10 хоногийн дотор өөрийн суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг баталж мөрдөнө.

4.3. Хөдөлгөөний нэгдсэн зурмагийг дараахь цаглабарын дагуу боловсруулж, батална.

4.3.1. хөдөлгөөн зохицуулалтын төв нь хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгуулахаар ирүүлсэн төслүүдийг нэгтгэн, өвлийн хөдөлгөөний нэгдсэн зурмагийг жил бүрийн 9 дүгээр сарын 20-ны дотор, зуны хөдөлгөөний нэгдсэн зурмагийг 4 дүгээр сарын 20-ны дотор боловсруулж, батлах;

4.3.2. хөдөлгөөний нэгдсэн зурмагийг батлагдсанаас хойш ажлын 3 хоногийн дотор суурь бүтэц эзэмшигчид хүргүүлэх.

ТАВДУГААР БҮЛЭГ

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Суурь бүтцийн ачаа тээврийн хэмжээнд өөрчлөлт орох, тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотойгоор шинээр өртөө, зөрлөг нээх, хаах, шинээр шугам барих, зурмагт өөрчлөлт оруулах, мөн суурь бүтцийн техникийн байдал нь муудсанаас хурд хязгаарлах, голын ачааллыг хязгаарлах, тээвэрлэгчийн зүтгүүрийн хурдны шаардлагыг хангахгүй болох зэрэг техникийн шинэчлэлт хийж, технологид өөрчлөлт орох, тээх, нэвтрүүлэх чадвар нэмэгдэх тохиолдол бүрт суурь бүтэц эзэмшигч нь өөрийн суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулна.

5.2. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулах тухай саналаа бичгээр гарган, үндэслэл, түүнийг нотолсон баримт, материалын хамт суурь бүтэц эзэмшигчид ирүүлнэ.

5.3. Суурь бүтэц эзэмшигч нь өөрийн суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулсан тухай бүрт хөдөлгөөний нэгдсэн зурмагт өөрчлөлт оруулах саналыг Хөдөлгөөн зохицуулалтын төвд энэхүү журмын 3.2.1-д заасны дагуу ирүүлнэ.

5.4. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь суурь бүтэц эзэмшигчийн хөдөлгөөний нэгдсэн зурмагт өөрчлөлт оруулах тухай саналыг хянан үзэж, ажлын 5 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ.



5.5. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулах явц, түүнтэй хамааралтай мэдээллүүд нь энэхүү журмын 3.4-д заасны адил хүрээнд нээлттэй байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГИЙН ГҮЙЦЭТГЭЛД ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

6.1. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах, суурь бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар, суурь бүтэц эзэмшигчийн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад хяналт тавих зорилгоор суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийнэ.

6.2. Зурмагийн гүйцэтгэлийн шинжилгээг шаардлагатай гэж үзвэл Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зам тээврийн хяналт хариуцсан нэгж болон суурь бүтэц эзэмшигчтэй хамтран гүйцэтгэж болно.

6.3. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийх удирдамжийг боловсруулж, суурь бүтэц эзэмшигчид албан бичгээр хүргүүлнэ.

6.4. Суурь бүтэц эзэмшигч нь зурмагийн гүйцэтгэлийн шинжилгээнд ашиглуулахаар дараахь материалыг албан бичигт заасан хугацааны дотор Хөдөлгөөн зохицуулалтын төвд гаргаж өгнө.

6.4.1. тухайн хугацааны суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний хоногийн ажлын төлөвлөгөө ба ээлжийн ажлын гүйцэтгэлийн зурмагууд;


6.4.2. ачааны вагоны паркийн хоногийн тайлан;

6.4.3. шаардлагатай тохиолдолд суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн төлөвлөлтийн болон хөдөлгөөн зохицуулагчийн шуурхай тушаалын дэвтрүүд;

6.4.4. удирдамжид заасан бусад баримт бичиг.

6.5. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь хөдөлгөөний нэгдсэн зурмагийн биелэлт болон суурь бүтцийн ашиглалтын ажлын чанарын үзүүлэлтүүдийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган, хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах талаар суурь бүтэц эзэмшигчид албан даалгавар өгч, биелэлтийг хангуулж ажиллана.

6.6. Суурь бүтэц эзэмшигч нь Хөдөлгөөн зохицуулалтын төвөөс өгсөн албан даалгаврын дагуу хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба биелэлтийг заагдсан хугацааны дотор Хөдөлгөөн зохицуулалтын төвд гаргаж өгнө.



ДОЛДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛГӨӨНИЙ НЭГДСЭН ЗУРМАГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ ХИЙХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

7.1. Хөдөлгөөний нэгдсэн зурмагаар тухайн төмөр замын суурь бүтцээр аялах болон төмөр замын суурь бүтцүүд хооронд солилцох галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүн, тээвэрлэх зорчигч болон ачааны боломжит дээд хэмжээ, галт тэрэгний аяллын хурд, хөдлөх бүрэлдэхүүний ба суурь бүтцийн ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлно.

7.2. Суурь бүтэц эзэмшигч нь энэхүү журмын 2.1.1-д нийцүүлэн өөрийн суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг, тодорхой хугацаа /хоног, ээлж/-ны ажлын төлөвлөгөө-зурмаг, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн шуурхай тохируулгыг тус тус боловсруулан, хэрэгжүүлж байх ба өөрийн суурь бүтэц дэх хөдөлгөөний гүйцэтгэлийн зурмагийг хөтөлнө.

7.3. Хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгасан галт тэрэгний аяллын мөрийг суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нар хууль тогтоомжид заасан тээвэрлэлтийн гэрээ байгуулан, харилцан ашиглана.

7.4. Суурь бүтэц эзэмшигч нь өөрийн суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг болон тээвэрлэгчтэй байгуулах тээвэрлэлтийн гэрээг Төмөр замын тээврийн тухай хууль, багц дүрэм, хөдөлгөөний нэгдсэн зурмагт нийцүүлэн боловсруулж, зохион байгуулан, мөрдүүлэн ажиллана.

7.5. Хөдөлгөөний нэгдсэн зурмагийн өөрийн суурь бүтэц дэх галт тэрэгний аяллын мөрийг ямар нэгэн хуулийн этгээдэд болон өөртөө /үүнд өөрийнх нь хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нэгэн адил хамаарна/ тээвэрлэлтийн үйл ажиллагаанд давуутай байдлаар ашиглахгүй байхыг хатуу анхаарч ажиллана .

7.6. Суурь бүтэц эзэмшигч нь өөрийн суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг, тодорхой хугацаа /хоног, ээлж/-ны ажлын төлөвлөгөөг үндэслэн зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийх ба галт тэрэгний зурмагийн тасалдлын мэдээг Хөдөлгөөн зохицуулалтын төвд Төмөр замын тээврийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журамд заасан хугацаанд, тогтоосон маягтын дагуу гаргаж өгнө.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БУСАД

8.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг мөрдөөгүйгээс учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.



8.3. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага /суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага/, иргэн нь галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах, тэдгээрт өөрчлөлт оруулах явц болон хөдөлгөөний нэгдсэн зурмагийн хэрэгжилттэй холбоотой гомдол, саналыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гаргаж, шийдвэрлүүлнэ.

--- о о о ---



Зам тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн
264 дүгээр тушаалын есдүгээр хавсралт

118268063 5910487 6579513

СУУРЬ БҮТЭЦ АШИГЛУУЛАХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар суурь бүтэц ашиглах, ашиглуулах үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү журмыг суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн өмчлөлийн хэлбэр, суурь бүтэц эзэмшигчийн харьяаллын тээвэрлэгч эсэхээс үл хамааран суурь бүтэц ашиглуулахтай холбоотой бүх харилцаанд дагаж мөрдөнө.

1.3. Суурь бүтэц эзэмшигч болон тээвэрлэгч нар нь Монгол Улс нэгдэн орсон Олон улсын гэрээ, Иргэний хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актууд болон энэ журмыг баримтлан суурь бүтэц ашиглуулах тухай гэрээ байгуулж тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.4. Тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд суурь бүтцийн хүчин чадал хангалтгүй тохиолдолд тээвэрлэгчийн ирүүлсэн захиалгыг зөвшилцөх, татгалзах, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг "Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам"-аар зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

СУУРЬ БҮТЭЦ АШИГЛУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА


2.1. Суурь бүтэц ашиглуулан үзүүлэх үйлчилгээний үнэлгээ нь шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөгдсөн тариф, хөлс, хураамжид үндэслэсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

СУУРЬ БҮТЭЦ АШИГЛУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

3.1. Суурь бүтэц ашиглуулах үйлчилгээ нь суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нарын хооронд Монгол Улсын Иргэний хууль, Төмөр замын тээврийн тухай хууль болон энэхүү журамд заасан шаардлагыг хангасан, харилцан тохиролцож бичгээр үйлдсэн гэрээ /цаашид "гэрээ" гэх/-ний үндсэн дээр хэрэгжинэ.

3.2. Суурь бүтэц ашиглуулах гэрээг Төмөр замын тээврийн тухай хуульд заасны дагуу Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв



байгууллагаас баталсан үлгэрчилсэн загварын дагуу бичгээр байгуулах бөгөөд тус байгууллагад хүргүүлнэ.

3.3. Суурь бүтэц эзэмшигч нь эрх бүхий тээвэрлэгчтэй суурь бүтэц ашиглуулах гэрээ байгуулахаас үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй. Гэрээний нөхцөлийг тохиролцож чадаагүй тохиолдолд бусад тээвэрлэгч, түүний дотор өөрийн харьяаллын тээвэрлэгчид олгож буй нөхцөлийг жишиг болгон баримтлана.

3.4. Гэрээ байгуулах санал, гэрээний нөхцөлийн талаарх саналаа тээвэрлэгч Төмөр замаар ачаа тээвэрлэх журмын 3.1-т заасны дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 2 сараас доошгүй хугацааны өмнө суурь бүтэц эзэмшигчид хүргүүлнэ.

3.5. Гэрээнд дараахь нөхцөлийг тохиролцон тусгана:

3.5.1. зорчигчийн галт тэрэг аялуулах хуваарь /хагас жилд нэг удаа өөрчлөлт оруулахаар/;

3.5.2. ачааны хэмжээ, ачаа тээвэрлэх хугацаа;

3.5.3. ачаа тээвэрлэлтийн сар, улирал, жилийн төлөвлөгөөний хуваарь /эсхүл сар бүр аялуулах ачааны галт тэрэгний тоо, жин/;

3.5.4. тариф хэрэглэх нөхцөл, энэхүү журмын 4.4-т заасан нэмэгдэл үйлчилгээний хөлс;

3.5.5. тээвэрлэлтийн технологи, тээвэрлэлтийг хэрэгжүүлэх захиалгыг зөвшилцөх журам, хугацаа.

3.5.6. гэрээг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага.

3.6. Гэрээний талаар маргаан гарсан тохиолдолд эвийн журмаар зохицуулах боломжгүй бол харьяалах шатны шүүхэд хандаж хянан шийдвэрлүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

СУУРЬ БҮТЭЦ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Суурь бүтэц эзэмшигч нь өөрийн техник технологийн боломжийн талаарх мэдээллийг суурь бүтэц ашиглах гэрээ байгуулах гэж буй этгээдэд өгөх үүрэгтэй. Мөн өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээвэрлэлтийн бүх төрлийн үйл ажиллагааг зурмагийн нэгдмэл зохицуулалттай, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангаж, тасралтгүй явуулна.

4.2. Суурь бүтэц эзэмшигч нь галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горимд нийцүүлэн галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах, бусад суурь бүтэц эзэмшигчтэй зөвшилцөн тээвэрлэлтийг тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

4.3 Суурь бүтэц эзэмшигч нь өөрийн ажил үйлчилгээний хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбай, суурь бүтэц эзэмшигчийн болон бусдын эзэмшлийн



дагнасан хэрэглээний зам талбайд вагон тавьж өгөх, буцаан татан авах ажлыг өөрийн эзэмшлийн сэлгээний илчит тэргээр гүйцэтгэх үүрэгтэй. Энэ чиглэлээр суурь бүтэц эзэмшигч нь зам талбай эзэмшигч, ачаа илгээгч нартай гэрээний үндсэн дээр ажиллана.

4.4. Суурь бүтэц эзэмшигч нь Төмөр замын тээврийн тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах, суурь бүтцийг ашиглуулахдаа доорх ажлыг хийж гүйцэтгэнэ:

4.4.1. суурь бүтэц, нийтийн хэрэглээний салбар зам, талбайг ашиглуулах;

4.4.2. суурь бүтэц өөрийн нийтийн хэрэглээний зам дээр хэрэглэгчдэд төмөр замын үйлчилгээг ойртуулах үүднээс ачаа тээвэрлэлтийн хэтийн төлөвлөлттэй уялдуулан дагнасан хэрэглээний зам барих техникийн асуудлыг тээвэрлэгч болон үйлчлүүлэгч нарт салбар замын зураг төсөл боловсруулах, барих журмын дагуу тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горимд нийцүүлэн шийдвэрлэх;

4.4.3. суурь бүтэц нийтийн хэрэглээний замаас салаалсан бусад үйлчлүүлэгчдийн эзэмшлийн дагнасан хэрэглээний замд тээвэрлэлтийн үйл ажиллагаа, галт тэрэгний хөдөлгөөний шуурхай удирдлагаар хангах;

4.4.4. суурь бүтэц эзэмшигч нь өөрийн ажил, үйлчилгээний нийтийн хэрэглээний зам, талбай дээр болон бусдын эзэмшлийн дагнасан хэрэглээний зам талбайд хөдлөх бүрэлдэхүүнийг тавьж өгөх, буцаан татаж авах ажлыг өөрийн эзэмшлийн илчит тэргээр гүйцэтгэнэ. Суурь бүтэц эзэмшигч нь энэ чиглэлийн ажил, үйлчилгээг суурь бүтэц эзэмшигч, зам талбай эзэмшигчид, тээвэрлэгч, ачаа илгээгч нартай гэрээний үндсэн дээр ажиллана.

4.4.5. явуулах өртөөнөөс хүлээн авах өртөө хүртэлх чиглэлийг аль болох дөт байх нөхцөлөөр тогтоох;

4.4.6. тээвэрлэгч тээвэрлэлтийг хэвийн гүйцэтгэх бололцоогүй тохиолдолд тээвэрлэгчийн хөдлөх бүрэлдэхүүнийг нийтийн хэрэглээний замд болон нийтийн хэрэглээний замаас хүлээн авах, явуулах, дамжин өнгөрүүлэх;


4.4.7. тээвэрлэгч бие даан өөрийн хүчээр гүйцэтгэх бололцоогүй тохиолдолд суурь бүтэц эзэмшигч нь өөрийн нийтийн хэрэглээний замууд дээр өртөөдийн байгууламж, сэлгээний тэргээр тээвэрлэгчийн хөдлөх бүрэлдэхүүн ба галт тэргийг бэлтгэж, найруулах;

4.4.8. бусад суурь бүтэц эзэмшигч болон гадаадын төмөр замын байгууллагуудтай тээврийн үйл ажиллагааны техник, технологийн асуудлуудыг зөвшилцөх;

4.4.9. тээвэрлэгчийн хөдлөх бүрэлдэхүүн суурь бүтэц эзэмшигчийн эзэмшлийн нийтийн хэрэглээний замаар гэрээнд заасан нөхцөлийн дагуу тээвэрлэлтийг гүйцэтгэхэд хөдөлгөөнийг шуурхай зохион байгуулах;

4.4.10. тээвэрлэлтэд ашиглаж байгаа тээвэрлэгчийн хөдлөх бүрэлдэхүүний салгалтгүй, техникийн үйлчилгээ болон урсгал засварыг суурь бүтэц эзэмшигч гүйцэтгэнэ. Энэхүү ажлыг гүйцэтгэх үйлчилгээний хөлс нь тээвэр үйлчилгээний тарифт орсон байна. (колотка солих, тоормосны хийн хураагуурын татуурга, холбоосууд солих, гэх мэт ажлуудыг гүйцэтгэхэд);

4.4.11. суурь бүтэц эзэмшигч нь хэсгийн өртөөн дээр өөрийн болон төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн хөдлөх бүрэлдэхүүнийг түлш,



тос, ус, нүүрс зэхэн нийлүүлэх тусгай станцуудтай байна. Галт тэрэгний хөдөлгөөнийг тасралтгүй явуулахын тулд тээвэрлэгч нарыг өмчийн хэлбэр үл харгалзан шаардлагатай түлш, тосоор зэхэж, төлбөр тооцоог “Түлш тосоор зэхэх үйлчилгээ үзүүлэх тухай” заавар, гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийг тооцоолно;

4.4.12. хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөний болон байрлалын талаарх холбогдох мэдээллийг тээвэрлэгчийн хүсэлтээр гаргаж өгөх;

4.4.13. суурь бүтцийг цахилгаанжуулсан тохиолдолд тээвэрлэгч нь цахилгаан зүтгүүрээр тээвэрлэлтийн ажиллагаа явуулбал суурь бүтэц эзэмшигч цахилгаан тэжээлээр хангах.

4.5. Тээвэрлэгч хүсэлт гаргасан нөхцөлд суурь бүтэц ашиглуулах гэрээнд энэхүү журмын 4.4-т заагаагүй үйлчилгээг үзүүлэхээр тусгаж болно. Тээвэрлэгчид үзүүлэх нэмэлт ажил үйлчилгээний жагсаалтыг суурь бүтэц эзэмшигч нийтэд зарлана.

4.6. Суурь бүтэц эзэмшигч нь тээвэрлэгчид суурь бүтцийг ашиглуулан үйлчилгээ үзүүлэхдээ энэ журмын 4.4-т заагаагүй үйлчилгээг үзүүлэхээр тулгах, гэрээний нөхцөлд оруулахыг шаардах эрхгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Тээвэрлэгч нь суурь бүтэц ашиглуулах гэрээ байгуулснаар дараахь эрх эдэлнэ.

5.1.1. суурь бүтэц эзэмшигчийн нийтийн хэрэглээний замыг ашиглах;

5.1.2. суурь бүтэц эзэмшигчийн хөдөлгөөний удирдлага дор тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;


5.1.3. зорчигч, ачаа, тээш болон ачаан тээш тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бусад байгууламжуудыг ашиглах;

5.1.4. суурь бүтэц эзэмшигчийн нийтийн хэрэглээний замыг ашиглаж үйлчлүүлэгч нарт ойртож тээвэрлэлтийн үйл ажиллагааг хүргэхдээ суурь бүтэц эзэмшигчийн замаас салаалсан суурь бүтэц эзэмшигчийн бус эзэмшлийн дагнасан хэрэглээний зам, салбар замуудаас үйлчлүүлэгч нарын ачааг тээвэрлэх;

5.1.5. явуулах өртөөнөөс хүлээн авах өртөө хүртэлх чиглэлийг сонгох, зөвшилцөх.

5.2. Тээвэрлэгч нь суурь бүтэц ашиглалтын хөлсийг тогтоосон хугацаанд төлөх, суурь бүтцийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүйгээр тээвэрлэлтийг зохион байгуулах үүрэгтэй.

5.3. Тээвэрлэгч нь тээвэрлэлтээ зохион байгуулахдаа Суурь бүтэц эзэмшигчээс тогтоосон жингийн норм, голын тоог баримтлах үүрэгтэй.



5.4. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийг зохион байгуулах хөдлөх бүрэлдэхүүн, тоног төхөөрөмж, хүний нөөцтэй байх, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас тээвэрлүүлэгч, гуравдагч этгээд, түүний дотор суурь бүтэц эзэмшигчид учирч болох хохирлыг тооцож, түүнээс сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТЭЭВЭРЛЭЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

6.1. Суурь бүтэц ашиглуулах тухай гэрээ байгуулсан тээвэрлэгч нь орон нутгийн тээвэрлэлт хийх тухай захиалгаа тээвэрлэлт хийхээс 8-аас доошгүй хоногийн өмнө, олон улсын ачаа тээвэрлэлт хийх тухай захиалгаа тээвэрлэлт хийхээс 13-аас доошгүй хоногийн өмнө, олон улсын зорчигчийн галт тэрэгний зурмаг тохиролцож, үйлчилж эхлэхээс хуанлийн 400 хоногоос доошгүй хоногийн өмнө суурь бүтэц эзэмшигчид ирүүлнэ.

6.2. Захиалгыг тээвэрлэгч эрх бүхий этгээдийн гарын үсэг, тэмдгээр баталгаажуулан 2 хувь үйлдэж суурь бүтэц эзэмшигчид хүргүүлнэ.

6.3. Захиалгыг дутуу, буруу хийсэн, захиалга өгөх журмыг зөрчсөн тохиолдолд суурь бүтэц эзэмшигч түүнийг хүлээн авахаас татгалзах эрхтэй бөгөөд захиалга хүлээн авснаас хойш 1 өдрийн дотор татгалзсан шалтгааныг бичиж албан бичгээр мэдэгдэнэ.

6.4. Суурь бүтэц эзэмшигч нь захиалга ирүүлсэн өдрөөр тусгай бүртгэл хөтөлж, бүртгэлийн дугаар олгоно. Суурь бүтэц эзэмшигч захиалга бүртгэх дотоод журмыг тогтоож нийтэд мэдээлэх үүрэгтэй.

6.5. Суурь бүтэц эзэмшигч орон нутгийн тээвэрлэлт хийх тухай захиалгыг 5 хоногийн дотор, олон улсын ачаа тээвэрлэлт хийх тухай захиалгыг 10 хоногийн дотор хянан үзэж тээвэрлэлтийг зөвшөөрөх тухай, эсхүл зөвшөөрөхөөс татгалзсан үндэслэлийг тусгасан хариуг бичгээр өгнө.

6.6. Суурь бүтэц эзэмшигч дараахь тохиолдолд зөвшилцөхөөс татгалзаж буй шалтгааныг тодорхой бичиж, захиалгыг тээвэрлэгчид буцааж өгнө:

6.6.1. холимог тээвэр гүйцэтгэх байгууллага зөвшилцөхөөс татгалзсан;

6.6.2. гадаад улсын төмөр зам зөвшилцөхөөс татгалзсан;

6.6.3. бусад суурь бүтэц эзэмшигч зөвшилцөхөөс татгалзсан;

6.6.4. эрх бүхий байгууллагын шийдвэрээр ачаа тээвэрлэх замналын дагуу ачилт, тээвэрлэлтийг зогсоосон буюу хязгаарласан;

6.6.5. тээвэрлэлт зохион байгуулах гэрээний дагуу өөр тээвэрлэгчийн захиалгыг зөвшилцөх үүрэг хүлээсэн;



6.6.6. тээвэрлэлтийг гүйцэтгэх техник, технологийн бодит боломжгүй.

6.7. Суурь бүтэц эзэмшигч нь энэхүү журмын 6.6.2-6.6.4, 6.6.6-д заасан үндэслэлээр захиалгад өөрчлөлт оруулах саналыг тээвэрлэгчид хүргүүлж болно.

6.8. Гэрээнд өөрөөр заагаагүй бол тодорхой тээвэрлэлт бүрийн дараа гүйцэтгэлийн хэмжээг баталгаажуулна.

6.9. Суурь бүтэц эзэмшигч нь вагоны жин, аюулгүй байдлын шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж аюулгүй байдлын шаардлага хангуулах, шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд тээвэрлэлтийг үргэлжлүүлэхээс татгалзах эрхтэй.

6.10. Суурь бүтэц эзэмшигчийн үндэслэл бүхий шаардлагыг тээвэрлэгч биелүүлэх үүрэгтэй.


6.11. Суурь бүтэц эзэмшигчийн шаардлага үндэслэлтэй эсэх талаар маргаан гарвал суурь бүтэц ашиглах гэрээнд заасан журмаар шийдвэрлэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ХАРИУЦЛАГА

7.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 28 ны өдрийн
264 дүгээр тушаалын аравдугаар хавсралт

СУУРЬ БҮТЭЦ АШИГЛАЛТЫН ТАРИФ ТОГТООХ АРГАЧЛАЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү аргачлалыг багц дүрмийн Төмөр замын суурь бүтэц ашиглуулах журамд заасан суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нарын хооронд суурь бүтцийн ашиглалттай холбоотой харилцаанд ашиглана.

1.2. Төмөр замын суурь бүтэц ашиглалтын тариф тогтоох аргачлал нь Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1.3. Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-д заасны дагуу төмөр замын тээврийн салбарт шударга бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх зорилгоор тариф, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ, гэрээний өөрчлөлтийг хянаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилно.

1.4. Ажлын хэсгийн хэсгийн бүрэлдэхүүнд суурь бүтэц эзэмшигч /тариф, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээгээ хянуулж, санал, дүгнэлт гаргуулахаас бусад/-ийн төлөөллийг оруулан Захиргааны ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллана.

1.5. Суурь бүтэц ашиглалтын тарифыг тогтоохдоо дараахь үзүүлэлтүүдээр тооцоолно:

1.5.1. тээврийн зах зээлийн нөхцөл, суурь бүтцийг оновчтой ашиглах шаардлага, замын нэвтрүүлэх чадвар, суурь бүтцийн үйлчилгээний чанарын дээшлэлт;

1.5.2. зорчигч, ачаа урсгал, түүний хэмжээ, төрөл;


1.5.3. тухайн суурь бүтцийн техникийн онцлог, шинж;

1.5.4. хөдлөх бүрэлдэхүүнийг хурд, нийт жин, гол дээр дарах даралт зэрэг техникийн үзүүлэлтүүд;

1.5.5. галт тэрэгний урт, жин, төрөл;

1.5.6. төмөр замын суурь бүтцийн элэгдлийн зэрэглэл;

1.5.7. инфляци, валютын ханшийн хэлбэлзэл.



100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

100

1.6. Төмөр замын суурь бүтэц эзэмшигч нь тээвэрлэгчид тарифын хөнгөлөлт үзүүлж болно. Тухайн суурь бүтцийн хүчин чадлыг оновчтой ашиглахад нөлөөлөхүйц хөнгөлөлтийг тодорхой хугацаанд хэрэглэж болно. Хөнгөлөлт нь төмөр замын суурь бүтцийн тодорхой хэсэгт, ижил үйлчилгээнд, ижил хөнгөлөлт тогтоох замаар үйлчилнэ.

1.7. Энэхүү журамд хэрэглэгдсэн нэр томъёо, тодорхойлолтыг Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төмөр замын техник ашиглалтын журам болон MNS 6387-1.2.3.4:2013 "Төмөр зам, замын, автоматик, телемеханикийн, хөдлөх бүрэлдэхүүний, тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томъёо, тодорхойлолт" заасан утгаар ойлгож хэрэглэнэ. /хаанаас гараад ирэв/

1.8. Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

18.1. "суурь бүтцийн зардал" гэж суурь бүтэц ашиглуулахтай холбогдон гарсан зардлыг;

1.8.2. "захиалсан галт тэрэг километр" гэж тухайн жилд суурь бүтцээр тээвэрлэлт хийх захиалгын хэмжээг хэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТАРИФ ТОГТООХОД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1. Төмөр замын суурь бүтэц ашиглалтын тариф тогтооход дараахь зарчмыг баримтална:

2.1.1. өрсөлдөөнт зах зээлийг бий болгох;

2.1.2. шударга бус аргаар зах зээлээс ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэгчийг гаргах зорилго агуулаагүй байх;

2.1.3. бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулах;

2.1.4. суурь бүтэц эзэмшигч эдийн засгийн хувьд ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх;


2.1.5. ижил төрлийн үйлчилгээнд ялгавартай үнэ тогтоохгүй байх;

2.1.6. үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТАРИФЫН ТООЦООЛЛЫН АРГАЧЛАЛ

3.1. Суурь бүтэц ашиглалтын тарифыг өртөг, хөрөнгө оруулалтын өгөөжид үндэслэх аргаар тооцоолно. Төмөр замын суурь бүтцийн ашиглалтын тарифыг суурь бүтцийн зардал, тухайн суурь бүтцээр тухайн жилд захиалсан галт тэрэг километрийг үндэслэн тогтооно.



T _{сб}	-	Суурь бүтэц ашиглалтын тариф;
C _{БЗ}	-	Тухайн жилд гарсан нийт зардал;
A	-	Ашгийн коэффициент;
ЗА _{км}	-	Захиалсан галт тэрэг киллометр.

3.2. Суурь бүтцийн зардлын тооцоолол

ШЗ	-	Суурь бүтцийн шууд зардал;
ШБЗ	-	Суурь бүтцийн шууд бус зардал.

3.2.1. Шууд зардлын тооцоолол:

AЗ	-	Галт тэрэгний хөдөлгөөнийг хангах, зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах зэрэг суурь бүтцийн ашиглалтын зардал;
ИЗ	-	Суурь бүтцийн их засварын жилийн зардал;
ЭЗ	-	Суурь бүтцийн элэгдлийн жилийн зардал /Монгол Улсын хууль, тогтоомжид заасны дагуу жилд байгуулах элэгдлийн хэмжээг тооцно/;
ЗХ	-	Суурь бүтэцтэй холбогдон гарсан зээлийн хүүгийн зардал.

3.2.2. Шууд бус зардлын тооцоолол:


НЗ	-	Нийтлэг ба ерөнхий зардал;
УЗ	-	Суурь бүтэц эзэмшигчийн удирдлагын зардал;
ДХ	-	Даатгалын зардал;
ТХ	-	Суурь бүтэц эзэмшигчийн татвар хураамжууд.

3.3. Ашгийн төвшин:

Төмөр замын суурь бүтэц ашиглалтын ашгийн коэффициент /A/ нь хөрөнгийн жигнэсэн дундаж өртгөөс /WACC/ хэтэрч болохгүй ба дараахь томъёогоор тооцоологдоно.

WACC

WACC	-	хөрөнгийн жигнэсэн дундаж өртөг нь компани зээл олгогч, хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулсан бусад этгээдүүдийн шаардлагыг хангах зорилгоор олох ёстой хамгийн бага үр өгөөжийн хэмжээ;
Re	-	Өөрийн хөрөнгийн өртгийн жигнэсэн дундаж хэмжээ, /хувиар/
Rd	-	Зээлийн хөрөнгийн өртгийн жигнэсэн дундаж хэмжээ, /хувиар/, /хүү төлөх үүрэгтэй/;
E	-	Өөрийн хөрөнгийн мөнгөн илэрхийлэл;
D	-	Зээлийн хөрөнгийн мөнгөн илэрхийлэл.



3.4. Тарифт тооцогдохгүй, шаардлагатай үед суурь бүтэц эзэмшигчийн техник хэрэгслээр нэмэгдэл төлбөртэй хийгдэх ажил үйлчилгээнд доорх үйлчилгээнүүд орно.

3.4.1. вагоныг тээвэрлэлтэд бэлтгэх;

3.4.2. вагоны төлөвлөгөөт бүх засварын төрлүүд болон урсгал салгалттай засвар;

3.4.3. зүтгүүрийн зэхэлт, техникийн үйлчилгээ ба засвар, зүтгүүрийн арчлах тослох материал.

3.5. Төмөр замын суурь бүтцийн зардалд дараахь зардлыг тооцохгүй:

3.5.1. буцалтгүй тусламжаар бий болсон хөрөнгө болон түүний ашгаас үүссэн үндсэн хөрөнгийн зардал;


3.5.2. өмчийн өртгийн өөрчлөлт /нөөцийн үлдэгдлийн өөрчлөлт, эргэлтийн хөрөнгийн хямдрал, үндсэн хөрөнгийн өртгийн бууралт, материаллаг болон материаллаг бус үндсэн хөрөнгийн устгал болон борлуулалтаас үүдсэн алдагдал/;

3.5.3. хууль, дүрэм, журмын дагуу тогтоогдсон алданги, торгууль;

3.5.4. удирдлагын буруутай үйл ажиллагаа, нөөцийн зүй бус ашиглалтаас үүдэлтэй зардал;

3.5.5. хууль тогтоомж, багц дүрмийг зөрчсөнөөс үүдсэн хохирлыг арилгахтай холбогдсон зардал.

--- о О о ---




Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 29 ны өдрийн 264 дүгээр
тушаалын Суурь бүтэц ашиглалтын тариф
тогтоох аргачлалын нэгдүгээр хавсралт


575427 CGT0513

Төмөр замын суурь бүтэц ашиглалтын зардлын задаргаа


1. Шууд зардал	
1.1. Ашиглалтын зардал	
1.1.1. Замын аж ахуй	
1.1.1.1.	Зам ба байнгын төхөөрөмжийн арчилгаа
1.1.1.2.	Модон болон төмөр бетон дэрний ганцаарчилсан солилт
1.1.1.3.	Хайрга шороо чигжээсний солилт
1.1.1.4.	Суман шилжүүлгийн металл эд ангийн солилт
1.1.1.5.	Суман шилжүүлгээс бусад металл хэсгийн солилт
1.1.1.6.	Малын хориг торон хашааны арчилгаа
1.1.1.7.	Зам, гүүр, хиймэл төхөөрөмж, гармуудын хамгаалалт
1.1.1.8.	Хиймэл төхөөрөмж, гармын арчилгаа
1.1.1.9.	Хамгаалалтын ойн зурвасын арчилгаа
1.1.1.10.	Цас, ус, элс, мөсний хохирлоос урьдчилан сэргийлэх болон хохирлыг арилгах ажил
1.1.1.11.	Замын аж ахуйн бусад ажлууд
1.1.2. Дохиолол холбооны аж ахуй	
1.1.2.1.	Дохиолол холбооны аж ахуйн үйлдвэрлэлийн барилга байгууламжийн урсгал засвар
1.1.2.2.	Механикжсан болон автоматжсан довын байгууламжийн техникийн үйлчилгээ
1.1.2.3.	Диспетчерийн төвлөрүүлэлтийн техникийн үйлчилгээ
1.1.2.4.	Сумын цахилгаан төвлөрүүлэлтийн техникийн үйлчилгээ
1.1.2.5.	Төмөр замын автоматикийн техникийн үйлчилгээ
1.1.2.6.	Төмөр замын автоматикийн бусад хэрэгсэл, ДТХ-ын төхөөрөмжийн техникийн үйлчилгээ
1.1.2.7.	Радио станц, радиоузел ба чанга яригчийн техникийн үйлчилгээ
1.1.2.8.	Радио, холбоо, релейний байгууламж, цахилгаан тэжээлийн аппарат, төхөөрөмжийн техникийн үйлчилгээ
1.1.2.9.	Үйлдвэрийн телевизийн төхөөрөмж, телевиз, өргөн нэвтрүүлгийн радио хүлээн авагч, радио цэгийн техникийн үйлчилгээ
1.1.2.10.	Цахилгаан мэдээний станцын аппаратын ашиглалт, техникийн үйлчилгээ
1.1.2.11.	Телефон утасны станцын ашиглалт, техникийн үйлчилгээ
1.1.2.12.	Шуурхай технологийн холбооны захиран хуваарилах станц, дамжуулах системийн аппаратын техникийн үйлчилгээ
1.1.2.13.	Холбооны агаарын шугам болон шилэн кабелиар дамжуулах системийн техникийн үйлчилгээ
1.1.2.14.	Холбооны агаарын шугам болон шилэн кабелийн техникийн үйлчилгээ
1.1.2.15.	Холбооны холбох шугамын ашиглалт
1.1.2.16.	Хиймэл дагуулын байгууламжийн техникийн үйлчилгээ
1.1.2.17.	Төмөр замын холбооны хэрэгслийн техникийн үйлчилгээ



	1.1.2.18.	Тооцоолон бодох техникийн хэрэгсэл, өгөгдөл дамжуулах сүлжээний техникийн үйлчилгээ болон урсгал засвар
	1.1.2.19.	Төмөр замын холбооны бусад тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээ
	1.1.3. Өртөө зөрлөг	
	1.1.3.1.	Ачаа тээвэрлэлттэй холбоотой барилга, байгууламжийн урсгал засвар
	1.1.3.2.	Ачаа тээвэрлэлттэй холбоотой барилга, байгууламж, тоног төхөөрөмж, эд хогшилын үйлчилгээ
	1.1.3.3.	Зорчигч тээвэрлэлттэй холбоотой барилга, байгууламжийн урсгал засвар
	1.1.3.4.	Зорчигч тээвэрлэлттэй холбоотой барилга, байгууламж, тоног төхөөрөмж, эд хогшилын үйлчилгээ
	1.1.3.5.	Ачааны өртөөдөд ачааны галт тэрэг хүлээн авах ба явуулах
	1.1.3.6.	Зорчигчийн өртөөдөд зорчигчдын галт тэрэг хүлээн авах ба явуулах
	1.1.3.7.	Хилийн өртөөдөд галт тэрэг хүлээн авах ба явуулах
	1.1.3.8.	Бусад өртөөдөд галт тэрэг хүлээн авах ба явуулах
	1.1.3.9.	Ачааны болон ангилах өртөөдийн сэлгээний ажил
	1.1.3.10.	Зорчигчийн өртөөдийн сэлгээний ажил
	1.1.3.11.	Хилийн өртөөдийн сэлгээний ажил
	1.1.3.12.	Бусад өртөөдийн сэлгээний ажил
	1.2. Их засвар	
	1.2.1. Зам аж ахуй	
	1.2.1.1.	Замын дээд цогцос, ул шорооны их засвар
	1.2.1.2.	Хиймэл төхөөрөмжийн их засвар
	1.2.1.3.	Салбар замын их засвар
	1.2.1.4.	Хамгаалалтын ойн зурвасын их засвар
	1.2.1.5.	Замын их засварт ажиллаж байгаа машин механизмын их засвар
	1.2.2. Дохиолол холбооны аж ахуй	
	1.2.2.1.	Төмөр замын автоматикийн хэрэгсэл, ДТХ-ын төхөөрөмжийн их засвар
	1.2.2.2.	Шуурхай технологийн холбооны их засвар
	1.2.2.3.	Төмөр замын радио холбооны их засвар
	1.2.2.4.	Холбооны бусад хэрэгслийн их засвар
	1.2.3 Өртөө зөрлөг	
	1.2.3.1.	Ачаа тээвэрлэлттэй холбоотой барилга, байгууламжийн их засвар
	1.2.3.2.	Ачаа тээвэрлэлттэй холбоотой тоног төхөөрөмж, эд хогшилын их засвар
	1.2.3.3.	Зорчигч тээвэрлэлттэй холбоотой барилга, байгууламжийн их засвар
	1.2.3.4.	Зорчигч тээвэрлэлттэй холбоотой тоног төхөөрөмж, эд хогшилын их засвар
	1.3. Элэгдлийн зардал	
	1.3.1. Зам аж ахуй	
	1.3.1.1.	Замын дээд цогцос ул шорооны элэгдэл
	1.3.1.2.	Хиймэл төхөөрөмжийн элэгдэл
	1.3.1.3.	Салбар замын элэгдэл
	1.3.1.4.	Малын хориг торон хашааны элэгдэл
	1.3.1.5.	Хамгаалалтын ойн зурвасын элэгдэл




	1.3.1.6.	Замын их засварт ажиллаж байгаа машин механизмын элэгдэл
	1.3.2. Дохиолол холбооны аж ахуй	
	1.3.2.1.	Төмөр замын автоматикийн бусад хэрэгсэл, ДТХ-ын төхөөрөмжийн элэгдэл
	1.3.2.2.	Шуурхай технологийн холбооны элэгдэл
	1.3.2.3.	Төмөр замын радио холбооны элэгдэл
	1.3.2.4.	Холбооны бусад хэрэгслийн элэгдэл
	1.3.3. Өртөө зөрлөг	
	1.3.3.1.	Ачаа тээвэрлэлттэй холбоотой барилга, байгууламжийн элэгдэл
	1.3.3.2.	Зорчигч тээвэрлэлттэй холбоотой барилга, байгууламжийн элэгдэл
	1.3.3.3.	Ачаа тээвэрлэлттэй холбоотой тоног төхөөрөмж, эд хогшилын элэгдэл
	1.3.3.4.	Зорчигч тээвэрлэлттэй холбоотой тоног төхөөрөмж, эд хогшилын элэгдэл
	1.4. Зээлийн хүү, түрээсийн төлбөр	
	1.4.1.	Түрээсийн болон лизингийн төлбөр
	1.4.2.	Хүүгийн төлбөр
	2. Шууд бус зардал	
	2.1. Ерөнхий ба нийтлэг зардал	
	2.1.0.1.	Үйлдвэрлэлийн зориулт бүхий үндсэн хөрөнгийн элэгдэл
	2.1.0.2.	Нийтлэг аж ахуйн зориулалт бүхий үндсэн хөрөнгийн элэгдэл
	2.1.0.3.	Үйлдвэрлэлийн зориулт бүхий үндсэн хөрөнгийн их засвар
	2.1.0.4.	Нийтлэг аж ахуйн зориулалт бүхий үндсэн хөрөнгийн их засвар
	2.1.0.5.	Байгаль хамгаалах зориулалт бүхий объект, тоног төхөөрөмжийн ашиглалт, арчилгаа
	2.1.0.6.	Байгаль хамгаалахаас бусад объект, тоног төхөөрөмжийн ашиглалт, арчилгаа
	2.1.0.7.	Үйлдвэрлэлийн зориулт бүхий үндсэн хөрөнгийн урсгал засвар
	2.1.0.8.	Үйлдвэрлэлд шууд хамааралгүй барилга байгууламж, эд хогшилын арчилгаа, үйлчилгээ, урсгал засвар
	2.1.0.9.	Автоташин тээврийн хэрэгслэлийн техникийн үйлчилгээ ба урсгал засвар
	2.1.0.10.	Автомашинаас бусад тээврийн хэрэгслэлийн арчилгаа, үйлчилгээ, урсгал засвар
	2.1.0.11.	Нийтлэг аж ахуйн зориулалт бүхий барилга, байгууламж, эд хогшилын арчилгаа, үйлчилгээ, урсгал засвар
	2.1.0.12.	Бусад аж ахуйн үйлдвэрлэлийн барилга байгууламжийн урсгал засвар
	2.1.0.13.	Захиргааны удирдлагад хамаарахгүй ажилтнуудын цалин
	2.1.0.14.	Захиргааны удирдлагад хамаарахгүй ажилтнуудад тавьж олгосон дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт
	2.1.0.15.	Захиргааны удирдлагад хамаарахгүй ажилтнуудын албан томилолт
	2.1.0.16.	Үйлдвэрийн ажилтнуудын ажиллаагүй үеийн цалин
	2.1.0.17.	Үйлдвэрийн ажилтнуудын цалингийн дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт
	2.1.0.18.	Үйлдвэрийн ажилтнуудын албан томилолт
	2.1.0.19.	Боловсон хүчин бэлтгэх
	2.1.0.20.	Ажиллагсад үзүүлэх үйлчилгээ




	2.1.0.21.	Төмөр замын ажилчдын эрүүл мэндийн урьдчилсан үзлэг
	2.1.0.22.	Техникийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрийн эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал
	2.1.0.23.	Автомашин ашиглалт
	2.1.0.24.	Цэрэгжүүлсэн ба гал, харуул хамгаалалтын зардал
	2.1.0.25.	Нийтлэг салбарын зардал
	2.1.0.26.	Худалдааны зардал
	2.1.0.27.	Материалын хэвийн хорогдол
	2.1.0.28.	Шинжилгээ ба туршилтын зардал
	2.1.0.29.	Шинэ бүтээл, оновчтой санал
2.2. Удирдлагын зардал		
	2.2.1.	Захиргааны удирдах ажилтны хөдөлмөрийн хөлсний зардал
	2.2.2.	Захиргааны удирдах ажилтнуудын албан томилолт
	2.2.3.	Удирдлагын хэрэгцээнд зориулсан тайлан бүртгэлийн баримт бичгийн механикжсан боловсруулалтын ажлын хөлсний зардал
	2.2.4.	Захиргааны удирдлагын бусад зардал
2.3. Даатгалын зардал		
	2.3.1.	Албан журмын даатгалын төлбөр
	2.3.2.	Сайн дурын даатгалын төлбөр
	2.3.3.	Эд хөрөнгө болон хариуцлагын даатгалын төлбөр
2.4. Татвар, хураамж, төлбөр		
	2.4.1.	Байгалийн нөөц ашигласны төлбөр
	2.4.2.	Газрын албан татвар
	2.4.3.	Бусад албан татвар ба хураамж

--- o O o ---



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
264 дүгээр тушаалын арваннэгдүгээр хавсралт



ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ОБЪЕКТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.


1.2. Энэхүү журмын зорилго нь төмөр замын тээврийн салбарын тасралтгүй, найдвартай, хүртээмжтэй үйлчилээг үзүүлэх, мөн хөдөлгөөний аюулгүй байдал болон үйл ажиллагааг хангах, үйлчлүүлэгчдийн эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх зэрэг нөхцөлийг бүрдүүлэх, салбарт дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх, тээх, нэвтрүүлэх чадвар болон өрсөлдөөний нөхцөл байдлыг тодорхойлоход оршино.

1.3. Гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм журам, MNS 5523:2013 стандартын шаардлагын дагуу, ил тод, нээлттэй, шуурхай, хүртээмжтэй, чанартай, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтална.

1.4. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох үндэсний MNS 5523:2013 стандартад нийцүүлэн гэрчилгээжүүлэх ажлыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

1.5. Энэхүү журамд хэрэглэгдсэн нэр томьёо, тодорхойлолтыг Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төмөр замын техник ашиглалтын дүрэм болон MNS 6387-1,2,3,4:2013 "Төмөр зам, замын, автоматик, телемеханикийн, хөдлөх бүрэлдэхүүний, тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томьёо, тодорхойлолт"-д заасан утгаар ойлгож хэрэглэнэ.

1.6. Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нь төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлтэд хамрагдсан иргэн, хуулийн этгээдтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд гэрээ байгуулж хамтран ажиллана.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ОБЪЕКТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Объектын гэрчилгээжүүлэлтийг дараахь байдлаар ангилна.

2.1.1. суурь бүтэц ашиглах чиглэлээр:

- нийтийн хэрэглээний зам, талбай;
- дагнасан хэрэглээний зам, талбай;
- өртөө, зөрлөг /төмөр замын дохиолол, холбооны байгууламж/.

2.1.2. хөдлөх бүрэлдэхүүний чиглэлээр:

- бүх төрлийн зүтгүүр;
- бүх төрлийн ачааны вагон;
- бүх төрлийн зорчигчийн вагон;
- сэргээн босгох, гал унтраах галт тэрэг;
- зам засвар, арчлалт, оношлогоо, хэмжилт хийх бүх төрлийн машин механизм.

2.2. Дараахь үйл ажиллагааг гэрчилгээжүүлнэ:

2.2.1. дагнасан хэрэглээний замын дээд, доод бүтцийн засвар, арчлалт гүйцэтгэх;

2.2.2. төмөр замын зураг төсөл боловсруулах;

2.2.3. дагнасан хэрэглээний зам, талбай барих;

2.2.4. дагнасан хэрэглээний замд сэлгээний ажил гүйцэтгэх;


2.2.5. төмөр замын дохиолол, холбооны байгууламжийн техникийн үзлэг, үйлчилгээ гүйцэтгэх;

2.2.6. зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ гүйцэтгэх;

2.2.7. вагоны техникийн үзлэг, үйлчилгээ гүйцэтгэх;

2.2.8. төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх;

2.2.9 хатуу тооцоот багаж, хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх.



ГУРАВ. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага нь дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг боловсруулж батлах;

3.1.2. гэрчилгээ бүхий объект, үйл ажиллагаа нь гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан шалгах, гэрчилгээ олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох;

3.1.3. гадаад улсын гэрчилгээжүүлэх байгууллагаас олгосон гэрчилгээг хүлээн зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэх;

3.1.4. төмөр замын тээврийн объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх асуудлаар бусад улсын ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах;

3.1.5. гадаадын төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж шинээр гэрчилгээ авах хүсэлт гаргасан тохиолдолд үр ашигтай өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Засгийн газарт хүсэлт хүргүүлж хязгаарлалт тогтоолгож болно.

3.1.6. энэхүү журмын зорилгод нийцүүлэн гэрчилгээжүүлэлтийн үйл ажиллагаа, түүний төрөл ангилал, тавигдах нөхцөл, шаардлагыг боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх;

3.1.7. гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх;

3.1.8. гэрчилгээжүүлэлтийг хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу явуулж байгаа эсэхийг шалгаж, шаардлагатай тохиолдолд гаргасан дүгнэлт, шийдвэрийг дахин хянах, энэхүү журмын зургадугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлэх;

3.1.9. төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавьж, биелэлтийг хангуулах;


3.1.10. гэрчилгээжүүлэлтийн байнгын, орон тооны бус ажлын хэсгийг байгуулах, ажлын хэсэг ажиллах зааврыг батлах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГЭРЧИЛГЭЭ ХҮССЭН ӨРГӨДЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

4.1. Гэрчилгээ шинээр авах тухай хүсэлт гаргахдаа дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:


4.1.1. объектын гэрчилгээ авахад тавигдах шаардлага:



- зохих журмын дагуу гаргасан иргэн, хуулийн этгээдийн албан хүсэлт;
- улсын бүртгэлийн гэрчилгээ /иргэний үнэмлэх/-ний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- гэрчилгээжүүлэх объектын танилцуулга;
- тухайн объектын гарал үүсэл, тохирлын эсхүл чанарын гэрчилгээ, паспорт, засвар өөрчлөлтийн бүртгэл, ашиглалтын заавар, техникийн зураг, схем;
- объект нь гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг хангаж байгааг нотолсон баримт бичиг;
- үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газар эзэмших, ашиглах, шилжүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ, өмч хувьчлалын шийдвэр, худалдах, худалдан авах гэрээ, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, узуфрукт эрх, түрээсийн гэрээ болон бусад шаардлагатай баримт бичиг;
- төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн Монгол Улсын хилээр шинээр оруулж ирэх хөдлөх бүрэлдэхүүн урьд нь тээвэрт ашиглагдаж байсан бол олон улсын түвшинд засвар, техникийн оношилгоо үйлчилгээ хийхээр эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагаар түүнд засвар, оношилгоо хийлгэж, техникийн болон тээврийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааны баталгааг тодорхойлсон баримт бичиг, мөн техникийн дүгнэлтийг гаргуулсан байна.

4.1.2. Үйл ажиллагааны гэрчилгээ авахад тавигдах шаардлага:


- зохих журмын дагуу гаргасан иргэн, хуулийн этгээдийн албан хүсэлт;
- улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- эрхлэх үйл ажиллагааны танилцуулга;
- төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмыг үндэслэн төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч нь дугаар бүхий хатуу тооцоот багаж, хэрэгсэлтэй байх ба тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт болон техникийн тодорхойлолт, ажлын байрны талаарх мэдээлэл, тэдгээрийг ашиглах болон хүлээлцэх технологийн горим, зааврыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулан ирүүлэх;



- энэхүү журамд заасан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, ажлын байрыг бусад хуулийн этгээдээс түрээсээр авч ашигладаг бол энэ тухай гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- холбогдох үйл ажиллагааны төрөл, суурь нөхцөл, шаардлагад нийцсэн мэргэжлийн ажилтнуудын мэргэжлийн диплом, мэргэшлийн гэрчилгээ, батламжийн нотариатаар баталгаажуулсан хуулбар, тэдгээрийн туршлага, ур чадварын тухай мэдээлэл;
- гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нь тухайн гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон холбогдох үйл ажиллагааны зөвшөөрлийн гэрчилгээний орчуулга, нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- зохих журмын дагуу харьяалах татварын байгууллагад татварын тайлан тогтмол гаргадаг болон татварын өргүй болохыг тодорхойлсон тодорхойлолтыг хавсаргах;
- холбогдох үйл ажиллагааны дагуу хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын харьяалах нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлэн, шимтгэл төлснийг баталгаажуулсан тодорхойлолтыг эх хувиар нь хавсаргах;
- хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын журмын хавсралтад заасан инженер техникийн болон бусад ажиллагсдын нийгмийн даатгалын дэвтрийн нүүр, тушаал, шимтгэл төлсөн хуудсыг нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага нь хариуцлагын даатгалын баталгаа эсхүл даатгалын гэрээний төлбөрийн баримтын эх хувь;
- гэрчилгээжүүлэлтийн үйл ажиллагаа нь энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгааг нотолсон баримт бичгийг тус тус ирүүлнэ.

4.2. Энэхүү журмын 4.1.1-д заасан баримт бичгүүд нь банкны болон ямар нэгэн зээлийн барьцаанд байгаа тохиолдолд барьцаалагч иргэн, хуулийн этгээдээс төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ гаргуулахад татгалзах зүйлгүй гэсэн албан тодорхойлолт гаргуулж ирүүлснийг үндэслэн гэрчилгээ олгоно.

4.3. Гэрчилгээжүүлэх төмөр замын объект, үйл ажиллагаа нь дараахь нөхцөлийг хангасан байхаас гадна объект, үйл ажиллагааны төрөл, онцлогоос шалтгаалан энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан нөхцөл шаардлагыг хангасан байвал зохино:



- төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, техникийн зохицуулалт, стандартын шаардлагыг хангасан байх;
- объект, үйл ажиллагааны ашиглалт, үйлчилгээний дүрэм, журам заавар болон технологийн горимын шаардлагыг хангасан байх;
- үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүгийн чадавхи, боловсон хүчин, техник тоног төхөөрөмжтэй байх.

4.4. Хуулийн этгээдээс ирүүлсэн гэрчилгээ авахыг хүссэн албан хүсэлт, холбогдох материалыг энэхүү журамд заасан шаардлагын дагуу хүлээн авсан өдрөөс хойш ажлын 21 хоногийн дотор хянан үзэж, шийдвэрийг гаргана.

4.5. Шаардлагатай тохиолдолд энэхүү журмын 4.4-д заасан хугацааг 14 хүртэл хоногоор нэмж сунгаж болно.

4.6. Төмөр замын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага нь гэрчилгээний нөхцөл, шаардлагыг хангахгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллагад гэрчилгээ олгохоос татгалзаж байгааг тайлбар, үндэслэлийн хамт албан бичгээр мэдэгдэнэ.

4.7. Энэхүү журмын 3.1.9-д заасан байнгын, орон тооны бус гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсэг гэрчилгээ хүсэгчийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бааз, техник хангамжийн нөхцөл байдлыг шаардлагатай гэж үзвэл газар дээр нь хянан шалгана.

4.8. Объект, үйл ажиллагааны гэрчилгээний хугацаа:


- объектын гэрчилгээг 3-5 жил хугацаагаар олгоно.
- үйл ажиллагааны гэрчилгээг 3 жил хугацаагаар олгоно.
- гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж хугацаа нь дууссанаар хүчингүйд тооцно.

4.9. Ажлын хэсэг гэрчилгээний нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргана.

4.10. Ажлын хэсэг нь өргөдөл гаргагчийн баримт бичгийн агуулга, бүрдэл, гэрчилгээний нөхцөл, шаардлагыг хангасан байдлыг ирүүлсэн дарааллын дагуу хянан үзэж, нягтлан шалгана.

4.11. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн гэрчилгээ олгохыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

4.12. Гэрчилгээнд объект, үйл ажиллагааны код, нэр, төрөл, хүчинтэй хугацаа, объектын техникийн үзүүлэлтүүд, гэрчилгээний нөхцөл, шаардлага, олгосон



байгууллага, эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, гэрчилгээ эзэмшигчийн нэр, хаяг улсын бүртгэлийн регистрийн дугаар, олгосон болон дуусгавар болох огноо бичигдэнэ.

4.13. Гэрчилгээ нь Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тамга дарагдсанаар баталгаажиг, хүчин төгөлдөр болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ГЭРЧИЛГЭЭ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ГЭРЧИЛГЭЭГ СУНГАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг:

5.1.1. гэрчилгээ эзэмшигч нь зөвхөн гэрчилгээнд заасан үйл ажиллагааг эрхэлнэ;

5.1.2. гэрчилгээний хүчинтэй хугацаанд объект, үйл ажиллагааны хэвийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж болох бүтэц, технологийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь 30 хоногийн дотор энэ тухай Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдсэн байна;

5.1.3. энэхүү журмын 5.1.2-т заасан өөрчлөлтийг хийсэн бол гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг нэмж тусгах буюу шинээр гэрчилгээ олгоно. Шинээр гэрчилгээ олгох асуудлыг энэ журмын 4 дүгээр бүлэгт зааснаар хянан шийдвэрлэнэ;

5.1.4. төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага нь төмөр замаар зуучилж тээвэрлүүлсэн ачааны төрөл, хэмжээний тайланг тээвэрлэгчээр баталгаажуулан, жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ;

5.1.5. гэрчилгээг цэвэр үзэмжтэй хадгалах;

5.1.6. төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, нормыг дагаж мөрдөх;

5.1.7. иргэн, хуулийн этгээд нь төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэлтэд хамруулах, тэдгээрт хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм, нормативын баримт бичгээр тавигдах нөхцөл, шаардлагыг хангах үүрэгтэй;

5.1.8. энэхүү журмын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

5.2. Гэрчилгээг сунгахад тавигдах шаардлага:



5.2.1. гэрчилгээний хугацаа сунгах тухай өргөдлийг гэрчилгээний зөвшөөрлийн хугацаа дуусахаас 21 хоногийн өмнө гаргаж, эрх бүхий байгууллага хугацаа сунгах эсэх асуудлыг 14 хоногийн дотор шийдвэрлэнэ;

5.2.2. төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь хүсэлт гаргасан албан бичигтэй хамт дараахь материалыг бүрдүүлэн ирүүлнэ:

- зохих журмын дагуу гаргасан албан хүсэлт;
- гэрчилгээний эх хувь;
- гэрчилгээжүүлсэн объектын ашиглалт, үйл ажиллагааны тайлан /захиалагч байгууллагаас гаргасан тодорхойлолт, үйл ажиллагааны үр дүнг нотлох баримт бичиг, акт, фото зураг зэрэг болно/;
- гэрчилгээ авахаар бүрдүүлсэн материал болон мэдээлэлд орсон өөрчлөлтийн тухай мэдээлэл;
- харьяалах татварын болон нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт.

5.3. Гэрчилгээний хугацааг сунгуулах тухай хүсэлтийг энэ журмын 5.2.1-т заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд ажлын хэсгээс хяналт, шалгалт хийж, гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ.

5.4. Гэрчилгээг сунгасан тухай бүртгэлийг гэрчилгээжүүлэлтийн сунгалтын хэсэгт тэмдэглэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, НӨХӨН ОЛГОХ ТУХАЙ

6.1. Гэрчилгээний үйлчлэлийг дараахь тохиолдолд түдгэлзүүлнэ.

6.1.1. гэрчилгээний хугацаа, нөхцөл шаардлагыг зөрчсөн;


6.1.2. энэхүү журмын 5.1, 5.2-т заасныг зөрчсөн;

6.1.3. гэрчилгээ эзэмшигчийн хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, байгууллагын эрх ашиг зөрчигдсөн;

6.1.4. төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны гэрчилгээ авсан хуулийн этгээд нь энэхүү журамд заасан тээвэр зуучлалын үйл ажиллагааг нэг жилийн дотор эрхлээгүй нөхцөлд.

6.2. Төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлэх санал гаргасны дагуу Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түдгэлзүүлэх эсэхийг хянан шийдвэрлэнэ.

6.3. Гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлсэн зөрчлийг арилгасан талаар төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагчийн саналыг үндэслэж түүнийг сэргээнэ.



6.4. Гэрчилгээг дараахь тохиолдолд хүчингүй болгоно:

6.4.1. гэрчилгээ эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан;

6.4.2. гэрчилгээний нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

6.4.3. гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

6.4.4. гэрчилгээ авах хүсэлт гаргахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

6.4.5. гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан, бусдад шилжүүлсэн;

6.4.6. үйл ажиллагааны ажил, үйлчилгээнд тавигдах нөхцөл шаардлагыг хангаагүй.

6.5. Гэрчилгээг хүчингүй болгосон тухай мэдэгдлийг гэрчилгээ эзэмшигч, холбогдох суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчид албан бичгээр 3 хоногийн дотор мэдэгдэж, хүчингүй болсон гэрчилгээг хураан авна.

6.6. Гэрчилгээг дараахь тохиолдолд нөхөн олгоно:

6.6.1. объект болон үйл ажиллагааны гэрчилгээний хүчинтэй хугацаанд өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигч солигдох;

6.6.2. гэрчилгээг үрэгдүүлж, бохирдуулах.

6.7. Гэрчилгээг энэхүү журмын 6.6.1-т заасан үндэслэлээр нөхөн олгоход дараахь баримт бичгийг ирүүлнэ:

6.7.1. өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигчийн иргэний үнэмлэх /улсын бүртгэлийн гэрчилгээ/-ний нотариатаар баталгаажуулсан хуулбар;


6.7.2. өмч өөрчлөлтийн талаарх тогтоол, шийдвэр, гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

6.7.3. хуучин гэрчилгээний эх хувь.

6.8 Гэрчилгээг энэхүү журмын 6.6.2-т заасан үндэслэлээр нөхөн олгоход дараахь баримт бичгийг ирүүлнэ:

6.8.1. өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигчийн иргэний үнэмлэх /улсын бүртгэлийн гэрчилгээ/-ний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

6.8.2. гэрчилгээ эзэмшигч нь энэхүү журмын 7 дугаар зүйлд заасан гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сангаас авсан лавлагаа, хуулбар;



6.8.3. гэрчилгээг үрэгдүүлсэн тухай өдөр тутмын сонин, хэвлэлээр зарласан хэвлэлийн эх хувь.

6.9. Гэрчилгээг хаяж гээгдүүлэн, мөн бохирдуулан гэрчилгээний хүчинтэй байх хугацаанаас өмнө нөхөн авах тохиолдолд албан хүсэлт, гэрчилгээ болон холбогдох материалыг ирүүлж, гэрчилгээний үнийн төлбөрийг төлсөн байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭЛТ, ХӨТЛӨЛТ, ХАДГАЛАЛТ, АШИГЛАЛТ

7.1. Гэрчилгээжүүлэлттэй холбоотой мэдээллийн санг хөтлөх, бүртгэх, хадгалах, ашиглуулах үйл ажиллагааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүний эрх олгосон байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

7.2. Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан дараахь мэдээллүүдийг агуулна:

- стандарт, норм, нормативын баримт бичиг;
- гэрчилгээжсэн объект;
- гэрчилгээжсэн үйл ажиллагаа;
- объектын дугаар, ангилал, төрөл;
- хүний нөөцийн мэдээлэл.

7.3. Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг гэрчилгээ олгох тухай шийдвэр гарсны дараа болон хяналт шалгалтын үр дүнг үндэслэн тухай бүр баяжуулна.

7.4. Холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцад хамаарахаас бусад мэдээллийг салбарын мэдээллийн сангийн цахим хуудсанд нээлттэй байршуулна.

7.5. Гэрчилгээжүүлэлттэй холбоотой баримт бичгийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүний эрх олгосон байгууллага архивын нэгж болгон хадгална.

7.6. Салбарын мэдээллийн санд төвлөрсөн мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглах үйл ажиллагааг "Архивын тухай" хуулиар зохицуулна.


НАЙМДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

8.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрчилгээжүүлэлтэд хамрагдсан объект, үйл ажиллагаанд хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавина.

8.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---






Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 24 ны өдрийн
2.64 дүгээр тушаалын Төмөр замын тээврийн
аюулгүй байдалтай холбоотой зарим
объект, үйл ажиллагаанд гэрчилгээ
олгох журмын нэгдүгээр хавсралт

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ОБЪЕКТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЧИЛГЭЭНИЙ ЭХ ЗАГВАР, ТҮҮНД ТАВИГДАХ МЭДЭЭЛЭЛ

1. Гэрчилгээний нүүрэн тал, түүний агуулга:
 - 1.1. гэрчилгээ нь нууцлал бүхий үнэт цаас байна;
 - 1.2. гэрчилгээ нь А4 буюу 21x29.7 см-ийн хэмжээтэй байх ба 157 граммтай цаасыг ашиглана;
 - 1.3. гэрчилгээний дээд хүрээнээс 5.5 мм-ийн зайд төв хэсэгт нь 17x35 мм хэмжээтэй соёмбыг байрлуулна. Соёмбо нь MNS 6262:2011 стандартад заасан шаардлагыг хангасан байна;
 - 1.4. гэрчилгээний дээд хэсэгт байрлах соёмбын доод талд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийг том үсгээр бичсэн байна;
 - 1.5. объектын болон үйл ажиллагааны гэрчилгээнд бичигдэх өгөгдлүүд нь монгол хэл дээр бичигдэж, англи хэл дээр орчуулагдан бичигдсэн байна;
 - 1.6. гэрчилгээнд бичигдсэн Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийн доод талд “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааны гэрчилгээ” гэсэн гарчиг байх ба түүний баруун доод талд гэрчилгээний дугаарыг бичнэ;
 - 1.7. гэрчилгээний дугаар нь олгогдсон он, тушаалын дугаар, бүртгэлийн дугаарын тооноос тус тус бүрдэнэ;
 - 1.8. төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх журамд заагдсан нэр төрөл бүр дээр дугаарлалт хийгдэнэ;
 - 1.9. гэрчилгээнд сунгалт хийх үед гэрчилгээний арын “Сунгалт, өөрчлөлтийн бүртгэл” хэсэгт тэмдэглэл хийж, гарын үсэг, тамга дарж баталгаажуулна;
 - 1.10. гэрчилгээний дугаарын зүүн доод талд тухайн гэрчилгээний төрөлд оногдох кодыг бичнэ;
 - 1.11. гэрчилгээний дунд хэсэгт гэрчилгээ эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн нэр, албан ёсны хаяг /улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх/, гэрчилгээ олгогдож байгаа объект, үйл ажиллагааны нэр төрөл, зориулалтыг тодорхойлж бичнэ;



1.12. гэрчилгээний доод хэсэгт олгосон он, сар, өдөр, дуусгавар болох он, сар, өдрийг тус тус бичнэ.

2. Гэрчилгээний ар тал, түүний агуулга:

2.1. объектын болон үйл ажиллагааны гэрчилгээний ар талд 2 удаагийн сунгалт, өөрчлөлтийн бүртгэлийн хэсгийг оруулсан байна.

2.2. “Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгож буй энэхүү объектын гэрчилгээ нь тухайн объект нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангаж байгааг тодорхойлсон баримт бичиг болно” гэсэн санамж гэрчилгээний ард бичигдсэн байна.


2.3. объектын гэрчилгээний ард тухайн объект (суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг)-д хамаарах Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй Монгол Улсын Үндэсний стандарт, олон улсын болон бүс нутгийн техникийн зохицуулалтын баримт бичиг, түүнчлэн техникийн нөхцөл (MNS 6276:2011, MNS 6312:2012, MNS 6039:2009, MNS 6229:2010, MNS 5833:2014, MNS 4700:1999, MNS EN 13230-1, MNS EN 13230-2: 2013, MNS 6060: 2010, MNS EN:13450:2015, MNS 2092: 2011, MNS 2848: 2011, MNS 6277: 2011, MNS ГОСТ R 51685 : 2014, MNS EN 13674-2: 2014, MNS EN 13231-3 : 2016, MNS EN 13977: 2016 г.м)-ийг тусгана.

2.4. нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай, өртөө, зөрлөг болон объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэхэд тавигдах шаардлага, техникийн нөхцөлийг 1-8 дугаар хүснэгтэд үзүүлэв.

Нэгдүгээр хүснэгт

Бүх төрлийн ачааны вагоны техникийн нөхцөл

Д/д	Техникийн үзүүлэлт	Утга
1.	Эзэмшигчийн нэр	
2.	Төрөл, зориулалт	
3.	Вагоны бүртгэлийн дугаар	
4.	Овор	
5.	Даац/хувийн жин, т	
6.	Эзлэхүүн, м ³	
7.	Голын тоо	
8.	Хийцийн хурд, км/цаг	
9.	Тэргэнцрийн төрөл, дугаар	
10.	Ниших татах байгууламжийн төрөл	
11.	Хос дугуйн төрөл	
12.	Ашиглалтын байдал, ашигласан хугацаа	
13.	Автотоормосын төрөл	
14.	Үйлдвэрлэгдсэн он, улс	
15.	Бусад	



Хоёрдугаар хүснэгт


Бүх төрлийн зорчигчийн вагоны техникийн нөхцөл

Д/д	Техникийн үзүүлэлт	Утга
1.	Эзэмшигчийн нэр	
2.	Төрөл, зориулалт	
3.	Вагоны бүртгэлийн дугаар	
4.	Овор	
5.	Даац/(хувийн жин), т	
6.	Зорчигчийн суудлын тоо	
7.	Тэвшний урт, өргөн, өндөр, ммхммхмм	
8.	Голын тоо	
9.	Хийцийн хурд, км/цаг	
10.	Тэргэнцрийн төрөл	
11.	Ниших татах байгууламжийн төрөл	
12.	Хос дугуйн төрөл	
13.	Ашиглалтын байдал, ашигласан хугацаа	
14.	Автооормосын төрөл	
15.	Авто угсрааны төрөл, тоо/ш	
16.	Дотоод тоноглолын ангилал, төрөл	
17.	Үйлдвэрлэгдсэн он, улс	
18.	Бусад	

Гуравдугаар хүснэгт

Бүх төрлийн зүтгүүрийн техникийн нөхцөл


Д/д	Техникийн үзүүлэлт	Утга
1.	Эзэмшигчийн нэр	
2.	Төрөл, зориулалт	
3.	Зүтгүүрийн бүртгэлийн дугаар	
4.	Голын тоо	
5.	Зүтгүүрийн хувийн жин, т	
6.	Нэг гол дээрх даралт, т	
7.	Түлшний савны багтаамж, л	
8.	Тосны савны багтаамж, л	
9.	Элсний савны багтаамж, л	
10.	Усны савны багтаамж, л	
11.	Дизель генераторын дугаар, чадал, кВт	
12.	Татах генераторын дугаар, чадал, кВт	
13.	Статер генераторын дугаар, чадал, кВт	
14.	Сэрээгчийн дугаар	
15.	Дамжлагын төрөл	
16.	Тэргэнцрийн дугаар: 1 дүгээр, 2 дугаар	
17.	Хос дугуйн дугаар	
18.	Их засварт орсон огноо	
19.	Урсгал засварт орсон огноо	
20.	Үйлдвэрлэгдсэн он, улс	
21.	Бусад	



Дөрөвдүгээр хүснэгт

Нийтийн хэрэглээний зам, талбайд тавигдах шаардлага

Д/д	Үзүүлэлт	Утга
1.	Эзэмшигчийн нэр	
2.	Байрлал	
3.	Гэрчилгээжүүлэгдсэн замын нэр, дугаар	
4.	Төмөр замын зэрэглэл	Хурдны, онцгой их ачааны нягтралттай, I, II, III, IV зэрэглэлийн аль нь болох
5.	Төмөр замын зориулалт	гол зам, өртөөний холбох, салбар замын аль нь болох
6.	Удирдах хэвгий, ‰	
7.	Замын эхлэл, төгсгөл	
8.	Замын бүрэн урт, м	
9.	Замын ашигт урт, м	
10.	Зорчигч буулгалт, суулгалт болон ачилт, буулгалтын хийх хэсэглэх газрын нэр	
11.	Дэрний төрөл	
12.	Зам, төмрийн марк	
13.	Зам төмрийн бэхэлгээний төрөл	
14.	Суман шилжүүлгийн удирдлага, тоо хэмжээ	
15.	Тухайн замд харьяалагдах хиймэл төхөөрөмж, тоо, тэнхлэгийн байршил (пк)	
16.	Гармын байршил (пк), зэрэглэл	
17.	Эпюр	
18.	Замын зураг хийсэн ААН, огноо, дугаар	
19.	Ашиглалтад оруулсан огноо	
20.	Зам дээр байрлаж буй бусад техник тоног төхөөрөмж	
21.	Бусад	



Тавдугаар хүснэгт

Дагнасан хэрэглээний зам, талбайд тавигдах шаардлага

Д/д	Үзүүлэлт	Утга
1.	Эзэмшигчийн нэр	
2.	Байрлал	
3.	Салбар зам дахь нийт замын тоо	
4.	Гэрчилгээжүүлэгдсэн замын дугаар, нэр	
5.	Өртөө, зөрлөгт нийлэх уулзвар	
6.	Замын эхлэл, төгсгөл	
7.	Тухайн замд харъяалагдах суман шилжүүлгийн удирдлага, тоо, дугаар	
8.	Замын бүрэн урт, м	
9.	Замын ашигт урт, м	
10.	Ачилт буулгалт хийх хэсэг	
11.	Зам төмрийн марк	
12.	Дэрний төрөл	
13.	Тухайн замд харъяалагдах гарам	
14.	Тухайн замд харъяалагдах хиймэл төхөөрөмж, тоо, тэнхлэгийн байршил (пк)	
15.	Зам дээр байрлаж буй бусад техник тоног төхөөрөмж	
16.	Замын зураг хийсэн ААН, огноо, дугаар	
17.	Ашиглалтад орсон огноо	
18.	Бусад	

Зургадугаар хүснэгт


Өртөө, зөрлөгт тавигдах шаардлага


Д/д	Үзүүлэлт	Утга
1.	Байрлал	
2.	Төрөл, зориулалт	Ачааны, зорчигчийн, техникийн, завсрын аль нь болох
3.	Өртөө, зөрлөгийн ангилал	Ангилалгүй, I, II, III, IV, V зэрэглэлийн аль нь болох
4.	Өртөө, зөрлөгт харъяалагдах нийт замын тоо, ш	
5.	Хүлээн авах, явуулах, дамжуулан өнгөрүүлэх замын тоо, ш	
6.	Хүлээн авах, явуулах замын удирдах хэвгий, %	
7.	Жилийн нийт зорчигч, ачилт, буулгалтын тоон үзүүлэлт, /мян.зорч, мян.тонн/	
8.	Хүлээн авах, явуулах, дамжуулан өнгөрүүлэх зорчигч, ачааны галт тэрэгний тоо	
9.	Дамжин өнгөрөх галт тэргэнд зэхэлт, техникийн үзлэг хийдэг эсэх	
10.	Вагон, зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээний газартай эсэх /ЛПТО, ПТО/	
11.	Зорчигчийн вагоны зэхэлт хийгддэг эсэх	/ус, дизель түлш, нүүрсний зэхэлтийн аль нь хийгддэг/



Объектын болон үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлтийн код

Объектын код		
1. Суурь бүтцийн чиглэлээр:		
1.1.	O-1	Нийтийн хэрэглээний зам, талбай
1.2.	O-2	Дагнасан хэрэглээний зам, талбай
1.3.	O-3-1	Өртөө
1.4.	O-3-2	Зөрлөг
2. Хөдлөх бүрэлдэхүүний чиглэлээр:		
2.1	O-4	Зүтгүүр
2.2	O-5	Ачааны вагон
2.3	O-6	Зорчигчийн вагон
2.4	O-7	Сэргээн босгох, гал унтраах галт тэрэг
2.5	O-8	Зам засвар, арчлалт, оношлогоо, хэмжилт хийх бүх төрлийн вагон, машин механизм
Үйл ажиллагааны код		
1.	Ү-1	Дагнасан хэрэглээний замын дээд, доод бүтцийн засвар, арчлалт гүйцэтгэх
2.	Ү-2	Төмөр замын зураг төсөл боловсруулах
3	Ү-3	Дагнасан хэрэглээний зам, талбай барих
4	Ү-4	Дагнасан хэрэглээний замд сэлгээний ажил гүйцэтгэх
5	Ү-5	Төмөр замын дохиолол, холбооны байгууламжийн техникийн үзлэг, үйлчилгээ гүйцэтгэх
6	Ү-6	Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ гүйцэтгэх
7	Ү-7	Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ гүйцэтгэх
8	Ү-8	Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх
9	Ү-9	Хатуу тооцоот багаж, хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх





Зам, тээврийн хөгжлийн сайдын
 2018 оны 11 дүгээр сарын 28 ны өдрийн
 26 дүгээр тушаалын Төмөр замын тээврийн
 аюулгүй байдалтай холбоотой зарим
 объект, үйл ажиллагаанд гэрчилгээ
 олгох журмын хоёрдугаар хавсралт

**ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ
 БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНД
 ТАВИГДАХ ШААРДЛАГА**


Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд мөн төмөр замын тээврийн салбарт үйл ажиллагаа болон үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь Төмөр замын тээврийн тухай хууль болон энэхүү журмыг мөрдөж ажиллана.

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой дагнасан хэрэглээний зам, талбай барих, мөн зам, талбайд ачих, буулгах, сэлгээний ажил гүйцэтгэх, бүх төрлийн хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаа, хатуу тооцоот багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, төмөр замын дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбооны байгууламжийн техникийн үзлэг, үйлчилгээ эрхлэх, төмөр замын зураг төсөл боловсруулах, түүнд хяналт тавих үйл ажиллагааг эрхлэх, дагнасан хэрэглээний замын дээд, доод бүтцийн засвар арчлалт гүйцэтгэх зэрэг үйл ажиллагаанд тавигдах шаардлага, техникийн нөхцөлийг 8-9 дугаар хүснэгтэд үзүүлэв.


Наймдугаар хүснэгт

Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагын үйл ажиллагаа болон үйлчилгээнд тавигдах шаардлага


Үйл ажиллагааны төрөл	Байвал зохих инженер техникийн ажилчид	Инженер техникийн ажилчдын ажлын туршлага	Бусад мэргэжлийн ажиллагсад	Бусад мэргэжлийн ажиллагсда д тавигдах шалгуур	Үйл ажиллагааны суурь шаардлага	Үйл ажиллагаа эрхлэх ажлын байр, тоног төхөөрөмж
Дагнасан хэрэглээний зам, талбай барих үйл ажиллагааны нөхцөл, шаардлага	Төмөр замын инженер-1, Геодези, хайгуул зураг төслийн инженер-1, Замын техникч-2,	Төмөр замын инженер нь мэргэжлээр ээ 5 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.	Механикч-1, Төмөр замын мэргэжлийн ажилтан-5	Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх	Дагнасан хэрэглээний замын дээд, доод бүтцийн засвар, арчлалтын үйл ажиллагааг 3 жил зөрчил, дутагдалгүй гүйцэтгэсэн;	Багаж, тоног төхөөрөмж хадгалах талбай, агуулахтай байх, Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан хэмжих багаж, хэрэгсэлтэй байх, Цахилгаан, хийн гагнуурын аппарат, Замын индүү,




						Усалгааны машин, Авто самосвал, Экскаватор, Грейдер, Замын домкрат, цахилгаан чигжүүр, цахилгаан үүсгүүр, замын чиг татагч
Дагнасан хэрэглээний зам, талбайд ачих, буулгах үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага	Тээвэр зохион байгуулалтын инженер-1	Мэргэжлээр ээ 5 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.	Агуулах, талбайн эрхлэгч-1, Оосорлогч-2, Кранчин-1, Дохиочин-1	Мэргэжлийн үнэмлэхтэй байх.		Зориулалтын ажил, амралтын байр талбайтай байх, Кран Авто ачигч Аюулгүй ажиллагааны хувцас хэрэгсэл, Хатуу тооцоот багаж хэрэгслийн байр, савтай байх.
Дагнасан хэрэглээний замд сэлгээний ажил гүйцэтгэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага	Тээвэр зохион байгуулалтын инженер-1,	Мэргэжлээр ээ 5 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.	Найруулагч-2, Туслах найруулагч-2, Машинч-2, Туслах машинч-2.	Мэргэжлийн үнэмлэхтэй байх.	Сэлгээний зүтгүүрийн объектын гэрчилгээ Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ эрхлэх аюулгүй байдлын гэрчилгээ эсхүл зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ хийлгэх гэрээтэй байх, Сэлгээний ажлын заавар	Сэлгээний бригадын амрах байртай байх, Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: Радио станц, Албан яриа бичлэгийн төхөөрөмж, Хатуу тооцоот багаж хэрэгсэл.
Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааны	Зүтгүүрийн инженер-2	Төмөр замын их, дээд сургуулийг зүтгүүрийн инженер мэргэжлээр	Техникийн үйлчилгээний ажилтан-4, Гагнуурчин-1	1-ээс доошгүй жил мэргэжлээр ажилласан	Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ хийх	Зориулалтын ажил, амралтын байртай байх, Техник үзлэг, үйлчилгээ, засвар гүйцэтгэх зориулалтын



нөхцөл, шаардлага		бакалавр болон түүнээс дээш зэрэг цолтой дүүргэсэн, мэргэжлээр ээ 5 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.		мэргэжлийн диплом, үнэмлэхтэй эсхүл мэргэжлийн комисст шалгалт өгсөн байх.	технологийн горим	засварын замтай байх, Нөөц болон нэн шаардлагатай сэлбэг, материал, хатуу тооцоот багаж хэрэгслийг хадгалах байртай байх, Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага : Кран, Гагнуурын хэрэгсэл, Багаж хэрэгсэл, Нөөц сэлбэг, Зэхэлтийн тоног төхөөрөмж
Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага	Вагоны инженер-2	Төмөр замын их, дээд сургуулийг вагоны инженер мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэг цолтой дүүргэсэн, мэргэжлээр рээ 3 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.	Техник үйлчилгээний ажилтан-4, Гагнуурчин-1	1-ээс доошгүй жил мэргэжлээр рээ ажилласан , мэргэжлийн диплом, үнэмлэхтэй эсхүл мэргэжлийн комисст шалгалт өгсөн байх.	Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ хийх технологийн горим	Зориулалтын ажил, амралтын байртай байх, Техник үзлэг, үйлчилгээ, засвар гүйцэтгэх зориулалтын засварын замтай байх, Нөөц болон нэн шаардлагатай сэлбэг, материал, хатуу тооцоот багаж хэрэгслийг хадгалах байртай байх, Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: Кран, Гагнуурын хэрэгсэл, Багаж хэрэгсэл, Нөөц сэлбэг, Зэхэлтийн тоног төхөөрөмж
Хатуу тооцоот багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа	инженер-2 Чанар хэмжилтийн инженер-1	Мэргэжлээр рээ 5 ба түүнээс дээш жил ажилласан эсхүл	Тэжарьчин Халуун төмөрчин Мужаан Хэвлэгч	Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх.		Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын ажлын байртай байх: Үйлдвэрлэлийн байр



эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага		мэргэшсэн инженер	Цутгуурчин Гагнуурчин			Хадгалах склад Суурь машины цех Халуун төмрийн цех Механик цех Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: Токарийн суурь машин Цахилгаан Компютер Шалгах, турших багаж тоног төхөөрөмж /Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан байх/ Гагнуурын аппарат /цахилгаан, хийн/
Төмөр замын дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбооны байгууламжийн засвар, техникийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага	Автомат, телемеханикийн инженер-2 /аль нэг нь мэргэшсэн инженер байх/ Холбооны инженер-1.	Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер	Механик-2 Холбооны техникч-1 Монтёр-3	Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх.		Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай ажлын байртай байх; Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: - Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан хэмжих хэрэгсэл - Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан багаж хэрэгсэл
Төмөр замын зураг төсөл боловсруулах, түүнд хяналт тавих үйл ажиллагааны нөхцөл, шаардлага	Төмөр замын инженер-1, Төмөр замын дохиололын инженер-1 Геодезийн инженер-1	Төмөр замын инженерийн аль нэг нь зураг төслийн байгуулагчид 5 ба түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн	Зургийн техникч-2	Мэргэжлийн үнэмлэхтэй байх	Гүйцэтгэсэн ажлын талаарх захиалагч байгууллагын тодорхойлолт	Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан хэмжих хэрэгсэл, Зураг, тооцооны программ хангамж, түүнийг




		инженер байх				боловсруулах компьютерийн техник хангамжтай байх,
Дагнасан хэрэглээний замын дээд, доод бүтцийн засвар арчлалт гүйцэтгэх үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага	Төмөр замын инженер-1	5 ба түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер	Замын техникч-2 Замын мэргэжлийн ажилтан-4	Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх		Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: - Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан хэмжих хэрэгсэл, - Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан багаж хэрэгсэлтэй байх,

Есдүгээр хүснэгт

Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага

Зайлшгүй байх мэргэжилтэн, тэдгээрийн тоо	Ажлын туршлага	Мэргэжилтэнд тавигдах шаардлага	Ажил үйлчилгээнд тавих суурь нөхцөл	Ажлын байранд тавигдах шаардлага	Тавигдах бусад шаардлага
Тээврийн мэргэжилтэн-2, санхүүгийн мэргэжилтэн-1,	Тээврийн мэргэжилтэн нь мэргэжлээрээ 3 болон түүнээс дээш жил ажилласан байх.	Тээврийн мэргэжилтэн нь тээврийн мэргэжлийн бакалавр ба түүнээс дээш зэргийн мэргэжлийн дипломтой байх, нэгээс доошгүй мэргэжилтэн нь тээвэр зуучлалын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх.	Үйл ажиллагааны гэрчилгээ олгосноос эсхүл сүүлийн жилийн тайлан ирүүлснээс хойш дараагийн тайлан ирүүлэх хугацаанд 10 вагон эсхүл 20 футийн чингэлэгт дүйцүүлсэн нэгж /TEU/-ээс доошгүй ачаа төмөр замаар зуучилсан байх	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай 25м ² -аас доошгүй талбай бүхий ажлын байртай байх.	Төмөр замаар зуучилсан ачааны тайланг журмын хоёрдугаар хавсралтын дагуу тээвэрлэгчээр баталгаажуулан Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зам, тээврийн хяналтын нэгжид журамд заасан хугацаанд тайлагнах.



Арваннэгдүгээр хүснэгт


Төмөр замаар зуучлан тээвэрлүүлсэн ачааны жилийн тайлан

Д/д	Төмөр замаар ачаа зуучилж тээвэрлүүлсэн хугацаа, улирал	Илгээлтийн төрөл	Тоо хэмжээ, ш /20тн-ийн чингэлэгт дүйцүүлсэн нэгж/
1.	I улирал	Вагон	
		Чингэлэг	
2.	II улирал	Вагон	
		Чингэлэг	
3.	III улирал	Вагон	
		Чингэлэг	
4.	IV улирал	Вагон	
		Чингэлэг	

Мэдээ гаргасан: /төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхэлсэн аж ахуйн нэгж байгууллагын холбогдох ажилтны овог нэр, албан тушаал, гарын үсэг, тамга тэмдэг/

Мэдээг хянасан: /тээвэрлэгч байгууллагын холбогдох ажилтны овог нэр, албан тушаал, гарын үсэг, тамга тэмдэг/

--- о О о ---



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 1.1 дүгээр сарын 28-ны өдрийн
264 дүгээр тушаалын арванхоёрдугаар хавсралт

1119248063 5919487 СЭТ9513

ТӨМӨР ЗАМЫН АЮУЛТАЙ БҮС, ТӨМӨР ЗАМЫН ЗУРВАС ГАЗАР, АЮУЛГҮЙН БҮСЭД ТӨМӨР ЗАМЫН БОЛОН БУСАД ОБЪЕКТ БАЙРЛУУЛАХ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ, НЭВТРЭХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь төмөр замын аюултай бүс, зурвас газар, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект, барилга байгууламжийг байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмын нэр томъёог Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, Барилгын тухай хууль, багц дүрэм, MNS 6387-1,2,3,4:2013 стандартад заасан утгаар ойлгоно.

1.3. Төмөр замын болон бусад объект, барилга байгууламжийн зураг төсөл, хийц загвар, үйл ажиллагаа нь Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын шаардлагуудад нийцсэн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН АЮУЛТАЙ БҮС, ЗУРВАС ГАЗАР, АЮУЛГҮЙН БҮСЭД ТӨМӨР ЗАМЫН ОБЪЕКТ БАЙРЛУУЛАХ

2.1. Төмөр замын аюултай бүс, зурвас газар, аюулгүйн бүсэд төмөр замын объект байрлуулах гэж төмөр замын суурь бүтэц барих зөвшөөрөл олгох, зураг төсөл боловсруулах, батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хэлнэ.

2.2. Төмөр замын суурь бүтэц барих зөвшөөрөл олгох:

2.2.1. төмөр замын суурь бүтэц барих, өргөтгөх /цаашид "суурь бүтэц барих" гэх/, нийтийн хэрэглээний замд холбох зөвшөөрөл авах өргөдлийг иргэн, хуулийн этгээд /цаашид "Өргөдөл гаргагч" гэх/ нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 16.2, 16.3-т заасан баримт бичгийн хамт Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Ирүүлбэл зохих баримт бичгийн бүрдүүлэлт дутуу, шаардлага хангаагүй бол өргөдлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болно;



2.2.2. өргөдөл гаргагч нь техник, эдийн засгийн урьдчилсан үндэслэлд доорх зүйлүүдийг тусгаж зохих тооцоог хийсэн байна:

- ерөнхий шаардлага;
- ачаа болон зорчигч урсгалын чиглэл, цаашдын хандлага;
- төмөр замын шугамын үндсэн шалгуур үзүүлэлтүүд;
- төмөр зам барих газар нутгийн гадаргуу, хөрсний бүтэц, байгаль, цаг агаарын нөхцөл;
- төмөр замын шугамын чиг, дэвсгэр зураг;
- хиймэл төхөөрөмжийн байршил, тоо;
- өртөө, зөрлөг, зүтгүүрийн болон вагон засвар, ашиглалтын депо, ачааны терминал, зэргийн байршил, тэдгээрийн хүчин чадал;
- хоорондын замын тээх, нэвтрүүлэх чадвар;
- галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалт, өртөөний сум, дохиоллын байгууламжийн удирдах, хянах техник хэрэгсэл;
- зорчигч болон ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааны технологи, техник тоноглол;
- хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр;
- эдийн засгийн үр ашгийн тооцоо;
- байгаль орчны ерөнхий үнэлгээ;
- барилга угсралтын ажлын хэмжээ, тооцоолсон өртөг, хүний нөөцийн хэрэгцээ;
- галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах шаардлага;
- холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тухайн үйл ажиллагаатай холбогдолтойгоор сонсох ажиллагааг явуулсан байх.

2.2.3. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг /цаашид “Комисс” гэх/ нь өргөдөл гаргагчийн ирүүлсэн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативт нийцэж байгаа эсэхийг хянаж, шинээр баригдах төмөр замын суурь бүтэц, зохион байгуулалтын талаар техникийн дүгнэлт гаргана.

2.2.4. комиссын ажиллах журам, хуралдааны дэгийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.



2.2.5. өргөдөл гаргагч нь шинээр барих төмөр замын суурь бүтцийг үйл ажиллагаа явуулж буй төмөр замын шугам, нийтийн хэрэглээний замтай холбох талаар тухайн төмөр замын шугам, нийтийн хэрэглээний зам эзэмшигчтэй зөвшилцсөн байна.

2.2.6. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянаж дүгнэлт гаргаж, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ.

2.3. Төмөр замын суурь бүтцийн зураг төсөл боловсруулах, батлах:

2.3.1. төмөр замын зураг төсөл боловсруулах эрх бүхий байгууллага /цаашид "Зураг төслийн байгууллага" гэх/ өргөдөл гаргагчийн хүсэлт, ажлын зургийн техникийн даалгаврыг үндэслэн төмөр замын суурь бүтэц барих ажлын зураг төслийг боловсруулна;

2.3.2. өргөдөл гаргагч нь зураг төслийн байгууллагыг сонгох эрхтэй;

2.3.3. төмөр замын зураг төслийн байгууллага нь суурь бүтэц барих ажлын зураг төслийг Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативыг баримтлан боловсруулна;


2.3.4. зураг төслийг орон нутгийн төрийн захиргааны байгууллага, төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, шаардлагатай тохиолдолд /суурь бүтэц нь үерийн далан, бүх төрлийн шугам сүлжээ, нийтийн үйлчилгээний авто зам зэргийг огтлох, аюултай, цэргийн ачаа боловсруулах, хадгалах г.м./ эрх бүхий бусад байгууллагуудтай зөвшилцсөн байна;

2.3.5. өргөдөл гаргагч нь төмөр замын суурь бүтэц барих ажлын зураг төслийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулна;

2.3.6. ажлын зураг төслийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 15 хоногийн дотор хянаж, төмөр замын суурь бүтэц барих барилга угсралтын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгох, эсхүл татгалзсан тухай шийдвэр гаргаж албан бичгээр мэдэгдэнэ;

2.3.7. төмөр замын суурь бүтцийн зураг төслийг гадаад орны зураг төслийн байгууллагаар гүйцэтгүүлэх бол тухайн орны төмөр замын зураг төсөл хийх эрхийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулсан байна;

2.3.8. шинэ төмөр замын суурь бүтцийг барьж, байгуулах зураг төсөлд зэрлэг ан амьтан, малыг чөлөөтэй нэвтрүүлэх гарц, гарам, хиймэл байгууламжийг барих тоо, норм хэмжээг тогтоон зураг төсөлд тусган боловсруулж, "Баягаль орчин ногоон хөгжлийн яаманд хянуулан, зөвлөмж авсан байна. Мөн шинэ төмөр замын суурь



бүтцийг барьж, байгуулах зураг төсөлд авто зам болон бусад зам, талбайтай нэг шугам болон чиглэлд огтлолцохгүйгээр төсөлсөн байна.

2.4. Төмөр замын суурь бүтцийн барилга угсралтын ажил гүйцэтгэх:

2.4.1. төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү журмын 2.3.6-д заасан зөвшөөрлийн дагуу төмөр замын суурь бүтэц барих, эсхүл өргөтгөх, барилга угсралтын ажил /цаашид “Суурь бүтцийн барилгын ажил” гэх/-ыг эрх бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ;

2.4.2. өргөдөл гаргагч нь тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг сонгох үүрэгтэй;

2.4.3. төмөр замын суурь бүтэц барих ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй үед барилга угсралтын ажил гүйцэтгэхгүй байхыг хатуу анхаарч ажиллана;

2.4.4. суурь бүтцийн барилгын ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, MNS 6229:2010 стандарт, норм нормативт нийцүүлэн гүйцэтгэнэ;

2.4.5. суурь бүтцийн барилгын ажлын явцын хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын дагуу хэрэгжүүлнэ;

2.4.6. төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл эзэмшигч нь барилгын ажлыг бүрэн гүйцэтгэж дуусмагц гүйцэтгэлийн зураг төслийг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлсэн байна.

2.5. Төмөр замын суурь бүтцийг ажлын түр хөдөлгөөнд ашиглах:

2.5.1. төмөр замын суурь бүтцийг үргэлжлүүлэн барих явцдаа баригдсан төмөр замыг ул шороо, замын чигжээсийг тогтворжуулах ажлын түр хөдөлгөөнд /цаашид “ажлын түр хөдөлгөөн” гэх/ ашиглаж болно;

2.5.2. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргаж төмөр замын суурь бүтцийг ажлын түр хөдөлгөөнд ашиглах эсэх шийдвэр гаргана;

2.5.3. комиссын бүрэлдэхүүнд суурь бүтцийн барилга угсралтын ажлын захиалагч, зураг төслийн байгууллага, гүйцэтгэгч байгууллага, холбогдож байгаа суурь бүтцийн төлөөлөл оролцоно;

2.5.4. суурь бүтцийг ажлын түр хөдөлгөөнд ашиглах тохиолдолд суурь бүтцийн техникийн байдал нь доорх шаардлагыг хангасан байна;

2.5.5. замын далан, сэтэрхийн налуулгыг тогтворжуулж, ус зайлуулах төхөөрөмж суурилуулсан байх, ул шороог төслийн төвшинд хүргэсэн байх;



2.5.6. хиймэл төхөөрөмж нь түр ашиглалтын хугацаанд энэ хэсгээр явах хөдлөх бүрэлдэхүүнийг тогтоосон хурдаар явуулах нөхцөлийг хангасан байх;

2.5.7. төмөр замын дээд бүтэц нь 20 см-ээс багагүй зузаантай чигжээсний үе дээр тавигдсан байх;

2.5.8. холбоо, дохиоллын байгууламж нь галт тэрэгний хөдөлгөөн зохицуулахад мөн галт тэрэг болон өртөө хоорондын холбоо, дохиололд /өртөөнд сумын постын холбоонд/ ашиглах боломжтой байх.

2.6. Төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулах:

2.6.1. төмөр замын суурь бүтцийг байнгын ашиглалтад оруулахдаа энэ журам болон Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрмийг баримтална;

2.6.2. өргөдөл гаргагч нь төмөр замын суурь бүтцийг хүлээлгэн өгөхдөө Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын шаардлагуудыг бүрэн хангасан байна;


2.6.3. төмөр замын суурь бүтцийг байнгын ашиглалтад оруулахдаа бүрэн болон барилга угсралтын зураг төслийн төлөвлөгөөний дагуу хэсэгчлэн хүлээн авч болох ба ажлын зураг төсөл нь өөрчлөгдсөн эсэхийг заавал шалгана;

2.6.4. төмөр замын суурь бүтцийн барилга угсралтын ажил дууссаны дараа захиалагч нь барилга угсралтын ажил дууссан тухай гүйцэтгэгчийн албан ёсны мэдэгдлийн дагуу техникийн комисс томилон ажиллуулна;

2.6.5. техникийн комисс нь ашиглалтад оруулах эсэх тухай шийдвэр /дүгнэлт, акт/-ийг гаргахдаа доорх үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ;

- тухайн төмөр замын суурь бүтэц болон байгууламжуудын батлагдсан зураг төсөл болон түүнд оруулсан өөрчлөлтүүд нь зохих журмын дагуу хийгдсэн, энэхүү журамд заасан нөхцөл шаардлагыг хангаж буй эсэхэд дүн шинжилгээ өгөх;
- гүйцэтгэлийн зураг төсөл болон бусад гүйцэтгэлийн баримтуудад хийсэн дүн шинжилгээ;
- автоматжуулсан зам хэмжилтийн болон сэв шалгагчийн хэмжилтийн үр дүн, байгууламжуудын бүрэн хэмжээний ажиллагаа болон хэсэгчлэн туршсан байдлын хэмжилтийн үр дүн.

2.6.6. захиалагч нь техникийн комиссын шийдвэрийг үндэслэн улсын комисст хүлээлгэн өгөх хүсэлтийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Өргөдөлд Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэмд заасан бичиг баримтууд, мөн зураг төсөлд заасан ажлууд бүрэн хийгдсэн болон энэхүү журамд заасан шаардлагууд



бүрэн хангагдаж байгаа тухай техникийн комиссын дүгнэлт, мөн бусад төрийн хяналтын байгууллагуудын дүгнэлт /галын, байгаль орчны, эрүүл ахуйн гэх мэт/-үүдийг хавсаргана;

2.6.7. улсын комисс нь техникийн комиссын илрүүлсэн зөрчлүүдийг арилгасан эсэхийг болон тухайн байгууламж нь ашиглалтад хүлээн авахад бэлэн эсэхийг заавал шалгах үүрэгтэй;

2.6.8. төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулах шийдвэрт тус комисст оролцсон бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна;

2.6.9. улсын комиссын гишүүдээс өөрийн эрх мэдлийн хүрээнд тухайн байгууламжийг хүлээн авахтай холбоотойгоор гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд комиссын даргад илэрсэн зөрчил шалтгааныг мэдэгдэж дүрэм, журмын заалт зөрчигдсөн болохыг баримтжуулсан дүгнэлтийг танилцуулна;

2.6.10. улсын комиссын заасан хугацаанд тухайн зөрчлийг арилгаагүй бол тухайн байгууламжийг ашиглалтад хүлээн авахгүй байхыг хатуу анхаарч ажиллана;

2.6.11. гүйцэтгэлийн зураг хийгдээгүй төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулахгүй байхыг хатуу анхаарч ажиллана;

2.6.12. байгаль орчинд сөргөөр нөлөөлөх бодисын хаягдал цэвэрлэх байгууламж байхгүй, барилга барих үеийн хог хаягдал, ахуйн хог хаягдлыг зайлуулах, цэвэрлэх арга хэмжээ аваагүй, байгаль орчинд тавигдах шаардлагыг хангаагүй төмөр замын суурь бүтцийн байгууламжийг ашиглалтад хүлээн авахгүй байхыг хатуу анхаарч ажиллана;


2.6.13. байгаль орчинд хор нөлөө үзүүлж буйд хяналт тавих төхөөрөмжгүй, зураг төсөлд тусгагдсан байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлууд дутуу хийгдсэн болон огт хийгдээгүй, барилга угсралтын явцад хөрсний гэмтлийн нөхөн сэргээлт хийгээгүй, хүн амын аюулгүй байдлыг хангаагүй нөхцөлд төмөр замын суурь бүтцийг ашиглалтад хүлээж авахгүй байхыг хатуу анхаарч ажиллана;

2.6.14. төмөр замын суурь бүтцийн бүх байгууламжуудад Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журмын дагуу аюулгүй ажиллагааны гэрчилгээжүүлэлт хийсний дараа зохих журмын дагуу ашиглах тусгай зөвшөөрөл олгоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН АЮУЛТАЙ БҮС, ЗУРВАС ГАЗАР, АЮУЛГҮЙН БҮСЭД ДАГНАСАН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАМ БАРИХ, ӨРГӨТГӨЛ ХИЙХ

3.1. Төмөр замын аюултай бүс, зурвас газар, аюулгүйн бүсэд дагнасан хэрэглээний зам /цаашид "салбар зам" гэх/ барих, өргөтгөл хийх гэж төмөр замын салбар зам барих зөвшөөрөл олгох, зураг төсөл боловсруулах, батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хэлнэ.



3.2. Төмөр замын салбар зам барих зөвшөөрөл олгох:

3.2.1. төмөр замын салбар зам барих, өргөтгөл хийх өргөдлийг энэхүү журмын хавсралтад заасан баримт бичгийн хамт өргөдөл гаргагч нь Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ;

3.2.2. дээрх заалт төмөр замын байгууллагад мөн адил хамаарна;

3.2.3. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өргөдөл гаргагчийн өргөдөл, баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативт нийцэж байгаа эсэхийг хянаж, шийдвэрлэнэ;


3.2.4. төмөр замын салбар зам барих, өргөтгөл хийх асуудлаар дүгнэлт гаргах комиссыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилно;

3.2.5. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь комиссыг ахлах ба түүний бүрэлдэхүүнд суурь бүтэц эзэмшигч байгууллага, иргэний төлөөллийг оролцуулж болно. Салбар замын зориулалт, байршлын онцлогыг харгалзан, комиссын бүрэлдэхүүнд мэргэжлийн бусад байгууллагууд, салбар зам эзэмшигч, өргөдөл гаргагчийн төлөөллийг оруулж болно;

3.2.6. комисс нь өргөдлийг хянах, судлах, дүгнэлт гаргах ажиллагааг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч, сэлгээний үйлчилгээ үзүүлэгч иргэн, байгууллагаас хараат бусаар бие даан хэрэгжүүлнэ;

3.2.7. комисс нь төмөр замын салбар зам барих, өргөтгөл хийх техникийн нөхцөлийг газар дээр нь судлан шалгаж дүгнэлт гаргана. Дүгнэлтэд дараахь асуудлуудыг тусгасан байна:

- салбар зам барих болон өргөтгөлийн ажил нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам, MNS 6229:2010, MNS EN 13848-1,2,3,4,5,6:2016 стандарт, норм нормативын шаардлагад нийцсэн эсэх;
- салбар замыг өртөө, зөрлөгийн замтай холбох боломж, зохистой чиглэл, хувилбар, дайран өнгөрөх салбар замуудын талаарх мэдээлэл;
- дохиолол, холбооны төхөөрөмжийг ашиглах боломж, хувилбар;
- салбар замд суурилуулах шаардлагатай байгууламж, тоног төхөөрөмж;
- төмөр замын суурь бүтцийн одоогийн хүчин чадал, өргөдөлд заасан тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгэх боломж, хэрэгжүүлэх арга хэмжээ, шийдвэрлэх арга зам;
- байршил, ачаа боловсруулалт болон бусад онцлогоос хамаарч зайлшгүй хийх шаардлагатай нэмэлт ажил, байгууламж, технологийн талаарх санал;



- салбар зам, түүний өргөтгөл болон төмөр замын өртөө, зөрлөг, бусад салбар зам хоорондын харилцан ажиллагааны зарчим;
- галт тэрэгний хөдөлгөөн ба ачаа боловсруулалт, сэлгээний ажлын зохион байгуулалтын талаар тээвэрлэгч болон салбар зам эзэмшигч нарт өгөх зөвлөмж, санал, сэрэмжлүүлэг;
- холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тухайн үйл ажиллагаатай холбогдолтойгоор сонсох ажиллагааг явуулсан байх;
- бусад асуудал.

3.2.8. салбар замын ачаа боловсруулалт, өргөдөлд заасан тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгэхийн тулд ашиглагдаж байгаа төмөр замын суурь бүтцийн болон холбогдох бусад замууд, бусдын эзэмшлийн төмөр замын байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, технологийг өөрчлөн шинэчлэх шаардлагатай бол дүгнэлтэд энэ тухай тусгайлан заана.

3.2.9. энэхүү дүгнэлт нь төмөр замын салбар зам барих, өргөтгөл хийх ажлын зураг төсөл боловсруулах үндэслэл болно.

3.3. Салбар замын зураг төсөл боловсруулах:

3.3.1. төмөр замын зураг төсөл боловсруулах эрх бүхий байгууллага /цаашид “Зураг төслийн байгууллага” гэх/ энэхүү журмын 3.2.10-д заасан салбар зам барих, өргөтгөх шийдвэрийг үндэслэн төмөр замын салбар зам барих, өргөтгөл хийх ажлын зураг төслийг мөн өргөдөл гаргагчийн хүсэлтийг үндэслэн төмөр замын салбар замын гүйцэтгэлийн зураг төслийг тус тус боловсруулна;


3.3.2. өргөдөл гаргагч нь зураг төслийн байгууллагыг сонгох эрхтэй;

3.3.3. энэхүү журмын 3.2.9-т заасан ажлын нэмэлт зураг төсөл боловсруулахтай холбоотой зардлыг өргөдөл гаргагч хариуцна;

3.3.4. зураг төслийг Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам, MNSTB 50504:2017, MNSTB 10002:2017 стандарт, норм норматив болон бусад холбогдох эрх зүйн актад нийцүүлэн боловсруулна;

3.3.5. зураг төслийг суурь бүтэц эзэмшигч байгууллага, иргэнтэй болон шаардлагатай тохиолдол /салбар зам нь үерийн далан, бүх төрлийн шугам сүлжээ, нийтийн үйлчилгээний авто зам зэргийг огтлох, аюултай, цэргийн ачаа боловсруулах, хадгалах г.м./-д эрх бүхий бусад байгууллагуудтай зөвшилцсөн байна;

3.3.6. өргөдөл гаргагч нь төмөр замын салбар зам барих, өргөтгөл хийх ажлын зураг төслийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулна;



3.3.7. ажлын зураг төслийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 5 хоногийн дотор хянаж, салбар зам барих, өргөтгөл хийх барилга угсралтын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэр гаргана. Барилга угсралтын ажлыг эхлүүлэхээс татгалзсан бол үндэслэлийг тодорхой заана;

3.3.8. энэхүү журмын 3.3.7-д заасны дагуу олгосон зөвшөөрлийг үндэслэн төмөр замын салбар зам барих, өргөтгөл хийх барилга угсралтын ажлыг эхлүүлнэ;

3.3.9. төмөр замын салбар замын гүйцэтгэлийн зураг төсөл нь салбар замыг гэрчилгээжүүлэх үндэслэл болно.

3.4. Салбар зам барих, өргөтгөх ажил гүйцэтгэх:

3.4.1. төмөр замын салбар зам барих эрх бүхий байгууллага /цаашид “Барилгын байгууллага” гэх/ нь энэхүү журмын 3.3.7-д заасан зөвшөөрлийн дагуу төмөр замын салбар зам барих, эсхүл өргөтгөх барилга угсралтын ажил /цаашид “Барилгын ажил” гэх/-ыг гүйцэтгэнэ;

3.4.2. салбар зам барих, өргөтгөх ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй үед барилгын ажил гүйцэтгэхгүй байхыг хатуу анхаарч ажиллана;

3.4.3. өргөдөл гаргагч барилгын байгууллагыг сонгох эрхтэй;

3.4.4. барилгын ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативт нийцүүлэн гүйцэтгэнэ;

3.4.5. барилгын ажлын явцын хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, стандарт, норм нормативын дагуу төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ;

3.4.6. өргөдөл гаргагч барилгын ажлыг бүрэн гүйцэтгэж дуусмагц салбар замын гүйцэтгэлийн зураг төслийг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлсэн байна.

3.5. Салбар замыг ашиглалтад оруулах:

3.5.1. өргөдөл гаргагч салбар замыг ашиглалтад оруулах хүсэлт /цаашид “хүсэлт” гэх/ гаргахын өмнө салбар зам барих, өргөтгөлийн ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулсан байна;

3.5.2. хүсэлтийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана. Хүсэлтэд төмөр замын салбар замын гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын гүйцэтгэлд шалгалт хийсэн болон шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулсан баримтыг хавсаргасан байна;



3.5.3. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүсэлтийг хянан шийдвэрлэх ажлыг хуанлийн 14 хоногийн дотор шийдвэрлэнэ;

3.5.4. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төмөр замын салбар замыг байнгын ашиглалтад оруулах дүгнэлт гаргах техникийн комисс томилно;

3.5.5. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага комиссыг ахлах ба түүний бүрэлдэхүүнд суурь бүтэц эзэмшигч, ашиглагч байгууллага, иргэн, барилгын, зам засварын байгууллага, салбар замд үйлчлэх тээвэрлэгчийн төлөөллийг хамруулсан байна. Салбар замын зориулалт, байршлын онцлогийг харгалзан, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд мэргэжлийн бусад байгууллагууд, салбар зам эзэмшигч, өргөдөл гаргагчийн төлөөллийг оруулж болно;


3.5.6. комиссын унааны болон үдийн хоолны зардлыг өргөдөл гаргагч хариуцна;

3.5.7. Комисс нь салбар замыг ашиглалтад оруулахдаа энэхүү журам болон бусад MNS 6229:2010 стандарт, нийтлэг багц дүрэмд заасны дагуу газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргана. Дүгнэлтэд дараахь асуудлыг тусгасан байна:

- салбар зам, түүнд суурилуулсан төхөөрөмж, байгууламж, машин механизм холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын шаардлагад нийцэж байгаа эсэх;
- барилгын ажлыг ажлын зургийн дагуу гүйцэтгэсэн эсэх, өөрчилсөн бол шалтгаан, зөв оновчтой хэрэгжүүлсэн эсэх;
- салбар замын гүйцэтгэлийн зураг нь бодит байдалтай нийцэж байгаа эсэх;
- салбар зам нь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх;
- салбар зам нь ачаа боловсруулалт, хадгалалт, ачааны бүрэн бүтэн байдлын шаардлагыг хангаж байгаа эсэх;
- салбар зам нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагад нийцэж буй эсэх;
- галт тэрэгний хөдөлгөөн, ачаа боловсруулалт, сэлгээний ажлуудын зохион байгуулалт, өртөө, зөрлөг, ачааны терминал, бусад салбар зам хоорондын харилцан ажиллагааны технологи;
- зөвлөмж, санал, сэрэмжлүүлэг;
- бусад асуудал.

3.5.8. гүйцэтгэлийн зураг хийгдээгүй төмөр замын салбар замыг ашиглалтад оруулахгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

3.5.9. комисс нь салбар замыг байнгын ашиглалтад оруулах дүгнэлтийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, өргөдөл гаргагчид тус тус хүргүүлнэ. Салбар замыг ашиглалтад оруулахад шаардлагатай нэмэлт ажил, арилгах зөрчлийг дүгнэлтэд тусгасан бол өргөдөл



гаргагч холбогдох арга хэмжээ авч, хэрэгжилтийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана;

3.5.10. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь комиссын дүгнэлт, өргөдөл гаргагчийн тайланг үндэслэн салбар замыг ашиглалтад хүлээн авах эсэх талаар шийдвэр гаргана;

3.5.11. дээрх шийдвэрийг үндэслэн салбар замд тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ олгоно.

3.6. Салбар замыг ашиглах:

3.6.1. төмөр замын зам засвар, арчлалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага /цаашид "Зам засварын байгууллага" гэх/ нь энэхүү журмын 3.4.6-д заасан төмөр замын салбар замын гүйцэтгэлийн зураг төслийг үндэслэн салбар замын байнгын засвар арчлалт, өдөр тутмын хяналтыг хариуцан гүйцэтгэнэ;

3.6.2. өргөдөл гаргагч нь зам засвар арчлалтын байгууллагыг сонгох эрхтэй ба салбар зам засвар, арчлалтын гэрээ байгуулна;

3.6.3. төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага /цаашид "Тээвэрлэгч" гэх/ салбар замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээг үндэслэн тус замд вагон тавих-татах үйлчилгээ /цаашид "сэлгээний үйлчилгээ" гэх/ үзүүлнэ;

3.6.4. төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журмын дагуу тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ олгогдоогүй салбар замд сэлгээний үйлчилгээ, үйл ажиллагаа хийгдэхгүй байхыг хатуу анхаарч ажиллана;

3.6.5. өргөдөл гаргагч тээвэрлэгчийг сонгох эрхтэй;

3.6.6. салбар замын өдөр тутмын ашиглалтын үйл ажиллагааны аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд өргөдөл гаргагч, зам засварын байгууллага, тээвэрлэгч нар хяналт тавина;

3.6.7. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь салбар замын ашиглалтын үйл ажиллагааг түдгэлзүүлэх, зогсоох асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын дагуу шийдвэрлэнэ.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН ЗУРВАС ГАЗАР, АЮУЛГҮЙН БҮСЭД БУСАД ОБЬЕКТ БАЙРЛУУЛАХ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ

4.1. Төмөр замын зурвас газар, аюулгүйн бүсэд бусад объект байрлуулах гэж төмөр замын ашиглалтын үйл ажиллагаатай холбоогүй барилга байгууламж барих зөвшөөрөл олгох, зураг төсөл боловсруулах, батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хэлнэ.

4.2. Төмөр замын зурвас газар, аюултай бүсэд бусад объект байрлуулахдаа Төмөр замын зурвас газрын болон аюулгүйн бүсийн дэглэмийг мөрдлөг болгоно.

4.3. Төмөр замын аюулгүйн бүсэд бусад объект байрлуулахад зөвшөөрөл олгох:

4.3.1. төмөр замын аюулгүйн бүсийн орчим барилга байгууламж барих, өргөтгөл хийх өргөдлийг энэхүү журмын хавсралтад заасан баримт бичгийн хамт өргөдөл гаргагч нь Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ;

4.3.2. дээрх заалт төмөр замын байгууллагад мөн адил хамаарна;

4.3.3. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өргөдөл гаргагчийн өргөдөл, баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, MNS 6060:2010 стандарт, норм нормативт нийцэж байгаа эсэхийг хянаж, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ;

4.3.4. барилга байгууламж барих, өргөтгөл хийх асуудлаар дүгнэлт гаргах комиссыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилно;

4.3.5. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь комиссыг ахлах ба түүний бүрэлдэхүүнд өргөдөл гаргагч, суурь бүтэц эзэмшигч байгууллага, иргэний төлөөллийг хамруулсан байна. Барилга, байгууламжийн зориулалт, байршлын онцлогийг харгалзан, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд мэргэжлийн бусад байгууллагууд, салбар зам эзэмшигч, өргөдөл гаргагчийн төлөөллийг оруулж болно;

4.3.6. комисс нь өргөдлийг хянах, дүгнэлт гаргах ажиллагааг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч, сэлгээний үйлчилгээ үзүүлэгч иргэн, байгууллагаас хараат бусаар бие даан хэрэгжүүлнэ;

4.3.7. комиссын үйл ажиллагааны зардлыг өргөдөл гаргагч хариуцна;

4.3.8. барилга байгууламж барих өргөдөлд дараахь зүйлүүдийг хавсаргана:



- барилгын ажлын төлөвлөгөө, төсөл;
- барилгын үерийн ус зайлуулах зураг төслийг төмөр замын суурь бүтцийн байгууламжийн үерийн ус зайлуулах системтэй уялдуулсан байх;
- магадлан шалгалт хийгдсэн зөвшөөрөл бүхий зураг төсөлтэй байх;
- зураг төслийн бичиг баримтын бусад хавсралт материалууд;
- байр зүйн зураг;
- холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тухайн үйл ажиллагаатай холбогдолтойгоор сонсох ажиллагааг явуулсан байх.

4.4. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах:

4.4.1. энэ хэсэгт төмөр замын аюулгүйн бүсэд баригдах барилгын зураг төслийн нөхцөл, шаардлага, гүйцэтгэх үйл явцыг тодорхойлно;

4.4.2. төмөр замын аюулгүйн бүсэд баригдах барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, MNS 5833:2014, MNS 6029:2010, MNSTB 50504:2017, MNSTB 10002:2017 стандарт, норм нормативын дагуу гүйцэтгэнэ;

4.4.3. зураг төсөлд Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийн дагуу магадлан шинжилгээ хийлгэсэн байна;

4.4.4. зураг төсөл нь доорх нөхцөл шаардлагыг хангасан байна;

- зураг төслийн хуудас бүр дээр хариуцсан инженерээр хянуулж гарын үсэг зуруулсан байна /цахим зураг төсөлд мөн адил хамаарна/;
- зураг төслийг 1:100, 1:200, 1:250-ын масштабтай гүйцэтгэнэ. Мөн барилга барих талбайг оруулаагүй хэсгийг 1:500-н масштабтай гүйцэтгэж болно.

4.4.5. зураг төслийн дэвсгэр хэсэгт доорх зүйлийг байрлуулна:

- зураг төслийн масштаб;
- төмөр замын суурь бүтцийн байгууламж хүртэл зай, хил;
- төмөр замын аюултай бүс, зурвас газар, аюулгүйн бүсийн хил хязгаараас ямар зайд байрлаж байгаа байдал;
- барилгын суурийн хэсгийн зураглал.

4.4.6. зураг төслийн хөндлөн дагуу огтлолын /барилгын өндрийг үзүүлсэн/хэсэгт доорх зүйлсийг байрлуулна:

- зураг төслийн масштаб;
- баригдах байгууламжийн өндрийн хязгаар;



- төмөр замын суурь бүтцийн байгууламжаас шинээр баригдах барилга байгууламж хоорондох өндрийн хамгийн бага зай;
- төмөр замын аюултай бүс, зурвас газар, аюулгүйн бүсийн хил хязгаараас ямар зайд байрлаж байгаа байдал.

4.5. Барилга байгууламж барих, өргөтгөх барилга угсралтын ажил гүйцэтгэх:

4.5.1. барилга байгууламж барих, өргөтгөл хийх өргөдөл гаргагч нь Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэмд заасны дагуу харьяалах хяналтын байгууллагад гаргаж, Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулна;

4.5.2. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газар дээр нь доорх асуудлуудыг судлан шалгаж дүгнэлт гаргана;

- барилга байгууламжийн ажлын зураг, төлөвлөгөө;
- зөвшилцсөн хот байгуулалтын баримт бичиг;
- инженерийн тооцоо;
- ашиглах багаж хэрэгслийн тодорхойлолт, технологийн үйл ажиллагаа;
- ажлын явцын дараалал;
- гэнэтийн нөхцөл үүссэн үед авах арга хэмжээ;
- байр зүйн зургийн урьдчилсан нөхцөл;
- батлагдсан байр зүйн зураг;
- батлагдсан загварын дагуу материал.

4.5.3. шинээр баригдах барилга байгууламж нь төмөр замын суурь бүтцийн хийц болон тээврийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөр бол өргөдөл гаргагчид энэ тухай шийдвэрийг бичгээр мэдэгдэнэ.

4.6. Барилга байгууламжийн батлагдсан зураг төсөлд өөрчлөлт оруулах:

4.6.1. барилга байгууламжийн батлагдсан төлөвлөгөө, зураг төсөлд өөрчлөлт оруулахад доор дурдсан нэмэлт материалыг ирүүлнэ.

- нэмэлт зураг төслийн ажлын зураг;
- инженерийн ажлын төлөвлөгөө.

4.6.2. нэмэлт зураг төсөлд өөрөөр заагаагүй бол батлагдсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах саналд барилгын ажлыг гүйцэтгэгчийг дахин сонгохгүй.

4.7. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

4.7.1. өргөдөл гаргагч барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрмийг мөрдөх ба Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад доорх баримт бичгийг хавсарган өргөдөл ирүүлнэ;



4.7.2. барилгын суурь, барилга байгууламжийн хийцийн гүйцэтгэлийн зураг төсөл /мэргэшсэн инженерээр баталгаажуулсан байх/;

- цахилгаан болон механикийн эд ангиудын гүйцэтгэлийн зураг төслийг хамаарах мэргэшсэн инженерээр баталгаажуулсан байх /төмөр замын суурь бүтцийн хил хязгаар дахь төлөвлөлтөд хамаарах хэсгийг/;
- төмөр замын суурь бүтцийн далангийн хөндлөн огтлол /хамгаалалтын бүс хилийг дуустал/;
- төмөр замын суурь бүтцийн сэтэрхийтэй хөндлөн огтлол /хамгаалалтын бүс хилийг дуустал/;
- гүүрэн дээрх төмөр замын хөндлөн огтлол /хамгаалалтын бүс хилийг дуустал/;
- хөдлөх бүрэлдэхүүний оврын зураг;
- судалгааны ажлын төгсгөлийн тайлан.

4.7.3. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүсэлтийг хянан шийдвэрлэх ажлыг дараахь байдлаар зохион байгуулж, хуанлийн 14 хоногийн дотор шийдвэрлэнэ;

4.7.4. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь комисс томилно;

4.7.5. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь комиссыг ахлах ба түүний бүрэлдэхүүнд өргөдөл гаргагч, суурь бүтэц эзэмшигч, иргэн, барилгын гүйцэтгэгч байгууллагын төлөөллийг хамруулсан байна. Барилгын байгууламжийн ажлын зориулалт, байршлын онцлогийг харгалзан, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд мэргэжлийн бусад байгууллагууд, салбар зам эзэмшигч, өргөдөл гаргагчийн төлөөллийг оруулж болно;

4.7.6. комиссын үйл ажиллагааны зардлыг өргөдөл гаргагч хариуцна;

4.7.7. комисс нь тухайн барилга байгууламж нь төмөр замын суурь бүтцэд нөлөөлөх байдлын дүгнэлт гаргана. Дүгнэлтэд дараахь асуудлыг тусгасан байна:

- барилга байгууламж, түүний хийц загвар, суурилуулсан төхөөрөмж, байгууламж, машин механизм холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын шаардлагад нийцэж байгаа эсэх;
- барилгын ажлыг ажлын зургийн дагуу гүйцэтгэсэн эсэх, өөрчилсөн бол шалтгаан, зөв оновчтой хэрэгжүүлсэн эсэх;
- барилга байгууламжийн гүйцэтгэлийн зураг нь бодит байдалтай нийцэж байгаа эсэх;
- барилга байгууламжнь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх.



ТАВДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН АЮУЛТАЙ БҮС, ЗУРВАС ГАЗАР АЮУЛГҮЙН БҮСЭД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ

5.1. Төмөр замын аюултай бүс, зурвас газарт төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигчид нь тээврийн технологийн зориулалттай ажил, үйлчилгээг Техник ашиглалтын журмын шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

5.2. Төмөр замын тээврийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг төмөр замын аюултай бүс дотор ажил үйлчилгээ эрхлэхгүй байхыг хатуу анхааруулна.


5.3. Төмөр замын зурвас газар аюулгүйн бүсэд байрлах төмөр замын өртөө, буудлын орчинд зорчигч үйлчилгээний зориулалтын шуудан, телефон холбоо, ном хэвлэл, бэлэг дурсгал, хүнсний бараа үйлчилгээний газар, цэгүүд ажиллаж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА


6.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зам, тээврийн хяналт хариуцсан нэгж, мөн төмөр замын байгууллагууд болон тэдгээрийн салбар, нэгжийн удирдлага, дотоод хяналтын нэгж хяналт тавина.

6.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны
11 дүгээр сарын 28 ны өдрийн 264 дүгээр тушаалын
Төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар,
аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект
байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх
журмын хавсралт



ТӨМӨР ЗАМЫН САЛБАР ЗАМ БАРИХ, ӨРГӨТГӨХ ТУХАЙ ӨРГӨДӨЛ, БАРИМТ БИЧИГ

1. Өргөдөл гаргагчийн талаарх мэдээлэл:

- Өргөдөл эсхүл албан бичиг;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ буюу иргэний үнэмлэхийн хуулбар, эх хувийн хамт;
- Оршин суугаа хаяг, утасны дугаар, шуудангийн хаяг;
- Сонсох ажиллагааг явуулсан байх.


2. Салбар замын талаарх мэдээлэл:

- Салбар замын чиг, байршлын бүдүүвч тойм зураг;
- Салбар замын замуудын тоо, багтаамж, төхөөрөмж байгууламж, техник хэрэгсэл;
- Салбар замын ачаа боловсруулах хүчин чадал;
- Салбар замын газрын ашиглалт, эзэмшлийн талаарх баримт бичиг.

3. Тээвэрлэлтийн талаарх мэдээлэл:


- Салбар замын зориулалт, үйлчилгээний ба ачааны нэр, төрөл;
- Ажил үйлчилгээний тойм хэмжээ /дамжуулах буюу боловсруулах вагон, ачаа/.

--- о о о ---



264

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
дүгээр тушаалын арвангурвдугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРЧ БУЙ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ХҮЛЭЭЛЦЭХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх /цаашид “хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх” гэх/-тэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх үйл ажиллагаанд үнэн зөв, шуурхай, ил тод байх, хууль тогтоомжийг сахин мөрдөх зарчмыг баримтална.

1.3. Энэхүү журмыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар /цаашид “Хөдөлгөөн зохицуулалтын төв” гэх/, төмөр замын суурь бүтэц эзэмшигч, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

1.4. Хөдлөх бүрэлдэхүүнд бүртгэл хөтөлж, хүлээлцэн нэвтрүүлэх ажилтан нь Монгол Улсын хууль тогтоомж, багц дүрэм болон энэхүү журмыг дагаж мөрдөж ажиллана.

1.5. Энэхүү журамд хэрэглэх нэр томъёо, тодорхойлолтыг Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төмөр замын техник ашиглалтын журам болон MNS 6387-1,2,3,4:2013 “Төмөр зам, замын, автоматик, телемеханикийн, хөдлөх бүрэлдэхүүний, тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томъёо, тодорхойлолт”-д заасан утгаар ойлгож хэрэглэнэ.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРЧ БУЙ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ХҮЛЭЭЛЦЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэхэд дараахь Олон улсын гэрээ, хэлэлцээр болон хууль тогтоомж, дүрэм, протоколын заалтыг баримтална:

2.1.1. төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон улсын ачааны харилцааны хэлэлцээр”;

2.1.2. төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон улсын зорчигчийн харилцааны хэлэлцээр”;

2.1.3. төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон улсын харилцааны зорчигчийн вагон эдэлгээний дүрэм”;

2.1.4. төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон улсын харилцааны ачааны вагон эдэлгээний дүрэм”;

2.1.5. төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон улсын зорчигчийн галт тэрэгний зурмаг тохирох хурал”-ын протокол;

2.1.6. монгол-Оросын хилийн төмөр замын хамтарсан комиссын зөвлөгөөний протокол;

2.1.7. монгол-Хятадын хилийн төмөр замын хамтарсан комиссын зөвлөгөөний протокол;

2.1.8. монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төмөр замуудын төлөөлөгчдийн зөвлөгөөний протокол;

2.1.9. монгол Улсын хилийн төмөр замын өртөөгөөр тусгай зориулалтын, олон голт, хүнд даацын, хортой аюултай ачаа тээвэрлэх дүрэм;

2.1.10. төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм;

2.1.11. төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журам;

2.1.12. төмөр замаар ачаа тээвэрлэх журам;

2.1.13. зорчигчийн галт тэрэг дамжуулах технологийн процесс;

2.1.14. хилийн төмөр замын өртөөний нэгдсэн технологийн процесс;

2.1.15. хилийн төмөр замын өртөөнд вагонд үзлэг, шалгалт, техникийн үйлчилгээ хийх технологийн процесс;

2.1.16. төмөр замын тээврийн салбарт нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон бусад дүрэм, журам.

2.2. Монгол Улсын төмөр замын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх ажиллагаанд энэхүү журмын 1.3-т заасан иргэн, хуулийн этгээд нь Олон улсын төмөр замын гэрээ, хэлэлцээр, Төмөр замын тээврийн тухай хууль, багц дүрэм болон төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эрх зүйн баримт бичиг, стандарт Монгол Улсын хил, гаалийн байгууллагын холбогдох эрх зүйн акт, хилийн төмөр замын өртөөний техник захирамжийн акт, технологийн процесс зэргийг өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр мөрдөж ажиллана.



2.3. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх ажиллагааг тухайн суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нар харилцан тохиролцон зохион байгуулж, Монгол Улсын хилийн боомт болон хилийн өртөөнд гүйцэтгэнэ.

2.4. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх үйл ажиллагаанд дараахь хуулийг сахин мөрдөнө:

2.4.1. Төмөр замын тээврийн тухай хууль;

2.4.2. Монгол Улсын хилийн тухай хууль;

2.4.3. Захиргааны ерөнхий хууль;

2.4.4 Зөрчлийн тухай хууль.

2.5. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэхэд дараахь стандартын шаардлагыг баримтална:

2.5.1. MNS 5877:2008 “Гол замын ба сэлгээний илчит тэрэгний ялгаруулах хорт бодис болон ажилласан хийн утаажилт. Норм хэмжээ ба тодорхойлох арга”;

2.5.2. MNS 6039:2009 “Илчит тэрэгний техникийн ерөнхий шаардлага”;

2.5.3. MNS 6143:2010 “1520 мм-ийн царигтай Төмөр замын ачааны вагоны хоёр голт тэргэнцэр техникийн ерөнхий шаардлага”;

2.5.4. MNS 6229:2010“ 1520 мм-ийн царигтай Төмөр зам. Техникийн ерөнхий шаардлага”;

2.5.5. MNS 6276:2011 “Төмөр замын ачааны вагон. Техникийн ерөнхий шаардлага”;

2.5.6. MNS 5876:2012 “Төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ. Зорчигчийн галт тэрэг, вагоны үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага”;

2.5.7. MNS 6312:2012 “Төмөр замын зорчигчийн вагон. Техникийн ерөнхий шаардлага”;

2.5.8. MNS 3084:2013 “Ачилт буулгалт ба сэлгээний ажлын үед вагоны бүрэн бүтэн байдлыг хангах ерөнхий шаардлага”;

2.5.9. MNS 5833:2014 “Төмөр замд барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ”;

2.5.10. MNS 6500:2015 “Төмөр замын зорчигчийн вагоны техникийн нөөцийн үнэлгээ. Ерөнхий шаардлага.”;



2.5.11. MNS EN 15273-1,2,3:2016 “Төмөр замын хэрэглээ. Овор. Суурь бүтэц ба хөдлөх бүрэлдэхүүний ерөнхий-нийтлэг дүрэм”;

2.5.12. MNS 6466:2016 “Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ, засвар. Ерөнхий шаардлага”;

2.5.13. MNS 6630-1,2,3,4:2016 “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага.”.

2.6. Монгол Улсын хилийн төмөр замын өртөө нь хөдлөх бүрэлдэхүүнд техникийн болон хил, гаалийн үзлэг, шалгалт хийх нөхцөлөөр бүрэн хангагдсан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРЧ БУЙ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

3.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүн нь дараахь шаардлагыг хангасан байна:


3.1.1. хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэн хүлээлцэх баримт бичиг нь энэхүү журмын 2.1, 2.4, 2.5-д заасан шаардлагыг хангасан байх;

3.1.2. хөдлөх бүрэлдэхүүн нь техникийн байдлыг тодорхойлох техникийн баримт бичиг /гэрчилгээ/-тэй байх;

3.1.3. Монгол Улсын хилээр анх удаа оруулж ирэх хөдлөх бүрэлдэхүүн нь шинэ эсвэл ашиглалтын хугацаа нь үйлдвэрлэгчээс тогтоосон хугацааны 1/3 /гуравны нэг/-ээс хэтрэхгүй байна. Уг хугацаанаас хэтрэхгүй ашигласан хөдлөх бүрэлдэхүүнийг оруулж ирэхдээ эрх бүхий байгууллагаар засвар, оношилгоо хийлгэсэн байх, мөн техникийн болон тээврийн аюулгүй байдлыг хангаж байгааг нотолсон баримт бичгийг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага нь бүрдүүлсэн байна.

3.1.4. суурь бүтэц эзэмшигч нь өөрийн суурь бүтэц дээр явах хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөний аюулгүй болон техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллана.

3.2. Монгол Улсын хилээр шинээр оруулан ирж, төмөр замын тээвэрт ашиглах хөдлөх бүрэлдэхүүний техникийн нөхцөл, шаардлага, дугаарлалт, тэмдэг



тэмдэглэгээ нь энэхүү журамд заасан хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэн, хүлээлцэхэд мөрдөх баримт бичгийн шаардлагыг хангасан байна.

3.3. Энэхүү журмын шаардлагыг хангаагүй хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын төмөр замын тээврийн хөдөлгөөнд оролцуулахгүй байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН НЭВТРҮҮЛЭХ, БҮРТГЭЛ ХӨТЛӨХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Иргэн, хуулийн этгээд нь шинээр худалдан авах, түрээслэх хөдлөх бүрэлдэхүүний талаарх дараахь мэдээллийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхээс 14 хоногийн өмнө Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад /баримт бичгийг/ ирүүлсэн байна:

4.1.1. хөдлөх бүрэлдэхүүн шинээр худалдан авах, түрээслэх иргэн, хуулийн этгээдийн дүгнэлт гаргуулах тухай албан хүсэлт;

4.1.2. иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.1.3. хөдлөх бүрэлдэхүүний төрөл, хийц, бүдүүвч, овор болон гэрэл зураг, үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн үзүүлэлт, ашиглах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон баримт бичиг;

4.1.4. хөдлөх бүрэлдэхүүнд засвар, оношилгоо үйлчилгээ хийгдсэн байдлыг тодорхойлсон баримт бичиг, техникийн байдлын талаарх дүгнэлт, гэрчилгээ;

4.1.5. худалдан авах болон түрээслэхтэй холбоотой гэрээний хуулбар;

4.1.6. хөдлөх бүрэлдэхүүнийг шинээр худалдан авах, түрээслэх, ашиглах иргэн, хуулийн этгээд нь Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, суурь бүтэц эзэмшигч болон техникийн засвар оношилгоо үйлчилгээг хариуцан гүйцэтгэх байгууллагаас зөвлөгөө авч болно.

4.2. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичиг, холбогдох мэдээллийг үндэслэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж, хөдлөх бүрэлдэхүүн нь техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлын стандарт, дүрэм, журмын шаардлагад хэрхэн нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргана.



4.3. Дүгнэлтийг ажлын хэсгийн олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд эсрэг саналтай гишүүд энэ тухайгаа дүгнэлтэд тусгаж, гарын үсэг зурсан байна. Дүгнэлтэд заагдсан шийдвэр нь хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын төмөр замын тээвэрт ашиглах эсэхийн үндэслэл болно.

4.4. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч байгууллагаас Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний талаарх шаардлагатай бүртгэл, мэдээ, тайланг тухай бүрт нь шуурхай, цахим хэлбэрээр болон албан бичгээр авч, нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж, хөтөлж ажиллана.

4.5. Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, тээвэрлэгч нар нь Монгол Улсын хилээр нэвтэрч буй галт тэрэгний бүрэлдэхүүний бүдүүвчид техникийн болон тээвэрлэлтийн нөхцөлөөс хамааран өөрчлөлт оруулах тохиолдолд техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулан явуулах, мөн Хөдөлгөөн зохицуулалтын төвд мэдэгдсэн байна.

4.6. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний хийцэд өөрчлөлт оруулсан тохиолдолд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлгөөн зохицуулалтын төвд тус тус мэдэгдэж, гэрчилгээнд тэмдэглэл хийлгэж, ашиглалтын үеийн найдвартай ажиллагааг хангуулсан байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРЧ БУЙ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ХҮЛЭЭЛЦЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэхдээ суурь бүтэц эзэмшигч нь энэхүү журмын 5.2.1-5.2.3-т заасан баримт бичгийг хөтөлнө.

5.2. Олон улсын ачаа тээврийн харилцааны дагуу хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэхдээ суурь бүтэц эзэмшигч болон тээвэрлэгч нь Олон улсын ачааны харилцааны хэлэлцээр болон Олон улсын харилцааны ачааны вагон эдэлгээний дүрмийг баримтлах бөгөөд дараахь баримт бичгийг хөтөлж ажиллана:

5.2.1. галт тэрэгний биечилсэн хуудас /энэхүү журмын нэгдүгээр хавсралт/;

5.2.2. хөдлөх бүрэлдэхүүн дамжуулах хүснэгт /энэхүү журмын хоёрдугаар хавсралт/;



5.2.3. зүтгүүрийн машинчийн замналын болон зүтгүүрийн хуудас /энэхүү журмын гуравдугаар хавсралт/.

5.3. Монгол Улсын хилээр нэвтэрч буй Олон улсын зорчигчийн галт тэргийг хилийн төмөр замын өртөөн дээр үзлэг, шалгалт, техникийн үйлчилгээг хийж, хөдөлгөөний нэгдсэн зурмаг, цагийн хуваарийн дагуу хүлээлцэнэ.

5.4. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг хийсний дараа вагон дамжуулах хүснэгтэд хоёр талын хилийн өртөөний холбогдох төмөр замын ажилтан гарын үсэг зурсан цаг минутаас эхлэн хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцсэнд тооцно. Орох хилийн өртөөнөөс цааш аялахгүй зүтгүүрийг бүртгэхгүй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

6.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлгөөн зохицуулалтын төв, төмөр замын суурь бүтэц эзэмшигч нар тус тусын эрх, чиг үүргийн хэмжээнд хяналт тавина.

6.2. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт, шийдвэрийг үндэслэн Монгол Улсын хилээр анх удаа нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгож, мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, хадгална. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр мэдээллийг ирүүлж ажиллана.

6.3. Суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, тээвэрлэгч нь Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журамд заасны дагуу ашиглагдаж байгаа, мөн нөөцөд шаардлагатай, хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын тайлан, судалгааг улирал бүрээр болон жилээр гаргаж, Хөдөлгөөн зохицуулалтын төвд ирүүлж, тус төв нь тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулан хяналт тавина.

6.4. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын төмөр замын тээвэрт шинээр нэвтрүүлэх, мөн ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүний техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавина.



6.5. Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, захиалагч нь Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг Олон улсын болон төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй журам, заавар, технологийн дагуу засвар, үзлэг, үйлчилгээнд хамруулж түүний техникийн болон тээврийн аюулгүй байдлыг бүрэн хариуцан ажиллана.

6.6. Монгол Улсын хилийн боомтын төмөр замын хилийн өртөөгөөр нэвтрүүлэх хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх үйл ажиллагаа нь энэхүү журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд Хөдөлгөөн зохицуулалтын төв хяналт тавьж ажиллана. Гэмтэл, эвдрэлтэй хөдлөх бүрэлдэхүүнийг нэвтрүүлэх тохиолдолд Олон улсын харилцааны ачааны вагон эдэлгээний дүрмийн гаргасан техникийн байдлын тодорхойлолт, тээвэрт хэрхэн оролцуулах талаар гаргасан дүгнэлт, баримт бичгийн бүрдүүлэлт, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, тээвэрлэгч нарт олгосон санамж, зөвлөмж зэрэгт хяналт тавина.

6.7. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о 0 о ---



ГАЛТ ТЭРЭГНИЙ БИЕЧИЛСЭН ХУУДАСНЫ АРЫН НҮҮР

Галт тэрэгний бүрэлдэхүүн, жин, урт

Вагоны дугаар	Найруулсан өртөөний нэр				Бүрэлдэхүүн өөрчилсөн өртөөний нэр			
	4 голт		8 голт		4 голт		8 голт	
	Ачаа	Хоосон	Ачаа	Хоосон	Ачаа	Хоосон	Ачаа	Хоосон
	Битүү вагон							
Тавцан вагон								
Хагас вагон								
Цистерн вагон								
Ледник								
Чингэлэг тээгч тавцан								
Тогтмол дулаант вагон								
Хоппер								
Суудлын вагон								
Бусад вагон								
ДҮН								
Галт тэрэгний жин /тонноор/	Сав	Цэвэр	Бохир		Сав	Цэвэр	Бохир	
Галт тэрэгний урт, томъёолсон вагоноор				Томъёолсон урт				

Галт тэрэгний эхний вагон №		Галт тэрэгний эхний вагон №	
Сүүлийн вагон №		Сүүлийн вагон №	

Гарын үсэг


Гарын үсэг


ДСП.....

ДСП.....

Тех. Конт

Тех. конт.....





Зам, тээврийн хөгжлийн сайдын
 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
 264 дүгээр тушаалын Монгол Улсын хилээр нэвтэрч
 буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх,
 хүлээлцэх журмын хоёрдугаар хавсралт

ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН ДАМЖУУЛАХ ХҮСНЭГТ

..... өртөөнөөс өртөөнд №- р галт тэргээр
 хүлээлгэн өгөх хөдлөх бүрэлдэхүүний мэдүүлэг

..... он дугаар сарын-ны өдөр

Д/д	Замын эхний үсгүүд		Хөдлөх бүрэлдэхүүний дугаар	Хөдлөх бүрэлдэхүүний төрөл		Голын тоо	Ачаатай эсхүл хоосон	Өртөөний нэр	Хүлээн авагч
	нэр	шифр		нэр	шифр				
1									
2									
3									
4									
5									
6									
7									
8									
9									
10									
...									
n									

Хүлээлгэн өгөгч төмөр замын агент агент

Хүлээн авагч төмөр замын

Гарын үсэг

Гарын үсэг


Хүлээлгэн өгөгч төмөр замын тамга тамга

Хүлээн авагч төмөр замын

Хүлээлгэн өгөгч төмөр зам

Хүлээн авагч төмөр зам





Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн
264 дүгээр тушаалын Монгол Улсын хилээр нэвтэрч
буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх,
хүлээлцэх журмын гуравдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН БООМТООР НЭВТРҮҮЛЭХ ЗҮТГҮҮРИЙН МАШИНЧИЙН ЗАМНАЛЫН ХУУДАС

... он ... дугаар сарын ...-ны өдөр

Замналын хуудасны		I бүлэг. Зүтгүүр ба зүтгүүрийн бүрэлдэхүүний тухай				Туслах машинчийн нэр		II бүлэг. Зүтгүүрийн бригад бэлтгэлээр явсан тухай																
Бригад	Депогийн код	Серийн индекс	Серийн код	Зүтгүүрийн дугаар	Маяг ТУ-ЗТТ	Машин чийн нэр	Туслах машинчийн нэр	Галт тэрэгний дугаар	Явуулах өртөө	Явах цаг	Очих өртөө	Очих цаг	Тушаалын дугаар	Албан тушаал	Гарын үсэг									
																Зүтгүүрийн данслагдсан депо нээсэн ...он ... сар ...өдөр	Табелийн дугаар код	Табелийн дугаар код						
III бүлэг. Зүтгүүрийн бригадын ажил амралын цагийн тухай																								
Зүтгүүрийн бригадын ажилд ирсэн цаг, минут	Зүтгүүр түлш хүлээн авсан цаг, минут	Шалгах цэгээр өнгөрсөн цаг, минут	депо гарсан ос	депо орсон	Зүтгүүр түлш хүлээлгэн өгсөн цаг, минут	Зүтгүүрийн бригадын ажил дүүссэн цаг, минут	Зүтгүүрийн бригадын амарсан цаг	Нөхөлт (минутаар)	Техникийн хурд	Төлөвлөгөө	Биелэлт	Түүш орчуулагч		Явалтын төрлийн код	Зүтгүүрийн депогийн код	Серийн индекс	Серийн код	Зүтгүүрийн дугаар	Очсон өртөө	Явсан өртөө	Хий шахуурын тос	Гарын тос	Бусад тос	Арчих материал
												Табелийн дугаар	Гарын үсэг											
Аялалын өмнө түлш хүлээлцсэн машинчдын	Гарын үсэг	Хүлээн авсан түлш	Хүлээлгэн өгсөн түлш	Аялалын хойно түлш хүлээлцсэн машинчдын	Зөхсөн түлш	Агуулахын нэр	Түгээгч	Хоно-гийн шаардах хуудасны дугаар	Зөхсөн хугацаа	Эхэлсэн	Дууссан	Зүтгүүрийн дугаар	Секцийн ажлын шинж	Гарын тос	Хий шахуурын тос	Бусад тос	Арчих материал							
																		Табелийн дугаар	Гарын үсэг	өмнө	хойно	Табелийн дугаар	Гарын үсэг	

Тайлбар: Монгол Улсын хилээр нэвтэрч буй галт тэргийг зүтгүүрээр хангаж буй суурь бүтэц эзэмшигч, аж ахуйн нэгж, байгууллага нь зүтгүүрийн техникийн байдал, засвар үйлчилгээг бүрэн хармуцаж, ашиглалтын үед зүтгүүрийн бригад техникийн найдвартай ажиллагааг хангаж, ашиглалтын дэглэмд хяналт тавьж, цагийн хуваарийн дагуу ажиллана.

Хилийн өртөөний оператор:
Хилийн өртөөний ажилтан:

..... /
..... /
..... /

Зүтгүүрийн машинч:



Зам тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 28 ны өдрийн
264 дүгээр тушаалын арвандөрөвдүгээр хавсралт

1118268363 5919487 6679512

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ШУУД ХОЛБООТОЙ АЖИЛТНЫ САХИЛГЫН ТУСГАЙ ЖУРАМ, АЖЛЫН ЦАГИЙН ХУВААРЬ, ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Төмөр замын тээврийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төмөр замын тээврийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, галт тэрэгний хөдөлгөөний технологийн горимыг сахин биелүүлэхэд төмөр замын тээврийн нийт ажилтан болон галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилга, ажил амралтын хуваарийг зохицуулах, хөдөлмөрийн нөхцөл, сахилга, дэг журам тогтооход оршино.

1.2. Энэхүү журмын хамрах хүрээ нь төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан /цаашид ажилтан гэх/ дагаж мөрдөнө.


1.3. Энэхүү журамд хэрэглэгдсэн нэр томьёо, тодорхойлолтыг Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон MNS 6387-1,2,3,4:2013 “Төмөр зам, замын, автоматик, телемеханикийн, хөдлөх бүрэлдэхүүний, тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томьёо, тодорхойлолт” стандартад заасан утгаар ойлгож хэрэглэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЖИЛТНУУДЫН НИЙТЛЭГ ҮҮРЭГ

2.1. Төмөр замын тээврийн нийт ажилтан нь дор дурдсан үүргийг ханган биелүүлж ажиллана.

2.1.1. төмөр замын тээврийн тухай хууль, багц дүрмийг чанд биелүүлэх, техник хэрэгслийг технологийн горим, стандартын шаардлагын дагуу ашиглах,



зорчигчийн аялах аятай нөхцөлийг бүрдүүлэх, ачаа, тээш, ачаан тээшийг бүрэн бүтэн тээвэрлэх, үйлчлүүлэгчийн тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээ ба галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг найдвартай бүрэн хангах, хүрээлэн буй орчинд хохирол учруулахгүй байх;

2.1.2. ажилтан нь багц дүрмийн шаардлага, төмөр замын тээврийн тасралтгүй, найдвартай, аюулгүй үйл ажиллагааг хангахад чиглэсэн өөрийн чиг үүргийг биечлэн гүйцэтгэх;

2.1.3. төмөр замын байгууллагын ажилтнаас багц дүрмийг сахин биелүүлэх шаардлага тавих үүргийг ажил олгогч, ажил удирдагч хариуцах;

2.1.4. хүний эрүүл мэнд, амь нас, хөдөлгөөний аюулгүй байдал болон тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хохирол учруулахуйц эвдрэл, гэмтэл, саад илэрвэл нэн даруй галт тэрэгний болон сэлгээний хөдлөх бүрэлдэхүүнийг зогсоох, уул саадтай газрыг хааж хамгаалах, гэмтлийг түргэн засаж арилгах арга хэмжээ авах;

2.1.5. төмөр замаар үйлчлүүлэгчийн аюулгүй байдал болон ажиллагааг бүрэн хангаж эелдэг, уриалгахан хөнгөн шуурхай, чанартай, хүртээмжтэй үйлчилж, тэднээс төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, стандарт, норм норматив, технологийн горимыг сахин биелүүлэхийг шаардах;

2.1.6. албан үүргээ гүйцэтгэхдээ тухайн байгууллагаас тогтоосон дүрэмт хувцас, ялгах тэмдэг, мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлагын үүднээс олгогдсон хамгаалах хэрэгсэл, ажлын тусгай хувцасыг зориулалтын дагуу хэрэглэх;

2.1.7. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон галын аюулгүй байдлыг хангах дүрэм, журам, стандарт, норм, нормативыг мөрдөж ажиллана. Тухайн аж ахуйн нэгжийн удирдлага эдгээр дүрэм, журмын биелэлтийг бүрэн ханган, хариуцах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГАЛТ ТЭРЭГНИЙ БОЛОН СЭЛГЭЭНИЙ ХӨДӨЛГӨӨНТЭЙ

ШУУД ХОЛБООТОЙ АЖИЛТНЫ ҮҮРЭГ

3.1. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан нь дор дурьдсан үүргийг хэрэгжүүлнэ:



3.1.1. тухайн ажил үүрэгтэй холбоотой Олон улсын гэрээ, Монгол Улсын хууль тогтоомж, Төмөр замын тээврийн тухай хууль, багц дүрэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон галын аюулгүй ажиллагааны стандарт, зааврыг судалж үйл ажиллагаандаа дагаж мөрдөх;

3.1.2. галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан нь батлагдсан ажил мэргэжлийн дүрэм, журам, стандартаар зохих сургалтад хамрагдаж, мэргэжил дээшлүүлж, шалгалт өгч тэнцсэн байх:


- Монгол Улсын төмөр замын тээврийн тухай хууль;
- Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм;
- Ажлын байрны тодорхойлолт болон тэдний үүргийг тогтоосон бусад баримт бичиг;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, дүрэм, журам.

3.1.3. вагон болон чингэлэгт ачаа ачих, бэхлэх, ачилт буулгалтын ажил хариуцсан ажилтан нар нь хөдлөх бүрэлдэхүүнд ачаа ачих, бэхлэх техникийн нөхцөлийн талаар шалгалтад бүрэн хамрагдсан байна;

3.1.4. галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтнаас бусад ажилтан нь төмөр замын тээврийн ажилтны нийтлэг үүргийг мэдэж байхаас гадна хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам, норм норматив, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг бүрэн хангасан байна;

3.1.5. галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой нэмэлт ажил, үүрэг гүйцэтгэхээр албан тушаал хавсрах, ажил, мэргэжил хослох, түр эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгүүлэхэд тогтоосон дүрэм, журмын дагуу сургалтад хамрагдаж, шалгалт өгсөн төмөр замын тээврийн ажилтанг томилон ажиллуулах;

3.1.6. галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдал, мөн ажиллагааг бүрэн хангаж, хөдөлгөөний зурмагийг чанд биелүүлэх, галын аюулгүй байдлыг хангах, зорчигчийг эрүүл, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, зорчигч, ачаа, ачаан тээшийг цаг тухайд нь тээвэрлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх, галт тэрэгний зурмагийг мөрдөх;



3.1.7. хөдлөх бүрэлдэхүүний жолоодлогын бүхээг болон хөдөлгөөний аюулгүй байдал, мөн ажиллагааг хангахтай холбогдсон дохио, сум, аппарат, хэрэгсэл, механизм мөн түүнчлэн дээр дурдсан тоног төхөөрөмжийг удирдан ажиллуулдаг байранд зохих эрхгүй хүнийг нэвтрүүлэхгүй байна;

3.1.8. зохих эрхтэй ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ зүтгүүр, төмөр замаар өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүн ба хөдлөх нэгжийг жолоодох болон хөдөлгөөний хэвийн ажиллагаа хангахтай холбогдсон дохио, сум, аппарат, хэрэгсэл, механизмыг стандарт болон технологийн горимын дагуу ажиллуулах;

3.1.9. харьяалал болон өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч зүтгүүр, моторт вагон, галт тэрэг, өөрөө явагч бусад хөдөлгөөнт нэгжийг жолоодох, тэдгээрийн хөдөлгөөнийг удирдах төмөр замын ажилтан нь мэргэжлийн сургалтын байгууллага /төв/-д бэлтгэгдэж, эрхийн үнэмлэх авсан байна;

3.1.10. зохих журмын дагуу дадлагажигч ажилтанг зүтгүүр, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүн ба хөдлөх нэгжийг жолоодох болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дохио, сум, аппарат, бусад механизмыг эрх бүхий ажилтны хяналт дор жолоодох, ажиллуулахыг зөвшөөрнө;

3.1.11. төмөр замын байгууллага, нийтийн болон дагнан хэрэглээний зам эзэмшигч нь галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой үйл ажиллагаа явуулдаг ажилтнуудад техникийн сургалт явуулах, мэргэжил дээшлүүлж, мөн давтан сургаж мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй;

3.1.12. зүтгүүрийн бригад, галт тэрэгний зохицуулагч, өртөөний жижүүр, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний бригадын ажилтанг мэргэжлээр нь давтан сургаж мэргэшүүлэн мэргэжлийн зэрэг дэв олгож, мэргэжлийн ур чадвараар нь сонгон шалгаруулан авч ажиллуулна;

3.1.13. мэргэжлийн сургалтад хамрагдаж, төмөр замын тээврийн хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмаар шалгалт өгсөн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон Эрүүл мэндийн үзлэг хийх журмын дагуу эрүүл мэндийн үзлэгт орж тэнцсэн, 18 насанд хүрсэн иргэнийг галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил, албан тушаалд энэхүү журмын нэгдүгээр болон хоёрдугаар хавсралтад заасан албан тушаалд томилон ажиллуулна;



3.1.14. галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны ажлын байр нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлагад бүрэн нийцсэн байна;

3.1.15. багц дүрмийн мэдлэгээ сайжруулж, техникийн зохих сургалтад хамрагдаж, мэргэжлийн ур чадвараа байнга нэмэгдүүлж, техник ашиглалт, аюулгүй ажиллагааны арга барил эзэмшсэн байх;

3.1.16. байгууллагын удирдлага, шууд харьяалах албан тушаалтан, ажлын ахлагч нарын албан үүргийн хүрээнд өгсөн тушаал, заавар, зааварчилгааг цаг тухайд нь бүрэн гүйцэд биелүүлэх, тухай бүр хариу илтгэж байх;

3.1.17. хариуцсан объектод байнга үзлэг, үйлчилгээ хийж байх ба хүний эрүүл мэнд, амь насанд аюул учирч болзошгүй нөхцөл бүрдсэн, байгууламж, төхөөрөмжид илэрсэн эвдрэл, гэмтэл, хэвийн бус ажиллагаа болон түүнд хүргэж болзошгүй нөхцөл байдлын талаар тухай бүрд нь дээд шатны удирдах албан тушаалтан, холбогдох ажилтанд шуурхай мэдэгдэх;

3.1.18. эрхэлсэн ажилтай нь холбогдуулан олгосон ажлын тусгай болон дүрэмт хувцас, бие хамгаалах болон дохионы хэрэгслийг багц дүрэмд зааснаар зориулалтын дагуу хэрэглэх;

3.1.19. галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, хөдөлгөөний зурмагийг чанд биелүүлж ажиллах, мөн хөдөлгөөнийг оновчтой, шуурхай зохион байгуулах;

3.1.20. зорчигчийн ая тухтай зорчих нөхцөлийг хангах, ачаа, тээш, ачаан тээшний бүрэн бүтэн байдал, төмөр замын байгууллагын эд хөрөнгө, сэлбэг материалыг арчлан хамгаалах;

3.1.21. албан үүргээ гүйцэтгэж байхдаа албан ярианы дэглэмийг баримталж ажиллах;

3.1.22. харилцагч байгууллага, иргэдийг тээвэрлэлт, ажил, үйлчилгээтэй холбогдолтой үнэн зөв мэдээллээр хангаж, хөнгөн шуурхай, соёлтой боловсон үйлчилж, ажил үйлчилгээний болон галт тэрэгний цагийн хуваарийг чанд баримтлах;

3.1.23. тогтоосон хугацаанд эрүүл мэндийн үзлэгт орсон байх;



3.1.24. авлига, хээл хахууль, шан харамж авах, өгөх, өгөхийг шаардах, танил тал харах, үйлчлүүлэгчид тэгш бус хандаж, аль нэгэнд нь давуу эрх олгох зэргээр төмөр замын байгууллагын нэр хүндэд харшлах үйлдэл гаргахгүй байх;

3.1.25. хүний эрүүл мэнд, амь насанд аюул учирч болзошгүй нөхцөл бүрдсэн, ачаа, тээш, ачаан тээшинд эвдрэл, гэмтэл гарсан, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад саад тохиолдвол хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээ авах, байгууламж, төхөөрөмжид эвдрэл, гэмтэл илрүүлбэл тухайн осолтой газрыг хааж хамгаалах, засварлах арга хэмжээг яаралтай авч байх, мөн мэдээлэх;

3.1.26. байгалийн гамшиг, сүйрэл, осол, гологдлын хор уршгийг арилгах ажилд оролцуулахаар дуудсан тохиолдолд анхны дуудлагаар ажлын байранд хүрэлцэн ирэх, зааварчилгааны дагуу ажил гүйцэтгэх;

3.2. Төмөр замын ажилтныг шууд харьяалах албан тушаалтан, ажлын ахлагч ажилтан нь дор дурдсан нэмэлт үүрэгтэй:


3.2.1. тушаал, шийдвэр, заавар, үүрэг даалгаврыг хуулийн хүрээнд тодорхой, ойлгомжтой өгөх, гүйцэтгэлийг бүрэн хангуулах, хянах, шалгах, шуурхай холбогдох арга хэмжээг авах, тайлагнах, мэдээлэх;

3.2.2. хууль бус үйл ажиллагаа илэрвэл цаг алдалгүй таслан зогсоож, байгууллага эсвэл нэгжийн удирдах албан тушаалтанд мэдэгдэж, өөрийн эрх, үүргийн хүрээнд холбогдох арга хэмжээ авах;

3.2.3. ээлж хүлээн авах, ажил хэвийн гүйцэтгэх нөхцөл бүрдээгүй үед ээлж хүлээлцэх шийдвэр гаргасан удирдах ажилтан нь түүнээс үүдэн гарах хариуцлагыг хүлээнэ;

3.2.4. ажлын байр эзэнгүй орхих, ажлын байранд унтах, бусадтай ажилтай холбогдолгүй яриа өрнүүлэх зэргээр ажил цалгардуулах, дутагдлыг нуун дарагдуулах, эвлэрэн хаацайлах зэрэг зөрчил гаргахгүй байна;

3.2.5. ажлын байранд ажил гүйцэтгэхэд саад болох техник хэрэгсэл, эд материал /зөвшөөрөгдсөнөөс бусад/ хадгалахгүй, мөн гадны хүн байлгахгүй байна.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

4.1. Төмөр замын тээврийн байгууллага нь Төмөр замын тээврийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох эрх зүйн актад заасны дагуу дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1. төмөр замын тээврийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан багц дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт зэргийг ажилтанд танилцуулж, судлуулах, мэргэжлийн сургалт явуулах, зааварчилгааг тогтоосон журмын дагуу өгөх, эрхийн болон мэргэжлийн зэргийн үнэмлэхтэй иргэнийг ажиллуулах;

4.1.2. ажилд шинээр орох иргэн болон ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулж, эрүүл мэндээр тэнцсэн ажилтанг ажиллуулах;

4.1.3. ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангахад зориулсан хөрөнгийг жил бүрийн үйлдвэрлэл-санхүүгийн төлөвлөгөө, хамтын гэрээнд тусгаж, зарцуулах;


4.1.4. ажилтныг албан үүргээ биелүүлэхэд шаардагдах ажлын онцлогт тохирсон, хөдөлмөрлөх нөхцөлийг хангасан ажлын байр, техник хэрэгсэл, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах бодис, хоол, хүнс, ариутган цэвэрлэх бодисоор хангах;

4.1.5. үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналт шалгалтыг тогтмол явуулах;

4.1.6. үйлдвэрлэл, үйлчилгээнд гарсан технологийн болон бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, сүйрэл, осол, гологдол, зөрчил гарсан шалтгааныг бүрэн тогтоож, арилгахаар авсан арга хэмжээний тухай мэдээллийг хамт олонд тухай бүр өгч, давтагдан гарахаас урьдчилан сэргийлж байх;

4.1.7. галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилд хоёроос дээш ажилтан ажиллаж байгаа нөхцөлд аль нэгийг нь ахлуулан ажиллуулах,

4.2. Технологийн тасралтгүй ажиллагаатай байгууллагын ажилтны ээлж солилцоход дор дурдсан нөхцөлийг хангасан байна:



4.2.1. дараагийн ээлжинд хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, бэлтгэлийг бүрэн хангуулах;

4.2.2. ажлын цаг дуусахаас өмнө тухайн ээлжинд гүйцэтгэсэн ажлын тоон болон чанарын үзүүлэлтийг шалгах;

4.2.3. ажилтан ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд түүнийг ажлаас түр чөлөөлж, өөр ажилтныг томилох болон шаардагдах бусад арга хэмжээг авах;

4.2.4. байгалийн гамшиг, сүйрэл, осол, гологдол гарсан эсхүл гарч болзошгүй нөхцөл бүрдсэн тохиолдолд ээлж солилцуулахыг түр хойшлуулж, тухайн ажлын байранд аюулгүй ажиллах нөхцөл бүрдсэний дараа гүйцэтгэх;

4.2.5. ээлж солилцох, ажил хүлээлцэх үед хариуцсан хөдлөх бүрэлдэхүүн, тоног төхөөрөмж, хатуу тооцоот болон бусад багаж хэрэгсэл бүрийг биечлэн үзэж хүлээлцэх;

4.2.6. ээлж хүлээлцэх тогтоосон нөхцөл бүрдээгүй үед ээлж хүлээн авсан бол түүнээс үүдэн гарах хариуцлагыг ээлж хүлээн авагч хариуцах.

ТАВДУГААР БҮЛЭГ АЖИЛТНЫ АЖИЛ, АМРАЛТЫН ДЭГЛЭМ

5.1. Ажилтны ажил, амралтын дэглэм нь дараахь үндсэн шаардлагыг хангасан байна:

5.1.1. хөдөлмөрийн болон хамтын гэрээнд заасан долоо хоногийн ажлын цаг, ердийн ажлын өдрийн үргэлжлэх цаг, ээлжийн ажлын хоногт үргэлжлэх хугацаа, ээлжийн ажлын эхлэх, дуусах цаг, завсарлага, амралтын өдөр нь Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн байна;

5.1.2. тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтныг галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт зохицуулан ажиллуулах ба ажлын цаг нь тухайн сард ажиллавал зохих ажлын цагаас ихгүй байна;

5.1.3. ээлжийн хуваариар ажилладаг ажилтны жинхэнэ ажилласан цаг нь ажлын ачаалал, зурмагийн зохицуулалтаас хамааран тухайн сард ажиллавал зохих



ажлын цагт хүрэхгүй тохиолдолд нэмэлт ажил, үүргийг гүйцэтгүүлж болох ба ажлын цагийг нь нэгтгэн бодно;

5.1.4. ажлын онцлогийг харгалзан тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ажилладаг ажилтныг шөнийн ээлжинд 2-оос илүү удаа дараалан ажиллуулахгүй байхыг хатуу анхаарч ажиллана;

5.1.5. ажилтныг ээлжинд ажиллуулахдаа Хөдөлмөрийн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3 хэсэгт заасан шаардлагыг мөрдөнө;

5.1.6 ажилтны ээлжийн хуваарь зөрчигдсөн тохиолдолд дуудлагаар ажиллуулж болно. Дуудлагаар ажиллуулахыг Хөдөлмөрийн дотоод журамд тодорхой заасан байна.

5.2. Ажлын цаг:

5.2.1. зорчигчийн болон тусгай үйлчилгээний галт тэрэг, зүтгүүрийн, зам засварын, тусгай хөдлөх бүрэлдэхүүний бригадын ажлын цагт дараахь хугацаа хамаарна;

5.2.2. ажилд бэлтгэх, зааварчлага авах, зүтгүүрийн бригад шалгалт өгөх хугацаа:

- аяллын өмнөх болон дараахь эмчийн үзлэгт хамрагдах хугацаа;
- аяллын болон ажил гүйцэтгэсэн хугацаа;
- ажил хүлээлцэх болон хүлээсэн хугацаа;
- зүтгүүрийн бригад зорчигчоор аялах хугацаа болон хүлээсэн хугацаа;
- сорил тавьсан хугацаа зэргийг ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогч тогтоож өгнө.

5.2.3. ажилтны тасралтгүй ажиллах хугацаа нь 8 цагаас ихгүй байна. Хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцсон бол 4 хүртэл цагаар нэмэгдүүлж болно;

5.2.4. ачаа, зорчигчийн галт тэрэгний машинчийн тасралтгүй ажлын цаг нь туслах машинчгүй үед 8 цагаас ихгүй байна. Хоёр дараалан шөнийн цагаар туслах машинчгүйгээр ажиллуулахгүй;

5.2.5. зорчигчийн галт тэрэгний зүтгүүрийн бригад дараалан хоёроос дээш удаа шөнийн цагаар ажиллуулахгүй байна. Энэ шаардлага нь эргэлтийн депо, амрах байраас буцаж байгаа болон зорчигчоор аялж байгаа зүтгүүрийн бригадад хамаарахгүй;



5.2.6. сэлгээний бригадыг ээлж солилцохоос 30 минутын өмнө өөр өртөөнд ажиллуулахаар явуулахгүй байна;

5.2.7. зүтгүүр, зорчигчийн галт тэрэгний бригадын цагийг үндсэн байрнаас эргэлтийн байр хүртэл явсан, эргэлтийн байрнаас үндсэн байранд хүрэлцэн ирсэн цагийн нийлбэрээс амрах нөхцөлөөр хангагдсан өртөөнд амарсан хугацаа, зорчигчийн вагонд амарч явсан хугацааг хасаж, үндсэн ба эргэлтийн өртөөнд ажилласан бэлтгэл, төгсгөлийн цагийг ажилтан тус бүр дээр нэмж тооцно;

5.2.8. галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн дагуу үндсэн байранд дуудагдан ирсэн зүтгүүрийн бригадын ажилтныг аялал хойшлогдсон тохиолдолд 3 цагаас багагүй хугацаагаар амрах нөхцөлөөр хангагдсан байранд амраагаад дахин дуудаж болно;

5.2.9. зүтгүүрийн бригад нь зүтгүүр, галт тэргийг хүлээн авахаар зүтгүүрээр болон бусад тээврийн хэрэгсэлээр явсан хугацааг ажлын цагт тооцно;


5.2.10. зүтгүүрийн бригад мөн тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтны шөнийн цагаар ажиллах цагийг хорогдуулахгүйгээр тогтооно. Зааварлагч машинчийн аялалд явж ажилласан цагийг дагалдан явсан тухайн галт тэрэгний машинчийн ажлын цагийн нэгэн адилаар тооцно;

5.2.11. тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтны ажил хүлээлцэх цаг 20 минутаас ихгүй байна. Ажлын онцлогоос шалтгаалан төмөр замын байгууллагын дарга өөрөөр тогтоож болно;

5.2.12. зорчигчийн галт тэрэгний тасалбарын явуулын нярав, тээш түгээгч тэдгээртэй адилтгах ажилтны ажлын цагийн хуваарийг зүтгүүрийн бригадын ажил, амралтын цагийн дэглэмтэй адилаар тогтоож болно;

5.2.13. зорчигчийн вагоны хоёр үйлчлэгчийн аяллын мөрөн дэх нийт ажиллах хугацааг тус бүрд тэнцүү хуваах ба зорчигчийн галт тэрэгний эргэлт, дамжин өнгөрөх цэгүүдэд ажиллах ээлжийн хуваарьтай байна;

5.2.14. тусгай үйлчилгээний болон албан хэрэгцээний вагоны үйлчлэгчийн ажлын цагийн хуваарийг батлагдсан ажил, амралтын дэглэмийг үндэслэн ээлжинд



12 цагаас ихгүй байхаар зохицуулах бөгөөд аялалд явах цагийг галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагаар тогтооно;

5.2.15. зорчигчийн галт тэрэгний механик, засварчин болон тэдгээртэй адилтгах ажилтны ажлын цагийн хуваарийг зорчигчийн галт тэрэгний бригадын ажил, амралтын цагийн дэглэм адилаар тогтооно;

5.2.16. сэргээн босгох галт тэрэгний бригад болон бусад салбар, нэгжээс татагдан ирсэн ажилчдын ажлын цагт галт тэргийг байрлуулсан газарт ирсэн цагаас буцаж ирсэн цаг хүртэлх бүх цагийг тооцох бөгөөд амралтын завсарлага өгч, хоол хүнсээр үйлчилнэ. Энэхүү завсарлага нь ажлын цагт орохгүй;

5.2.17. сэргээн босгох галт тэрэгний бригад нь сургалт-бэлтгэлийн ажил гүйцэтгэх, мөн гэрээгээр ажил гүйцэтгэхээр бол ердийн хуваарийн үндсэн дээр ажлын цагийг тодорхойлно;

5.2.18. зам, засварын ажилчид ажил гүйцэтгэж буй хэсэглэл рүү зорчихдоо тусгай ажилчдын галт тэргээр зорчиж зурмагийн дагуу зорчсон цагийг оруулж тооцно;


5.2.19. төмөр замын барилгын болон замын машин механизмын техникийн үйлчилгээ хийх ажилтан, мөн мэргэжилтний ажлын цагт дараахь цагууд орно;

5.2.20. замын барилга угсралтын машин механизмыг галт тэрэгний бүрэлдэхүүнд холбох, ажлын бус горимд бие дааж өөр өртөөнд шилжих мөн хоппер-дозатор, думпкар вагоноор бусад өртөөнд ачаа ачиж, буулгах, буцах зэрэг үйл ажиллагаанд оролцох тохиолдолд ажил олгогч, ажилчдын төлөөлөл нар тохиролцож барилга угсралтын машин механизмын ээлжийн ажилтны ажил, амралтын хуваарийг зохионо;

5.2.21. хил гарах, дамжуулах галт тэрэг, сэлгээний ажил, түлхэгч зүтгүүр дээр тогтмол буюу түр хугацаагаар ажиллуулахаар зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын ажилтныг байнгын оршин суудаг газраас явуулахад энэ журам хамаарахгүй.

5.3. Илүү цаг:

5.3.1. хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцсоны дагуу төмөр замын тээврийн хэвийн тасралтгүй үйл ажиллагаанд саад учруулсан байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгах эсвэл яаралтай хийхгүй бол хэвийн үйл



ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгуулахаар ажилтныг илүү цагаар ажиллуулж болно;

5.3.2. илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулна. Амруулаагүй тохиолдолд Хөдөлмөрийн хуульд заасны дагуу илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг тухайн сард нь тооцож олгоно;

5.3.3. ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтан галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн дагуу нийтээр амрах баярын өдөр, долоо хоногийн бүрийн амралтын өдөр ажиллах нь илүү цагт хамаарахгүй. Ингэхдээ хөдөлмөрийн гэрээнд тусгаж 2 тал тохиролцсон байна.

5.4. Ажлын цагийн үргэлжлэх хугацааг сунгах тохиолдол:

5.4.1. зүтгүүр, галт тэрэгний бригадын тасралтгүй ажиллагааны үргэлжлэх хугацааг сунгах зайлшгүй тохиолдолд төмөр замын байгууллагын даргын шийдвэрээр сунгана. Энэ тохиолдолд захиргаа уг ажилтныг өөр ажилтнаар түргэн хугацаанд солих арга хэмжээг яаралтай авах үүрэгтэй;

5.4.2. төмөр замын тээврийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагаанд саад учруулсан байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгах, эсвэл яаралтай хийхгүй бол хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгах хойшлуулшгүй ажил гүйцэтгүүлэхээр галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтныг амралт эдэлж буйг үл харгалзан төмөр замын байгууллагын даргын шийдвэрээр ажилд дуудан оруулж болно;

5.4.3. Дээр дурдсанаас бусад тохиолдолд ажилтныг бүрэн амарч дуусаагүй байхад нь ажилд дуудахгүй байхыг анхаарч ажиллана.

5.5. Амралтын цаг:

5.5.1. ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтан долоо хоногийн амралтын хугацааг зурмагт 48 цагаас багагүй, 72 цагаас ихгүй байхаар тухайн сарын ажлын ээлжийн хуваарт тэнцүү хуваарилж тусгах бөгөөд долоо хоногийн амралтын хугацаа нь тухайн сарын амралтын цагаас багагүй байна. Амрах хуваарийг урьдчилан мэдэгдсэн байна;



5.5.2. байгалийн гамшиг, сүйрэл, осол гарсан тохиолдолд төмөр замын байгууллагын даргын шийдвэрээр долоо хоногийн амралтыг бууруулан 24 цагаар тогтоож болох ба дутууг дараа нөхөн амраана;

5.5.3. галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажлын байранд ажилтны амрах, хооллох завсарлагын хугацааг 30 минутаас багагүй, 2 цагаас ихгүй байхаар хөдөлмөрийн дотоод журмаар тогтооно. Харин байгаль, цаг уурын онцгой нөхцөл /хэт халалт, хүйтрэлт/-д ажлын өдрийн тусгай завсарлагын хугацааг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган 2-оос дээш цагаар зохицуулж болно;


5.5.4. ажлын өдрийн дараахь хэвийн амралтын үргэлжлэх хугацааг 8 цагийн ажлын өдөртэй ажилтанд 16, 7 цагийн ажлын өдөртэй ажилтанд 17, 12 цагийн ээлжийн хуваариар ажилладаг ажилтанд 24 цагаар тус тус тогтооно;

5.5.5. зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын ажилтны байнга оршин суудаг газарт олгох амралтыг тооцохдоо хоёр талын аялалд зарцуулсан нийт цагийг хэвийн амралт зохицуулах итгэлцүүрээр үржүүлж, гарсан үржвэрээс эргэлтийн байр буюу амрах нөхцөлөөр хангагдсан зорчигчийн вагонд амарсан хугацааг хасаж тооцно. Итгэлцүүрийг долоо хоногийн ажлын өдрийн дараахь амралтын цагийн нийлбэрийг долоо хоногийн ажлын нормт цагт хувааж гаргана $/80:40 = 2.0/$;

5.5.6. ажилтны байнга оршин суудаг газар дахь амралтыг ажлын шаардлагаар 12 цаг хүртэл хугацаагаар багасгаж болох ба тасралтгүй амарсан хугацаа нь 24 цагаас багагүй байна;

5.5.7. эргэлтийн болон солилцох байранд зүтгүүрийн бригадын аялал нэг талдаа 4 цагаас илүү үргэлжлэх тохиолдолд гүйцэтгэсэн ажлын цагийн хагасаас буюу 3 цагаас багагүй хугацаагаар амрах бөгөөд шөнийн цагаар /22-06 цаг/ ажилласан бол шөнийн цагаар ажилласан цагт ноогдох хувиар нэмэгдэл амралт олгоно;

5.5.8. зүтгүүрийн бригадын ажилтныг эргэлтийн байр буюу ажил дууссан газарт нь зохих амралтыг нь эдлүүлэхгүйгээр буцааж болох боловч буцах замд нь ажиллуулж болохгүй;



5.5.9. зүтгүүрийн бригадын ажилтны ажлын цагийг халаа /турный/ ээлжээр зохион байгуулах тохиолдолд ажилтны байнга оршин суудаг газарт олгох амралтыг хоёр талын аялал хийсний дараа тооцож олгоно.

5.6. Сарын ээлжийн ажлын хуваарь:

5.6.1. ажлын цагийн хуваарийг зохиохдоо галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн болон суурь бүтэц дэх зурмагтай зохицуулж, дараахь зүйлүүдийг удирдлага болгоно:

- тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажилладаг ажилтан, мөн түүнчлэн ажлын цагийг хэсэглэн хуваах зохицуулалтаар ажилладаг ажилтны ажлын хуваарийг төмөр замын байгууллагын дарга баталж, өөрчлөнө;

- ажлын цагийг хэсэглэн хуваах зохицуулалтаар ажилладаг ажилтны ажлын хуваарийг үдийн хоолны завсарлагыг оролцуулан 2-оос илүүгүй завсарлагатай, завсарлага бүрийн үргэлжлэх хугацааг 1 цагаас багагүй, хоногийн туршид амралтын тасралтгүй үргэлжлэх хугацаа 12 цагаас багагүй байхаар тус тус зохионо;


- төмөр замын байгууллага, салбар нэгжийн захиргаа нь ажилтны ажил, амралтын хуваарийг сар эхлэхээс 3 хоногийн өмнө ажилтанд танилцуулж, ажлын байранд ил тавьсан байна;

- ажлын цагийн хуваарьт ажилтны ажил, амралтын цаг тодорхой заагдсан байх ба амарч байгаа ажилтанд хуваарийг танилцуулах, шийдвэр өгөх зэргээр захиргаанаас үүрэг хүлээлгэхгүй байна.

5.7. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилга, ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл нь энэхүү журмын 5 дугаар бүлэг, мөн MNS 5080:2001 "Хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, хүчин зүйл, үнэлгээ" стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

6.1. Хүний эрүүл мэнд, амь нас, ачаа, тээш, ачаан тээш, эд хөрөнгийг авран хамгаалсан, сүйрэл, осол, гологдлоос урьдчилан сэргийлсэн, ажлын бүтээмж, чанарыг сайжруулахад шинэ санал санаачилга гаргаж үр дүн үзүүлсэн, хөдөлмөрийн тодорхой амжилт гаргасан ажилтанд шагнал урамшуулал олгож болно.



6.1.1. байгууллагын шагнал, урамшуулал;

6.1.2. Засгийн газар болон салбарын тэргүүний ажилтан, яамны жуух бичиг;

6.1.3. Монгол Улсын цол, одон, медаль.

6.2. Энэхүү журмын 6.1.2, 6.1.3-т заасан шагналд нэр дэвшүүлж байгаа ажилтныг төмөр замын байгууллагын дарга хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагад тодорхойлно.

6.3. Төмөр замын байгууллага нь шагнал, урамшууллын журамтай байна.

6.4. Төмөр замын байгууллагын салбар, нэгжийн дарга нь төр, засгийн шагналд ажилтныг тодорхойлох, төмөр замын байгууллагын даргын баталсан журамд заасан хэмжээнээс хэтэрсэн шагнал урамшууллыг үзүүлэх, харьяа байгууллага нь удирдах байгууллага болон удирдах ажилтныг шагнаж урамшуулахгүй байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ САХИЛГА, ХАРИУЦЛАГА

7.1. Энэхүү журамд заасан үүргээ биелүүлээгүй, сахилгын зөрчил гаргасан ажилтан, хуулийн этгээдэд түүний гэм буруугийн байдлыг харгалзан Хөдөлмөрийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль болон Хөдөлмөрийн дотоод журамд заасан дараахь шийтгэл оногдуулна:

7.1.1. сануулах;

7.1.2. үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

7.1.3. төмөр замын хөдөлгөөний бус ажилд 1 жил хүртэл хугацаагаар шилжүүлэх;

7.1.4. ажлаас халах.

7.2. Ажилтанд түүний гэм буруугийн байдлыг харгалзан сануулах сахилгын шийтгэлийг дор дурьдсан тохиолдолд ногдуулна:

7.2.1. ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заагдсан үүрэг, удирдлагаас өгсөн хуульд нийцсэн даалгавар, заавар биелүүлээгүйгээс төмөр замын объект, үйл ажиллагаанд саад учирсан, ачаа тээврийн зөрчил, гэмтэл гарах нөхцөл бүрдүүлсэн;

7.2.2. ёс зүйн зөрчил гаргасан.



7.3. Ажилтанд түүний гэм буруугийн байдлыг харгалзан ажилтны үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэлийг дор дурьдсан тохиолдолд ногдуулна:

7.3.1. төмөр замын тээврийн гологдол гаргасан, гологдол гарах нөхцөл бүрдүүлсэн;

7.4. Ажилтанд түүний гэм буруугийн байдлыг харгалзан төмөр замын хөдөлгөөнтэй шууд бус холбоотой ажилд 1 жил хүртэл хугацаагаар шилжүүлэх сахилгын шийтгэлийг дор дурьдсан тохиолдолд ногдуулна:

7.4.1. хөдлөх бүрэлдэхүүн жолоодохдоо технологийн алдаа гаргаж осол гаргасан;

7.4.2. галт тэрэг хүлээн авах, явуулах, сэлгээний ажил гүйцэтгэхдээ технологийн алдаа гаргаж осол гаргасан;

7.4.3. зам засварын ажил хийгдэж буй газарт зохих ёсоор хамгаалалт хийгээгүйгээс хүн гэмтсэн, осол гарсан;

7.4.4. хариуцсан үүргээ биелүүлээгүйгээс хөдлөх бүрэлдэхүүнийг бусад тээврийн хэрэгсэлтэй мөргөлдүүлсэн;

7.4.5. дохиолол, төвлөрүүлэлт ба холбооны тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний технологийн алдаа гаргаж осол гаргасан;

7.4.6. вагон чингэлгийн ачааг бэхлэх, байршуулах техникийн нөхцөл зөрчиж осол гаргасан;

7.4.7. шуудан, тээш, зорчигчийн вагоны үйлчлэгч нь хаалгаа түгжээгүй, гүүшингийн халалтад хяналт тавих төхөөрөмжийн ажиллагааг тогтмол шалгаагүйгээс болж хүн гэмтсэн, осол гарсан;

7.4.8. галын аюулгүй байдлын холбогдох дүрэм зөрчсөнөөс хөдлөх бүрэлдэхүүнд гал гарсан;

7.4.9. аюултай бүсийн дэглэмийг хэрэгжүүлээгүйгээс хүний амь эрсэдсэн, гэмтсэн.

7.5. Дараахь сахилгын зөрчил гаргасан төмөр замын ажилтныг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулж, хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар цуцална:



7.5.1. төмөр замын тээврийн сүйрэл гаргасан, сүйрэл гарах нөхцөл бүрдүүлсэн болон хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан;

7.5.2. ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, ажилдаа согтуу буюу мансууран ирсэн;

7.5.3. төмөр замын объект, сэлбэг, хэрэгсэл, эд анги, бусад материалыг хулгайлсан, тоносон, үрэгдүүлсэн нь нотлогдсон;

7.5.4. хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг санаатайгаар задалсан, сулласан, эвдсэн, хөдлөх бүрэлдэхүүнд хориотой зүйлс нуусан;

7.5.5. албан тушаалаа ашиглан ачаа, тээш, ачаан тээш, зорчигчийг үнэ, хөлсгүй тээвэрлэсэн;

7.5.6. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дараалсан ажлын 3 өдөр ажил тасалсан, сардаа нийлбэр дүнгээрээ 4 ба түүнээс дээш өдөр ажил тасалсан;

7.5.7. улсын хилээр хууль бусаар эд зүйлийг нэвтрүүлэх зорилгоор төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүнийг нуувч болгон ашигласан;


7.6. Ажил олгогч нь сахилгын шийтгэлийг ногдуулахаасаа өмнө тухайн ажилтнаас бичгээр тайлбар, тодорхойлолт, хүсэлтийг хүлээн авч зөрчлийн шалтгааныг олон талаас судалж, үнэн зөвийг бодитоор дүгнэнэ;

7.7. Ажилтанд хөдөлгөөнтэй шууд бус холбоотой ажилд томилох сахилгын хариуцлага ногдуулсан тохиолдолд ажилтантай зөвшилцөж, шийдвэрлэнэ;

7.8. Энэхүү журмын 7.1.3-т заасан сахилгын шийтгэл хүлээсэн ажилтныг шийтгэлийн хугацаа дууссаны дараа холбогдох дүрэм, журмын мэдлэгээр шалгалт өгч, тэнцсэн тохиолдолд хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилд томилж болно;

7.9: Сахилгын шийтгэлийн талаарх гомдлоо ажилтан хууль тогтоомжид заасны дагуу шүүхэд гаргаж болно;

7.10. Сахилгын шийтгэлийн талаар гомдол гаргасан нь шийтгэлийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.



НАЙМДУГААР БҮЛЭГ
АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ

8.1. Ажилтны ажиллах хөдөлмөрийн нөхцөл нь хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлага хангасан байна.


8.2. Ажил олгогч, ажилтан нь Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай болон Төмөр замын тээврийн тухай хуульд заасан эрх, үүргийг эдэлнэ.


ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

9.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зам, тээврийн хяналт хариуцсан нэгж, мөн төмөр замын байгууллагууд болон тэдгээрийн салбар, нэгжийн удирдлага, дотоод хяналтын нэгж хяналт тавина.

9.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---





Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 28 ны өдрийн
264 дүгээр тушаалын арвантавдугаар хавсралт

СУУРЬ БҮТЭЦ, НИЙТИЙН БОЛОН ДАГНАСАН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАМ АШИГЛАХ, СУУРЬ БҮТЭЦ ЭЗЭМШИГЧ, ТЭЭВЭРЛЭГЧ ХООРОНДЫН ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Нэг. Нийтлэг үндсэлэл.

1.1. Монгол Улсын Иргэний хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, салбарт мөрдөгдөж байгаа стандартыг удирдлага болгон нэг талаас /цаашид "тээвэрлэгч" гэх/ түүнийг төлөөлж, нөгөө талаас/цаашид "суурь бүтэц эзэмшигч" гэх/ түүнийг төлөөлж нар /цаашид хамтад нь "талууд" гэх/ харилцан тохиролцож дараахь нөхцөлтэйгээр энэхүү гэрээг байгуулав.

1.2. Энэхүү гэрээний дагуу тээвэрлэгчийн зорчигч, ачаа, ачаан тээшийн тээвэрлэлтэд /цаашид "тээвэрлэлт" гэх/ суурь бүтэц эзэмшигч нь өөрийн эзэмшлийн төмөр замын тээврийн суурь бүтцээр гэрээний нөхцөлийн дагуу үйлчилгээ үзүүлэх /цаашид "үйлчилгээ" гэх/, тээвэрлэгч нь дээрх үйлчилгээнд төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.

1.2. Талууд үйлчилгээ, тээвэрлэлтийн хэмжээ, захиалга зөвшилцөх хугацаа болон бусад холбогдох зүйлийг албан бичгээр үйлдэн тохиролцон гэрээнд хавсаргана.

Хоёр. Үндсэн үйлчилгээ:

2.1. Суурь бүтэц эзэмшигч нь Суурь бүтэц ашиглуулах журам, Суурь бүтэц ашиглалтын тариф тогтоох аргачлалд заасан дараахь үндсэн /өөрийн эзэмшлийн суурь бүтцээр тээвэрлэгчийн зорчигч, ачаа, ачаан тээшийн тээвэрлэлт/ үйлчилгээг тээвэрлэгчид үзүүлнэ.

2.1.1. суурь бүтэц эзэмшигчийн галт тэрэгний зурмагийн дагуу галт тэрэг аялуулах;

2.1.2. галт тэрэг болон хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг хийх;

2.1.3. өртөөн дээр галт тэрэг найруулах, сэлгээ хийх;

2.1.4. нийтийн хэрэглээний зам, талбайгаар үйлчлэх.

2.2. Суурь бүтэц эзэмшигч нь дараахь нэмэлт үйлчилгээг үзүүлнэ:



- 2.2.1. хөдлөх бүрэлдэхүүний засвар, зэхэх үйлчилгээ;
- 2.2.2. зүтгүүрийн бригадын амрах байр;
- 2.2.3. зорчигч тээврийн вокзал, тасалбар түгээх үйлчилгээ;
- 2.2.4. цэрэгжүүлсэн хамгаалалт, галын аюулаас сэргийлэх.

Гурав. Суурь бүтэц эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Суурь бүтэц эзэмшигч нь дараахь үүрэгтэй.

3.1.1. суурь бүтэц эзэмшигч нь өөрийн эзэмшлийн төмөр замын тээврийн суурь бүтцээр тээвэрлэгчтэй тохиролцсон нөхцөл, хугацаанд тохирсон тээвэрлэлтийн үйлчилгээ авах боломжоор хангах;

3.1.2. тохиролцсон нөхцөл, хугацааны дагуу тээвэрлэгчийн галт тэргийг суурь бүтцээр тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх;

3.1.3. суурь бүтэц эзэмшигч нь тохиролцсон үйлчилгээний нөхцөл, хугацаанд нөлөөлөх галт тэрэгний цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тохиолдолд өөрчлөлтийг оруулахаас өмнө хуанлийн ... өдрөөс хэтрүүлэлгүйгээр тээвэрлэгчид бичгээр мэдэгдэх;

3.1.4. тээвэрлэгчийн галт тэргийг тогтоосон хурдны ангиллын дагуу аялуулах шаардлагатай арга хэмжээг авах;

3.1.5. суурь бүтэц эзэмшигч нь өөрийн эзэмшлийн техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал болон аюулгүй ажиллагааг бүрэн хариуцах;

3.1.6. Тээвэрлэгчийн галт тэргэнд техникийн үзлэг хийх;

3.1.7. зурмагийг биелүүлэх, галт тэрэгний хөдөлгөөнд тээвэрлэгч хяналт тавих, зүтгүүр болон вагоны эргэлтийг зохицуулах, вагон урсгал болон тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах зэрэгт шаардагдах хөдлөх бүрэлдэхүүний байршлын талаар тээвэрлэгчийг үнэн бодит мэдээллээр хангах;

3.1.8. урьдчилан тааварлах боломжгүй нөхцөл байдал үүссэн, үйлчилгээ үзүүлэх боломжгүй нөхцөл байдал бий болсон бол тээвэрлэгчид нэн даруй мэдэгдэх, захиалгыг дахин зөвшилцөх.


3.2. Суурь бүтэц эзэмшигч нь дараахь эрхтэй байна:

3.2.1. энэхүү гэрээнд заасан үйлчилгээний төлбөрийг тарифын дагуу авах;

3.2.2. тээвэрлэгчийн тусгай зөвшөөрөл, баримт бичгийг шалгах, шаардан гаргуулах;

3.2.3. гэрээнд заасан үйлчилгээний хөлс төлөхийг тээвэрлэгчээс шаардах.

3.3. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг эдэлнэ.



Дөрөв. Тээвэрлэгчийн эрх, үүрэг.

4.1. Тээвэрлэгч нь дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1. гэрээнд заасан үйлчилгээний хөлсийг тарифын дагуу суурь бүтэц эзэмшигчид төлөх;

4.1.2. суурь бүтэц эзэмшигчид үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон бусад баримт бичгийг танилцуулах, гэрээний хугацаанд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах, хүчингүй болсныг тухай бүр мэдэгдэх;

4.1.3. галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний нэгдсэн зурмаг биелүүлэх, галт тэрэг найруулах төлөвлөгөө ба журам, өртөөний технологийн горим мөрдөх талаар суурь бүтэц эзэмшигчээс тавьсан шаардлагыг биелүүлэх;

4.1.4. захиалгад тохиролцсон үйлчилгээний хугацаа, нөхцөлийг баримтлах;

4.1.5. захиалгад тохиролцсон үйлчилгээнээс татгалзах, өөрчлөх тохиолдолд суурь бүтэц эзэмшигчид хуанлийн ... өдрөөс хэтрүүлэлгүйгээр үйлчилгээнээс татгалзах, эсхүл өөрчлөх үндэслэлийн хамт урьдчилан албан бичгээр мэдэгдэх;

4.1.6. суурь бүтцийн болон нэмэлт үйлчилгээг цаг тухайд нь бүрэн авах, суурь бүтцийн объектын эвдрэл гэмтэл илэрсэн, техник ашиглалтын дүрэм зөрчигдсөн тохиолдлын талаар суурь бүтэц эзэмшигчид мэдэгдэх, арга хэмжээ авахыг шаардах;

4.1.7. ачаа, тээш, ачаан тээш болон зорчигч тээвэрлэх үйл ажиллагааг тохиролцсон захиалга, батлагдсан зурмагийн дагуу зохих ёсоор гүйцэтгэх;

4.1.8. өөрийн эзэмшлийн техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал болон аюулгүй ажиллагааг бүрэн хариуцана;

4.1.9. тээвэрлэгч нь тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас талуудад учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцлагын даатгалд даатгуулж энэхүү гэрээнд хавсаргасан байна;

4.1.10. хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг эдэлнэ.

Тав. Тээврийн тариф хэрэглэх нөхцөл, нэмэлт үйлчилгээний хөлс.


5.1. Төмөр замын тээвэрлэлтийн тарифийн нөхцөл, нэмэлт үйлчилгээний хөлсийг дараахь байдлаар ангилан хэрэглэнэ:

5.1.1. үйлчилгээний тариф:

5.1.2. хөнгөлөлт:

5.1.3. нэмэлт үйлчилгээний хөлс:

5.1.4. төлбөр тооцоо хийх журам:



5.1.5. Бусад:

Зургаа. Тээвэрлэлтийг хэрэгжүүлэх

6.1. Гэрээгээр зөвшилцсөн хугацаа, нөхцөлүүдийн дагуу тээвэрлэгч нь хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг хийлгэхээр суурь бүтэц эзэмшигчийн заасан өртөөний зам дээр найруулж бэлэн болсон галт тэргийг хөдлөхөөс ... цагийн өмнө хүлээлгэн өгнө.

6.2. Тээврийн баримт бичгийг үндэслэн суурь бүтэц эзэмшигч нь галт тэрэгний биечилсэн хуудас ... хувь бүрдүүлнэ.

6.3. Гэрээгээр зөвшилцсөн хугацаа, нөхцөл болон зурмагийн дагуу галт тэргийг тээвэрлэх нөхцөлөөр суурь бүтэц эзэмшигч хангана.

6.4. Аяллын замд галт тэргэнд боловсруулалт хийгдэх тохиолдол бүрт суурь бүтэц эзэмшигчийн төлөөлөгч /өртөөний жижүүр/ биечилсэн хуудсанд холбогдох тэмдэглэгээг хийж баталгаажуулсан байна.

6.5. Тээвэрлэгч хүрэх өртөөнд ирсэн галт тэрэгний биечилсэн хуудасны 1 хувийг суурь бүтэц эзэмшигчид өгөх ба энэхүү баримт бичиг болон замын хүснэгт нь үйлчилгээ үзүүлсний нотолгоо байх бөгөөд төлбөр тооцоо хийх үндэслэл болно.

6.6. Тээвэрлэгч нь өөрийн суурь бүтэцтэй тохиолдолд хиллэж байгаа тохиролцсон өртөөн дээр галт тэрэг солилцох ажлын нэгдсэн технологийг суурь бүтэц эзэмшигчтэй хамтран боловсруулж, гэрээний хавсралт болгон мөрдөж ажиллана.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл


7.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал, газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

7.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

7.3. Тухайн нөхцөл байдлын улмаас гэрээний үүргийн хугацаа хоногоор хойшлогдвол талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд хохирол төлүүлэхийг шаардахгүй.

Найм. Талуудын хариуцлага

7.1. Суурь бүтэц эзэмшигч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу хангалтгүй гүйцэтгэлийн улмаас тээвэрлэгчид хохирол учирсан тохиолдолд Иргэний хууль, Зөрчлийн тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.



7.2. Тээвэрлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу хангалтгүй гүйцэтгэлийн улмаас суурь бүтэц эзэмшигчид хохирол учирсан тохиолдолд Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлнэ.

Ес. Гэрээний үйлчлэх хугацаа

9.1. Гэрээний үйлчлэх хугацаа 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс 20...оны ... дугаар сарын ...-ны өдөр хүртэл байна.

9.2. Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал бичгээр тохиролцсоноор сунгаж болно.

9.3. гэрээний үйлчлэх хугацааг дараахь тохиолдолд зогсоож болно:

9.3.1. талуудын зөвшилцсөнөөр;

9.3.2. Монгол Улсын эрх бүхий байгууллагын шийдвэрээр;

9.3.3. давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээр.

Арав. Маргаан шийдвэрлэх

10.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

10.2. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүх /арбитр/-ээр шийдвэрлүүлнэ.

Арваннэг. Бусад

11.1. Гэрээг 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

11.2. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм болон бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

Тээвэрлэгч:

Суурь бүтэц эзэмшигч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас:

Утас:

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

--- о о о ---





Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 28 дүгээр сарын 28 ны өдрийн
264 дүгээр тушаалын арванзургадугаар хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАЙГУУЛЛАГУУД ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" улсын төсөвт үйлдвэрийн газар /цаашид "Хөдөлгөөн зохицуулалтын төв" гэх/ болон төмөр замын байгууллагуудын хооронд харилцан мэдээлэл солилцох, түүнтэй холбогдуулан зам, тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн санг төмөр замын тээврийн статистик мэдээллээр (цаашид "Салбарын мэдээллийн сан" гэх) бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам нь Монгол Улсын Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Статистикийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, багц дүрэм, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1.3. Статистик мэдээлэл нь үнэн, бодитой байхаас гадна шуурхай байна.

1.4. Төмөр замын тээврийн байгууллагууд нь холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмаар тогтоосон хамрах хүрээний баталгаажсан, үнэн зөв статистик мэдээ, мэдээллийг Хөдөлгөөн зохицуулалтын төвд дараахь хугацаанд ирүүлнэ:

1.4.1. хоногийн мэдээг өдөр бүрийн 22.00 цагийн дотор;

1.4.2. долоо хоног бүрийн мэдээг баасан гараг бүрийн 09:00 цагийн дотор;


1.4.3. сарын мэдээг дараа сарын 04-ний дотор;

1.4.4. улирлын мэдээг улирал бүрийн дараа сарын 04-ний дотор;

1.4.5. жилийн мэдээг дараа оны нэгдүгээр сарын 04-ний дотор;

1.5. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёо, тодорхойлолтыг Төмөр замын тээврийн тухай хууль болон MNS 6387-1,2,3,4:2013 "Төмөр замын автоматик ба телемеханикийн, хөдлөх бүрэлдэхүүний тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томъёо, тодорхойлолт" заасан утгаар ойлгоно.

1.6. Энэхүү журмаар иргэн, хуулийн этгээдийг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааны болон бусад шаардлагатай статистик мэдээллээр хангах, салбарын статистик мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг Хөдөлгөөн зохицуулалтын төв хэрэгжүүлнэ.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ТАЙЛАГНАХ ХҮРЭЭ

2.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлгөөн зохицуулалтын төв болон төмөр замын байгууллагууд энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан мэдээллийг харилцан солилцож, олон нийтэд мэдээлнэ.

2.2. Хөдөлгөөн зохицуулалтын төв Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хороонд энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу холбогдох статистик мэдээллийг энэхүү журмын 1.4-т заасан хугацаанаас хойш ажлын 3 өдөрт багтаан цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ.

2.3. Шинэ програм хангамжийг ашигласнаар гарсан мэдээлэл нь мэдээллийн бүрэн бүтэн байх чанар, үнэ цэнэтэй, эрэлт хэрэгцээтэй байх шинж чанарыг давуу байдлаар агуулсан тохиолдолд энэхүү журмаар тогтоосон статистик мэдээллийн хамрах хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2.4. Хөдөлгөөн зохицуулалтын төв төмөр замын байгууллагуудад холбогдох дүрэм, журмын дагуу баталсан галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг /өвөл, зун/-ийг Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журамд заасан хугацаанд хүргүүлнэ.

2.5. Хөдөлгөөн зохицуулалтын төвөөс тээсэн ачаа, ачаа эргэлт, зорчигч тээвэрлэлт, зорчигч эргэлт зэрэг мэдээллийг олон нийтэд мэдээлнэ.

2.6. Суурь бүтэц эзэмшигч дараахь мэдээллийг олон нийтэд тогтмол мэдээлнэ:

2.6.1. тээврийн үйлчилгээний хөлс, тарифийн хэмжээ;

2.6.2. тээвэрлэлтийн горим, техникийн нөхцөл, зарим төрлийн тээвэрлэлтэд тавигдах тусгай шаардлага;

2.6.3. зорчигчийн галт тэрэгний аяллын цагийн хуваарь.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭЛТ, ХӨТЛӨЛТ, АШИГЛАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Салбарын мэдээллийн санд төвлөрсөн мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглах үйл ажиллагаанд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай болон бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

3.2. Салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, хадгалах, ашиглах үйл ажиллагаанд дараахь нөхцөл шаардлагыг хангаж ажиллана:



3.2.1. холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцад хамаарахаас бусад мэдээллийг төмөр замын тээврийн салбарын мэдээллийн сангийн цахим хуудсанд нээлттэй байршуулна.

3.2.2. мэдээллийг хувийн ашиг сонирхолд нийцүүлэн хууль бусаар ашиглах, бусдад дамжуулахгүй байх;

3.2.3. салбарын мэдээллийн сан, програм хангамжид хууль бусаар тусгайлан бэлтгэсэн програм болон техникийн тусламжтайгаар хандах, нэвтрэх, програм хангамжийн файлыг устгах, эвдэх, ашиглах боломжгүй болгох, мэдээллийн сүлжээний хэвийн, найдвартай үйл ажиллагааг алдагдуулахаас урьдчилан сэргийлэх;

3.2.4. салбарын мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах эрх бүхий этгээдэд холбогдох эрхийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хөдөлгөөн зохицуулалтын төвийн захирлын зөвшөөрлөөр олгох;

3.2.5. салбарын мэдээллийн санд хандах эрхээ бусдад дамжуулах, бусдын хандах эрхийг хууль бусаар олж авах, ашиглах, бусдад дамжуулах, албан ёсны давуу эрхээ хууль бус үйлдэлд болон хувийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

3.2.6. төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хөдөлгөөн зохицуулалтын төвийн захирлын зөвшөөрөлгүйгээр цахим сангийн програм хангамжийг хувилж тараах мөн тэдгээрийг интернэт болон гадны бусад сүлжээнд холбохгүй байх.

3.3. Төмөр замын байгууллагуудаас энэхүү журамд заасан мэдээлэл болон салбарын мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийг гаргуулах эрхийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хөдөлгөөн зохицуулалтын төв хэрэгжүүлнэ.


ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

4.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зам, тээврийн хяналт хариуцсан нэгж, эрх, үүргийн хэмжээнд дүн шинжилгээ хийж, хяналт тавина.

4.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- 0 0 0 ---



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны
 11 дүгээр сарын 28 ны өдрийн 267 дүгээр тушаалын
 Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл
 солилцох журмын нэгдүгээр хавсралт




ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЖАГСААЛТ


д/д	Мэдээний нэр	Мэдээлэх хугацаа					Маягтын дугаар
		Жил	Улирал	Сар	Долоо хоног	Хоног	
Нэг. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хороонд							
1.1	Төмөр замын ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтийн мэдээ	ЗТХЯ	ЗТХЯ	ЗТХЯ			6
1.2	Ачилтын мэдээ	ЗТХЯ	ЗТХЯ	ЗТХЯ			7
1.3	Дамжин өнгөрөх ачааны мэдээ	ЗТХЯ	ЗТХЯ	ЗТХЯ/ҮСХ			8
1.4	Чингэлэг тээвэрлэлтийн мэдээ	ЗТХЯ					9а
1.5	Чингэлэг тээвэрлэлтийн мэдээ /илгээгчээр/	ЗТХЯ					9б
1.6	Зорчигч тээвэрлэлтийн мэдээ	ЗТХЯ	ЗТХЯ				10а
1.7	Орон нутгийн зорчигч урсгалын мэдээ	ЗТХЯ	ЗТХЯ/ҮСХ				10б
1.8	Ачааны вагоны парк ашиглалтын мэдээ	ЗТХЯ					11
1.9	Суудлын вагоны парк ашиглалтын мэдээ	ЗТХЯ					12
1.10	Зүтгүүрийн парк ашиглалтын мэдээ	ЗТХЯ					13
1.11	Суурь бүтэц эзэмшигчийн техникийн үзүүлэлт мэдээ	ЗТХЯ	ЗТХЯ				14
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр. Тухайн тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээнд туссанаар товчлохгүйгээр бичнэ.

II. Үндсэн үзүүлэлтийн хэсэг

Зам арчилгааны тайланд замын урсгал засвар, замын их засварыг хийдэг.



Замын арчилгаа, урсгал засвар нь замын ажлуудын үндсэн төрөл болно. Арчилгаа засварын зорилго нь замыг эвдлэх гэмтлүүдээс урьдчилан сэргийлэх, гэмтлүүдийг илрүүлэн засварлах, гэмтэл гарсан шалтгааныг тодруулах, замын бүх эд ангиудыг байнга гэмтэлгүй байлгахад оршино. Арчлал засварын ажлын бүрэлдэхүүнд зам, төхөөрөмж, байгууламжуудын үзлэг шалгалтууд түүнд тавих хяналт, замын цариг төвшинг хэвий байлгах, замын хөөлтөөс хамгалах ба шаардлагатай үед уулзварын зайг тохируулах, балластыг хэсэгчлэн солих дэр, зам төмөр, бэхэлгээ, суман шилжүүлгийн хэсгүүдийг солих, ус зайлуулах төхөөрөмжийг цэвэрлэх зэрэг ажлууд ордог.

Дагнасан хэрэглээний зам (мөр 1) гэдэг нь Төмөр замын тээврийн тухай хуульд эзэмшигчийн өөрийн хэрэгцээг хангах буюу гэрээний үндсэн дээр тодорхой хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэхэд зориулагдсан салбар замыг хэлнэ гэж заасан.

Нийтийн хэрэглээний зам (мөр 2) гэдэг нь Төмөр замын тээврийн тухай хуульд гэж төмөр замын шугам, өртөөнд галт тэрэг хүлээж авах, явуулах, ялгах болон сэлгээний ажил гүйцэтгэх, ачаа, ачаан тээш хүлээн авах, олгох, зорчигчдод үйлчлэх зам, түүнчлэн нийтэд үйлчлэх зориулалттай бусад салбар замыг хэлнэ гэж заасан.

Гол зам (мөр 3) - Төмөр замын тээврийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д зааснаар төмөр замын шугам гэж төмөр замын өртөө, хоорондын зам болон өртөөн дэх түүний шууд үргэлжлэлийг хэлнэ. Замын урсгал засвар хийсэн замын уртыг бичнэ.

Замын их засвараар замыг бүхэлд нь бэхжүүлэх, эрүүлжүүлэх ажлыг хийнэ. Үүнд, зам төмрийг замд байгаа зам төмөртэй адил маягаар буюу түүнээс илүү хүнд маягийн зам төмрөөр тууш солих, дэрийг тууш солих, буталмал чулуун балластыг цэвэрлэх буюу хайрга элсэн балластыг буталмал чулуугаар солих, суман шилжүүлгүүдийг сольж бүх тойруулах ба шилжүүлэх тохойнуудыг нарийн багажны тусламжтайгаар засварлах ажлуудыг хийдэг.

Гол зам (мөр 4) - Замын их засвар хийсэн замын уртыг бичнэ.

1-р багана. Тухайн онд засварласан замын тоог ялгаж тус тусд нь бичнэ.

2-р багана. Замын уртыг хэмжих нэгжийг бичнэ.


3-р багана. Өмнөх оны замын урсгал засвар болон замын их засварт засварласан замын уртыг нөхөж бичнэ.

4-р багана. Тухайн оны зам засвар, арчилгааны төлөвлөгөөг бичнэ.

5-р багана. Тухайн онд хийгдсэн зам засвар, арчилгааны төлөвлөгөөний биелэлтийг бичнэ.

6-р багана. Тухайн оны төлөвлөгөөг биелэлтэд харьцуулж хувиар илэрхийлнэ.
/ (багана 5: багана 4)*100/

7-р багана. Өмнөх оны гүйцэтгэлийг тайлант оны гүйцэтгэлд харьцуулна.
/багана 3: багана 5/



МАЯГТ № 166 БӨГЛӨХ ЗААВАР

Энэхүү мэдээг төмөр замын тээврийн үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон хугацаанд нь үнэн зөв, бөглөж ирүүлнэ.

I. Хаягийн хэсэг

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр. Тухайн тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээнд туссанаар товчлохгүйгээр бичнэ.

II. Үндсэн үзүүлэлтийн хэсэг

Салбар зам гэдэг нь сэлгээний болон ачих, буулгах ажил хийх зориулалтаар төмөр замын шугам болон өртөөний замаас салбарлаж тавьсан замыг хэлнэ.

Нээлттэй (мөр 1) Тухайн өртөөний салбар зам ачааны ажиллагаанд нээлттэй байгааг харуулсан болно.

Хаалттай (мөр 2) Тухайн өртөөний салбар зам ачааны ажиллагаанд хаалттай байгааг харуулсан болно.

Дагнасан хэрэглээний зам гэдэг нь төмөр замын тээврийн тухай хуульд эзэмшигчийн өөрийн хэрэгцээг хангах буюу гэрээний үндсэн дээр тодорхой хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэхэд зориулагдсан салбар замыг хэлнэ гэж заасан.

Дагнасан хэрэглээний зам эзэмшигч гэж эзэмшилдээ дагнасан хэрэглээний замтай хуулийн этгээдийг хэлнэ.

Нийтийн эзэмшлийн зам гэдэг нь Төмөр замын тээврийн тухай хуульд төмөр замын шугам, өртөөнд галт тэрэг хүлээж авах, явуулах, ялгах болон сэлгээний ажил гүйцэтгэх, ачаа, ачаан тээш хүлээн авах, олгох, зорчигчдод үйлчлэх зам, түүнчлэн нийтэд үйлчлэх зориулалттай бусад салбар замыг хэлнэ гэж заасан.


Нийтийн эзэмшлийн зам эзэмшигч гэж эзэмшилдээ нийтийн хэрэглээний замтай хуулийн этгээдийг хэлнэ.

1-р багана. Дагнасан хэрэглээний болон нийтийн эзэмшлийн замын тоог ачааны ажиллагаанд нээлттэй буюу хаалттайгаар ялгаж бөглөнө.

2-р багана. Дагнасан хэрэглээний болон нийтийн эзэмшлийн зам, талбайг эзэмшихээр объектын гэрчилгээтэй нийт замын тоог бөглөнө.

3-р багана. Дагнасан хэрэглээний болон нийтийн эзэмшлийн зам, талбайн төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй нийт замын тоог бөглөнө.

4-р багана. Дагнасан хэрэглээний болон нийтийн эзэмшлийн зам арчлалтын гэрээ байгуулсан нийт замын тоог бөглөнө.



5-р багана. Дагнасан хэрэглээний болон нийтийн эзэмшлийн замд ашиглагддаг тоног төхөөрөмжийн тоог бөглөнө. /кран, бункер, өндөрлөсөн тавцан, эстакад, агуулах, бусад/

ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЖИЛИЙН ТЗ-1 МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү мэдээг өмчийн бүх хэлбэрийн төмөр замын тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон хугацаанд нь үзүүлэлт тус бүрээр үнэн зөв, бүрэн нөхөж ирүүлнэ.

I. Хаягийн хэсэг

Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг. Тухайн Төмөр замын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө.

Аж ахуйн нэгж, байгууллагын оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийг бичиж, кодыг нөхнө.

Үйл ажиллагааны салбарын чиглэл. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.

II. Хөдлөх бүрэлдэхүүний хэсэг

Хөдлөх бүрэлдэхүүнд Төмөр замын тээврийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д зааснаар "зүтгүүр, вагон, түүнчлэн төмөр замаар явдаг бусад техникийг" хэлнэ.

1-р мөрөнд Тухайн жилд дансаар бэлэн байгаа төмөр замын нийт зүтгүүрийн тоог нөхнө. Зүтгүүр гэдэгт цахилгаан тэрэг, илчит тэрэг, уурын тэрэг, хийн трубинт, мотовоз гэх мэт орно.

2-р мөрөнд Тухайн жилд дансаар бэлэн байгаагаас ачаанд, суудалд, аж ахуйд, сэлгээнд болон бусад ашиглагдаж байгаа зүтгүүрийн тоог нөхнө. мөр (2)=мөр (3+4+5+6+7)


8-р мөрөнд Данслагдсан зүтгүүр гэж засвараас гараад ашиглалтанд орохоор хүлээгдэж байгаа зүтгүүрийг хэлнэ. мөр (8) =мөр (9+10+11+12+13)

14-р мөрөнд Актлаж устгасан зүтгүүрийн тоог нөхнө.

15-р мөрөнд Тухайн жилд дансаар бэлэн байгаа ачааны вагоны нийт тоог нөхнө.

16-р мөрөнд Тухайн жилд дансаар бэлэн байгаагаас хагас, битүү, тавцант, чингэлэг, цистерн, дозатор, думпкар, хоппер, ледник болон бусад ашиглагдаж байгаа ачааны вагоны тоог нөхнө. мөр (16) =мөр (17+18+19+20+21+22+23+24+25+26)

Цистерн гэдэг нь нефть, сүү зэрэг шингэн зүйлийг тээвэрлэх зориулалттай вагоныг хэлнэ.



Дозатор, Думпкар, Хоппер гэж хайрга, чулуу зэрэг зүйлийг тээвэрлэх зориулалттай.

Ледник гэдэг нь хөргүүрийн вагоныг хэлнэ.

27-р мөрөнд Данслагдсан ачааны вагон гэж засвараас гараад ашиглалтанд орохоор хүлээгдэж байгаа ачааны вагоныг хэлнэ. мөр (27) =мөр (28+29+30+31+32+33+34+35+36+37)

28-р мөрөнд Актлаж устгасан ачааны вагоны тоог нөхнө.

39-р мөрөнд Тухайн жилд дансаар бэлэн байгаа зорчигч вагоны тоог нөхнө.

40-р мөрөнд Тухайн жилд дансаар бэлэн байгаагаас зөөлөн, тасалгаат, нийтийн, тээшний, вагон ресторан, албаны болон бусад ашиглагдаж байгаа зорчигч вагоны тоог нөхнө. мөр (40) =мөр (41+42+43+44+45+46+47)

48-р мөрөнд Данслагдсан суудлын вагон гэж засвараас гараад ашиглалтанд орохоор хүлээгдэж байгаа суудлын вагоныг хэлнэ. мөр (48) =мөр (49+50+51+52+53+54+55)

49-р мөрөнд Актлаж устгасан суудлын вагоны тоог нөхнө.

III.Эзэмшигч байгууллагаар

Эзэмшигч байгууллагийн хөдлөх бүрэлдэхүүнийг төрөл тус бүрээр тоо хэмжээг гаргана.

1-р баганад Тухайн эзэмшигч байгууллагын зүтгүүрийн тоо хэмжээг бичнэ.

2-р баганад Тухайн эзэмшигч байгууллагын ачааны вагоны тоо хэмжээг бичнэ.

3-р баганад Тухайн эзэмшигч байгууллагын зорчигчийн вагоны тоо хэмжээг бичнэ.


1,2,3.... г.м мөрөнд Тухайн эзэмшигч байгууллагын нэрийг бичнэ.

СУУРЬ БҮТЦИЙН ТЕХНИКИЙН ХҮЧИН ЧАДЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ЖИЛИЙН ТЗ-2 МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү мэдээг өмчийн бүх хэлбэрийн төмөр замын тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон хугацаанд нь үзүүлэлт тус бүрээр үнэн зөв, бүрэн нөхөж ирүүлнэ.

I. Хаягийн хэсэг

Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг. Тухайн Төмөр замын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө.



Аж ахуйн нэгж, байгууллагын оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийг бичиж, кодыг нөхнө.

Үйл ажиллагааны салбарын чиглэл. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.

II. Суурь бүтцийн үзүүлэлтийн хэсэг

Суурь бүтэц гэдэг нь гэж Төмөр замын тээврийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д зааснаар "төмөр замын шугамын дээд, доод бүтэц болон гүүр, хоолой зэрэг инженерийн байгууламж, өртөө, зөрлөг, галт тэрэгний хөдөлгөөний хэвийн үйл ажиллагааг хангах эрчим хүч, усан хангамж, дохиолол холбоо, мэдээллийн барилга байгууламж, гарам, хориг хашаа зэрэг техник технологийн иж бүрдлийг" хэлнэ.

Гол шугамын нийт урт (мөр 1) Төмөр замын тээврийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д зааснаар төмөр замын шугам гэж төмөр замын өртөө, хоорондын зам болон өртөөн дэх түүний шууд үргэлжлэлийг хэлнэ. Гол шугамыг төмөр бетон дэр, модон дэр, P-75 зам төмөр, P-65 зам төмөр, P-50 зам төмөр болон бусад материалаар хийсэн замын уртыг бөглөнө. мөр (1) = мөр (2+3+4+5+6+7)

Салбар шугамын урт (мөр 8) Төмөр замын тээврийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д зааснаар салбар зам гэж сэлгээний болон ачих, буулгах ажил хийх зориулалтаар төмөр замын шугам болон өртөөний замаас салбарлаж тавьсан замыг хэлнэ. Салбар замыг төмөр бетон дэр, модон дэр, P-75 зам төмөр, P-65 зам төмөр, P-50 зам төмөр болон бусад материалаар хийсэн замын уртыг бөглөнө. мөр (8) = мөр (9+10+11+12+13+14)

Төмөр замын дээд бүтцийн бүрэлдэхүүн хэсэг /ул шороо, далан, замын дээд бүтэц, г.м/, бүрэлдэхүүн хэсгийн элементүүд /зам төмөр, суман шилжүүлэг, зам төмрийн бэхэлгээ, дэрүүд, чигжээс г.м/, нь даах чадварын бат бэх, тогтвортой байдлаараа зөвшөөрөгдөх хэмжээн дэхь хамгийн их хурдтай хөдлөх бүрэлдхүүний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан байхаар хийгдсэн байна.


Суман шилжүүлэг (мөр 15) Хөдлөх бүрэлдэхүүнийг нэг замаас нөгөө зам руу оруулахад зориулагдсан төхөөрөмж юм. (мөр 15) = мөр (16+17+18)

Замын тахир тойруу (мөр 19) Замын тахир хэсгийн градусыг хэлнэ.

Замын баримтлах хэвгий (мөр 24) Хэвгий гэж төмөр замын өгсүүр, уруудуур газрыг хэлнэ.

Өртөө, зөрлөгийн тоо (мөр 30) Галт тэрэг хүлээн авах, явуулах, зөрүүлэх, гүйцэж түрүүлэх, ачаа хүлээн авах олгох, зорчигчдод үйлчлэх тавцан, талбай, агуулахтай, галт тэрэг найруулах, задлах, галт тэрэгний бусад техникийн ажиллагаа хийж болох замын хэсэглэх газар юм.

Замын их засварын ажил (Мөр 31) - Жилийн хугацаанд гол болон салбар замд хийсэн засвар, өргөтгөл зэрэг орно.



Замын машин механизм (Мөр 32) Тусгай хөдлөх бүрэлдэхүүн, Кранууд, Замыг хэсэгчлэх, тэгшлэх, чигжээсэн призмийг нягтруулах машинууд г.м машин механизмууд тоог хэлнэ.

Шугамын нэвтрүүлэх чадвар (Мөр 33) Хоногт хамгийн олон галт тэрэг нэвтрүүлэх чадварыг хэлнэ. Гол замын техникийн нөхцлийг сайжруулсанаар галт тэрэгний хурд, жин, хөдөлгөөний аюулгүй байдлын түвшин, тээх нэвтрүүлэх чадвар зэргийг нэмэгдүүлэх боломжтой болно. Тухайн жилд хичнээн км зам засврын ажил хийхээр төлөвлөсөнөөс хичнээн км зам засварын ажил хийсэнийг тодорхойлох юм. Тээх нэвтрүүлэх чадвар нь хэсэглэх газар, хоорондын замын аяс, зүтгүүр вагоны хүчин чадал, холбоо дохиоллын хүчин чадал зэргээс шалтгаална.

Өртөөний нэвтрүүлэх чадвар (мөр 34) Өртөөн дээр хоногт хамгийн их галт тэрэг нэвтрүүлэх чадварыг хэлнэ.

Тээх чадвар (мөр 35) Төмөр замын чиглэл тус бүрээр өнгөрүүлэх ачааны галт тэрэгний тоо ба түүний жингээс хамааран төмөр замын шугамаар хоногт буюу жилд өнгөрүүлж чадах ачааны хэмжээг гэнэ.

Өртөөний вагон боловсруулах чадвар (мөр 36) Боловсруулах чадвар гэж хоногт өртөөний ажиллагаа хийж чадах (боловсруулж чадах) хамгийн олон вагоны тоо юм.

N= 1440-


- Технологийн ажиллагаанаас тооцоолох элементийн чөлөөтэй, сул байх хугацаа.

- Найдваржилтын коэффициент
- Тооцоолох элементийн 1 бүрэлдэхүүнээр эзэлгээтэй байх хугацаа
- 1 бүрэлдэхүүн дахь вагоны тоо
- Ажиллагаа хийхгүй өнгөрсөн галт тэрэгний тоо

Галт тэрэгний дундаж жин (мөр 37) Тухайн галт тэрэгний дундаж жинг илэрхийлнэ.



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны
11 дүгээр сарын 28 ны өдрийн 116 дүгээр тушаалын
Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл
солилцох журмын дөрөвдүгээр хавсралт



ТӨМӨР ЗАМЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН ТОО, АЖИЛЛАСАН ЖИЛ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН ИЙ ЖИЛИЙН

ТЗ-3 МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү мэдээг өмчийн бүх хэлбэрийн төмөр замын тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон хугацаанд нь үзүүлэлт тус бүрээр үнэн зөв, бүрэн нөхөж ирүүлнэ.

I. Хаягийн хэсэг

Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг. Тухайн Төмөр замын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө.

Аж ахуйн нэгж, байгууллагын оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийг бичиж, кодыг нөхнө.

Үйл ажиллагааны салбарын чиглэл. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.

II. Үзүүлэлтийн хэсэг

Бүгд (мөр 1) тухайн жилд цалин бодогдсон нийт ажиллагчдын тоог хүйсээр нь гаргаж өгнө.

Үүнээс ашиглалтын ажиллагчдын тоо (мөр 2+3+4+5+6+7) гэдэг нь төмөр замын тээврийн үйл ажиллагаанд шууд оролцдог ажиллагчдыг хэлнэ.

Удирдах ажилтан (мөр 3) Аж ахуй нэгж байгууллагын удирдах ажилтан, дарга, захирал, дэд захирал, орлогч дарга, хэлтэс, тасаг, албаны дарга, эрхлэгч, менежер г.м

Мэргэжилтэн (мөр 4) - Тухайн салбарын мэргэжилтэн, нябо, хуульч, эдийн засагч г.м

Инженер, техникийн ажилтан (мөр 5) - Тухайн салбарын инженер, техникийн ажилтан, технологийн инженер, техникийн инженер, хөдөлмөр хамгааллын инженер, бригадын дарга, мастерууд, машинч, өртөөний жижүүр, ээлжийн ахлагч г.м

Техникажилтан (мөр 6) - Техник технологитой холбоотой ажил гүйцэтгэдэг механикч, засварчиг, туслах ажилчид (туслах жижүүр, аолбогч, найруулагч, пүүлэгч) гэх мэт



Үйлчилгээний ажилтан (мөр 7) -Хувийн болон хамгаалах үйлчилгээний ажилчин (тогооч хоол зөөгч, үйлчлэгч, гал сөнөөгч), вагоны үйлчлэгч, цэрэг цагдаа, кассер, байгууллагын үйлчлэгчид, хамгаалагч, үүдний жижүүр, буудлын жижүүр гэх мэт.

Насны бүлгээр (мөр 8) Нийт ажиллагчдаас насны ангиллаар түүвэрлэн судалсан байна. (мөр 9+10+11+12+13+14+15)

Боловсролын түвшин (мөр 16) Нийт ажиллагчдаас боловсролын түвшингээр түүвэрлэн судалсан байна. (мөр 17+18+19+20+21+22+23+24+25)

Дээд боловсрол гэдэгт диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш орно. Гадаад, дотоодын их дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшиний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 120 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн зурс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль төгссөн хүмүүсийг дипломын боловсролтой гэж үзнэ.

Тусгай мэргэжлийн дунд боловсрол (мөр 22) Гадаад% дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй ажилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

Техникийн болон мэргэжлийн боловсрол (мөр 23) Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль -ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж ойлгоно.

Улсад ажилласан жил (мөр 26) Нийт ажиллагчдаас улсад ажилласан ажлын туршлагаар түүвэрлэн авсан. (мөр 27+28+29+30+31+32+33)

Эрдмийн цол (мөр 34) Нийт ажиллагчдаас эрдмийн зэрэг цолтой ажиллагчдыг ангиллаар нь түүвэрлэж авсан. (мөр 35+36+37)

Мэргэшлийн зэрэг (мөр 38) Нийт ажиллагчдаас мэргэшлийн зэргээр нь ангилан авсан. (мөр 39+40)

ТӨМӨР ЗАМЫН СҮЙРЭЛ, ОСОЛ, ГОЛОГДЛЫН ЖИЛИЙН ТЗ-4 МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү мэдээг өмчийн бүх хэлбэрийн төмөр замын тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон хугацаанд нь үзүүлэлт тус бүрээр үнэн зөв, бүрэн нөхөж ирүүлнэ.



I. Хаягийн хэсэг

Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг. Тухайн Төмөр замын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө.

Аж ахуйн нэгж, байгууллагын оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийг бичиж, кодыг нөхнө.

Үйл ажиллагааны салбарын чиглэл. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.


Б. Төмөр замын тээвэр дэх сүйрэл, осол, гологдол

Нийт осолд орсон хүний тоо-гэдэг нь нас барсан, хүнд гэмтсэн, хөнгөн гэмтсэн хүмүүсийн нийлбэрээр тодорхойлогдоно.

Сүйрэл-Төмөр замын тээвэр дэх сүйрэл, осол, гологдлыг шинжлэн судлах журамд зааснаар Зорчигчийн болон ачааны галт тэрэг нь өөр галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн буюу хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсны улмаас хүний амь нас хохирсон, хэд хэдэн хүн хүндээр гэмтсэн, байгаль орчин болон бусад (иргэн, хуулийн этгээд, төр)-ын эд хөрөнгөд онц их хэмжээний хохирол учирсан, сэргээн босгох галт тэрэг газар дээр нь очиж ажилласан, хөдлөх бүрэлдэхүүн эвдэрч дахин засварлах боломжгүй болсон нөхцөл байдал үүссэнийг сүйрэл гэж ойлгоно.

Осол - Төмөр замын тээвэр дэх сүйрэл, осол, гологдлыг шинжлэн судлах журамд зорчигчийн галт тэрэг нь өөр галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн; зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн замаас гарсан; ачааны галт тэрэг нь өөр ачааны галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн буюу хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсны улмаас хор хохирол учраагүй бөгөөд хөдлөх бүрэлдэхүүн их засварт орохоор эвдэрсэн; сэлгээ, зэхэлтийн болон бусад хөдөлгөөний үед хөдлөх бүрэлдэхүүн мөргөлдсөн буюу замаас гарсны улмаас хүний амь нас хохирсон, хүний эрүүл мэндэд хохирол учирсан, хөдлөх бүрэлдэхүүн их засварт орохоор эвдэрсэн; аюултай ачаа тээвэрлэх явцад хөдлөх бүрэлдэхүүн болон бусад шалтгааны гэмтлийн улмаас аюултай ачаа асгарч хүний эрүүл мэнд, байгаль орчин, бусдын өмч хөрөнгөд их хэмжээнээс дээш хохирол учирсан.

Гологдол-Төмөр замын тээвэр дэх сүйрэл, осол, гологдлыг шинжлэн судлах журамд хөдлөх бүрэлдэхүүн мөргөлдсөн; хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсан; Эзэлгээтэй замаар галт тэрэг хүлээн авсан; Эзэлгээтэй хоорондын замд галт тэрэг явуулсан; Бэлэн бус замналаар галт тэрэг хүлээн авсан; Бэлэн бус замналаар галт тэрэг явуулсан; Хориглосон дохио өнгөрсөн; Хөдлөх бүрэлдэхүүн дор сум эргэсэн; Хөдлөх бүрэлдэхүүн өөрөө хөдөлсөн; Хөдлөх бүрэлдэхүүний эд анги хугарсан; Зорчигчийн вагон салгасан; Галт тэрэгэнд эд юмс дайрагдсан; Тээврийн хэрэгсэл дайрагдсан; Дохиолол төвлөрүүлэлт хориглол, эрчим хүч тасалдсан; Төгсгөлийн кран хаалттай явуулсан; Зорчигчийн галт тэрэгний зүтгүүр эвдэрсэн; Усанд автах, элс, цасанд дарагдах, гал түймэрт өртөх; Зорчигчийн галт тэрэг цуцалсан, зорчигч буулгасан; Вагон, чингэлэг дэх ачаа шатах; Хөдлөх бүрэлдэхүүний эд анги зам дээр



унасан; Аялалын үед зам дээр ачаа унасан; Дохио буруу дохиолсон; Галт тэрэгний авто угсраа тасарсан, салсан; Сум зүссэн; Вагон салгасан; Ачааны нөхцөлөөс хамаарч вагон салгасан; Хос дугуй гацсан; Зам төмөр ухсан; Зам төмөр хугарсан; Галт тэргэнд мал дайрагдсан.

Б-р багана. Сүйрэл, осол, гологдол гарсан тоо.

В-р багана. Сүйрэл, осол, гологдол гарсан талаар товч мэдээлэл.

В. Төмөр замын тээвэр дэх сүйрэл, осол, гологдол

Төмөр замын байгууллагын ажилтан (мөр 1) Төмөр замын байгууллагад сар бүр цалин бодогдсон ажилтаныг хэлнэ. Сүйрэл, осол, гологдлын үед төмөр замын байгууллагын ажилтанаас нас барсан, хүнд гэмтсэн, хүндэвтэр гэмтсэн, хөнгөн гэмтсэн хүний нийлбэр байна. мөр (2+3+4+5)

Зорчигчид (мөр 6) Тухайн сүйрэл, осол, гологдлын үед галт тэргээр зорчиж байсан зорчигчийг хэлнэ. Сүйрэл, ослын үед зорчигчоос нас барсан, хүнд гэмтсэн, хүндэвтэр гэмтсэн, хөнгөн гэмтсэн хүний нийлбэр байна. мөр (7+8+9+10)

Бусад (мөр 11) Тухайн сүйрэл, осол, гологдлын үед галт тэргэнд мөргүүлсэн хүнийг хэлнэ. Сүйрэл, ослын үед бусад хүнээс нас барсан, хүнд гэмтсэн, хүндэвтэр гэмтсэн, хөнгөн гэмтсэн хүний нийлбэр байна. мөр (12+13+14+15)

Гэмтлийн зэргийг тогтоох шүүх эмнэлгийн магадлан шинжилгээний зааврын 2.1-д хүний биед учирсан гэмтлийн зэргийг хүнд, хүндэвтэр, хөнгөн гэж ангилна.

Нас барсан (мөр 2, 7, 12) -Ослоос болж нас барсан хүний тоог хэлнэ.

Хүнд гэмтсэн (мөр 3, 8, 13) -Хүнд гэмтэл гэдэг нь амь биед аюултай гэмтлүүд, уршигт үлдэц бүхий гэмтлүүд, энгийн хөдөлмөрийн чадварыг их хэмжээгээр (33-100%) алдсан гэмтлүүд хамаарна.

Хүндэвтэр гэмтсэн (мөр 4, 8, 14) - амь биед аюултай гэмтлийн шинжгүй байх, гэмтэл, түүнээс үүссэн өвчин, үйл ажиллагааны хямрал нь эрүүл мэндийг удаан хугацаагаар сарниулсан байх, энгийн хөдөлмөрийн чадвар үлэмж хэмжээгээр (15-33%) тогтонги алдсан байх, эрүүгийн хуулийн 96.1 дүгээр зүйлд заасан буюу энэ зааврын 2.2.3-т буй уршигт үлдэц бүхий гэмтлүүдийн шинжийг агуулаагүй байхыг ойлгоно.

Хөнгөн гэмтсэн (мөр 5, 10, 15)-Дээр дурдсан хүнд гэмтлийн шинжийг агуулаагүй байх; эрүүл мэнд түр хугацаагаар сарнисан байх; энгийн хөдөлмөрийн чадвар бага хэмжээгээр (15% хүртэл) тогтонги алдсан байхаар тодорхойлно.

Засварлах боломжгүй болсон хөдлөх бүрэлдэхүүний тоо (мөр 16) –Төмөр замын тээвэр дэх сүйрэл, осол, гологдлоос шалтгаалан гэмтсэн цаашид ашиглагдах, засварлах боломжгүй болсон хөдлөх бүрэлдэхүүнийг тодорхойлно.



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫН ЖИЛИЙН ТЗ-5 МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү мэдээг өмчийн бүх хэлбэрийн төмөр замын тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон хугацаанд нь үзүүлэлт тус бүрээр үнэн зөв, бүрэн нөхөж ирүүлнэ.

I. Хаягийн хэсэг

Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг. Тухайн Төмөр замын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө.

Аж ахуйн нэгж, байгууллагын оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийг бичиж, кодыг нөхнө.

Үйл ажиллагааны салбарын чиглэл. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.

II. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого

Үйлдвэрлэлийн осол мөр (1) хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байж үйлдвэрлэлийн осолд хүргэсэн. Үйлдвэрлэлийн ослын ямар шалтгаанаас болж осолд хүрсэнийг, хэдэн хүн осолдсоныг тодорхойлно.

Хурц хордлого Мөр (16) "хурц хордлого" гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг;

Хурц хордлогын ямар шалтгаанаас болж хурц хордлого болсон, хэдэн хүн өртсөнийг тодорхойлно.

Багана (1) Нийт ослын тоо. тухайн салбарт үйлдвэрлэлийн ослын тохиолдол хичнээн гарсаныг тодорхойлно.

Багана (2) Осолд өртсөн хүмүүсийн тоо. Тухайн ослоос болж хичнээн хүн өртсөнийг тодорхойлно. Осолд өртөж нас барсан, хүнд гэмтсэн, хөнгөн гэмтсэн хүний нийлбэрээр тодорхойлогдоно. Багана (2) = багана (3+4+5)

ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН МЭДЭЭНИЙ МАЯГТ Т-5-Г НӨХӨХ ЗААВАР

Энэ тайланг тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн дагуу тогтоосон хугацаанд нь үнэн зөв, бүрэн нөхөж ирүүлнэ.



А. Хаягийн хэсэг

ААНБ-ын хаягийн хэсэг нь ҮСХ-ны ААНБ-ын регистрийн санд өөрчлөлт, баяжуулалт хийхэд чухал ач холбогдолтой мэдээлэл юм. Аж ахуйн нэгж, байгууллагын хуулийн албан ёсны нэрийг бичиж, регистрийн дугаарыг тавина.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, үйл ажиллагааны салбарын чиглэлийн нэрийг бичиж, зохих кодыг тавина.

Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн хэлбэрийг дотор нь төрийн өмчийн-11; төрийн өмчийн оролцоотой-12; төрийн хамтарсан-13; орон нутгийн өмчийн-31; орон нутгийн өмчийн оролцоотой-32; орон нутгийн хамтарсан-33; монгол улсын иргэний-21; гадаадтай хамтарсан-22; гадаад улсын-23 гэж ангилан зохих кодыг тавина. 12, 13, 32, 33 гэсэн кодоор нөхсөн бол тухайн ААНБ-д төрийн болон орон нутгийн өмчийн эзлэх хувь, 22 гэсэн кодоор нөхөгдсөн бол гадны улсын эзлэх хувийг нөхнө.

Б. Орлого, зардал

Нийт үйлдвэрлэлтэд ачаа, зорчигч тээвэрлэлтийн орлого, тээвэр зууч, тээвэр зохицуулалтын орлого, агуулахын орлого, худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, барилга, байшин, машин, тоног, төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах үйлчилгээний орлого, бусад орлогууд орно.

1-р мөрөнд тайлангийн жилийн орлого, дотооддоо болон гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ буюу маягтын 2-оос 6-р мөрүүдийн дүнг нөхнө.

4-р мөрөнд тээвэр зууч, хяналт, шалгалттай холбогдсон, ачаа илгээх, хүлээн авах үйлчилгээний орлогыг оруулна.

6-р мөрөнд үйл ажиллагааны бус орлогын дүнг нөхнө.

Завсрын хэрэглээнд тухайн тайлант хугацаанд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад орц байдлаар зарцуулсан бараа, үйлчилгээний материалын зардал болон үйлчилгээний төлбөрийг хамруулж тооцно.

21-68-р мөрүүдэд борлуулалтын зардал болон ерөнхий удирдлагын зардал, үндсэн бус үйл ажиллагааны зардлуудыг холбогдох зардлын дансуудаас авч нөхнө.

29, 30-р мөрөнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, газрын төлбөр, ойгоос түлээ, мод бэлтгэж ашигласны төлбөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашигласны төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр, рашаан, ус ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр зэргийг оруулж нөхнө.



34-р мөрөнд зарим бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийн албан татвар, бууны албан татвар, автобензин, дизелийн түлшний албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, бусад татвар, хураамж зэргийг оруулан нөхнө.

56-р мөрөнд интернэтийн зардлаас гадна тухайн байгууллага өөрийн вэб хуудастай бол түүний үйлчилгээний төлбөр буюу хостингийн зардал орно.

71-р мөрөнд ажиллагчдын жилийн дундаж тоог нөхнө. Жилийн дунжийг тооцоходоо сар бүрийн эцэст байгаа ажиллагчдын тооны нийлбэрийг нийт сарын тоонд харьцуулж гаргана. Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

72-р мөрөнд эмэгтэй ажиллагчдын жилийн дундаж тоог нийт дүнгээс сугалж нөхнө.

Г. Нийт хөрөнгө

Үндсэн хөрөнгө нь хөрөнгийн хуримтлалын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэг жилээс дээш хугацаанд давтан эсвэл үргэлжлэн ашиглагддаг биет ба биет бус хөрөнгөөс бүрдэнэ.

Багана (1): Нийт хөрөнгө, оны эхний үлдэгдэл

Багана (21): Нийт хөрөнгө, оны эцсийн үлдэгдэл

Багана (2) = багана (3 + 9)

Багана (3) = багана (4 + 5 + 6 + 8)

Багана (9) = багана (10 + 11 + 12 + 13 + 14)


Багана (15) = багана (16 + 17 + 18 + 19 + 20)

Багана (21) = багана (1 + 2 - 15)

Биет үндсэн хөрөнгө нь орон сууцны барилга, бусад барилга, байгууламж, машин, тоног төхөөрөмж болон өсөж үрждэг хөрөнгөөс бүрдэнэ.

Орон сууцны барилгад (мөр 3) хүн суурин амьдардаг сууцны зориулалттай барилга, оршин суугчдад зориулж суурилуулсан байгууламж, гарааж, мөн эзэмшигчдэд нь шилжүүлэх зорилготой баригдаж байгаа дуусаагүй орон сууцны барилга болон завь, ачааны усан онгоцон дээрх орон байр, нүүдлийн орон гэр зэргийг хамруулна.

Бусад барилга, байгууламж (мөр 4) нь орон сууцны бус барилга болон бусад байгууламжаас бүрдэнэ.



• **Орон сууцны бус барилга** (мөр 5) үйлдвэрлэл, худалдаа, нийтийн үзвэр, үйлчилгээний барилга, зочид буудал, зоогийн газар, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын барилга гэх мэт барилгууд орно.

• **Бусад байгууламж** (мөр 6) суваг шуудуу, сүлжээ, авто зам, гудамж, төмөр зам, онгоцны нислэгийн зам, гүүр, өргөгдсөн зам, туннель, газар доорх зам, усан зам, усан зогсоол, далан, хол зайд тавигдсан хоолой, холбооны болон эрчим хүчний шугам, кабель болон бусад шугам, олборлох, боловсруулах үйлдвэрийн байгууламж; спорт, амралтын байгууламж орно.

Их засвар, сэргээн босголт, өргөтгөлийн ажил (мөр 8) үндсэн хөрөнгө, компьютерийн программ хангамж болон газрын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглагдах хугацааг уртасгах, тухайн хөрөнгөөр үйлдвэрлэх бүтээгдэхүүний чанар, хөрөнгийн бүтээмжийг сайжруулах зорилгоор хийгдсэн ажлыг хамруулна.

Үндсэн хөрөнгийг сайжруулахтай холбогдож хийгдсэн үндсэн гол ажлын зардлууд нь үндсэн хөрөнгийн хуримтлалын "Эдийн засагт шинээр бий болсон үндсэн хөрөнгийг олж эзэмших" гэсэн ангилалд багтана. Энэхүү шинэчлэгдсэн үндсэн хөрөнгө нь энэ үеэс эхлэн ҮТС-д энэ өртгөөрөө тусгагдаж, үндсэн хөрөнгийн элэгдлийг энэ дүнгээс тооцно.

Машин, тоног төхөөрөмж (мөр 9) тээврийн хэрэгсэл болон бусад машин, тоног төхөөрөмжийг оруулна. Хэрэв цэргийн зорилгоор эзэмшиж буй машин, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд ашиглаж байвал мөн оруулна.

▪ **Тээврийн хэрэгсэл** (мөр 10) гэж хүн болон амьтан, бусад эд, зүйлсийг зөөх хэрэгслийг ойлгоно. Үүнд хүнд, хөнгөн даацын автомашин, усан онгоц, галт тэрэг, нисдэг тэрэг, сансрын хөлөг, мотоцикл, унадаг дугуй гэх мэт орно.

▪ **Бусад машин, тоног төхөөрөмж** (мөр 12) тээврийн хэрэгсэлд хамаарахгүй машин, тоног төхөөрөмж орно. Тухайлбал, ерөнхий зориулалтын машин; тусгай зориулалтын машин; албан хэрэгцээний бодох, тооцоолох төхөөрөмж; цахилгаан машин, аппарат хэрэгсэл; радио, телевиз болон холбооны тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл; эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, нарийн хэмжилтийн аппарат хэрэгсэл, цаг, бугуйн цаг, цөмийн тогооны шингэн элемент (сум), хөгжмийн зэмсэг, албан газрын тавилга, уурын халаалтын генератор зэрэг орно.

Өсөж үрждэг хөрөнгө (мөр 14) байгууллагын шууд хяналт, хариуцлага, удирдлагын дор бүтээгдэхүүнийг давтан үйлдвэрлэх зорилгоор өсгөж, үржүүлж буй үржлийн, сүүний, махны чиглэлийн мал, амьтан (загас, гахай, шувуу, зөгий), ажлын мал; тарьж ургуулж байгаа чацаргана, алим, жимсний мод, бусад модыг оруулна. Тухайн жилд бойжуулсан төл орохгүй.

Энд жилээс жилд бүтээгдэхүүнээ өгдөг тарьж ургуулж буй мод, тухайлбал, жимсний бут, самрын мод, шүүс, резин, холтос, навчаар нь бүтээгдэхүүн хийдэг мод, бут орно.



Биет бус үндсэн хөрөнгөд нэг жилээс дээш хугацаагаар ашиглахаар төлөвлөсөн ашигт малтмалын хайгуулын зардал, компьютерийн програм хангамж, соёл урлаг, утга зохиол, урлаг, уран сайхны эх бүтээл зэрэг биет бус бусад үндсэн хөрөнгийг оруулна.

- **Ашигт малтмалын хайгуулын зардал** (мөр 18) нь газрын тос, байгалийн хий болон бусад ашигт малтмалын хайгуулын ажлын өртөг юм. Энэ зардалд лиценз авахын өмнөх зардал, лицензийн болон орд эзэмших зардал, хайгуулын өрөмдлөг, цооног гаргах, агаарын зураглал хийх зэрэг хайгуулын ажлын зардал орно.
- **Компьютерийн програм хангамж** (мөр 19) системийн болон хэрэглээний програм хангамж, програмын тодорхойлолт, ашиглах заавар зэргийг оруулна. Энд худалдан авсан болон өөрсдийн хэрэглээнд боловсруулсан програм хангамж аль аль нь орно. Түүнчлэн нэг жилээс дээш хугацаанд ашиглахаар төлөвлөж худалдан авсан, өөрсдөө боловсруулсан, томоохон хэмжээний мэдээллийн баазыг өргөжүүлсэн зардлыг түүнийг зарж борлуулах эсэхээс хамаарахгүйгээр оруулна.
- **Утга зохиол, урлагийн эх бүтээл** (мөр 20) кино, дуу бичлэг, гар бичмэл, соронзон хальсанд буулгасан онцлог үйл явдал, спорт, утга зохиол, урлаг, уран сайхны бүтээл зэргийг бичсэн, хадгалсан хуурцаг зэрэг орно. Энд өөрийн бүтээсэн эх бүтээл мөн орно.
- **Патент** (мөр 21) гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг хэлнэ.
- **Шинэ бүтээл** гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн шийдлийг хэлнэ.
- **Бүтээгдэхүүний загвар** гэж бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг хэлнэ.
- **Лиценз** (мөр 21) гэж патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болон ашигтай загварыг бусад этгээдэд ашиглуулах болзолтойгоор өгч байгаа зөвшөөрлийг хэлнэ.
- **Ашигтай загварын гэрчилгээ** гэж ашигтай загварыг эрх бүхий этгээд өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг хэлнэ.
- **Биет бус бусад үндсэн хөрөнгө** (мөр 22) үйлдвэрлэлийн хэрэглээ нь хязгаарлагдмал, зөвхөн тухайн нэгжид өмчлөх эрх нь хадгалагддаг, эсвэл өөр нэгжид лицензээр эзэмшүүлсэн, өмнө нь ангилагдаагүй биет бус бусад үндсэн хөрөнгө орно.
- **Газар** (мөр 23) өмчлөх эрхийг нь баталгаажуулж, мөн шилжүүлж болдог газар, хөрсний давхарга, тэдгээрт хамаарах газрын гадаргуугийн гол ус орно. Харин газар дээр байрлах, эсвэл түүгээр дамжих барилга, байгууламж; газар доорх хөрөнгө; газар доорх биологийн нөөц, усны нөөцийг оруулахгүй. Газар нь барилга, байгууламжийн газар, тариалангийн газар, амралтын газар болон бусад газар, тэдгээрт хамаарах газрын гадаргуугийн гол, уснаас бүрдэнэ.



- **Материаллаг эргэлтийн хөрөнгө** нь тайлант, эсвэл тайлант хугацаанаас өмнө үйлдвэрлэсэн, борлуулахад бэлэн байгаа, эсвэл үйлдвэрлэлийн болон өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнээс бүрдэх үйлдвэрлэсэн хөрөнгө болно.


Материаллаг эргэлтийн хөрөнгө нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн болон дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Түүнчлэн Засгийн газрын эзэмшилд байгаа стратегийн материал, үр тариа зэрэг улсын нөөцөд байгаа эргэлтийн бүх хөрөнгө орно.

- **Түүхий эд, материал** (мөр 25) дахин борлуулахаар биш харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүн орно.
- **Дуусаагүй үйлдвэрлэл** (мөр 27) нь үйлдвэрлэгчээс цаашид боловсруулалт хийхгүйгээр бусдад шилжүүлдэггүй, эсвэл үйлдвэрлэлийн дараачийн үе шатанд үргэлжлүүлэн боловсруулах хэсэгчилсэн боловсруулалт хийгдсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Энд өөрийн хэрэглээний үйлдвэрлэл, эсвэл худалдах/худалдан авах гэрээний дагуу өмчлөх эрх нь эцсийн эзэмшигчдээ шилжсэн дуусаагүй үйлдвэрлэлийг оруулахгүй. Дуусаагүй үйлдвэрлэл нь дараахь өсөж үрждэг хөрөнгө болон бусад дуусаагүй үйлдвэрлэлээс бүрдэнэ.

Өөрөө үйлдвэрлээд өөртөө хэрэглэх зорилгоор барьж байгаа дуусаагүй барилга, байгууламжийн дуусаагүй үйлдвэрлэл нь энд орохгүй, үндсэн хөрөнгөд орно.

- **Өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэлд** махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана. Түүнчлэн тухайн жилд бойжуулсан төл орно.
- **Бусад хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэлд** өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэлээс бусад үйлдвэрлэгчээс хэсэгчилэн боловсруулалт хийсэн, үйлдвэрлэсэн, угсарсан бүтээгдэхүүн, үйлчилгээ орно.
- **Бэлэн бүтээгдэхүүн** (мөр 30) тухайн үйлдвэрлэгчээс үйлдвэрлэсэн худалдах, ачуулахад бэлэн болсон бүтээгдэхүүн орно.
- **Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн** (мөр 31) үйлдвэрийн газраас, тухайлбал, бөөний болон жижиглэнгийн худалдаачдын эзэмшиж байгаа, цаашид боловсруулалт хийхгүйгээр (хэрэглэгчийн сонирхлыг татахуйц байдлаар чимэглэснээс өөрөөр өөрчлөөгүй) борлуулах зорилготой бүтээгдэхүүн орно.
- **Үнэт зүйлс** гэж үйлдвэрлэсэн хөрөнгө боловч үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагдаагүй, ердийн нөхцөлд удаан хугацаанд чанараа алддаггүй, үнэ нь өсөх, эсвэл үнэ нь ядаж буурахгүй гэсэн магадлалаар хадгалах зорилгоор эзэмшдэг хөрөнгийг хэлнэ. Үнэт зүйлсэд үнэт металл, чулуу, эртний зүйлс болон урлагийн бусад бүтээл орно.
- **Үнэт металл, чулуу** (мөр 33) нь үйлдвэрийн газраас өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа орц байдлаар хэрэглэдэггүй үнэт металл, чулуу болно.



- **Эртний зүйлс, урлагийн бусад бүтээл** (мөр 34) уран зураг, баримал зэрэг түүх, соёлын үнэт зүйлс, эртний эдлэлийн зүйлсэд тооцогддог бүтээл орно.
- **Бусад үнэт зүйлс** (мөр 35) нь ямар нэгэн ангилалд ороогүй, жишээ нь үнэт чулуу, металлаар хийсэн, чимэглэсэн үнэ цэнэтэй цуглуулга, гоёлын зүйлс болно.

Нэмэгдсэн үндсэн хөрөнгийг дотоод болон гадаад эх үүсвэрээр бий болгосон гэж ангилж багана 3, 9-д тусгана.

Дотоод эх үүсвэрээр бий болгосон хөрөнгийг төсвийн хөрөнгө (багана 4), банкны зээл (багана 5), өөрийн хөрөнгө (багана 6), бусад (багана 8) гэж хувааж бүртгэнэ. Өөрийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн хөрөнгөөс өөрийн хөрөнгөөр үйлдвэрлэсэн хөрөнгийг ялган тусад нь багана 7-д харуулна.

Гадаад эх үүсвэрээр бүрдүүлсэн үндсэн хөрөнгийг шууд хөрөнгө оруулалт (багана 10), зээл (багана 11), тусламж (багана 12), төсөл хандив (багана 13), бусад гадаад эх үүсвэр (багана 14)-ээр бий болгосон гэж ангилна.

Хасагдсан хөрөнгийг худалдсан (багана 16), бараа, солилцоогоор арилжсан (багана 17), үнэ төлбөргүй шилжүүлсэн (багана 18), акталж устгасан (багана 19), бусад хасагдсан хөрөнгө (багана 20) гэж ангилж бүртгэнэ.

Бараа, солилцоогоор бусад байгууллага иргэдтэй арилжсан хөрөнгийг хасагдсан хөрөнгөд оруулах бөгөөд багана 17-д бүртгэнэ.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТЭЭВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭНИЙ Т-9 МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү мэдээг өмчийн бүх хэлбэрийн төмөр замын тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон хугацаанд нь үзүүлэлт тус бүрээр үнэн зөв, бүрэн нөхөж ирүүлнэ.

I. Хаягийн хэсэг

Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг. Тухайн Төмөр замын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө.

Аж ахуйн нэгж, байгууллагын оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийг бичиж, кодыг нөхнө.

Үйл ажиллагааны салбарын чиглэл. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.

A. Үндсэн үзүүлэлт

Тээвэрлэсэн ачаа (мөр 1) -тээвэрлэсэн ачаанд төмөр замаар тээвэрлэсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэлийн ачааг оруулна. Төмөр замаар тээвэрлэсэн ачааг



дотоодын, төмөр замаар тээвэрлэж гаргасан, тээвэрлэж оруулсан, дамжин өнгөрсөн ачааны дүнгээр нөхнө.

Дотоодод болон гадаадад тээвэрлэсэн ачаа (мөр 2) Дотоодын төмөр замын тээврийн сүлжээнд тээвэрлэсэн болон дотоодын төмөр замын сүлжээнээс тээвэрлэж гадаадад гаргасан ачааны дүнгээр тодорхойлогдоно.

Гадаадаас тээвэрлэсэн (мөр 7) Гадаадын төмөр замын сүлжээнээс тээвэрлэж дотоодод оруулсан ачааны дүнгээр тодорхойлогдоно.

Дамжин өнгөрсөн ачаа (мөр 10) манай улсын төмөр замын сүлжээгээр дамжин тээвэрлэсэн ачааны хэмжээг оруулна. БНХАУ-аас ОХУ-д, ОХУ-аас БНХАУ-д дамжин тээвэрлэгдсэн ачааг дүнгээр салгаж мөр 11, 12-д нөхнө.

Дотоодод болон гадаадад тээвэрлэсэн ачаа, ачааны нэр төрлөөр (мөр 13-36) Төмөр замаар дотоодод болон гадаадад тээвэрлэсэн ачааг маягтанд заасан нэр төрлөөр ангилж 13-36-р мөрөнд нөхнө. Хүнсний бүтээгдэхүүнд гурил, будаа болон бусад хүнсний бүтээгдэхүүнийг; харин түргэн муудах бүтээгдэхүүнд мах, сүү, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, бусад түргэн муудах хүнсний зүйлийг оруулна. Мөр 13-аас 36-р мөрүүдийн нийлбэр нь мөр 2-той тэнцүү байна.

Ачаа эргэлт (мөр 37) Ачаа эргэлтийг тооцохдоо тээвэрлэсэн ачааг тээсэн зай /км-аар үржүүлсэн үржвэрүүдийн нийлбэрээр тодорхойлогдоно.

Зорчигч эргэлт, дотоодод (мөр 55) Төмөр замаар дотоодод зорчсон зорчигчдын тоог тус бүр аялсан зай/км-аар үржүүлсэн үржвэрүүдийн нийлбэр дүнгээр тодохойлогдоно.

Зорчигч эргэлт, олон улсад (мөр 56) Төмөр замаар гадаад руу, гадаадаас, дамжин өнгөрөн зорчсон зорчигчдын тоог тус бүр аялсан зай/км-аар үржүүлсэн үржвэрүүдийн нийлбэр дүнгээр тодохойлогдоно.

Ажиллагчид (мөр 57) гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ. Ажиллагчдын тоог дундажаар нөхнө. Ажиллагчдын дундаж тоог гаргахдаа өдөр бүрийн ажиллагчдын (дансны) тооны нийлбэрийг тухайн сарын нийт ажилласан өдөрт хуваана.

Эмэгтэй (мөр 58) нийт ажиллагчдын тооноос эмэгтэй ажиллагчдын тоог нөхнө.

Ашиглалтын ажиллагчид (мөр 59) гэж төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүн, хөдөлгөөн зохицуулалтын үйл ажиллагаанд хамаарах ажиллагчдыг хэлнэ. Тухайлбал, төмөр замын машинист, үйлчлэгч, техникийн үйлчилгээ болон засварын ажиллагчдыг энд хамруулна.

Эмэгтэй (мөр 60) нийт ашиглалтын ажиллагчдын тооноос эмэгтэй ажиллагчдын тоог нөхнө



Тээврийн нийт орлого (мөр 61) Төмөр замын тээврийн орлого нь зорчигч, ачаа, тээш тээврийн болон бусад орлогуудаас бүрдэнэ. Тээш тээврийн орлого нь суудлын вагоноор зорчигчдын авч яваа 36 км-аас дээш буюу овор ихтэй ачааг зориулалтын тээшний вагоноор тээвэрлүүлснээс орох орлого юм. Бусад орлого гэдэгт ачааг зөөж тавих, нэг вагоноос нөгөөд шилжүүлэх гэх мэт хураамжийн орлогууд орно.

--- о О о ---

